UNIYERSITY OF INTERNAL AFFAIRS
SCHOOL FOR COURT DECISION EXECTION SERYICE

COURT DECISION EXECUTION STUDY

THEORETICAL AND METHODOLOGICAL QUARTERLY JOURNAL

2023
№01

Ulaanbaatar

Дугаарыг эрхлэн гаргаж эмхэтгэсэн: **дэд хурандаа Я.Батгэрэл,**
ахмад Б.Замбага,
хошууч Э.Цэрэнханд
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхим

Эх бэлтгэсэн: Б.Тулга
Хэвлэл, редакцийн хэлтсийн
эх бэлтгэгч-дизайнер, дэд ахлагч

Хэвлэлийн хуудас: 35.8
Хэвлэлийн тоо: 10

ISBN: 978-99978-770-2-4

“ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ” сэтгүүл

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Цагдаагийн академийн өргөн чөлөө,
Хилчний гудамж,
Дотоод хэргийн их сургууль
И-мэйл: setguul.cd@gmail.com
Веб: uia.gov.mn

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ	JOURNAL EDITOR BOARD
Сэтгүүлийн эрхлэгч **Дамдинцэрэн Д.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн захирал, доктор, бригадын генерал	**Editor of the journal** **Damdintseren D.** Director, School For Court Decision Execution Seryice, Ph.D, Brigadier general
Нарийн бичгийн дарга **Галбадрах Б.** Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, хошууч	**Editor of the journal** **Galbadrakh B.** Head of Social work and psychology department, Ph.D, Major
Гишүүд **Алтангэрэл Б.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын хүрээлэнгийн эрхлэгч эрхлэгч, доктор, дэд профессор, хурандаа	**Members** **Altangerel B.** Head of Court Decision Execution Study Center, Ph.D, associated Professor, Colonel
Очгэрэл Ц. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын профессорын судалгааны багийн тэргүүлэх профессорын орлогч, доктор, дэд профессор, хурандаа	**Ochgerel Ts.** Deputy professor of Professor research team ofCourt Decision Execution, Ph.D, associated Professor, Colonel
Баттулга Г. Харуул хамгаалалт, гүйцэтгэх ажлын тэнхимийн эрхлэгч хурандаа	**Battulga G.** Head of Security and Executiye Work Department, Colonel
Батгэрэл Я. Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн эрхлэгч, дэд хурандаа	**Batgerel Ya.** Head of Ciyil Court Decision Execution Department, Lieutenant colonel
Батбаяр Э. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор, хурандаа	**Batbayar E.** Head of Non custodial Punishment Execution Department, Ph.D, associated Professor, Colonel
Мягмарсүрэн Д. Ахлагчийн мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төвийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны тэнхимийн эрхлэгч, доктор, дэд хурандаа	**Myamarsuren D.** Head of Department of the Court Decision Execution Seryice of the Sergeant Profession, Training and Production Center, Ph.D, Lieutenant colonel

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ

Онол-арга зүйн сэтгүүл

ДУГААРЫН ТОВЧООН

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

Хорих ял эдлүүлэх ажиллагаа

Б.Галбадрах 9
Хорих ял эдлүүлэх ажиллагааны олон улсын хэм хэмжээ

Н.Анар 19
Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөрийн хэрэгжилтэд анхаарах асуудал

З.Түвшинжаргал 25
Хоригдлын зүгээс үйлдэж болзошгүй нийтийг хамарсан эмх замбараагүй байдал түүний онцлог

Г.Сэргэлэн 31
Цагдан хорих байрны харуул хамгаалалтад анхаарах асуудал /цагдан хорих 461-р ангийн жишээн дээр/

Н.Эрдэнэчулуун 37
Хоригдлын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангахад анхаарах асуудал

Иргэн, захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

Я.Батгэрэл
Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудаас гаргасан гомдлыг шалган шийдвэрлэхэд анхаарах асуудал 45

Б.Даваадорж 52
Шийдвэр гүйцэтгэгчийн хүний нөөцийн бодлогод хийсэн дүн шинжилгээ, анхаарах асуудал

Б.Мөнгөннахиа, Э.Цэрэнханд 65
Захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ

Н.Өнөржаргал 81
Гэр бүлийн эрх зүйн харилцаан дахь хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаа: Тулгамдсан асуудал

Б.Энхтайван 87
Гэр бүлийн дундын хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагааны ойлголт, эрх зүйн зохицуулалт

Г.Түвшинтөр 95
Иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах явцад шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдлыг хангах нь

Ж.Чүлтэм 104
Цахим гэмт хэргийн улмаас үүссэн хохирлыг барагдуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа, албадлагын арга хэмжээ

Д.Одсэр 111

Өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны олон улсын хэм хэмжээ
Б.Эрдэнэчимэг 121
Нийтэд тустай ажил хийлгэх ялын объект хөдөлмөр болох нь, ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудал
Б.Байгальмаа 128
Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт, түүнийг боловсронгуй болгох арга зам

Нийгмийн ажил, сэтгэл зүй

Ц.Пүрэвням
ОХУ, Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжтой эмнэлгийн байгууллагын засах арга хэмжээний нийгэм-эрх зүйн байдал 135
Г.Төмөрбаатар 145
Хоригдлыг гэр бүлд нь тулгуурлан нийгэмшүүлэх ажлын ач холбогдол

Иргэний эрх зүй

Ж.Уганчимэг
Монгол Улсын Иргэний эрх зүйн шинжлэх ухааны түүхэн хөгжил, төлөвшил: Цаашдын чиг хандлага 155

Эрүүгийн эрх зүй

Л.Хаш, Б.Мөнгөннахиа
Цахим гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, түүнд тулгамдаж буй зарим асуудал 167
Ч.Отгонсүрэн 181
Сэтгэл санааны хохирлыг тооцох, арилгах талаарх гадаадын зарим улс орон болон Монгол Улсын туршлагыг харьцуулан дүгнэсэн байдал
С.Уганбаатар 197
Монгол улсын эрүүгийн хуулийн ялын төрлийг БНХАУ-ын эрүүгийн хуулийн ялын төрөлтэй харьцуулсан судалгаа

Хилийн эрх зүй

Л.Лхагвасүрэн 211
Гэр бүл ба шилжилт хөдөлгөөн
Б.Ням-Очир 222
Улсын хилээр хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх мансууруулах бодис нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх нь
Д.Энхтайван 228
Бидний нийгэм дэх тулгамдсан зарим асуудал
Ж.Баттөгөлдөр 238
Удирдлагын ухааны орчих үеийн чиг хандлага

Шинжлэн магадлах ухаан

Э.Батбаяр, О.Одонтуяа
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд криминалистикийн техник зүйн мэдлэг ашиглах нь 245
Б.Ундармаа, Ц.Нандинцэцэг, Б.Долгормаа 252

Хүний биед учирсан гэмтлийн зэрэг тогтоох шүүх эмнэлгийн шинжилгээг сүүлийн 5 жилийн материалаар судалсан дүн

Б.Хонгор 263
Криминалистикийн бэхжүүлэх гэрэл зургийн онол, эрх зүйн зарим асуудал

Боловсрол судлал

Ч.Чулуунхүү
Цахим сургалтыг их, дээд сургуулийн сургалтын хэлбэр, арга зүйд нийцүүлэх нь 270

Ч.Чулуунхүү 276
Идэвхтэй сургалтын арга зүй

Судлаач сонсогч, оюутан

Б.Анун 283
Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онцлог

Б.Хүслэн 295
Төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт

М.Маралмаа 314
Цэцэрлэгийн хүрэлцээ ба орон нутгийн байгууллагын оролцооны урвуу хамаарал

М.Анхбаяр 324
Сонсголын бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай

СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Э.Батбаяр
Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт судалгааны тайлан: Танилцуулга 333

ДУУРСАХ НЭР БУЛАН

Монгол улсын гавьяат хуульч, хууль зүйн ухааны доктор /Ph.d/, профессор, бэлтгэл хурандаа Р.Оюунбадамын “Дурсамж яриа” 341

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийг сургалт, судалгааны 403 дугаар анги-шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны сургууль болгох эрх зүйн орчин бүрдлээ 343

“Монгол эрэгтэй хүний дундаж наслалтыг уртасгахад уламжлалт анагаах ухааны гүйцэтгэх үүрэг” сэдэвт лекц боллоо 344

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тэнхимийн “офицер” дамжааны төгсөлтийн үйл ажиллагаа боллоо 345

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эмэгтэйчүүдийн зөвлөл хилийн чанад дахь монголчуудын зөвлөлтэй хамтран ажиллахаар боллоо 346

Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Нийгмийн ажил сэтгэлзүйн тэнхим “Боулингийн тэмцээн” зохион байгууллаа 347

Монголын анхны эмэгтэй хурандаа Р.Оюунбадамд хүндэтгэл үзүүллээ 348
Дотоод хэргийн их сургуулийн эмэгтэй албан хаагчдын дунд “Дартс-2023” тэмцээн боллоо 349
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн сонсогч Монгол улсын ерөнхийлөгч, зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн нэрэмжит 2023 оны “Шилдэг сонсогч” шагнал хүртлээ 350
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 521 дүгээр дэд түрүүч М.Маралмаа шинэ үндсэн хуулийг сурталчлах илтгэлийн уралдааны шилдгээр тодорлоо 351
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулиас сургалтын орчныг сайжруулах чиглэлээр тохижилтын ажил хийлээ 352
Сонсогч, суралцагчид Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нээлттэй хаалганы өдөрлөгт оролцлоо 353
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын “Спортын 6 төрөлт тэмцээн” 7 бүсэд боллоо 354

МЭДЭЭЛЭЛ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал сэтгүүлд нийтлэгдэх эрдэм шинжилгээний өгүүлэлд тавигдах хэлбэрийн шаардлага 355

---o0o---

ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС

Эрхэм хүндэт уншигч танд энэ өдрийн мэнд хүргэе.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулиас улирал тутамд эрхлэн гаргадаг “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл, судлал” онол, арга зүйн сэтгүүлийн 2023 оны 1 дүгээр улирлын дугаарыг тус сургуулийн Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхим эрхлэн гаргаж уншигч та бүхэнд хүргэж байгаадаа таатай байна.

Манай сэтгүүл нь 2012 онд анхны дугаараа нийтийн хүртээл болгосноос хойш 43 дахь дугаарыг хэвлэн нийтлүүлсэн байна. Ингэхдээ шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын судалгааны голлох эх сурвалж болон шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын салбарын үе үеийн эрдэмтэн профессорууд болон судлаачдын судалгаа, эрдэм шинжилгээ өгүүлэл, хорих ял эдлүүлэх ажиллагаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ зэргийг хэвлэн нийтэлдэг манай салбарын шинжлэх ухаан практикт өөрийн өнгө аяс бүхий хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүл болон хөгжиж ирсэн билээ.

Тус сэтгүүл нь 2018 оноос хойш олон улсын цуврал сэтгүүлийн хэвлэлтийн бүртгэлд ISBN:978-99978-720-2-4 дугаартайгаар бүртгэгдсэн нь олон улсын хэмжээнд баталгаажсан болохыг илтгэж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл сэтгүүлийн I дүгээр улирлын дугаарын онцлог шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн судлагдахууны хүрээгээр хязгаарлахгүйгээр эрх зүйн ерөнхий онолын агуулгыг илэрхийлсэн, иргэний эрх зүй, эрүүгийн эрх зүй, хилийн эрх зүй, шинжлэн магадлахуй, боловсрол судлал, сэтгэл судлал, удирдахуйн ухааны онол, практикийн тулгамдсан асуудлыг хөндөн судалсан багш, судлаагчдын судалгааны ажлыг нийтийн хүртээл болгож байгаагаараа онцлог юм.

Тус сэтгүүлийг орчин үеийн технологийн хөгжил, дэвшилд нийцүүлэн цахим хэлбэрт шилжүүлэн олны хүртээл болгохоор ажиллаж байна.

Уншигч, судлаач та бүхэн Монгол улс болон олон улсын түвшинд дүйцэхүйц шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын сэтгүүлийг буй болгох үйлсэд бидэнтэй хамтран ажиллаж, хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байна.

Уншигч Таны эрдэм шинжилгээ, судалгааны ажилд тань өндөр амжилт хүсье.

Хүндэтгэсэн:

ИРГЭНИЙ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН ТЭНХИМИЙН
ЭРХЛЭГЧ, ДЭД ХУРАНДАА Я.БАТГЭРЭЛ

ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ОЛОН УЛСЫН ХЭМ ХЭМЖЭЭ

INTERNATIONAL STANDARDS FOR THE EXECUTION OF IMPRISONMENT



Б.Галбадрах
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), хошууч

Товч утга: Өгүүлэлд хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулсан олон улсын хэм хэмжээний ойлголт, төрөл, ангиллын талаар тайлбарласан

Түлхүүр үгс: хорих ял, хоригдол, олон улсын хэм хэмжээ, хоригдлын эрх.

Abstract: The article describes the concepts, types, and classifications of international norms that regulate prison sentences.

Keywords: imprisonment, prisoner, international standards, rights of prisoners.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тэр дундаа гэмт хэрэг үйлдсэн хүний ял эдлүүлэх ажиллагаа нь олон улсын интеграцчиллын үйл явцад улс орны бодлогын чухал чиглэлийн нэг юм. Энэ төрлийн хамтын ажиллагааны зорилго нь интеграцчиллын хүрээнд ял эдлүүлэх ажиллагааны хамгийн наад захын жишгийг тогтоосон бие даасан хэм хэмжээний тогтолцоо, институцийг бүрдүүлэхэд оршдог. Олон эрдэмтэн, судлаачид хүний эрхийг хамгаалах бүс нутгийн тогтолцоог бий болгох зорилго нь универсал буюу бүх нийтийн тогтолцоог тодорхой улс, бүс нутгийн нөхцөл байдалд дасан зохицоход агуулагддаг гэж үзсэн байдаг. Гэсэн хэдий ч нэг эдийн засгийн бүсэд соёл, түүхэн уламжлалд тулгуурлан үүсдэг бөгөөд хүний эрхийг хамгаалах бүс нутгийн тогтолцоо нь бусад орны улс төр, нийгэм, соёл болон эдийн засгийн түвшинг нэгдмэл болгох зорилготой.

Английн гүн ухааанч, социологич И.Бентамын XVIII зуунд боловсруулсан “паноптикум” буюу “бүхнийг харагч” гэх хорих байгууллагын удирдлагын тогтолцоо нь хорих ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр олон улсын хамтын

ажиллагааны эхлэл болсон гэж үздэг бөгөөд хожим нь энэ загвараар хэд хэдэн хорих ангиуд баригдсан байдаг.

Хорих ял эдлүүлэх ажиллагаа нь Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948 он), Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт (1966 он), эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (1966 он), Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд (1955 он), Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц (1987 он), Хоригдлуудтай харьцах үндсэн зарчмууд (1990 он), Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд (Манделлын дүрмүүд (2015 он)) зэрэг баримт бичгүүд дээр тулгуурладаг.

Үндэсний хууль тогтоомжийг олон улсын баримт бичиг, стандартуудтай нийцүүлэх нь манай улсын гол зорилгын нэг юм. Гэхдээ ял эдлүүлэх системд олон улсын стандартыг хэрэгжүүлэхэд олноор ял эдлүүлэх систем болон улсын эдийн засгийн байдлыг харгалзан үзэх зайлшгүй шаардлагатай.

Олон улсын баримт бичиг болон Монгол улсын Үндсэн хуульд тусгагдсан хүний эрхүүд нь олон улсын нэгдэл, байгууллагуудаар хүлээн зөвшөөрөгдсөн, олон жилийн хугацаанд тогтсон хүний амьдралын жишиг юм.

Сүүлийн жилүүдэд манай орны эрх зүйн тогтолцоо нь олон улсын хэм хэмжээнд нийцүүлэх чиглэлээр нэлээдгүй өөрчлөлт хийгдсэн. Тэр дундаа хоригдлын эрхийг хамгаалах чиглэлээр үндэсний хууль тогтоомжийг олон улсын стандартад нийцүүлэх чиглэлээр хийгдсэн ажлууд юм.

Монгол улсын иргэний эрхийг хангах, хамгаалах нь төрийн үүрэг юм. 1992 оны Монгол Улсын Үндсэн хуульд иргэний эрх болон эрх чөлөөг хуульчилж өгсөн байдаг. Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дугаар хэсэгт зааснаар Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ, 3 дугаар хэсэгт Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ гэж заасан байдаг бөгөөд энэхүү зарчим нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 2.2 зүйлд Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө гэж зааснаар тусгалаа олсон байна.

Монгол улсын Үндсэн хуульд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмыг эрхэмлэн хуульчилсан нь хоригдлын амьд явах эрх, халдашгүй байдал, ял эдлүүлэх ажиллагаа зөвхөн хуулийн хүрээнд явагдах зэрэг хоригдолтой харьцах жишгийг нэвтрүүлсэн гэдгийг онцлох нь зүйтэй.

И.Л. Михеев хоригдлуудтай харьцах хүрээний олон улсын актууд нь нийгмээс тусгаарлагдан хоригдож байгаа иргэний эрхийн хязгаарлалтын хүрээг

тодорхойлсон гэмт хэргийн байдалд хяналт тавих олон улсын актуудын тогтолцооны нэг хэсэг гэж тодорхойлсон байдаг[1].

В.А. Уткин ял эдлүүлэх ажиллагаанд үндэсний хууль тогтоомжоос гадна олон улсын баримт бичгийг дагаж мөрдөх боломжтой гэж тэмдэглэсэн байдаг. Гэхдээ мэдээж тухайн улсын нэгдэн орсон олон улсын гэрээ л хамаарах юм[2].

Олон улсын актыг хэд хэдэн байдлаар ангилдаг байна. Жишээ нь, хоригдлын эрхийн төрлөөс хамаарч С.В. Бакин а) иргэний эрхийг; б) эдийн засгийн эрх; в) нийгмийн эрх; г) соёлын эрхийг зохицуулсан баримт бичгүүд гэж ангилсан[3].

М.Л. Энтин өөр нэг ангиллыг санал болгосон байна:

- хоригдол өөрийн эрхийг эдлэх боломжоор хангасан;

- шүүхийн хамгаалалт авах боломж олгосон[4].

П.Г. Пономарев олон улсын хэм хэмжээг өөр талаас нь мөн ангилсан байна. Жишээ нь, эрүүгийн ял эдлүүлэх системийн үйл ажиллагааны чиглэлээр: хорих ял эдлүүлэх дэглэм; хоригдлын хөдөлмөр эрхлэлт болон бэлтгэл; хоригдлын дунд явуулах хүмүүжүүлэх ажил[5].

В.А. Бажанов, А.Я. Волков, С.И. Курганов хүний эрхийг зохицуулсан олон улсын баримт бичгийг (хоригдол мөн хамааралтай) үйлчлэх хүчин чадлаар нь: заавал дагаж мөрдөх ёстой болон зөвлөмж хэлбэрийн[6]. Тэдний үзэж байгаагаар нэгдүгээр бүлэгт төрийн эрх барих барих дээд байгууллагаар дэмжигдэж нэгдэж орсон пакт, конвенц хамаарах бөгөөд энэ нь тус улсын хувьд заавал дагаж мөрдөгдөх ёстой. Харин дараагийн бүлэгт Нэгдсэн Үндэсний байгууллагын Ерөнхий Ассамблейн батлсан баримт бичгүүд байдаг бөгөөд энэ нь заавал дагаж мөрдөх бус зөвлөмжийн шинжтэй байдаг.

Профессор В.А. Уткин хоригдлын эрх зүйн байдлыг зохицуулсан олон улсын хэм хэмжээг дараах байдлаар ангилдаг байна:

1. Хамрах хүрээгээр нь – нийтлэг болон тусгай. Нийтлэг нь тусгайлан хоригдлын эрхийн талаар баталсан баримт бичиг биш бөгөөд зөвхөн зарим

---

[1] Михеев И.Л. Международные стандарты защиты прав осужденных. Саратов, 2010. 37 тал.

[2] Уткин В.А. Международное право борьбы с преступностью: учеб. пособие. Томск, 2017. 145 тал.

[3] Бакин С.В. О классификации прав человека, провозглашенных в международных соглашениях // Правоведение. 1991. №2. 42 тал.

[4] Энтин М.Л. Международные гарантии прав человека. М., 1992. 136 тал.

[5] Пономарев П.Г. Международно-правовые стандарты обращения с заключенными и национальные варианты их реализации. Рязань. 1994. 15 тал.

[6] Бажанов В.А., Волков А.Я. Правовое положение осужденных. Минск, 1983. 6 тал; Курганов С.И. Уголовно-исполнительное право: учеб. пособие. М., 2004. 105-106 тал.

зүйлүүд дээр л хоригдлын талаар л дурдсан байдаг. Харин тусгай нь хорих байгууллагад хоригдож байгаа этгээдүүдийн талаар баталсан эрх зүйн актууд юм.

2. Дагаж мөрдөх хэмжээгээр нь – үндэсний тогтолцоонд заавал дагаж мөрдөх ёстой болон зөвлөмжийн шинжтэй хэм хэмжээнүүд. Заавал дагаж мөрдөх гэдэгт төрийн дээд байгууллагын дэмжсэн нэгдэн орсон олон улсын пакт, конвенц болон бусад баримт бичгүүд (жишээ нь, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц (1987 он), Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт (1966 он), Монгол улсын бусад гадаадын улсуудтай байгуулсан олон улсын гэрээ). Зөвлөмжийн шинжтэй баримт бичгүүдэд Хүний эрхийн түгээмэл тунхаг (1948 он), Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд (1955 он), Европын пенитенциар дүрмүүд (2006 он) зэрэг бусад баримт бичгүүдэд агуулагдсан хэм хэмжээнүүд хамаардаг юм. Эдгээр баримт бичгүүд хууль зүйн хувьд заавал дагаж мөрдөх шаардлагагүй хэдийн ч олон улсын холбоодоор өргөнөөр хүлээн зөвшөөрөгдсөн байдаг.

3. Үйлчлэх хүрээгээр нь (газар нутгийн) – дэлхий нийтийн болон бүс нутгийн. Эхнийх нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаар батлагдан олон улсын холбоодод түгээгддэг. Хоёр дахь бүс нутгийн олон улсын байгууллага, нэгдлүүд, холбоодоор батлагддаг.

Бидний үзэж байгаагаар хамгийн сүүлийн ангилал нь хамгийн илүүгээр, тодорхойлсон байна.

Олон улсын баримт бичгийн гол зорилго нь дэлхийн аль ч улсад хоригдлууд эрх, эрх чөлөөгөө эдлэх адил боломжоор хангагдсан нэгдсэн бодлого бүхий хуулийг бүрдүүлэх юм.

И.В. Шмаровын үзэл бодолтой санал нийлэх нь зүйтэй. Тэрээр хүний эрхийг хамгаалах, хоригдлуудтай харьцах талаар заавал дагаж мөрдөх олон улсын баримт бичигт тусгагдсан зарчмууд нь 1) олон улсын шинж чанартай бөгөөд аливаа улсад үүссэн улс төрийн, эдийн засгийн, гэмт хэргийн нөхцөл байдлын сөрөг нөлөөнд өртөлгүйгээр тогтвортой байдлыг хадгалдаг; 2) НҮБ-ын гишүүн орнуудын олон жилийн туршлагад тулгуурлан боловсруулагдсан байдаг тул үндэсний хууль тогтоомжийг боловсруулахад чиглүүлэгч болж өгдөг[7].

Хоригдлын эрх зүйн байдлыг хөндсөн хүний эрхийн олон улсын гэрээ, хэлэлцээрүүд олон байдаг ба эдгээр баримт бичгүүд нь дэлхийн дийлэнх орны үндэсний хууль тогтоомжид нэвтрүүлэх боломжтой байдаг. Олон улсын хамтын

[7] Шмаров И.В. Разработка уголовно-исполнительного законодательства в сфете международных соглашений о защите прав человека и документов ООН, определяющих принцип обращения с осужденными // Сов. гос-во и право. 1990. №11. 39-40 тал.

ажиллагааны байгууллагуудын үйл ажиллагааны практик үр дүн нь олон улсын актууд байдаг.

Хоригдлын эрх зүйн байдлыг зохицуулсан олон улсын актуудад дараах баримт бичгүүд хамаардаг: Хоригдлын эрх зүйн байдал нь Хүний эрхийн түгээмэл тунхаг (1948 он), Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт (1966 он), эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (1966 он), Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд (1955 он), Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц (1987 он), Хүний эрх, эрх чөлөөний европын конвенц (1950 он), Хоригдлуудтай харьцах үндсэн зарчмууд (1990 он), Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд (Манделлын дүрмүүд (2015 он)) зэрэг баримт бичгүүд юм.

Чухам эдгээр баримт бичгүүд нь хорих байгууллагад байгаа хүний эрх зүйн байдлыг үндсээр нь өөрчилж олон улсын түвшинд гаргасан байна. Гэхдээ мэдээж эдгээр баримт бичгүүдэд улс орнууд цаг хугацааны хувьд харилцан адилгүй хугацаанд нэгдсэн байдаг.

В.Н. Белик олон улсын баримт зарим талаараа нэг талыг баримталсан байдаг гэж тэмдэглэсэн байдаг. Эдгээр баримт бичгүүдэд хоригдлын эрхийг хамгаалах, хэрэгжүүлэх баталгааны талаар тусгасан байдаг[8]. Олон улсын холбоо, хамтын ажиллагааны байгууллагууд ч хоригдлуудтай хүнлэгээр харьцах, ял эдлүүлэх ажиллагаанд хүнлэг байх зарчмыг хангахаар эрмэлздэг. Үүнтэй холбогдуулан В.А. Уткин эдгээр зарчмууд нь бүх орнуудад, тэдний эдийн засгийн байдал, газар зүйн байрлал, цаг агаарын нөхцөл байдал, үндэсний соёлын болон шашны уламжлалаас үл хамааран заавал дагаж мөрдөгдөх ёстой гэж тэмдэглэсэн байдаг[9].

Дээрх баримт бичгүүдийн хэм хэмжээнүүд нь хоригдлын эрх зүйн байдал зохицуулсан үндэсний хууль тогтоомжийг хөгжүүлэх үүрэгтэй байдаг ба хүнлэг болон хөгжлийн шинж чанартай зөвлөмжүүдийг агуулсан байдаг. Эдгээрийн мөн чанар нь хоригдлууд амьд явах, нэр хүндээ хамгаалуулах зэрэг эрхтэй байдагт оршдог юм. Тус эрхүүдийн агуулгын хувьд юуны өмнө эрүүдэн шүүх, хүч хэрэглэх, хүний нэр төрийг гутаан доромжлохыг хориглохыг хамааруулах нь зүйтэй. Гэвч хоригдлуудтай хууль бусаас харьцахыг хориглосон олон баримт бичгүүд байдаг хэдий ч тэднээс зохих байгууллагуудад өргөдөл, гомдол ирсээр байгаа юм.

[8] Белик В.Н. Обеспечение правовой защиты осужденных к лишению свободы: автореф. дис. ... д-ра юрид. наук. Рязань, 2014. 24 тал.
[9] Уткин В.А. Международное право борьбы с преступностью: учеб. пособие. 147 тал.

Олон улсын хэлэлцээрүүд хоригдлын эрхийн байдлыг хөндсөн байдаг бөгөөд оролцогч орнууд дагаж мөрдөх ёстой байдаг.

Хоригдол хорих ял эдэлж байгаа ч гэсэн нийгмийн бүрэн эрхт гишүүн хэвээр үлддэг ба бусад хүмүүсийн эдэлдэг эрхүүдийн дийлэнхийг эдэлдэг. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 16 дугаар зүйлд Хүн бүр хаана ч эрх зүйн чадвартай байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй гэж[10] . Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүдийн 61 дүгээр зүйлд Хоригдлуудтай харьцахад тэднийг нийгмээс тусгаарласан хэдий ч нийгмийн гишүүн хэвээр үлдэнэ гэдгийг тодруулах нь зүйтэй гэж заасан байдаг[11].

Бидний судалж байгаа сэдвийн хүрээнд олон улсын баримт бичгүүдийн хэм хэмжээг үндэсний хууль тогтоомжид нэвтрүүлэх явдал юм. Монгол Улсын Олон Улсын гэрээний тухай хуульд олон улсын хэм хэмжээг үндэсний эрх зүйн системд хэрэгжүүлэх 2 замыг заасан байдаг. Тухайлбал, 5.1 дүгээр зүйлд Олон улсын гэрээг Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, тухайн гэрээний үндэслэл, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчимд нийцүүлэн байгуулна, 26 дугаар зүйлд Хоёр талт болон олон талт олон улсын гэрээнд тухайн гэрээний зохицуулалт болон гэрээний нөгөө тал, эсхүл бусад талтай харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулна гэсэн байна[12].

Олон улсын баримт бичгүүдийн хэм хэмжээг үндэсний хууль тогтоомжид нэвтрүүлэхэд тухайн улсын улс төр болон эдийн засгийн нөхцөл байдлаас хамааралтай. Манай орон Зөвлөлт холбоот улсын жишгээр явсан социалист лагерийн улсуудын нэг болохын хувьд эрүүгийн ял эдлүүлэх систем нь тодорхой хэмжээгээр хаалттай байсан нь олон улсын стандартыг нэвтрүүлэх шаардлага байгаагүй гэж үзэж болох юм.

Энэхүү байдал нь Монгол Улсын ардчилсан Үндсэн хууль батлагдсанаар өөрчлөгдсөн юм.

Гэхдээ Монгол Улсын ял эдлүүлэх систем нь бүрэн хэмжээнд олон улсын жишигт нийцэж, тавигдах олон улсын стандартад тавигдах шаардлагыг бүрэн хангаж байгаа гэж хэлэх боломжгүй. Оросын Холбооны Улсын эрдэмтэд бүх орнуудын эрүүгийн ял эдлүүлэх хууль тогтоомжид олон улсын стандартыг нэвтрүүлэхэд хүндрэл учруулдаг хүчин зүйлүүдийг тодорхойлсон байдаг:

---

[10] Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт 1966 // Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл 2014. 15 тал.

[11]Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд 1955 // https://www.un.org/ru/documents/decl_conv/conventions/prison.shtml

[12] Олон улсын гэрээний тухай хууль 2016 // Төрийн мэдээлэл эмхэтгэл 2017. № 02.

- Эдийн засгийн уналт болон үүнтэй холбогдсон материаллаг, санхүүгийн нөөцийн хязгаарлагдмал байдал;

- Гэмт хэргийн өсөлт, үүнийг дагаж хоригдлын тоо өсдөг;

- Сэтгэцэд нөлөөлөх болон мансууруулах бодис хэрэглэгчдийн өсөлт, БЗХӨ өвчлөгчдийн өсөлт;

- Хоригдол болон хорих байгууллагын алба хаагчдын таагүй харьцаа, эрүүгийн ял эдлүүлэх байгууллагын мэргэжлийн албаны нэр хүнд буурах[13].

Эдгээрээс гадна үндэсний онцлогоос шалтгаалсан хүчин зүйлүүд ч байдаг бөгөөд Монгол улсад олон улсын стандартыг хэрэгжүүлэхдээ манай улсын үндэсний, түүхийн болон нийгмийн хөгжлийн онцлогийг харгалзан үзэх хэрэгтэй.

Юуны өмнө хорих ялын мөн чанар хамааралтай. Монгол улсад ч тэр Барууны улсуудад ч тэр хорих ялын шинж чанар нь хорих байгууллагын төрлөөр тодорхойлогддог. Барууны пенитенциар системд энэ нь шоронгууд байдаг. Үүнээс Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд үндэслэн гэж үзэж болно. Монгол Улсын хувьд хорих ял нь хоригдлыг нийгмээс тусгаарлаж тусгай хүмүүжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагад байлгахтай холбоотой ял юм. Монгол Улсын хорих байгууллагын төрөл нь барууныхаас ялгагдсан байсан. Хөгжлийн хувьд манай улсын хорих байгууллага нь ОХУ-ын туршлагаас суралцаж колоний системтэй байсан бөгөөд засан хүмүүжүүлэх анги, хөдөлмөрийн лагерь гэх зэрэг юм.

Колоний систем нь казармын зохион байгуулалтаар хэсэг бүлэг хоригдлуудыг хамтад нь байлгах, хүмүүжүүлэх ажлыг хөдөлмөртэй шууд холбодог. Харин шоронгийн системийн хувьд камерын зохион байгуулалттай, бүлгээр бус ганц, ганцаар хорих явдал юм.

Монгол Улсын эрүүгийн ял эдлүүлэх системд олон улсын стандартыг хэрэгжүүлэхэд ял эдлүүлэх ажиллагааны материаллаг, ахуйн нөхцөлийн өөрчлөлт, ард иргэдийн нийгэм эдийн засгийн бодит байдлыг харгалзан үзэхгүй байх боломжгүй. Хорих байгууллагын материаллаг, ахуйн нөхцөл нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцтэй зөрчилдөх ёсгүй юм.

Дээр дурдсанаас гадна манай улсын үндэсний хууль тогтоомжид олон улсын стандартыг нэвтрүүлэхэд дараах хүчин зүйлс хүндрэл учруулж байна:

---

[13] Уткин В.А. Международные стандарты обращения с осужденными и проблемы их реализации. 74 тал; Зубков А.И. Уголовно-исполнительное право России: теория, законодательство, международные стандарты, отечественная практика конца XIX – начала XX века : учебник для вузов. 683 тал.

- Нийгэм, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл;

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төсөв, орон тооны дутагдалтай байдал, чадварлаг хүний нөөцийн дутмаг байдал.

1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглал нь хүний бүхий л эрх, эрх чөлөөг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой байдлыг тунхагласан суурь баримт бичиг юм. Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчлалгүйгээр хуулиар хамгаалуулах эрхийг тухайн баримт бичгээр тунхаглагдсан байдаг.

1966 оны Иргэний болон улс төрийн эрхийн фактын 10 дугаар зүйлд хоригдлуудтай хүнлэг байдлаар харьцахыг тунхагласан “Эрх чөлөөгөө хасуулсан бүх хүнтэй хүнлэг харьцаж, угаас заяасан нэр төрийг нь хүндэтгэнэ”[14]. Энэ хэм хэмээ нь шууд хэрэгжих хэлбэртэй.

Олон улсын стандартуудын нөлөөгөөр Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль тогтоомжид хоригдлын эрх зүйн байдлын үндэс, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас хамгаалсан баталгаа тусгагдсан. Монгол Улсад өрнөсөн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хоригдлуудын ял эдлэх нөхцөлийг тэдэнтэй хүнлэгээр харьцах олон улсын стандартад ойртуулсан гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.Үүнийг 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн тодорхой заалтуудад дүгнэлт хийснээр харж болох юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 210 дугаар зүйлд хоригдлын эрхүүдийг тодорхой зааж өгсөн байдаг. Хоригдлууд Монгол Улсын иргэний эрхийг тодорхой хязгаарлалттайгаар эдэлдэг. Энэ нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 29 дүгээр зүйлд заасан “Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ гагцхүү бусдын эрх, эрх чөлөөг зохих ёсоор хүлээн зөвшөөрч хүндлэх, мөн ардчилсан нийгмийн ёс суртахууны шударга шаардлага, нийгмийн хэв журам, ерөнхий сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосноос өөр хязгаарлалтад өртөгдөх ёсгүй” гэсэн агуулгад нийцэж байгаа юм[15].

Манай оронд нүүрлээд байгаа эдийн засгийн хүндрэлтэй байдал нь эрүүгийн ял эдлүүлэх системд оруулах хөрөнгө оруулалтыг хэмжээг буруулж хоригдлуудыг байрлуулах материаллаг, техникийн орчныг дээшлүүлэх боломжийг хязгаарлаж байгаа юм.

---

[14] Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт 1966 // Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл 2014. 12 тал.

[15] Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1948 // Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл 2014. 8 тал.

Одоогийн байдлаар Монгол Улсад эрх зүйн шинэчлэл хийгдэж байгаа ба энэхүү шинэчлэл нь эрүүгийн ял эдлүүлэх системийг ч багтаагаад байгаа юм. Гэхдээ эрүүгийн ял эдлүүлэх системийн шинэчлэлийн шаардлагыг анхааралдаа авах хэрэгтэй хэдий ч олон улсын стандартыг хэрэгжүүлэхдээ өнөөгийн нөхцөл байдал, түүхэн онцлог болон улсын гэмт хэргийн нөхцөл байдлыг харгалзан үзэх хэрэгтэй.

Хоригдлуудтай харьцах олон улсын стандартууд нь Монгол Улсын эрүүгийн ял эдлүүлэх бодлогыг боловсронгуй болгох чиглэлийг тодорхойлж өгснийг тэмдэглэх нь зүйтэй.

Эрүүгийн ял эдлүүлэх системийн шинэчлэлийн хувьд Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 193 дугаар тогтоолоор Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй болон хаалттай тогтолцоонд шилжүүлэх хөтөлбөр батлагдсан бөгөөд 2011-2018 он хүртэл хугацаанд олон улсын стандартад нийцсэн нээлттэй, хаалттай төрлийн тус бүрдээ 1500 хоригдлын багтаамжтай төвлөрсөн хорих ангийг байгуулахаар төлөвлөсөн байдаг[16]. Үүнээс харахад Монгол Улсын эрүүгийн ял эдлүүлэх систем нь шоронгийн системийн туршлагыг нэвтрүүлэх боловч колоний систем буюу олноор байрлуулах тогтолцооны уламжлалыг хадгалсан хэлбэртэй байх болов уу гэж төсөөлөгдөж байна.

Олон улсын стандартыг практик дээр хэрэглэхтэй холбоотой хэд хэдэн асуудлыг нэрлэж болох юм: хорих байгууллагын алба хаагчдыг хоригдлуудтай хүнлэг байдлаар харьцахад чиглүүлэн сэтгэл зүйг өөрчлөх, эрүүгийн ял эдлүүлэх системийн хаалттай байдлыг даван гарах зэрэг. Мэдээж эдгээр асуудлыг шийдвэрлэхэд эдийн засгийн болон бусад нөхцөл байдлууд бүрдсэн байх шаардлагатай.

Үүнээс гадна Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль тогтоомжид хоригдлын эрхтэй холбогдолтой олон улсын стандартыг хэрэгжүүлэхэд дараах хүчин зүйлс хүндрэл учруулж байна:

- Эрүүгийн ял эдлүүлэх системийн төсвийн хангалтгүй байдал;
- Олон улсын стандартад бүрэн нийцсэн хорих байгууллагын дутмаг байдал, хорих байгууллагуудын хот, суурин газраас алслагдмал байрлал;
- Өндөр мэргэжлийн, бэлтгэгдсэн алба хаагчдын дутмаг байдал, ажлын байрны тодорхойлолтод нийцээгүй алба хаагчид ажиллаж байгаа байдал.

[16] Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэх хөтөлбөр // https://www.legalinfo.mn/annex/details/6205?lawid=9788)

Ял эдлүүлэх ажлын хүрээн дэх төрийн бодлогын өөрчлөлт нь төрийн болон төрийн бус байгууллагуудын анхаарлын төвд байхаас гадна нийгмийн бүхий л давхаргын анхаарлыг татсаар байна.

Мэдээж өнөөдрийн байдлаар Монгол Улсын ял эдлүүлэх систем нь олон улсын стандартад бүрэн нийцэж байна гэж хэлж болохгүй. Дэлхийн аль нэг орон өөрийн ял эдлүүлэх системийг олон улсын стандартад бүрэн нийцэж байна гэж зарлахгүй л байх. Эрүүгийн ял эдлүүлэх системийн практикт олон улсын стандартыг нэвтрүүлэх нь ганц удаагийн ажил биш бөгөөд маш олон хүчин зүйлээс хамаарсан урт хугацааны ажил юм. Хамгийн түрүүнд улсын эдийн засгийн нөхцөл байдал, хоригдлын эрхийг хангах чиглэлээр шинэчлэл хийх төрийн бодлогоос шалтгаална.

Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль тогтоомжийг хоригдлуудтай харьцах олон улсын стандартуудтай харьцуулан үзэхэд манай улсын хууль тогтоомж хоригдлын түр хугацааны уулзалт, захидал харилцаа, хорих байгууллагын алба хаагч, эрх бүхий албан тушаалтны зүгээс хүнлэг харьцах, эсхүл хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжилж харьцахгүй байхыг шаардах, хорих ангийн захиргаагаар дамжуулан өөрт холбогдох асуудлаар өргөдөл, гомдол гаргах, өдөр тутмын сонин, сэтгүүл захиалах зэрэг хүрээний агуулгаар олон улсын стандартад бүрэн нийцэж байгааг онцлох нь зөв юм.

Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хоригдлын эрх зүйг байдлыг тодорхойлсон зүйл байгаа нь эрүүгийн ял эдлүүлэх бодлогын хүнлэг байдал, хорих байгууллагын практикийг олон улсын стандартад нийцүүлэхэд ойр байгаа нь харагдаж байна.

Монгол Улсын эрүүгийн ял эдлүүлэх систем нь үе шаттайгаар барууны ял эдлүүлэх системд шилжиж байгааг онцлох нь зүйтэй. Гэвч эрүүгийн ял эдлүүлэх системд олон улсын стандартыг нэвтрүүлэхэд Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан үзэхгүй байх боломжгүй. Учир нь барууны систем нь хоригдлуудыг тусад нь нэг нэгээр нь байрлуулахыг шаарддаг бөгөөд энэ нь илүү үнэтэй ажиллагаа юм. Монгол Улсын эрүүгийн ял эдлүүлэх системийн өмнө дийлэнх хорих ангиудыг шоронгийн хэлбэрт шилжүүлэх маш хүнд даалгавар байгаа бөгөөд энэ маш их хугацааг шаардах юм.

---o0o---

ХОРИГДЛЫГ СУЛЛАХАД БЭЛТГЭХ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД АНХААРАХ АСУУДАЛ

PROGRAM TO PREPARE PRISONER FOR RELEASE THE PROBLEM OF FOCUSING ON APPLICATIONS



Н.Анар
Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, хошууч

Товч утга: Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан А/167, А/233 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалын хэрэгжилт, суллахад бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлын талаар.

Түлхүүр үгс: Нийгмийн ажил, суллахад бэлтгэх хөтөлбөр, хоригдол, нийгмийн ажилтан.

Abstract: Work carried out within the framework of the Programme for the Application and Release of the Order of A/167, A/233, coordinated by the Minister of Social Protection, legal and interior ministers.

Keywords: Social work, a program to prepare for release, a prisoner and a social worker.

Оршил

Хорих байгууллагын үйл ажиллагаанд нийгэмшүүлэх арга хэмжээ хэрэгжиж эхлээд 20 гаруй жил болж байгаа хэдий ч давтан гэмт хэрэг буурахгүй байгаа нь хоригдлыг суллахад бэлтгэх чиглэлээр үйл ажиллагаа хангалтгүй, дагнасан хөтөлбөргүй байгаатай холбон тайлбарлаж болох юм.

Өнөөгийн байдлаар хоригдлыг нийгэмшүүлэх чиглэлээр зөвхөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар хязгаарлахгүйгээр хорих байгууллагаас суллагдсан хүнд тавих хяналт, бусад чиглэлээр дараах хууль тогтоомжид тусгалаа олсон байна. Тухайлбал:

1. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт, 12.2 дахь хэсэгт “хорих болон засан хүмүүжүүлэх байгууллагад хоригдож байгаа залуучуудад зориулсан сэтгэл заслын үйлчилгээ, соёл, спорт, хүмүүжлийн арга хэмжээг холбогдох мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор

залуучуудын болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх";

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 15.1.2-т "хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан иргэнийг үйлдвэрлэл дээрээ дадлагажуулан үндсэн ажилтнаар нэг жилээс доошгүй хугацаагаар үргэлжлүүлэн ажиллуулж байгаа ажил олгогчид дадлагын хугацааны сургалтын зардлыг нөхөн олгож, нэг жилийн цалин хөлстэй тэнцэх хэмжээний санхүүгийн дэмжлэгийг ажилтан, ажил олгогч тус бүрд нь нэг удаа олгох", 15.1.5-т "хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан иргэнийг ажлын байраар хангаж, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх талаар тодорхой санаачилга гаргаж, үр дүнд хүрсэн ажил олгогчийг тусгай болзлын дагуу Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл шалгаруулж, урамшуулах";

3. Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5-т "онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн; дор дурдсан өрх, иргэнд олгох";

4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын 44.4-т "зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг хорих ял шийтгүүлсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, баривчлах, албадан сургалтад хамруулах шийтгэл хүлээсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаагийн байгууллага зохион байгуулах".

5. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9.2.2-т "гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор гэмт хэрэг үйлдэж, хорих ял шийтгүүлж суллагдсан хүнд хяналт тавих", 9.2.3-т "гэмт хэрэг үйлдэж болзошгүй нөхцөлд байгаа болон хорих ял шийтгүүлж, суллагдсан этгээдэд нийгэмд дасан зохицох, нийгмийн амьдралд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэх", 9.2.5-д "гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээдийн зан байдалд нөлөөлөх, хуулийг чандлан сахих дадал төлөвшүүлэх, хорих байгууллагад байх хугацаанд боловсрол, ажил хөдөлмөр эрхлэх дадал, туршлага олгох, суллагдсаны дараа нийгэмд дасан зохицох шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох";

6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 218.1-д "хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын хүрээнд хоригдол хорих ангид ял эдлэх бүхий л хугацааг хамарсан, хоригдолд нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ", 219.1-д "хоригдлыг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон хүсэл, сонирхолд нь үндэслэн эерэг зан үйлд төлөвшүүлэх бусад хэлбэрээр нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулна";

7. Нийгмийн ажлын аргачилсан зааварт “хорих байгууллагын нийгэмшүүлэх ажил гэж хоригдол нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход нь дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээ” “нийгэмшүүлэх ажлын үе шат гэж хорих ангид хүлээн авч хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил, хорих өрөөнд хуваарилан хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил, суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажил” зэргээр зохицуулсан байдаг.

Үндсэн хэсэг

Дэлхийн улс орнуудын эрүүгийн ялын гүйцэтгэлийн бодлого, үзэл баримтлалдаа тусган, хэрэгжүүлж буй нэг үндсэн асуудал нь хорих ял шийтгэгдсэн этгээдийг нийгэмшүүлэн, дахин гэмт хэрэг үйлдэх явдлаас урьдчилан сэргийлэхэд оршиж байна.

Монгол Улсын Хорих байгууллагын үйл ажиллагаанд хоригдлыг нийгэмшүүлэх арга хэмжээ хэрэгжиж эхэлснээс хойш даруй 20-д жил болсон хэдий ч давтан гэмт хэрэг буурахгүй байгаа нь хоригдлыг суллахад бэлтгэх чиглэлээр үйл ажиллагаа хангалтгүй, дагнасан хөтөлбөргүй байгаатай холбон тайлбарлаж болох юм.

Нийгмийн ажлын гол зорилго нь нийгмийн асуудалтай, тусламж дэмжлэг хэрэгтэй байгаа хүмүүст туслах явдал байдаг. Хорих байгууллагад явуулах нийгмийн ажлын үйлчилгээ нь хорих байгууллагын зүгээс хоригдолд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг үе шаттай, үр дүнтэй явуулснаар тэднийг нийгэмшүүлэх буюу нийгэмд нь эргэн нэгтгэх (resocialization, reintegration into society), суллагдахаас өмнө эрх чөлөөт амьдралд нь бэлтгэх, суллагдаж гараад дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдэн явагддаг.

Манай улсын хувьд хорих байгууллага дахь “нийгмийн ажил”, “нийгэмшүүлэх” гэсэн нэр томьёо, ойлголт 2017 онд шинээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /ШШГТХ/ батлагдах хүртэл “салбарын хуульд тусгаагүй” бөгөөд “хорих байгууллага дахь нийгмийн ажил”, “нийгмийн ажилтан” гэсэн бие даасан ажил, мэргэжлийн ойлголт 2003 оноос л бүрэлдэн бий болсон байна[17] .

Гадаадын зарим орон, тухайлбал Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад Хорихоос суллагдах нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны нэгэн чухал хэсэг тул бэлтгэл ажлыг хэрхэн хангах талаар хуульчилсан байдаг. Чөлөөт амьдралд зугуухан орох бэлтгэл хангахын тулд хорих дэглэмийг зөөлрүүлж болох ба суллагдахаас гурван сарын өмнө 7 хоногийн чөлөө олгох, мөн хорих байгууллагаас гадуур чөлөөтэй явах эрхтэй ялтанд сар бүр 6 хоногийн чөлөө олгодог.

[17] ШШГЕГ-аас 2003 онд зохион байгуулсан төв, орон нутгийн хорих ангийн дарга, ахуй дэглэмийн байцаагч нарын нэгдсэн зөвөлгөөнөөс “нийгмийн ажилтан” гэсэн нэр томьёог хэрэглэхээр тогтсон.

Суллагдсан хүмүүсийн 40 хувь нь эхний 5 жилд ямар нэгэн хэмжээгээр хууль давтан зөрчдөггүй гэсэн тооцоо гарсан нь Германы шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажлын амжилт гэж үздэг.

Хуулийн дагуу суллагдсан хүнд ажил, орон байр олгодог. Суллагдсаны дараа очих газар хүртэлх замын зардал, мөн ажлын хөлснийх нь хуримтлал, шаардлагатай бол хувцас олгодог. Гэр бүлийнхэнтэй нь холбож өгөх, ажил, орон сууцны зэрэг асуудал шийдвэрлэхийг нийгмийн ажилтан хариуцан гүйцэтгэнэ.

Суллагдахаас 6-9 сарын өмнө ялтныг хагас чөлөөт байдалтай ангид ирүүлдэг. Нэг өрөөнд 1-3 хүн байрлана. Энд ирсэн хүн суллагдсаны дараа хийх ажлаа өөрөө хайж олохоор ажиллах ба эс бүтвэл нийгмийн ажилтны туслалцааг авна. Зохих ажил олоогүй нөхцөлд ямар нэгэн байгууллагад ажиллахаар хөдөлмөрийн гэрээ байгуулж, хөлсний ажилчны маягаар ажиллах бөгөөд цалингийн 15 хувийг тухайн хүнд өгч бусдыг байр сууц зэргийн зардалд суутгана. Ялтан ар гэрийнхэн болон танил талтайгаа уулзаж тэднийг байрандаа хүлээн авах бололцоотой бөгөөд үүнд хөндлөнгийн ямар нэгэн хяналт шалгалт тавигддаггүй. Чөлөөт цагаараа захиргаанаас чөлөө авч гадуур явж болох бөгөөд энэ нь 22 цаг 30 минут хүртэл зөвшөөрөгддөг.

Энд байх хугацаанд явагдах хүмүүжлийн ажил нь хэсэг бүлгээр нь зохиох ярилцлага бөгөөд үүнийг нийгмийн ажилтан, эсхүл сэтгэл зүйч долоо хоногт хэд хэдэн удаа зохион байгуулдаг.

Японд ялтныг ялын хугацаанаас өмнө суллахдаа олон нийтийн байгууллагатай хамтарсан нийгэмшүүлэхэд чиглэсэн идэвхтэй үйл ажиллагаа явуулсны дараагаар сулладаг. Энэхүү үйл ажиллагаа нь тухайн ялтныг суллагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой бөгөөд тухайн ялтан “Чин сэтгэлийн ухаарал” олсон байх нь ялын хугацаанаас өмнө суллах үндэслэл болдог. Энэхүү ажиллагаа нь зөвхөн ялын хугацаанаас өмнө суллагдах ялтанд чиглэдэггүй, ялын хугацаанаас өмнө суллагдаад нийгмийн дунд амьдарч байгаа хүмүүст зөвлөгөө өгч тэдэнтэй хамтран ажиллахад чиглэдгээрээ онцлогтой.

Ялтнууд “Чин сэтгэлийн ухаарал” олсон байх нь маш чухал бөгөөд ингэж ухаарснаараа тухайн ялтан дахин гэмт хэрэг үйлдэх магадлал нь буурч, ялын хугацаанаас өмнө суллагдсаны дараа эрүүгийн ял эдлүүлэх байгууллагаас явуулдаг аливаа хөтөлбөрт идэвхтэй оролцож, хариуцлагатай ханддаг.

Японы хорих байгууллагын холбоо нь суллагдсан ялтныг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготойгоор төрөл бүрийн дэмжлэг үзүүлэх, хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг Засгийн газрын бодлогод тусгаж өгсөн. Жишээ нь; 2015 онд анх санаачилж, 2016 онд дахин шинэчилсэн “Үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Гэмт хэрэг дахин бүү үйлд, тэднээр гэмт хэрэг дахин бүү үйлдүүл”, “Илүү гэрэл гэгээтэй нийгмийг байгуулахын тулд нийгмийн гишүүн бүр нийгэмшүүлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцъё” уриатай хөтөлбөр юм. Эдгээр хөтөлбөрүүд дараах 10 асуудалд илүү анхааран ажилладаг. Тухайлбал,

1. Ялтанд чиглэсэн илүү үр дүнтэй засан хүмүүжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх;

2. Ялтныг суллагдсаны дараа тэднийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх

3. Насанд хүрээгүй ялтнуудад төрөлжүүлсэн боловсрол олгох;

4. Өндөр настай ялтнуудад чиглэсэн тусгай засан хүмүүжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх;

5. Эрүүгийн ял эдлүүлэх байгууллагад ажиллаж байгаа эмэгтэй алба хаагчдыг урам зоригтойгоор ажлаа хийхэд нөлөөлөх зорилгоор эрх зүйн байдлыг дээрдүүлэх;

6. Хорих ангийн удирдлагууд нээлттэй, ил тод байдлыг дэмжин ажиллах;

7. Нийтийн дунд тархсан хорих ангийн талаарх таагүй ойлголтыг тайлбарлан сурталчилж сайжруулах;

8. Газар хөдлөлтөд тэсвэртэй хорих анги барьж байгуулах;

9. Хорих анги дахь эрүүл мэндийн үйлчилгээг улам сайжруулах;

10. Хорих ангид ажилладаг офицеруудын үүргийн талаарх ойлголтыг сайжруулахаас гадна тэдний албан үүргээ гүйцэтгэх орчин, нөхцөл, хангамжийг улам сайжруулах чиглэлийн ажил багтана.

Өнөөгийн хорих ял эдлүүлэх ажиллагааны нөхцөл байдлыг харгалзан хорих ангиас суллагдаж буй хоригдлыг нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцох, өөрт холбогдох шийдвэрийг хууль тогтоомжийн хүрээнд бие даан гаргах чадварыг эзэмшүүлэх зорилгоор Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 10 дугаар сарын 14 өдрийн А/148 дугаартай тушаалаар Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн ажлын хэсэг байгуулагдан “Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөр”-ийг боловсруулж 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын А167, А/233 дугаар хамтарсан тушаалаар уг хөтөлбөрийг баталж оролцогч байгууллагад хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосон байдаг.

Өмнө хорих ял эдэлж байсан 502 хоригдлоос суллагдсаны дараа төрөөс ямарваа нэгэн халамжид хамрагдаж байсан эсэх талаарх асуулгад 502 хоригдлын 427 нь буюу 85% нь байгаагүй, 75 нь буюу 15% нь тодорхой хэлбэрээр байсан гэж хариулсан нь хоригдолд энэ талаарх мэдлэг хомс байгааг харуулж байна.

Зураг 1. Хорих ангиас суллагдсаны дараа төрөөс үзүүлж буй халамжид хамрагдсан эсэх талаарх судалгааны дүн:

Хорих ангиас суллагдан бэлтгэхэд чиглэгдсэн ямар арга хэмжээ авбал зүйтэй вэ? гэсэн асуултад 501 хоригдол хамрагдсанаас 181 буюу 36,1% нь мэргэжил эзэмшүүлэх, 64 буюу 12,7% нь сургалтад хамруулах, 203 буюу 40,5% ажилд зуучлах, 47 буюу 9,3% ар гэртэй нь холбон зуучлах, 6 нь 1,1% нь бусад арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар санал гаргасан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Сургалт, нийгэм сэтгэл зүйн хэлтсийн тайлангаас үзвэл:

-“Суллахад бэлтгэх байр”-ыг нэг загвар, стандартаар байгуулах зураг төсөл, санхүүгийн зардлын тооцоог гаргуулах;

-“Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх, нийгмийн ажил, үйлчилгээнд салбар дундын оролцоог нэмэгдүүлэх, үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилго бүхий 2023-2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулан, Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлсэн;

- ШШГЕГ-ын аймаг, нийслэл дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих анги, байгууллагуудад хөтөлбөрийн тухай хүргүүлсэн, зэрэг анхан шатны үйл ажиллагааг эхлүүлэх суурийг нь тавьж ажилласан нь харагдаж байна.

Цаашид уг хөтөлбөрийг иргэдийн оролцоо, төрийн болон төрийн бус байгууллагуудтай уялдаа холбоо, нэг зорилгын үүднээс хамтарч ажиллахыг алба нэгж бүр төлөвлөгөөндөө тусган хөтөлбөрийн үр дүнг гаргах, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгамдаж байгаа асуудлыг нээн илрүүлж тухай бүрд нь асуудлыг шийдэх нь уг хөтөлбөрийн давуу тал гэж үзэж байна.

Цаашид хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор дараах ажлыг эрчимжүүлэх хэрэгтэйг судлаачийн зүгээс үзлээ.

- ШШГЕГ-ын харьяа анги албатуудад уг хөтөлбөрийг сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах, зөвхөн албан бичгээр бус харилцан ажиллах санамж бичиг байгуулж ажиллах;

- Хөтөлбөрийг иргэдэд таниулах төрийн бус байгууллагыг хөтөлбөрт татан оролцуулах, хамтарч ажиллах;

- Холбогдох төрийн байгууллагад уг хөтөлбөрийг таниулах, сурталчлах ажлуудыг төлөвлөгөөнд тусган биелэлтийг үр дүнтэй гаргаж хэвших;

- Суллахад бэлтгэх өрөөг байр болгон өргөжүүлэх, техник хэрэгслийг бий болгох зэрэг болно.

---o0o---

ХОРИГДЛЫН ЗҮГЭЭС ҮЙЛДЭЖ БОЛЗОШГҮЙ НИЙТИЙГ ХАМАРСАН ЭМХ ЗАМБАРААГҮЙ БАЙДАЛ ТҮҮНИЙ ОНЦЛОГ

INTERNATIONAL STANDARDS FOR THE EXECUTION OF IMPRISONMENT



З.Түвшинжаргал
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Харуул хамгаалалт, гүйцэтгэх ажлын тэнхимийн багш, хууль зүйн магистр, ахмад

Товч утга: Хоригдлын зүгээс нийтийг хамарсан эмх замбараагүй байдал гаргасан үед ажиллах арга ажиллагааны бэлэн байдал, техник хэрэгсэл, хүн нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийн хүртээмж, сургалтыг сайжруулахад чиглэгдэнэ.

Түлхүүр үгс: Хорих анги, хоригдол, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, хүн нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл.

Abstract: The article aimed to improve the training for the readiness of working methods and the sufficiency of non - lethal weapon that can affect each person or public in case insurgence, occurs by prisoners.

Keywords: prison, prisoner, insurgence, weapons that can affect each person or public.

Нийгэм, эдийн засгийн болон амьдралын хэв маягийн өөрчлөлтэй уялдан Монголын нийгмийн амьдралд эерэг, сөрөг олон шинэ үзэгдэл бий болж үүнтэй холбоотойгоор гэмт хэрэг үйлдэж байгаа нөхцөл байдал, арга хэрэгсэл, хэв маягт ч өөрчлөлт гарсан.

Монгол улсын Үндсэн хуульд Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн гэж хуульчилсан.

Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон гэм буруутай хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, үүнээс гадна хорих ял шийтгүүлсэн хоригдлыг дахин гэмт хэрэг үйлдүүлэхгүй байх чиг үүргийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага буюу хорих анги хүлээдэг билээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн гэж хуульчилсан байдаг. Энэхүү тусгайлсан чиг үүргийнхээ хүрээнд эрүү, иргэн, захиргааны шүүхээс гаргасан бүхий л төрлийн шийдвэрийг гүйцэтгэдэг ба хоригдлын зүгээс гэмт хэрэг дахин гаргуулахгүй байх үүргийг хорих анги хариуцан зохион байгуулан ажиллаж байна.

Хорих ял эдэлж байгаа хоригдлын зүгээс гэмт хэрэг дахин үйлдэх буюу нийтийг хамарсан эмх замбараагүй байдал гаргаж болзошгүй өдөөн хатгалга, бусдыг энэ үйлдэлд турхирах үйлдэл гаргасаар ирсэн.

Иймд нийтийг хамарсан эмх замбараагүй байдал буюу онцгой учралын үед ажиллах бэлэн байдлыг хангуулах төлөвлөгөөг тодотгох, техник хэрэгсэл, хүн нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг нэмэгдүүлэх, сургалт дадлагыг тогтмолжуулах, арга тактикт алба хаагчдыг сургах шаардлагатай.

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал гэж юу вэ?

Янз бүрийн хүмүүс олноороо цугларах, цуглаан зохион байгуулах зорилго өөрчлөгдөн жижиг үймээн самуун, олныг хамарсан эсэргүүцэл, бослого, зэрлэг балмад үйл ажиллагаа /эвдэх, шатаах, дээрэмдэх г.м./ үүссэн нөхцөл байдлыг ойлгоно.

Энэ нь төрийн тусгай чиг үүргийн байгууллагад онцгой хүндрэл учруулдаг. Цуглааны төлөв, цуглаанд оролцогсдын зан байдлыг ойлгох нь авч хэрэгжүүлэх арга хэмжээг оновчтой тодорхойлох, хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй.

Олон нийтийн эмх замбараагүй байдал үүссэн нөхцөл байдалд оролцсон хүмүүс дараах 3 үе шатыг дамждаг:

1) хувь хүний чанараа алдаж олон нийтийн нөлөөнд автах,

2) өөрөө шийдвэр гаргах чадваргүй болж, олны урсгалд татагдан орох,

3) эргэн тойрны олон түмний нөлөө /шуугиан/ ихсэх үед сэтгэл зүйн хувьд тэдний уур амьсгалд уусан орох.

Монгол Улсад гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх ажлыг хэлбэрэлтгүй бэхжүүлж, хэрэгжүүлэх нь өнөөгийн нийгмийн хөгжлийн зүй тогтлын чухал зорилт болоод байна.

Олон нийтийн аюулгүй байдал нь байгалийн гамшиг, гэнэтийн бусад осол болон зарим байгууллага хүмүүс хүрээлэн байгаа орчиндоо эд зүйл, механизмтай

зүй бус харьцсанаас хүний амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгөд учирч болох хор хөнөөлийг арилгах, таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх зорилготой.

Монгол Улсын хэмжээнд хорих ял эдлүүлэх чиг үүрэг бүхий 51 орчим нэгж үйл ажиллагаа явуулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хуулиар олгогдсон эрх хэмжээ, чиг үүргийнхээ хүрээнд “Хоригдлын аюулгүй байдлыг хангаж, тэдний дунд хууль ёс, дэг журмыг сахиулах, хоригдол бусад этгээдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх” чиг үүргийг хэрэгжүүлсээр ирсэн билээ.

Энэ үүргийн хүрээнд хорих байгууллагад үүсэж болзошгүй онцгой нөхцөл байдлын нэг хэсэг болсон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал нь нийгмийн аюулт үзэгдлийн нэг юм.

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх газарт нийтийг хамарсан эмх замбараагүй байдал нь дараах хэлбэрээр илрэн гарч болно. Үүнд:

Хоригдлууд хэсэг бүлгээрээ нийлж өлсгөлөн зарлах, суулт зохион байгуулах

Нөлөө бүхий хоригдлууд хоорондоо хагаралдан зөрчил үүсгэх, уг зөрчил нь олон нийтийг хамарсан шинжтэй болох

Олны танил болон дуулиант хэрэг үйлдэж шийтгүүлсэн хоригдлыг суллах зорилгоор хорих ангийн харуул хамгаалалтын хэвийн үйл ажиллагааг алдагдуулж гаднаас халдах, жагсаал цуглаан зохион байгуулах

Байгалийн давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалсан үед

Монгол улсад хорих ял эдлүүлэх ажиллагааны түүхэн цаг хугацааны явцад хоригдлын дундаас онц ноцтой гэмт хэрэг үйлдэх, нийтийг хамарсан суулт, зэвсэгт халдлага зэрэг ноцтой хэрэг, учрал гарч олон хүний амь нас, бие эрхтэнд хор хохирол учруулж байсан гашуун сургамжууд бий.

Тухайлбал: Авдрант дахь хорих 403 дугаар ангийн онцгой дэглэмтэй 80 орчим хоригдол зохион байгуулалттайгаар “Онцгой дэглэмтэй ялтнууд хуулийн тэгшитгэлд хамрагдаагүй. Энэ асуудлыг шийдэж өгөх хүртэл суултаа дуусгахгүй” гэх шаардлага тавин 1990 онд суулт зохион байгуулсан байдаг.

Мөн 2009 онд “Өршөөл үзүүлэх тухай хууль” гарсны дараа буюу 2009 оны 07 дугаар сарын 24-ний өдөр Булган аймаг дахь онцгой дэглэмтэй хорих 439 дүгээр ангийн 60 гаран хоригдол “Өршөөлийн хуульд хамрагдаагүй, цаашид хамруулж өгтөл суулт хийнэ” гэсэн шаардлагыг тавин суулт хийсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа хорих анги, шийдвэр гүйцэтгэх газрын даргын баталсан “Онцгой учралын үед ажиллах төлөвлөгөө”-г хэрэгжүүлэн ажиллаж байгаа ба хорих анги, газрын алба хаагчид төлөвлөгөөнд

тусгагдсан үйл ажиллагааг дэс дараалалтай хийж гүйцэтгэх бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас томилогдсон тусгай бүлгийн алба хаагчид очих хүртэл үйл ажиллагааг тухайн хорих ангийн дарга удирдан зохион байгуулах, төрийн тусгай чиг үүргийн байгууллага буюу орон нутгийн цэрэг, онцгой, цагдаагийн байгууллагуудтай хамтран ажилладаг байна.

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх газарт ял эдэлж буй хоригдлын зүгээс нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болгосон, үймээн самуун, хорих байгууллагын ажилтан, албан хаагчдыг барьцаанд авсан зэрэг “Онцгой нөхцөл байдал”-ын үед хорих анги, шийдвэр гүйцэтгэх газрууд нь өөрийн хүч, хэрэгслээр таслан зогсоох боломж, нөхцөл бий эсэхийг судалж үзэв.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, хорих ангид нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон онцгой тохиолдолд хорих ангид харуул хамгаалалтыг байнгын хамгаалалт, өндөржүүлсэн бэлэн байдал, хүч нэмэгдүүлсэн хамгаалалт гэсэн гурван төрлөөр зохион байгуулахаар зохицуулсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа хорих анги, газрын харуул хамгаалалтад ямар нэгэн байдлаар гаднаас халдсан, онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухайн хорих ангид түүнийг зогсоох хүч хэрэгсэл байхгүй, зөвхөн ээлжийн бүрэлдэхүүн үүрэг гүйцэтгэхээс гадна “Онцгой учралын үед ажиллах төлөвлөгөө”-ний хүрээнд “Тусгай томилгоот бүлэг” бэлэн байдлыг ханган ажиллагдаг байна.

Хорих анги, салбар байгууллагад үүсэж болзошгүй нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын гол субъектийн онцлог нь:

Гэмт хэрэг үйлдэн хорих ялаар шийтгүүлж нийгмээс тусгаарлагдсан хүн байдаг

Дахин гэмт хэрэг үйлдэж болзошгүй

Бусдын нөлөөнд автах магадлал амархан зэрэг онцлогтой хүмүүс байдаг.

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх газрын “Онцгой учралын үед ажиллах төлөвлөгөө”-ний зохион байгуулалт, хэрэгжилтийг тандах зорилгоор арван байгууллагын хамгаалалтын ажилтан нараас судалгааг авсан юм.

Судалгаанд хорих анги, шийдвэр гүйцэтгэх газар, баривчлах байрны 36 албан хаагч хамрагдсан бөгөөд судалгааны асуулгад дараах байдлаар хариулсан байна.

Судалгаанд оролцогчдын 18 буюу 50 хувь нь “Онцгой учралын үед ажиллах төлөвлөгөө”-г хэрэгжүүлэхэд хүндрэлтэй гэж хариулсан. Тусгай хэрэгслийн хүрэлцээ ямар байдаг вэ? гэсэн асуултад 32 буюу 88,8 хувь нь хангалтгүй, дутагдалтай гэж хариулсан. Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл бий

юу? гэсэн асуултад 22 буюу 61 хувь нь байхгүй гэж хариулсан. Онцгой учралын үед ажиллах, тусгай хэрэгсэл хэрхэн хэрэглэх талаарх давтан сургалт болдог уу? гэсэн асуултад 14 буюу 39 хувь нь үгүй гэж хариулсан. Тусгай томилгоот бүлэгт ажиллахад нэмэгдэл цалин, урамшуулал, нийгмийн баталгаа олгодог? гэсэн асуултад 36 буюу 100 хувь үгүй гэсэн хариултыг тус тус өгсөн байна.

Судалгаанд оролцогчид нь “Тусгай томилгоот бүлэг”-т ажиллах нь үүрэг, хариуцлага нэмэхээс өөр ямар ч нэмэгдэл цалин, хөлс олгодоггүй, тусгай хэрэгсэл хэрэглэх давтан болон төрийн тусгай чиг үүргийн байгууллагатай хамтарсан сургалт хийх нь маш бага байдаг гэх зүйлсийг дурджээ.

Энэ талаар зохион байгуулалтын арга хэмжээг удирдлагаас авч ажиллахгүй бол алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс хамгаалах, эрсдэлийг бууруулах, тэдэнд хохирол учрахаас урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Дүгнэлт

Хорих, цагдан хорих үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад хорих байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдахуйц онцгой нөхцөл байдал, гадны болон дотоод ноцтой халдлага өмнө гарч байсан, цаашид ч гарч болзошгүй нөхцөл байдал ямагт байсаар байна.

Болзошгүй эрсдэл үүссэн үед энэхүү үйл ажиллагааг таслан зогсооход тусгай зэвсэглэсэн, бэлтгэгдсэн хүч зайлшгүй хэрэгтэй юм.

Энэ талаар зохион байгуулалтын арга хэмжээг удирдлагаас авч ажиллах, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс хамгаалах, эрсдэлийг бууруулах урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээг авч ажиллахгүй бол алба хаагчийн аюулгүй байдлыг ханган ажиллахад сөрөг нөлөөг үзүүлж байна.

Төрөөс алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хамгаалах чиг үүрэгтэй. Гэтэл энэ үүрэг нь бодит амьдрал дээр биеллээ олохгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Санал

1. Хорих байгууллагад бий болсон онцгой учралын үед ажиллах “Тусгай томилгоот бүлгүүд”-ийн нийгмийн баталгаа, цалин, урамшууллыг эрх зүйн актад тодорхой тусгаж өгөх.

2. Тусгай томилгоот бүлгийн албан хаагчийг бэлтгэх, давтан сургах, туршлага солилцох, сургалтын материаллаг баазыг бий болгох.

3. Тусгай бүлгийн албан хаагчийн үүрэг гүйцэтгэхэд зайлшгүй шаардагдах тусгай ажиллагааны хувцас, хамгаалах хэрэглэл, галт зэвсэг, тусгай хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжийн хангалтыг стандартын түвшинд хүргэх.

4. Гадаад орнуудын хорих байгууллагын Тусгай бүлгийн алба хаагчдын хэрэглэдэг хүний амь насанд аюулгүй, аминд халгүй тусгай хэрэгсэл, багажийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх зэрэг саналыг дэвшүүлж байна.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

1. Монгол улсын Үндсэн хууль. УБ., 1992
2. Эрүүгийн хууль. УБ., 2015
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. УБ., 2017. №24
4. Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэн, Цагдаагийн шинжлэх ухааны зарим нэр томьёоны гарын авлага. УБ., 2017

---o0o---

ЦАГДАН ХОРИХ БАЙРНЫ ХАРУУЛ ХАМГААЛАЛТАД АНХААРАХ АСУУДАЛ /Цагдан хорих 461-р ангийн жишээн дээр/

POLICE PRISON GUARD FOR PROTECTION ISSUES TO BE CONSIDERED

/On the example of police detention class 461/



Г.Сэргэлэн

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 71 дүгээр тойргийн шийдвэр гүйцэтгэгч, ахмад

Товч утга: Энэхүү илтгэлээрээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа цагдан хорих байруудын аюулгүй байдал, түүний онцлог, үйл ажиллагаанд нь тулгарч байгаа асуудлыг шийдвэрлэх, харуул хамгаалалтын үйл ажиллагаанд тулгамдаж буй хүчин зүйл, анхаарах асуудлын талаар судалж санал, дүгнэлтийг дэвшүүлэн гаргасан болно.

Түлхүүр үгс: Цагдан хорих байр-хоригдогч, хоригдол-эрсдэл-аюулгүй байдал-харуул хамгаалалт.

Abstract: In this report, the security of the detention facilities under the Judiciary, its characteristics, solving the problems faced by the operation, and the factors and issues to be considered in the operation of the security guard are studied and put forward suggestions and conclusions.

Keywords: Detention facility-detainee, prisoner-risk-security-security.

Хууль гэдэг бол нийгмийн харилцааг зохицуулж буй төрийн бодлого юм. Хуулиар нь дамжуулан тухайн улсын явуулж буй бодлогыг харж, нийгмийг нь таньж мэдэрч болдог бөгөөд хүн хуулийн дор төрж, хуулийн дор амьдарч, хуулийн дор үхдэг нь жам билээ.

Нийгэм болон нийгмийн үнэт зүйл, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалахын тулд төр зарим тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн болон үйлдсэн байж болзошгүй хэмээн сэжиглэгдэж буй этгээдүүдийн эрхийг хязгаарлах албадлагын арга хэмжээг хэрэглэдэг бөгөөд албадлагын арга хэрэгслийн хамгийн хүнд хэлбэрийн нэг бол цагдан хорих үйл ажиллагаа юм.

Энэхүү илтгэлээрээ хорих байгууллагын үйл ажиллагааны нэг хэсэг болох цагдан хорих үйл ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж хөндсөн төрийн албадлагын онцгой процесс болохын зэрэгцээ цагдан хорих байрны аюулгүй

байдал, түүний онцлог, аюулгүй байдлыг хангахад харуул хамгаалалтын албаны ажлын үр нөлөө, ач холбогдол, эрх зүйн зохицуулалт сэдвийн хүрээнд бичихийг зорилоо.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5 дугаар бүлгийн 5.1-д "*Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино*"[18] гэж заасан байдаг

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн[19] 14 дүгээр зүйлийн 14.1.5 дахь хэсэгт зааснаар гэмт хэрэгт сэжиглэгдэж буй этгээдийг уг хуульд заасан үндэслэл журмын дагуу цагдан хорьж тусгаарлах албадлагын арга хэмжээг хэрхэн ямар хугацаагаар авах тухай тодорхой тусгасан байдаг.

Цагдан хорих байранд хоригдож буй хоригдогч нар нь гэмт хэрэгт ял шийтгүүлээгүй, Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэгт сэжиглэгдэн түр саатуулагдан шалгагдаж байгаа иргэн тул хуулиар хязгаарласнаас бусад Монгол Улсын иргэний эрх, эрх чөлөө эдэлж, үүрэг хүлээж хуульд заасны дагуу сонгуулийн үеэр сонгох эрхээ эдэлж саналаа өгч байдаг онцлог бүхий эрх зүйн субъект билээ.

Цагдан хорих байрны өдөр тутмын болон харуул хамгаалалт, аюулгүй байдлын үйл ажиллагааг Сэжигтэн, яллагдагчийг баривчлах цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль /1999 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд 2002 оны 01 дүгээр сарын 10-ны хуулиар нэмэлт өөрчлөлт оруулсан/, Хууль зүйн сайдын үүрэг гүйцэтгэгчийн 2014 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/209 дүгээр тушаалаар батлагдсан "Хорих байрны дотоод журам" болон бусад эрх зүйн актуудад тулгуурлан зохион байгуулан ажиллаж байна.

"*Сэжигтэн, яллагдагчийг баривчлах цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль*"-иар цагдан хорих байрны аюулгүй байдлыг хангах талаар олон зүйлийг хуульчлан зааж өгсөн байдаг. Тухайлбал: Хорих байрны хамгаалалт, хорих өрөөнд тавигдах шаардлага, хоригдсон этгээдийн хорих өрөөнд хуваарилах, хоригдогчийн эрх үүрэг, хоригдсон этгээдийн аюулгүй байдлыг хангах, сахилгын шийтгэл оногдуулах, галт зэвсэг болон мэх хэрэглэх, тусгай хэрэгсэл хэрэглэх, хорих байранд онцгой дэглэм тогтоох зэрэг аюулгүй байдлыг хангах гол чухал хүчин зүйлүүдийг тогтоож өгснөөрөө онцлогтой.

"*Хорих байрны дотоод журам*"-аар цагдан хорих байрны аюулгүй байдлыг хангах, харуул хамгаалалтыг зохион байгуулалт үүрэгтэй гол субъектуудийн гүйцэтгэх эрх, үүрэг, мөн хорих байранд нэвтрэх албан тушаалтнууд, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах, хорих байрны хорих байранд мөрдөх цагийн хуваарь, хорих өрөөг онгойлгох, хоригдогч

[18] Эрүүгийн хууль./ Шинэчилсэн найруулга.2015 он/
[19] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль./ Шинэчилсэн найруулга. 2017 он /

нарт зөвшөөрсөн болон хориглосон зан үйл зэрэг дотоод үйл ажиллагаатай холбоотой олон харилцааг зохицуулж өгсөн байдаг.

Цагдан хорих байранд хоригдож буй хоригдогч нар нь эхэн үедээ сэтгэл зүйн байдлын хувьд тогтворгүй байдаг тул тухайн хоригдогч нарт харуул хамгаалалтын тасралтгүй хяналтыг тавьж байх шаардлагатай бөгөөд одоогийн байдлаар цагдан хорих төвд нэг хамгаалалтын ажилтанд 80-110 хоригдогч ноогдож байгаа нь харуул хамгаалалтын хүч суларч гэмт хэрэг, зөрчил гарч болзошгүй эрсдэлтэй байдалтай байна.

Хоригдогчдын дундаас амь, бие эрхтэндээ гэмтэл учруулах оролдлого хийж байгаа зөрчлүүдийн ихэнх хувь нь 48 цагаар саатуулагдаж байгаа хоригдогчдын дундаас гарч байгаа нь анхаарал татах зүй ёсны асуудлын нэг билээ.

Цагдан хорих байрны аюулгүй байдалд заналхийлэх гол объект бол хоригдогч, хоригдогчийн сэтгэл зүйн байдалд сөргөөр нөлөөлж буй гадаад болон дотоод хүчин зүйл байдаг тул хорих байрны аюулгүй байдлыг хангах зайлшгүй шаардлагын үүднээс харуул хамгаалалтын албаны хүн нөөцийн бодлогыг тогтвор суурьшилтай байлгахад бодлогын шийдвэр гаргах түвшинд энэ талаар анхаарах шаардлага зүй ёсоор бий болсоор байна.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль нь 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдөр батлагдсан бөгөөд уг хуулийн "*288.6.Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална.*"[20] гэсэн /Энэ хэсгийг 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар нэмсэн./ хэсгийг нэмэлтээр оруулж өгснөөр хөдөө орон нутагт ажиллаж байгаа албан хаагчдын нийгмийн баталгааг хангасан, тогтвор суурьшилтай ажиллуулах чухал шийдвэр болсныг тэмдэглэх нь зүйтэй болов уу.

Гэхдээ Монгол Улсад ганцхан байдаг Нийслэл дэх цагдан хорих төвийн алба хаагчдыг хамруулсан бол тус төвийн албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг дэмжсэн чухал шийдвэр болох байлаа.

Орон нутаг дахь цагдан хорих төвүүдэд хоригдож байгаа хоригдогч нарын талаар судлахад дунджаар 30-50, багадаа 10-15 орчим хоригдогчтой байдаг бол цагдан хорих төвд 700-900 хоригдогч, хоригдол өдөр тутам хоригддог бөгөөд нэг хамгаалалтын ажилтанд оногдох хоригдогч, хоригдлын тоо нормативаар бол 25 байдаг бол тус төвийн нэг хамгаалалтын ажилтанд хамгийн багадаа 50-70 хоригдогч, ихдээ 110 хоригдогч оногддог бөгөөд энэхүү ажлын ачааллаас шалтгаалан албан хаагчдын дунд ажлаас халшрах хам шинж илэрч улмаар ажлаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх нь сүүлийн 3 жилийн байдлаар 86, /үүнээс цалин хангамж болон ажлын ачааллаас болж чөлөөлөгдсөн 60 орчим/, өөр анги байгууллага руу 40-50 шилжих, цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй ч 20 жил ажилласан гэсэн шалтгаанаар цэргийн байнгын тэтгэвэрт

[20] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017 он.

гарах 25 хөдөлгөөнүүд сүүлийн 2 жилд огцом өссөн нь хүний нөөцийн албаны судалгаанаас харагдаж байна.

Тухайлбал: 2020 онд 14 албан хаагч өөрийн хүсэлтээр, 2021 онд 31 албан хаагч, 2022 онд 41 албан хаагч өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн бөгөөд ажилласан жилээр нь харахад 1 сараас 3 жил хүртэл хугацаагаар ажилласан албан хаагчид байна.

Мөн ээлжийн бүрэлдэхүүний албан хаагчдаас 7 хоногт 1-2 албан хаагч ажил таслах нь хэвийн үзэгдэл болоод байна.

Өнөөдрийн байдлаар тус ангийн харуул хамгаалалтын албанд хамгаалалтын ажилтны 23 орон тоо буюу бүтэн нэг ээлжийн ахлагч бүрэлдэхүүний орон тоо дутуу байна.

Ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдын ажилласан жилийн байдалд судалгаа хийхэд эрэгтэй албан хаагчид 80 хувийг эзэлж байна.

Тэтгэвэрт гарсан албан хаагчдын насны байдалд судалгаанаас харахад цагдан хорих төвд ажилласан ажлын дадлага туршлагатай цаашид 3-4 хүртэлх жил ажиллах боломж бүхий насны албан хаагчид байна.

Алба хаагчдын дунд хийсэн биечилсэн сурвалжилгын аргын судалгааны дүнгээс харахад хүн 5 жил нэг газраа ажилласан тохиолдолд тухайн ажил болон орчин нөхцөл, ажлын ачаалалдаа дасан зохицох чадвартай болдог бөгөөд 5 жил болох хугацаанд ажлын өндөр цалин хангамж бүхий өөр байгууллагыг сонирхох, ажлын ачааллаас шантран цалин багатай ч өөр газар ажиллах зэрэг сонголтуудыг хийдэг байна.

Сүүлийн хоёр жилийн байдлаар цагдан хорих төвд хоригдож байгаа хоригдогчдын дундаас албан хаагчдын хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн, дороомжилсон, дайрч довтолсон гэсэн үндэслэлээр сахилгын шийтгэл хүлээлгэсэн 2021 онд 10, 2022 онд 6, 2023 оны 01 дүгээр улирлын байдлаар 2 хоригдогч байна.

Алба хаагчдад оногдуулсан сахилгын шийтгэлийг сүүлийн 3 жилийн байдлаар судлахад хоригдогч, хоригдолтой хувийн харьцаа тогтоосон үндэслэлээр нийт 13 албан хаагч сахилгын арга хэмжээ авагдсанаас ажлаас халах сахилгын шийтгэлээр 8 алба хаагчид сахилгын арга хэмжээ авсан байна.

Гүйцэтгэх ажлын шугамаар авагдаж буй мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд алба хаагчдаас хориотой эд зүйл нэвтрүүлэх, ар гэртэйгээ холбоо бариулахын тулд мөнгө болон бусад эд зүйл амлах зэрэг мэдээлэл их авагддаг ба энэ нь сахилгын шийтгэлийн тодорхой хувийг эзэлдэг.

Зөвхөн эдийн засгийн баталгааны байдлаас шалтгаалан албан хаагчид ажлаас чөлөөлөгдөж байна гэвэл өрөөсгөл ойлголт бөгөөд хоригдогчдын дундаас ирж байгаа сэтгэл зүйн болон биет хэлбэрийн дарамт, дайралт, сүрдүүлэг, заналхийллээс шалтгаалан шинээр томилогдсон алба хаагчид ажлаас халшрах хандлага их байна.

Хорих байгууллагын нэгээхэн хэсэг болох цагдан хорих байрны харуул хамгаалалтын албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах шаардлагатай дараах үндсэн шаардлагууд байна. Үүнд:

- Гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчил, учралаас урьдчилан сэргийлж хорих байрны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах.
- Мэргэшсэн тогтвор суурьшилтай ажиллах хүний нөөцийг бүрдүүлэх гэх мэт.

Цагдан хорих төвийн албан хаагчдын тогтвортой суурьшилтай ажиллах орчныг бүрдүүлснээр ШШГТ-хуулийн "*245.2.Хорих ангийн алба хаагч биечилсэн хамгаалалт, жижүүрийн үүргийг дөрвөн ээлжээр гүйцэтгэнэ."* хэрэгжилтийг хангаж ээлжийн бүрэлдэхүүнийг 4 ээлжээр явуулах боломж харагдаж байгаа бөгөөд үүний үр дүнд алба хаагчид ар гэртээ зарцуулах цаг хугацаа нэмэгдэх, өөрийгөө хөгжүүлэх зэрэг олон талын боломж харагдаж байгаа юм.

Нийгэм, улс орны болон эрүүгийн нөхцөл байдал, хүний нөөцийн шилжилт, хөдөлгөөн зэргээс шалтгаалан хуульд тухай бүрт шинэчлэн найруулга хийснээр дотоод аюулгүй байдал хангагдах нэг чухал хүчин зүйл болохын зэрэгцээ хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах, гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд ихээхэн үр дүнтэй үйл ажиллагаа болно хэмээн дүгнэж байна.

Иймээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын өмнө тулгамдаж буй гол асуудлын нэг бол алба хаагчдыг тогтвортой суурьшилтай ажиллуулах эрх зүйн орчныг тухай бүр шинэчилж байх явдал бөгөөд үүний үр дүнд хорих анги болон цагдан хорих байрны өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа хангагдаж гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, мэргэшсэн тогтвортой суурьшилтай ажиллах албан хаагчдын нөөцийг бүрдүүлэх нь хорих байгууллагын аюулгүй байдал хангагдах үндэс суурь болно.

Дүгнэлт

"Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль"-ийн 288 дугаар зүйлийн "*288.6.Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална*" гэсэн хэсэгт Нийслэл дэх цагдан хорих төвийн харуул хамгаалалтын албан хаагчид хэмээн эрх зүйн зохицуулалтыг нэмэн тусгуулах саналтай байна.

Нийгмийн болон эрүүгийн нөхцөл байдлын цаг үетэй уялдуулан хуульд дээрх нэмэлт өөрчлөлтийг яаралтай нэмэлт оруулснаар үндэсний болон нийгэм, төр, иргэний аюулгүй байдлыг хангуулахын зэрэгцээ хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах, хүний нөөцийн тогтвор суурьшилтай ажиллах үйл ажиллагааг сайжруулсан чухал эрх зүйн зохицуулалт болох билээ.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2017 он.

6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль./ Шинэчилсэн найруулга. 2017 он /
7. Монгол улсын Эрүүгийн хууль 2015 он
8. Гүйцэтгэх ажлын тухай хууль. 1997.12.19.
9. “ШШГБ-ын гүйцэтгэх тагнуулын ажлын заавар” 2006 он

---o0o---

ХОРИГДЛЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД АНХААРАХ АСУУДАЛ

PRISONER LABOR SECURITY ISSUES TO CONSIDER WHEN SUPPLIED



Н.Эрдэнэчулуун
415 дугаар хаалттай хорих ангийн төлөөлөгч, ахмад

Товч утга: Хорих ял эдлэгсдийн хөдөлмөр зохион байгуулалтын эрх зүйн орчин, аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаанд гарч буй эрсдэлийг судалж шалтгаан нөхцөлийг тодорхойлон сайжруулах, боловсронгуй болгох арга замыг эрэлхийлэхэд оршино.

Түлхүүр үгс: Хорих байгууллага, хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөр эрхлэлт, бүтэц, зохион байгуулалт, аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн осол, хөдөлмөрийн эрүүл ахуй.

Abstract: It is to study the risks in legal environment, safety, and hygiene od the labor organization of the prisoners, identify the causes, and seek ways to improve them.

Keywords: Penitentiary, labor safety, employment, structure, organization, safety, industrial accidents, occupational hygiene

Хөдөлмөрийн аюулгүй байдал, ажлын байран дахь үйлдвэрлэлийн осол, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны менежментийг шинэчлэх шаардлага, хэрэгцээ өнөөгийн нийгэмд өсөн нэмэгдсээр байна. Үүнээс хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн онцлог нь албадлагын шинж чанарыг агуулсан тодорхой заасан орчин, нөхцөлд үйл ажиллагаа явуулдаг зэргээрээ өвөрмөц ба хорих ангид ял эдэлж буй хоригдлуудын хөдөлмөр эрхлэлтийн зохион байгуулалт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа алдагдаж буй шалтгаан нөхцөлийг тодорхойлон боловсронгуй болгох шаардлага тулгарч байна.

“Хөдөлмөрийн аюулгүй байдал” гэдэг нь: Хөдөлмөрлөх явцад хүний эрүүл мэнд, хөдөлмөрлөх чадварт үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллийн түвшин нь эрүүл ахуйн зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрээгүй байхыг хэлнэ.

“Үйлдвэрлэлийн осол” гэдэг нь: Аливаа хүн хөдөлмөр эрхэлж байхдаа үйлдвэрлэлийн болон түүнтэй сөрөг хүчин зүйлийн үйлчлэлд өртөж амь нас, эрүүл мэндээрээ хохирох асуудлыг хэлнэ.

“Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй” гэдэг нь: Хөдөлмөрлөх явцад хими, физик, биологийн хүчин зүйлээс шалтгаалан хүний бие, махбод, мэдрэл сэтгэхүйд өөрчлөлт орж өвчлөх, хөдөлмөрийн чадвараа түр болон бүрэн алдахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэлнэ.[21] хэмээн хуулийн нэр томьёоны тайлбарт бичжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын сүүлийн 5 жилийн тайлангаас үзэхэд 2013 оноос хойш хорих ял эдэлж буй хоригдлын дундаас үйлдвэрлэлийн ослоос шалтгаалсан нас баралт гараагүй боловч хоригдлуудын бие эрхтэнд гэмтэл учирсан явдал гарсаар байгаа нь хорих ангиуд өөрсдийн үйлдвэрлэлд техник, хэрэгслийг ихээр нэвтрүүлэн ашиглах болсонтой холбогдож болох талтай ч нөгөөтээгүүр хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг бүрэн хангаагүй хөдөлмөрт гаргах мөн шат шатны зааварчилгаанууд дутуу өгөгдсөнтэй холбон үзэж байна.

Монгол Улсын Хөдөлмөрийн хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль болон бусад холбогдох хууль, журам, заавар, стандартуудын хэрэгжилтийг хорих байгууллагуудад нэг мөр хэрэгжүүлж хариуцлага, хандлагыг боловсронгуй болгох арга замыг тодорхойлох нь чухал байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар доктор (Sc.D), профессор, академич С.Нарангэрэлийн “БНМАУ-ын засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн үндэс” 1985 он, доктор (Ph.D) А.Лхагваагийн “Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй сурах бичиг” 2005, 2008, 2010 он, БНМАУ-ын засан хүмүүжүүлэх байгууллагад хорих ял эдлэгсдийн хөдөлмөр зохион байгуулалтын зарим асуудал 1989 он, доктор (Ph.D) Р.Оюунбадам “Эмэгтэй хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн байдал, түүний эрх зүйн зохицуулалт, Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн хорих ял”: Онол арга зүй практик нэг сэдэвт бүтээлийн хоёрдугаар бүлэг 2013 он, доктор (Ph.D) Б.Алтангэрэл “Хорих ял эдлүүлэх онол арга зүйн асуудал” 2015 он, хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл, судлаач Д.Насанбатын “Ялтны эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судлал”, судлаач Л.Азжаргалын “Ялтны хөдөлмөр хамгааллын эрх зүйн зохицуулалт, практик” магистрын ажилд хоригдлын хөдөлмөр хамгааллыг хангахтай холбогдсон ажиллагаа, хууль тогтоомжийн уламжлал, эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт, өнөөгийн нөхцөл байдал, хөдөлмөр зохион байгуулалт, аюулгүй ажиллагааны талаар хөндөгдөж судлагдсан байна.

Нэг: Үндсэн хэсэг

Хоригдлын хөдөлмөрийг зөвхөн төрөөс баталсан хуульд заасан чиглэл, нөхцөлд захируулан зохион байгуулах явдал Засан хүмүүжүүлэх байгууллагын

[21] Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль. Төрийн мэдээлэл сэтгүүл. УБ.,2008. №21

нэг чухал үүрэг байлаа. Монгол Ард Улсын дотор аливаа хэрэгтэн ялтныг засан сайжруулах ажлын тухай хуульд (1931он) “Хоригдогсдын дотроос ажил үйлдвэрийг хийж чадахыг нь эрх биш бүгдийг нь ажилд хэрэглэх бөгөөд уул хоригдогсдоос хэн аль нь ямар ажилд авьяастай, мэдэх чадах нь юу болох, тэдгээрээс урьд хийж байсан ажил ба биеийн эрүүл мэнд ямар болохыг хянан үзэж харгалзан гүйцэтгэвээс зохимой” хэмээн заажээ. Харин 1966, 1993 оны хуулиудад хоригдлыг албадан хөдөлмөрлүүлэх, 1981 оны хуульд хоригдол заавал хөдөлмөрлөх, 1966, 2002 оны хуульд ял эдлүүлэх байгууллага хоригдлыг хөдөлмөрөөр хангах үүрэгтэйг онцлон заасан байна.

Хорих ял эдлүүлэх байгууллагын эрхлэх үйлдвэрлэлийн чиглэл, байршлыг зөв тогтоож, хоригдлыг ажлаар хангахад төрөөс зохих анхаарал тавьж ирсэн нь энэ чиглэлээр удаа дараа гаргасан баримт бичгийн агуулгаас тодорхой харагдаж байна. Эдгээрийн дотор түүхэн томоохон байр суурь эзлэх шийдвэр бол 1929 оны 6 дугаар сарын 14-нд Засгийн газрын есдүгээр хурал, Улсын бага хурлын тэргүүлэгчдийн 55 дугаар хурлаар батлагдсан “Аливаа хэрэгтэн, ялтнаар ажил үйлдвэрлэл хийлгэх тухай дүрэм”[22] юм.

Засан хүмүүжүүлэх байгууллагын үйлдвэрлэл нь 1950-иад оны эхэн үе хүртэл гар урлал, мал аж ахуй, газар тариалан эрхлэх, барилга барих, барилгын модон материал бэлдэх, тоосго үйлдвэрлэх зэрэг чиглэлээр хөгжиж ирсэн байна. Засан хүмүүжүүлэх байгууллагын үйлдвэрлэлийн салбарыг нэмэгдүүлэх, гар ажиллагааг механикжуулах, хоригдолд хөдөлмөрийн дадал олгох, мэргэжил эзэмшүүлэх ажил 1960-аад оноос нэлээд эрчимжсэний нэг жишээ бол БНМАУ-ын Сайд нарын зөвлөлөөс 1960 оны 3 дугаар сарын 2-ны өдрөөс “Засан хүмүүжүүлэх байгууллагын үйлдвэрлэлийн чиглэлийн тухай” 86 дугаар тогтоол гарсан явдал юм.

Сайд нарын зөвлөлөөс 1967 оны 4 дүгээр сарын 12-нд “Засан хүмүүжүүлэх байгууллагын ажлын талаар авах арга хэмжээний тухай” 98 дугаар тогтоол гаргаж засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын үйлдвэрлэлийг

1. Уул уурхай
2. Шохойн чулуу олборлох, боловсруулах
3. Тоосго
4. Мод бэлтгэлийн аж ахуй
5. Модны үйлдвэр
6. Зоорийн барилга гэсэн чиглэлүүдээр хөгжүүлбэл зохихыг заажээ.

Улсын болон ард олны захиалга, хэрэгцээг харгалзан засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын үйлдвэрлэл, хоригдлын хөдөлмөр зохион байгуулалтын чиглэл баяжин өөрчлөгдөж ирсэн байна.

Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг олон жилийн өмнөөс анхааран засан сайжруулж ирсний заримаас дурдвал:

---

[22] БНМАУ-ын Засгийн газрын албаны сэтгүүл.1930. №49, 53-63 дахь тал

Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 257 дугаар тогтоолоор анхны (1997-2000 он), 2001 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан хоёрдох хөтөлбөр (2001-2004), "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах Үндэсний хөтөлбөр" чухал үүрэг гүйцэтгэсэн.

Монгол Улс 2005 онд олон улсын хөдөлмөрийн байгууллагын "Хөдөлмөр аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн орчны тухай" 155 дугаар конвенцэд нэгдэн орсон бөгөөд Хөдөлмөрийн тухай хуульд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарттай холбоотой бүлгийг уг конвенцийн үзэл баримтлалтай нийцүүлэн боловсруулсан байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт, олон улсын стандартын дагуу явагдах болсон юм.

Өнөө үед техникийн шинжлэх ухааны хөгжил нь нийгмийн харилцааны хөгжлийг хурдасгах ба хөгжил дэвшил дээд түвшинд хүрсэн тохиолдолд хүний боловсролын түвшин өндөрсөж боловсрол сайтай ажилтан ажлын талбарт осолдох нь бага байх магадлалтай.[23]

Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг дараах байдлаар зохион байгуулна. Үүнд:

1. Үйлдвэр албан газруудад хөдөлмөр хамгааллын ажлыг зохион байгуулан удирдах, төлөвлөх, хөдөлмөр хамгаалалд зориулсан төсвийг бий болгон зарцуулах;
2. Ажилтнуудыг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны арга, техникт сургах;
3. Үйлдвэрлэлийн осол, золгүй явдлыг гаргахгүй байх гарсан ослыг шалган бүртгэж дахин гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;
4. Үйлдвэрийн осол, золгүй явдлаас урьдчилан сэргийлэх, эмнэлгийн үзлэгийг явуулах;
5. Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах үйл ажиллагаанууд багтдаг байна.

Аюулгүй ажиллах арга техник, үйлдвэрийн эрүүл ахуйн зааварчилгаа гэдэг нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны арга техник, эрүүл ахуйн дүрэм, журмуудыг судлуулан ажлын арга барилыг ажилтнуудад мэдүүлж үйлдвэрийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чадварыг эзэмшүүлж байгаа захиргааны үйл ажиллагаа мөн. Энэхүү зааварчилгаа нь урьдчилсан, ажлын байрны, давтан өгөх зааварчилгаа, сургалт гэсэн төрөл, хэлбэртэй байна. Ажлын байрны зааварчилгааг хоригдлуудын хийж гүйцэтгэх ажилтай нь шууд холбогдсон арга барилыг эзэмшүүлэх зорилгоор өгөх бөгөөд уг зааварчилгааны агуулга нь ажлын байранд хоригдлуудын гүйцэтгэх үүрэг, түүний хэрэгжүүлэх журам, багаж, төхөөрөмжийн байршилт, ажиллуулах журам, ажлын үед гарч болзошгүй осол, гэмтэл, түүнийг

[23] Ч.Авдай. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй УБ., 2006.14 дэх тал.

зайлуулах арга зам, ажлын байранд тээврийн хэрэгслүүдийн ажиллах журмыг танилцуулах үйл ажиллагаагаар тодорхойлогдоно.

Хүнээс ерөнхий болон тусгай мэргэжил шаардахуйц орчин үеийн механикжсан, техникжсэн үйлдвэр цехэд хоригдлыг ажиллуулах нь тэднийг хөдөлмөрөөр хүмүүжүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх ач холбогдолтой бөгөөд мэргэжлийн түвшинг ахиулах, өөрийн ажлыг хангалттай биелүүлсэн хоригдлыг сэтгэл зүйн хувьд урамшуулах хэлбэрийг ашиглаж ирсэн уламжлалыг шинэ нөхцөл байдлаар баяжуулан хэрэглэж болох талтай. Хорих байгууллага дахь хоригдлын хөдөлмөр зохион байгуулалт нь ял эдлүүлэх дэглэм, зэрэглэлийн онцлогт тохирсон өөрийн өвөрмөц хэлбэртэй ч нийтлэг зарчимд тулгуурлагдсан байна.

Хорих ял эдлүүлэх байгууллагын үйлдвэрлэлийн чиглэлийг Засгийн газар тогтоодог ба улс орны тухайн цаг үеэс шалтгаалан янз бүрээр өөрчлөгдөж иржээ.

Хорих байгууллагын хоригдлын хөдөлмөрийн нөхцөлд дараах зарчмууд байна. Үүнд:

1. Хоригдлын хөдөлмөрийг уламжлалт зах зээлийн харилцаанд нийцүүлэн зохион байгуулж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;
2. Хоригдлыг хэдийгээр албадан хөдөлмөрлүүлэх боловч тэдэнд эрхэлж буй үйлдвэрийн чиглэлээр хөдөлмөрийн дадлага олгох, мэргэжил эзэмшүүлэх;
3. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан орчинд ажиллуулах, тэдний амьдрах эрүүл ахуйн нөхцөлөөр хангах;
4. Хуулийн дагуу хөдөлмөрийн хөлс олгох;
5. Хорих ял эдлүүлэх байгууллагын үйлдвэрлэлийн ажиллагаа улсын болон хувийн хэвшлийн үйлдвэрүүдийнхээс зарчмын хувьд ялгаагүй боловч, өөрийн байгууллагын гол зорилт болсон хоригдлыг нийгмийн хүмүүжүүлэх болон хорих дэглэмийн шаардлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон ажиллагаанаас үндэслэн зарим онцлогтой байдаг.

Хорих ангид хоригдлын өдөр тутмын хөдөлмөрийн үйл ажиллагааг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан алба хаагч ангийн даргын шууд удирдлагаар арга хэмжээг авч хэрэгжүүлэн, шаардлагатай шийдвэрлэх саналыг өгч ажиллаж байгаа ба төсвийн байгууллагууд батлагдсан төсвийн 0.5%-иас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус зарцуулах эрх зүйн орчинтой юм. Өнөөдрийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд дараах хууль, журам, стандартуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хууль;
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль;
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль;
4. Хорих ангийн дотоод журам;

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нэгдсэн журам;

6. Холбогдох стандарт нийт /Монгол улсын хэмжээнд нийт 120 стандарт/;

7. Барилгын норм ба дүрм /БНбД/;

8. Өргөх, зөөвөрлөх механизмын аюулгүй ажиллагааны дүрэм;

9. Эрчим хүчний тухай, Эрчим хүчний тоног төхөөрөмжийн тусгай ажиллагааны дүрэм;

10. Хүнд машин механизмын аюулгүй ажиллагааны дүрэм;

11. Бага хүчин чадлын зуух ашиглах дүрэм, стандартууд болон холбогдох бусад бичиг, баримтуудын хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа ба Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 216 дугаар зүйлд зааснаар дараах тохиолдолд хоригдлыг хөдөлмөрт гаргахыг хориглоно.

1. Харуул хамгаалалтын зохих шаардлага хангагдаагүй;

2. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журам биелэгдээгүй, эсхүл энэ талаар зааварчилга өгөгдөөгүй;

3. Эмч болон сэтгэл зүйч хоригдлын биеийн эрүүл мэндийн байдал дордсон, сэтгэл санаа тогтворгүй байгаа тухай тодорхойлолт гаргасан;[24] гэж заасан байна.

Өнөөдрийн байдлаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хоригдлыг хөдөлмөр эрхлүүлэхдээ дээрх хууль, журам, стандартуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байгаа боловч хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа зөрчигдөж ажлын байранд бэртэл, гэмтэл гарсаар байна.

2021 он гарсаар хорих анги байгууллагуудын хэмжээнд үйлдвэрлэлийн ослоос шалтгаалан нэр бүхий 2 хоригдол хүнд хэлбэрийн бэртэл авсан байх ба осол гарсан шалтгаан нөхцөлийг судлахад хариуцсан алба хаагчийн хариуцлага, хяналт алдсан байдал мөн мэргэжлийн дадлага, сургалт зохион байгуулаагүй зэргээс гарсан болох нь тогтоогдсон байна.[25]

Өнөөгийн нөхцөлд нээлттэй, хаалттай хорих анги, шийдвэр гүйцэтгэх газруудад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа нь үндсэн 2 хэлбэрээр зохион байгуулагдаж байна.

1. Хоригдол хорих ангийн үйлдвэрийн бүсэд хөдөлмөрлөх үед хорих анги хариуцах;

2. Гэрээгээр ажиллах тохиолдолд тухайн аж ахуй нэгж байгууллага хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж байна.

Нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдан аливаа байгууллага нь хөдөлмөрийн аюулгүй байдал гэдэг ойлголтод “Хөдөлмөрийн эрүүл ахуй”-н тухай асуудал чухлаар яригдах болжээ. 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн

[24] Төрийн мэдээллийн эмхэтгэл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль УБ.,2017.№24

[25] 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 03 дугаар улирлын тайлан

эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын бүрэлдэхүүн 2022 онд нийт хорих ангиудад давхардсан тоогоор 14474 хоригдолд нарийн мэргэжлийн эмч нарын эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ хийж улмаар нийт үзлэгт хамрагдсан хоригдлуудаас хэвтэн эмчлүүлсэн хоригдлуудын нийт өвчлөлийн 986 буюу 51% нь дотрын өвчлөл, 438 буюу 22% мэс заслын өвчлөл, 500 буюу 27%-ийг мэдрэлийн өвчлөл тус тус эзэлсэн ба 13А маягтаар системийн хэмжээний хорих ангиудаас нийт 360 өвчтэй хоригдлыг шат дараалан эхний ээлжинд хэвтүүлэн эмчлүүлэхээр эмч нар шийдвэрлэсэн байна.

Дээрх судалгаатай уялдуулан хөдөлмөрийн хүнд нөхцөл буюу шохойн чулуу боловсруулах үйлдвэрлэл эрхэлдэг 415 дугаар нээлттэй, хаалттай хорих ангиас 2022 онд нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн нэр бүхий 264 (давхардсан тоогоор) хоригдлын өвчлөлд дүн шинжилгээ хийхэд 114 буюу нийт өвчлөлийн 43%-ийг дотрын тэр дундаа уушгины өвчлөл эзэлж байх нь хоригдлуудын эрхэлж буй хөдөлмөрөөс шалтгаалан эрүүл мэндэд шууд бус замаар буюу урт хугацааны явцад сөрөг байдал илэрч болзошгүй байх тул үүнээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг авч ажиллах шаардлага зайлшгүй тулгарч байна.

Хоёр: Дүгнэлт

Судалгааны ажлын явцад дараах дүгнэлтэд хүрч байна.

Судалгаанаас үзэхэд хоригдлын хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, эрх зүйн зохицуулалт, хууль, стандартуудыг нэр мөр хангахгүй байгаагаас шалтгаалан эрсдэл гарсаар байна.

Хорих ангиуд болон хоригдлоор хөдөлмөр эрхлүүлж буй газрууд тэдний аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах чиглэлд хангалт, хувцас, хэрэглэлийг хангалттай хүрэлцэхүйц байдлаар зохион байгуулаагүй.

Хоригдлын хөдөлмөрийг өдөр тутам мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэгтэй алба хаагч нарын мэдлэг, чадвар дутмаг мэргэжлийн бус алба хаагч нар томилогдон ажилладаг.

Шохойн чулуу олборлодог, боловсруулдаг үйлдвэрт ажилладаг хоригдлуудад үзүүлэх эрүүл мэндийг үзлэг, оношилгоог шинэ түвшинд гаргаж ирэх энэ зүйл дээр удирдлагын зүгээс онцгой анхаарах шаардлага байна.

Гурав: Санал

Судалгааны ажлын явцад дараах санал, анхаарах асуудлыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, хамгааллын талаар сургалтыг алба хаагч нарт явуулж хэрэгжилтэд хяналт тавих;
2. Хөдөлмөр аюулгүй ажиллагаатай холбогдолтой гарч болзошгүй ослын талаар мэдээлэл авч ач холбогдолтой мэдээлэл өгсөн хоригдлыг зохих хэмжээнд урамшуулах;
3. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх газар бүр хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйтай холбогдуулан тодорхой төсөв бүрдүүлэн

үйлдвэрлэлийн осол, золгүй явдлаас урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмол үр дүнтэйгээр явуулж хэвших;

4. Аюулгүй ажиллагаа, эрүүл мэндтэй холбогдсон бүхий л эрсдэлийг төрөлжүүлэн (жишээ нь: үйлдвэрт ажилладаг ажилчдын хувьд чих-сонсголын эрүүл ахуй гэх мэт төрөлжүүлэн тогтоох) ажилтан бүрийг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангаж тухайн хорих ангийн үйлдвэрлэлд тохирсон төхөөрөмж, хувцсыг зохион бүтээх, үйлдвэрлэх, нийлүүлэх, хэрэглэх, шалгах;

5. Ажлын нөхцөлийн улмаас үүсэх бие болон сэтгэцийн дарамт ачааллаас урьдчилан сэргийлэх зэрэг болно.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

Монгол Улсын үндсэн хууль. Төрийн албаны мэдээлэл сэтгүүл.1992.№1

1. Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн тухай Монгол Улсын хууль. Төрийн мэдээлэл сэтгүүл.2008.№21
2. Ч.Авдай, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. УБ. 2006 он.
3. Л,Баасан, Г.Баярмаа, Монгол Улсын Хөдөлмөрийн эрх зүй. УБ. 2006 он.
4. А.Лхагваа, Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй. УБ. 2005,2008,2012 он.
5. Р.Оюунбадам, Ялтны хөдөлмөрийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал. Хууль зүйн мэдээ сонин. УБ. 2013 он.
6. Б.Алтангэрэл, Хорих ял эдлүүлэх онол арга зүйн асуудал. УБ. 2015 он.

Цахим эх сурвалж:

1. www.legalinfo.mn

---o0o---

ИРГЭНИЙ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ТАЛУУДААС ГАРГАСАН ГОМДЛЫГ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ

THE CONCERNING PROBLEM OF REVIEW AND RESOLVE COMPLAINTS LODGED BY PARTIES TO CIVIL DECISION ENFORCEMENT PROCESS



Я.Батгэрэл
Дотоод хэргийн их сургуулийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн эрхлэгч,
хууль зүйн магистр, дэд хурандаа

Товч утга: Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд шийдвэр гүйцэтгэгчийн явуулсан үйл ажиллагаа, гаргасан шийдвэрийг эс зөвшөөрч төлбөр төлөгч, төлбөр авагч, эрх ашиг сонирхол нь хөндөгдсөн гуравдагч этгээд тэдгээрийн төлөөлөгчдийн зүгээс гаргасан гомдлыг хянан шийдвэрлэхэд ахлах шийдвэр гүйцэтгэгчийн баримтлах зарчим, анхаарах асуудлыг тодорхойлохыг зорилоо.

Түлхүүр үгс: Гомдол, хянан шийдвэрлэх, үндэслэл

Abstract: It is intended to determine the principles and issues to be considered by the senior decision enforcer in handling complaints filed by payers, payees, and third parties whose interests are affected by their representatives, who disapprove of the actions and decisions made by the decision enforcer in.

Keywords: Complaints, reviews and grounds.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хүний эрх, эрх чөлөөг зөвхөн хуульд зааснаар хязгаарлах, энэрэнгүй, шуурхай байх зарчмыг баримтална.[26]

Дээрх зарчмын хүрээнд шийдвэр гүйцэтгэгч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, үндэс, угсаа, хэл, арьсны

[26] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл №24.

өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүйгээр хүний эрхийг ханган ажиллах шаардлагатай. Гэхдээ зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүний эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тогтоодог эрх бүхий субьект юм.

Тухайлбал иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллага, албан тушаалтны шүүхээр баталгаажуулсан шийдвэрийг үндэслэн явуулах бөгөөд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээг авна.

Иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээ гэж “Гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг албадан гүйцэтгэх, эсхүл төлбөр төлөгчийг гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг тогтоосон хугацаанд бүрэн гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн шийдвэр гүйцэтгэгчийн хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу хэрэгжүүлэх арга хэмжээг ойлгоно”[27]. Үүнд:

- иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд /төлөөлөгчид/, бусад хүн, хуулийн этгээдийн төлөөллийг дуудан ирүүлэх;
- иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд /төлөөлөгчид/, бусад хүн, хуулийн этгээдээс гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг биелүүлэхэд шаардлагатай баримт бичиг, лавлагаа, тодорхойлолт гаргуулан авах;
- төлбөр төлөгч болон бусад этгээдээс төлбөр төлөгчийн хөрөнгийн тухай мэдүүлэг гаргуулан авах, түүнийг төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэх;
- төлбөр төлөгчийн үйл ажиллагаанд холбогдох санхүүгийн болон бусад баримт бичигт үзлэг хийх;
- иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд /төлөөлөгчид/, бусад хүн, хуулийн этгээдэд гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангах зорилгоор тодорхой үүрэг хүлээлгэх, энэ тухай мэдэгдэл хүргүүлэх;
- төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг эзэмшиж, ашиглаж байгаа этгээдийн орон байрнаас бусад газар, барилга байгууламж, агуулах сав, эзэмшил газарт нэвтрэн орох, үзлэг хийх;
- төлбөр төлөгчийг албадан нүүлгэхээс бусад тохиолдолд ахлах шийдвэр гүйцэтгэгчийн зөвшөөрснөөр төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг эзэмшиж, ашиглаж байгаа этгээдийн орон байранд нэвтрэн орох, үзлэг хийх;
- гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг биелүүлэх зорилгоор төлбөр төлөгчийн бие, бэлэн мөнгө, бусад хөрөнгөд үзлэг хийх, тэдгээрийг

[27] Мөн тэнд.

битүүмжлэх, барьцаалах, хураан авах, худалдан борлуулах, хураан авсан эд зүйл, хөрөнгийг хадгалуулах, хамгаалуулахаар хүлээлгэн өгөх;

- хуульд заасан үндэслэл, журмын дагуу битүүмжилсэн, барьцаалсан, хураан авсан эд зүйл, хөрөнгийг үнэлэх, уг ажиллагаанд үнэлгээчнийг оролцуулах;
- төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг эрэн сурвалжлах;
- төлбөр төлөгчийн эд хөрөнгө, түүний эрхийн бүртгэлийн талаар улсын бүртгэлийн байгууллагад хандах, лавлагаа, тодорхойлолт гаргуулах;
- иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогчоос гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх;
- төлбөр төлөгчийн банк, эрх бүхий хуулийн этгээд дэх мөнгөн хадгаламж, харилцах дансан дахь хөрөнгөөс суутгал хийх, дансны зарлагын гүйлгээг хаах, банк, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох, эсхүл эзэмшиж байгаа дансны орлого, зарлагын гүйлгээнд хяналт тавих;
- төлбөр төлөгчийн улсын бүртгэлд бүртгэгдсэн эрхийг түдгэлзүүлэх;
- төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх;
- үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчийн удирдлагад шилжүүлэх;
- худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөрт тооцон суутгаж төлбөр авагчид шилжүүлэх, уг зорилгоор албадан чөлөөлөх;

Шийдвэр гүйцэтгэгч баталгаажуулах арга хэмжээг явуулахдаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан арга журмын дагуу тогтоосон хугацаанд гүйцэтгэх бөгөөд зөрчсөн тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр холбогдох эрх бүхий тушаалтанд гомдол гаргах үндэслэл үүснэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд “Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд шийдвэр гүйцэтгэгчийн явуулсан арга хэмжээ, түүний гаргасан шийдвэрийг зөвшөөрөөгүй тохиолдолд тухайн арга хэмжээг гүйцэтгэсэн өдрөөс хойш, энэ тухай мэдээгүй бол олж мэдсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор ахлах шийдвэр гүйцэтгэгчид гомдол гаргаж болно. Ахлах шийдвэр гүйцэтгэгч гомдлыг 14 хоногийн дотор шийдвэрлэж, тогтоол гаргана. Тогтоолыг зөвшөөрөөгүй тохиолдолд хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид, ерөнхий шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно.”[28] гэж заасан.

Юуны өмнө гомдол гэж юуг ойлгох талаар авч үзье.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд "гомдол гэж төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх

[28] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл №24.

чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлтийг"[29], "өргөдөл, гомдлыг шийдвэрлэх" гэж өргөдөл, гомдолд дурдсан асуудлыг бүх талаас нь судлан үзэж, түүний дагуу хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох арга хэмжээ авсныг мэдэгдэж, энэ хуульд заасан хугацаанд багтаан хариу өгөхийг[30] хэлнэ гэж заасан байдаг бол академич С.Нарангэрэл "Монгол улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг" бүтээлдээ "Төрийн байгууллага албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлт. Гомдол гаргагч нь гомдлынхоо хариуг авах, гомдолтойгоо холбогдуулж тайлбар, нотлох баримт гаргах, гомдлоосоо татгалзан буцаан авах, өгсөн хариуг зөвшөөрөөгүй тохиолдолд зохих дээд шатны албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"[31] гэж тодорхойлсон байна.

Монгол хэлний тайлбар тольд "Үйл явдал сэтгэлд нь тохироогүйгээс гуньхран, гутан шаналахын нэр: гомдол айлтгах /гомдол гаргах/, гомдол барагдах /гомдол тайлагдах/, гомдол гаргах /гомдол мэдүүлэх, гомдсоноо илэрхийлэх/, гомдол нэхэх /гомдолтой байгаагаа илэрхийлэх, гомдлоо тайлагдах /гомдохоо болих/, гомдол эрэх /гомдсон учраа илэрхийлэн өчих/" гэж тус тус тайлбарлажээ.[32]

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлын 35 орчим хувийг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр гаргасан өргөдөл гомдол эзэлж байна.[33]

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гомдол гэж шийдвэр гүйцэтгэгчийн гаргасан шийдвэр хууль бус, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хууль зөрчиж, эрхийг хөндсөн гэж талуудаас гаргасан гомдлыг ойлгоно.

Талуудаас гаргасан гомдлыг ахлах шийдвэр гүйцэтгэгч хүлээн авч шалган шийдвэрлэх буюу урьдчилан шийдвэрлүүлэх ажиллагаа явуулна.

Урьдчилан шийдвэрлэх ажиллагаа гэж иргэн, хуулийн этгээдийн гомдлоор дээд шатны болон гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллага, албан тушаалтнаас гомдол хянан хэлэлцэх үе шатыг хэлэх бөгөөд тухайн эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргасан алдаагаа засах боломж олгодог.

Гомдол хангагдсан тохиолдолд шүүхээр явж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлж цаг алдахгүй, асуудлыг богино хугацаанд шийдвэрлэх боломжтой юм.

---

[29] Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль. Уб., 1995. Төрийн мэдээлэл эмхэтгэл №7.
[30] Мөн тэнд
[31] Монгол улсын хууль зүйн нэвтэрхий толь. Уб., 2021. 84 дэх тал.
[32] Монгол хэлний тайлбар толь. Уб., 2016. 127 дахь тал.
[33] ШШГЕГ-ын үйл ажиллагааны тоон мэдээ.

Ахлах шийдвэр гүйцэтгэгч талуудын гаргасан гомдлыг шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахдаа хэд хэдэн нөхцөл байдлыг тодруулан шалгах шаардлагатай. Үүнд:

- гомдол гаргах эрхтэй эсэх, төлөөлөх эрхийг хянах
- хуулиар тогтоосон гомдол гаргах хугацааг хянах
- тодорхой төрлийн ажиллагаа явуулах хуулиар тогтоосон цаг, зөвшөөрлөөр хийгдэх ажиллагааны журам зөрчсөн эсэхийг хянах
- тодорхой төрлийн ажиллагаа явуулахдаа хуулиар тогтоосон журам зөрчсөн эсэхийг хянах
- хөндлөнгийн гэрч оролцуулсан байдлыг хянах
- Эрүүгийн болон зөрчлийн талаарх гомдол мэдээлэл эсэхийг хянах

Гомдол гаргах эрхтэй эсэх, төлөөлөх эрхтэй эсэх:

Гомдол гаргагч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх баримт бичигт заасан шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд эсхүл эрх ашиг нь хөндөгдсөн гуравдагч этгээд мөн эсэх, иргэний эрх зүйн зарим, эсхүл бүрэн бус чадамжтай, иргэний эрх зүйн чадамжгүй этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах тэдгээрийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч мөн эсэхийг гүйцэтгэх баримт бичиг, иргэний баримт бичигтэй тулган үзэх нь зүйтэй. Талуудын эрх залгамжлагч, төлөөллийн томилсон, эрх олгосон, гэрчилсэн баримт бичиг, тэдгээрийн иргэний баримт бичиг хавсаргасан эсэхийг хянах үзэх зайлшгүй шаардлагатай.

Ингсэнээр шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хамааралгүй этгээд гомдол гаргаж, ажиллагааг удаашруулах боломжийг хаах юм.

Гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа:

Хуулиар тогтоосон гомдол гаргах хугацааг хянахдаа ажиллагаа явагдсан өдрөөс эсхүл мэдсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор гомдлоо гаргасан эсэхийг гүйцэтгэх баримт бичигт авагдсан тухайн ажиллагаанаас хойш ямар хугацаа өнгөрсөн талаар хянаж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хугацаандаа гомдлоо гаргасан үгүйг тухайн байгууллагын өргөдөл, гомдол хүлээн авсан бүртгэлтэй тулган үзнэ.

Хугацааг цаг ажлын өдөр, хоног, сар, жилээр тооцох бөгөөд тоолж эхэлсэн минут, цаг, хоногийг хугацаа тоолоход оруулан тоолохгүйг анхаарах шаардлагатай. Мөн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны баримт бичгийг тогтоосон хугацааны сүүлийн өдрийн 24 цагийн дотор ажиллагааны талуудад хүргүүлсэн, эсвэл шуудангийн байгууллагад шилжүүлсэн бол хүргүүлсэнд тооцдог.

Зөвшөөрлөөр хийгдэх ажиллагааны журам зөрчсөн эсэх:

Шийдвэр гүйцэтгэгч иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээг ажлын бус өдөр явуулах, эсхүл ажлын өдрийн 22.00 цагаас 06.00 цагийн хооронд гүйцэтгэх шаардлагатай тохиолдолд ахлах шийдвэр гүйцэтгэгчээс

зөвшөөрөл авч гүйцэтгэх бөгөөд явуулсан шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар шийдвэр гүйцэтгэгчийн тэмдэглэлд тусгасан эсэхийг хянан үзнэ.

Хойшлуулшгүй нөхцөл байдлын улмаас баталгаажуулах арга хэмжээг шууд гүйцэтгэсэн тохиолдолд 24 цагийн дотор ахлах шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэнэ. Энэ талаар тэмдэглэлд тусгаж баталгаажуулсан байхыг шаарддаг.

Хөдлөнгийн гэрч оролцуулсан эсэх:

Төлбөр төлөгчийн орон байр, эд хөрөнгө байгаа газарт нэвтрэх, эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх, түүнийг хураан авах ажиллагааг хөндлөнгийн хоёроос доошгүй гэрчийн оролцоотой явуулна. Хөндлөнгийн гэрчээр иргэний эрх зүйн бүрэн чадамжтай, тухайн иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар хувийн ашиг сонирхолгүй, өөр хоорондоо, эсхүл иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бусад оролцогчтой төрөл, садангийн, эсхүл ажил үүргийн холбоогүй хүнийг оролцуулна.

Хөндлөнгийн гэрчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний бүртгэлийн дугаар болон бусад мэдээллийг тэмдэглэлд заавал тусгасан байхыг шаардана. Мөн хөндлөнгийн гэрчид шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эхлэхийн өмнө шийдвэр гүйцэтгэгч түүний эрх, үүрэг, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар санал гаргаж болох талаар тайлбарлаж өгнө. Хэрэв шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хөндлөнгийн гэрчээс санал гаргасан бол энэ талаар тэмдэглэлд тусган гарын үсэг зуруулан баталгаажуулсан байна.

Битүүмжлэх, барьцаалах, хураахдаа тогтоосон журам зөрчсөн эсэхийг шалгах:

Шийдвэр гүйцэтгэгчийн битүүмжлэх, барьцаалах, хураах тухай шийдвэр хуулийн шаардлага хангасан эсэх, тэмдэглэлээр баталгаажуулсан эсэх, битүүмжилсэн хөрөнгийн захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлж бүртгэлийн байгууллагад хүргүүлсэн эсэх, эзэмших ашиглах эрх хязгаарлах ажиллагаа явуулсан эсэх, хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг шийдвэрлэсэн эсэх, төлбөр төлөгчид төлбөр төлөх хугацаа тогтоосон эсэх, төлбөрт гаргуулахыг хориглосон хөрөнгийг битүүмжилж, хураасан эсэхийг заавал хянах шаардлагатай.

Мөн битүүмжлэх, барьцаалах, хураах ажиллагааг явуулахдаа ажлын байрандаа эсхүл тухайн байршил хаягаас өөр газар байршилд тогтоол үйлдэх, өөр өөр хаягт байрлалтай эд хөрөнгийг нэг тогтоолоор битүүмжлэх, хураах ажиллагаа явуулах, төлбөр төлөгчийн санхүүгийн блансанд тусгагдсан хөрөнгийн бүртгэлээр битүүмжлэх тогтоол үйлдэх, тухайн ажиллагааны талаар тэмдэглэл үйлдэхгүй байх зэрэг зөрчлүүд ихээхэн гардгийг анхаарах хэрэгтэй.

Төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгө, үнэт цааснаас бусад хөрөнгийг битүүмжилсэн бол энэ тухай тэмдэглэл үйлдэж, жагсаалт гаргах ёстой.

Шинжээч томилоход анхаарах асуудал:

Шийдвэр гүйцэтгэгч хөрөнгө үнэлүүлэхээр хөрөнгийн үнэлгээчин, шинжээч томилохдоо тогтоол үйлдсэн эсэх, шинжээчид эрх, үүрэг танилцуулж, хүлээлгэх хариуцлага сануулан тэмдэглэлээр баталгаажуулсан эсэх, тогтоолд үнэлэх хөрөнгийн мэдээлэл, үнэлгээ тогтоох хугацаа зэргийг тусгасан эсэхийг хянана.

Мөн өөр өөр хаягт байршилтай хөрөнгүүдэд үнэлгээ тогтоолгох бол хөрөнгө тус бүрд шинжээч томилох тогтоол үйлдсэн байхыг шаардана. Үнэлгээг тогтоосон хугацаанд талуудад танилцуулсан эсэх, үнэлгээний талаар талуудаас гаргасан санал тэмдэглэлд тусгасан эсэхийг хянах шаардлагатай.

Гомдол хянан шийдвэрлэх:

Ахлах шийдвэр гүйцэтгэгч талуудын гаргасан гомдлыг хянаад, гаргасан гомдол нь үндэслэлтэй бол тогтоол үйлдэн гомдол гаргагчид хариуг өгч, явагдсан шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүчингүй болгон зөвтгөх явуулахыг шийдвэр гүйцэтгэгчид даалган шийдвэрлэнэ.

Хэрэв гаргасан гомдол нь үндэслэлгүй бол гомдлыг хангахаас татгалзсан үндэслэлийг дурдан тогтоол үйлдэн хариуг өгч шийдвэрлэнэ.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч талуудын гаргасан дараах гомдолд хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй бөгөөд энэ нь Шүүхэд хандан гаргах буюу Шүүхийн харъяалалын гомдол юм. Үүнд:

- талуудын хөрөнгийн үнэлгээний талаарх гомдол
- битүүмжилсэн хөрөнгийг чөлөөлүүлэх бие даан шаардлага гаргасан гуравдагч этгээдийн гомдол
- хураагдсан хөрөнгийг өмчлөх эрхтэй холбоотой маргаан гомдол
- зөрчлийн үйлдлийн талаарх гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагаа тусгай журмаар зохицуулагдах

Ахлах шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогчдоос гаргасан гомдол нь эрүүгийн болон зөрчлийн талаарх гомдол мэдээлэл байвал холбогдох байгууллагад шилжүүлнэ. Мөн шүүхийн харьяаллын гомдол байвал энэ талаар гомдол гаргагчид мэдэгдэн гомдлыг буцаан шийдвэрлэнэ.

---o0o---

ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГОД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ, АНХААРАХ АСУУДАЛ

HUMAN RESOURCES OF THE EXECUTIVE ANALYSIS AND ATTENTION ISSUES



Б.Даваадорж
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын
Шийдвэр гүйцэтгэх албаны
Мэргэжлийн удиртгалын хэлтсийн ахлах мэргэжилтэн,
хууль зүйн магистр, ахлах дэслэгч.

Товч утга: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 32 дугаар зүйлд төлбөр авагч гэж “Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж түүнийг сэргээх, хамгаалахаар гүйцэтгэх баримт бичигт заасан хүн, хуулийн этгээдийг” ойлгохоор заасан.

Түлхүүр үгс: Шийдвэр гүйцэтгэгч, хүний нөөц

Abstract: Article 32 of the law on judicial execution teaches that the recipient is "the person and the legal entity taught in the executive document to restore and protect him, considering that his or her legal interests have been violated."

Keywords: Decision Executive, human resources.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замналыг авч үзвэл 1921 оны 7 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын Шүүх яамны харьяанд “Гяндан салаа” нэртэйгээр байгуулагдсанаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үндэс суурь бий болсон гэж үздэг бөгөөд түүхэн эх сурвалжаас харахад өмнөх тогтолцооны үед иргэний шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг Шүүхийн байгууллагын харьяанд шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлдэг байсан бөгөөд 1996 оноос “...Хууль зүйн яамны Хорих байгууллагуудыг удирдах газрыг нэгтгэн Хууль зүйн яамны Шүүхийн шийдвэр биелүүлэх газар болгон зохион байгуулах болсноор Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын харьяанд үйл ажиллагаа явуулж ирсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үүсэл хөгжил шүүхийн байгууллагын үүсэл хөгжилтэй салшгүй холбоотой. Шүүн таслах ажиллагааны шууд үргэлжлэл болох шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үйл ажиллагааг нэгэн үед

түүний бүтцэд хамаардаг тодорхой албан тушаалтан, хожмоо хуулийн хэллэгээр тогтоол гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч эрхэлж гүйцэтгэдэг болсон байна. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь өөрийн харьяаллаа түүхэндээ 4 удаа өөрчилсөн байна.

Анх Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага хурлын тэргүүлэгчдийн 1926 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр баталсан "Аливаа шүүх газруудын дүрэм"-ийн дагуу Нийслэл хотын шүүн таслах байгууллагыг зохион байгуулжээ. Мөн 1930 онд нийслэл хотын шүүн таслах байгууллагыг “Улаанбаатар хотын шүүх” хэсэгтэйгээр шинэчлэн байгуулж, шүүхийн тогтоол гүйцэтгэх үйл ажиллагааг шүүгч, нарийн бичгийн дарга 1953 он хүртэл гүйцэтгэн явуулж байсан ба 1953 оноос Улаанбаатар хотын шүүхэд тогтоол гүйцэтгэгч гэсэн орон тоотой болсон байна.[34]

Тэгвэл шийдвэр гүйцэтгэгч гэж хэн бэ? Өнөөгийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд шийдвэр гүйцэтгэгч нь эрх зүйн дээд боловсролтой, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас зарласан шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад тэнцэж, иргэн, эрүү, захиргаа, зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх олгогдсон 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн байхаар хуульчилсан.

Улмаар Монгол Улсын эрүүгийн ял шийтгэлийн бодлого өөрчлөгдөн 2017 онд Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бүтцэд Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба шинээр бий болсноор хэрэгжүүлж байгаа чиг үүргээс хамаарч иргэний шийдвэр гүйцэтгэгч, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан шийдвэр гүйцэтгэгч гэсэн нэр томьёо гарч ирээд байна.

Шийдвэр гүйцэтгэгчийн нөөц бүрдүүлэлтийн бодлогын зарим асуудал

Өдгөө Монгол Улсын хэмжээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг 3700 гаруй ажилтан, алба хаагчийн бүрэлдэхүүнтэй Засгийн газрын том агентлаг болж төлөвшсөн боловч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нийт бие бүрэлдэхүүний 10 хүрэхгүй хувь буюу 237 шийдвэр гүйцэтгэгч, 44 ахлах шийдвэр гүйцэтгэгч гардан гүйцэтгэж, энэхүү нэр хүндтэй бөгөөд хүнд албанд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн этгээдийн эрхийг сэргээн, хамгаалах зорилгын төлөө зүтгэж байна.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гардан гүйцэтгэж байгаа шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдал, хүний нөөцийн бодлогын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагад судлаачийн байр сууринаас дараах дүн шинжилгээг хийв.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаалтан, шийдвэр гүйцэтгэгч, хорих байгууллагын алба хаагч нараас бүрдэхээр, мөн шийдвэр

[34] А.Лхагва “Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй” 2012 он

гүйцэтгэгч нь Ерөнхий шийдвэр гүйцэтгэгч, ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгчээс бүрдэнэ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчаар Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан шаардлага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тогтоосон журам, эрүүл мэнд, бие бялдар, боловсрол, мэргэшил, ёс зүйн шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан, арван найман насанд хүрсэн, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байгаагүй Монгол Улсын иргэнийг ажиллуулахаар тус тус хуульчилсан.

Шийдвэр гүйцэтгэгч нь дээрх шалгуур үзүүлэлтийг хангасан, шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн байна.

Шийдвэр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 2017 оны журамд зааснаар шийдвэр гүйцэтгэгчээр ажиллах мэдлэг, чадвар, зан төлөв, ёс зүйн шалгууруар сонгон шалгаруулдаг бөгөөд мэдлэг, чадварын шаардлагыг эрх зүйн ерөнхий мэдлэг болон мэдээллийн технологийн хэрэглээний программ ашиглалтын өгөгдөл бүхий сорил авч сонгон шалгаруулдаг.

Шийдвэр гүйцэтгэгчээр ажиллах зан төлөв, ёс зүйн шаардлагыг монгол хэлний ярианы болон бичгийн соёлын чадварыг илэрхийлэхүйц тодорхой сэдэв сонгон эсээ бичүүлэх, иргэний болон захиргааны, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлийн хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх тухай асуулга тавьж, шийдвэрлүүлэх аргаар шалгаруулдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд нийт бие бүрэлдэхүүний 10 хувийг иргэний шийдвэр гүйцэтгэгч эзэлж байгаа нь тун чамлалттай үзүүлэлт бөгөөд улсын хэмжээнд шүүхээр шийдвэрлэгдсэн гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулж байгаа шийдвэр гүйцэтгэгчдийн тоонд хувааж үзэхэд нэг шийдвэр гүйцэтгэгчид ногдох гүйцэтгэх баримт бичгийн тоо, түүнийгээ дагаад ажлын ачаалал өндөр байдаг нь судалгаанаас харагддаг.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2017 оны хамтарсан тушаалаар шийдвэр гүйцэтгэгчид ногдох жишиг, норматив тогтоохдоо харьяалах нутаг дэвсгэрийг бүсчилсэн байдлаар тогтоож 1 дүгээр бүсэд хамаарах газар, нэгжийн 1 шийдвэр гүйцэтгэгч 180 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахаар, 2 дугаар бүсэд хамаарах газар, нэгжийн 1 шийдвэр гүйцэтгэгч 150 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахаар, 3 дугаар бүсэд хамаарах газар, нэгжийн 1 шийдвэр гүйцэтгэгч 120 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахаар тогтоосон байдаг.

Гэвч бодит байдал дээр шийдвэр гүйцэтгэгч бүрийн ажлын ачаалал нь харьяалах тойргийн газар нутгийн хүн амын төвлөрлөөс шалтгаалаад зарим

тойрогт жишиг норматив заасан тооноос 38-60 хувиар их, зарим тойрогт бага байх зэргээр харилцан адилгүй байна.

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын шийдвэр гүйцэтгэгчийн ажлын нэг өдрийг сонгон ажлын байрны зураглал хийхэд дараах дүр зураг харагдаж байна.

- Ажлын 7 хоногийн эхний өдөр ахлах шийдвэр гүйцэтгэгчээр батлуулсан төлөвлөгөөний дагуу төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн хаягаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах гүйцэтгэх баримт бичгийг ангилан бэлдэхэд 30 минут,
- Шийдвэр гүйцэтгэгчтэй уулзахаар ирсэн 3 төлбөр төлөгч, төлбөр авагч иргэнийг хүлээн авч уулзан санал хүсэлт, гомдлыг сонсон, тайлбар авч, мэдэгдэл гардуулахад 1 цаг 15 минут,
- Шийдвэр гүйцэтгэх газарт ирсэн яаралтай судалгааг гаргаж өгөхөд 1 цаг,
- Төлбөрийн дансанд төвлөрсөн мөнгийг төлбөр авагч нарт олгох 6 мэдэгдлийг бичиж, ахлах шийдвэр гүйцэтгэгч болон ахлах нягтлан бодогчоор хянуулж, гарын үсэг зуруулах /талуудын өр төлбөртэй эсэхийг бүртгэлийн ажилтнаас тодруулж тэмдэг дарж баталгаажуулах ажиллагаа хамаарна/-д 35 минут,
- Шүүхээс шинээр ирсэн 3 гүйцэтгэх баримт бичгийг хавтаслан нааж, төлбөр авагчтай байгуулсан зардлын гэрээг нягтлан бодогчоор шалгуулж, ахлах шийдвэр гүйцэтгэгчээр батлуулах, иргэний болон эд хөрөнгийг тогтоохоор цахим сангаас лавлагаа авах, лавлагаагаар тогтоогдсон хөрөнгийн захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлэх албан бичгийг төлөвлөж, холбогдох газруудад хүргүүлэх, тогтоосон хугацаанд төлбөрөө төлөөгүй 5 төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн харилцах дансыг битүүмжилж, хасалт хийх тогтоолыг төлөвлөж, ахлах шийдвэр гүйцэтгэгчээр хянуулан, газрын даргаар батлуулж 12 арилжааны банканд цахимаар болон шуудангаар хүргүүлэх /бусад байгууллагуудад хүргүүлэх албан бичигт холбогдох баримт бичгийг хуулбарлах, тэмдэг дарж баталгаажуулах ажиллагааг гүйцэтгэдэг/ 2 цаг,
- Төлбөрөө бүрэн төлж барагдуулсан 1 иргэн, хуулийн этгээдийн харилцах данс болон тээврийн хэрэгслийн захиран зарцуулах эрхийг сэргээх, мөн төлбөрт гаргуулж болохгүй орлого буюу хүүхдийн мөнгөний данс сэргээлгэхээр хүсэлт гаргасан 1 иргэний харилцах дансыг сэргээх тогтоолыг төлөвлөж, ахлах шийдвэр гүйцэтгэгчээр хянуулан, газрын даргаар батлуулах /бүртгэлийн ажилтнаас данс сэргээлгэх иргэнийг бусдад төлбөртэй эсэхийг шалгах ажиллагаа хамаарна/-д 30 минут,
- Төлбөр төлөгч, төлбөр авагч талууд харилцан эвлэрч, төлбөртөө тооцон хөрөнгө шилжүүлэх хүсэлт гаргасны дагуу дүүргийн улсын бүртгэлийн хэлтэст өмчлөх эрх шилжүүлэх албан бичгийг төлөвлөж, ахлах шийдвэр гүйцэтгэгч, дэд даргаар хянуулан, газрын даргаар гарын үсэг зуруулах

/дагалдах баримт бичгийг хуулбарлан тэмдэг дарж баталгаажуулах ажиллагаа хамаарна/-д 45 минут,

- Хотын төв буюу орон сууцны хороололд 1 албан байгууллагад яаралтай албан бичгийг хүргэж, төлбөр төлөгч 2 хуулийн этгээд, 2 иргэний оршин суугаа хаягаар очиж эд хөрөнгөнд үзлэг, нэгжлэг хийх, үл хөдлөх эд хөрөнгө битүүмжлэх, мэдэгдэх хуудас гардуулах ажиллагаа явуулахад 3 цаг,
- Хотын зах буюу ажлын байрнаас 25-30 км зайд байрлах гэр хорооллын 2 төлбөр төлөгч иргэний оршин суугаа хаягаар очиж хөрөнгө хураан авах, мэдэгдэл гардуулах ажиллагаа явуулахад 3 цаг /хаяг тодорхойгүйгээс хайж олоход хугацаа их ордог/,
- Тухайн өдрийн хийж гүйцэтгэсэн ажлыг ахлах шийдвэр гүйцэтгэгчид шалгуулах /хийсэн ажлаа цахим бүртгэлд оруулж, дэвтэрт бичиж тэмдэглэх, гүйцэтгэх баримт бичгийн баяжилт, товъёог хийх ажил хамаарна/-д 40 минут,
- Дараагийн өдөр шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах гүйцэтгэх баримт бичгээ бэлдэх, шаардлагатай албан бичиг, лавлагааг төлөвлөх, гүйцэтгэх баримт бичгүүдээ эмхэлж цэгцлэх, товъёог бичих, холбогдох байгууллагуудаас ирсэн лавлагааг гүйцэтгэх баримт бичгийг нааж хавсаргахад 1 цаг 30 минут,

Шийдвэр гүйцэтгэгч өдөр тутамдаа тогтмол хийдэг ажлуудын цагийг нэгтгэн дүгнэхэд 13 цаг 50 минут болж байгаа юм[35].

Зураг авалтад багтсан ажлаас гадна төлбөр төлөгч, бусад этгээдийн хүч түрсэн эсэргүүцэл, төлбөрөөс зайлсхийсэн үйлдэлтэй тулгарч, ажлын байранд байнга сууж ажиллахаас илүү төлбөр төлөгчийн хаяг, байршил тодруулах, төлбөр төлөгч, тэдний хөрөнгийн мэдээлэл, нотлох баримтыг цуглуулах, өөрийн гүйцэтгэсэн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой гомдол, нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхэд төлөөлөн оролцох, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн дуудсан цагт очиж тайлбар, мэдүүлэг өгөх, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэж хариу өгөх гэх мэт ажлыг хийж гүйцэтгэдэг.

Иймээс 2017 он баталсан 3 сайдын хамтарсан тушаалаар шийдвэр гүйцэтгэгчид ногдох жишиг, норматив бодит байдалд нийцэж байгаа эсэх нь эргэлзээтэйгээс гадна уг норматив батлагдсанаас хойш 4 жил орчим хугацаа өнгөрч, цаг үеийн нөхцөл байдал тодорхой хэмжээнд өөрчлөгдөн нийслэлийн хэмжээнд 1 шийдвэр гүйцэтгэгч 180 гүйцэтгэх баримт бичигт богино хугацаанд үр дүн гарахуйц хэмжээнд хүрч ажиллах боломж хязгаарлагдмал болсон.

Дээрх нөхцөл байдлыг илүү бодитой жишээн дээр авч үзье.

---

[35] Ю.Оюунаа, М.Хажидмаа. “Шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачаалалд хийсэн судалгаа” (2020).

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нэг онцлог нь төлбөр төлөгчийн хаяг, эд хөрөнгө тогтоох, хаягаар очиж тайлбар мэдүүлэг авах, мэдэгдэх хуудас гардуулах, эд хөрөнгө хураах, битүүмжлэх, үзлэг, нэгжлэг хийх, бусад иргэн хуулийн этгээдээс тайлбар тодорхойлолт, лавлагаа авах зэргээр албан тасалгаанд бус ажлын байрнаас гадуур хийж гүйцэтгэх ажиллагаа нь шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангуулах, бодит биелэлтийг ахиулахад шийдвэрлэх нөлөө үзүүлж байдаг.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны олон жилийн практикаас харахад 2011-2015 он хүртэл нэг шийдвэр гүйцэтгэгч өдөрт 8-10 гүйцэтгэх баримт бичигт ажлын байранд бус төлбөр төлөгчийн хаягаар явуулах ажиллагааг гүйцэтгэх боломжтой байсан бол өдгөө Улаанбаатар хотын суурьшлын бүсийн тэлэлт, хүн амын нягтаршил, замын түгжрэл, хаягжилт зэргээс шалтгаалж, 5-6 жилийн өмнөхтэй адил хэмжээнд гадуур ажиллагаа зохион байгуулах боломж хязгаарлагдмал болсон бөгөөд бичиг баримт төлөвлөх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогчдыг дуудаж уулзах, мэдээ судалгаа гаргах, удирдах байгууллагад танилцуулга хүргүүлэх, цахим бүртгэл, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны баяжилт хийх, хурал, сургалт, цэрэгжилтийн бэлтгэл зэрэг байгууллагын дотоод үйл ажиллагаанд оролцох, ажлын байранд хийж гүйцэтгэх ажлыг амжуулахын зэрэгцээ нэг шийдвэр гүйцэтгэгч хариуцаж байгаа тойргийн нутаг дэвсгэрийн байршлаас шалтгаалж, нэг өдөрт 5-6 гүйцэтгэх баримт бичигт хаягт ажиллах бодит боломжтой болжээ.

Дээрх нөхцөл байдалтай уялдуулан өнөөдрийн түвшинд 2017 онд тогтоосон жишиг, нормативын дагуу Нийслэлийн хэмжээнд 180 гүйцэтгэх баримт бичиг хариуцдаг шийдвэр гүйцэтгэгч өдөрт дунджаар 6 гүйцэтгэх баримт бичигт р ажиллагааг зохион байгуулахад ямар хугацаанд нийт гүйцэтгэх баримт бичигт бүрэн хүрч ажиллах боломжтойг тооцоолол хийж үзье.

Шийдвэр гүйцэтгэгч 7 хоногийн нэг өдөр ажлын байранд байж, иргэд хүлээн авч, 4 өдөр гадуур ажиллагаанд явж, 1 өдөрт 6 төлбөр төлөгчийн хаягаар очих бодит боломжтой гэж үзвэл, 7 хоногт 24 гүйцэтгэх баримт бичигт хаягт ажиллагаа зохион байгуулах тооцоо гарна.

Үүнийг 180 гүйцэтгэх баримт бичигт хуваахад 7-8 долоо хоног буюу 2 сар орчим хугацаанд бүх гүйцэтгэх баримт бичигт хаягаар ажиллагаа зохион байгуулах боломжтой гэсэн тооцоо гардаг, өөрөөр хэлбэл бүх материалдаа жигд хүрч ажиллана гэвэл хамгийн эхний 7 хоногт хаягаар очсон гүйцэтгэх баримт бичигт 2 сар орчмын дараа дахин хаягаар очих бодит боломж харагдаж байна.

Дээрх нөхцөл байдлаас шалтгаалан төлбөр авагч нь тогтмол ирж уулздаг, төлбөр төлөгдөх боломжтой, эд хөрөнгө тодорхой, барьцаатай, эсвэл байнга тогтмол өргөдөл гомдол гардаг материалд илүү ач холбогдол өгч, төлбөр төлөгчийн хаяг, нуугдмал эд хөрөнгө, орлого тогтоох, шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийсэн этгээдэд хариуцлага тооцуулах нарийвчилсан

ажиллагаанууд орхигдон шүүхийн шийдвэр бүр заавал биелэгдэх суурь зарчим алдагдах хандлага ажиглагддаг.

Иймд жишиг нормативыг эргэн харж, шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачааллыг бодитой тогтоох, үүнтэй холбоотойгоор шийдвэр гүйцэтгэгчийн тоог нэмэгдүүлэх хүний нөөцийн оновчтой бодлого хэрэгжүүлэх зайлшгүй хэрэгцээ байгааг анхаарах шаардлагатай байна.

Шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт, сургалт

Хүний нөөцийн бодлоготой холбоотойгоор шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт, томилогдохын өмнөх болон томилогдсоны дараах мэргэшүүлэх сургалтыг үр дүнтэй, зөв зохион байгуулах асуудал юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль шинээр батлагдан, хэрэгжиж эхэлснээс хойших Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хэмжээнд 2017 онд 2, 2018 онд 26, 2019 онд 10 шийдвэр гүйцэтгэгч, улсын хэмжээнд нийт 40 шийдвэр гүйцэтгэгч өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн бол 2017, 2018 онд тус бүр 1 ахлах шийдвэр гүйцэтгэгч ажлаас чөлөөлөгдсөн тоон үзүүлэлт байдаг. Мөн дээрх хугацаанд 5 шийдвэр гүйцэтгэгч, 1 ахлах шийдвэр гүйцэтгэгч ажлын байрны тодорхойлолт болон хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлээгүй үндэслэлээр ажлаас халагдсан байна.

Энэ тоо баримтаас харахад шинээр батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар шийдвэр гүйцэтгэгчийг урамшуулах зохицуулалтгүй болсон, мөн 1 шийдвэр гүйцэтгэгчид ногдох ажлын ачаалал их байснаас шалтгаалж, шийдвэр гүйцэтгэгч өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх тохиолдол 2018-2019 онд нэмэгдэх хандлагатай байсан[36] байна.

Дээрх шалтгаанаас гадна хүүхэд асрах чөлөө авах, эрүүл мэндийн шалтгаанаар ажлаас чөлөөлөгдөх зэргээр сул орон тоо гарах шийдвэр гүйцэтгэгчдийн хөдөлгөөн их байдаг тул 2015 оноос эхлэн жил бүр /2016 онд зохион байгуулагдаагүй/ шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж жилдээ 40-60 иргэн сонгон шалгаруулалтад тэнцэж, шийдвэр гүйцэтгэгчийн нөөц бүрдүүлдэг боловч шийдвэр гүйцэтгэлийн сул орон тоонд шийдвэр гүйцэтгэгч томилогдоход тодорхой хугацаа шаардагддаг нь дараах судалгаанаас харагдаж байна.

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын сул орон тооны судалгаа /2017-2019 он/[37]

[36] С.Бямбарагчаа, “Үндэсний шуудан” сонин 2020.05.19-ний өдрийн 5-р нүүр ярилцлага
[37] НШШГГазрын сул орон тооны судалгаа 2020 он

д/д	2017 он	Сул байсан хугацаа	2018 он	Сул байсан хугацаа	2019 он	Сул байсан хугацаа
1	177-тойрог		155-р тойрог	10 сар	223-тойрог	8 сар
2	129-тойрог		151-тойрог	3 сар	122-тойрог	6 сар
3	140 тойрог		150-тойрог	5 сар	179-тойрог	5 сар
4			185-тойрог	3 сар	165-тойрог	7 сар
5			184-тойрог	7 сар	177-тойрог	
6			140-тойрог			
7			180-тойрог	1 сар		
8			178-тойрог	3 сар		
9			127-тойрог	3 сар		
10			124-тойрог	3 сар		
11			125-тойрог	3 сар		
12			188-тойрог	1 жил		
13			167-тойрог	5 сар		
14			158-тойрог	8 сар		
15			126-тойрог	2 сар		
16			182-тойрог	3 сао		
17			171-тойрог	3 сар		
18			183-тойрог	8 сар		
19			134-тойрог	5 сар		
20			177-тойрог	1 жил		
21			130-тойрог	4 сар		

Судалгаанд дүн шинжилгээ хийж үзэхэд зөвхөн 2018 онд шийдвэр гүйцэтгэгчийн 21 сул орон тоо гарч, сул орон тоонд шийдвэр гүйцэтгэгч томилогдоход дунджаар 3 сар, дээд тал нь 8 сараас 1 жилийн хугацаа шаардагдсан байх бөгөөд энэ хугацаанд шийдвэр гүйцэтгэлийн тойргийг хариуцах алба хаагчгүй байж, тэр хэмжээгээр шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлтэд нөлөөлсөн гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Иймд шийдвэр гүйцэтгэгчийн сул орон тоо гарсан тохиолдолд нөөцөд байгаа иргэдээс нэн даруй томилгоо хийхэд анхаарах шаардлагатай байна.

Мөн дээрх судалгааны тоо баримтад өөр нэг дүгнэлт хийх боломжтой байна.

Тухайлбал сул орон тоонд шийдвэр гүйцэтгэгч томилогдоход тодорхой хугацаа шаардагддаг тул энэ хугацаанд шийдвэр гүйцэтгэгчийн сонгон

шалгаруулалтад тэнцсэн иргэдийг томилогдох нэгжид дадлагажих боломж олгож тухайн нэгжийн саналыг үндэслэн шийдвэр гүйцэтгэгчээр томилох боломжтой юм.

Өөрөөр хэлбэл шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар огт ойлголтгүй, албан бичиг, тогтоол мэдэгдэл зэрэг бичиг баримт бичиг төлөвлөж үзээгүй, төрийн албан хэрэг хөтлөлтийн анхан шатны мэдэгдэхүүнгүй, ажилд хандах хандлага, ёс зүй, зан харилцаа төлөвшөөгүй хүмүүс томилогдох тохиолдол түгээмэл байгаа тул томилогдохын өмнөх сургалтыг тодорхой хугацаанд, хөтөлбөр төлөвлөгөөний дагуу зохион байгуулах шаардлага практикаас урган гарч байна.

Мөн сонгон шалгаруулалтын агуулга, хүрээг зөвхөн хууль тогтоомжийн хүрээнд хязгаарлах бус бичиг хэргийн чадвар, төрийн албан хэрэг хөтлөлтийн анхан шатны мэдлэг, хувь хүний сахилга, хандлага, логик сэтгэлгээ зэргийг сорих хэлбэрээр өргөн хүрээнд шалгаруулалтыг зохион байгуулах нь боловсон хүчний чанартай нөөц бүрдүүлэхэд ач холбогдолтой юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бодлогыг бэхжүүлэх дунд хугацааны /2020-2024 оны/ хөтөлбөрт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бодлогын хөгжлийг бэхжүүлэх, хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, судлах, сонгож бэлтгэх, оновчтой байршуулах, тэднийг тогтвор суурьшилтай ажиллуулах, төлөвшүүлэх, хөгжүүлэх арга замыг боловсруулах цогц харилцааг бий болгох зорилго[38] дэвшүүлсэн байна.

Эрхэм зорилгодоо хүрэхийн тулд үйл ажиллагааны 4 үндсэн стратеги зорилтыг дэвшүүлсэн бөгөөд хамгийн эхэнд Иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллагын шүүхээр баталгаажуулсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулахаар стратеги зорилтоо тодорхойлсон нь ололттой боловч энэ томоохон зорилтын хүрээнд хийж хэрэгжүүлэх алба хаагчид нийт бие бүрэлдэхүүний 10 хүрэхгүй хувь ажиллаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр батлагдан, мөрдөгдөж эхэлснээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоог шинээр тодорхойлж, алба хаагчийн баталгааг улс төрийн, хууль зүйн, эдийн засгийн, нийгмийн болон бусад баталгаа болгон нарийвчлан зааж шүүхийн шийдвэрийн бодит биелэлтийг нэмэгдүүлэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шуурхай, үр дүнтэй болж, иргэд олон нийтийн зүгээс шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд эерэг хандлага, шийдвэр гүйцэтгэгчийн ажилдаа хандах сэтгэл ханамжийг дээшлүүлэх нөхцөл бүрдэнэ хэмээн тооцож байсан.

[38]Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бодлогыг бэхжүүлэх дунд хугацааны /2020-2024 оны/ хөтөлбөр

Гэвч хууль хэрэгжиж эхлээд 4 дэх жилийн нүүрийг үзэж байгаа хэдий ч шүүхийн шийдвэрийн биелэлт хангалтгүй, иргэд иргэний хэргийн шүүхийн шийдвэр биелэлтэд төдийлөн сэтгэл ханамжгүй, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдаас хамгийн тогтворгүй бие бүрэлдэхүүн шийдвэр гүйцэтгэгч нар болоод байгаа нь доорх судалгаанаас харагдаж байна.

Ахлах шийдвэр гүйцэтгэгч болон шийдвэр гүйцэтгэгчдийн хөдөлгөөний судалгаа /Шийдвэр гүйцэтгэх алба 2020 он/

д/д	Албан тушаал	Тушаалын он сар өдөр	Халагдсан		Өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн	Шинээр томилогдсон
			Ажлын байрны тодорхойлолт болон хууль тогтоомжоор	Хууль зөрчин ажиллага явуулсан		
1	Шийдвэр гүйцэтгэгч	2016	-	1		17
2	Ахлах шийдвэр гүйцэтгэгч	2016	-	-	-	-
				1	**-**	**17**
1	Шийдвэр гүйцэтгэгч	2017	-	-	2	18
2	Ахлах шийдвэр гүйцэтгэгч	2017	-	-	1	1
					3	**19**
1	Шийдвэр гүйцэтгэгч	2018	2	1	26	31
2	Ахлах шийдвэр гүйцэтгэгч	2018	-	1	1	13
			2	**2**	**27**	**44**
1	Шийдвэр гүйцэтгэгч	2019	-	-	10	51
2	Ахлах шийдвэр гүйцэтгэгч	2019	-	-	-	3
					10	**54**
1	Шийдвэр гүйцэтгэгч	2020	-	1	2	15
2	Ахлах шийдвэр гүйцэтгэгч	2020	-	-	-	4

				1	**2**	**19**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөгжил дэвшил, урагш алхах алхмыг тодорхойлоход хүний нөөцийн хөгжил, тогтвортой байдал нэн тэргүүнд яригдах учраас шийдвэр гүйцэтгэгчийн нөөц бүрдүүлэх арга замыг боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай байгаа бөгөөд эрх зүйн баримт бичгийн хувьд чухал ач холбогдолтойг харуулж байна.

Хүний нөөцийн бүрдүүлэлт нь хүний нөөцийг бэхжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах, чадвартай, мэргэшсэн алба хаагч, хамт олныг бий болгохыг ойлгоно. Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт, шийдвэр гүйцэтгэгчийг сургаж бэлтгэх үе шат, газар хэлтэс, анги байгууллагад томилох оновчтой бодлого барих, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Тухайлбал Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 2018 онд нийт 63 шийдвэр гүйцэтгэгч ажилладаг. Үүнээс 31.7 хувь буюу 20 орчим шийдвэр гүйцэтгэгч тухайн онд өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн нь байгууллагын хэвийн ажиллагааг алдагдуулж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтийг ахиулахад хүндрэлтэй нөхцөл байдал үүсэх сөрөг үр дагаврыг бий болгосон байна.

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 2018 оны жилийн эцсийн мэдээний үзүүлэлтээр гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт 46,8 ажилласан бөгөөд олон сул тоогүйгээр бүрэн бүрэлдэхүүнээр үүрэг гүйцэтгэсэн тохиолдолд бодит биелэлтийн хувь илүү өндөр байх боломжтой байсныг үгүйсгэхгүй юм.

Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид шийдвэр гүйцэтгэгчийн заасан нийгмийн баталгааг ижил төстэй байгууллага болох Цагдаагийн байгууллагын алба хаагчтай харьцуулав.

нэмэгдэл	Шийдвэр гүйцэтгэгч		Цагдаагийн алба хаагч	
Төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл	5-7 жил	5 хувь	5-10 жилд	10 хувь
	8-10 жил	8 хувь	11-17 жилд	15 хувь
	11-14 жил	12 хувь	18 ба түүнээс дээш	20 хувь
	15-19 жил	15 хувь		
	20-24 жил	20 хувь		
	25-аас дээш жил	27 хувь		
Цолны нэмэгдэл	Дэслэгч	26 хувь	Цагдаагийн Дэслэгч	30 хувь
	Ахлах дэслэгч	28 хувь	Ахлах дэслэгч	
	ахмад	30 хувь	Ахмад	
	хошууч	32 хувь	Хошууч	
	Дэд хурандаа	34 хувь	Дэд хурандаа	

	хурандаа	36 хувь	Хурандаа	
Онцгой нөхцөлийн нэмэгдэл	Шийдвэр гүйцэтгэгч, ахлах шийдвэр гүйцэтгэгч	10 хувь	Цагдаагийн албан хаагч	15-25 хувь
Мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам			3 жил	5 хувь
			5 жил	10 хувь
			10 жил	15 хувь
			15 жил	20 хувь
			20 жил	25 хувь
Мөнгөн урамшуулал олгох журам			Сумд 60 сар ажилласан бол 5 жил тутамд нэг удаа	Цалингийн дунджийг 30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх мөнгөн урамшуулал

Судалгаанаас харахад цагдаагийн байгууллага нь хөдөө орон нутагт, ажлын ачаалал ихтэй газарт алба хаагчийг тогтвортой ажиллуулахын тулд 5 жил тутам тухайн алба хаагчийн цалингийн дундаж дүнг 30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх мөнгөн урамшуулал олгож байгаа эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан судалж, шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагааны урамшууллын тогтолцоог боловсронгуй болгон хуульчлах боломжтой гэж үзэж байна.

Дүгнэлт

Судалгааны ажлаас нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхэд шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачааллын судалгаа, шинжилгээг жил бүр хийж, ачааллыг бодитой үнэлж, жишиг нормативыг бодитой тогтоосон судалгааг үндэслэн шийдвэр гүйцэтгэгчийн орон тоог нэмэгдүүлэх, асуудлыг тухай бүр шийдвэрлэж байх шаардлагатай байна.

Шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулахаас гадна шалгалтын агуулгыг илүү өргөн хүрээтэй болгож, шалгуурыг өндөрсгөх, логик сэтгэлгээ болон олон талт мэдлэгийг шалгах байдлаар зохион байгуулах хэрэгцээ, шаардлага бий болж байна.

Шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэдийг томилогдохын өмнөх дадлагажих сургалтыг тодорхой хугацаанд Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын газар, нэгжид зохион байгуулж, тухайн газар, нэгжийн саналыг үндэслэн шийдвэр гүйцэтгэгчээр томилох эсэхийг шийдвэрлэж байх.

Шийдвэр гүйцэтгэгчийг ажлын байранд тогтвортой, сэтгэл ханамжтай ажиллуулахын тулд ижил төстэй байгууллагуудад мөрдөгдөж буй нийгмийн баталгааны эрх зүйн орчиныг нарийвчлан судалж, шийдвэр гүйцэтгэгчийг урамшуулах тогтолцоог бий болгож, эдийн засаг, нийгэм, улс төрийн баталгааг

сайжруулснаар мэргэшсэн, тогтвортой боловсон хүчний тогтолцоог бий болгох бодлого боловсруулж, шийдвэрлэх шаардлага зүй ёсоор гарч ирж байна гэж дүгнэж байна.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

а. Монгол эх сурвалж

1. А.Лхагва, Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй, УБ, 2012 он,
2. С.Бямбарагчаа, “Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удаашруулах зорилгоор шүүхэд үндэслэлгүй гомдол гаргах тохиолдол их байна”, Үндэсний шуудан УБ 2020 он
3. Ю.Оюунаа, М.Хажидмаа, Шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачаалалд хийсэн судалгаа, УБ 2020 он,
4. Шийдвэр гүйцэтгэх алба, “алба хаагч нарын хөдөлгөөний судалгаа”, 2020 он,
5. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын мэдээ, 2020 он,
6. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын сул орон тооны судалгаа, 2020 он,

II. Эрх зүйн эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992 он
2. Иргэний хууль. Уб., 2002 он
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2002 он
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2017 он

---o0o---

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАЛААРХ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS OF COURT DECISION EXECUTION AND LEGAL REGULATION OF ADMINISTRATIVE CASES IN THE LAW ON ENFORCEMENT OF COURT DECISIONS



Б.Мөнгөннахиа
Санхүү эдийн засгийн их сургуулийн,
Эрх зүйн тэнхимийн ахлах багш,
хуульч, өмгөөлөгч, хууль зүйн магистр.



Э.Цэрэнханд
Дотоод хэргийн их сургуулийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш,
хууль зүйн магистр, хошууч

Товч утга: Тус өгүүлэлдээ захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онол, практикийн асуудлыг хөндөн судлалаа.

Түлхүүр үгс: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, захиргааны шийдвэр гүйцэтгэл, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, захиргааны хэргийн шүүх, иргэний хэргийн шүүх

Abstract: In this article, we aim to analyze and evaluate the newly approved law on the enforcement of court decision. It is also the article examines the theory and practice of enforcement of administrative decision and enforcement of administrative court decision.

Keywords: Enforcement of court decisions, enforcement of administrative decision, enforcement of administration court decision, administrative court, civil court

Захиргааны эрх зүйд *захиргааны байгууллагын шийдвэрийг биелүүлэх* болон *захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх* гэсэн хоёр ойлголт байдаг. Захиргааны байгууллагын шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа нь захиргааны ерөнхий хуулиар зохицуулагдах бол захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар зохицуулагдаж байна.

1. *Захиргааны байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийн тухай*

Захиргааны байгууллагаас өдөр бүр иргэдэд хандан ямар нэг үйлдэл хийхийг даалгасан, хориглосон агуулга бүхий шийдвэрийг гаргаж байдаг. Энэхүү шийдвэрийг хүн, хуулийн этгээд биелүүлээгүй бол захиргааны байгууллага гаргасан шийдвэрийнхээ биелэлтийг өөрөө хариуцан гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас тусдаа захиргааны байгууллагаас өөрийн хууль ёсны шийдвэрийг биелүүлэх тухай ойлголт юм.

Захиргааны шийдвэр гүйцэтгэл хэмээх ойлголтод захиргааны байгууллагаас гаргасан захиргааны актыг албадан гүйцэтгэхийг ойлгоно.[39] Захиргааны байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийн нийтлэг зохицуулалтыг Захиргааны ерөнхий хуулийн 8-р бүлэгт хуульчилсан байна. Харин энд захиргааны шийдвэр гүйцэтгэлийн тухай ойлголтын албан ёсны тодорхойлолтыг хуульчлаагүй ба судлаач П.Одгэрэл “Захиргааны шийдвэр гүйцэтгэл гэж захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн хүрээнд гаргасан хаяглагдсан этгээдэд сөрөг нөлөөтэй үүрэг даалгавар бүхий шийдвэрийг тухайн этгээд сайн дураараа биелүүлээгүй бол түүнийг захиргааны байгууллагаас хариуцан албадан гүйцэтгүүлэх ажиллагааг ойлгоно”[40] гэж тодорхойлоод энэхүү тодорхойлолтын дагуу дараах үндсэн шинж бүхий ажиллагаа захиргааны шийдвэр гүйцэтгэлд хамаарна гэжээ.

- Захиргааны байгууллагын шийдвэр,
- Нийтийн эрх зүйн хүрээнд гарсан,
- Уг шийдвэрээр дарамт бүхий үүргийг иргэдэд даалгасан,
- Даалгасан үүргийг сайн дураараа биелүүлээгүй бол,
- Захиргааны байгууллага албадан гүйцэтгүүлнэ.[41]

Дээрхээс үзвэл иргэн, захиргааны байгууллага буюу төрийн хүсэл зоригийн эсрэг байж даалгасан үүрэг даалгаврыг сайн дураараа биелүүлээгүй тохиолдолд л албадлагын аргаар хэрэгжүүлэх үр дагавар үүсэж байна.

Захиргааны шийдвэр гүйцэтгэхдээ хэрэглэх албадлага нь Захиргааны ерөнхий хуульд зааснаар:

---

[39] Д.Сүнжид “Захиргааны ерөнхий хууль: үзэл баримтлал, хэрэглээ” УБ., 2017 он. 90 дэх тал
[40] П.Одгэрэл “Захиргааны эрх зүйн ерөнхий анги” УБ., 2016 он. 330 дахь тал.
[41] Мөн тэнд

- Торгууль ногдуулах,
- Бусдаар гүйцэтгүүлэх,
- Албадан гүйцэтгэх гэсэн хэлбэртэй байна. Эдгээр хэлбэрийн тухай товч авч үзье.

Захиргааны шийдвэрийг сайн дураараа биелүүлээгүй бол торгууль ногдуулна. Энэ нь зөвхөн мөнгөн шаардлага бүхий захиргааны акт төдийгүй тодорхой үйл ажиллагаа хийхийг даалгах, эсхүл тодорхой үйл ажиллагаа хийхийг зогсоох зэрэг агуулга бүхий захиргааны шийдвэрийн тухайд хэрэглэж болно. Торгууль оногдуулах хэмжээ, нөхцөл нь зөрчлийн тухай хууль[42], зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль[43] холбогдох бусад хуультай нийцсэн байх шаардлагатай.

Бусдаар гүйцэтгүүлэх албадлага хэрэглэхийг ЗЕХ-ийн 86.1.2, 88-р зүйл хуульчилсан байна. Энэ арга нь мөнгөн шаардлага бүхий захиргааны актын хувьд хэрэглэхгүй. Харин тодорхой үйл ажиллагааг хийх үүрэг хүлээсэн этгээд түүнийг хийгээгүй бөгөөд бусад этгээдээр уг ажлыг хийлгэх боломжтой бол захиргааны шийдвэр гүйцэтгэх байгууллага тухайн этгээдээр хийлгэж, гарсан зардлыг үүрэг хүлээсэн этгээдээс гаргуулан ажил гүйцэтгэсэн этгээдэд олгоно.

Албадан гүйцэтгэх аргыг ЗЕХ-ийн 86.1.6, 89-р зүйлд хуульчилсан байдаг. Дээрх 2 захиргааны шийдвэр гүйцэтгэх арга нь зорилгодоо хүрээгүй, эсхүл энэ хоёр аргыг хэрэглэх боломжгүй агуулга бүхий захиргааны актын тухайд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага албадан гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулна. Захиргааны ерөнхий хуульд заасан албадан гүйцэтгэх арга хэрэгсэл нь хүний болон эд юмст биеийн эсхүл бусад арга хэрэгслийн тусламжтайгаар халдахыг ойлгодог. Энэ арга нь хүний бие, эд юманд халддаг учир холбогдох хуульд заасан журмын дагуу явагдах учиртай.

Албадлага хэрэглэх дээрх гурван арга хэрэгслийн нэгийг сонгож, гарсан захиргааны актыг уг захиргааны актыг батлан гаргасан байгууллага, дээд шатны захиргааны байгууллагын актын тухайд анхан шатны нэгжээс, эсхүл тусгайлан хуулиар эрх олгосон байгууллага болон цагдаагийн байгууллагаас туслалцаа авч хэрэгжүүлнэ.[44]

Захиргааны ерөнхий хуулийн 84.2-т захиргааны байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ тухайн салбарын хуульд заасан эрх хэмжээний дагуу, хуульд заасан журмаар албадлага хэрэглэх эрхтэй. Тухайлбал, татварын байцаагч, цагдаагийн албан хаагч, шийдвэр гүйцэтгэгч зэргийг ойлгоно. Захиргааны

[42] Зөрчлийн тухай хууль 3.4-р зүйл., УБ. 2017.05.11
[43] Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль., УБ. 2017.05.18
[44] Захиргааны ерөнхий хууль 84.1-р зүйл

шийдвэрийг гүйцэтгэх байгууллагаас ЗЕХ-ийн 83.1.3, 83.1.4[45], 85.1[46]-д заасан мэдэгдэл дэх хугацаанд сайн дураар биелүүлээгүй тохиолдолд захиргааны шийдвэр гүйцэтгэх албадлага хэрэглэх тухай шийдвэр гаргана. Энэ шийдвэрт захиргааны шийдвэр гаргах ажиллагааны журам үйлчлэхгүй ч гомдол гаргах журам үйлчилдэг.

Харин захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай доор дурдъя.

1. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зорилго нь шүүхээс гарсан шийдвэрийг албадан биелүүлж, бусдын хуулиар хамгаалагдсан эрх ашгийг бодит байдлаар сэргээхэд оршино.[47]

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр бүрэн гүйцэд биелэгдэж байх нь эрх зүйн соёл, ухамсрын түвшин харилцан адилгүй олон нийтийн зүгээс захиргааны хэргийн шүүхийг хүлээн зөвшөөрөхөд чухал ач холбогдолтой юм. Өөрөөр хэлбэл, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэрээс шууд хамааралтай байх онцлогтой.[48]

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг Монгол Улсын Үндсэн хууль[49], шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль[50], захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 15-р бүлэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хүрээнд зохицуулдаг. Харин захиргааны шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа албан тушаалтанд эрүүгийн хууль, зөрчлийн хууль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, төрийн албаны тухай хууль, захиргааны хэрэг

---

[45] Захиргааны ерөнхий хуулийн 83.1.3 “83.1.3.хуульд өөрөөр заагаагүй бол шаардах эрх бүхий шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 14 хоногийн хугацаа өнгөрсөн байх”, 83.1.4 “үүрэг хүлээгчид 14 буюу түүнээс доошгүй хоногийн хугацаанд захиргааны шийдвэрийг биелүүлэх тухай мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн байх”

[46] Захиргааны ерөнхий хуулийн 85.1 “Албадлагыг хуульд зааснаар нэн даруй хэрэглэхээс бусад тохиолдолд албадлага хэрэглэх тухай мэдэгдлийг үүрэг хүлээгчид бичгээр өгөх бөгөөд уг мэдэгдэлд үүрэг биелүүлэх хугацааг заана.”

[47] А.Дугармаа “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онол, практикийн асуудал” илтгэл

[48] “Шүүхийн шйидвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох-чадавхыг бэхжүүлэх” төсөл. 2016 он.

[49] Монгол Улсын Үндсэн хуулийн 16.2 “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй”, 19.1 “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, 16.14 “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах...”

[50] Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9.2.10 “шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн статистик мэдээлэлд хяналт тавьж, холбогдох байгууллагад шаардлага тавих”

шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 16-р бүлэг болон хууль тогтоомжийн бусад актад заасан хариуцлага хүлээлгэнэ.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл нь хуулийн хүчин төгөлдөр болсон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, захиргааны шийтгэвэр, мөн эвлэрлийн гэрээг баталгаажуулсан захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн захирамж, тэдгээрийн үндсэн дээр олгосон гүйцэтгэх хуудас байдаг. Шүүхийн хүчин төгөлдөр болсон эцсийн шийдвэрийг хэргийн оролцогчид сайн дурааараа биелүүлээгүй тохиолдолд албадан биелүүлэх шаардлага бий болдог.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн эрх зүйн үр дагавар нь бусад шүүхийн шийдвэрээс зарим талаараа өвөрмөц байдаг. Учир нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэр нь нэхэмжлэгч, хариуцагчаас гадна гуравдагч этгээд буюу олон нийтэд хамааралтай байдаг. Шүүх хэргийг хянан үзээд ЗХШХШтХуульд заасан 14 төрлийн[51] шийдвэр гаргах бөгөөд ямар төрлийн шийдвэр гаргахаас хамаарч, шүүхийн шийдвэрийг биелүүлэх арга, журам өөр өөр байна.

Захиргааны хэргийн шүүхээс гаргаж байгаа шийдвэрүүдийг тоймлон авч үзвэл дараах төрлүүдтэй байна. Үүнд:

1. Захиргааны акт, захиргааны гэрээ хууль бус болох нь тогтоогдвол түүнийг хүчингүй болгох
2. Захиргааны акт, захиргааны гэрээ нь илт хууль бус болохыг тогтоох
3. Захиргааны акт хууль бус болохыг тогтоох
4. Захиргааны акт даалгахыг даалгах, эс үйлдэхүй нь хууль бус болохыг тогтоох
5. Төлбөр тогтоосон захиргааны актын төлбөрийн хэмжээг өөрчлөх
6. Захиргааны акт хүчин төгөлдөр бус болохыг тогтоох
7. Захиргааны акт илт хууль бус болохыг тогтоох
8. Захиргааны шинэ акт гарах хүртэл хугацаагаар захиргааны актыг түдгэлзүүлэх
9. Шүүхийн зардал тогтоосон захирамж

Дээрх шүүхийн шийдвэрээс шалтгаалан хэрэгжүүлэх арга журам, албадлагын арга хэмжээг сонгон хэрэглэхэд ялгаатай байдаг. Тухайлбал ЗХШХША-г дотор нь төлөөлөн гүйцэтгэж болох ба төлөөлөн гүйцэтгэж болохгүй ажиллагаа гэж ангилдаг. Захиргааны зохих акт гаргахыг даалгасан шүүхийн шийдвэрийг зөвхөн тухайн захиргааны актыг гаргах эрх бүхий захиргааны байгууллага, албан тушаалтан л гаргах замаар биелүүлэхээс, өөр хэн нэгэн уг захиргааны актыг гаргах эрхгүй тул төлөөлүүлэн гүйцэтгэх боломжгүй юм.[52]

---

[51] Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль.,106.3-р зүйл.

[52] А.Эрдэнэцогт “Монгол улсын захиргааны процессын эрх зүй” УБ., 2014 он. 323 дахь тал.

Захиргааны хэргийн шүүхийн зорилго нь иргэн, хуулийн этгээдийн эрхийг хамгаалахад чиглэдэг тул шийдвэр гүйцэтгэл нь энэ зорилгыг хангахад оршино.[53]

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсны дараа хариуцагчид шүүхийн мэдэгдэх хуудсыг хүргүүлнэ. Энэхүү мэдэгдэх хуудаст шүүхийн шийдвэрийн агуулга, шаардлага, түүнийг биелүүлэх хугацаа, шүүхийн шийдвэрийг сайн дурааараа биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлага, тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд албадан гүйцэтгэх ажиллагааг эхлүүлэх хугацаа, албадлага хэрэглэх арга журмын талаар тодорхой тусгасан байна. Хариуцагч мэдэгдэх хуудаст заасан хугацаанд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй бол захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулуулахаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандана.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр түүнд нийцүүлэн олгосон гүйцэтгэх хуудсыг үндэслэн явуулдаг.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг үндэслэн шууд гүйцэтгэх хуудас олгох болон нэхэмжлэгчийн хүсэлтээр гүйцэтгэх хуудас олгох нөхцөлийг тус тус заасан байна. Нэхэмжлэлийн агуулга, гүйцэтгэх үүргээс хамааран шууд олгох гүйцэтгэх хуудсыг дараах байдлаар тодорхойлно[54].

1. Нэхэмжлэгчийг урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд нь эгүүлэн тогтоох тухай
2. Ажлаас үндэслэлгүй халсан, чөлөөлсөн, шилжүүлсний нөхөн олговор олгуулах тухай
3. Захиргааны актыг түдгэлзүүлэх тухай
4. Шүүхийн шийдвэрийг биелүүлэх хугацаанаас хамаарч хүн, хуулийн этгээдэд ноцтой хохирол учрахаар бол түүний хүсэлтээр
5. Хуульд заасан бусад /бусдын амь бие, эрүүл мэндэд учирсан хохирол/ үндэслэлээр гэж заасан.

Дээрх үндэслэлээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст гүйцэтгэх баримт бичгийг шууд хүргүүлэхээр, бусад тохиолдолд шийдвэр гаргасан шүүхэд нэхэмжлэгч хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг гаргаж, нэхэмжлэгчийн хүсэлтийг үндэслэн гүйцэтгэх хуудсыг олгосноор шүүхийн шийдвэр, гүйцэтгэх хуудсын хамт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст ирүүлнэ. Ийнхүү ирүүлсэн гүйцэтгэх баримт бичгийг агуулгын болон хэлбэрийн шаардлага хангаж байгаа эсэхийг ахлах шийдвэр гүйцэтгэгч хянаж, 3 хоногийн дотор шийдвэр гүйцэтгэх

[53] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох-чадавхыг бэхжүүлэх” төсөл. УБ., 2016 он.
[54] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. УБ., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл №24

ажиллагааг үүсгэх, эсхүл гүйцэтгэх хуудас олгосон шүүхэд буцаах асуудлыг шийдвэрлэнэ. Хууль зүйн шаардлага хангасан гүйцэтгэх баримт бичгийг ахлах шийдвэр гүйцэтгэгч үүсгэх тогтоол үйлдэн шийдвэр гүйцэтгэгчид хуваарилан олгож, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эхлүүлнэ.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь гүйцэтгэх хуудсыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд ирүүлсэн байх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эхлүүлэх, хугацаатай мэдэгдэл хүргүүлэх, албадан биелүүлэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох гэсэн 5 үе шаттай байна.[55]

Захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь өөрийн онцлогийг харуулсан хэд хэдэн өвөрмөц зохицуулалтуудтай. Эдгээр зохицуулалтыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилттэй харьцуулан авч үзвэл:

1. Бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газар нь доод шатны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэрийн биелэлтэд хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийн хүрээнд хяналт тавьж, харилцан хамтран ажиллана.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр уламжлан шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан хугацаанд захиргааны хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, Засгийн газраас томилогдож, чөлөөлөгддөг бусад албан тушаалтны асуудлыг Засгийн газарт, Улсын Их Хурлаас томилогдож, чөлөөлөгддөг албан тушаалтны асуудлыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд танилцуулна гэжээ. Дээрх 2 зохицуулалтаас харахад төрийн байгууллагууд шүүхийн шийдвэрийн биелэлтэнд тодорхой хэмжээгээр дэмжлэг үзүүлж хамтран ажиллах боломжтой талаар тусгасан байна. Харин дээрх 2 ойлголтоор шүүхийн шийдвэр биелүүлээгүй албан тушаалтны мэдээллийг "...Засгийн газар болон Улсын их хуралд танилцуулна" гэж хэт ерөнхий зохицуулсан нь танилцуулаад тэндээс хэрхэн уг асуудлыг шийдвэрлэх, хариуцлага тооцох эсэх талаарх үндсэн ойлголтыг орхигдуулсан зохицуулалт болжээ.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 132.2-т "Шийдвэр гүйцэтгэгч шүүхийн мэдэгдэлд заасан хугацаа, эсхүл ШШГТХ-д заасны дагуу нэмэлт хугацаа тогтоосон бол тухайн хугацаа дуусмагц шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй захиргааны байгууллага, албан тушаалтны дээд шатны байгууллага, албан тушаалтанд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах, шүүхийн

[55] "Захиргааны хэргийн шүүхийн тухай мэдэгдэхүүн" гарын авлага. УБ., 2004 он.

шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авахыг даалгасан мэдэгдэл хүргүүлнэ” гэжээ.

4. Төрийн албаны төв байгууллага буюу Төрийн албаны зөвлөл болон шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй, биелүүлсэн боловч албан хаагчийг хууль бусаар дахин ажлаас халсан албан тушаалтны шийдвэрийг төрийн албаны төв байгууллага хүчингүй болгож, буруутай албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх мэдэгдлийг эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.

5. “Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана” гэсэн нь төрийн байгууллагын алба хаагчийн буруутай үйл ажиллагаанаас төрд учруулсан хохирол, төлбөрт анхаарал хандуулсан асуудал болохоос албан тушаалтны буруутай шийдвэр түүнийг хянах, нэгдсэн зохион байгуулалтаар үүний эсрэг арга хэмжээ авах талаар ойлголтыг агуулаагүй байна.

Дээрх зохицуулалтуудаас үзвэл захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх, шийдвэр гүйцэтгэгчийн хуульд нийцсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн хамгаллын механизм бүрэлдсэн тогтсон гэж үзэх боломжтой байна.

Гэвч төрийн албан хаагчийн эрх, үүргийг нийтлэг байдлаар тодорхойлсон Төрийн албаны тухай хуульд энэ төрлийн харилцааг зохицуулсан зохицуулалт байхгүй байна. Төрийн албаны тухай хуульд төрийн албан хаагчид сахилгын шийтгэл оногдуулах талаар зохицуулалт байх хэдий ч шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй албан тушаалтанд хэрхэн, ямар төрлийн сахилгын шийтгэл, арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар зохицуулалт байхгүй байна.

Хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх[56] зорилготой Монгол Улсын зөрчлийн тухай хуулийн 15.27 дугаар зүйлд “Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх” гэдэг ойлголтонд захиргааны байгууллага, албан тушаалтан шүүхийн шийдвэрийг үл биелүүлсэн тохиолдолд авах арга хэмжээг огт хуульчлан тогтоож өгөөгүй байна.

Үүнээс үзэхэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлага хэт ерөнхий бөгөөд явцуу байгаа нь харагдаж байна.

“Хариуцагч шүүхийн мэдэгдэлд заасан хугацаанд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй бол ахлах шийдвэр гүйцэтгэгч энэ тухай олон нийтэд мэдээлж, шаардлагатай бол биелүүлэх хугацааг 14 хүртэл хоногоор сунгаж болно” хэмээн

[56] Зөрчлийн тухай хууль. 2017

зохицуулсан боловч Шийдвэр гүйцэтгэх албанд төлбөр төлөгчийн төлбөрөө төлөөгүй болон шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээллэсэн талаар тоон баримт, судалгаа өнөөдрийн байдлаар байхгүй байна. Энэ нь энэ төрлийн арга хэмжээг хэрэглэж хэвшээгүй байгааг илэрхийлж байгаа хэрэг юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.2-т “Улсын төсвөөс санхүүждэг төлбөр төлөгч-хуулийн этгээдийн дансанд байгаа төлбөр төлөх зориулалт бүхий мөнгөн хөрөнгө нь төлбөрт хүрэлцэхгүй тохиолдолд дараагийн жилийн төсөвт нэмж тусгаж, төлбөрийг барагдуулна” гэж хуульчилсан. Төлбөр төлөгч-улсын төсвийн байгууллагууд нь хохирол, төлбөр төлөх зориулалт бүхий төсөвлөсөн мөнгөн хөрөнгөгүй, Төсвийн тухай хуульд зааснаар Төрийн сангийн газраас мөнгөн хөрөнгийн гүйлгээ хийж, санхүүгийн бүртгэл хөтөлж, шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар төлбөр төлөгч-улсын төсвийн байгууллагын данс битүүмжлэх, суутгал хийх, балансад бүртгэлтэй хөрөнгөөс төлбөр гаргуулах боломжгүйгээс 2008 оноос хойш тухайн жилийн төсөвт шүүхийн шийдвэрт заасан төлбөрийн санхүүжилтийн эх үүсвэрийг тусгуулж, хохирол, төлбөрийг барагдуулж байна. Төрийн байгууллага, алба хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирол, төлбөрийг барагдуулах ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2008-2023 оны төсөвт тусгагдсан мөнгөн хөрөнгөөс шүүхийн шийдвэрийг үндэслэн 72.6 тэрбум төгрөгийг төлбөр авагч иргэн, хуулийн этгээдэд олгосон[57] байна.

[57] Төлбөр төлөгч- төсвийн байгууллагад холбогдох шийдвэр гүйцэтгэх ажиллагааны танилцуулга. 2023.03.31. ШГА. ШШГЕГ

Хүснэгт 1. Төрийн байгууллага, албан тушаалтнаас иргэнд учирсан хохирлыг нөхөн төлүүлсэн судалгаа

Д/д	Он	Тушаалаар олгогдсон дүн		Үүнээс:			
				Иргэнд		Хуулийн этгээдэд	
		Гүйцэтгэх хуудас	Мөнгөн дүн /мян.төг/	Гүйцэтгэх хуудас	Мөнгөн дүн /мян.төг/	Гүйцэтгэх хуудас	Мөнгөн дүн /мян.төг/
1	2008	16	183,187.2	16	183,187.2		
2	2009	132	3,399,998.8	76	543,179.9	56	2,856,818.9
3	2010	83	1,000,000.0	41	333,002.6	42	666,997.4
4	2011	65	11,694,533.0	30	229,380.0	35	11,465,153.0
5	2012	240	12,006,569.3	165	4,284,067.7	75	7,722,501.6
6	2013	61	6,700,959.7	46	542,318.9	15	6,158,640.8
7	2014	31	4,953,073.0	25	796,265.3	6	4,156,807.7
8	2015	74	2,247,800.9	70	1,640,817.3	4	606,983.6
9	2016	69	2,374,305.0	60	1,945,451.5	9	428,853.5
10	2017	04	15,1 15,191.8	299	5,625,680.5	105	9,489,511.3
11	2018	11	2,36 2,776.7	187	1,367,357.2	24	995,419.5
12	2019	00	2,42 8,192.4	99	2,073,255.9	1	354,936.5
13	2020	113	2,280,547.7	61	607,864.5	52	1,672,683.2
14	2021	153	2,280,486.7	124	1,329,320.2	29	951,166.5
15	2022	102	1,916,608.8	98	1,332,712.4	4	583,896.4
16	2023	87	1,657,630.1	41	790,763.7	46	866,866.4
Нийт		**1941**	**72,601,861.1**	**1,438**	**23,624,624.8**	**503**	**48,977,236.3**

Шийдвэр гүйцэтгэх албаны 2023 оны 1 дүгээр улирлын мэдээгээр нийт ажиллагаанд байгаа гүйцэтгэх баримт бичгийн 74 хувийг иргэний, 19 хувийг эрүүгийн, 6 хувийг бусад, 1 хувийг захиргааны хэргийн гүйцэтгэх баримт бичиг эзэлж байна. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт нь 7 жилийн дунджаар авч үзэхэд 59 хувьтай биелэгдэж байна.

График 1. 2023 оны ажиллагаанд байгаа гүйцэтгэх баримт бичгийн судалгаа



Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь бодит биелэлтийн тухайд иргэний хэргийн болон эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас урт хугацаа шаардагдсан ажиллагаа байсаар ирсэн.

Үүнд нөлөөлж буй хамгийн гол хүчин зүйлд захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд нь нэг талдаа төрийн байгууллага, албан тушаалтан оролцож байгаад оршдог. Төр гэдэг бол хийсвэр ойлголт бөгөөд нийтийн эрх, ашгийг хангах, хамгаалах чиг үүргээрээ төрийн байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй явагдах жамтай. Энэ зарчмын ойлголт нь төрийн байгууллага, албан тушаалтанд холбогдуулан албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамгийн их хаалт болдог. Тиймээс шийдвэр гүйцэтгэх ажиллагааг албадлага хэрэгжүүлэхгүйгээр зохион байгуулах нь өөрөө шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтэд сөргөөр нөлөөлж байдаг. Энэ агуулгаараа төлбөртэй төрийн байгууллага, албан тушаалтанд хэрэглэх албадлагын арга хэмжээ хангалтгүй томьёологдсон. Бусад байгууллагын тухайд төлбөр төлөгчийн банк дахь харилцах болон хадгаламжийн данснаас төлбөр гаргуулах ажиллагааг шууд зохион байгуулдаг бол төлбөртэй төрийн байгууллага, албан тушаалтны данснаас хасалт хийх ажиллагааг практикт тэр бүр зохион байгуулдаггүй.

График 2. Захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тоон үзүүлэлт




Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд байгаа гүйцэтгэх баримт бичгээс харахад 2023 оны 03 дугаар сарын байдлаар улсын төсөвт байгууллагад холбогдох 156 гүйцэтгэх баримт бичгийн төлбөрийн шаардлагуудыг нарийвчлан авч үзвэл ажлаас үндэслэлгүй халагдсан иргэдэд олгох төлбөр 1.1 тэрбум, ажил гүйцэтгэх гэрээ, тендерийн санхүүжилтийн дутуу төлбөр 56.4 тэрбум төгрөг, эрх бүхий албан тушаалтнаас бүрэн эрхээ хэрэгжүүлээгүйгээс 3.3 тэрбум төгрөгийн хохирол, төлбөрийг үүсгэсэн талаар тоо баримт гарч байна.

Хүснэгт 2. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн судалгаа

Д/Д	Ажлаас үндэслэлгүй халагдсан, ажилгүй байсан хугацааны цалин	Бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад учруулсан хохирол	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас учирсан хохирол	Гэрээний үүрэг болон ажил гүйцэтгэхтэй холбоотой маргаанаас үүссэн төлбөр	Нийт
Гүйцэтгэх хуудас	92	16	1	44	153
Мөнгөн дүн /төгрөг/	1.147.883.631	3.397.327.858	1.011.437	56.416.337.922	56.416.337.922

Дээрх мэдээллээс харахад төрийн байгууллага, албан тушаалтан ажлаас үндэслэлгүй халсан талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нийт гүйцэтгэх баримт бичгийн 60 орчим хувийг дангаараа эзэлж байна.

График 3. Ажлаас үндэслэлгүй халагдсан тухай шүүхийн шийдвэрийн судалгаа



Ажлаас үндэслэлгүй халагдсан талаарх шүүхийн шийдвэрийг нарийвчлан авч үзэхэд төрийн улс төрийн албан тушаалтан 2%, төрийн тусгай албан хаагч 8%, төрийн үйлчилгээний албан тушаалтан 41%, төрийн захиргааны албан тушаалтан

49%-ийг тус тус эзэлж байна. Үүнээс үзэхэд төрийн захиргааны албанд ажлаас үндэслэлгүй халах явдал хамгийн их байгааг харуулж байна.

Дүгнэлт

Захиргааны эрх зүйд захиргааны байгууллагын шийдвэрийг биелүүлэх болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх гэсэн хоёр ойлголт байдаг тухай дээр өгүүлсэн билээ.

Захиргааны байгууллагын шийдвэр биелүүлэх ажиллагаа нь захиргааны ерөнхий хуулийн хүрээнд хэрэгжих бөгөөд шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд хуулийн дагуу албадлагын арга хэмжээг хэрэглэдэг.

Харин захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа нь захиргааны хэргийн шүүх ажиллагааны үргэлжлэл бөгөөд эцсийн үр дүн гэж хэлж болох ба уг ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар зохицуулна.

2002 оны ШШГтХуульд “захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа”-ны тухай захиргааны ерөнхий хууль батлагдсантай холбоотой 2016 оны 2 сарын 4-ний тогтоолоор нэмэлт бүлэг шинээр орж ирсэн байдаг. Үүнээс өмнө иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас эш татаж хэрэглэдэг байсан.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн харилцаа нь тэгш бус эрхтэй талуудын хооронд үүсдэг нийтийн эрх зүйн харилцаа байдаг. Энэ утгаараа захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхэд хүндрэл учирдаг байсан бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх шинэ хууль батлагдсанаар захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэх арга механизмыг тодорхой тусгасан юм.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх шинэ хуулийн зохицуулалттай болсон нь сайн талтай ч хуулийг судлан үзэхэд 128-р зүйлд захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэрт хяналт тавих механизмыг хуульчилсан боловч хуулийн 128.2 “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр уламжлан энэ хуульд заасан хугацаанд захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, Засгийн газраас томилогдож, чөлөөлөгддөг бусад албан тушаалтны асуудлыг Засгийн газарт, Улсын Их Хурлаас томилогдож, чөлөөлөгддөг албан тушаалтны асуудлыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд танилцуулна” гэж бүрхэг заалт оруулжээ. Энэ нь зөвхөн танилцуулаад орхих уу гэдэг асуудал хөндөгдөж байна. Хуулийн 132.2-т “...шийдвэрийг биелүүлээгүй албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах, шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авахыг даалгасан мэдэгдэл хүргүүлнэ” гэж заасан нь бодит байдал дээр

ийм үндэслэлээр сахилгын шийтгэл оногдуулсан тухай мэдээлэл байхгүй байна. Мөн Судалгаанаас харахад шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа төлбөр төлөгч /хариуцагч/ албан тушаалтан нь дээрх хуулийн заалтад байгаа албан тушаалтнууд байгаа юм. Тиймээс дээрх эрх мэдэл бүхий албан тушаалтан шүүхийн шийдвэрийг хэрхэн гүйцэтгэх тухай нарийн тогтоосон журам гаргах хэрэгтэй байна.

Монгол Улсын Төрийн албаны тухай хуульд ”Энэ хуулийн зорилт нь төрийн албаны мэргэшсэн, тогтвортой, ил тод, хариуцлагатай байх эрх зүйн үндсийг бүрдүүлэх, төрийн албаны төв байгууллага, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгааг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино” хэмээн тодорхойлсон боловч шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй төрийн албан хаагчид оногдуулах хариуцлагыг тодорхойлон хуульчлаагүй байна. Төрийн байгууллагын үйл ажиллагаанд төрийн алба хариуцлагатай байх эрх зүйн үндсийг тогтоох зорилготой атлаа шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй төрийн байгууллага, албан тушаалтанд авч хэрэгжүүлэх албадлагын арга хэмжээ болон хариуцлагын талаарх ойлголт огт тусгаагүй байгаа нь захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтэнд сөргөөр нөлөөлж байна.

Хэрэв Төрийн албаны тухай хуулийн хариуцлагын хэсэгт Шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг үе шаттайгаар хуульд тусгаж өгвөл жинхэнэ утгаараа төрийн албаны хариуцлага нэмэгдэж, иргэнийхээ эрх ашгийг хөндөх эрх зүйн зөрчлийн тоо багасах боломжтой юм.

Санал

1. Захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх, төрийн эрх мэдлийн хуваарилалтын тогтолцоог тэнцвэржүүлэх хүрээнд төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн нийтлэг үүрэгт “Шүүхийн шийдвэрийг биелүүлэх” гэсэн заалтыг нэмж тусгах шаардлагатай. Ингэснээр шүүхийн шийдвэрийг үл биелүүлсэн төрийн албан хаагчид сахилгын шийтгэл хүлээлгэх эрх зүйн үндсийг бэхжүүлнэ.

2. Зөрчлийн тухай хуульд заасан “Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх” зөрчилд “Захиргааны хэргийн талаар шүүхийн шийдвэрийг биелүүлэх зорилгоор төрийн байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн үүргийг биелүүлээгүй нь төрийн албан тушаалтанд зөрчлийн тухай хуулиар зөрчлийн шийтгэл хүлээлгэх үндэслэл болгох.

3. Мөн төсвийн буюу төрийн байгууллага шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлбөр төлөгчөөр оролцох тохиолдолд төсвийн байгууллагын дараа жилийн төсөвт тусгуулах зохицуулалтыг дээр дурдсан тул тус зохицуулалтыг бодитой болгох хүрээнд төсвийн тухай хуульд заасан төсвийн зарчимд “Шүүхийн шийдвэрийг нэн тэргүүнд барагдуулах” зарчмыг тусгах. Учир нь Монгол Улсын

Үндсэн хуулиар шүүх эрх мэдлийн үндсийг гүйцэтгэх, хууль тогтоох эрх мэдэлтэй адилтган тогтоосон хэдий ч гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд шүүхийн шийдвэрийг хэрхэн авч үзэх талаар зарчмын шинжтэй агуулгыг тусгаагүй нь шүүхийн шийдвэр, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хоёрдогч ач холбогдолтойд авч үзэхэд хүргэж байна.

4. Онцлог нь захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа нь төрийн байгууллага, албан тушаалтан цаашлаад төрийн өндөр дээд албан тушаалтан болон түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны үйл ажиллагаанд хамаарах тул тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулсан бие даасан эрх зүйн хэм хэмжээнд шүүхийн шийдвэрийг биелүүлэх зарчмын агуулгыг тусгах шаардлагатай ба ингэснээр Төрийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуульд заасан захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд холбогдох зохицуулалт нь бодитой хэрэгжих суурь нөхцөлийг хангах боломжтой болно.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

b. Монгол эх сурвалж

7. Г.Банзрагч “Захиргааны процессын эрх зүй” 2019 он
8. А.Дугармаа “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онол, практикийн асуудал” илтгэл
9. П.Одгэрэл “Захиргааны эрх зүйн ерөнхий анги” УБ., 2016 он
10. Д.Сүнжид “Захиргааны ерөнхий хууль: үзэл баримтлал, хэрэглээ” УБ., 2017 он
11. Ц.Цогт “Захиргааны эрх зүй” өгүүлэл, нийтлэлийн эмхэтгэл. УБ., 2016 он
12. А.Эрдэнэцогт “Монгол улсын захиргааны процессын эрх зүй” УБ., 2014 он
13. А.Эрдэнэцогт ”Монгол улсын захиргааны процессын эрх зүй” УБ., 2022 он

II. Эрх зүйн эх сурвалж

5. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992 он
6. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2002 он
7. Захиргааны ерөнхий хууль. УБ 2016 он
8. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2016 он
9. Захиргааны ерөнхий хуулийн тайлбар. УБ., 2017 он
10. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. УБ., 2002 он
11. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. УБ., 2017 он
12. Зөрчлийн тухай хууль. УБ., 2017 он.
13. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль. УБ., 2017 он
14. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль. УБ., 2012 он
15. Төрийн албаны тухай хууль. УБ., 2002 он.

III. Бусад эх сурвалж

1. Төсөл “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох-чадавхыг бэхжүүлэх” УБ., 2016 он.
2. Гарын авлага “Захиргааны хэргийн шүүхийн тухай мэдэгдэхүүн” УБ., 2004 он.
3. Тайлан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар”. УБ., 2015 он.

---o0o---

ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААН ДАХЬ ХҮҮХДИЙН ТЭТГЭЛЭГ ГАРГУУЛАХ АЖИЛЛАГАА: ТУЛГАМДСАН АСУУДАЛ

CHILD ALLOWANCE IN FAMILY JUDICIAL RELATIONSHIPS: THE PROBLEM



Н.Өнөржаргал
Дотоод хэргийн их сургуулийн
Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Хувийн эрх зүйн тэнхимийн багш,
хууль зүйн магистр, ахлах дэслэгч

Товч утга: Монгол улсад сүүлийн жилүүдэд гэр бүл болж байгаа хосуудын тодорхой хувь гэрлэлтээ бүртгүүлэн албан ёсоор гэр бүл болж байгаа бол ихэнх хосууд гэрлэлтээ бүртгүүлэхгүйгээр хамтран амьдарч байна. Гэрлэгчид гэр бүл цуцлах, хамтран амьдрагчид хамтын амьдарлаа дуусгавар болгосноор хүүхдийн тэтгэлэг төлөх асуудал урган гардаг. Шүүхээс хүүхдийн тэтгэлэг тогтоосон ч тэтгэлэг төлөгч нь тэтгэлэг төлөхгүй байх, төлөхөөс зайлсхийх зэрэг янз бүрийн шалтгаан, нөхцөлөөс үүдэн хүүдийн эрх ашиг зөрчигдөх явдал байсаар байна.

Түлхүүр үгс: Гэр бүл, хүүхэд, тэтгэлэг, амьжиргааны доод түвшин, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

Abstract: In Mongolia, recently married couples have registered their private marriages to become official families, and couples are living together without registering their marriages. The issue of child support arises when married couples support their families and cohabitants become breadwinners. Children's rights are still violated due to various reasons and situations, such as child support, child support, and child support payments

Keywords: Family, children, alimony, minimum living standards, enforcement process.

Манай улсын тухайд 2022 оны эхний таван сард 6267 хос гэрлэлтээ бүртгүүлсэн бол 1743 хос гэрлэлтээ цуцлуулсан байна. Монгол улсад өнгөрсөн 2019, 2020 онд нийт 7500 гаруй гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан байна. Гэрлэлт цуцлахад хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нэн тэргүүнд тавигдах бөгөөд салсан гэр бүлийн 20 гаруй хувь нь өөрийн ухамсраараа хүүхдийн тэтгэмж өгдөг

бол бусад нь албадан төлүүлэхээр шийдвэр гүйцэтгэлийн байгууллагад ханддаг байна.

Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, амьдрах эрүүл саруул, аюулгүй орчин бүрдүүлэх, нэн шаардлагатай хоол хүнс, орон байр, хувцас, тоглоом, бусад шаардлагатай зүйлсээр хангах үүргийг эцэг, эх хүлээдэг. Хүүхдийн эрх ашиг үргэлж нэгт байх нь гэр бүлийн эрх зүйн харилцааны гол зарчмын нэг билээ. Хүүхдийн бие бялдар, оюун санаа, ёс суртахууны хөгжлийг хангах, сурч боловсроход эцэг, эх, адил үүрэг хүлээх нь хүүхдийн эрхийг хамгаалах үндсэн зарчмын нэг. Эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулсан ч гэсэн хүүхдийн өмнө хүлээх үүрэг хариуцлага нь хэвээр үргэлжилнэ.

Гэрлэлт гэдэг нь 18 насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёр, сайн дурын, чөлөөтэй, тэгш эрхийн үндсэн дээр гэр бүл болох зорилгоор хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг[58] хэлдэг. Харин гэрлэлтийн гэрчилгээгээ аваагүй боловч гэр бүл болсон хүмүүсийг энгийнээр хамтран амьдрагч гэж нэрлэдэг.

Нэгэнт л эцэг, эх болсон бол насанд хүрээгүй, насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх үүрэг хүлээнэ[59]. Хэрвээ гэрлэгчид гэр бүл цуцлах, хамтран амьдрагчид хамтын амьдралаа дуусгавар болгож буй тохиолдолд хүүхдийн эрх ашиг хамгийн их хөндөгдөж байдаг тул хүүхдийг хэн нь өөрийн асрамждаа авах, хэрхэн тэжээн тэтгэх талаар эцэг, эх харилцан тохиролцож гэрээ байгуулдаг. Гэрээ байгуулаагүй бол тэтгэлгийг шүүх тогтооно.[60]

Гэрлэлт түүнтэй харьцах цуцлалтын тоо жил ирэх тусам нэмэгдэж байна. Монгол Улсын хэмжээнд тухайн тоо баримтаар өдөрт 10 гэр бүл гэрлэлтээ цуцлуулж, 40 хос гэрлэлтээ бүртгүүлдэг[61]. Цуцлалтын тоо энэ байдлаар үргэлжлэх бол өдөрт гэр бүлээ батлуулж буй 40 хосын 10 нь салах эрсдэлтэйг тоо баримт сануулж байна.

Гэр бүл цуцлалтын тоо жилээс жилд дунджаар 269-өөр нэмэгдэж байна[62]. Гэр бүл салалтын шалтгааныг маш олон талаас тайлбарладаг. Гэр бүл салах шалтгаан нь юу ч байж болно. Гол нь түүнээс үүсэх хор хохирол нь гэрлэгчдээс гадна хүүхдүүдэд илрэх нь ойлгомжтой.

Эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулж байгаа тохиолдолд хамгийн эхэнд хүүхдийн асрамжийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж эцэг, эхийн хэн нэгний асрамжид үлдээсэн бол нөгөөхөөс нь тэтгэлэг гаргуулна. Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, амьдрах эрүүл саруул, аюулгүй орчин бүрдүүлэх, нэн шаардлагатай

[58] Гэр бүлийн тухай хууль., 1999он, 3-р зүйл
[59] Гэр бүлийн тухай хууль., 1999он, 38-р зүйл
[60] А. Батбаатар., Гэр бүлийн эрх зүйн зарим асуудал, УБ , 2021он, 72дахь тал
[61] https://ikon.mn/opinion/y5q
[62] https://ikon.mn/opinion/y5q

хоол хүнс, орон байр, хувцас, тоглоом, бусад шаардлагатай зүйлсээр хангах[63] үүргийг эцэг, эх хүлээнэ гэж хуульд заасанчлан тэтгэлгийг өгөх үүрэгтэй.

Талуудын хэлэлцээгээр тэтгэлэг төлөх тохиолдолд тэтгэлэг тогтоох нөхцөл, тэтгэлгийн хэмжээг тогтооно. Тэтгэлэг тогтоох гэрээг гэр бүлийн тухай хуулийн холбогдох зохицуулалтад нийцүүлэн бичгийн хэлбэрээр байгуулан нотариатаар гэрчлүүлнэ.[64]

Тэтгэлгийн хэмжээг харилцан тохиролцоогүй, тохиролцоонд хүрч чадаагүй, гэрээ байгуулаагүй тохиолдолд тэтгэлгийн хэмжээг шүүх тогтоох[65] бөгөөд хүүхдэд олгох тэтгэлгийг түүний насны байдлыг харгалзан сард нэг хүүхдэд дараах хэмжээгээр тогтооно. Үүнд:

Арван нэг хүртэлх насны хүүхдэд тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшний 50 хувиар;

Жишээ нь: Улаанбаатарт өнөөдрийн байдлаар хүн амын амьжиргааны доод түвшин 313,400 төгрөг байна. Үүний 50 хувь нь 156,700 төгрөг байна.

11-16 нас /суралцаж байгаа бол 18 нас/-тай болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдэд амьжиргааны доод түвшний хэмжээгээр тогтооно. Амьжиргааны доод түвшний хэмжээг үндэсний статистикийн газраас тогтоодог.

Манай улсын хувьд амьжиргааны доод түвшин 2023 оны байдлаар:

- Баруун бүс-274,400
- Хангайн бүс-282,500
- Төвийн бүс-272,300
- Зүүн бүс-271,800
- Улаанбаатар-313,400[66]

Зөвхөн цалин хөлснөөс өөр орлогогүй хариуцагчаас гаргуулах хүүхдийн тэтгэлгийн хэмжээ нь түүний сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын 50 хувиас хэтэрч болохгүй.

Жишээ нь: Өнөөдрийн байдлаар Монгол улсын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 550,000 төгрөг бол түүний 50 хувь буюу 275,000 хэтэрч болохгүй.

Хүүхдийн тэтгэлгийг мөнгөн хэлбэр эсвэл эд хөрөнгөөр олгож болох бөгөөд сар, улирал, хагас жил, бүтэн жилээр, эсхүл нэг удаа бөөнд нь олгож болно.

Хэрэв тэтгэлэг төлөгч тэтгэлэг төлөхөөс санаатай зайлсхийсэн, цалин хөлс, бусад орлогоо нуун дарагдуулсан нь тогтоогдсон бол шүүх тэжээн тэтгүүлэгч, бусад иргэн, холбогдох байгууллагын нэхэмжлэлийг үндэслэн төлөгдөөгүй тэтгэлгийг нөхөн төлүүлж болдог. Тухайлбал: 18 нас хүртэлх хугацаанд нийт хэдэн төгрөг төлөхөөс, төлөгдөөгүй үлдсэн нь хэд вэ? гэдгийг бодоод дээр нь алданги тооцоод нэхэмжлэх боломжтой. Харин тэтгэлэг нөхөн төлүүлэхэд

---

[63] Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, 1996, 12 дугаар зүйл

[64] . Даваажав, С. Оюунчимэг., Монгол улсын гэр бүлийн эрх зүй, УБ,2014он, 122 дахь тал

[65] Ж. Амарсанаа., хүүхдийн эрхийн нэр томъёоны тайлбар толь, УБ, 2001он, 66дахь тал

[66] http://eagle.mn/r/110641

тэтгэлэг төлөгч хөдөлмөр эрхлээгүй буюу цалин хөлс, бусад орлогын хэмжээг тогтоох боломжгүй бол тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг баримтална. Тэтгэлэг төлөгч хөдөлмөрийн чадваргүй болсон тохиолдолд тухайн хугацааны тэтгэлгийн хэсгийг буюу бүхэлд нь нөхөн төлүүлэхээс шүүх чөлөөлж болдог.[67]

Монгол улсад 2022 оны байдлаар хүүхдийн тэтгэлэг гаргуулах асуудлаар шүүх 383[68] маргааныг шийдвэрлэсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2022 оны мэдээгээр хүүхдийн тэтгэлгийн гүйцэтгэвэл зохих 13526 гүйцэтгэх хуудасны 47.789.271,0 төгрөгийн баримт бичиг байснаас 1272 гүйцэтгэх хуудасны 20.078.703.8 төгрөгийн баримт бичгийг гүйцэтгэсэн байна.

Төлөгдөөгүй 14.707 хүүхдэд олгогдох 27.710.567,9 төгрөгийн гүйцэтгэх баримт бичиг байгаагаас тогтмол төлөлттэй 7109 хүүхдэд холбогдох 145.322,8 төгрөгийн 5923 гүйцэтгэх баримт бичиг, төлөгдөлгүй хуримтлагдсан 7598 хүүхдэд олгогдох 27.855.890,0 төгрөгийн 6396 гүйцэтгэх баримт бичиг байна.

Үүнийг хүүхдийн насны байдлаар авч үзвэл 0-11 насны 12142 хүүхдэд холбогдох 20.587.026,9 төгрөгийн, 11 ба түүнээс дээш насны 2565 хүүхдэд холбогдох 7.123.540,3 төгрөгийн гүйцэтгэх баримт бичиг байна.

Төлбөр төлөгдөхгүй байгаа шалтгааныг авч үзвэл:

- Төлбөрийн чадваргүй 349 гүйцэтгэх хуудасны 2.772.445,8 төгрөгийн,
- Оршин суух хаяг тодорхойгүй 380 гүйцэтгэх хуудасны 2.768.801,4 төгрөгийн ,
- Хорих ял эдэлж байгаа 56 гүйцэтгэх хуудасны 320.188,0 төгрөгийн,
- Эрэн сурвалжлах ажиллагаа явагдаж байгаа 245 гүйцэтгэх хуудасны 2.316.198,8 төгрөгийн,
- Хэсэгчлэн төлөлттэй 6221 гүйцэтгэх хуудасны 19.053.351,6 төгрөгийн,
- Бусад шалтгаантай 5003 гүйцэтгэх хуудасны 479.581,6 төгрөгийн гүйцэтгэх баримт бичиг байна.

Дээрх мэдээнээс харвал хүүхдийн тэтгэлгийг цаг тухайд нь төлдөггүй, төлөхөөс зайлсхийдэг тохиолдол маш их байгаа нь харагдаж байна.

Тэгвэл тэтгэлэг төлөгч нь шүүхийн шийдвэрээр тогтоосон тэтгэлгийг гурван сараас дээш хугацаанд төлөөгүй тохиолдолд гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх арга хэмжээг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага авдаг байна.

Мөн Зөрчлийн тухай хуульд “тэтгэлэг төлөгч шүүхийн шийдвэрээр сар бүр төлбөл зохих хүүхдийн тэтгэмжийг гурван сараас дээш хугацаанд төлөөгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй /100,000/ тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос

[67] А. Батбаатар., Гэр бүлийн эрх зүйн зарим асуудал, УБ , 2021он, 78 дахь тал
[68] https://shuukh.mn/cases/1/1

гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна."[69] хэмээн заасан байдаг.

Дүгнэлт

Гэрлэгчид гэр бүл цуцлах, хамтран амьдрагчид хамтын амьдралаа дуусгавар болгож буй тохиолдолд хүүхдийн эрх ашиг хамгийн их хөндөгдөж байдаг тул хүүхдийг хэн нь өөрийн асрамждаа авах, хэрхэн тэжээн тэтгэх талаар эцэг, эх харилцан тохиролцож гэрээ байгуулдаг. Гэрээ байгуулаагүй бол тэтгэлгийг шүүх тогтоодог.

Гэрлэлт түүнтэй харьцах цуцлалтын тоо жил ирэх тусам нэмэгдэж байна. Монгол Улсын хэмжээнд тухайн тоо баримтаар өдөрт 10 гэр бүл гэрлэлтээ цуцлуулж, 40 хос гэрлэлтээ бүртгүүлдэг байна. Жилд 7200 гэр бүл салахад үүнээс зөвхөн 383 нэхэмжлэл шүүхэд гаргаж байгаа нь хүүхдийн тэтгэлгийн талаар иргэд эрх зүйн мэдлэг дутмаг байгааг нэг талаараа илтгэж байна.

Эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулж байгаа тохиолдолд эхний ээлжид хүүхдийн асрамжийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж эцэг, эхийн хэн нэгний асрамжид үлдээн нөгөөхөөс нь тэтгэлэг гаргуулна. Тэтгэлэг төлөгч нь хуульд заасны дагуу тэтгэлгийг төлөх үүрэг хүлээдэг ч шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэдээнээс харахад хүүхдээ тэжээн тэтгэх үүргээ биелүүлэхгүй байх тохиолдол их байна.

Тиймээс иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хүүхдийн тэтгэлэг төлөхгүй байгаа, төлөхөөс зайлсхийсэн тохиолдолд хүүлээлгэх хуулийн хариуцлагыг нэмэгдүүлэх нь зүйтэй юм.

Санал

1. Гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн үнэт зүйлийн талаар ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгах.
2. Шүүхээс тогтоосон хүүхдийн тэтгэлгийг төлөхгүй байгаа тэтгэлэг төлөгчийг албадан хөдөлмөрлүүлж цалин хөлснөөс тэтгэлгийг нөхөн төлүүлэх арга хэмжээ авах талаар зөрчлийн хуульд тусгах.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

1. Ж. Амарсанаа., Хүүхдийн эрхийн нэр томьёоны тайлбар толь, УБ, 2001он
2. А. Батбаатар., Гэр бүлийн эрх зүйн зарим асуудал, УБ , 2021он
3. Х. Отгонтуяа., Монгол улсын гэр бүлийн тухай хууль, түүний хэрэгжилт., УБ, 2009он
4. Гэр бүлийн тухай хууль., 1999он
5. Зөрчлийн тухай хууль.,2017он

[69] Зөрчлийн тухай хуулийн 6.20.6

6. Б. Даваажав, С. Оюунчимэг., Монгол улсын гэр бүлийн эрх зүй, УБ,2014он
7. https://shuukh.mn/cases/
8. http://mongolcom.mn/read/12399
9. https://isee.mn/n/31129
10. https://ikon.mn/n/uom
11. http://www.taniltsuulga.ubstat.mn/une7.aspx

---o0o---

ГЭР БҮЛИЙН ДУНДЫН ХӨРӨНГӨӨС ТӨЛБӨР ГАРГУУЛАХ АЖИЛЛАГААНЫ ОЙЛГОЛТ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

UNDERSTANDING OF THE LEGAL REGULATION AND SETTLEMENT OF FAMILY JOINT PROPERTY COLLECTION



Б.Энхсайхан
Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Хан-Уул дүүргийн 97 дугаар тойргийн шийдвэр гүйцэтгэгч, дэслэгч

Товч утга: Гэр бүлийн эд хөрөнгийн харилцааны талаар системтэй мэдлэг эзэмших, гэр бүлийн эд хөрөнгийг ангилан, хамаарагдах эд хөрөнгийг зөв тодорхойлох, эрх зүйн зохицуулалтыг тайлбарлах, холбогдох хуулийн заалтыг сонгон хэрэглэх, хууль зүйн үнэлэлт дүгнэлт хийх, гэрээ боловсруулах чадвартай болж, цаашид энэ асуудалд хууль зүйн үүднээс хандах.

Түлхүүр үгс: Гэр бүл, өмч хөрөнгө, гэр бүлийн дундын хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагаа.

Abstract: Acquire systematic knowledge of family property relationships, classify family property, correctly identify related property, explain legal regulations8 selectively apply revevant legal provisions, make legal assessments, develop contracts approach from a legal perspective.

Keywords: Family, property, joint family assets.

“Гэрлэлт” гэдэг нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёр, сайн дурын, чөлөөтэй, тэгш эрхийн үндсэн дээр гэр бүл болох зорилгоор хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг[70] хэлнэ. Харин “Гэр бүл” гэж гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг[71] хэлнэ гэж Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Гэр бүлийн тухай хууль”-д заасан байдаг.

Хүний жам ёсны эрхийн үндсэн суурь нь амьдрах эрх юм. Харин түүнийг хангахын тулд өмчийн эрхийг орхигдуулж болохгүй. Өмч гэдэг нь өөртөө

[70] Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг
[71] Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

материаллаг, хүсэл зорилгын шинжийг агуулж байдаг. Өмч гэсэн ойлголтыг эдийн засаг, улс төр, хууль зүйн судлагдахууны хувьд судлаачид өөр өөрийн үзэл баримтлалаар тайлбарлаж байсан. Тэдгээрээс заримыг нь авч үзье.

Баялаг болгон өмч байдаггүй ч өмч болгон баялаг байдаг юм. Уг баялгийн эзэн нь хүн бөгөөд нийгмийн гишүүдийн хоорондын харилцаа, санаа зорилгод өртөгдөж, тэдний хэрэгцээ, шаардлагыг хангах чанарыг агуулгатай болсон нь өмч юм.[72]

Джон Локк "Өмч бол хүнд байгаа бүх зүйл. Тухайлбал хөрөнгө төдийгүй, амь нас, эрүүл мэнд, алдар хүнд, хүндэтгэл хүлээх гэх мэт хуульчлагдсан эрхүүд, мөн байгалийн хуулийн дагуу хүн бүр хувийн өмчөө хамгаалах, хүн бүр өмчтэй байх нь түүний ердийн эрх юм."[73]

Марксийн хэлснээр "Өмч гэдэг бол тодорхой хүмүүс өөрийн болон эзэмшилдээ байгаа материал баялагтай харьцаж байгаа харьцаа юм. Өмчийн хамгаалалт сайтай газар ядуурал байхгүй[74]. Мөн өмч бол хөрөнгө бус чадвар юм. Өмч нь хүний эрх зүйн байдлыг тодорхойлж өгдөг бөгөөд өмчгүй хүн эрх чөлөөгүй байна. Хүний өмч хэдий чинээ ихсэх тусам эрх чөлөө төдий чинээ нэмэгдэнэ[75] гэх мэтээр өмчийн талаар шинжлэх ухааны олон салбарт судлан үзэл баримтлалаа дэвшүүлэн ирсэн байна.

Гэр бүлийн эд хөрөнгийг дараах байдлаар ангилан авч үздэг.

1. Гэр бүлийн гишүүний хуваарьт хөрөнгө
2. Гэр бүлийн гишүүний хамтран өмчлөх дундын хөрөнгө

Иргэний хуулийн 126 дугаар зүйлд "Гэрлэснээс хойш хамтран амьдарсан хугацаанд бий болсон гэр бүлийн гишүүдийн хуваарьт хөрөнгөөс бусад хөрөнгө нь гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын өмч мөн"[76] гэж тодорхойлсон бөгөөд дараах хөрөнгө хамаарна. Үүнд:

- гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүн болон тэдгээрийн хамтын хөдөлмөр, аж ахуйн үйл ажиллагаанаас олсон болон бусад орлого, мөнгөн хуримтлал, шинээр бий болсон хөрөнгө;
- гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгийн орлогоор олж авсан үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө;
- ногдол хувь, үнэт цаас;

[72] Ц.Цэрэнжээ, "Өмчийн эрх зүй", УБ, 2000 он, 3 дахь тал
[73] В.С. Нерсесянц, "Эрх зүйн гүн ухаан", орч, УБ,1999 он, 151 дэх тал
[74] К.Маркс "Капитал" орч, 1 дүгээр боть, УБ, 1999 он 698 дах тал
[75] Т.Одонхүү, "Эрх зүйн философи", УБ, 1999 он, 100 дах тал
[76] Иргэний хуулийн 126 дугаар зүйл

- гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүний хэн нэгний нэр дээр байгаагаас үл шалтгаалан гэрлэснээс хойш бий болсон бусад хөрөнгө;
- гэр бүлийн гишүүн өөрийн хуваарьт хөрөнгөөс дундаа хамтран өмчлөхөд зориулж шилжүүлсэн хөрөнгө, мөнгөн хуримтлал.
- Гэр бүлийн гишүүний хуваарьт эд хөрөнгийг гэр бүлийн бусад гишүүд их засвар хийсэн, шинэчилсэн, өөрчлөн тоноглосны улмаас үнэ нь үлэмж нэмэгдсэн, эсхүл анх гэр бүл болоход нь зориулагдсан /орон сууц, гэр, хашаа, байшин зэрэг/ бол хамтран өмчлөх дундын эд хөрөнгө болгон тогтоож болно.
- Гэрлэснээс хойш гэр ахуйн ажил эрхэлсэн, хүүхэд асарсан, өвчтэй байсан болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар орлого олоогүй байсан эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн хөрөнгөө хамтран өмчлөх эрх эдэлнэ.

Гэр бүлийн дундын өмчийг үүсгэхэд "гэрлэгчид" байх зайлшгүй шаардлагатай тул албан ёсны гэрлэлт чухал үүрэг гүйцэтгэнэ. Албан ёсны гэрлэлт нь Монгол Улсын "Гэр бүлийн тухай" хуулийн 7 дугаар зүйлд заасан "Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ гэрчийн этгээдийг байлцуулан иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ" гэсэн шаардлагыг хангасан байна. Гэр бүлийн дундын өмч үүсэх нэг нөхцөл нь хамтран амьдрах шаардлагатай бөгөөд дундын хөрөнгөд хамтран амьдарсан хугацаанд бий болгосон хөрөнгийг хамааруулна.

Гэр бүлийн дундаа хамтран өмчлөх үл хөдлөх эд хөрөнгө бусад үл хөдлөх эд хөрөнгийн адил энэ хуулийн 110 дугаар зүйлийн 110.1 дэх хэсэгт зааснаар "Үл хөдлөх эд хөрөнгийг Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар бүртгүүлснээр өмчлөх эрх үүсэх ёстой". Гэр бүлийн дундаа хамтран өмчлөх үл хөдлөх эд хөрөнгийн хувьд өмчлөх эрх өөрөөр үүсэх журмыг Иргэний хуульд заагаагүй байна.

Иймд шийдвэр гүйцэтгэгч бид гэрлэгчид болон гэр бүлийн гишүүдээс гэр бүлийн дундын өмч гэж маргаж байгаа үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөгчөөр болон хамтран өмчлөгчөөр хэн бүртгэгдсэн байгааг хамгийн түрүүнд харах ёстой. Учир нь Иргэний Хуулийн 183 дугаар зүйлийн 183.1-д[77] "Эрх шилжүүлж байгаа этгээдийн нэр дээр улсын бүртгэлд бүртгүүлсэн эрхийг хэлцлийн үндсэн дээр олж авч байгаа этгээд улсын бүртгэлд бичигдсэн тэмдэглэлийг буруу ташаа болохыг мэдэж байсан, эсхүл уг бүртгэлийг буруу ташаа гэж эсэргүүцсэнээс бусад тохиолдолд үнэн зөв гэж тооцно" гэж зааснаас харахад тухайн бүртгэлийн талаар буруу, ташаа болох тухай гомдлыг энэ зүйлийн 183.3-д зааснаар бүртгэлийн байгууллагад гаргаагүй тохиолдолд тухайн бүртгэлийг үнэн зөв гэж үзэхээр байгааг анхаарах хэрэгтэй болов уу.

[77] Иргэний хуулийн 183 дугаар зүйл

Иргэний хуулийн 126 дугаар зүйлийн 126.4 дэх хэсэгт “Гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүний хэн нэгний нэр дээр байгаагаас үл шалтгаалан гэрлэснээс хойш бий болсон бусад хөрөнгийг гэр бүлийн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгө гэнэ” гэсэн заалт нь зөвхөн гэрлэгчид, гэр бүлийн гишүүдийн хооронд үүссэн эд хөрөнгийг зохицуулж байгаа юм. Мэдээж гэрлэгчид, гэр бүлийн гишүүний аль нэг нь тухайн эд хөрөнгийг өмчлөх эрхтэй гэж үзэж байгаа бол өмчлөгчөөр бүртгүүлэхийг шүүхээс шаардах нь ойлгомжтой. Шийдвэр гүйцэтгэгчийн заавал анхаарах зүйлийн нэг бол Иргэний хуулийн 128 дугаар зүйлийн 128.2 дах хэсэгт “Гэр бүлийн гишүүд нь хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө харилцан тохиролцсоны үндсэн дээр эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах эрхтэй бөгөөд гэр бүлийн аль нэг гишүүн хамтран өмчлөх дундын өмчийн үл хөдлөх эд хөрөнгөө захиран зарцуулах бол гэр бүлийн насанд хүрсэн гишүүний бичгээр гаргаж, нотариатаар гэрчлүүлсэн зөвшөөрлийг авна” гэсэн зохицуулалт нь үл хөдлөх эд хөрөнгийг дундаа хамтран өмчлөх эрхийг олж авсан. Өөрөөр хэлбэл үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээнд нэр нь өмчлөгчөөр бичигдсэн гэр бүлийн гишүүдэд хамааралтай юм. Иймд тухайн төлбөр төлөгчийн үл хөдлөх эд хөрөнгийг өмчилж буй этгээдийн эхнэр, нөхөр, бусад гэр бүлийн гишүүнд тооцогдож буй этгээд мөн боловч дээр дурдсан хамтран өмчлөх эрх олж авсан этгээд биш тул өмчлөгчөөр тогтоолгох, шаардах эрхийг хэрэгжүүлэх боломжгүй юм.

Төлбөр төлөгчийн дундын эд хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулахдаа тухайн үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээн дээр бичигдсэн хамтран өмчлөгч нараас үнийн санал авах, төлбөр төлөгч, төлбөр авагч болон талуудад Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан талуудын эрх үүргийг тайлбарлан танилцуулан ажиллах ёстой.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулсан боловч төлбөр төлөгчийн хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхгүй бол төлбөр төлөгчийн хамтран өмчлөх эд хөрөнгийн түүнд ногдох хэсгээс төлбөрийг гаргуулна.

Гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгөөс гишүүнд ногдох хэсгийг тодорхойлон төлбөрийг гаргуулна

1. Гэрлэгчдээс төлбөр гаргуулахад тэдгээрийн хуваарьт эд хөрөнгө хүрэлцэхгүй бол

2. Гэр бүлийн бусад гишүүнээс төлбөр гаргуулбал

3. Гэр бүлийн гишүүдийн хамтран олсон, эсхүл гэр бүлийн гишүүний хэн нэгний хүлээх үүргийн дагуу олсон ашиг орлогыг гэр бүлийн хэрэгцээнд ашигласан нь нотлогдсон бол гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгөөс төлбөр гаргуулж болох бөгөөд уг эд хөрөнгө хүрэлцэхгүй бол гэр бүлийн гишүүний хуваарьт эд хөрөнгөөс гаргуулна.

4. Гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь төлбөрөө төлөхөөс зайлсхийх, хууль бус үйлдлээ халхавчлах зорилгоор хамтран өмчлөх дундын болон хуваарьт эд хөрөнгийг санаатайгаар бусдад шилжүүлсэн, нуун дарагдуулсан бол эдгээр эд хөрөнгөөс төлбөр гаргуулж болно.

5. Бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөхөөс зайлсхийх зорилгоор, эсхүл хууль бус үйлдлээ халхавчлах үүднээс олсон ашиг орлогоо гэр бүлийн бусад гишүүдийн хуваарьт эд хөрөнгөд, эсхүл хамтран өмчлөх дундын эд хөрөнгөд шилжүүлсэн нь нотлогдсон бол тэр хэмжээгээр уг эд хөрөнгөөс төлбөр гаргуулж болно.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хуулийн 133 дугаар зүйлд заасны дагуу “Шийдвэр гүйцэтгэгч” нь дараах бүрэн эрх эдэлнэ[78] гэж тодорхойлсон байдаг. Үүнд:

1. Гүйцэтгэх баримт бичгийг бүрэн гүйцэтгэх;

2. Хуульд заасан журмын дагуу төлбөр төлөгч хуулийн этгээд, төлбөр төлөгч иргэний, эсхүл бусад этгээдийн орон байр, агуулахад нэвтрэн орох, биед болон эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх;

3. Эд хөрөнгө битүүмжлэх, барьцаалах, хураах, нуугдмал хөрөнгө илрүүлэх, хураагдсан эд хөрөнгийг худалдан борлуулах;

4. Гүйцэтгэх баримт бичигт заасан үнийн дүнгийн хэмжээгээр банк, банкны бус санхүүгийн байгууллагад хадгалагдаж байгаа төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгө, бусад үнэт зүйлийг битүүмжлэх;

5. Гүйцэтгэх баримт бичиг нь тодорхой бус байгаа тохиолдолд түүнийг тодруулахаар шүүхэд хүсэлт гаргах;

6. Шийдвэр гүйцэтгэхтэй холбогдуулан иргэн, албан тушаалтныг дуудан ирүүлэх;

7. Холбогдох иргэн, байгууллага, албан тушаалтнаас баримт, тайлбар, танилцуулга гаргуулан авах;

8. Шийдвэр гүйцэтгэх явцад эрүүгийн хэргийн шинж бүхий баримт илэрвэл холбогдох байгууллагад мэдэгдэх;

9. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар талуудаас гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх;

[78] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 133 дугаар зүйл

10. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр дүнд хувийн сонирхолтой, эсхүл шударгаар ажиллахад эргэлзээ байгаа бол шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас татгалзан гарах эрхтэй билээ.

Шийдвэр гүйцэтгэгч хуулиар олгогдсон эрхийнхээ хүрээнд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулан дундын эд хөрөнгөөс төлбөр гаргуулахдаа дараах ажиллагааг зайлшгүй явуулах шаардлагатай. Үүнд:

1. Шүүхээс ирсэн гүйцэтгэх баримт бичгийг нэг бүрчлэн уншиж танилцах нь тухайн маргаан, төлбөр төлөгч, төлбөр авагч нарын талаар үнэн, зөв мэдээлэл олж авах, тухайн шийдвэр гүйцэтгэгч хууль хэрэглэх чадвар, дадалтай болно.

2. Шийдвэр гүйцэтгэгч нь сэтгэл судлаачтай адилхан. Учир нь иргэний эрх зүйн маргаанд оролцогчидтой байнга харьцаж, уурлаж бухимдсан сэтгэл зүйн янз бүрийн зан араншинтай иргэдийн нөхцөл байдлыг соргогоор мэдрэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулж дуусгадаг.

3. Шийдвэр гүйцэтгэгч нар хөрөнгө илрүүлэх ажиллагааг тухайн хэрэг маргаан гарч эхэлсэн он, сар, өдрөөс эхлэн явуулах шаардлагатай. Төлбөр төлөгч нар шүүхийн шийдвэр гарахаас өмнө урьдчилан хөрөнгөө бусдын нэр дээр шилжүүлэх, хуурамч гэрээ байгуулах гэх мэт шүүхийн шийдвэрээс зайлсхийх боломжит бүхий л аргыг ашиглаж болзошгүй учир шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр төлөгч нараас түрүүлж, сэтгэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хууль журмын дагуу шуурхай явуулах хэрэгтэй.

4. Нэг эд хөрөнгө хэд хэдэн өмчлөгчийн дундын өмч болж, нэг эд хөрөнгийг өмчийн эрхийн хэд хэдэн субъект нэгэн зэрэг өмчилж байдаг нь төвөгтэй харилцааг бий болгодог тул шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахдаа бусад оролцогчдын эрх, ашиг сонирхлыг хамгаалах шаардлагатай.

5. Шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр төлөгчид эд хөрөнгө байгаа эсэх талаар хуульд заасан журмаар мэдээлэл олж авах, төлбөр төлөгчийн мөнгөн хадгаламж болон харилцах данснаас хасалт хийх, эд хөрөнгө болон биед үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгийг битүүмжлэх, албадан барьцаалах, хураах, худалдан борлуулах бүх шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад тэмдэглэл хөтөлнө. Тэмдэглэлийг ойлгомжгүй, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар дэлгэрэнгүй бичээгүйгээс болж шийдвэр гүйцэтгэгч ажиллагаагаа хамгаалж чадахгүйд хүрдгийг анхаарах нь чухал.

6. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд төлбөр төлөгч, төлбөр авагч болон биеэ даасан шаардлага гаргасан гуравдагч этгээдэд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хуулийн 22 дугаар зүйлд заасан “Талуудын эрх, үүрэг”-ийг тайлбарлан танилцуулж, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцох эрхээр хангана.

7. Битүүмжилсэн, барьцаалсан эд хөрөнгийг худалдан борлуулах зорилгоор хураан авахдаа шийдвэр гүйцэтгэгч хугацааг нарийн тогтоож, хугацаандаа төлбөрөө төлөөгүй тохиолдолд гарах үр дагаврыг талуудад сайтар ойлгуулан шийдвэр гүйцэтгэгчийн тэмдэглэлээр баталгаажуулна.

8. Төлбөр төлөгчийн эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураах, шийдвэр гүйцэтгэгчийн тэмдэглэл хөтлөхдөө шийдвэр гүйцэтгэгч хувийн дугаартай тэмдэг дарж баталгаажуулна.

9. Төлбөр төлөгчөөс хуульд заасны дагуу “Эд хөрөнгийн тухай мэдүүлэг” авна.

10. Төлбөр төлөгчийн орон байр, эд хөрөнгө байгаа газарт нэвтрэх, эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх, түүнийг хураан авах зэрэг шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хөндлөнгийн хоёроос доошгүй гэрчийг заавал байлцуулна.

11. Гэрлэгчдээс төлбөр гаргуулахад тэдгээрийн хуваарьт эд хөрөнгө хүрэлцэхгүй бол гэр бүлийн хамтран өмчлөх дундын хөрөнгөөс тэдгээрт ногдох хэсгийг тодорхойлж, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” Монгол улсын хуулийн 53 дугаар зүйлийн 53.3 дахь хэсэгт заасан “Гүйцэтгэх баримт бичгийг үндэслэн эхний ээлжид бэлэн мөнгө эсхүл банк, банкны бус санхүүгийн байгууллага дахь хадгаламжийн болон харилцах дансанд байгаа төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгө болон бусад үнэт зүйлээс төлбөрийг гаргуулах” шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулсан боловч эд хөрөнгө байхгүй, мөн төлбөр төлөхөд хүрэлцэхгүй бол төлбөр төлөгчийн өмчлөлийн бусад эд хөрөнгөөс төлбөрийг гаргуулах ёстой.

12. Дээрх шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулсан боловч эд хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхгүй бол төлбөр төлөгчийн дундаа хэсгээр буюу хамтран өмчлөх эд хөрөнгийн түүнд ногдох хэсгээс төлбөр гаргуулна.

13. Шийдвэр гүйцэтгэгч дундын эд хөрөнгөөс төлбөр гаргуулахдаа гэрлэлтийн гэрчилгээг шалгах тухайн хөрөнгө хэзээ бий болсныг тогтоох шаардлагатай.

14. Дундын эд хөрөнгөөс төлбөр гаргуулахдаа төлбөр төлөгчид ногдох хэсгийг үнэн зөв тодорхойлох, үүний тулд талуудаас буюу хамтран өмчлөгчдөөс үнийн санал авах зөрүүтэй санал гарсан тохиолдолд мэргэжлийн шинжээчээр үнэлүүлнэ.

15. Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн дундын хөрөнгийн хувьд ногдох хэсгийг тэргүүн ээлжид хамтран өмчлөгч худалдан авах давуу эрх байдгийг анхаарах шаардлагатай.

Өнөөдөр Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжоор шийдвэр гүйцэтгэгч зөвхөн шүүхийн шийдвэрт заагдсан төлбөр төлөгч болон түүний нэр

дээр бүртгэлтэй хөрөнгөнд л шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах эрх зүйн зохицуулалттай.

Хэдийгээр Иргэний хуулийн 126 дугаар зүйлийн 126.2.4 дэх хэсэгт “Гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүний хэн нэгний нэр дээр байгаагаас үл шалтгаалан гэрлэснээс хойш бий болсон бусад хөрөнгийг гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгө” гэж хуульчилсан ч энэ заалт зөвхөн Шүүх дэх хэрэг маргааныг шийдвэрлэхэд баримталдаг заалт юм.

Харин шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн гэрлэлт, “Гэр бүлийн тухай хууль”-ийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь хэсэгт заасан “Гэр бүл” гэж гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг” хэлнэ гэж заасны дагуу гэр бүлийн гишүүдийн нэр дээр бүртгэлтэй хөрөнгийг тогтоон холбогдох цуглуулсан материалыг шүүхэд хүргүүлэн тухайн төлбөр төлөгчийн хувьд ногдох хэсгийг тогтоолгон ажиллах шаардлага зайлшгүй урган гарч байна.

Дүгнэлт

Гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагаанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан нийтлэг зохицуулалтыг шууд хэрэглэхэд учир дутагдалтай. Учир нь гэр бүлийн хамтран өмчлөх дундын өмч нь гэр бүлийн насанд хүрсэн болон насанд хүрээгүй бүх гишүүдийн эрх ашиг, сонирхолтой холбоотой бөгөөд гэр бүлийн амжиргааны баталгаа болж байдаг. Шүүхийн шийдвэрт төлбөр төлөгчөөс төлбөрийг гаргуулах гэж заасан байдаг ба харин ямар хөрөнгөөс гаргуулах вэ? гэсэн асуудал практикт тулгамдаж буй асуудал юм. Өөрөөр хэлбэл гэр бүлийн дундын эд хөрөнгөөс ногдох хэсгийг тодорхойлох асуудал чухал ач холбогдолтой. Нэг хүний хөндөгсөн эрхийг сэргээн эдлүүлэхийн тулд нөгөө хүний эрхийг зөрчихгүйн тулд хуулийн нарийвчилсан зохицуулалт шаардлагатай байна.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

12. Гэр бүлийн тухай хууль 2002 он
13. Иргэний хууль 2002 он
14. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он
15. Ц.Цэрэнжээ, “Өмчийн эрх зүй”, УБ, 2000 он, 3 дахь тал
16. В.С. Нерсесянц, “Эрх зүйн гүн ухаан”, орч, УБ,1999 он, 151 дэх тал
17. К.Маркс “Капитал” орч, 1 дүгээр боть, УБ, 1999 он 698 дах тал
18. Т.Одонхүү, “Эрх зүйн философи”, УБ, 1999 он, 100 дах тал

---o0o---

ИРГЭНИЙ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙГ БАТАЛГААЖУУЛАХ ЯВЦАД ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ НЬ:

ENSURING THE SECURITY OF DECISION EXECUTORS IN THE PROCESS OF ENFORCEMENT OF CIVIL DECISIONS:



Г.Түвшинтөр
Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-423 дугаар
нээлттэй, хаалттай хорих ангийн ахлах төлөөлөгч, ахмад

Товч утга: Шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлийг хангахын тулд зайлшгүй төрийн албадлагын ажиллагаа хийх шаардлага гардаг бөгөөд энэ ажиллагааны бие даасан нэг төрөл нь иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээ юм. Энэхүү ажиллагааг хэрэгжүүлж байгаа эрх зүйн субьект нь шийдвэр гүйцэтгэгч бөгөөд тэдний аюулгүй байдлыг хангах асуудал орхигдсоор байна. Энэхүү судалгааны ажлаар иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах явцад шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдлыг хангах арга замын талаар авч үзлээ.

Түлхүүр үгс: Шийдвэр гүйцэтгэгч, төрийн албадлага, иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах, аюулгүй байдал, хангах арга зам

Abstract: In order to ensure the execution of the court decision, there is a need for mandatory state coercive action, and one of the independent types of this action is the civil enforcement action. The legal entity implementing this operation is the decision maker, and the issue of ensuring their safety is still neglected. In this research work, the way to ensure the safety of the decision maker during the verification of the execution of the civil decision has been considered.

Keywords: Decision maker, state coercion, civil enforcement, security and enforcement.

Хүн өдөр тутамдаа нийгмийн харилцаа, тэр тусмаа эрх зүйн харилцаанд орж байдаг бөгөөд энэ явцад эрх, эрх чөлөө зөрчигдөх, хохирох асуудал үүсч, эрхээ хамгаалуулахаар хууль, шүүхийн байгууллагад хандаж, зөрчигдсөн эрхээ сэргээлгэдэг билээ. Энэ процесс ажиллагааны үр дүн нь шүүхийн шийдвэрээр эцэслэгдэж, тэр нь нэг мөр биелэгдснээр хүн эрх, эрх чөлөө сэргээн, улмаар хуулийн байгууллагад иргэдийн итгэх илтгэл бий болно.

Энэ утгаараа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага бол олон шат дамжлагатай хуулийн байгууллагуудын хийсэн ажлын үр дүнг гүйцэтгэлээрээ тодорхойлдог төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллага юм. Харин үүнийг хэрэгжүүлж байгаа эрх зүйн сүбьектын нэг бол шийдвэр гүйцэтгэгч бөгөөд тэдгээрийн эдлэх эрх, хүлээх үүргийг хуулиар баталгаажуулж өгсөн ч, тэдний ажил үүргийн онцлогтой холбоотойгоор бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад нь аюулгүй байдлыг давхар өндөр түвшинд хангаж байх нь гүйцэтгэлийн үр нөлөөг дээшлүүлэх чухал ойлголт юм.

Тэгэхээр шийдвэр гүйцэтгэгчийн чиг үүрэг, ажлын онцлогтой холбоотойгоор тэдний аюулгүй байдлыг авч үзэх асуудал нь нэг талаар эрх зүйн суурь шинжтэй ойлголт юм. Өөрөөр хэлбэл үйл ажиллагаа, чиг үүрэг, бүрэн эрхээ тодорхой тогтсон байранд хэрэгжүүлдэг Шүүх, Прокурорын байгууллагын алба хаагчдаас өөр гэсэн үг юм. Шийдвэр гүйцэтгэгч нь бүрэн эрхээ албан өрөөндөө хэрэгжүүлэхээс илүүтэйгээр гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөр төлөгч этгээдүүдийг орон байр, эд хөрөнгө байгаа газар явуулдаг онцлогтой юм.

Иймд тэдний тухайн нөхцөл дэх аюулгүй байдлыг хангах нь хамгийн чухал асуудал бөгөөд эрх зүйн онолын хувьд аюулгүй байдлыг урьдчилан хангах ойлголт юм.

Хэдийгээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулиар аюулгүй байдлыг хангах хариуцлагын төрлүүдийг зааж өгсөн боловч энэ бол аюулгүй байдлын дараагийн түвшний ойлголт.

Иймд энэхүү судалгааны ажлаар шийдвэр гүйцэтгэгчийн ажил, чиг үүргийн онцлогтой холбоотойгоор бүрэн эрхээ хэрэгжүүлэх / цаашид иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах явцад гэх / явцад аюулгүй байдлыг нь урьдчилан хангах арга замын талаар тодорхойлон авч үзлээ.

Нэг. Иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах тухай ойлголт, түүний төрлүүд

Иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах гэдэг бол нэр томьёоны хувьд шинэ ойлголт юм. “Иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээ гэж гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг албадан гүйцэтгэх, эсхүл төлбөр төлөгчийг гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг тогтоосон хугацаанд бүрэн гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн шийдвэр гүйцэтгэгчийн хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу хэрэгжүүлэх арга хэмжээг ойлгоно”[79] Үүнд:

[79] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг. Төрийн мэдээлэл - 2017 он. №24

- Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд /төлөөлөгчид/, бусад хүн, хуулийн этгээдийн төлөөллийг дуудан ирүүлэх;
- Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд /төлөөлөгчид/, бусад хүн, хуулийн этгээдээс гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг биелүүлэхэд шаардлагатай баримт бичиг, лавлагаа, тодорхойлолт гаргуулан авах;
- Төлбөр төлөгч болон бусад этгээдээс төлбөр төлөгчийн хөрөнгийн тухай мэдүүлэг гаргуулан авах, түүнийг төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэх;
- Төлбөр төлөгчийн үйл ажиллагаанд холбогдох санхүүгийн болон бусад баримт бичигт үзлэг хийх;
- Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд /төлөөлөгчид/, бусад хүн, хуулийн этгээдэд гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангах зорилгоор тодорхой үүрэг хүлээлгэх, энэ тухай мэдэгдэл хүргүүлэх;
- Төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг эзэмшиж, ашиглаж байгаа этгээдийн орон байрнаас бусад газар, барилга байгууламж, агуулах сав, эзэмшил газарт нэвтрэн орох, үзлэг хийх;
- Төлбөр төлөгчийг албадан нүүлгэхээс бусад тохиолдолд ахлах шийдвэр гүйцэтгэгчийн зөвшөөрснөөр төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг эзэмшиж, ашиглаж байгаа этгээдийн орон байранд нэвтрэн орох, үзлэг хийх.
- Гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг биелүүлэх зорилгоор төлбөр төлөгчийн бие, бэлэн мөнгө, бусад хөрөнгөд үзлэг хийх, тэдгээрийг битүүмжлэх, барьцаалах, хураан авах, худалдан борлуулах, хураан авсан эд зүйл, хөрөнгийг хадгалуулах, хамгаалуулахаар хүлээлгэн өгөх;
- Хуульд заасан үндэслэл, журмын дагуу битүүмжилсэн, барьцаалсан, хураан авсан эд зүйл, хөрөнгийг үнэлэх, уг ажиллагаанд шинжээчийг оролцуулах;
- Төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг эрэн сурвалжлах;
- Төлбөр төлөгчийн эд хөрөнгө, түүний эрхийн бүртгэлийн талаар улсын бүртгэлийн байгууллагад хандах, лавлагаа, тодорхойлолт гаргуулах;
- Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогчоос гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх;Төлбөр төлөгчийн банк, эрх бүхий хуулийн этгээд дэх мөнгөн хадгаламж, харилцах дансан дахь хөрөнгөөс суутгал хийх, дансны зарлагын гүйлгээг хаах, банк, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох, эсхүл эзэмшиж байгаа дансны орлого, зарлагын гүйлгээнд хяналт тавих;
- Төлбөр төлөгчийн улсын бүртгэлд бүртгэгдсэн эрхийг түдгэлзүүлэх;
- Үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчийн удирдлагад шилжүүлэх;

- Худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөрт тооцон суутгаж төлбөр авагчид шилжүүлэх, уг зорилгоор албадан чөлөөлөх;
- Хуульд заасан бусад.

Өөрөөр хэлбэл Иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээ гэдэг бол шийдвэр гүйцэтгэгчийн хуулиар олгогдсон бүрэн эрхтэй шууд холбогдох ойлголт бөгөөд бүрэн эрхээ хэрэгжүүлэх үйл ажиллагаа гэж ойлгож болно.

Гурав. Шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдлын тухай ойлголт ба өнөөгийн байдал

3.1. Аюулгүй байдлын тухай ойлголт:

Шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдал гэх ухагдахууныг авч үзэхийн өмнө ер нь “Аюулгүй байдал” гэж юуг ойлгоод байгаа талаар товч үзье.

Түүхийн цаг хугацааны үе шат бүрт “ Аюулгүй байдал” гэх ойлголтыг бүхий л салбарын эрдэмтэн судлаач, философичид хүний буюу хүн төрөлхтний хэвийн аж төрөх, оршин тогтнох, хөгжин дэвших амьдралын зорилго, үйл ажиллагаатай холбож авч үзжээ. [80]

Аюулгүй байдлын тухай ойлголтыг хэл зүйн талаас нь судлахад: Я.Цэвэл “ Монгол хэлний товч тайлбар толь” бүтээлд “ аюулгүй: - аймаар, жигшмээр юмгүй, аюултай: байвал зохих” хэмээн тайлбарлажээ.[81] Харин Б.Баярсайхан “ Монгол хэлний тайлбар толь” эмхэтгэлд “Аюулгүй: - аюулгүй байхгүй, айж эмээх, сандрах түгшүүргүй” хэмээн тайлбарлажээ. [82]

Энэ бүгдээс дүгнэхэд “аюулгүй байдал “хэмээх ойлголт нь хүн, төр, нийгмийн амин чухал хэрэгцээ хангагдсан байдал гэсэн ойлголтоор илрэн гарч байна.

Тэгэхээр аюулгүй байдал гэх ойлголт нь маш өргөн утга, агуулга бүхий ойлголт болох нь харагдаж байх бөгөөд үүнээс шийдвэр гүйцэтгэгч гэсэн эрх зүйн сүбьект хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад аюулгүй байдал нь хэрхэн хангагдаж байгаа талаар тусгайлан авч судлах нь зүйтэй гэж үзлээ.

3.2. Шийдвэр гүйцэтгэгч, түүний бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад аюулгүй байдлыг нь хэрхэн хангах буй талаарх эрх зүйн зохицуулалт:

Шийдвэр гүйцэтгэгч гэж Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан шаардлага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тогтоосон журам, эрүүл мэнд, бие бялдар, мэргэжил, ёс зүйн шаардлага, шалгуур

[80] Ц.Очгэрэл. Хорих байгууллагын аюулгүй байдал. УБ., 2017 он. 12 дахь тал.
[81] Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 2007 он. 5 дахь тал.
[82] Б.Баярсайхан. Монгол хэлний тайлбар толь. УБ., 2011 он. 87 дахь тал.

үзүүлэлтийг хангасан, арван найман насанд хүрсэн, дээд боловсролтой, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байгаагүй, шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн Монгол Улсын иргэн [83] байна.

Шийдвэр гүйцэтгэгч нь ерөнхий шийдвэр гүйцэтгэгч, ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгчээс бүрдэнэ.[84] гэж заажээ.

Дээрх эрх зүйн субьектийн аюулгүй байдлыг холбогдох хууль тогтоомжоор хэрхэн тодорхойлсон байдлыг авч үзье.

Монгол улсын Зөрчлийн тухай хуульд: Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах гэж юуг ойлгох, тэдгээрт хүлээлгэх хариуцлагыг заажээ. Үүнд:

1. Төрийн албан хаагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсхүл биелүүлэхгүй байхыг уриалсан;
2. Төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд нь саад учруулсан;
3. Төрийн албан хаагчийг хүч хэрэглэхгүйгээр эсэргүүцсэн, эсхүл доромжилсон бол хүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.[85] / *Тайлбар: "хууль сахиулах чиг үүрэг" шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны алба хаагчийн хуульд заасан чиг үүргийг ойлгоно гэж тодорхойлсон* /

-Монгол улсын Эрүүгийн хуульд: Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэдгийг хэрхэн ойлгох талаар тодорхойлж, хүлээлгэх хариуцлагыг мөн заажээ. Үүнд: Хууль сахиулагчийг албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлж эсэргүүцсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Энэ гэмт хэргийг галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, хууль сахиулах албаны тоног төхөөрөмж, барилга, байгууламжид халдаж үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.[86] гэж тус тус,

---

[83] " Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль"-ийн 270 дугаар зүйлийн 270.3 дахь хэсэг. Төрийн мэдээлэл - 2017 он. №24

[84] МУ-ын "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль"-ийн 270 дугаар зүйлийн 270.2 дахь хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл - 2017 он. №24

[85] МУ-ын" Зөрчлийн тухай хууль"-ийн 15.2 дугаар зүйлийн 2-ийн 2.1, 2.2, 2.3 дахь хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл - 2017 он. №24

[86] МУ-ын" Эрүүгийн хууль"-ийн 23.1 дүгээр зүйлийн 2-ийн 2.1, 2.2 дахь хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл - 2016 он. №7

- Мөн хуульд Нийтийн албан тушаалтныг заналхийлэх гэж нийтийн албан тушаалтныг тодорхой шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулах, шийдвэр гаргахгүй байх, үйл ажиллагаа явуулахгүй байхыг шаардаж өөрт нь, түүний ойр дотны хүнд хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.[87] гэж тус тус заажээ.

Хэдийгээр шийдвэр гүйцэтгэгч нь нийтийн албан тушаалтан, хууль сахиулагч болохын хувьд аюулгүй байдалд нь дээрх байдлаар халдсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхой заасан сайн тал боловч, дээрх зөрчил, гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах асуудал нь хамгийн чухал юм. Үүнийг холбогдох хуульд хэрхэн тодорхойлсон талаар авч үзье.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, техник, галт зэвсэг хэрэглэж болно.[88]

1. Биеийн хүчийг дараах тохиолдолд хэрэглэнэ.

- Алба хаагчийн хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн.
- Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад албадан хүргэх үед эсэргүүцэл үзүүлсэн;
- Нэг бүрийн тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхээр энэ хуульд заасан тохиолдолд.

2. Нэг бүрийн тусгай хэрэгслийг дараах тохиолдолд хэрэглэнэ:[89]

- Өөрийн, бусдын амь нас, эрүүл мэндэд учирч болзошгүй аюулыг таслан зогсоох;
- Зэвсэглэсэн болон зэвсэг хэрэглэн эсэргүүцэж болзошгүй ялтан, хоригдлыг баривчлах;
- Хоригдол хорих ангийн алба хаагчийн тавьсан шаардлагыг хүч хэрэглэн эсэргүүцсэн;
- Алба хаагчийн аюулгүйн тойрогт зөвшөөрөлгүй нэвтэрсэн;
- Хоригдлыг хуяглан хүргэх;

---

[87] МУ-ын” Эрүүгийн хууль”-ийн 23.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл - 2016 он. №7

[88] МУ-ын “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 290 дүгээр зүйлийн 290.1 дэхь хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл - 2017 он. №24

[89] МУ-ын “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 292 дугаар зүйлийн 292.1 дэхь хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл - 2017 он. №24

- Хяналтад байгаа хоригдол амиа хорлох, өөрийн бие махбодод гэмтэл учруулах, оргон зайлж болзошгүй бол тэдгээрээс урьдчилан сэргийлэх;

- Хорих байгууллага дотор гарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, хяналтдаа авах, хорих байгууллага доторх аливаа хууль бус үйлдлийг таслан зогсоох, хорих байгууллагыг бүслэн хаасныг чөлөөлөх;

- Хуульд галт зэвсэг хэрэглэхээр заасан бусад.

3.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг дараах тохиолдолд хэрэглэнэ:[90]

- Хорих ангид бүлэглэн халдсан;

- Хорих ангийн дотоод журмыг бүлэглэн зөрчсөн, эсхүл хорих ангид гарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч дээрх тохиолдлуудад биеийн хүч, тусгай хэрэгсэл, олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэж, гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс сэргийлэх, өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангахаар заасныг нэг бүрчлэн анзаарвал:

Дээрх тохиолдлууд бол Хорих байгууллагын алба хаагч руу чиглэсэн хамгаалалт байгаа нь тодорхой байна. Тэгвэл шийдвэр гүйцэтгэгчийн бүрэн эрх, чиг үүрэгтэй холбогдуулан, тухайлбал: шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн эд хөрөнгөнд үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгө битүүмжлэх, хураах ажиллагаа явуулж байх тохиолдолд биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрхэн хэрэглэх талаарх тохиолдлууд нь ойлгомжгүй бөгөөд нарийн тодорхой заагаагүй байна.

3.3. Шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдлын судалгаа:

Шийдвэр гүйцэтгэгч нарыг албан үүргээ буюу бүрэн эрхээ хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдуулан халдсан, заналхийлсэн тохиолдлуудыг 2014, 2015, 2016, 2017 онуудын байдлаар авч үзье. / Зураг -1 /

[90] МУ-ын “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 295 дугаар зүйлийн 295.1 дэхь хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл - 2017 он. №24



Дээрх судалгаанаас харахад жил ирэх тусам шийдвэр гүйцэтгэгч ямар нэгэн халдлагад өртөх нь нэмэгдэж байх бөгөөд 2013 онд нэг шийдвэр гүйцэтгэгч иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах явцад төлбөр төлөгчөөс эсэргүүцэл үзүүлж, буудуулж амь насаа алдсан тохиолдол ч байгаа гэдгийг сануулах нь зүйтэй.

Дөрөв. Дүгнэлт

1. Шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдлыг хангахдаа зөрчил, гэмт хэрэг гарсан тохиолдолд л хүлээлгэх хариуцлагыг заасан байх бөгөөд аюулгүй байдлыг хангах урьдчилсан хамгаалалтын талаар эрх зүйн зохицуулалт бараг байхгүй байна.
2. Шийдвэр гүйцэтгэгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад аюулгүй байдлыг нь хэрхэн хамгаалах эрх зүйн зохицуулалтыг хорих байгууллагын алба хаагчаас тусгайлан авч үзэх.

Санал:

1. Шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдлыг хангахдаа зөрчил, гэмт хэрэг гарсан тохиолдолд л хүлээлгэх хариуцлагыг заасан байх бөгөөд аюулгүй байдлыг хангах урьдчилсан хамгаалалтын талаар эрх зүйн зохицуулалтыг хуулиар бий болгох.
2. Шийдвэр гүйцэтгэгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад аюулгүй байдлыг нь хэрхэн хамгаалах эрх зүйн зохицуулалтыг хорих байгууллагын алба хаагчаас тусгайлан авч үзэж, тодорхой зааж өгөх.
3. Шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдлыг хангах тусгай нэгж / алба хаагч /-ийг алба бүр дээр байгуулж, иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах явцад аюулгүй байдлыг нь хангуулах.
4. Шийдвэр гүйцэтгэгч бүрийг тусгай хэрэгслээр хангах, сургалт, бэлтгэл тогтмол зохион байгуулах эрх зүйн үндэслэлийг бий болгох гэсэн саналуудыг дэвшүүлж байна.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

1. Монгол Улсын “Эрүүгийн хууль”., Төрийн мэдээлэл эмхэтгэл., 2016 он. №7
2. Монгол Улсын “ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”., Төрийн мэдээлэл., 2017 он. №24
3. Монгол Улсын “Зөрчлийн тухай хууль”, Төрийн мэдээлэл эмхэтгэл - 2017 он. №24
4. Баярсайхан, Б., Монгол хэлний тайлбар толь. УБ., 2011 он.
5. Очгэрэл, Ц., Хорих байгууллагын аюулгүй байдал. УБ., 2017 он.
6. Цэвэл, Я., Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 2007 он.
7. Хууль сахиулахын их сургууль., Төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын менежментэд тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам онол, практикийн хурлын эмхэтгэл. УБ., 2015 он.

---o0o---

ЦАХИМ ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ҮҮССЭН ХОХИРЛЫГ БАРАГДУУЛАХ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА

ENFORCEMENT PROCEEDINGS FOR COMPENSATION FOR DAMAGES CAUSED BY CYBERCRIME



Ж.Чүлтэм
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорих ял эдлүүлэх албаны холбоо, техник ашиглалтын хэлтсийн телекамерын инженер, ахлах дэслэгч

Товч утга: Дэлхийн улс орнуудын хууль, эрх зүйн хөгжил нь нийгмийн хөгжлийнхөө үйл явцтай зэрэгцэн шинэчлэгдэж боловсронгуй болсоор байгаагийн тод жишээ нь цахим гэмт хэргийг эрүүгийн хуульдаа тусгаж өгсөн явдал юм. Мэдээллийн технологийн салбар өндөр хурдтай хөгжихийн хирээр цахим орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн үйлдэл илүү нарийсаж, энэ төрлийн гэмт хэргийг гэмт бүлэг, этгээдүүд нууц далд хэлбэрээр зохион байгуулсаар байна.

Цахим гэмт хэрэг үйлдэж, бусдад учруулсан хохирлыг барагдуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үйл явцын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, төлбөр төлөгдөхгүй байгаа шалтгаан нөхцөлийг тодорхойлж цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал гаргасан.

Түлхүүр үгс: Төлбөр төлөгч, техник технологи, цахим орчин, цахим хэрэгсэл, гэмт хэрэг, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, Эрүүгийн хууль, тайлан мэдээ,.

Abstract: A clear example of how the law and legal development of countries around the world continues to be updated and refined along with the process of social development is the inclusion of cybercrime in their criminal law. Due to the rapid development of the information technology sector, the crimes committed in the online environment have become narrower, and criminal groups and individuals continue to organize this type of crime in a secret and hidden manner.

Analyzing the current state of the decision enforcement process for cybercrimes and compensation for damages caused to others, the reasons and conditions for non-payment of payments were identified and suggestions were made for further implementation measures.

Keywords: Payer, technology, electronic environment, electronic tools, crime, decision enforcement, Criminal Law, reports.

Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийг тодорхойлбол, цахим мэдээллийн аюулгүй байдал, төр, хуулийн этгээд, иргэний мэдээллээ өмчлөх эрхэд гэм буруугийн санаатай хэлбэрээр цахим мэдээлэлд хууль бусаар халдах, цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдах программ, техник хэрэгсэл бэлдэх, худалдан борлуулах, хор хөнөөлтэй программ хангамж бүтээх, ашиглах, тараах зэргээр халдсан, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай үзэгдэл юм.

Цахим гэмт хэргийн улмаас үүссэн хохирлыг барагдуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа


Монгол улсын хувьд 2015 онд батлагдаж 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төлдөр мөрдөгдөж байгаа эрүүгийн хуулийн 17-р зүйлд "Хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, **цахим хэрэгсэл ашиглаж**, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан бол дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ"[91], 13.10 дугаар зүйлд "Хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг хууль бусаар олж авсан, бусдад дамжуулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.... Энэ гэмт хэргийг:... харилцаа холбоо, **цахим хэрэгсэл ашиглаж;** эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ"[92] гэж тус тус зааж өгсөн.

Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас хүн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг барагдуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, шүүхээс бичигдэж ирсэн гүйцэтгэх хуудсыг үндэслэн

[91] Эрүүгийн хууль 2015 он. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2016 он, №07
[92] Эрүүгийн хууль 2015 он. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2016 он, №07

шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар гүйцэтгэдэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт цахим гэмт хэрэг үйлдсэн 14 төлбөр төлөгчид холбогдох 1,5 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 31 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж 953 сая төгрөгийн төлбөрийг бодитой биелүүлсэн байна. Дээрх төлбөрийн 60 орчим хувийг гадаад улсын иргэдээс учруулсан хохирол төлбөр эзэлж байна.




Дээрх гүйцэтгэх баримт бичгүүдийг гэмт хэргийн төрлөөр нь авч үзвэл:

- “Цахим сайтад орон сууц түрээслэх хуурамч зар байршуулж, урьдчилгаа мөнгө авсан” 9 буюу;
-“Бусдын цахим хаягт нэвтэрч, мөнгө зээлдүүлэх хүсэлт гаргасан” 13;
-Залилах гэмт хэргийг цахим хэрэгсэл ашиглаж, зохион байгуулалттай гэмт бүлэглэл үйлдсэн” 8;
-Бусдын виза карт ашиглан мөрийтэй тоглоом тоглосон” 1 буюу 3 хувь байна.



Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн гэмт хэрэг үйлдэгдсэн этгээдэд битүүмжлэх хөрөнгө, орлогыг олж тогтоох зайлшгүй шаардлагатай байдаг. Хэрэв хөрөнгө орлого тогтоогдоогүй бол иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар хөрөнгө, орлогыг олж тогтоох, бусад этгээдэд үл хөдлөх, хөдлөх хөрөнгөө шилжүүлсэн эсэхийг шалгах албадлагын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Дээрх төлбөр төлөгчдийн 6 нь Монгол улсын иргэн, 8 нь БНХАУ-ын харьяат иргэд байна.



Төлбөр төлөгч гадаад улсын иргэд нь Монгол улсад оршин суух тодорхой хаяггүй, эрхэлсэн ажилгүй, өөрийн нэр дээрх хууль ёсны хөрөнгө бүртгэлгүй гэх мэт шалтгаануудтай байдаг учир иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахад хүндрэлтэй байдаг.

Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирол, төлбөрийг барагдуулахад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн гэмт хэрэг үйлдсэн этгээдийн өмчлөл, эзэмшлийн хөрөнгө, хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг битүүмжилсэн нөхцөл байдал нь албадлагын арга хэмжээний үр дүнд шууд нөлөөлж байдаг учраас шүүхээс гарах шийдвэрийн

биелэлтийг баталгаажуулах урьдчилсан арга хэмжээ авагдсан нөхцөл байдал нь хохирол, төлбөрийг шуурхай шийдвэрлэхэд гол үндэслэл, нөхцөлийг үүсгэдэг гэсэн үг юм[93].

Сүүлийн жилүүдэд цар тахлын нөхцөл байдал болон цахим орчны хэрэглэгчдийн эрэлт ихэссэнээс шалтгаалан цахим худалдааны олон төрөл бий болсон бөгөөд түүнд тохирсон эрх зүйн орчин хангалтгүй байгаа тул хуурамч цахим худалдааны хохирогч болсон иргэд элбэгших хандлагатай байна. Мөн цахим сүлжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн нэг болох мөрийтэй тоглоом тоглуулах зөрчил олширч байгаа нь Нийслэлийн прокурорын газраас гаргасан дараах судалгаагаар харагдаж байна.

Улсын хэмжээнд 2022 оны 9 дүгээр сард 230895 иргэн, 293 хуулийн этгээд Зөрчлийн тухай хуульд зааснаар шийтгүүлсэн ба зөрчил үйлдсэн хүмүүсийн 76 хувь нь эрэгтэй, 24 хувь нь эмэгтэй байгаа бол 64.4 хувь нь 26-45 насныхан байна энэ дотор мөрийтэй тоглоом зохион байгуулсан 16 зөрчил байгаа нь цаашид энэ тоо өдөр өдрөөр өсөх хандлагатай байгааг тод харуулж байгаа билээ.

Дүгнэлт

Цахим орчинд иргэд олон нийтийн сүлжээ ашиглан нийгмийн харилцаанд оролцохдоо хувийн мэдээллээ алдах, хэт хувийн чанартай мэдээллийг хууль бус аргаар олж авч олон нийтийн сүлжээнд тавих, тавихаар заналхийлэх, бусдыг үндэслэлгүйгээр гүтгэх, нэр төрд нь халдах, доромжлон гутаах, залилах зэрэг гэмт хэргийн золиос болж байна.

Кибер гэмт хэргийн гаралт ийнхүү нэмэгдэж байгаа нь Монгол Улсад кибер аюулгүй байдлыг хангах хууль эрх зүйн орчин хангалттай бүрдээгүйтэй холбоотой.

Гэмт хэрэг үйлдэж буй хүмүүс ихэвчлэн гадаад сервертэй веб сайтуудыг хэрэглээндээ ашигладаг ба тухайлбал Фейсбүүк, твиттер нь АНУ-д бүртгэлтэй компани бөгөөд эдгээрт бүртгүүлсэн хэрэглэгчийн мэдээлэл Америкийн хуулиар хамгаалагддаг, манай улсын хуулиар зохицуулагдах боломжгүй тул иргэн гомдол гаргасан тохиолдолд тэр улсаас нь тухайн сайтыг шалгаж өгөх, мэдээлэл авах хүсэлтийг явуулдаг, цахимаар үйлдэгдэж байгаа гэмт хэргийн мэдээллийг автоматаар олж авах технологийн боломж дэлхийн аль ч улсад хязгаарлагдмал байдаг тухай мэдээллийн технологийн мэргэжилтнүүд тайлбарлаж байна.

Мөн Фейсбүүк /Facebook/ компани нь терроризм, хүний амь нас хохирох нөхцөл байдал бий болсон, хүүхдийн садар самуун, секс сүрдүүлэг, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг /хар тамхи, хүн худалдаалах, мөнгө

[93] Өнөрмаа.Б 2022 он. Цахим хэрэгсэл ашиглан үйлдэгдэж буй гэмт хэргийн шалтгаан нөхцөл, эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлага нийтлэл. Монголын хуульчдын холбооны веб сайт.

угаах/ зэрэг тодорхой төрлийн цөөн хэргээс бусад хэрэгт мэдээлэл гарган өгдөггүй нь олон төрлийн гэмт хэргийг таслан зогсооход хүндрэл учирдаг байна.

Цахим гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд нь төлбөрийн чадваргүй, оршин суух хаяггүй, өөрийн өмчлөлд бүртгэлтэй эд хөрөнгө байхгүй, хуулийн дагуу орлого олдоггүй, өөрийн нэр дээрх банкны дансаар гүйлгээ хийдэггүй зэрэг шалтгааны улмаас төлбөр төлүүлэх ажиллагаанд саад учирч байна.

Цахим хэрэгсэл ашиглан үйлдэж буй гэмт хэргийг таслан зогсоох, иргэдийг халдлагаас хамгаалахын тулд эрх зүйн орчныг бүрдүүлэх нь нэн түрүүний асуудал болж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн гэмт хэрэг үйлдэгдсэн этгээдэд битүүмжлэх хөрөнгө, орлогыг олж тогтоох зайлшгүй шаардлагатай байна. Ингэснээр төлбөр барагдуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд нэлээдгүй ахиц гарах болно.

Санал

Дээрх судалгаа дүгнэлтэд цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр дараах саналуудыг гаргаж байна. Үүнд:

1. Эрх зүйн орчныг бүрдүүлэх гол нөхцөл нь өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн зохицуулалтад дүн шинжилгээ хийх, сүүлийн 3 жилийн байдлаар энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хүн, халдлагад өртсөн хохирогчийн нийгэм хүн ам зүйн шинж, гэмт хэрэг үйлдсэн орчин нөхцөл зэргийг бүрэн хамруулсан суурь судалгааг мэргэжлийн байгууллагууд хамтран хийх;
2. Цахим хэрэгсэл ашиглан гэмт хэрэг /бусдыг заналхийлэх, цахим орчинд бусдыг дорамжлох, цахим хэрэгсэл ашиглан хүүхдийн эсрэг хууль бус үйлдэл хийх, эрсдэлт нөхцөлд оруулах зэрэг/ үйлдэж байгааг Эрүүгийн хуульд заасан үндсэн гэмт хэргийн хүндрүүлэх шинж болгон тусгах;
3. Цахим орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх;
4. Цахим орчинд хүүхдийн эсрэг чиглэсэн аливаа төрлийн хүчирхийлэл, хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө бүхий мэдээллийг зориуд түгээсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцож хуульчлах шаардлагатай байна.
5. Цахим худалдаа, цахим сугалааны эрх зүйн орчныг бүрдүүлэх;
6. Мөрдөгч нар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн гэмт хэрэг үйлдэгдсэн этгээдэд битүүмжлэх хөрөнгө, орлогыг олж тогтоох зайлшгүй шаардлагатай байна.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

1. Эрүүгийн хууль /2015 он/
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /2017 он/

3. НШШГГ-ын мэдээ, тайлан 2022 оны 09 сарын байдлаар
4. Эрүүгийн эрх зүйн тусгай анги 2018 он
5. Монгол улсын эрүүгийн хуулийн тайлбар 2013 он
6. Монгол улсын Ерөнхий прокурорын газрын цахим

---o0o---

ӨСВӨР НАСНЫ ХҮНД ОНОГДУУЛСАН ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ОЛОН УЛСЫН ХЭМ ХЭМЖЭЭ

INTERNATIONAL STANDARDS ON OTHER PENALTIES FOR JUVENILE PERSONS



Д.Одсэр
401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн дарга, удирдахуйн ухааны магистр, хурандаа

Товч утга: Өгүүлэлд өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг зохицуулсан олон улсын хэм хэмжээний ойлголт, төрөл, ангиллын талаар тайлбарласан.

Түлхүүр үгс: хорихоос өөр төрлийн ял, өсвөр насны хүн, олон улсын хэм хэмжээ, хяналт.

Abstract: The article describes the concepts, types, and classifications of international norms that other penalties for juvenile persons.

Keywords: non-custodial sentences, juveniles, international norms and controls.

Өсвөр насны хүний гэмт явдал нь нийгмийн тусгайлсан динамик үзэгдэл бөгөөд нийт гэмт явдлын хувьд аюултай “нөөц” гэж хэлж болох юм. Хууль зөрчигчийн насанд хүрээгүй байдлыг гэмт үйл хэрэгтэй тэмцэхэд чиглэсэн эрүүгийн эрх зүйн арга хэмжээний онцлогууд тодорхойлдгоос гадна нийгмийн, насны, сэтгэл зүйн болон бие бялдрын шинж чанараас хамаарсан энэ төрлийн иргэдэд хандах онцгой хандлага ч тодорхойлдог байна.

Насанд хүрээгүй хүний гэмт явдал нь дийлэнх нь орнуудын анхаарлын төвд байдаг асуудлуудыг нэг юм.

Э.Б. Мельникова “насанд хүрээгүй хүн” гэж өөрийн наснаас хамааран амьдралд хүлээн зөвшөөрөгдөхгүйгээс шалтгаалан тодорхой онцлог бүхий эрх,

үүрэгтэй бүлэг хүмүүсийг хэлдэг бөгөөд тэдний эрхийг хамгаалах эрх зүйн тогтвортой үндсийг боловсруулах шаардлагатай гэж үзсэн[94].

Энэ асуудлын хүрээн дэх олон улсын хамтын ажиллагаа нь насанд хүрээгүй хүнд эрүүгийн ял оногдуулах, түүнийг хэрэгжүүлэхэд хамаарсан олон улс, орнуудын туршлагад суурилсан суурь олон улсын баримт бичгийг боловсруулахад хүргэсэн. Үүнтэй холбогдуулан бидний судалж буй салбарын хүрээнд олон улсын баримт бичиг боловсруулах Нэгдсэн Үндэсний Байгууллагын голлох чиг үүрэг болсон юм.

Бидний судалж буй өсвөр насны хүний онцлогийг тодруулахын зэрэгцээ олон улсын байгууллагаас гэмт хэрэгт сэжиглэгдэж буй, буруутгагдаж буй, ял эдэлж буй насанд хүрээгүй хүмүүст хамаарах олон улсын баримт бичгийг боловсруулсан юм. Тэр дундаас Хүүхдийн эрхийн тунхаглал 1959 он, Хүүхдийн эрхийн тухай конвенци 1989 он.

Насанд хүрээгүй хүнд оногдуулах эрүүгийн ял нь олон улсын баримт бичгийн зарчимд бүрэн нийцсэн байх учиртай. Гэсэн хэдий ч дээр дурдсан олон улсын актууд нь өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ялыг эдлүүлэх ажиллагааг зохицуулаагүйг тэмдэглэх хэрэгтэй.

Олон улсын баримт бичгийг судлахын өмнө насанд хүрсэн болон насанд хүрээгүй бүхий л хүмүүст хамааралтай хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг зохицуулсан НҮБ-ын Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жижиг дүрмүүд буюу Токиогийн дүрмүүдийг нэрлэх нь зүйтэй. Бидний судалгааны хүрээнд бид зөвхөн насанд хүрээгүй буюу өсвөр насны ялтнуудын талаар судлах юм.

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны олон улсын эх сурвалж:

Хорихоос өөр төрлийн ял шийтгэлийн асуудлаар 1990 онд Нэгдсэн Үндэсний Байгууллагаас “Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм” Токиогийн дүрмийг батлан гаргасан нь хорих ялаас татгалзах, хорихоос бусад төрлийн ял шийтгэлийг өргөн хэрэглэх нөхцөлийг зарчмын хувьд бүрдүүлсэн чухал дүрэм болсон билээ.Токиогийн дүрэм[95] нь Ерөнхий Ассамблейн 1990 оны 10 сарын 14-ний өдрийн 4(110) дугаар тогтоолоор 7 бүлэг 23 зүйлтэйгээр батлагдсан бөгөөд уг дүрмээр хорих ялын хэрэглээг багасгах, эрх зүйн зөрчил гаргагчид нийгмийн өмнө хариуцлага хүлээх мэдрэмжийг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх зорилгыг агуулж, нийгмийн болон

[94] Мельникова Э.Б. Ювенальная юстиция. Проблемы уголовного права, уголовного процесса и криминологии : учеб. пособие. М., 2000. 11 дэх тал.
[95] Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхэтгэл. УБ., 2012. 159 дэх тал.

хохирогчийн ашиг сонирхлыг хамгаалахыг анхаарч шаардлагатай тохиолдолд хохирогчтой зөвлөлдөж байхыг зөвлөжээ.

Энэхүү Токиогийн дүрмээр хорихоос өөр төрлийн арга хэмжээнд хэрэглэгдэх зарчмуудыг тусгасан юм. Үүнд:

- Хорихоос өөр төрлийн ял хэрэглэж байгаа этгээдүүдийн хувьд наад захын баталгааг агуулах, ЭБША-г хэрэгжүүлэх

- Эрх зүйн зөрчил гаргагч этгээдэд хандахад олон нийтийн идэвхтэй оролцоог хангах;

- Эрхийн зөрчил гаргагчид нийгмийн өмнө хариуцлага хүлээх мэдрэмжийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

- Үндэсний эрүүгийн хууль тогтоомжийн бодлого зорилтыг харгалзан хэрэглэгдэх;

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн аюулгүй байдлын тухайд нийгмийн сонирхол, хохирогчийн эрх, зөрчил гаргагчийн эрхийн хооронд зүй зохистой харьцааг хангах;

- Хорих ялыг хэрэглэх явдлыг багасгах замаар бусад боломжийг хангах, нийгмийн шударга ёсны шаардлага, хүний эрхийг хангах зайлшгүй шаардлагыг харгалзан эрүүгийн хууль тогтоомж дахь бодлогыг оновчтой болгох зорилгоор үндэсний хууль тогтоомжийн хүрээнд хорихоос өөр төрлийн арга хэмжээг боловсруулах зорилготой.

Дүрэм нь хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэглэхэд дэмжлэг үзүүлэх, түүний зарчмыг тодорхойлох, шийтгүүлсэн этгээдүүдийн хувьд наад захын баталгаануудыг агуулдаг. Энэхүү дүрмийн гол онцлог нь эрх зүйн зөрчил үйлдсэн этгээдүүдийг нийгмийн хэвийн амьдралд түргэн эргэж ороход нь туслах, хорих ялаас татгалзах, ялын нөлөөг цээрлүүлэхээс илүүтэй дахин хэрэг зөрчил үйлдэж давтан гэмт хэрэгтэн болох явдлаас сэргийлж, төрийн эрх бүхий байгууллагын хяналтад авах замаар хүмүүжүүлж авахыг илүүд үзжээ. Үүнээс гадна хорихоос өөр төрлийн арга хэмжээ нь үр дүнгээ өгч байгаа тохиолдолд эрх зүйн зөрчил гаргагч этгээдийн хугацаанаас нь өмнө уг арга хэмжээг зогсоох, уучлах, үр дүнд хүрээгүй тохиолдолд шууд хорих ял хэрэглэхээс зайлсхийж дахин хорихоос өөр төрлийн ял шийтгэлээс сонгохыг санал болгож урамшуулах, уучлах, өршөөх, ажил сургалттайн холбогдуулж чөлөө олгох механизмыг тогтоож өгсөн байна.

Дээрх зохицуулалтаас гадна хорихоос өөр төрлийн арга хэмжээ хэрэгжүүлэгч тогтоол гүйцэтгэгчийн хувьд нарийн тодорхойлж амьдралын туршлагатай, мэргэжлийн зохих бэлтгэлтэй, хувийн шинж чанараар тохирсон хүн байвал зохино хэмээн тусгайлан тодорхойлсон нь ихээхэн анхаарал татсан юм.

Эдгээрээс үзэхэд хорихоос өөр төрлийн арга хэмжээ авагдсан этгээдийн сэтгэл зүйн байдалд ихэд анхаарч тусгайлсан мэргэжилтэн, сэтгэл зүйч бэлтгэхээс гадна олон нийтийн оролцоо уг арга хэмжээнд зайлшгүй чухал гэдгийг ухамсарлуулах зорилгоор онол практикийн бага хурал, семинар, бусад арга хэмжээг байнга зохион байгуулж ажиллахыг мөн зөвлөжээ.

НҮБ-ын гишүүн орнууд эрүүгийн хууль тогтоомждоо дээр дурдсан зарчмыг баримталж, хорих ялаас татгалзаж хорихоос өөр төрлийн ялыг сонгон хэрэглэх, уг ялыг хэрэглэхдээ олон нийтийн оролцоог сайжруулж, зөрчил гаргагч этгээдийн нийгмийн өмнө хариуцлага хүлээх мэдрэмжийг нэмэгдүүлж, эргээд нийгэмд хэвийн амьдралд эргэж орох хэрэгцээ, зөрчил гаргагч, хохирогч этгээдийн эрхийн хооронд зүй зохистой харьцааг хангаж, үндэсний хууль тогтоомж, нийгмийн шударга ёсны шаардлагад нийцүүлж хуульчлах шаардлагатайг дурдсан байгаа нь тус ялыг эдлүүлэх ажиллагааны тогтолцоог илэрхийлсэн гэж үзэж болох юм.

Олон улс үндэстэн эрүүгийн эрх зүйд хүний эрхийг хангаж, хүнлэг, энэрэнгүй ёсны хандлагыг хэрэгжүүлж ялын хатуу чанга ял шийтгэлээс татгалзаж, хүмүүжил олгох хорихоос өөр төрлийн нөлөөллийн арга хэмжээг өргөн дэлгэр хэрэглэх чиг хандлагатай байна. Уг байр суурийг ч мөн НҮБ өөрийн олон улсын баримт бичигт тусгах замаар гишүүн орнуудад үүрэг болгожээ.

Тиймдээ ч хорих ялын нийгэмд үзүүлэх үр нөлөө нь төдийлөн өндөр байдаггүйг дэлхий нийт хүлээн зөвшөөрч аль болох хорихоос өөр төрлийн ялыг сонгож, гэмт хэргийн шинж байдлаас нь шалтгаалан ялыг ялгамжтай оногдуулж, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэр бүл, нийгэмд нь байлгаж, гэмт хэргийн нийгмийн хор аюулыг ухамсарлуулахад чиглэсэн ялын бодлогыг баримтлах хандлагатай байна.

Токиогийн дүрмүүдийг боловсруулах гол учир нь хорих ялыг орлох өөр ялын төрлийн хэрэглэхэд оршсон. Энэ дүрмүүдэд хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүний баталгаа, эрх, хууль ёсны ашиг сонирхол зэргийг агуулдаг. Хорихоос өөр төрлийн ялыг ялтны хувийн байдал, түүнчлэн хохирогчийн эрх, шийтгэлийн зорилгод нийцэн тогтоогдсон шалгууруудад үндэслэн ялын төрлийг сонгодгийг тэмдэглэх хэрэгтэй[96].

Дүрмүүд нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэх, ялангуяа эрх зүйн зөрчил үйлдэгчдэд хандахад олон нитийн илүү идэвхтэй оролцоог хангах, түүнчлэн эрхийн зөрчил гаргагчид нийгмийн өмнө хариуцлага хүлээх мэдрэмжийг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх зорилгыг агуулдаг байна.

[96] Токиогийн дүрмүүдийн 3.2 дугаар дүрэм.

М.Р. Гета хорихоос өөр төрлийн ял нь зөвхөн бие даасан институц бус харин гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн эрх зүйн бүхэл бүтэн арга хэрэгсэл юм гэсэн байдаг[97].

Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг нийгэмд зүгээр орхилгүй хорихоос өөр төрлийн ял оногдуулж, олон нийтийн байгууллага, сайн дурын ажилтнуудыг татан оролцуулах чухал ач холбогдолтой. Харин үр дүнд нь ялын засрал хүмүүжил чөлөөт нийгэмд болох учиртай.

1990 оны Токиогийн дүрмүүдэд ялтанд тавих хяналтын гол зорилго нь давтан гэмт хэргийг бууруулах, нийгмийн амьдралд нь дэмжлэг үзүүлэхэд оршино гэж заасан.

Шаардлагатай тохиолдолд өсвөр насны ялтанд нийгмийн, сэтгэл зүйн болон хууль зүйн дэмжлэг үзүүлдэг байна. Өсвөр насны хүнд оногдуулсан үүрэг, хязгаарлалт нь түүний, хохирогчийн болон нийгмийн ашиг сонирхлыг харгалзан үзсэн тодорхой байх ёстой. Ялын зорилгод хугацаа дуусахаас өмнө хүрсэн тохиолдолд хорихоос өөр төрлийн ялаас хугацаанаас өмнө суллагдах боломжтой байдаг.

Токиогийн дүрмүүдэд ялтнуудад бүлгийн болон ганцаарчилсан сургалтыг зохион байгуулах арга зүйг боловсруулахдаа төрөл бүрийн хууль зөрчигчидтэй тусгайлан харьцах хэрэгтэй болохыг заавал харгалзан үзэх нь оновчтой гэж тэмдэглэсэн байна.

Хэрэг ялтан оногдуулсан ялыг эдлүүлэх журмыг зөрчсөн тохиолдолд ялыг зогсоох эсхүл өөр ялаар сольдог байна. Хэрэв ялтанд үзүүлэх ялын үр нөлөө үнэхээр бага байгаа бол нэн даруй хорих ялаар солих зөвлөмжийг олон улсын баримт бичгүүдэд тусгасан байдаг.

Шүүхээс хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн өсвөр насны хүнд хяналт тавьж байгаа албан хаагч нь ялтан бүрийн засрал хүмүүжлийн түвшинд үнэлгээ өгөх чадвар бүхий мэргэжлийн бэлтгэлжилттэй байх ёстой.

Үүний зэрэгцээ олон улсын баримт бичигт тусгагдсан зөвлөмжийг үл тоох хэрэггүй бөгөөд үндэсний хууль тогтоомждоо аль боломжтой байдлаар тусгах хэрэгтэй гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

Өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг зохицуулсан олон улсын баримт бичгийг судлахын зэрэгцээ Европын Холбооны “Насанд хүрээгүй хүнд хэрэглэсэн эрүүгийн эрх зүйн шинжтэй арга хэмжээний талаар Европын дүрмүүд”ийг судлах хэрэгтэй. Энэ дүрмүүдийг 2008 онд Бээжингийн болон Токиогийн дүрмүүдийн заалтуудыг харгалзан үзэж

[97] Гета М.Р. Альтернативы наказанию. М., 2004. С. 22-27.

боловсруулсан бөгөөд өсвөр насны гэмт хэрэгтэнд хэрэглэх нийгмийн санкци, арга хэмжээнүүдийн үндсэн зарчмууд, эрх зүйн хэм хэмжээг тогтоосон байна. Нийгмийн санкцид таслан сэргийлэх арга хэмжээнээс бусад өсвөр насны хүнд эрх чөлөөтэй, тодорхой хязгаарлалтыг дагаж мөрдөх аливаа арга хэмжээг хэлнэ гэж баримт бичигт дурдсан байна.

Иймд, өсвөр насны хүний насны ангиллыг харгалзсан хорихоос өөр төрлийн ялын олон сонголттой байхыг улс орнуудад зөвлөсөн байдаг байна.

Европын дүрмүүд нь өвсөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ялыг эдлүүлэх үндсэн зарчмуудыг тогтоосон байна. Үүнд:

- насанд хүрээгүй ялтны эрхэд хүндэтгэлтэй хандах;
- нийгмийн нэгдмэл байдал, хүмүүжүүлэх, давтан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зарчмууд нь тухайн хүмүүсийн ангилалд хамаарах ялыг хэрэгжүүлэхэд үндэс суурь байх ёстой;
- ял эдлүүлэхдээ өсвөр насны ялтан бүрийн онцлогийг (сонирхол, сэтгэл зүйн байдал), үйлдсэн гэмт хэргийн байдал, хэрэв шаардлагатай бол сэтгэл зүйн байдал, түүний талаар судалсан материал зэргийг харгалзан үзэх ёстой;
- ял эдлүүлэх явцад ямар нэгэн үндэслэлээр өсвөр насны хоригдлыг ялгаварлан гадуурхаж болохгүй;
- ялтны ашиг сонирхолд нийцээгүйгээс бусад тохиолдолд өсвөр насны ялтанд оногдуулсан хорихоос өөр төрлийн ялыг эдлүүлэх түүний эцэг эх болон бусад хууль ёсны төлөөлөгчдийг татан оролцуулах нь зөв гэж зөвлөсөн байна[98].

Ялтны эрхэд хүндэтгэлтэй хандах, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмууд нь бүх насны ялтнуудад хамааралтай гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Өсвөр насны хүнд оногдуулсан ялыг эдлүүлэх ажиллагааны онцлогийг дараах зарчмууд тодорхойлдог: хүмүүжүүлэх, насны ангиллыг харгалзан хүн бүртэй ажиллах замыг тодорхойлох, ялтны ашиг сонирхолд нийцээгүйгээс бусад тохиолдолд ял эдлүүлэх ажиллагаанд эцэг, эх, хууль ёсны төлөөлөгчдийг татан оролцуулах зэрэг.

Өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх талаар дүрмүүдэд тусгасан байна. Үүнд:

- эрх бүхий байгууллагаас өсвөр насны ялтны эцэг, эх, хууль ёсны төлөөлөгчид ял эдлүүлэх ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийн зорилго, агуулгын талаар тайлбар өгөх үүрэгтэй;
- ял эдлүүлэх байгууллагаас өсвөр насны ялтны эцэг, эх эсхүл хууль ёсны төлөөлөгчидтэй хамтын ажиллагааг идэвхжүүлэх;
- өсвөр насны хүнд оногдуулсан арга хэмжээнээс хамааран түүний эцэг эх, эсхүл хууль ёсны төлөөлөгчид эрх, үүрэг оногдуулах зэрэг.

[98] https://www.refworld.org/cgi-bin/texis/vtx/rwmain/opendocpdf.pdf?reldoc=y&docid=4d7882552

Европын дүрмүүд нь хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн өсвөр насны хүнийг ял эдлүүлэх наад захын нөхцөлийг тогтоодог. Эдгээрээс хамгийн чухал гэснийг судлан үзье.

1. Төрөөс өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ялыг эдлүүлэх олон сонголттой буюу хүмүүжүүлэх, нийгмийн хэм хэмжээнд нийцсэн дадал эзэмшүүлэх, ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг өсвөр насны хүнтэй зөвлөлдөх журмыг тогтоох хэрэгтэй.

2. Ял эдлүүлэх явцад нийгмийн эерэг харилцааг анхаарч өсвөр насны хүн болон түүний гэр бүлийн харилцааг тогтоох нь зүйтэй.

3. Өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ялыг эдлүүлэх нөхцөл, журмыг талаар төрөлх хэл дээр танилцуулах.

4. Үндэсний хууль тогтоомжид өсвөр ялтан ял эдлүүлэх нөхцөлийг өөрчлүүлэх талаар хүсэлт (амаар эсхүл бичгээр) гаргах эрхийг тусгах ёстой.

5. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх байгууллага нь ялтан бүрд хувийн хэрэг нээж, тогтмол баяжилт хийн, зохих журмыг дагуу хадгална.

6. Өсвөр насны ялтнаар нийтэд тустай ажил хийлгээд:

- ял эдлүүлэхдээ ашиг олохыг зорилго болгохгүй;

- ажил хийлгэх нөхцөл, журам нь хөдөлмөрийн болон эрүүл мэндийн тухай хуульд нийцсэн байх ёстой.

7. Өсвөр насны ялтныг нийтэд тустай ажил хийлгэхдээ аливаа тохиолдол, гэмтэл авахаас урьдчилан сэргийлж датгуулах хэрэгтэй.

8. Өсвөр насны ялтан, түүний эцэг эх, эсхүл хууль ёсны төлөөлөгчид ял эдлүүлэх ажиллагааны зардлыг төлөх ёсгүй.

9. Хэрэв өсвөр насны ялтан гадаадын иргэн бол түүнд эрх, үүргийг тайлбарлан харьяалагдах улсад шилжүүлэн өгнө.

Өсвөр насны хүнд оногдуулсан санкц, хязгаарлалтын арга хэмжээнүүд нь боловсрол эзэмших үйл явцад саад учруулахгүй байх ёстой. Өсвөр насны хүнийг хүмүүжлийн нөлөө үзүүлэх арга хэмжээнд ач холбогдол өгдөг байна.

Үүнээс гадна өсвөр насны хүнд хэрэглэх журам, өсвөр насны хүн, түүний эцэг эх, эсхүл хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөл хэрэгтэй тохиолдлын талаар үндэсний хууль тогтоомжид тусгах хэрэгтэй.

Насанд хүрээгүй хүмүүсийн боловсролын үйл ажиллагаа, мэргэжлийн боловсрол, нийгмийн хамгаалал, тэтгэмж авах, бие махбодийн болон сэтгэцийн эрүүл мэндийг нь хамгаалах, шийтгэл, хязгаарлах арга хэмжээ авах эрхийг өчүүхэн төдий хэмжээгээр зөрчихөд хүргэх нөхцөл байдлаас бүх талаар зайлсхийх шаардлагатай[99].

[99] Мөн тэнд.

Европын дүрмүүдэд өсвөр насны хоригдол тогтоосон нөхцөл, үүргийг биелүүлээгүй тохиолдолд дараах үндсэн хэм хэмжээг тогтоосон байна.

Нэгдүгээрт, ялын нөхцөл, журмыг биелүүлээгүй, ял эдлэхээс зайлсхийсэн тохиолдолд ирэх үр дагаврын талаар ялтан, түүний эцэг эх, эсхүл хууль ёсны төлөөлөгчдөд заавал танилцуулах хэрэгтэй.

Хоёрдугаарт, үндэсний хууль тогтоомжид өсвөр насны ялтан ялын нөхцөл, журмыг зөрчсөн тохиолдолд хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх байгууллагын ажилтан хэрхэн ажиллах талаар зохицуулалтыг тусгах шаардлагатай.

Гуравдугаарт, өсвөр насны ялтны хувийн хэрэгт бага ч хамаагүй зөрчлийн талаар тэмдэглэх хэрэгтэй. Ялтан ноцтой зөрчил гаргасан тохиолдолд энэ талаар шийдвэр гаргах субъектэд нэн даруй мэдэгдэх хэрэгтэй. Ингэхдээ эрүүгийн ял эдлүүлэх байгууллага шаардлагатай мэдээллийг (зөрчил гаргах нөхцөл, өсвөр насны хүний зан байдлын тодорхойлолт) агуулсан тайланг гаргадаг. Шаардлагатай тохиолдолд өсвөр насны хүнд сэтгэл зүйн, сэтгэц зүйн сорилыг зохион байгуулна.

Дөрөвдүгээрт, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх нөхцөл, журмыг зөрчсөн талаар хавтаст материалтай өсвөр насны ялтан, түүний эцэг эх, эсхүл хууль ёсны төлөөлөгчийг заавал танилцуулна.

Тавдугаарт, өсвөр насны хүний эдэлж буй ялыг өөрчлөх, зогсоох талаар асуудлыг шийдвэрлэхдээ юуны өмнө тэр бүх тогтоосон үүргийг биелүүлж байсан эсэхийг тогтоох, харин үүний дараагаар гаргасан зөрчлийн хүнд, хөнгөн байдлаас хамааран авах арга хэмжээг шийдвэрлэнэ[100].

Иймд, 2008 оны Европын дүрмүүд нь өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны үндсэн чиглэлүүдийг тогтоодог ба голлох байр суурийг нийгэмд дасан зохицуулах, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиглэл эзэлдэг. Мөн хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны онцлогийн талаар тусгасан байна.

Үүний зэрэгцээ өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны явцад үүсч буй асуудлыг шийдвэрлэхийн тулд тэдний эцэг эх, эсхүл хууль ёсны төлөөлөгчдийн эрх зүйн байдлыг тодорхойлохыг зөвлөдөг байна.

Дээр дурдсан олон улсын баримт бичгүүдээс гадна өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны асуудлыг бусад актуудад тусгалаа олсон байна. Энэ талаар бид товчлон судлан үзье.

---

[100] Мөн тэнд.

Европын Холбооны сайд нарын хорооны **“Пробацийн тухай Европын дүрмүүд” зөвлөмж № rec(2010)1**-т нийтэд тустай ажил хийлгэх нь ял болохын хувьд ямар нэгэн доромжлон гутаасан шинжтэй байж болохгүй. Нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулахдаа ялтанд өөрийн хөдөлмөрлөх чадвар, дадлыг хөгжүүлэх боломжийг харгалзан үзэх хэрэгтэй (47 дахь хэсэг)[101].

Дүрмүүдэд өсвөр насны хүмүүсээр хийлгэх нийтэд тустай ажлыг олон төрөлтэй байлгах болон нийтэд тустай ямар хийх сонирхолтой байгааг харгалзан үзэх хэрэгтэй гэж заасан (51 дэх хэсэг).

Мөн дүрмүүдэд ялтны гэр бүлтэй шууд болон бусад байгууллагаар дамжуулан ажиллахын ач холбогдлын талаар бичсэн байдаг (56 дахь хэсэг).

Европын Холбооны сайд нарын хорооны **“Нийгмийн санкц, арга хэмжээний тухай Европын дүрмүүд” зөвлөмж № rec(2017)**-ийн талаар дурдах нь зүйтэй. Энэ зөвлөмжийг боловсруулахдаа Пробацийн тухай Европын холбооны дүрмүүд (2014), Цахим хяналтын тухай Европын дүрмүүд (2014), Токиогийн дүрмүүдийн (1990) зарчмуудыг үндэс болгосон нь хорихоос өөр төрлийн ялыг хэрэглэх нэгдсэн, олон улсын хандлагыг боловсруулах хэрэгцээ шаардлага байгааг харуулсан байна.

Энэ олон улсын актад хорихоос өөр төрлийн ял оногдуулах үндсэн зарчмууд, хэрэглэх эрх зүйн үндэс, ял эдлүүлэх журам, нууцлалыг хангах арга хэмжээ, олон нийтийн оролцоо, шүүхээс тогтоосон хязгаарлал, үүргийн биелүүлээгүй тохиолдолд гарах үр дүн, ял эдлүүлэх байгууллагын албан хаагчид тавигдах шаардлагын талаар тусгасан байдаг.

Мөн дүрмүүдэд нийтэд тустай ажил агуулгын хувьд ялтны ажлын мэргэшлийн түвшинг аль болох нэмэгдүүлэхэд анхаарч, ач холбогдол өгсөн байдаг.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын № 29 Конвенцид шүүхийн шийдвэрээр хийгдэж байгаа аливаа ажилд хяналт эсхүл төрийн байгууллагаас хяналт тавих шаардлагатай бөгөөд ялтныг хувь хүн, компани эсхүл нэгдэлд шилжүүлэн өгч болохгүй. Монгол Улсын хувьд нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн хүний ажлын бүртгэлийг ажил хийлгэхээр гэрээ байгуулсан байгууллага хариуцдаг байна. Нөхцөл байдлыг манай орны нутаг дэвсгэрийн хэмжээ болон зарим орон нутагт шийдвэр гүйцэтгэх хэлтэс байхгүй нь хүндрүүлдэг байна. Эдгээр нь нийтэд тустай ажил хийлгэх ялын үр нөлөөнд сөргөөр нөлөөлдөг байна.

[101] http://www.consultant.ru/cons/cgi/online.cgi? req=doc&base=INT&n=58510#09198428253691164

Олон улсын баримт бичгийн агуулгад дүн шинжилгээ хийж өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх онцлог хэм хэмжээг тэмдэглэж болох юм. Үүнд:

- үндэсний хууль тогтоомжид хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн өсвөр насны ялтныг хүмүүжүүлэх талыг давамгай байлгах нь зүйтэй;

- өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа нь өсвөр насны хүнийг боловсрол эзэмшихэд хүндрэл учруулж болохгүй;

- хорихоос өөр төрлийн ялыг эдлүүлэхдээ өсвөр насны ялтны насны ангиллыг харгалзан харилцах хэрэгтэй;

- өсвөр насны ялтны зан үйлд эерэг үр дүн гарсан эсхүл эрүүгийн хариуцлагын нийгэмшүүлэх зорилгод хугацаанаас өмнө хүрсэн бол ялын нөхцөлийг зөөлрүүлэх, багасгах, хугацаанаас өмнө чөлөөлөх боломжийг бүрдүүлэх;

- өсвөр насны ялтны ашиг сонирхолд харшлаагүй бол түүний эцэг эх, эсхүл хууль ёсны төлөөлөгчийг татан оролцуулах;

- өсвөр насны хүнийг засан хүмүүжүүлэх, нийгмийн олон бусад туслалцаа үзүүлэх ажилд олон нийтийг идэвхтэй татан оролцуулах;

- Өсвөр насны ялтныг нийтэд тустай ажил хийлгэхдээ аливаа тохиолдол, гэмтэл авахаас урьдчилан сэргийлж датгуулах хэрэгтэй зэрэг.

---o0o---

НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

SENTENCING FOR PUBLIC BENEFIT WORK THE PROBLEM WITH THE JOB



Б.Эрдэнэчимэг
Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн
Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа
хариуцсан шийдвэр гүйцэтгэгч, ахлах дэслэгч

Товч утга: Нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтныг ажиллуулахад анхаарах зарим асуудал, тус ялыг хэрэгжүүлдэг гадаадын улс орнуудын туршлага, нийгэмд ашигтай ажлыг судлаач эрдэмтдийн судалгаанд тулгуурлан тодорхойлох, хэрэгжилтийг хангах, шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлага, хууль, эрх зүйн зохицуулалтын хүрээнд тулгамдаж буй асуудлыг гарган, шийдвэрлэх арга замыг тодорхойлохыг зорилоо.

Түлхүүр үгс: Нийтэд тустай ажил хийлгэх ял, түүний мөн чанар, ялын зорилго, нийгэмд үйлчлэх ял.

Abstract: Some issues to be considered in the employment of convicts sentenced to community service, the experience of foreign countries that implement this sentence, the definition of socially useful work based on the research of researchers, ensuring implementation, liability in case of non-compliance with the court; and legal and regulatory issues aimed to identify the problem and solve it.

Keywords: Community service sentence , its nature, purpose of sentence, community service sentence.

Нийгмийн түүхэн хөгжлийн тодорхой үе шатуудад хүмүүс өөрсдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан этгээдүүдийн үйлдлийг нь гэмт хэрэг хэмээн үзэж, тэднийг янз бүрээр шийтгэдэг байлаа. Харин энэхүү шийтгэлийн агуулга, зорилго нь тухайн нийгмийнхээ мөн чанараас шалтгаалан өөр өөр байж ирсэн.

Гэмт хэрэг үйлдэгчдэд оногдуулах эрүүгийн ял шийтгэлийн гол хэлбэр нь хорих ял бөгөөд дэлхийн ихэнх орнуудад түгээмэл хэрэглэдэг билээ. Гэтэл сүүлийн үед дэлхийн нийтээр хорих ялын нийгэмд болон хувь хүндээ үлдээх сөрөг үр дагаврыг улам бүр ойлгон, гэмт хэрэг үйлдсэн хүнийг шоронд хорихоос өөр

байдлаар цээрлүүлэх, засч хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх арга хэлбэрийг илүү сонгох болсон дэлхий нийтийн чиг хандлагаас харагдаж байна. Тухайлбал Голланд улс анх удаа шийтгэлийн гол төрөл болох хорих ялаас татгалзсан шийдвэрийг гаргасан. Тиймээс хорихоос өөр төрлийн ялыг сонгож хэрэглэх нь үр дүнтэй байгааг тодорхойлж байгаа юм. Үүний үр дүнд хорихоос өөр төрлийн ялын нэг төрөл болох нийгэмд тустай хөдөлмөр хийлгэх буюу нийтэд тустай ажил хийлгэх ял нь эрүүгийн хариуцлагын арга хэмжээнд хамгийн үр нөлөөтэйд тооцогдож, дийлэнх улсын эрүүгийн хууль тогтоомжид тусгалаа олж, шүүн таслах үйл ажиллагааны практикт өргөн хэрэглэгдэх болсон байна.

Хорихоос өөр төрлийн ял болох нийтэд тустай ажил хийлгэх ялыг практикт зонхилон хэрэглэж байгаа хорих ялтай харьцуулбал өөрийн гэсэн эерэг олон шинжийг агуулж байгаа юм. Энэ талаар судлаачдын дүгнэлтээс иш татвал Ш.Эрдэнэбат, О.Алтангэрэл "Гэмт хэрэгтнийг хорих газраас өөр газар олон нийтэд ойр орчинд ялыг эдлүүлэх, тодорхой хяналтын дор нийгэмд ашигтай хөдөлмөр эрхлэх боломжоор хангах нь шоронжих сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэхэд эерэг нөлөөтэй"[102], профессор Б.Уранцэцэг "Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр, гэр орондоо, садан төрлийн хүмүүсийнхээ дэргэд улмаар тодорхой хамт олны дунд байж тэдгээрийн дэмжлэг нөлөөн дор гэм буруугаа ойлгож, амьдралын зөв байр суурь хандлага руугаа эргэн орох боломжийг хорихоос өөр төрлийн ял болох албадан ажил хийлгэх ял олгодог"[103] Ц.Мөнхбат " Нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн этгээдэд цалин хөлстэй ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийж гүйцэтгүүлэх гэсэн санал агуулагдаж байна". хэмээн тус тус дүгнэн бичсэн байна. Мөн ХБНГУ-ын Эрүүгийн ялын нэг гол зорилго нь ялтынг нийгмээс тусгаарлахгүйгээр нийгэмшүүлэх асуудалд анхаарч ажилладаг нь тухайн улсын туршлагаас ажиглагдаж байна. Жишээлбэл: ХБНГУ-ын хорих байгууллагууднь хотын төв дунд байршилтай, нийгэмшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахдаа нийгэмд нээлттэй хэлбэрээр зохион байгуулдаг байна**.**

Харин манай улсын хувьд хорих ялыг хүчтэй байлгах сонирхол их байгаа нь хүмүүсийн эрх зүйн ухамсар, боловсрол дутуу дулимаг, төрийн ялын **бодлого** учир дутагдалтай, хууль сахиулах байгууллагуудын ажлын уялдаа холбоо төдийлэн сайн биш, төрийн болон иргэдийн хяналт сул байгаатай холбон үзэж болно. Өөрөөр хэлбэл, хүнд гэмт хэрэг **үйлдсэний** төлөө удаан хугацаагаар хорих нь шударга ёсыг тогтоох **явдал** гэсэн үзэл санаа нийгэмд хүчтэй байгаатай холбоотой.

Хэдийгээр нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдсэн боловч **түүндээ** тохирсон ял хүлээж байгаа нь шударга ёс бөгөөд харин ялаа эдэлж байгаа явдал нь түүнийг

---

[1] Ш.Эрдэнэбат, О.Алтангэрэл. Шийдвэр гүйцэтгэгчийн ном. УБ.2004 он 186 дах тал.

[103]А.Алтанзул . Албадан ажил хийлгэх ялын хэрэгжилтийн өнөөгийн байдал, түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгох зарим асуудал. 2007 он

дахин гэмт хэрэг үйлдүүлэхгүй **байхад** чиглэгдсэн хүмүүжлийн буюу урьдчилан сэргийлэх ач холбогдлоор тайлбарлах нь илүү зохистой гэж үзэж байна.

Тиймээс энэхүү илтгэлийн нэг үндсэн эорилго нь нийтэд тустай ажил хийлгэх ял, түүний мөн чанар, зорилгыг тодорхойлох ба энэ нь практикт ялыг зөв оногдуулж, түүнийг бодитой хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардагдах мэдлэг түгээхэд оршиж байгаа билээ.

Нийтэд тустай ажил хийлгэх ял нь "нийгэмд үйлчлэх ял" хэмээн зарим улс орны Эрүүгийн хуульд тусгалаа олсон байна[104]. Нийгэмд үйлчлэх ялыг ялын мөн чанарын үүднээс холбон тайлбарлавал ялтныг хөдөлмөрөөр хүмүүжүүлэхэд оршдог гэж хэлж болно. Иймд нийгэмд үйлчлэх ялын обьект нь зайлшгүй хөдөлмөр байдаг.

Нийтэд тустай ажил хийлгэх ял нь улс орнуудын Эрүүгийн хуульд ялын нэг төрөл болон хуульчлагдсан нь 19-р зууны сүүл үе, 20-р зууны эхэн үед бий болсон "нийгмийн ажил" хэмээх ухагдахуунтай салшгүй холбоотой юм. Тухайлбал, Дани улс 1930 онд Эрүүгийн хуульдаа энэ ялыг хуульчлан өгсөн нь анхдагч улсын тоонд ордог.[105]

Нийтэд тустай ажил хийлгэх ял нь нэр томъёоны хувьд улс орон бүрт харилцан адилгүй хуульчлагдан томъёологдсон байна. Жишээлбэл: Казакстан, Киргизийн Эрүүгийн хуулиудад уг ялыг "нийгмийн ажилд татан оролцуулах" гэсэн байдаг бол Английн зарим хуульд "нийгэмд үнэ хөлсгүй үйлчлэх", Гүржийн Эрүүгийн хуульд "нийгэмд ашигтай хөдөлмөр эрхлэх" Молдавт бол "нийгмийн тусын тулд үнэ хөлсгүйгээр ажиллах", харин Латвийн Эүүгийн хуульд "албадан хөдөлмөр хийх", Францад "нийтийн ашиг сонирхлын төлөө ажил хийх", Испанид бол "нийгмийн тусын тулд ажиллах" хэмээн тодорхойлдог. Тэгвэл **ОХУ,** Голланд, **Украйн** зэрэг улсуудад нийгмийн хөдөлмөр буюу "заавал ажил хийх" **ял** гэж тус тус нэрлэгддэг байна.[106]

Харин Нийтэд тустай ажил хийлгэх ялын гол шинжүүдээс дурдвал:

- нийгмийн болон олон нийтэд зориулагдсан шинжтэй ажил хийх
- нийгэмд ашигтай ажил байх
- албадлагын шинжтэй
- үнэ хөлсгүй хийх ажил байх гэсэн шинжүүд хамаарах юм. Энд дурдагдсан нийгмийн буюу олон нийтийн төлөө ажил хийх болон нийгэмд ашигтай ажил гэдгийг ялган авч үзэх зайлшгүй шаардлагатай байгаа юм.

Монгол Улсад хөдөлмөрлөх эрхтэй холбоотойгоор үүссэн гол гол нийгмийн харилцааг зохицуулдаг эрх зүйн үндсэн салбар бол Хөдөлмөрийн эрх

---

[104]Б.Билэгсайхан Албадан ажил хийлгэх ял бол ял шийтгэлийн өвөрмөц төрөл мөн. Улаанбаатар.2004 он. 23 дах тал

[105] А.Алтанзул . Албадан ажил хийлгэх ялын хэрэгжилтийн өнөөгийн байдал, түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгох зарим асуудал. 2007 он

[106] А.Алтанзул . Албадан ажил хийлгэх ялын хэрэгжилтийн өнөөгийн байдал, түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгох зарим асуудал. 2007 он

зүй байдаг билээ. Гэхдээ нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтны хөдөлмөрийн харилцаа эрүүгийн эрх зүйн зохицуулалтад хамаардаг нь уг ялын объект хөдөлмөр буюу нийгэмд ашигтай хийгдэх ажил байдагтай холбоотойгоор тайлбарлагдана.

Эрүүгийн хуульд зааснаар нийтэд тустай ажил хийлгэх ялын объект болох нийгэмд ашигтай ажлыг ялтан хаана гүйцэтгэхийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага тогтоон ял эдлүүлэх ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлдэг. Эндээс бид нийгэмд ашигтай ажил, хөдөлмөр гэж юу болох, түүний үндсэн шинж болон төрлийн талаар авч үзье.

Ер нь хөдөлмөр гэдэг ойлголтыг хүн төрөлхтөн эртнээс нааш мэдлэгийн янз бүрийн салбаруудаар дамжуулан судалж, тодорхойлж ирсэн. Хамгийн товчхоноор хэлбэл хөдөлмөр гэдэг бол эдийн болон эдийн бус баялгийг бүтээгч хүний зорилтот үйл ажиллагаа гэж хэлж болно.

Монгол улсын Эрүүгийн хуульд нийгэмд ашигтай ажил гэж ямар шинжтэй ажил байхыг заагаагүй. Харин эрдэмтэн судлаачдын бүтээлд товчхон агуулгаар тусгагдсан байдаг. Тухайлбал, доктор, профессор Г.Совд “тухайн нутаг дэвсгэрийн
тохижилт үйлчилгээний чиглэлийн биеийн хүчний ажлуудыг”[107], харин хуульч Д.Дэмбэрэлцэрэн “гудамж талбай цэвэрлэх, тохижуулах, хог цэвэрлэх, булах, мод сөөг суулгаж арчлах зэрэг ажил багтана” гэсэн бол доктор, профессор Б.Уранцэцэг “нийгэмд ашигтай ажил буюу ялтны хөдөлмөрийн үр дүн нь нийтэд эсхүл тодорхой нутаг дэвсгэрийн, тодорхой бүлгийн хүн амд хүртэж байх ажлыг хэлнэ”[8]. гэж тус тус үзсэн байна. Эдгээр хүмүүс “Нийгэмд ашигтай ажил” гэдэг ойлголтын агуулгыг үндсэн шинжүүдээр нь тодорхойлсон байна.

Нийгэмд ашигтай ажил нь заавал биеийн хүчний ажлын хэлбэрээр илэрнэ гэж үзэх нь учир дутагдалтай юм. Харин ялтны хийж буй ажил нь нийт хүн ам буюу олон түмний нийтлэг хэрэгцээ шаардлагыг хангасан шинжтэй байх нь уг хөдөлмөрийн үндсэн шинж гэж үзэж болно. Иймээс Эрүүгийн хуульд “нийгэмд ашигтай” гэсэн тодотгол нь тусгагдсан гэж дүгнэж болно. Өнөөдрийн практикт аймаг,хот, сум, дүүргийн засаг даргатай гэрээ хийж хот тохижуулах газар ажиллуулж байна. “**Нийгэмд ашигтай**” ажлыг төрөлжүүлэн ангилж авч үзэж болох юм. Үүнд:

Эрүүл аюулгүй орчны таатай нөхцөл байдлыг бий болгоход чиглэсэн ажил.

Нийтийн эзэмшлийн газарт мод зүлэг тарих, усалгаа хийх зэрэг хот цэцэгжүүлэлтийн газруудад ажиллахыг хэлнэ. Өнөөдөр манай улсад энэ төрлийн үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит “Хот цэцэрлэгжүүлэлт”, “Хот тохижилт”

---

[107] Г.Совд “тухайн нутаг дэвсгэрийн тохижилт үйлчилгээний биеийн хүчний ажил” 2002 он

[7] Д.Дэмбэрэлцэрэн Эрүүгийн хуулийн ерөнхий анги гол гол өөрчлөлтүүд, тэдгээрийг хэрэглэх асуудлууд / Монголын төр эрх зүй 2002/2 49 дах тал

ОНӨААТҮГазар байдаг бөгөөд цаашид энэ чиглэлээр хувь хүн, хуулийн этгээдүүдийг олноор бий болгож, үүнд нь албадан ажил хийлгэх ялаар шийтгэгдсэн ялтныг ажиллуулах нөхцлийг бий болгох шаардлагатай.

Хот тохижуулах чиглэлээр, тодруулбал нийтийн эзэмшлийн газар болох гудамж талбайг орчны хогийг цэвэрлэх, хүйтний улиралд цас, мөс арилгах зэрэг орно.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлийн ажил. Энд ой цэвэрлэх, нөхөн суулгах гэх мэт орно.

Нийгмийн хүмүүнлэгийн чанартай ажил хөдөлмөр.

Нийтийн сайн сайхны төлөө ажилладаг буяны болон хүмүүнлэгийн байгууллагуудад ажиллахыг хэлнэ. Жишээ нь: Улаан загалмайн нийгэмлэгт, асрамжийн байгууллагуудыг нэрлэж болно.

Гамшигт байдал буюу байгалийн давагдашгүй хүчний улмаас бий болсон нөхцөл байдлын хор уршгийг арилгахтай холбоотой чиглэсэн ажил. Үүнд: ялтан галын аюул, үер, зуд зэрэг онцгой нөхцөл байдалд ажиллах болно.

Бүтээн байгуулалтын шинжтэй буюу барилгын, аймаг, сумыг холбосон авто болон төмөр зам, гүүр барих ажлууд хийлгэж болно.

Яг ийм чиглэлээр албадан ажил хийлгэх ялаар шийтгэгсэд ажиллахгүй байгаа билээ. Энэ салбарт харьцангуй тухайн чиглэлийн мэргэжилтэй ялтнуудыг ажиллуулах нь уг этгээдэд ялын зорилго хангагдахад чухал ач холбогдолтой юм.

Ялангуяа нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтны хувийн онцлог байдлыг харгалзан үзэж ямар төрлийн ажлыг хийлгэх нь ач холбогдолтой вэ гэдэг талаас нь хууль сахиулах байгууллагын ажилтан бид анхаарч ажиллах нь зүйтэй юм. Нэгэн баримт тоон үзүүлэлт авч үзэхэд нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгэгдсэн 42 ялтны 38 нь тохижилт үйлчилгээний компанид ажилласан байх жишээтэй байгаа юм энэ нь ялтныг хувийн болон ажил мэргэжлийн онцлог байдлыг харгалзан үзэж албадан ажил хийлгэж нийгэмшүүлэх биш цээрлүүлэх, бусдад өширхөх, нийгмийг үзэн ядах үзлийг төлөвшүүлэх эрсдэлтэй.

Ялтнаар тэгвэл ямар ажлыг хийлгэж болох вэ?

Ер нь аливаа хүний хөдөлмөр бол түүний амьд явах эрхийн баталгаа, сайн сайхан амьдрах эрхэм зорилгоо биелүүлэх үндсэн хэрэгсэл болдог. Тэгвэл нийгэмд ашигтай ажпын зорилго бол нийтийн сайн сайхны төлөө, тэдгээрийн эрүүл аюулгүй орчныг бий болгох, хамгаалах, хадгалагдахад чиглэсэн байх ёстой билээ.

Иймд нийгэмд ашигтай ажлын үндсэн шинжийг бид тодорхойлохдоо нийтийн ашиг сонирхлын дагуу бүтээн байгуулалтын болон хамгаалалтын шинжтэй хөдөлмөр байна гэж үзэж байна. Энэхүү нийгэмд ашигтай ажлыг төрийн ба төрийн бус байгууллага, нийтэд үйлчилдэг аж ахуй нэгжүүдийн алинд ч хийж гүйцэтгэж болно. Өөрөөр хэлбэл, тухайн аж ахуйн нэгж, байгууллагад нийтэд тустай ажил хийлгэж буй ялтнаар ажил хийлгэхдээ өөрсдийн эрхэм зорилгод тусгасан нийтэд үйлчилдэг шинж чанартай ажлуудыг л гүйцэтгүүлэх ёстой.

Тулгамдаж буй асуудлын талаар

1. Нийслэл болон орон нутгийн шүүхээс гүйцэтгэх баримт бичгийг ялтан, этгээдгүй ирүүлдэг
2. ШШГТХууль болон холбогдох бусад хууль, журамд эрэн сурвалжлан олж тогтоосон ялтан, этгээдийг түр хугацаагаар саатуулах зохицуулалт байхгүй
3. Шөнийн цагаар болон амралтын өдрүүдэд эрэн сурвалжилж, олж тогтоосон ялтныг саатуулах, ял солих зохицуулалт байхгүй
4. Ялын цаг бүртгэлийн системд орчин үеийн дэвшилтэд технологийг нэвтрүүлэх, систем хөгжүүлэлт хийх, боловсронгуй болгох
5. Шүүхээс нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн зарим орон нутгийн харьяатай ялтнуудыг тухайн сум, орон нутагт нь ялыг эдлуүлэхэд ажпын байр байгаа боловч тэдэнд хяналт тавихад шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал байхгүй.
6. Сумдад нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтны ял эдлэлтийн байдалд аймгийн хуулийн хэлтэс хянаж шалгах үүрэгтэй боловч практикт хэрэгждэггүй
7. “Нийгэмд ашигтай ажил” гэсэн тодорхойлолтыг эрх зүйн талаас тодорхойлоогүй тул орон нутагт ялтнаар ямар ажил хийлгэх вэ гэдэг нь бүрхэг байдгаас уг ялын зорилго хангагддаггүй.

Санал

1. Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилтэд цаашид анхаарах асуудалд судлаачийн зүгээс дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:
2. Нийтэд тустай ажил хийлгэх ялыг хуулийн дагуу хэрэгжүүлэхэд тусгайлсан алба, мэргэжлийн ажилтныг ажиллуулах талаар орон нутагт ажлын байр бий болгож, байгууллагын бүтэц орон тоог нэмэгдүүлэх /нийгмийн ажилтан, сэтгэл зүйч/
3. ШШГТХууль болон холбогдох бусад хууль, журамд эрэн сурвалжлан олж тогтоосон ялтан, этгээдийг түр хугацаагаар саатуулах болох,
4. Шөнийн цагаар болон амралтын өдрүүдэд эрэн сурвалжилж, олж тогтоосон ялтныг саатуулах, ял солих зохицуулалттай болох,
5. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал, төсөвтэй болох
6. Нийтэд тустай ажил хийлгэх ялын талаар хууль сахиулах байгууллага болон холбогдох захиргааны байгууллага, ажил олгогч, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, уг ялыг эдлүүлэх ажиллагаатай холбоотой мэдээлэл сурталчилгаа, сургалтыг зохион байгуулах
7. Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн үйлдвэрийн газарт ажиллуулах,
8. Үндэсний брэнд бүхий үйлдвэртэй болох, үйлдвэрийг үнэгүй, хямд ажиллах хүчээр хангах
9. Нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтныг ажлын байраар хангах хөдөлмөр, нийгмийн харилцааг тодорхой боловсронгуй болгох, ял эдлэх хугацаанд ялтан орлого олох боломжгүй байдаг тул ажил олгогч, байгууллагаас ялтанд унааны болон өдрийн хоолны мөнгө гаргуулдаг байх

зэрэг болно.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

1. Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он
2. Монгол улсын Эрүүгийн хууль 2015 он
3. А.Алтанзул . Албадан ажил хийлгэх ялын хэрэгжилтийн өнөөгийн байдал, түүний эрх зүйн орчныг боловсронгуй болгох зарим асуудал. 2007 он
4. Д.Дэмбэрэлцэрэн Эрүүгийн хуулийн ерөнхий ангихол гол өөрчлөлтүүд, тэдгээрийг хэрэглэх асуудлууд / Монголын төр эрх зүй 2002/2
5. Б.Уранцэцэг Албадан ажил хийлгэх ял бүхий ялтныг ажиллуулахад анхаарах зарим асуудлаас / Хүний эрх сэтгүүл. 2005 он № 3.
6. Б.Билэгсайхан Албадан ажил хийлгэх ял бол ял шийтгэлийн өвөрмөц төрөл мөн. Улаанбаатар.2004 он.
7. Ш.Эрдэнэбат, О.Алтангэрэл. Шийдвэр гүйцэтгэгчийн ном. УБ.2004 он
8. О.Пүрэвсүрэн Албадан ажил хийлгэх ялыг эдлүүлэх үед анхаарах зарим асуудлууд. Зөвлөмж 2004 он
9. Б.Алтангэрэл “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хэрэгжилт, чиг хандлага” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл 2018 он

---o0o---

ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫН ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АРГА ЗАМ

EXECUTION OF THE PENALTY FOR LIMITATION OF FREE TRAVEL RIGHT AND WAYS TO IMPROVE IT



Б.Байгальмаа
Өмнөговь аймаг дахь
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын
техник хяналтын ажилтан, дэслэгч

Товч утга: Дэлхийн улс орнуудын хууль, эрх зүйн хөгжил нь нийгмийн хөгжлийнхөө үйл явцтай зэрэгцэн шинэчлэгдэж боловсронгуй болсоор байгаагийн тод жишээ нь технологийн дэвшлийг ашиглан цахим төхөөрөмжийг гэм буруутай хүний биед зүүж байршлыг тогтоон, зорчих маршрутыг хязгаарлан, хяналт тавьдаг болсон.

Монгол улсад шүүхээс ял шийтгэгдсэн этгээдийн зорчих хөдөлгөөнд хяналт тавих зарчмаар ашигладаг цахим тоног төхөөрөмжийг ял эдлүүлэх ажиллагаанд 2021 оноос хэрэглэж эхэлсэн бөгөөд, боловсронгуй болгох үйл явц явагдсаар байна.

Манай улс гэмт хэрэг үйлдсэн хүний хөл, гарын аль нэгэнд **бугуйн цаг** зүүчхээд гэр бүлтэйгээ хамт байж, нийгмийн харилцаанд хэвийн оролцож хийсэн хэргийнхээ ялыг үүрээд явна гэж хэн ч төсөөлж байгаагүй биз. Энэ нь “Зорчих эрхийг хязгаарлах ял” юм. Илтгэлд уг ялын хэрэгжилт, тулгамдаж буй асуудлын талаар бичлээ.

Дэлхийн улс орнуудад цахим бугуйвчийг анх Америкийн Нэгдсэн Улсад 1983 оноос хэрэглэж эхэлсэн ба Англи улс 1989 онд анх нэвтрүүлж, түүнээс хойш Швед, Голланд, Франц, Бельги, Канад, Австри, Швейцар, Герман, Португали, Итали, Израйл, Эстони, Оросын Холбооны Улс 2009 онд, Ази тивд Бүгд Найрамдах Солонгос, Турк, Сингапур зэрэг улсууд 2007 оноос хэрэглэх болсон. Мөн Их Британи, Умард Ирландын нэгдсэн Вант улс, Швед, Нидерланд, Норвег гэх мэт Европын холбооны улсууд 3-12 сарын хугацаатай, БНСУ, Турк гэх мэт Азийн орнууд 3 сараас 30 жилийн хугацаагаар ялыг оногдуулж, хяналт тавьж

ажилладаг байна. Өнөөдөр дэлхийн 30 гаруй оронд цахим бугуйвч хэрэглэгдэж байна.[108]

Түлхүүр үгс: Ял шийтгэл, эрүүгийн хариуцлага, эрх үүрэг, гэмт хэрэг, цахим бугуйвч, хязгаарлах бүс, бүс тогтоох, эрх хязгаарлах ял.

Abstract: Abstract: A clear example of how the law and legal development of countries around the world continues to be renewed and refined along with the process of social development is the use of technological advances to determine the location, limit and monitor the route of a guilty person by wearing electronic devices.

In Mongolia, the electronic equipment used by the court to monitor the movement of convicted persons has been used in the process of serving sentences since 2021, and the process of improvement is still ongoing.

No one in our country could have imagined that a person who has committed a crime will wear a wrist watch on one of his feet or hands, and then he will be with his family and take part in normal social relations. This is a "penalty to restrict the right to travel". In the report, he wrote about the implementation of the sentence and the problems.

Keywords: Punishment, criminal liability, rights and obligations, criminal, electronic bracelet, penalty of restriction of rights.

Эрүүгийн хуульд зорчих эрх хязгаарлах ялыг “Гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрх бүхий байгууллагын хяналтад өөрийн оршин суух газраас явахыг хориглох, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүргийг нэг сараас таван жил хүртэл хугацаагаар хүлээлгэхийг зорчих эрхийг хязгаарлах ял гэнэ.” гэж заасан.

Манай улсын хууль тогтоомж, бодлого боловсруулагчид энэхүү ялыг улсынхаа хөрсөнд буулгах гэж 2015 онд Эрүүгийн хуульд ялын бодлогыг тусгаж, 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хэрэгжих арга замыг батлуулж, хэрэгжилтийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлүүлэхээр тус тус заасан.

Монгол улсад зорчих эрх хязгаарлах ялыг хэрэгжүүлж эхэлсэн 2021 онд 1713 хүн шийтгэгдэж, шүүхээс шинээр хүлээн авснаас ялын хугацаа дууссан 199, өршөөл уучлал үзүүлсэн 21, хэрэгсэхгүй буюу хүчингүй болгосон 3, нас барсан 8, ял эдэлж байгаа 1194, зорчих эрх хязгаарлах ялыг хорих ялаар сольсон 169 гэх тоон үзүүлэлт гарсан байна. Үүнийг графикаар үзүүлбэл:

---

[108] Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны 2022 онд “Техник хяналтын ажилтан”-уудад зохион байгуулсан сургалт

2023 оны 02 сарын байдлаар 1437 хүн зорчих эрх хязгаарлах ялаар шийтгэгдэж газар, ялын хугацаа дууссан 93, өршөөл уучлал үзүүлсэн 24, хэрэгсэхгүй буюу хүчингүй болгосон 17, нас барсан 27, зорчих эрх хязгаарлах ялыг хорих ялаар сольсон 735 ялтан байна. Үүнийг графикаар үзүүлбэл:

Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэгдсэн этгээдийн судалгааг сүүлийн 2 жилийн байдлаар харьцуулбал:

Монгол улсын их хурлаас 2021 оны 07 дугаар 02-ны өдөр баталсан Тулгар төр байгуулагдсаны 2230 жил, Их Монгол Улсын 815 жил, Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан хүмүүнлэг, энэрэнгүй ёсны зарчмыг удирдлага болгон корона вирус халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор зарим гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлага, зөрчлийн шийтгэлээс нэг удаа өршөөн хэлтрүүлэх, чөлөөлөх, хасах, ялын төрлийг солихтой холбогдсон харилцааг зохицуулсан “Өршөөл үзүүлэх тухай хууль” хэрэгжсэнтэй холбоотойгоор хорих ангиас хорих ялаар шийтгэгдсэн хоригдогчийг өршөөлд хамруулж үлдсэн ялыг зорчих эрх хязгаарлах ялаар сольсон байна.

Зорчих эрх хязгаарлах ялын 2023 оны 02 дугаар сарын байдлаарх хэрэгжилтийг графикаар үзүүлбэл:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 170 дугаар зүйлд заасны дагуу зорчих эрх хязгаарлах ялыг дараах үндэслэлээр хорих ялаар сольдог. Үүнд:

Хяналтын тоног, төхөөрөмжийг устгасан, гэмтээсэн, хэвийн ажиллагааг сарниулсан;

Зөрчлийн тухай хуульд заасан нийтийн хэв журам, аюулгүй байдлын эсрэг зөрчил үйлдэж, шийтгүүлсэн;

Техникийн болон биечилсэн хяналтаас 24 цагаас илүүгүй хугацаагаар санаатайгаар зайлсхийсэн;

Эдгээр зөрчлүүдийг 2-3 удаа давтан гаргасан тохиолдолд ялыг хорих ялаар солино. Мөн хуулийн 170 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу дараах тохиолдолд ял эдлэх журмыг ноцтой зөрчсөнд тооцох бөгөөд хорих ялаар шууд сольж байна. Үүнд:

Гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн;

Шийдвэр гүйцэтгэгчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэхээс татгалзсан, хүч хэрэглэн эсэргүүцсэн, шийдвэр гүйцэтгэгчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан, хохирол учруулахаар заналхийлсэн;

Техникийн болон биечилсэн хяналтаас 24 цагаас илүүгүй хугацаагаар санаатайгаар зайлсхийсэн;

2021 оны байдлаар зорчих эрх хязгаарлах ял шийтгэгдэн ял эдэлж байх явцдаа дээрх зөрчлүүдийг гаргасан 169 ялтны үлдсэн хугацааг хорих ялаар сольсон байна. Тухайлбал:

-Зөвшөөрөгдсөн бүсээс удаа дараа гарсан 109 ялтан,

-Тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг 24 цагаас илүү хугацаагаар сарниулсан 41 ялтан,

-Дахин гэмт хэрэг үйлдсэн 19 ялтан байна.

2022 оны 09 дүгээр сарын байдлаар зорчих эрх хязгаарлах ял шийтгэгдсэн ялтнуудын хорих ялаар сольж буй 186 ялтнаас

-Зөвшөөрөгдсөн бүсээс гарсан 130

-Тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг 24 цагаас илүү хугацаагаар сарниулсан 30

-Дахин гэмт хэрэг үйлдсэн 26 ялтан хорих ялаар сольсон байна.

Тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг санаатайгаар сарниулна гэдэг нь цахим бугуйвчийг унтраах, эвдэх, оосрыг таслах зэрэг зөрчлүүд орно.

Уг зөрчлүүдийг эхний удаа гаргасан тохиолдолд ялтанд сануулж, техник тоног төхөөрөмжийг 24 цагаас илүү хугацаагаар ажиллагааг санаатайгаар сарниулсан тохиолдолд ахлах шийдвэр гүйцэтгэгч санал гарган прокурорт хянуулан, прокурорын дүгнэлтээр шүүхээс хорих ялаар солино.

2021 он буюу 2022 онд хорих ялаар сольсон үндэслэлийг графикаар харьцуулбал:

Үүнээс үзвэл 2023 оны 02 дугаар сарын байдлаар зорчих эрх хязгаарлах ял шийтгэгдсэн ялтан зөвшөөрөгдсөн бүсээс гарах, дахин гэмт хэрэг үйлдэх зөрчлүүд өмнөх оноос нэмэгдсэн байгаа нь ажиглагдаж байна.

Зорчих эрх хязгаарлах ял нь хүний зан төлөв, үйлдсэн гэмт хэргийн байдал, нийгэмд учруулсан хор уршгийг харгалзан нийгэм, хамт олныхоо дунд ажил хөдөлмөр эрхлэх, сурч боловсрох, гэр бүл үр хүүхдээ тэжээн тэтгэх үүргээ биелүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэн ял эдэлж байгаа юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 167-176 дугаар зүйлд дээрх ялыг хэрэгжүүлэх аргыг тусгаж, үүнтэй уялдуулан гаргасан журмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба нь Нийслэл болон орон нутаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт ажиллаж буй эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч нарыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, Улсын хэмжээнд ялын хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг. Харин шийдвэр гүйцэтгэгч нар зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтны дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлж, техникийн зааварчилгаа өгөхөөс гадна хувийн баталгаа гаргуулан авч, цахим бугуйвчийн нөөц цэнэг хураагуур, цэнэглэх залгууруудыг хүлээлгэн өгч, хяналтын цахим программд бүртгэж, үүний дараа шүүхийн шийдвэрт заасны дагуу зөвшөөрсөн, хориглосон бүс, явах чиглэлийг

тогтоож, шийдвэр гүйцэтгэгч нар биечилсэн хяналтыг тавихаас гадна “Цахим хяналт, удирдлагын төв”-өөс 24 цагаар давхар хяналт тавьж ажиллаж байна.

Шүүхээс оногдуулсан хязгаарлалтын дагуу хориглосон болон зөвшөөрсөн бүс, замын чиглэлийг тогтоон өгч, тухайн ялтанд аюулгүй ажиллагааны болон ашиглалтын талаар тайлбар, танилцуулга, зааварчилгааг өгдөг бөгөөд хэрэв заасан хориглолт, хязгаарлалтыг зөрчих, цахим бугуйвчийг таслах, гэмтээх зэрэг зөрчлийг гаргавал сануулга өгөх, гаргасан зөрчлөө дахин давтан гаргах, хориглолт хязгаарлалтыг ноцтой зөрчсөн тохиолдолд зорчих эрх хязгаарлах ялыг хорих ялаар солихоор хуульчилж өгсөн.

Мөн ялтан нь тогтоосон бүсээс гарч, 24 цагаас дээш хугацаагаар цахим бугуйвчийг цэнэглэхгүй, гар утсаар холбогдох боломжгүй үед техник хяналтын ажилтан, шийдвэр гүйцэтгэгчийн хамт эрэн сурвалжлах ажиллагааг зохион байгуулж олсон даруйд Прокурорын байгууллагад хорих ялаар солих саналыг материалын хамт хүргүүлэн ажиллаж байна. Гэвч Прокурорын байгууллагаас материалтай танилцаж, хянаж шүүхийн байгууллагад хүргүүлэх, шүүхээс шийдвэр гарах хүртэлх хугацаанд тухайн ялтныг дахин ялаас оргон зайлах нөхцөл бүрдэж байгаа гэж үзэж тулгамдсан дараагийн асуудлаар авч үзэж байна.

Дүгнэлт:

Илтгэлийн хүрээнд Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийг боловсронгуй болгох талаар дараах дүгнэлтийг хийлээ.

Энэхүү ял хэрэгжиж эхэлснээс хойш 2021 оны 07 дугаар сард гарсан Өршөөлийн хуультай холбогдуулан суллагдсан нэлээдгүй хоригдогчдын хорих ялыг дээрх ялаар сольж хэрэгжилт, ач холбогдлыг мэдрэх боломж олдсон гэж үзэж болно.

Зорчих эрх хязгаарлах ялыг хэрэгжилт нь аймаг, сум дүүргийн төв суурин газар болон алслагдмал зэлүүд багт амьдардаг гэмт хэрэг үйлдсэн иргэдэд харилцан адилгүй үйлчилж байна. Жишээ нь зорчих эрх хязгаарлах ялын тоног төхөөрөмж байнгын асаалттай байх мөн тухайн тоног төхөөрөмжийг хянах дата сүлжээтэй байснаар ял эдлүүлэх нөхцөл бүрдэж байгаа нь ямар нэгэн дата сүлжээгүй тог цахилгаангүй газрын хөнгөн, хүндэвтэр, анх удаа гэмт хэрэг үйлдсэн иргэнийг сонгох санкц бүхий зүйл эрүүгийн хуулийн зүйл заалтаас сонголтгүй болгож байгаа нь хүний эрх, ялын бодлогыг алдагдуулах ялтны эрх зүйн байдлыг дордуулж байгаа нь зорчих эрх хязгаарлах ялын хяналтын тоног төхөөрөмжийг боловсронгуй болгохыг шаардаж байна.

Хорихоос өөр төрлийн ялын нэг төрөл болох зорчих эрх хязгаарлах ял нь иргэдэд Монгол улсын үндсэн хуулиар олгосон иргэний язгуур эрх ашгийг дээдэлж, энэрэнгүй, эрүүл мэнд, эрх чөлөө, сурч боловсрох, гэр бүлтэйгээ байж үр хүүхдээ тэжээн тэтгэх, зэрэг эрхийг дээдэлж, ял эдлүүлэх ажиллагаа явагдаж

байгаа учир зорчих эрх хязгаарлах ялтан үүргээ биелүүлээгүй бол хүлээх хариуцлагыг хурдан шуурхай авах шаардлагатай бөгөөд ял завшуулахгүй байх бодитоор ял эдлүүлэх нь чухал гэх асуудал алба хаагчдад тулгарч байна.

Тухайлбал оргосон ялтан этгээдийг эрэн хайх нэгжийг бүсчлэн байгуулж, түүний шаардлагад нийцсэн алба хаагчийг бий болгох тусгай хэрэгсэл болон аюулгүй байдлыг бүрэн хангах тоног төхөөрөмжөөр хангах шаардлага үүссэн.

Санал:

Шинэ тутам хэрэгжиж байгаа, амьдралд суурь нь тавигдаж, орчиндоо дасах хугацаа хэдий хэрэгтэй ч цаана нь хүний эрх, гэр бүлийн гишүүдийн эрх ашиг хөндөгдөж байдаг гэдгийг ямагт санаж байх хэрэгтэй. Тиймээс асуудлыг зөв тодорхойлж, хурдан хугацаанд шийдвэрлэх арга замыг эрэлхийлж байх нь чухал.

Мөн хэрэгжиж эхлээд 2 жилийн нүүрийг үзэж зорчих эрх хязгаарлах ялын хэрэгжилтийн талаарх саналаа өөрийн өнцгөөс бичихийг хичээлээ. Үүнд:

1. Оргосон ялтныг эрэн сурвалжлах ажиллагааны зардал батлагдаагүй тул зардлын нормативыг батлах, эрэн сурвалжлах ажилтантай болох

2. Аймаг нийслэлээс алслагдсан сумдын ялтнуудыг холбогдох хуульд зааснаар цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах талаар тусгаж өгсөн ч төдийлөн үр дүнгүй байгаа тул сумын хэсгийн төлөөлөгчийн чиг үүрэг буюу гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нэмж тусгуулах, энэ нь ажлын хариуцлагыг нэмэгдүүлнэ.

3. Оргосон ялтны ял солих санал хүргүүлснээс хойш шийдвэрлэгдэх хүртэлх хугацаанд тухайн ялтныг хаана байлгах, хэрхэн хяналт тавих талаар хуульд заалт оруулах. Ямар нэгэн шүүгчийн захирамж гараагүй байхад Цагдан хорих байранд хорьж болохгүй, явуулчихлаа гэхэд дахин алга болж, дахиад л эрэн сурвалжлах хүн хүч, шатахуун гээд зардал гарна. Эсвэл нэг шинэ цахим бугуйвч зүүлгээд явуулчихлаа гэхэд дахиад эвдэх, алга болгох эрсдэл байна. Иймд оргосон ялтныг эрэн хайж олсноос хойших шүүх шийдвэрлэх хүртэлх хугацаанд ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолоор цагдан хорьж, саатуулах зохицуулалттай байвал ялтныг дахин оргох гэмт хэргээс урьдчилан сэргийлж, хорих ялаар солих үйл ажиллагааг явагдах хугацаанд хүндрэл учрахгүй гэж бодож байна.

Цаашид зорчих эрх хязгаарлах ял улам илүү өргөжиж, цахим бугуйвч болон техник хэрэгсэл илүү хөгжил дэвшилттэй, мөн хяналтын үйл явц хариуцлагатай, чанартай хэрэгжинэ гэдэгт би итгэлтэй байна.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /2017 он/
2. Эрүүгийн хууль /2015 он/

3. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны мэдээ, тайлан 2022 оны 09 сарын байдлаар
4. Зорчих эрх хязгаарлах ялын хэрэгжилтийг хангахад ашиглагдах гарын авлага /2021 он/
5. Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллагаанд дагаж мөрдөх хууль тогтоомжийн эмхэтгэл /2022 он/

---o0o---

ОХУ, МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖТОЙ ЭМНЭЛГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАСАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НИЙГЭМ-ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

IN ACCORDANCE WITH THE CRIMINAL LEGISLATION OF RUSSIA AND MONGOLIA



Ц.Пүрэвням
Дотоод хэргийн их сургуулийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн
багш, магистр, ахмад

Товч утга: ОХУ болон Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн дагуу эмнэлгийн албадлагын арга хэмжээ авах байгууллагын нийгэм, эрх зүйн шинж чанар, түүнчлэн эрүүгийн хуулиар хориглосон үйлдэл хийсэн хүмүүст эрүүгийн хариуцлага хүлээлгэх болон эрүүгийн эрх зүйн нөлөөллийн бусад арга хэмжээг ялгах хэрэгцээг шинжлэх ухааны үндэслэлтэй болгоход оршино.

Түлхүүр үгс: Эрүүгийн эрх зүйн нөлөөлөл; эрүүгийн хариуцлага; эрүүгийн хуулийн шинж чанартай бусад арга хэмжээ; эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ; албадлагын арга хэмжээ; ОХУ улсын эрүүгийн хууль.

Abstract: According to the criminal laws of the Russian Federation and Mongolia, the social and legal nature of the institutions that take coercive medical measures, as well as the need to distinguish between criminal liability and other measures of criminal legal influence on people who have committed acts prohibited by criminal law, is to be scientifically based.

Keywords: Criminal Justice Impact; criminal liability; other measures of a criminal law nature; coercive measures of medical quality; coercive measures; Criminal law of the Russian Federation.

Эмнэлгийн шинж чанартай албадлагын арга хэмжээг ОХУ-ын Эрүүгийн хуульд эрүүгийн хуулийн шинж чанартай бусад арга хэмжээ гэж хууль ёсны дагуу тусгасан болно (ОХУ-ын Эрүүгийн хуулийн 15-р бүлэг). Тэднийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх (ОХУ-ын Эрүүгийн хуулийн 97 дугаар зүйлийн 1 дэх

хэсгийн "а" хэсэг), ялаас чөлөөлөх ("б" хэсэг) зэрэг сэтгэцийн эмгэгтэй хүнд шүүхээс томилж болно. "ОХУ-ын Эрүүгийн хуулийн 97 дугаар зүйлийн 1 дэх хэсэг) эсвэл шийтгэлийн хамт ("в", "г" хэсэг) ОХУ-ын Эрүүгийн хуулийн 97), Эдгээр хэм хэмжээний дүн шинжилгээ нь мөн чанарыг харуулж байна. Эмнэлгийн албадлагын арга хэмжээ хууль тогтоомжийн түвшинд тодорхой тодорхойлогдоогүй байгаа тул энэ цоорхойг зөвхөн одоо байгаа сургаалын судалгааг харгалзан нөхөх боломжтой гэж үзэж байна.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг агуулгын талаар гаргасан дүгнэлтүүдийг "Эмнэлгийн албадлагын арга хэмжээ" гэж дараах байдлаар бүлэглэн ангилж болно:

- Эрүүгийн хуулийн хамтын институци буюу түүний агуулга нь хуулиар тогтоосон арга хэмжээнээс гадна эмнэлгийн шинж чанартай тул хар тамхинд донтох өвчтэй хүмүүст ял эдлэх хугацааг хойшлуулахыг багтаасан байх ёстой [10, х. 183];

- Ижил шийтгэлтэй байгууллага [13, х. 46];

- ОХУ-ын Эрүүгийн хуулийн 97 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тодорхой этгээдийг гэм буруутайд тооцсон ял, шийдвэрийн үндсэн дээр шүүхээс тогтоосон эрүүгийн хуульд заасан төрийн албадлагын арга хэмжээг авна. [4, х. 59];

- Эрүүгийн хариуцлагаас ангид бусад эрүүгийн хуулийн шинж чанартай арга хэмжээ [11, х. 17];

- Эрүүгийн хариуцлага хүлээлгэх хэлбэр нь "өөр арга хэмжээ" биш, харин сэтгэцийн өвчтэй хүн эрүүгийн хуулиар хориглосон нийгэмд аюултай үйлдэл хийсэнтэй холбогдуулан авсан аюулгүй байдлын арга хэмжээ юм. [1, х. 12].

Эмнэлгийн албадлагын арга хэмжээний эрүүгийн эрх зүйн хамтын институци болохын хувьд эрүүл мэндийн шалгуурын (зан чанар) багтаасан эрүүгийн эрх зүйн нөлөөллийн арга хэмжээг хамрах шаардлагатай. Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлд донтогчийн ял эдлэх хугацааг хойшлуулах нь эрүүгийн хуулийн шинж чанартай өөр арга хэмжээ гэж хүлээн зөвшөөрөх боломжгүй, тухайлбал ОХУ-н эрүүгийн хуульд эмнэлгийн албадлагын арга хэмжээ хэд хэдэн шалтгааны улмаас тайлбарлагддаг үүнд:

- Нэгдүгээрт албан ёсны шалгуурыг харгалзан эмнэлгийн албадлагын арга хэмжээ нь ОХУ-ын Эрүүгийн хуулийн хэм хэмжээгээр тодорхой зүйлд заасан жагсаалт, бүрэн гүйцэд бөгөөд өргөн хүрээтэй тайлбар хийх боломжгүй, харин хар тамхинд донтсон хүмүүст ял эдлэхийг хойшлуулах нь хуулийн дагуу ялаас чөлөөлөх төрөл гэж ангилдаг (ОХУ-ын Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэг 82^1 хуудас);

- Хоёрдугаарт "хугацааг" хойшлуулах үндэслэл нь гэмт хэргийн шинжтэй хууль зүйн баримт юм;

- Гуравдугаарт хорих ялыг хойшлуулах нь зөвхөн гэмт хэрэг үйлдэх явцад үйлдлээ ухамсарлаж, түүнийг удирдах чадвартай этгээдэд л хэрэгжиж болно;

- Дөрөвдүгээрт ял эдлэхийг хойшлуулах өргөдөл гаргахдаа түүнд тохиолдсон эрх чөлөө, хязгаарлалтыг хуульд заасан хугацаанд (5 жилээс илүүгүй (ОХУ-ын Эрүүгийн хуулийн 82[1] дүгээр зүйлийн 1 дэх хэсэг)) хэрэгжүүлдэг бөгөөд зөвхөн албан ёсоор хамаарна. Гэмт хэрэг үйлдсэн хүний эрүүл мэндийн байдал, бие хүний бусад онцлогоос шалтгаална.

- Тавдугаарт хар тамхинд донтох эмгэгийг эмчлэх, хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрүүл мэндийн нөхөн сэргээлт хийх нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн сайн дурын хүсэл, харин ОХУ-н Эрүүгийн хуулийн 15-р бүлэгт заасан эрүүгийн хууль сахиулах арга хэмжээ нь үндсэндээ сонгох эрх чөлөөг хангадаггүй бөгөөд зөвхөн албадлагын шинж чанартай байдаг.

Эмнэлгийн албадлагын арга хэмжээ, ялангуяа "хязгаарлагдмал эрүүл ухаантай" хүмүүст хэрэглэсэн эмнэлгийн албадлагын арга хэмжээ нь эрүүгийн хариуцлагын материаллаг илэрхийлэл гэж үздэг зохиогчдын үзэл бодолтой санал нийлэх нь хэцүү байдаг.

1) Эрүүгийн хариуцлагын сэдвийн талаарх орчин үеийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн (хууль тогтоох түвшинд) онолыг харгалзан сэтгэцийн эмгэгтэй хүмүүст эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь хүлээн зөвшөөрөгдөхгүй гэж үзэх нь аксиономик юм. Нийгэмд аюултай үйлдэл хийсэн сэтгэцийн өвчтэй хүн объектив шалтгаанаар эрх чөлөө, хуулийн хязгаарлалтад өртөж байгаагаа ойлгох чадваргүй байгаа тул урьд өмнө нь гэмт хэрэг үйлдсэний улмаас эрүүгийн хариуцлага шийтгэл оногдуулах арга хэмжээ авах боломжгүй юм.

2) ОХУ-ын Эрүүгийн хуулийн VI хэсэгт хуульд заасан ёсоор хуваах зарчим тодорхойгүй байна. Эмнэлгийн албадлагын арга хэмжээ, эрүүгийн эрх зүйн нөлөөллийн олон талт арга хэмжээний талаар бие биенээсээ тусгаарлагдсан байдал юм. Ийм хуваагдал нь тухайн байгууллагын нийгэм, эрх зүйн шинж чанарыг зөрчиж байдаг. Тиймээс түүний агуулга нь толилуулж буй үзэл бодлын дагуу эрүүгийн хариуцлагыг хэрэгжүүлэх явцад "гэмт хэрэгтэн" болон өөр арга хэмжээ хэрэглэх явцад сэтгэцийн эмгэгтэй хүмүүст тохиолдсон өөр өөр хомсдол, хязгаарлалт байх болно.

3) Эрүүгийн шийтгэл оногдуулахдаа гэмт хэргийн шинж чанар, нийгмийн аюулын зэрэг, гэмт этгээдийн хувийн шинж чанар, ялыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал, ял оногдуулсан ялын шийтгэл нь ялтныг засч залруулах, түүний гэр бүлийн амьдралын нөхцөл байдалд үзүүлэх нөлөө (ОХУ-ын Эрүүгийн хуулийн 60 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт) шууд харгалзан үзнэ. Үүнтэй адил эмнэлгийн албадлагын арга хэмжээ жагсаасан нөхцөл байдлын дийлэнх нь хууль эрх зүйн ач холбогдолгүй тул эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ нь зөвхөн сэтгэцийн эмгэгтэй хүмүүст хамаарах бөгөөд албадан эмчлэх хэлбэр нөхцөл нь зөвхөн эрүүгийн

хуулиар хориглосон үйлдэл хийсэн хүний сэтгэцийн эмгэгийн зэрэг, эрүүл мэндийн байдлаас хамаарна.

Байгууллагын төлөөлөл эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ. Эрүүгийн хуульд заасан, гэм буруутайд тооцсон шийтгэх тогтоол, шийдвэрийн үндсэн дээр шүүхээс тогтоосон төрийн албадлагын арга хэмжээ нь маргаантай бөгөөд нэмэлт үндэслэл шаардлагатай байдаг. Үнэн хэрэгтээ авч үзэж буй тодорхойлолт нь одоогийн эрүүгийн хууль тогтоомжийн заалтуудтай албан ёсоор нийцэж байгаа боловч тухайн байгууллагын жинхэнэ мөн чанарыг илчлэхгүй, тодорхойлохгүй байна. Үүний үр дүнд нийгэм, эрх зүйн ба эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний тухай асуулт нээлттэй хэвээр байна.

Эмнэлгийн шинж чанартай албадлагын арга хэмжээний мөн чанарыг аюулгүй байдлын арга хэмжээ гэж үнэлэх нь нэлээд маргаантай бөгөөд шинжлэх ухааны тусгай судалгаанд олон удаа анхаарал хандуулж ирсэн.

Нэгдүгээрт, ОХУ-ын Эрүүгийн хуульд хууль тогтоогч "Аюулгүй байдлын арга хэмжээ" гэсэн ангиллыг тогтоохоос санаатайгаар татгалзсан боловч ийм тодорхойлолтыг зөвлөлтийн эрүүгийн хуулийн эх сурвалжид тодорхой байсан. Одоогийн байдлаар төрийн албадлагын арга хэмжээний ангиллыг ашиглаж байна. Эдгээр нэр томьёо нь ижил биш, учир нь эхнийх нь аюулын эх үүсвэрт чиглэгддэг бөгөөд сүүлийнх нь эрх, эрх чөлөөг хязгаарлах гэсэн үг юм.

Хоёрдугаарт, "Аюулгүй байдал" гэдэг нь хувь хүн, нийгэм, улсын амин чухал ашиг сонирхлыг дотоод болон гадаад аюулаас хамгаалах байдал юм. Үүний үндсэн дээр эрүүгийн хуулиар хориглосон үйлдэл хийсэн ч сэтгэцийн өвчтэй хүмүүст үзүүлэх нөлөөллийн арга хэмжээ болгон бууруулах нь бараг боломжгүй юм. Ийнхүү бодит байдал дээр эрүүгийн хуулийн шинж чанартай бусад арга хэмжээг өөрөөр хэлбэл шийтгэл, эрүүгийн хариуцлага биш, харин эрүүгийн хуулийн хүрээнд хэрэглэгдэх арга хэмжээг "аюулгүй байдал" гэсэн үгээр сольж байна.

Үүнээс үндэслэн эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ нь эрүүгийн хариуцлагаас ангид, эрүүгийн шинж чанартай бусад арга хэмжээ гэж үздэг хэсэг эрдэмтдийн санал нэгдэж байна. Р.И.Михеевийн тэмдэглэснээр сэтгэцийн эмгэгтэй хүний зан төлөв нь түүний гадаад орчин, нийгэмд аюултай үйлдэл хийх явцад үүссэн нөхцөл байдлаас бус харин түүний эмзэг субъектив тайлбараар тодорхойлогддог. [7, х. 45].

Эрүүгийн хариуцлага нь зөвхөн гэмт хэрэг үйлдсэн, албадлагын арга хэмжээ хэрэглэсний үр дүнд үйлдсэн үйлсийнхээ тайланг эрх бүхий байгууллагын биеэр төрд өгөх чадвартай, сөрөг үр дагаварт өртсөн этгээдэд хамаарна. Сэтгэцийн эмгэгтэй хүн эдгээр хэд хэдэн үүргийг гүйцэтгэж чадахгүй.

Энэ тохиолдолд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг шийтгэлээс

үл хамааран авч үзэх ёстой зэрэг хэрэгжилтийг тусад нь хангана гэж үзэж байна. Шүүхээс тогтоосон хугацаа өнгөрсний дараа ялын зорилгодоо хүрэх нь эрүүгийн хуулиар хориглосон үйлдэл хийсэн этгээд эдгэрч, сэтгэцийн байдал сайжирсан гэсэн үг биш юм. Мөн хүрээлэнгийн зорилгыг хэрэгжүүлэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ эрүүгийн шийтгэлийн зориулалтын дагуу тодорхойлогдоогүй. Хүний сэтгэцийн эмгэгийг арилгах нь зөвхөн хэрэглээг зогсоох нөхцөл байж болно.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг эрүүгийн шийтгэлийн хамт ногдуулах, эсхүл ялыг гүйцэтгэх (үйлчлэх) явцад эрүүгийн хуулийн нөлөөллийн гэж үзэж буй арга хэмжээний нийгэм, эрх зүйн шинж чанар нь үндсэндээ өөрчлөгддөггүй. Зарим судлаачдын тэмдэглэснээр, оюун ухааныг үгүйсгэдэггүй сэтгэцийн өвчтэй бол гадаад ертөнцтэй харилцах харилцаа нь хадгалагдан үлддэг боловч тодорхой гажуудалтай байдаг. Тиймээс, хэлэлцэж буй хүмүүсийн ангилал нь объектив шалтгааны улмаас шинж чанараасаа шалтгаалан нөхцөл байдал, түүний дотор зөрчилдөөнийг эсэргүүцэх чадваргүй; нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн, нийгэмд ашигтай хувь хүний шинж чанарыг хөгжүүлэхэд саад бэрхшээл байгаа тул гадаад орчинд дасан зохицох. Дүрмээр бол "хязгаарлагдмал эрүүл ухаантай" хүн өөрийн эрхгүй, санамсаргүй, хууль бус, хамааралтай үйлдэл хийх хандлагатай байдаг.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ, эрүүгийн хэргийг ерөнхий журмын дагуу урьдчилсан мөрдөн байцаалтад илгээх, шүүхээс оногдуулсан ялын гүйцэтгэлийг үргэлжлүүлэх (ОХУ-ын Эрүүгийн хуулийн 103-р зүйл). А.Д.Кононов хэлж байгаагаар зөв эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ ял эдэлж байх хугацаандаа болон эдлүүлсний дараа аль алиныг нь авч үзэх ёстой [6, х. 26].

Эрүүгийн хариуцлага нь зөвхөн гэмт хэрэг үйлдсэн, төрийн албадлагын арга хэмжээ хэрэглэсний үр дүнд үйлдсэн үйлсийнхээ тайланг эрх бүхий байгууллагын биеэр төрд өгөх чадвартай, сөрөг үр дагаварт өртсөн этгээдэд хамаарна.

Е.В.Илюкийн байр суурийг бас шударга гэж үзэж байна: эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний шийтгэлийн зэрэгцээ гэм буруугийн зарчмаас бус харин нийгэм, ард түмэн, сэтгэцийн эмгэгтэй хүний аюулгүй байдлыг хангах зорилгоос үүдэлтэй. Дүрмээр бол эдгээр хүмүүс өөрсдийн үйлдлийнхээ нийгмийн аюулыг бүрэн ухамсарлаагүй, үйлдлээ хянах чадваргүй, эсвэл нийгмийн аюул, аюултай үр дагаврыг бүрэн ойлгодоггүй байна [5, х. 586].

Тиймээс дотоодын эрүүгийн хууль тогтоомж, тусгай ном зохиолд дүн шинжилгээ хийх нь мөн чанартай холбоотой асуудлуудыг дүгнэх боломжийг бидэнд олгодог. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ тэдний зорилго,

зорилт, нийгэм-эрх зүйн шинж чанар, эрүүгийн эрх зүйн нөлөөллийн арга хэмжээний ерөнхий бүтцэд эзлэх байр суурь нь дотоодын эрүүгийн эрх зүйн орчин үеийн сургаалд улам бүр нэмэгдэж байна.

Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжид тогтоогдсон хэд хэдэн асуудлыг шийдвэрлэх шаардлага анхаарлыг татаад байгаа юм. Монгол Улсын Эрүүгийн хуулийн хэм хэмжээний шинжилгээ, зохицуулалт эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ гэрчилж байна:

- Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээнд албан ёсны тодорхойлолт байхгүй, энэ нь эрүүгийн эрх зүйн онол болон хууль сахиулах ажиллагааны аль алинд нь авч үзэж буй байгууллагыг ойлгоход хэцүү болгодог;

- Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ зөрчилтэй мөн чанар болон үүнтэй холбогдуулан тэдний нийгэм, эрх зүйн мөн чанарыг хоёрдмол утгаар хүлээн зөвшөөрдөг;

- Хууль тогтоох арга техник, тухайлбал албадлагын арга хэмжээний тухай хэсэгт хэм хэмжээний материалыг танилцуулах журмыг зөрчсөн (Монгол Улсын Эрүүгийн хуулийн 7.2 дугаар зүйл) [12, х. 32];

- Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хүрээлэнгийн дотоод зөрчил (Монгол Улсын Эрүүгийн хуулийн 7.4-р зүйл) [12, х. 33].

Эдгээр асуудал тус бүрийг нарийвчлан авч үзье.

Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжид Эрүүгийн хуулийн тусгай ангид (Монгол Улсын Эрүүгийн хуулийн 2.1-т) заасан гэм буруутай, нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэж хүлээн зөвшөөрсөн байдаг. Эрүүгийн хуулийн сургаалд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөний дагуу сэтгэцийн эмгэгтэй хүн объектив шалтгаанаар өөрийн үйлдэл, эс үйлдлийнхээ хууль бус байдлыг ухамсарлах чадваргүй байдаг тул энэ үйлдлийг гэмт хэрэг гэж нэрлэхэд хэцүү байдаг.

Монгол Улсад эрүүгийн хариуцлагын зорилго нь ял оногдуулах, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, учирсан хохирлыг барагдуулах, шинээр гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, түүнчлэн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэх (Эрүүгийн хуулийн 5.1-р зүйл)-д ингэж үзэх нь логик юм. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ бусад эцсийн үр дүнг яллах, түүний дотор нийгэмд аюултай үйлдэл хийсэн хүнийг эдгээх, түүний сэтгэцийн байдлыг сайжруулах зэрэг нь эрүүгийн хариуцлагын материаллаг илэрхийлэл биш юм. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 5.1-д эрүүгийн хариуцлага нь ял, албадлагын арга хэмжээнээс бүрдэнэ. Сүүлд нь ял оногдуулахгүйгээр (тэнсэн) болон түүнтэй хамт хэрэглэсэн арга хэмжээ (үүрэг ногдуулах, эрхийг хязгаарлах хэлбэрийн албадлагын арга хэмжээнд; Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ; Эд хөрөнгийг хураах хэлбэрийн албадлагын арга хэмжээ) (7.2-р зүйл)

Монгол Улсын Эрүүгийн хуулийн). Үүний зэрэгцээ гэмт хэрэг үйлдэх үедээ эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрсэн, эрүүл саруул байвал эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ (Монгол Улсын Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг).

Тиймээс эрүүгийн хариуцлагын агуулгыг тодорхойлсон норматив эрх зүйн актын хэм хэмжээний дүн шинжилгээ нь зөрчилдөөнтэй шинж чанарыг харуулж байна. Энэ нь нэг талаас эрүүгийн хариуцлагаас өөр, өөрийн гэсэн зорилго, зорилт, хэрэглэх үндэслэлтэй төрийн албадлагын арга хэмжээ юм. Гэмт хэрэг үйлдсэн сэтгэцийн эрүүл бус хүнтэй холбоотой урьдчилан сэргийлэх зорилгоор. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ, эрүүгийн хуулийн нөлөөллийн бусад арга хэмжээ нь хууль эрх зүйн агуулгын өөр нөхцөлд (тэнцэл, эрүүгийн хариуцлага, эрхийг хязгаарлах, эд хөрөнгийг хураах) нь эрүүгийн хариуцлагыг хэрэгжүүлэх бие даасан хэлбэр бөгөөд шийтгэл, нөхөн төлбөр, нөхөн олговор олгох зорилготой юм.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хоёрдмол үзэл нь тухайн байгууллагын дотоод зөрчилдөөнөөс үүдэлтэй юм шиг санагддаг. Иймхүү Монгол Улсын эрүүгийн хуулийн дагуу эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ Эрүүгийн хуулиар хориглосон үйлдэл хийсэн этгээдэд дараахь байдлаар томилогдоно.

- Өөрийн ухаангүйгээр тухайн цаг хугацаанд болон өнгөрсөн цаг хугацаанд үйлдэгдсэн үйлдэл;
- Архи, мансууруулах бодисын донтолтоос болж зовж шаналах.

Эхний тохиолдолд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ эрүүгийн хариуцлагаас тусгаарласан төрийн албадлагын арга хэмжээ юм.

Нэгдүгээрт, эрүүгийн хариуцлагын сэдвийн орчин үеийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн (түүний дотор хууль тогтоомжийн түвшинд) онолыг харгалзан сэтгэцийн эмгэгтэй хүмүүст эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь хүлээн зөвшөөрөгдөхгүй гэдгийг батлах нь аксиономик юм.

Хоёрдугаарт, хуулийн актын заалтын дагуу шүүхээс албадан эмчилгээнд хамруулах явцад солиорлыг арилгахдаа эмнэлгийн албадлагын арга хэмжээ хүчингүй болгож, тухайн хүнд ерөнхий үндэслэлээр эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр /Монгол Улсын Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх хэсэг/. Энэ баримт нь авч үзэж буй арга хэмжээний бие даасан байдал, өвөрмөц байдлыг дахин нотолж байна, учир нь тэдгээрийг хэрэгжүүлэх нь шийтгэл, эрүүгийн хариуцлагаас тусгаарлагдсан зэрэгцэн явагддаг.

Гуравдугаарт, эмнэлгийн албадлагын арга хэмжээ томилохдоо “сэтгэцийн өвчтэй” хүнд холбогдох эрүүгийн ялын хамт, эсхүл ялыг гүйцэтгэх (бие биелэх) явцад /Монгол Улсын Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг/, түүний

нийгэм, эрх зүйн шинж. Эрүүгийн хуулийн хэмжүүр нь бидний өмнө дурдсан шалтгааны улмаас үндсэндээ өөрчлөгдөхгүй.

Хоёр дахь тохиолдолд, эмнэлгийн албадлагын арга хэмжээ, хууль тогтоогчийн үүднээс эрүүгийн хариуцлагын хэрэгжилтийн нэг хэлбэр юм. Иймд гэмт хэрэг үйлдсэн, архи, мансууруулах бодис донтсон хүнд Монгол Улсын Эрүүгийн хуулийн дагуу оногдуулсан эрүүл мэндийн арга хэмжээ нь нэмэлт ял юм (Хуулийн 6.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг) Монгол Улсын Эрүүгийн хууль), энэ нь шийтгэлийг тодорхойлох болон эмнэлгийн албадлагын арга хэмжээ юм.

Дээр дурдсан зүйл нь албадлагын арга хэмжээний төрлийг зохицуулах хэм хэмжээг бүрдүүлэхэд хууль тогтоомж, техникийн холбогдох дүрмийг зөрчсөн мөн байгууллагын дотоод зөрчилдөөнийг гэрчилж байна.

Юуны өмнө эмнэлгийн албадлагын арга хэмжээ нийгэм, эрх зүйн зорилгыг илэрхийлсэн объектив шалтгаанаар эрүүгийн хариуцлага хүлээхгүй хүмүүст хамаарна. Эсрэг заалтыг хүлээн зөвшөөрөх, өөрөөр хэлбэл эрүүгийн хариуцлагын хүрээнд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх нь үнэндээ нийгэм, эрх зүйн мөн чанарыг зөрчсөн явдал юм. Энэ тохиолдолд шийтгэлийн хоорондох шугам ба эмнэлгийн албадлагын арга хэмжээ. Түүгээр ч барахгүй сүүлийнх нь үндсэн шийтгэлээс гадна хэрэглэх шийтгэл болж хувирдаг нь үзэл баримтлалын үүднээс үндсээрээ буруу юм.

Энэ байдлаас гарах гарц бол архи, хар тамхинд донтсон хүмүүст чиглэсэн арга хэмжээг өөрчлөх, шинэчлэх явдал гэж үзэж байна. Ялангуяа энэ арга хэмжээг биш гэж тодорхойлох шаардлагатай эмнэлгийн албадлагын арга хэмжээ, шийтгэлийн хамт гүйцэтгэж болох боловч эрүүгийн биш, харин ял эдлэх хуулийн хүрээнд шийтгэлтэй холбоотой нэмэлт (дагалдах) үүрэг. Тиймээс, оногдуулсан ялыг гүйцэтгэх журамд тодорхой өвчтэй хүмүүст хэрэглэх ялын арга хэмжээг багтаасан байх ёстой.

Мэдээжийн хэрэг, санал болгож буй үүрэг бол албадлага, гэхдээ албадлага бөгөөд энэ нь ялыг гүйцэтгэх дэглэмийн хүрээнд хийгддэг. Эрүүгийн хуульд эрүүгийн эрх зүйн нөлөөллийн арга хэмжээг тэдгээрийн мөн чанарт үндэслэн тодорхой системчилсэн байх ёстой.

- Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай, түүний дотор архи, мансууруулах бодис донтсон хүмүүст эрүүгийн хариуцлага хүлээлгэх арга хэмжээ;

- Хууль тогтоомжид заасан шалтгаанаар эрүүгийн хариуцлага хүлээх чадваргүй хүнд оногдуулсан эрүүгийн эрх зүйн шинж чанартай бусад арга хэмжээ (албадах арга хэмжээ), үүнд мэдээжийн хэрэг Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ орно.

Уран зохиол

1. Васеловская, А. V. ОХУ-ын Эрүүгийн хуулийн дагуу хэвтэн эмчлүүлэх нөхцөлд сэтгэцийн эмчилгээ хийдэг эмнэлгийн байгууллагад албадан эмчилгээ хийх: хууль зүйн шинжлэх ухааны нэр дэвшигчийн зэрэг олгох диссертацийн хураангуй / А. V. Васеловская. - Томск, 2020. - 12 х. - Текст: шууд.

2. Иргэний болон эрүүгийн хэргийн хууль зүйн туслалцаа, эрх зүйн харилцааны тухай Оросын Холбооны Улс, Монгол Улс хоорондын хэлэлцээр (2002 оны 9-р сарын 12-ны өдрийн нэмэлт өөрчлөлт).

3. Дубинин, Н.П., Карпец И.И., Кудрявцев В.Н. Генетик, зан үйл, хариуцлага: нийгэмд харш үйлдлүүдийн мөн чанар, түүнээс урьдчилан сэргийлэх арга замын тухай. - Москва: Политиздат, 1982. - 304 х.

4. Ефремова, I. А. Эмнэлгийн албадлагын арга хэмжээний тухай ойлголт ба шинж тэмдэг / I. А. Ефремова. - Текст: шууд // Баруун өмнөд мужийн их сургуулийн эмхэтгэл. Цуврал: түүх ба хууль. - 2021. - No 4. - S. 53-62.

5. Илюк, Е. В. Аюулгүй байдлын арга хэмжээ болох эмнэлгийн албадлагын арга хэмжээ - Текст: шууд // Эрүүгийн эрх зүй: XXI зууны хөгжлийн стратеги: Олон улсын шинжлэх ухаан, практикийн XVII бага хурлын материал. - Москва, 2020. - S. 583-589.

6. Кононов, А. D. Сэтгэцийн эмгэгтэй хүмүүст эрүүгийн хариуцлага хүлээлгэх тулгамдсан асуудал, эдгээр хүмүүст эмнэлгийн шинж чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх нь: Хууль зүйн шинжлэх ухааны нэр дэвшигчийн зэрэг олгох диссертацийн хураангуй / А. D. Кононов . - Москва, 2019. - 31 х. - Текст: шууд.

7. Михеев, Р.И. Галзуу. Нийгэм-эрх зүйн эссе / R. I. Михеев. - Владивосток: Алс Дорнодын их сургуулийн хэвлэлийн газар, 1992. - 286 х. - Текст: шууд.

8. Аюулгүй байдлын тухай: 2010 оны 12-р сарын 28-ны өдрийн 390-ФЗ-ийн холбооны хууль. - Текст: шууд // Российская газета. - 2010. - 12-р сарын 29.

9. Шүүхээс эмнэлгийн албадлагын арга хэмжээ хэрэглэх практикийн талаар: ОХУ-ын Дээд шүүхийн 2011 оны 4-р сарын 7-ны өдрийн 6-р хурлын тогтоол. - Текст: шууд // Российская газета. - 2011.

10. Савин, А. А. Эрүүгийн хуулийн нөлөөллийн арга хэмжээний тогтолцоонд эмнэлгийн шинж чанартай албадлагын арга хэмжээ / А. А. Савин. - Текст: шууд // ОХУ-ын Мөрдөн байцаах хорооны академийн мэдээллийн товхимол. - 2020. - No 1. - S. 181-184.

11. Скрипченко, Н.Ю. Эрүүгийн хуулийн шинж чанартай бусад арга хэмжээний тухай ойлголт, төрлүүд / Н.Ю.Скрипченко. - Текст: шууд // Хүрээлэнгийн мэдээллийн товхимол: гэмт хэрэг, шийтгэл, залруулга. - 2011. - No 2. - S. 16-21.

12. Монгол Улсын Эрүүгийн хууль

13. Якушин, В.А. Шийтгэл ба эрүүгийн хуулийн нөлөөллийн бусад арга хэмжээ: монографи / В.А. Якушин. - Тольятти: хэвлэлийн газар, 2018 - 337 х. - Текст: шууд.

---o0o---

ХОРИГДЛЫГ ГЭР БҮЛД НЬ ТУЛГУУРЛАН НИЙГЭМШҮҮЛЭХ АЖЛЫН АЧ ХОЛБОГДОЛ

THE IMPORTANCE OF SOCIALIZATION OF PRISONERS TO FAMILIES



Г.Төмөрбаатар
Дотоод хэргийн их сургуулийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
магистрант, хошууч

Товч утга: Хураангуй: 2015 оны Эрүүгийн хуульд “Эрүүгийн хариуцлагын зорилго нь ...гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино” хэмээн заасан нь хоригдлыг нийгэмшүүлэх ажлын ач холбогдлыг хуульчилж өгсөн хамгийн дэвшилтэт алхам болсон. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд “Хорих ял эдэлж байгаа ялтныг хоригдол гэнэ” хэмээн заасан. Хоригдол хүн хэдийгээр гэр бүлээсээ тусгаарлагдан, гэр бүлийн гишүүдээсээ хол, тодорхой эрхүүдээ хязгаарлуулж хорих ял эдэлж байгаа хэдий ч гэр бүлийн гишүүн хэвээрээ л байдаг. Хүн заавал орон гэртээ, хашаа байшиндаа, эсвэл орон сууцандаа гэр бүлийн гишүүдтэйгээ нэг дор, хамт амьдарч байж л гэр бүлдээ харьяалагдана гэсэн үг биш. Хоригдлыг нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулахдаа тэрхүү “гэр бүл” хэмээх үнэт зүйлтэй нь хамтад нь судалж, үйлчилгээ үзүүлэх нь нэн чухал билээ. Хоригдлыг гэр бүлд нь тулгуурлан нийгэмшүүлэх ажлын ач холбогдлыг судалснаар хорих байгууллагын ажилтнууд хоригдлыг нийгэмшүүлэх ажил, үйлчилгээг зохион байгуулахдаа тэдний гэр бүлийн үзэл баримтлал, үнэт зүйлсэд нь тулгуурлан үйлчилгээ үзүүлж, нийгэмшүүлэх ажлын бодит үр дүнд хүрээсэй гэсэн итгэл найдварыг тээж энэхүү илтгэлийг бичлээ.

Түлхүүр үгс: Нийгэмшүүлэх ажил, гэр бүлийн тухай ойлголт.

Abstract: In the Criminal Code, "The purpose of criminal liability is is to socialize the person who committed the crime It was the most progressive step that legitimized the importance of prisoner socialization The Law on Execution of Court Decision states that "Prisoner is a convict who is serving a prison sentence" stated. A prisoner is still a member of the family, even though he is separated from his family, away from family members, and serving a prison sentence with certain rights restricted It does not mean that a person belongs to a family only if he lives together with his family members in a house, a house, or an apartment. When organizing the socialization of

prisoners, it is very important to study and provide services together with the value of the "family".

Keywords: Concept of social work and family

Гэр бүлийн тухай ойлголт, системийн онолын үзэл баримтлал

Гэр бүл гэж хамтдаа амьдардаг, бие биетэйгээ ямар нэгэн холбоотой (цусан холбоотой, гэрлэсэн г.м.) бүлэг хүмүүс буюу амьтдыг (зарим амьтад нь үр төлөө асарч гэр бүлтэй төсөөтэй зүйлийг бүрдүүлдэг) хэлнэ. Гэр бүлийн анхдагч үүрэг нь үр удмаа нөхөж үйлдвэрлэх, өсгөж хүмүүжүүлэх явдал юм.

Гэрлэлт болон үрчлэлтэд суурилсан, хүмүүсийн харилцааг гэр бүл гэнэ. Гэр бүл нь нийгмийн бичил хэлбэр мөн. Гэр бүлийн зохион байгуулалт буюу гэр бүлийн тогтолцоог чулуун зэвсгийн үеэс үүсэлтэй гэж үздэг бөгөөд үүнээс өмнө гэр бүл болох явдал замбараагүй байснаас цус ойртолт элбэг байжээ.[109]

Эдгээрээс үзэхэд гэр бүл хэмээх ойлголт нь 2-оос дээш хүний бүрэлдэхүүнтэй, хоорондын хамааралт харилцаа бүхий нийгмийн бичил бүлгийн шинжийг агуулсан байна.

Монгол улсын Гэр бүлийн тухай хуульд “гэр бүл гэж гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг” ойлгох талаар, “Гэр бүл нь нийгмийн үндсэн нэгж мөн” хэмээн тус тус тунхагласан.[110]

Манай улсад гэр бүлийн систем хамгийн сонгодог утгаар хөгжсөн гэж үзэж болно. Учир юу гэвэл Монгол хүн гэр бүлсэг /гэрсэг/ шинж чанартай төдийгүй хамаатан садан, цусан төрлийн харилцаа холбоо болон нэг хонхор, дов жалганы үзэл /ярианы хэллэг/-ийг эрхэмлэдэг. Мөн өргөжсөн гэр бүлийн шинжийг хамгийн сонгодог утгаар нь хөгжүүлсэн. Өөрөөр хэлбэл нэг гэр бүлд эцэг эх, хүүхдүүд, тэдний ач зээ, эсвэл өвөө эмээ нь нэг дор, нэг ам бүл болж амьдрах тохиолдол түгээмэл байдаг. Тиймээс Монгол хүнийг нийгэмшүүлэх, гэмт санаа бодлоос нь татгалзуулахын тулд “гэр бүл” хэмээх тэрхүү “үнэт зүйл”-д нь тулгуурлан, тэдний дэмжлэг туслалцааг авч хамтран ажиллах нь нэн чухал.

Тэгвэл систем гэж юу вэ? Систем гэдэг нь нэгтгэх, нэг дор байрлуулах, хамтад нь авч үзэх, өөр хоорондоо уялдаа холбоо бүхий нэгж хэсгүүдийн нийлбэр цогц гэсэн утга бүхий “systema” гэсэн грек үгнээс гаралтай. Энэ үгийг тайлбар толь бичгүүдэд дараах байдлаар тайлбарласан байдаг. “Систем нь өөр хоорондоо харилцан холбоотой буюу харилцан хамааралтай нэгжүүдийн цуглуулга. Харин дэд систем гэдэг нь ямар нэгэн системийн хэсэг болж буй систем юм” хэмээн

[109] “Википедиа” чөлөөт нэвтэрхий толь. Цахим хаяг.
[110] Төрийн мэдээлэл эмхэтгэл // Гэр бүлийн тухай хууль.

тодорхойлсон байдаг “Нэгэн цогц байдлаар ажиллах зүйлс буюу хэсгүүдийн бүлэг” хэмээн тодорхойлжээ. Системүүдийг байгалийн болон хүний гараар бүтээгдсэн (загварчлагдсан) хэмээн хуваан үздэг. Хүний гараар бүтээгдсэн системүүд гол төлөв тодорхой зорилго, багц зорилтуудтай байдаг бол байгалийн системүүд тодорхой зорилгогүй хэрнээ харьцангуй тогтвортой, уян хатан бөгөөд үр ашигтай байдаг. Байгалийн төрөл бүрийн системүүд байдаг.

Систем гэсэн ойлголтыг хамгийн энгийнээр “Систем нь өөр хоорондоо харилцан холбоотой хэсгүүдийн олонлог” хэмээн тодорхойлсон байдаг. Систем бүр бие биенээсээ хамаарсан, уялдаа холбоотой элементүүдээс (дэд системүүдээс) тогтож, өөрийг нь хүрээлэн буй орчноос өгөгдөл мэдээлэл хүлээн авч, өөрийн төлөв байдлыг илэрхийлдэг. Системийг хүрээлж буй орчныг системийн орчин гэнэ. Аливаа систем нь орчинтойгоо байнга харилцан үйлчлэлцэж байдаг төдийгүй үйлчлэх орчноосоо хамааран байнга хувьсан өөрчлөгдөж байдаг. Систем нь том системийн бүрэлдэхүүн хэсэг байхаас гадна өөртөө дэд хэсгүүд буюу дэд системүүдийг агуулж болно.[111]

Гэр бүлийг нэгэн систем гэж үзвэл гэр бүлийн гишүүн /хоригдол/ нь тэрхүү системийг бүрдүүлэгч нэг хэсэг нь юм. Хоригдол ямар нэгэн байдлаар гэр бүлд харьяалагдаж байдаг тул гэр бүлийн бусад гишүүдтэйгээ гэр бүлийн харилцан хамаарлаар холбогдож бие биенээсээ шалтгаалж байдаг. “Систем нь өөр хоорондоо харилцан холбоотой хэсгүүдийн олонлог” хэмээх тодорхойлолтод анхаарлаа хандуулж, түүний мөн чанарыг сайтар тунгаан бодох нь чухал. Хоригдол хэдийгээр гэр бүлээсээ тусгаарлагдсан газарт тодорхой хугацаанд тусдаа байгаа хэдий ч суллагдан гарсны дараа эргээд л гэр бүлдээ ирэх төдийгүй тэнд байх хугацаандаа ч гэр бүлийн гишүүн хэвээр байдаг.

Хоригдлыг нийгэмшүүлэх ажлын тухай, ШШГТ хуульд зааснаар хоригдлын гэр бүлтэйгээ харьцах эрх зүйн боломжийн талаар

Хоригдлыг нийгэмшүүлэх ажлын талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд дараах байдлаар тусгасан. Үүнд:

218 дугаар зүйл. Нийгэмшүүлэх ажил

“Хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын хүрээнд хоригдол хорих ангид ял эдлэх бүхий л хугацааг хамарсан, хоригдолд нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ.”

“Хорих анги нь нийгэмшүүлэх ажлын мэргэшсэн нэгжтэй байх бөгөөд хоригдлыг хорих ангид хүлээн авмагц нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ

[111] Амарбаясгалан, Р. Онош. 2006

үзүүлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, түүнд үндэслэн нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө боловсруулж ажиллана.”

219 дүгээр зүйл. Нийгэмшүүлэх ажлын хэлбэр, зохион байгуулалт

“Хоригдлыг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон хүсэл, сонирхолд нь үндэслэн эрэг зан үйлд төлөвшүүлэх бусад хэлбэрээр нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулна.”

“Нийгэмшүүлэх ажилд хорих ангийн албаа хаагчаас гадна бусад байгууллага, иргэнийг оролцуулж болно.”

“Нийгэмшүүлэх ажлыг хоригдлын үйлдсэн гэмт хэргийн болон түүний хувийн байдал, нас, хүйс, ял эдлүүлэх нөхцөлийг харгалзан ганцаарчилсан, бүлгийн, эсхүл нийтэд чиглэсэн хэлбэрээр тусгай хөтөлбөр боловсруулж үе шаттай, ялгамжтай зохион байгуулна. Нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулахад хорих анги, албаа хаагч, бусад байгууллага, албан тушаалтнаас хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд туслалцаа авч болно.”

“Хоригдлыг нийгэмшүүлэх ажлыг ял эдлүүлэх ажиллагааг хөдөлмөр, сургалттай хослуулах, хоригдлын бүтээлч ажиллагаа, үр ашигтай санаачилгыг дэмжих, ёс зүй, сэтгэл зүйн нөлөөллийг хорих ангийн дэглэм, зэрэглэлийн онцлогийг харгалзан зохион байгуулна.”[6]

Хуулийн эдгээр зүйл заалтаас харахад хоригдлыг нийгэмшүүлэх ажилд албаа хаагч, бусад байгууллага, иргэнийг татан оролцуулж болох тухай заасан боловч түүний гэр бүлийг татан оролцуулах, гэр бүлийн үнэт зүйлд нь тулгуурлан нийгэмшүүлэх ажил, үйлчилгээг зохион байгуулж болох тухай тусгаагүй байна. Энэ нь хоригдлыг гэр бүлд нь тулгуурлан нийгэмшүүлэх ажлын судалгаа шинжилгээг сайтар хийж, ач холбогдлыг нь таниулан ойлгуулах ажил дутмаг байгаагийн нэг илрэл юм. Харин “хоригдол хорих ангид ял эдлэх бүхий л хугацааг хамарсан” хэмээн заасан явдал нь хоригдол ял эдэлж эхлэхээс авхуулаад л түүнийг суллагдан гарахад нь бэлтгэх шаардлагатайг харуулж байна.

Хоригдлыг гэр бүлийн гишүүдтэй нь уулзуулах, тэднийг гэр бүлтэй нь харилцаа холбоотой байлгах талаар дараах байдлаар тусгасан. Үүнд: Хоригдлын хорих ял эдлэх дэглэм, зэрэглэлээс хамаарч уулзалт хийх, утсаар ярих, илгээмж, захидлаар харилцах хугацааг ялгамжтай байдлаар зохион байгуулсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 198 дугаар зүйл: Нээлттэй хорих анги

“Нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол 30 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж болох бөгөөд түр хугацааны уулзалт хийх, захидал илгээх, илгээмж авах, утсаар ярих тоог хязгаарлахгүй.”

“Нээлттэй хорих ангийн тусгай зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол 7 хоногт нэг удаа түр, 45 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 7 хоногт нэг удаа илгээмж авч, нэг удаа утсаар ярьж болох бөгөөд захидал илгээх тоог хязгаарлахгүй.”

Хуулийн 199 дүгээр зүйл: Хаалттай хорих анги

“Хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол нь 60 хоногт нэг удаа түр, 90 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 30 хоногт нэг удаа илгээмж авч, нэг удаа утсаар ярьж болно.”

“Хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол 90 хоногт нэг удаа түр, 120 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 60 хоногт нэг удаа илгээмж авч, нэг удаа утсаар ярьж болно.”[7]

Түр ба удаан хугацааны уулзалт авах нь хоригдлуудын гэр бүлтэйгээ хамт байх хамгийн том боломж юм. Хорих ялын дэглэм, зэрэглэлээс хамаарч хоорондын хугацаа нь харилцан адилгүй байдаг бөгөөд энэ нь тэдний сэтгэл зүйд маш их нөлөөллийг бий болгодог. Гэр бүлээс нь эргэлт уулзалт тогтмол ирдэг хоригдлуудын хувьд хуульд заасан дээрх хугацаанд уулзалт хийх нь тэдний сэтгэл зүйд сайнаар нөлөөлж нийгэмшил, төлөвшилд нь эерэг нөлөөллийг бий болгодог. Нийгмийн ажилтан “Хоригдлыг нийгэмшүүлэх ажлын төлөвлөгөө”-дөө тэдний гэр бүлийн гишүүдтэй хамтарч ажиллах тухай хэсгийг заавал тусгаж, эргэлт уулзалтаар ирсэн үед нь гэр бүлийн гишүүдтэй нь уулзалт зохион байгуулж байх нь чухал.

Утсаар ярих, илгээмж авах, захидлаар харилцах зэрэг нь хоригдлын гэр бүлтэйгээ харилцах хуулиар олгогдсон үндсэн эрхүүдийн нэг бөгөөд холбогдох хууль, журамд заасан хугацаанд харилцаа холбоо тогтоож, эрхээ эдлэх нь тэдэнд сэтгэл санааны тайвшрал авах боломжийг олгодог. Хорих анги хоригдлын эдгээр эрхүүдийг хязгаарласан ямар ч үйлдлийг таслан зогсоож, нөхцөл боломжоор хангах нь маш чухал.

ШШГЕГ-ын даргын тушаалаар “Цахим уулзалт зохион байгуулах журам”-ыг баталж, хэрэгжилтийг хангаж эхэлсэн нь гэр бүлээсээ хол ял эдэлж буй, уулзалтаар ирэх боломжгүй хоригдлуудын нийгэмшилд эерэгээр нөлөөлсөн маш дэвшилтэт алхам болсон.

Гэр бүлийн харилцаа хоригдлын нийгэмших үйл явцад хэрхэн нөлөөлдөг талаар

Судалгаанаас үзэхэд давтан гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын 80% нь ямар нэгэн байдлаар гэр бүлийн харилцаа холбоо сул, гэр бүлийн гишүүдтэйгээ таарамжгүй харилцаатай эсвэл огт гэр бүлийн харилцаагүй байдаг байна. Тэднийг олон удаа, дахин давтан гэмт хэрэг үйлдэх тусам нь гэр бүлийн гишүүд нь харилцаагаа хөндийрүүлж, таарамжгүй харьцаатай болж, улмаар харилцаагаа таслах хүртэл сөрөг үр дагаварт хүрдэг. Гэр бүлийн дэмжлэг туслалцаагүй хоригдол сэтгэл санааны хувьд тогтворгүй болж энэ байдал нь даамжирсаар дахин давтан гэмт хэрэг үйлдэх, ял эдлэх хугацаандаа зөрчилд холбогдох шалтгаан болно.

Харин эсрэгээрээ гэр бүлтэйгээ харилцаа сайтай, тогтмол уулзалт хийж илгээмж авч утсаар харилцдаг хоригдлуудын хувьд ял эдлэх хугацаандаа аль болох ажил хөдөлмөр, сургалт, нийгэмшүүлэх ажилд идэвхтэй оролцон шагналын хоногоор урамшуулагдаж богино хугацаанд гэр бүлдээ очихыг эрмэлзэнэ. Гэр бүл нь амьдралын боломж тааруухан, санхүүгийн дэмжлэг туслалцаа бага байлаа ч өөрөө цалинтай хөдөлмөр эрхэлж ахуйн хэрэгцээний зүйлсээ худалдан авах санхүүгийн эх үүсвэртэй байж “амиа борлуулах”-ыг л хичээдэг.

Улмаар зарим нь цалингаасаа хохирол төлбөрөө бүрэн барагдуулж, улмаар гэр бүлийн гишүүддээ холбогдох журмын хүрээнд мөнгө шилжүүлж амьдрал ахуйд нь дэмжлэг болох ч тохиолдол элбэг байдаг.

Зарим хоригдлуудын хувьд гэр бүлийн гишүүд нь /эцэг, эх, ах, эгч, дүү, төрөл садан/ хорих ял эдэлж байгаа /хамт эсвэл өөр хорих ангид/ тохиолдол бий. Харин тэдгээр хоригдлуудын гэр бүлийн харилцаа нь зарим тохиолдолд тэдний нийгэмшил, төлөвшилд сөргөөр нөлөөлөх хандлага ажиглагддаг. Тэд буруу, сөрөг зүйл дээр санаа нэгдэж, гэр бүлийн итгэлцэл, харилцаа холбоогоо сөргөөр ашиглан нийгэмд аюултай үйлдэл хийж болзошгүй төдийгүй заримдаа тийм бодит кейс ч тохиолддог.

Кейс-1.

Хоригдол Ч.Ц нь 3 удаагийн ял шийтгэлтэй бөгөөд хамгийн сүүлд 2009 онд танхайн гэмт хэрэгт шийтгэгдэн ял эдэлж байгаад 2017 онд тус ангиас суллагдсан. Тэрээр багаасаа өнчин өссөн, эцэг, эхээ мэдэхгүй бөгөөд асрамжийн газраар хүмүүжиж ирсэн. Удаа дараа танхайн гэмт хэрэгт шийтгэгдэж байсан тул Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдож Хорих 439 дүгээр “Онцгой” дэглэмтэй хорих ангид ял эдэлж байгаад тус ангид 2014 онд ирсэн. Түүнийг хариуцсан нийгмийн ажилтан түүний амьдарч байсан асрамжийн төвтэй холбогдож, хамаатан садныг нь судлан, олж харилцаа холбоо тогтоосны үндсэн дээр ойрын хамаатныг нь эргэлт уулзалтаар уулзуулж, “гэр бүл зохиож сайхан амьдрах” тухай ярилцсан байна. Улмаар түүнийг багын найзтай нь уулзуулан, зуучилж гэрлэлтийг нь батлуулан “гэр бүл”-тэй болгосон бөгөөд тэрээр хугацааны өмнө суллагдаж

одоогоор тогтсон ажилтай, эхнэр 2 хүүхдийн хамт сайн сайхан амьдарч байгаа билээ.

Дээрх тохиолдлоос үзэхэд хоригдлын ухамсарт “гэр бүл” хэмээх үнэ цэнэтэй ойлголтыг төлөвшүүлж, хүний ёсонд гэр бүлийн харилцаа хамгийн чухал болохыг ойлгуулан ухамсарлуулж чадвал тэр л жинхэнэ сайн нийгэмшил болдог нь харагдаж байна. Хүн нэгэнт л гэр бүлийн гишүүн болж нийгмийн харилцаанд оролцож амьдрах жамтай “Нийгмийн амьтан” тул гагцхүү тэр л ёсонд нь тулгуурлан нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулах нь хамгийн үр дүнтэй арга юм.

Гэр бүлийн харилцаагүй, эргэлт уулзалтгүй хоригдлыг нийгэмшүүлэх ажлын тухай

Хорих ял эдэлж буй гэр бүлийн харилцаа холбоо сул, эргэлт уулзалтгүй хоригдлыг нийгэмшүүлэх ажилд ихээхэн хүндрэл бэрхшээл тулгардаг. Тэд хорих ял эдлэх хугацаандаа төдийгүй суллагдан гарсны дараа нийгэмд дасан зохицож чадахгүй дахин давтан гэмт хэрэг үйлдэх тохиолдол түгээмэл тохиолддог. Зарим нь гэмт хэрэг үйлдэхэд хамтарч оролцсон этгээд /хам хэрэгтэн эсвэл гал хам/-ийг “гэр бүлийн гишүүн”-ээ болгож, суллагдан гарсны дараа хамт амьдрах тухай ч төлөвлөсөн байх нь бий. Эдгээр тохиолдолд хоригдлуудыг нийгэмд суллагдан гарахаас нь өмнө гэр бүлийн харилцаа, “амьдрал зохиох”-ын ач холбогдлыг ойлгуулах ухуулга, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгтэй. Тэдэнд хорих ял эдлэх хугацаанд нь ШШГТ хуульд заасан “эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон хүсэл, сонирхолд нь үндэслэн эрэг зан үйлд төлөвшүүлэх бусад хэлбэрээр нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулдаг” боловч гэр бүлийн үнэ цэнэтэй харилцааны ач холбогдлыг ойлгоогүй, суллагдан гарсны дараа гэр бүлийн нэг гишүүн болж амьдрах тухайгаа ухамсарлаагүй тохиолдолд нийгэмшүүлэх ажлын үр дүн нь хангалтгүй, хий дэмий зүйл болж хувирдаг. Учир нь тэрхүү хоригдол суллагдан гарсны дараа ямар нэгэн байдлаар “гэр бүл”-д харьяалагдаж, гэр бүлийн харилцаа үүсгэдэг бөгөөд энэ л арга техникт суралцаагүй тохиолдолд дахиад л нийгмийн хэм хэмжээг зөрчих “эрсдэл”-тэй нүүр тулдаг.

Гэр бүлийн харилцаагүй хоригдлын гэр бүлийн харилцааг эргэн сэргээх ажил зохион байгуулах нь хоригдлын нийгэмшилд маш эерэгээр нөлөөлдөг. Тухайлбал:

Кейс-2.

Хаалттай дэглэмийн хоригдол С.Ө нь 4 удаагийн ял шийтгэлтэй. 2007 оноос гэр бүлээсээ харилцаагаа хөндийрүүлж эцэг, эхтэйгээ 11 жил уулзалгүй хулгайн гэмт хэрэгт холбогдож явсаар иржээ. Энэ хугацаанд түүний эцэг нь нас барж, эх нь амьдралын боломж тааруу тул хүүгээ төдийлөн хайж, эрж уулзах

боломжгүй байлаа. 2018 онд хорих ангийн хүний нөөцийн ажилтан, нийгмийн ажилтан нар хамтран судалгаа хийж ажилласны үр дүнд хоригдол С.Ө-ийн эхийг Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг “Улиастай”-д амьдардаг талаар олж мэджээ. Тэд “Хүний эрхийн өдөр”-ийг тохиолдуулан түүний өндөр настай эхийн гэрт нь очиж, уулзан хүүтэйгээ уулзах талаар саналыг тавьж зөвшөөрүүлсэн байна. Ийнхүү ажилтнууд хорих ангиас унаагаар үйлчлэн, тодорхой хэмжээний санхүүжилтийг гаргаж эхийг нь хорих ангийн байршилд авч ирэн 11 жил уулзаагүй хүүтэй нь уулзуулах ажлыг зохион байгуулсан бөгөөд тэр гэр бүлийн халуун дотно харилцааг эргэн сэргээж, хүүг нь дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэлт байдлаас урьдчилан сэргийлж чадсан юм. Одоо эх, хүү 2 гэр бүлээрээ Улаанбаатар хотод сайн сайхан амьдарч байна.

Практикт хоригдлыг хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох асуудлыг шийдвэрлэхдээ тухайн хоригдлыг суллагдан гарсны дараа оршин суух хаяг, газрын тодорхойлолт, хүлээж авах гэр бүлийн гишүүд, тэдний утасны дугаар, ажлын газрын тодорхойлолт /аж ахуйн нэгж, байгууллагын албан ёсны баталгаа бүхий/ зэргийг ар гэрээс нь хүлээн авч, баталгаа гаргуулсны дараа шүүхээр хэлэлцүүлэн шийдвэрлэдэг. Энэ нь хоригдол суллагдан гарсны дараа тухайн хоригдол ямар нэгэн байдлаар нийгмийн хэм хэмжээг зөрчих, дахин давтан гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлсэн эерэг арга хэмжээ билээ. Гэтэл гэр бүлийн харилцаагүй, эргэлт уулзалтгүй хоригдлуудын хувьд хугацаанаас өмнө суллагдаж, хяналт тогтоох эрх нь дээрх шаардлагаас болж хаагдмал байдалд ордог. Зөвхөн хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох асуудалд гэр бүлийн байдлыг нь анхаарч үзэх бус хоригдлын хорих ялын дэглэм, зэрэглэлийг хөнгөрүүлэх, хоригдлыг хорих ангийн байршлаас гадуур хөдөлмөр эрхлүүлэх асуудалд ч үүнийг анхаарч ажиллах нь чухал.

АНУ-ын туршлагаас үзэхэд хоригдлуудын үйлдсэн гэмт хэргийн шинж байдал, нийгмийн хор аюул, хувь хүний нийгэмшил, төлөвшил, гэр бүлийн харилцаа холбооноос нь хамаарч тэднийг Halfway House буюу түр байрлуулах төвүүдэд хуваарилан аль болох нийгэмд ойр байлгаж ажил хөдөлмөр эрхлүүлэн, сэтгэл зүйн үйлчилгээнүүдэд хамруулдаг. Тухайн төвдөө хоригдол дунджаар 18 сарын хугацаанд байрлах бөгөөд тэндээ ажил хөдөлмөр эрхэлж, цалингаасаа хуримтлал үүсгэдэг төдийгүй тодорхой хугацаанд гэр бүлдээ очиж харилцаа холбоогоо сайжруулах боломжтой талаар хуульчилж өгсөн. Хоригдол энэ төвөөс мөн л хугацааны өмнө суллагдах боломжтой бөгөөд уг асуудлыг авч хэлэлцүүлэхдээ харьяа орон нутгаас нь томилогдсон комисс, шаардлагатай тохиолдолд гэр бүлийн гишүүнийг нь ч оролцуулан шийдвэрлэдэг. Энэ нь хоригдлыг суллагдан гарсны дараа дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх баталгаагаар хангасан чухал ач холбогдолтой тогтолцоо юм.

Дээрх төвөөс хоригдол суллагдан гарсны дараа тодорхой хугацаанд гэрээр нь хяналт тогтоож 1 жил тутам хаягийн бүртгэлээ баталгаажуулж байх, тодорхой газар нутагт зорчих эрхийг хязгаарлан GPS бугуйвч ашиглан байршлыг хянах тогтолцоо ч байдаг байна. Манай улсын хувьд гэр бүлийн харилцаагүй, дэмжлэг туслалцаагүй, эргэлт уулзалтгүй хоригдлуудыг байрлуулах тусгай төвүүдийг дэмжиж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тогтолцооны нэг хэсэг болгон АНУ-ын дээрх тогтолцоог өөрийн улсын хөрсөнд буулган нэвтрүүлэх нь чухал ач холбогдолтой. Улаанбаатар хотод "Зөв амьдрах ухаан" ТББ болон шашны урсгал бүхий хэд хэдэн төвүүд байдаг боловч хуульчлагдаагүй, төрийн дэмжлэг туслалцаагүйн улмаас үйл ажиллагаа нь тийм ч хангалттай бус байгаа билээ. Мөн хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоолгосон хоригдол хэрвээ дахин гэмт хэрэг үйлдэх магадлалтай бол тодорхой газар нутагт зорчих эрхийг хязгаарлан GPS бугуйвч ашиглан байршлыг хянах тогтолцоог нэвтрүүлэх нь зүйтэй. Гэхдээ үүнийг зөвхөн хугацаанаас өмнө суллагдсан хоригдолд бус хөнгөн гэмт хэрэг үйлдсэн, анх удаа нийгмийн хэм хэмжээг зөрчсөн хүнийг аль болох гэр бүлээс нь салгахгүй, хорих анги, хорих байрны нөхцөлд дасан зохицохоос урьдчилан сэргийлж ашигладаг байх нь чухал байна. Учир нь хүнийг боломжтой л бол гэр бүлээс нь салгаж, хөндийрүүлэх нь тийм ч ач холбогдолтой зүйл биш шүү дээ.

Дүгнэлт, санал

Хорих анги Эрүүгийн хариуцлагын зорилгыг хангаж хоригдлыг "нийгэмшүүлэх" ажлыг зохион байгуулахдаа тэдний гэр бүлд нь тулгуурлан холбогдох хууль, журмын хүрээнд үйлчилгээ үзүүлж хэвших нь илүү үр дүнтэй арга хэмээн үзэж болно. Хоригдол хорих ял эдлэх хугацаандаа ч, суллагдан гарсны дараа ч ямар нэгэн байдлаар гэр бүлд харьяалагдаж, гэр бүлийн гишүүн болж амьдардаг. Системийн онолын үзэл баримтлалаар хоригдол тэрхүү "гэр бүл" гэх нэгэн системийн гишүүн "дэд систем" бөгөөд гэр бүлийн бусад гишүүд түүнээс шалтгаалж, бие биедээ харилцан нөлөөлж байдаг. Түүнийг хорих ял эдлэх хугацаанд нь нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулахдаа "би гэр бүлдээ хэрхэн сайн сайхан амьдрах вэ? Миний эрхэмлэн нандигнах зүйл маань миний гэр бүл биш гэж үү? Би хэрхэн сайн хань, сайн эцэг /эх, ах, эгч, дүү, хүү, охин, өвөө, эмээ/ байх вэ? гэсэн асуултуудад л хамгийн сайнаар хариулах бэлтгэлийг хангуулж, гэр бүлийн нандин харилцааны талаар үзэл бодлыг төлөвшүүлэх нь чухал. Мөн ямар ч төрлийн нийгэмшүүлэх ажил зохион байгуулсан түүнийг гэр бүлээс нь огт салгалгүй хамтад нь авч үзэх, гэр бүлийн гишүүдийнх нь дэмжлэг туслалцааг авч ажиллах нь хамгийн үр дүнтэй.

Хорих ангийн удирдлага, алба хаагчид хоригдлын гэр бүлтэйгээ харилцаа холбоотой байх хуулиар олгогдсон эрхийг хэзээ ч хязгаарласан үйлдэл, нөхцөл байдал үүсгэж болохгүй. Нэг удаагийн тийм үйлдэл, нөхцөл байдал нь хоригдлын бүхий л амьдралыг хар бараан руу хөтөлж, түүнийг насаар нь гэмт хэрэгтэн болгох

эрсдэл дагуулдгийг сайтар анхаарч ажиллах хэрэгтэй. Ялангуяа хоригдлын уулзалт хийх, утсаар ярих, илгээмж авах, захидлаар харилцах эрхүүд нь хоригдлын сэтгэл зүйд асар ихээр эерэг нөлөөллийг бий болгож түүнд “ганцаараа биш” мэдрэмжийг сэтгэлийн гүнээс нь ухааруулж өгдөг. Харин ч эсрэгээрээ хоригдлын гэр бүлтэйгээ харилцаа холбоотой байх бүхий л боломжийг судлан үзэж, хуулийн хүрээнд дэмжиж үйл ажиллагаа явуулах нь чухал юм.

Бүр гэр бүлгүй хоригдлуудад ч нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулахдаа суллагдан гарсны дараа ямар нэгэн байдлаар гэр бүлд харьяалагдаж амьдрах талаар нь сайтар ойлгуулж, “Түр байр” -нд байрласан ч “Миний л гэр бүл” гэж хандах талаар ухамсарлуулахад нийгэмшүүлэх ажлыг чиглүүлэн зохион байгуулах хэрэгтэй.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ТҮҮХЭН ХӨГЖИЛ,ТӨЛӨВШИЛ: ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

HISTORICAL DEVELOPMENT AND FUTURE TRENDS OF THE SCIENCE IN CIVIL LAW OF MONGOLIA



Ж.Уганчимэг
Дотоод хэргийн их сургуулийн
Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Хувийн эрх зүйн тэнхимийн дэд профессор,
докторант, ахмад

Товч агуулга: Энэ удаад та бүхэнд хувийн ба нийтийн эрх зүйн ялгаатай талыг тодорхойлж,иргэний эрх зүйн шинжлэх ухааны хөгжлийн үе шатны талаар судалгаа хийж, цаашид хувийн эрх зүй тэр дундаа иргэний эрх зүйг хэрхэн төгөлдөржүүлэх, түүний хөгжлийг түргэсгэх, зарим нэг тулгамдсан асуудлыг тодорхойлж шийдвэрлэх талаар санал дэвшүүлэхийг зорилоо.

Abstact: This time, I would like to identify the differences between priyate and public law, conduct research on the stages of deyelopment of the science of ciyil law, and make suggestions on how to improye priyate law, including ciyil law, and accelerate its deyelopment, and identify and solye some pressing issues. aimed.

Түлхүүр үг: Хувийн эрх зүй, иргэний эрх зүй, нийтийн эрх зүй, даяаршил

Key word: Priyate law, ciyil law, public law Globalization

Оршил:

Хувийн эрх зүй нь тэгш эрхтэй эрх зүйн этгээдүүдийн хооронд үүссэн харилцааг зохицуулж буй эрх зүйн нэг салбар юм. Харин нийтийн эрх зүй нь эсрэгээрээ босоо харилцаа буюу захирах, захирагдах харилцааг зохицуулдаг.

Юуны өмнө хувийн эрх зүй ба нийтийн эрх зүйн ялгаатай байдлыг тайлбарлая.

1. Аливаа хэрэг хувийн эрх зүй, эсвэл нийтийн эрх зүйн дагуу шийдвэрлэгдэх нь тухайн тохиолдолд ямар эрх зүйн хэм хэмжээ хэрэглэгдэхээс хамаардаг.

2. Нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллаараа ялгаатай байдаг.

Хувийн эрх зүй нь нийгмийн ашиг сонирхлын ухаалаг тэнцвэрийг тогтоох ба дэмжих, эрчимтэй хөгжиж буй нийгмийн харилцааг аль болох уян хатан болгох, хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэн хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэсэн, гүйцэтгэсээр ч байх бөгөөд аж ахуйн үйл ажиллагаа, зах зээлийн эдийн засгийн үндэс болдог билээ[112].

Хувийн эрх зүй буюу иргэний эрх зүйн хөгжлийн суурь нь эртний Ромын эрх зүйгээс үүдэлтэй бөгөөд Ромын иргэд эд хөрөнгөө өмчлөх, эзэмших эрхтэй гэсэн үзэл сэтгэлгээ бий болж улмаар нь тэр нь эрх зүйгээр баталгаажин эрх зүйн системд **JUS CIYIL** буюу хувийн эрх зүйн гол цөм болох иргэний эрх зүйн салбар болон үүсэн хөгжсөөр бидний үед хүрч ирсэн.

Үндсэн хэсэг:

Иргэний эрх зүй нь хууль зүйн шинжлэх ухааны салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хувийн эрх зүйн голлох буюу тэргүүлэх салбар юм. Уг эрх зүйн салбар нь бие даасан нэгэн салбар төдийгүй бусад олон салбар эрх зүйтэй харилцан шүтэлцээтэй байх ба зарим эрдэмтдийн томьёолсноор иргэний хууль нь “бага үндсэн хууль” гэж нэрлэгддэг.

Монгол улсын Иргэний эрх зүйн хөгжлийн үе шатыг дараах байдлаар авч үздэг[113].



Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлд “төрт ёс, түүх, соёлынхоо уламжлал”-ыг нандигнан хөгжүүлэхийн ач холбогдлыг тунхаглан заасан нь эрх зүйн шинжлэх ухааны хөгжилд шууд хамааралтай юм.

Иргэний эрх зүй нь хууль зүйн шинжлэх ухааны салшгүй бүрэлдэхүүн хэсэг, түүний бие даасан нэгэн салбар төдийгүй бусад олон салбар эрх зүйтэй харилцан шүтэлцээтэй байхаас гадна тэдгээрийн нэг эх сурвалжид хамаарч байдгаараа зарим эрдэмтдийн томьёолсноор “бага үндсэн хууль” гэж нэрлэгддэг. Иргэний эрх зүйн субъект нь бусад салбар эрх зүйн субъектээс үлэмж өргөн бөгөөд тэдгээрийн эрх үүргийн үндсэн шинж нь ямар нэгэн ялгаваргүй адил тэгш байх зарчимд тулгуурласан байх, нөгөө талаар үндэсний болон олон улсын хэмжээнд

[112] С.Нарангэрэл,Эрх зүйн эх толь бичиг. УБ 2005 он.,537 дугаар тал.
[113] Ж.Уганчимэг. “Иргэний эрх зүйн лекцүүд” УБ.,2012 он 12 дугаар тал.

бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн эрх зүй, зан үйлийн уламжлал дэвшлийг хүлээн зөвшөөрч, улмаар иргэний хууль тогтоомж төдийгүй шүүх, арбитрын байгууллагын практик үйл ажиллагаагаар баталгаажин хэрэгждэгээрээ онцлогтой. Монгол Улсын Иргэний эрх зүй нь олон улсын иргэний эрх зүйтэй уламжлан хөгжиж ирсэн гэж үзэж болно. Гагцхүү иргэний эрх зүй төдийгүй бусад салбар эрх зүй, төр, нийгмийн түүх нь хэзээ ч ямар ч нөхцөлд уламжлал, шинэчлэлийн замаар тасралтгүй үргэлжлэх үйл явц юм.

Монгол Улсын төр, эрх зүйн үүсэл, хөгжлийн түүхэн үйл явцыг судалсан эрдэмтдийн бүтээлээс үзвэл монголчуудын хууль зүйн хэм хэмжээг аман, бичмэл хоёр хэлбэрээр илэрч хэрэгжиж ирснийг хүлээн зөвшөөрдөг. Аман хэлбэрийн хууль зүй нь хаад, ноёдын болон шашны үзэл сургаал, хориг, дэг, түүнчлэн үлгэр домог гэх мэт хэлбэртэй байсан бол бичгийн хэлбэрийн хууль цааз нь эзэн богд Чингис хааны Их засгаас эхлэлтэй гэж эрдэмтэд баталсан байдаг. Энэ тухай “БНМАУ-ын түүх” номын 143-р талд “13, 14-р зууны үед монголчуудын хууль зүйн мэдлэг, мэдэгдэхүйц хөгжиж иржээ. 13-р зууны эхээр гарсан Монголын анхны бичигдмэл хуулийн хураамж “Их жасаа” Их засаг юм. Их засаг бол монголын төр, захиргаа, цэрэг эрүү шүүлт, иргэн, худалдаа, хэв ёсны хуулийн хураамж бичиг байжээ. Монголын анхны хураамж бичгийг боловсруулах, ерөөсөө их гүрний хууль цаазын үйл ажиллагаанд Монголын тулгар төрийн анхны “Заргач” /шүүгч/ хууль зүйч татарын Шихи хутуг /1180-1262/ чухал үүрэг гүйцэтгэжээ” гэж тэмдэглэжээ[114].

Эрдэмтэн Н.Нам-Осор эзэн Чингисийн Их засаг хуулийн тайлбар / “ёс заншил бол ёслон биелүүлэх хууль мөн” /номын 102-р тал/. Их засаг хууль нь өөрийн үеэс өмнөх аман хэв хуулиудад суурилсан, тэдгээр хэв хуулиуд нь ард түмний ёс заншлаас ургаж гарсан бөгөөд цаашдаа хууль, эрх зүйг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж онцлон дурджээ.

“Монголын нэгдсэн төрийн болон дараа үеийн хууль цааз, заншлын хэм хэмжээг харьцуулан судалсан нь” бүтээлдээ эрдэмтэн Б.Баярхүү “Монголын эртний хуулиудад заншлын хэм хэмжээ хэрхэн тусгалаа олж хөгжсөн, улмаар хууль зүйн хэм хэмжээ, заншлын хэм хэмжээ болж хувирсныг хууль зүйн үүднээс харьцуулж,түүхчлэн дүгнэсэн байна.

Б.Чимид “Их Чингисийн байгуулсан тулгар төрийн үе 12-р зууны эцсээс 20-р зууны эхний 20 жил хүртэл Монгол их, бага олон үеийн хаант засгийг дамжин хөгжсөн феодалын эрх зүйт орон байв. Бурхны номлол, хаадын зарлиг, заншил, шашин сүм, хийдийн хэм хэмжээнээс бүрдсэн эрх зүйн тогтолцоо байсан. Манж Чин улс Монголыг ноёрхсон 220 гаруй жил манж, Хятадын хуулийг хүчээр дагуулснаас үндэсний уламжлал ихэд суларч, тасалдсан” гэж /Прокурорын ном, 2001 оны 145-р тал/ тэмдэглэжээ.

Иргэний эрх зүйн олон талт харилцаа нь хууль зүйн хэлбэрээр бие даасан эрх зүйн эх сурвалжийн хэмжээнд хүртэл боловсрогдон батлагдаж ирсэн гэх баримт олдоогүй ч Монгол Улсад төрт ёс үүсэн тогтож хөгжиж ирсэн түүхэн үе

[114]Ж.Болдбаатар.,Ж.Лүндээжанцан “Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал.УБ.,1997.,14 дэх тал

шат бүрд нийгмийн амьдралаас уламжлан залгамжилж хадгалагдаж ирсэн баримт сурвалж цөөнгүй байдаг.

Өөрөөр хэлбэл тухайн үеийн төр нийгмийн харилцааг зохицуулж байсан нэгдмэл хууль тогтоомжид ямар нэг хэлбэр, хэмжээгээр тусгалаа олж хамгаалагдан бэхжиж, эрх зүйн шинжлэх ухааны салбарт зохих байр суурь эзэлсээр ирсэн гэж үзэх үндэслэлтэй юм. Эрдэмтэн Н.Ням-Осорын бүтээл "13-р зууны Монголын нийгэм, эдийн засгийн амьдралд Чингис хааны "Их засаг" хуулийн гүйцэтгэсэн үүрэг юм[115].

Египетийн түүхч Магриз, Хятадын эрдэмтэн Сайшаал болон бусад олон эрдэмтэн судлаачдаас "Их засаг" хуульд аж ахуй, арилжаа, худалдаа, ан ав, байгаль орчноо хамгаалах зэрэг ёс горимыг тогтоосон бүхэл бүтэн бүлэг бий гэж тодорхой баримтаар дурдсан байдаг. Тухайлбал, байгаль орчны эд агуурс баялаг ан амьтдыг зөвхөн өөрийн эзэмшлийн газар нутгаас авч ашиглаж байх, амьтдыг үржил төллөлтийн үед авлах, тэр байтугай шувууны үүрэнд сүүдрээ тусгахыг хүртэл цээрлэж байх. Арилжаа, худалдаа шударгаар явуулах, бусдыг хуурч мэхлэх, эд агуурсыг өндөр үнээр дамлахын хориглох, олсон олз, ашгаас татвар, хураамж төлж байх, өртөө харуулын албыг эрхлэн гүйцэтгэж түүний зардал, уналгыг адил тэгш хангаж байх, малын үүлдэр, угсаа, үр шимийг сайжруулах зэрэг иргэний эрх зүйд хамаарах олон бүлэг асуудлыг хуулиар зохицуулж байсан баримт байна. Түүгээр ч барахгүй аливаа хэрэг, зөрчил гаргасан этгээдийг мал, эд зүйлээр торгож байсан нь эрүүгийн ял төдийгүй мөн иргэний эрх зүйн журмаар "хохирол нөхөн төлүүлэх" хэм хэмжээтэй адил давхцаж байсан гэж үзэх үндэслэлтэй юм.

Их засаг цаазын нэг онцлог бол ялангуяа иргэний эрх зүйн гол зарчим болох "тэгш эрхийн" тухай асуудлыг түүнчлэн эд хөрөнгийн эрхийг өвлөх, залгамжлах эрх, үүргийн талаар нэн тодорхой нийтлэг хэм хэмжээ тогтоосон байдаг.[116] Жишээлбэл, эрх мэдэл өндөр, эд хөрөнгө ядуу хоосон гэж ангилан ялгаж болохгүй. Бодгаль бүр адил тэгш үүрэгтэй байхыг хуульчлан тогтоож байжээ. Түүнчлэн хэн нэгнийг нас барсан нөхцөлд түүний гэр бүлийн гишүүд төдийгүй, хөлсөөр ажиллагсад, зарцлагдаж байсан хүмүүст нас барагчийн эд хөрөнгөнөөс заавал хувь хүртээж, өв үлдээж өгч байх журмыг тогтоосон байна. 1640 оны Халх журам хууль бол Монгол Улсын төр, нийгэм, хууль зүйн шинжлэх ухааны түүхэнд чухал эх сурвалж болох бие даасан бүтээл гэж тэмдэглэгддэг. Энэ хууль нь тухайн үеийн Монгол орны аж ахуй, эдийн засаг, улс төр, нийгмийн байдлаас урган гарсан эхлэлтэйгээрээ онцлогтой эрх зүйн баримт бичиг болно.

Ц.Жамсранов, Ц.А.Трунов, Б.Е.Владимирцов, А.В.Рязновский нарын бүтээлд тэмдэглэснээр Халх журам бол нүүдлийн феодализмын нийгмийн харилцааг зохицуулахад шууд чиглэсэн хэв заншлын хуулийн цуглуулгын шинжтэй эрх зүйн баримт бичиг юм. Халх журам бол эрдэмтэн С.Жалан-Аажавын тодорхойлсноор төрийн захиргааны, иргэний, эрүүгийн гэх мэт тулгуур болон салбар олон төрлийн эрх зүйд ангилан үзэж болох юм. С.Жалан-Аажав өөрийн бүтээлдээ "худалдаа, арилжааны өр авалга, өв залгамжлал, гэр бүлийн зэрэг

[115] Б.Я.Владимирцов. Чингис хаан.УБ.,1996.14 дэх тал
[116] Э.Авирмэд.,Г.Совд.,Д.Дашцэдэн. Монгол хууль.,УБ.,1997. 6 дахь тал

иргэний эрх зүйд хамаарах олон зүйл, заалтыг Халх журамд тусган хуульчилсан гэж тодорхойлжээ. Мөн профессор Ш.Нацагдорж, С.Жалан-Аажав нар өөрсдийн бүтээлдээ Халх журам хуулийг Чингисийн Их засаг, Улаан хацарт гэх шавь яамны таслан шийтгэсэн зэрэг олон эх сурвалж болох түүхэн баримт бичгээс уламжлалтай бөгөөд тэдгээрийг харьцуулан судлах нь нэн чухал гэж тэмдэглэсэн байдаг[117].

1921 оны ардын хувьсгалын өмнөх Монгол оронд хар шар феодалын эрх ашиг, сонирхлыг хамгаалсан эрх зүйн тогтолцоо үйлчлэн зохицуулж байсныг батлах олон эх сурвалж байдаг. Тухайлбал, ОХУ-ын монголч эрдэмтэн зохиолч, академич И.Я.Златкин "Монгол улсын нэн шинэхэн үеийн түүхийн тухай" бүтээлдээ "богд гэгээний засгийн газар, автономит Монголд манжийн хууль тогтоомж, манжийн үеийн язгуртны шүүх, өөрөөр хэлбэл, лам, феодал мөн хамжлага ард, шавь нарт тус тусад нь байгуулсан шүүхийг хөндсөнгүй, засаг захиргаа, цэрэг, шүүхийн хэрэг хуучнаараа хошууны засаг ноёны бүрэн эрхэд хэвээр хадгалагдан үлдсэн байв" гэж тэмдэглэжээ.

Үүнээс үзэхэд иргэний төдийгүй, аль төрөл, салбарын эрх зүй нь манжийн хааны зарлиг хуульд тусгалаа олж хэрэгжиж ирсэн гэж үзэх үндэслэлтэй байна.

<u>Монгол Улсын ардчилсан шатны үе дэх иргэний эрх зүй /1921-1960/</u>

БНМАУ-ын анхдугаар Их хурлаас 1924 онд баталсан Үндсэн хууль нь иргэний эрх зүйн төдийгүй бусад салбар эрх зүйн гол эх сурвалж болсноороо МУ-ын иргэний хууль тогтоомжийг боловсруулах, батламжлах нөхцөл бололцоог бүрдүүлсэн байна. Үндсэн хуульд тус орны хамжлагат ёсыг халж, хөрөнгөтний бус замаар хөгжүүлэх, ардчилсан шинэ тогтолцоог бүрдүүлэх талаар заасан зорилт, зарчмууд нь иргэний хууль тогтоомжид шууд тусгалаа олж хуульчлагдсан юм. Аливаа хууль тогтоомж бол хэн нэгэн эрдэмтэн мэргэн эсвэл эрх мэдэлтний хүсэл санал, үзэл бодлоор биш харин тухайн төр, нийгэм, эдийн засгийн зайлшгүй тулгамдсан хэрэгцээ шаардлагын хүрээнд боловсрогдон батлагдаж, дагаж мөрдөгдөх жам ёсны зүй тогтолтой ажээ. Тухайлбал, 1926-1929 онуудад хэсэгчлэн боловсруулж, тухай бүр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн баталсан БХМАУ-ын Иргэний хууль нь тухайн цаг үеийнхээ нөхцөл байдалд шаардагдсан гол гол харилцааг зохицуулахад шууд чиглэсэн байв. Энэ хугацаанд батлагдсан 10 бүлэг 217 зүйл бүхий Иргэний хуулиар зохицуулж ирсэн гол харилцааг дараахь байдлаар утгачлан тайлбарлаж болох юм. 1/Тухайн үеийн иргэний эрх зүйн харилцааны гол субъект нь иргэд, тэр дундаа эд хөрөнгийн хувьд ядуу дорой аж амьдрал бүхий хүмүүсийн эд хөрөнгийн болон амин хувийн ашиг сонирхлыг хамгаалах асуудлыг тэргүүн зэргийн зорилт болгон баталгаажуулсан байв. 2/Аливаа эд хөрөнгийг эзэмших, ашиглах эрхийг уламжлан хадгалах, тухайлбал, хар шар феодал, ноёдын эд хөрөнгийг хураан авах буюу худалдах, шилжүүлэх аргаар улсын буюу иргэдийн өмчлөлд шилжүүлэх журмыг тогтоон хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн байна. 3/Төр, нийгмийн үүр үндэс болох гэр бүл бологсод болон тэдний гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн болон амин хувийн эрх, эрх чөлөөг адил тэгш хамгаалах зарчмыг тогтоож, гэр бүлийн харилцаан дахь хоцрогдлыг арилгахад шууд чиглэсэн хэм хэмжээг тогтоон хэрэгжүүлсэн. 4/ Хууль тогтоомжоор эрх мэдэл нь

[117]Т.Мөнхжаргал "Монгол Улсын Иргэний цаазын товчоон" УБ.,2006 он 10 дахь тал

ямар нэг хэлбэрээр хязгаарлагдаагүй иргэн, албан хаагч хэн боловч олон нийтийн байгууллага, эвлэл хоршоонд гишүүнээр нэгдэн орох эрхийг хуульчлан баталж өгсөн. 5/Аливаа хөрөнгө хогшлын тухай гэсэн бүлэгт өнөө үеийн өмчийн хэлбэр, төрөл, мөн үүрэг үүсэх үндэслэл, үүргийн гүйцэтгэлийг хангах арга, журам, зарчмыг тухайн үеийн эрх зүй, эдийн засгийн ойлголтын хүрээнд томьёолон тодорхойлсон. 6/Аливаа өр ширийг арилгах гэсэн бүлэгтээ иргэний эрх зүйн харилцаанаас үүссэн өр авлагыг барагдуулах арга журмыг захиргааны болон шүүхийн журмаар шийдвэрлэх зарчмыг тогтоон өгсөн байна. 7/Эл хуульд аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах, эд хөрөнгийг барьцаалах, гэрээ хэлцэл хийх болон түүний үр дагаврыг тооцох хууль зүйн үндэслэлийг тодорхой заасан байв. 8/Иргэний эрх зүйн харилцаанаас үүссэн маргааны талаар эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг биелүүлэх, давж заалдах зэрэг иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдсон эрх зүйн үндэслэлийг өөртөө агуулж хуульчлан заасан байлаа.

Энэхүү Иргэний хуулийг 1952 он хүртэл дагаж мөрдсөн бөгөөд түүний гүйцэтгэсэн гол үүрэг, ач холбогдлыг тодорхойлбол: 1/1921 оны ардын хувьсгалын ялалт, ардчилсан төрийн тогтолцоо, нийгмийн ололт амжилт, иргэний эрх, эрх чөлөөг хамгаалах болон хуучин феодалын нийгмийн харилцааг халж солих, тухайлбал, урьдах нийгмийн үеийн эрх тэгш бус хууль цаазыг өөрчлөн шинэчлэх, 2/тухайн нийгмийн үе дэх гэр бүл, ахуй соёлын харилцаан дахь хоцрогдол, дарангуйллын ул мөрийг арилгаж, ардчилсан шинэ дэвшилтэт ёс суртахууны харилцааг үүсгэн тогтоох нөхцөлийг бүрдүүлэх, 3/хөрш зэргэлдээ ЗХУ болон хөгжилтэй зарим орны хууль зүйн түүхэн туршлагаас судалж, суралцах, түүнээс үлгэр дуурайл авч хууль тогтоомжийн хэлбэр, загвар, агуулгыг дэлхийн олон улсын түвшинд хүртэл боловсронгуй болгох эх үндсийг тавих, 4/хар, шар феодал, ноёд, түшмэдийн гарт зонхилон төвлөрсөн өмч хөрөнгийг улсын болон иргэдийн мэдэлд шилжүүлэх, эд хөрөнгийн эрх үүргийг аль болох адил тэгш байх зарчмыг тусгах, 5/Монгол Улсын төрт ёсны түүхэнд анх удаа гэж хэлж болохоор иргэний эрх зүйн бие дааж системчлэгдсэн Иргэний хуулийг батлан мөрдүүлснээрээ хууль зүйн шинжлэх ухааны түүхэнд чухал баримт бичиг эх сурвалж болсон гэж үзнэ.

Мөн 1952 онд Иргэний байцаан шийтгэх хууль батлагдаж дагаж мөрдсөнөөр аливаа иргэний хэрэг маргааныг шүүхээс хянан шийдвэрлэх дэг журмыг хуульчлан баталгаажуулсан төдийгүй эрх зүйн салбар дахь нэг шинэ төрөл болон хөгжих үндэс тавигдсан болно.

<u>Социалист байгууллагын үе дахь иргэний эрх зүй /1960-1990он</u>/

Олон улсын эрх зүйн тогтолцоонд социалист эрх зүйн тогтолцоо нь чухал байр суурь эзэлж бие даасан нэгэн хэсэг болж судлагддаг билээ. Социалист эрх зүйн тогтолцооны нэг бие даасан салбар нь социалист иргэний эрх зүй юм. Социалист иргэний эрх зүйн тогтолцоог 1960-аад онд ЗСБНХУ, БНМАУ, БНХАУ, БНУАУ, БНКУ гэх зэрэг Ази, Европ, Америк тивийн тухайлбал, дэлхийн 2-р дайны дараа бүрэлдэн тогтсон социалист чиглэлийн төр, нийгэм эдийн засгийн байгуулал бүхий 10 гаруй улс орныг хамааруулан үздэг.

Социалист тогтолцоо бүхий тэдгээр улс орнуудын тухайд төр, нийгмийн байгууламж эдийн засгийн харилцаа бараг нэгдмэл нэг стандартчилагдсан эрх зүйгээр зохицуулж ирснээрээ онцлогтой. Социалист эрх зүйн тогтолцооны гол эх сурвалж нь Эдийн засгийн харилцан туслалцах Зөвлөлийн гишүүн орнуудын дээд эрхийг барих эрх бүхий байгууллагын зөвлөмж шийдвэр, түүнчлэн ЗСБНХУ-ын туршлага шийдвэрлэх үүрэг, гүйцэтгэж байжээ.

1990-ээд оноос социалист байгууллын тогтолцоо задарч, түүний бүрэлдэхүүнд багтаж байсан олон улс орон зах зээлийн харилцаанд шилжин орох нөхцөл бүрдсэнээр социалист эрх зүйн тогтолцоо өөрчлөгдөх улс, төр эдийн засгийн үндэс суурь тавигджээ. Гэхдээ зах зээлийн харилцааны үеийн эрх зүй нь агуулга хэлбэрийн хувьд өөрчлөгдөн шинэчлэгдсэн ч гэсэн социалист иргэний эрх зүйн харилцаанаас уламжлан авч үлдээсэн олон төрөл зүйлийн харилцаа байгааг хүлээн зөвшөөрч уламжлал-шинэчлэлийн утгаар тайлбарлаж судлах нь зохистой гэж үзнэ.

1940 онд хуралдсан 8 дугаар Их хурлаас баталсан БНМАУ-ын Үндсэн хууль нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн харилцаанд гарсан гүн гүнзгий өөрчлөлтийг тусгаж хувьсгалын ардчилсан шатнаас социалист байгууллын үр үндсийг хөгжүүлэн бэхжүүлэх шинэ үед шилжин орсныг батлан тунхагласан нь дагаж мөрдөж ирсэн хууль тогтоомжийг өөрчлөн шинэчлэх зайлшгүй хэрэгцээ, шаардлага болсон байна.

1952 онд батлагдсан Иргэний хууль болон Иргэний байцаан шийтгэх хууль нь Монгол улсад социализмын үндсийг үүсгэн байгуулах, социалист аж ахуйн харилцааг төлөвшүүлэн тогтооход чиглэсэн хэм хэмжээ тогтоосон байв. Энэ хуулиар иргэний эрх зүйн харилцааны субъектийг иргэн, хуулийн этгээд гэж ангилж тэдгээрийн нийтлэг эрх, үүргийн чадварыг товч боловч тодорхойлсон, мөн үүргийн эрх зүйн тусгай төрлийг худалдаа, арилжаа, эд хөрөнгө хөлслөх, даалгаврын болон контрактацын зэрэг эдийн засаг, аж ахуйн харилцаанд нэлээд түгээмэл ашиглагдаж байсан гэрээний зарим нөхцөл, шинжийг хуульчлан тогтоосон зэргээрээ онцлогтой байв. Үүнээс гадна гэрээний бус хэлбэрээр үүрэг үүсэх зарим үндэслэлийг тухайлбал, үндэсгүйгээр баяжих, гэм хор учруулснаас үүсэх үүрэг, мөн зохиогч, шинэ бүтээлийн эрхтэй холбогдох үүргийн төрлийг шинээр тусгасан зэрэг тухайн үеийн нийгмийн харилцаанд шаардагдах хэм хэмжээг тогтоон системчилснээрээ иргэний эрх зүйн зохицуулалтын цаашдын хөгжилд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Социалист иргэний эрх зүйн гол эх сурвалж нь 1963 оны Иргэний хууль байсан ба Энэ хууль нь тус улсад эдийн засаг, аж ахуйн харилцааг социалист ёсоор өөрчлөн байгуулах, социалист төр нь, нийгэм, соёлын болон аж ахуйн байгууллагын эрх ашиг сонирхлыг хамгаалах, ялангуяа социалист өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах онцгой эрх мэдлийг тогтоон, хувийн болон амины өмчийн эрх мэдлийг хязгаарлах зэрэг харилцааг 1960 оны үндсэн хуулийг үндэслэн шууд зохицуулж ирснээрээ социалист иргэний эрх зүйн харилцааг төлөвшүүлэн тогтооход гол үүрэг гүйцэтгэсэн сонгодог хэлбэр, үзэл сурталжсан эрх зүйн нэгж хэсэг байв.

Монгол улсын Иргэний хуулийн гол зорилтыг харьцуулан үзвэл 1963 оны Иргэний хуульд зааснаар “БНМАУ-ын Иргэний хууль нь социалист системийн аж ахуй, социалист өмчийг бэхжүүлэн хөгжүүлэх, социалист байгуулалтаас цаашид коммунизмын байгуулалтад шилжих, иргэдийн эд материалын болон оюун санааны хэрэгцээг дүүрэн хангах зорилгоор эд хөрөнгийн болон түүнтэй холбогдсон эд хөрөнгийн бус харилцааг, хуульд заасан бол эд хөрөнгийн бус амины бусад харилцааг зохицуулна” гэж тодорхойлсон байхад 1994 оны Иргэний хуульд “Иргэний гүйлгээнд оролцогчдын эрх зүйн байдлыг тодорхойлж, эд хөрөнгийн болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бус амины харилцааг, уг харилцаанд оролцогчдын эрх тэгш байдал, хүсэл зоригийн болон эд хөрөнгийн бие даасан байдлыг үндэслэн зохицуулна” гэж тодорхойлжээ.

Энэ тодорхойлолтуудаас үзэхэд 1994 оны Иргэний хууль нь социалист байгуулалтын болон социалист өмчийг хамгаалан бэхжүүлэх, иргэдийн материалын болон оюун санааны хэрэгцээг дүүрэн хангах гэсэн зорилтоос бүрэн татгалзаж харин эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус амины харилцааг уг харилцаанд оролцогчдын эрх тэгш байдал, хүсэл зориг, бие даасан байдлыг хангах зорилтыг гол зорилго болгосноороо зарчмын онцлог ялгаатай байна.

Иргэний хууль тогтоомж нь зорилгоосоо шалтгаалж зохицуулж байгаа харилцааны агуулга, хэлбэр нь үндсээрээ өөр өөр шинж чанарыг илэрхийлнэ. Тухайлбал, иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэлийг харьцуулан 1963 оны Иргэний хуульд “улсын төлөвлөгөө, даалгаврыг” нэн чухал байр эзлүүлэн тодорхойлж байсан бол 1994 оны Иргэний хуульд түүнийг хасаж харин иргэний эрх зүйн харилцаа үүсгэхэд чиглэсэн шүүхийн шийдвэрийг нэн чухал үндэслэл болгон тодорхойлсон байх жишээтэй байна.

Социалист байгуулалтын үед эдийн засаг, аж ахуйн харилцааг зохицуулахад төвлөрсөн төлөвлөгөө, хуваарилалт чухал үүрэг гүйцэтгэсэн төдийгүй түүнийг баталгаатай хангах хууль зүйн гол хөшүүрэг нь Монгол Улсын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Улсын арбитрын газар байсан юм. 1930-аад онд анх үүсэн байгуулагдсан Улсын арбитрын байгууллага социалист үйлдвэр, аж ахуйн байгууллагын хооронд улсын төлөвлөгөө, даалгавар болон гэрээ хэлцлийн замаар үүссэн хэрэг маргааныг иргэний хууль тогтоомж болон арбитрын байгууллагаас аж ахуйн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх хууль, дүрэмд зааснаар нэг үгээр хэлбэл шүүн таслах үүргийг гүйцэтгэж ирсэн байна. Харин 1990-ээд оноос арбитрын байгууллагыг татан буулгаж, түүний үүргийг шүүхэд шилжүүлж гүйцэтгүүлэх болжээ.

Энэ үед иргэний эрх зүйн онол, практикийн судалгаа, эрдэм шинжилгээний ажилд шинэ эхлэл гарч ирснийг зориуд тэмдэглэх нь чухал юм. 1957 онд Хууль цаазын дунд сургуулийн багш Б.Жавзмаа “БНМАУ-ын иргэний эрх” гэсэн товхимол хэвлүүлснийг эрдэмтэн- судлаачид иргэний эрх зүйн анхны бүтээл гэж үнэлж иржээ. Мөн Л.Зэвгээгийн “БНМАУ-ын иргэний эрх зүйн ерөнхий анги” /1975 он/, Д.Зундуй, Л.Чинбат нарын редакторласан хамтын бүтээл “БНМАУ-ын Иргэний эрх зүй” /1988 он/, “БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх эрх зүйн тайлбар” /1984 он/, Т.Мөнхжаргалын ”Монгол Улсын Иргэний эрх зүй” /1996-1997 он/, Д.Наранчимэгийн “ Иргэний эрх зүйн үндсэн асуудал” /1999 он/ зэрэг бие даасан зохиол бүтээлүүд хэвлэгдэн гарсан нь иргэний эрх зүй судлаачдад

онол практикийн мэдлэг олгох эрдэм шинжилгээний ач холбогдолтой эх сурвалж болжээ.

Түүнчлэн иргэний эрх зүй нь их, дээд сургуулиудад судлах үндсэн суурь хичээлийг нэг болж сургалтын төлөвлөгөөнд тусгагдах болсноор түүний зохицуулах харилцааг улам боловсронгуй болгох шаардлага байнга өндөржсөөр байна.

1963 оны Иргэний хуулийн гол шинжийг Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан нар тодорхойлохдоо: “Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үндсийг бэхжүүлж, өмчийн олон хэлбэрийн адил тэгш хөгжих эрхийг хязгаарлан улмаар улсын өмчийг давуутай хөгжүүлэх, эрх зүйн бааз, суурь нь болсон боловч эд хөрөнгийн бус харилцааны олон төрөл чиглэл, иргэний эрх зүйн харилцааны талууд /субъект/-ын хариуцлагыг дээшлүүлэх, иргэдийн эрх ашиг сонирхлыг хамгаалах хууль зүйн баталгааг хүчтэй болгоход чухал үүрэг гүйцэтгэсэн юм гэж дүгнэжээ.

<u>Нэн шинэ үеийн иргэний эрх зүй /1994 оноос хойших үе/</u>

Монгол Улсад өрнөсөн улс төр, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэл нь социалист байгуулалтын харилцааг зохицуулж байсан хууль тогтоомжийг үндсээр нь өөрчлөн шинэчлэх бодит шаардлага болсон юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн /1992 оны/ хавсралт хуульд зааснаар хууль тогтоомжийг Үндсэн Хуульд нийцүүлэн бүрэн шинэчлэх асуудлыг 1996 онд багтаан хийж дуусгах зорилт тавигдсан байна.

Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд Монгол улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна. Төр нь нийгмийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална гэж тодорхойлон заасан нь иргэний эрх зүйн төдийгүй бусад салбар эрх зүйг шинэчлэх эдийн засгийн эрх зүйн гол үндэслэл болсон байна.

Өнөө үед Монгол улсын хуулиудыг шинэчлэх үйл явц нь эх газрын буюу Ром-Германы эрх зүйгээс гадна, далайн оруудын буюу Англо-Саксоны эрх зүйн тогтолцооны зарим чиг хандлагыг тусган боловсруулснаараа нэлээд онцлогтой гэж зарим судлаачид тэмдэглэсэн байдаг.

1994 онд батлагдсан Иргэний хуулийн гол агуулга нь социалист хэвмаягийн харилцааг халж, өөрчлөх, орчин үеийн олон улсын хөгжлийн түүхэн хандлагын дагуу хүмүүнлэг ардчилсан соёл иргэншлийг төлөвшүүлэн тогтооход чиглэсэн хэм хэмжээг тогтоосноороо онцлог талтай гэж үзэж болно.

Төр, нийгмийн харилцааг өөрчлөн шинэчлэхэд иргэний эрх зүйн гүйцэтгэж ирсэн үүргийг түүхчлэн судлах явдал чухал ач холбогдолтой юм. Тухайлбал, Монгол Улсын эдийн засаг, аж ахуйн харилцаа, өмч, өмчлөх эрх үүргийн талаар явуулсан төр нийгмийн бодлого нь иргэний эрх зүйн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжид бүрэн тусгалаа олж нийгмийн амьдралд хэрэгжүүлж ирснийг тэмдэглэвэл зохино.

Дүгнэлт:

Монгол улсын тухайд өнгөрч байгаа 20-р зууны түүхэнд өмч, өмчлөх эрхийн үндсэн дөрвөн хэлбэрийг дамжин хөгжиж ирсэн хэмээн тодорхойлж болох юм.

Нэгдүгээр үе буюу 1920-иод он хүртэлх хугацаанд тухайн цаг үеийн шинжлэх ухаан техникийн хөгжлөөс хоцрогдсон арга, ажиллагаатай зөвхөн амь, хувиа аргацаах байдалтай энгийн нөхөн үйлдвэрлэлийн шинжтэй, нүүдлийн мал аж ахуй зонхилсон сүм хийдийн болон зарим ноёд, феодалын эрх мэдэлд хамаарах төдий хувийн өмчийн хэлбэрт тулгуурласан.

Хоёрдугаар үе буюу /1920-1940-өөд онд/ сүм хийд, ноёд феодалын хувийн өмчийг улсын болгох, үндэсний үйлдвэрлэл, аж ахуйн газрыг үүсгэн байгуулж улмаар социализмын эдийн засаг, аж ахуйн харилцааг тогтоон төлөвшүүлэхэд чиглэсэн хууль тогтоомжоор зохицуулж байв.

Гуравдугаар үе буюу 1940-60-аад онд мал, газар тариалан зэрэг хөдөө аж ахуйн салбарыг хоршоолон нэгтгэх улсын болгох замаар хувийн өмчийн хэлбэрийг үндсэнд нь бүрэн халж улсын болон хоршооллын хэлбэрээс бүрдэх социалист өмчийн харилцааг тогтоох улмаар 1960-аад оноос 1990 –ээд он хүртэл Монгол улсад амины болон социалист өмч гэсэн хоёр хэлбэрээр эдийн засаг, аж ахуйн харилцаа бүрэн ноёрхох болж түүнийг төлөвшүүлж тогтоох асуудалд иргэний эрх зүй шууд зохицуулах үүрэг гүйцэтгэж иржээ.

Дөрөвдүгээр үе буюу 1990-ээд оноос Үндсэн хуулиар тогтоосон зарчмаас үндэслэж, 1994 онд баталсан иргэний хууль нь социалист өмчийн хэлбэр төрлийг бүрэн халж зах зээлийн харилцаанд тохирч нийцсэн өмчийн хэлбэр төрөл түүнчлэн өмчлөх эрхийн агуулгыг үндсээр нь өөрчлөн зохицуулах эрх зүйн гол эх сурвалжийн нэг болсон юм.Тус улсад хувийн, нийтийн гэсэн өмчийн хоёр хэлбэр эрчимтэй хөгжиж социалист хэмээн нэрлэж байсан өмч, түүнийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх нь гагцхүү төрийн мэдэлд үлдэж улмаар түүнийг “хувьчлах” аргаар хувийн буюу холимог өмчийн хэлбэр төрөлд шилжүүлэх үйл ажиллагаа явагдаж байсан.

Нөгөө талаар Монгол Улсын Иргэний хуульд нийтийн өмчийн төрийн аж ахуйн нэгжийн /нөхөрлөл, компани, хоршоо, холбооны гэх мэт/ төрийн бус соёл гэх мэт түүнчлэн гадаадын иргэд, хуулийн этгээд, олон улсын байгууллагын гэх мэт олон төрөлд ангилан үзэж тэдгээрийн эрх мэдлийн хэмжээ хязгаарыг хуульчлан тогтоосон салбар эрх зүйн эх сурвалжийн нэг болов.

Үүнтэй холбогдуулж иргэний эрх зүйгээр зохицуулж байгаа харилцааг үүсэн гарч байгаа иргэний хэрэг маргааны төрөл зүйлийг Улсын Дээд шүүхийн дараах архивын баримт мэдээнээс харьцуулан үзэж дүгнэлт хийж болно.Тухайлбал, социалист нийгмийн харилцааны эд өрнөлийн үе буюу 1979 онд тус улсын нийт шүүхийн хэмжээгээр 14038 Иргэний хэрэг шийдвэрлэж байсан бол зах зээлийн харилцаанд шилжсэн үеийн 10 дахь жил буюу 1999 онд 28039 Иргэний хэрэг шийдвэрлэсэн нь өмнөх 20 дахь жилээс хоёр дахин өссөн байна.

Энэ тооноос үзвэл тус улс зах зээлийн харилцаанд шилжин орсон энэ үед Иргэний хууль тогтоомжоор зохицуулж байгаа харилцаа үлэмж өргөжсөн гэдэг нь харагдаж байна. Нөгөө талаар түүнийг зөрчиж гажуудуулснаас шүүхэд гомдол,

нэхэмжлэл гаргах явдал их өссөнийг харуулж байна. Шүүхээс хянан шийдвэрлэж байгаа иргэний хэргийн дотроос голлон зөрчигдөж байгаа харилцааны төрлөөр үзвэл 1999 онд шүүхээр шийдвэрлэсэн бүх иргэний хэргийн 54 хувийг иргэд, албан газар, хуулийн этгээд, тэдгээрийн хооронд үүссэн эд хөрөнгө, аж ахуйн үйл ажиллагаанаас үүссэн хэрэг бараг 10 хувийг гэрлэлт цуцлуулсан, хүүхдийн тэтгэлэг тогтоосон зэрэг гэр бүлийн харилцаанаас үүссэн хэрэг, 5 хувийг ажлаас буруу халсан, цалин хөлс дутуу олгосон зэрэг хөдөлмөрийн эрх зүйн харилцаанаас үүссэн хэрэг тус тус эзэлж байна. Иргэний хэргийн гаралтын тоо хэмжээ аймаг, хотуудад харилцан адилгүй байна.

2002 оны Иргэний хууль нь шинэ зуунд Монгол Улсын эдийн засаг, нийгмийн харилцааг олон улсын зах зээлийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн даяарчлалын хэм хэмжээний хүрээнд улам ойртуулан зохицуулах нөхцөл боломжийг бүрдүүлж өгснөөрөө онцгой ач холбогдолтой хууль болсон юм.

Санал:

2002 оноос хойш буюу нэн шинэ үеийн Иргэний хууль батлагдсанаас хойш эдүгээ 21 жил өнгөрсөн байна. Дээрх хуулиуд батлагдсан цаг үеэс хойш бид хувийн эрх зүйд дараах байдлаар шинэтгэл хийх, түүнийг төгөлдөржүүлэх шаардлагатай байна.

1. Даяарчлалын энэ эрин зуунд нийгэм эдийн засгийн харилцаа нэг улсын хил хязгаараас хальж улс орнууд улам бүр ойртон нягтрах үйл явц нийгмийн амьдралын бүхий л хүрээг хамарч, энэ нь улс орнуудын эрх зүйн тогтолцоонд ч харилцан нөлөөлж байна. Хувийн эрх зүйн энэхүү даяаршлын үйл явц нь төрөл бүрийн эрсдэлийг дагуулж буйг анхаарах нь зүйтэй. Монгол улсад худалдаа арилжаатай холбоотой харилцааг Иргэний хууль болон Нөхөрлөлийн тухай, Компанийн тухай хууль, Өрсөлдөөний тухай, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай, Дампуурлын тухай гэх мэт хуулиар зохицуулж байгаа хэдий ч аж ахуй, бизнес эрхлэгчдийн хооронд үүссэн харилцааг цогц байдлаар зохицуулсан эрх зүйн тогтолцоо байхгүй байна. Өөрөөр хэлбэл Иргэний хуульд аж ахуй эрхлэгч болон хэрэглэгч хоорондын, эсхүл иргэд хоорондын харилцааг илүүтэйгээр зохицуулсан бөгөөд аж ахуй эрхлэгчдийн хооронд үүсэх бизнесийн онцлог харилцааг зохицуулсан хэмжээг эдийн засгийн агуулгаар баяжуулах, бие даасан эдийн засгийн эрх зүй буюу арилжааны эрх зүйг бий болгох шаардлагатай байгаа юм.
2. Ажил гүйцэтгэх гэрээтэй холбоотой барилгын хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэж байгаа практикийг харахад түүний үнэлгээг тогтооход шинжээч нар ихээхэн үүрэгтэй оролцох ёстой атал тэдгээрийн оролцоог хангахад зарим талаар хүндрэлтэй асуудлууд гардаг. Тиймээс одоогийн шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгийн шинжээчдийг энэ чиглэлээр мэргэшүүлэх, энэ чиглэлийн тусгайлсан бүтцийн нэгж байгуулах хэрэгтэй байна.
3. Иргэний эрх зүйн шинэтгэлийн хүрээнд анхаарал хандуулах нэг зүйл бол гэм хорын асуудал юм. Тухайлбал: эрүүл мэндийн ажилтнууд өвчтөнд

хайхрамжгүй хандах, хүний биед гэмтэл учруулах, хүний амь насанд хохирол учруулах байдлууд нэмэгдсээр байх тул тэдгээрийг гэм хорын зөрчилд тооцож хариуцлага тооцох механизмыг иргэний хуульд оруулах нь зүйтэй.

4. Дэлхий нийтийн чиг хандлагаас харвал хувийн эрх зүйд тэр дундаа иргэний эрх зүйд сансрын эрх зүй, компанийн эрх зүй, үнэт цаасны эрх зүй, эрчим хүчний эрх зүй, мэдээллийн эрх зүй, хэвлэл мэдээллийн эрх зүй, интернэтийн эрх зүй, өрсөлдөөний эрх зүй зэрэг шинэ төрлийн дэд салбарууд хөгжиж байна. Манай улсад ч гэсэн эдгээр салбаруудыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагатай байгаа юм.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

1. Э.Авирмэд, Д.Дашцэдэн. Монгол хууль. Уб., 1997.
2. Т.Алтангэрэл. Монгол ойрадын их цааз, түүний судалгаа Уб. 1998.
3. С.Нарангэрэл. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо Уб. 2001.
4. Б.Баярсайхан. Монгол цаазын товчоон. Уб., 2001.
5. Н.Лүндэндорж. Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал, шинэчлэлийн зарим асуудал. Уб., 2001.
6. Б.Баярсайхан. Хууль зүйн тайлбар толь /Монгол улсын төр, эрх зүйн түүх/. Уб., 2003.
7. Г.Баярхүү. Монголын нэгдсэн төрийн болон дараах үеийн хууль цааз, заншлын хэм хэмжээг харьцуулан судалсан нь. Уб., 1997.
8. Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. Уб., 1997.
9. Т.Мөнхжаргал. Монгол улсын иргэний эрх зүй. Уб., 2000.
10. Т.Мөнхжаргал. Монгол улсын иргэний цаазын товчоон. Уб., 2006.

---o0o---

ЦАХИМ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТҮҮНД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

LEGAL REGULATION OF CYBERCRIME AND SOME OF THE ISSUES PRESSING IT.



Л.Хаш

Санхүү эдийн засгийн их сургуулийн, Эрх зүйн тэнхимийн ахлах багш, хуульч, өмгөөлөгч, доктор (Ph.D).



Б.Мөнгөннахиа

Санхүү эдийн засгийн их сургуулийн, Эрх зүйн тэнхимийн ахлах багш, хуульч, өмгөөлөгч, хууль зүйн магистр.

Товч агуулга: Өнөөгийн техник технологи эрчимтэй хөгжин буй энэ цаг үед хүний өдөр тутмын амьдрал, аж ахуйн, байгууллагын үйл ажиллагаанд томоохон нөлөө үзүүлж байгаа интэрнет орчин буюу цахим орчин нь хүн төрөлхтний амьдралын салшгүй нэг хэсэг болоод байна. Тиймээс энэхүү судалгаагаар, цахим гэмт халдлагын эрх зүйн орчныг судлах, цахим гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх, практикт нөлөөлж буй хүчин зүйлүүдийг тодорхойлон, хохирогчийн эрх зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн санал, зөвлөмж боловсруулна.

Abstact: In this era of rapid development of technology, the internet or electronic environment has become an integral part of human life, which has a great impact on daily life, business, and organizational activities. Therefore, in this study, we will study the legal environment of cybercrime prevention and practice, and develop suggestions and recommendations aimed at solving the legal issues of victims.

Түлхүүр үг: цахим гэмт халдлага, цахим халдлага, урьдчилан сэргийлэх

Key word: Cybercrime attacks, cyberattacks, prevention of cybercrime

Оршил:

Саяхан л гар утас гэж юу вэ? Утсаар холбогдоогүй хэрнээ бусдыг ойртуулж хүмүүсийг хооронд холбох хэрэгсэл болж байгаа нь өөрөө гайхамшиг юм гэх зэрэг гайхан шагшин байсан үе маань ердөө 20 хан жилийн өмнө монгол улсад үүрэн телефон, интернэт орчин орж ирж байсан мөн технологийн дэвшил хөгжлийн шинэ боломж олгохын зэрэгцээ нийгмийн бусад сөрөг үзэгдлүүдийг ч дагуулсаар тэдгээрийн нэг нь “Цахим” гэмт хэрэг буюу “Цахим гэмт халдлага” юм.

Энэхүү гэмт хэргийн талаар хэд хэдэн тодорхойлолт байдаг боловч /компьютер болон цахим сүлжээ ашиглаж бусдын эд хөрөнгө, алдар нэр, хувийн нууц, аюулгүй байдал, өдөр тутмын хэвийн үйл ажиллагаанд нь хууль бусаар халдаж буй өөр өөр төрлийн гэмт хэргийн нийлбэр/ хэмээн хамгийн энгийнээр тайлбарлаж болно.

Энэхүү гэмт хэргийг үйлдэгчдийн тоо жил бүр нэмэгдэж, арга хэлбэр нь илүү боловсронгуй, залуус тэр тусмаа бага насны этгээдүүд холбогдох сонирхол татахаар байна. Иймд цахим гэмт хэрэг гэж юу болох, түүний онцлог шинж чанар, гэмт этгээдүүдийн үйл ажиллагааны талаар ойлголт, мэдээлэлтэй болсноор хохирогч болохоос урьдчилан сэргийлэх боломжтой.

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооноос гаргасан судалгаагаар Монгол Улсад 2016 оны байдлаар давхардсан тоогоор 2.512.100 интернэт хэрэглэгч байгаагаас 30 сүлжээний хэрэглэгч 90.97 хувийг эзэлж, нийт хэрэглэгчийн хамрах хүрээ 86.7 хувь нь Улаанбаатар хотод, 10.3 хувь нь аймгуудад, 2.9 хувь нь сумдад, интернэт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 59 аж ахуй нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Монгол улсад 1990 он гарснаар орж ирсэн шинэ төрлийн гэмт хэргүүдийн нэг бөгөөд энэ нь Дэлхийн улс орнуудаас жишээ нь: “АНУ-д цахим гэмт хэрэг хамгийн ихээр үйлдэгддэг бөгөөд Холбооны мөрдөх товчоо жилд 300 мянга орчим, өдөрт 900 гаруй цахим гэмт хэрэгтэй холбоотой өргөдөл, гомдол хүлээн авдаг байна. Хэдийгээр цахим гэмт хэргийн объект өргөн хүрээг хамардаг ч гэмт этгээдүүд богино хугацаанд өндөр ашиг олох боломжтой хэмээн үзэж хувь хүн болон байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг цахим халдлагын бай болгох сонирхолтой байдаг”

Үүнээс гадна “Facebook”, “Twitter” зэрэг нийгмийн сүлжээг ашиглан цахим гэмт хэрэг үйлдэгчид жилд тутам их хэмжээний хохирол бусдад учруулдаг бөгөөд хохирогчдын тоо жил бүр нэмэгдсээр байна. Энэ төрлийн гэмт хэргийн дотроос нийгмийн сүлжээ хэрэглэгчдийн нэвтрэх нэр, нууц үг, дансны болон

зээлийн картын мэдээлэл зэрэг хувийн мэдээллийг хулгайлах, бусдад зарж борлуулах явдал хамгийн түгээмэл хувийг эзэлдэг.

Цахим гэмт хэргийн хамгийн түгээмэл хэлбэрүүдэд “фишинг” буюу интэрнетээр залилан үйлдэх, “сошиал инженерчлэл” буюу хувь хүний сэтгэл зүйн онцлогийг харгалзан сэдэл /мөнгө хожих, тэтгэлэг авах зэрэг/ өгч, итгэл төрүүлэх замаар мэдээлэл цуглуулах, нууцад нэвтрэх болон компьютерийн сүлжээнд төрөл бүрийн вирус, хортой код тараах зэрэг аргууд багтдаг.

АНУ-ийн “Accenture securtiy” байгууллагын 2019 оны “Кибер гэмт хэргээс учирсан хохирол”-ийн талаарх тайланд дурдсанаар “фишинг” болон “сошиал инженеринг” хэлбэрийн халдлагад өртсөн байгууллагын тоо 2018 онтой харьцуулахад 16 хувиар өсч, нийт цахим халдлагад өртсөн байгууллагын 85 хувийг эзэлж, Харин хортой код ашиглаж үйлдсэн халдлагын улмаас 2018 онд 2.6 сая ам.долларын хохирол учирсан нь өмнөх оноос 11 хувиар өссөн үзүүлэлттэй байна гэсэн мэдээлэл хийж байжээ.

Харин австралийн их сургуулийн судалгаагаар, биткоин нь цахим гэмт хэрэгтнүүдийн төлбөрийн хамгийн таатай хэрэгсэл бөгөөд жилд 76 орчим тэрбум ам.долларын биткоин гүйлгээ хийгдэж байгаа нь АНУ, Европын Холбооны орнууд дахь хар тамхи, мансууруулах бодисын хууль бус худалдаанаас олох ашиг орлоготой тэнцэж байна хэмээн дүгнэжээ. АНУ-ийн цахим аюулгүй байдлыг хангах байгууллага 2021 он гэхэд криптовалют ашиглан үйлдэгдэх цахим гэмт хэргийн тоо мэдэгдэхүйц хэмжээгээр өсөх бөгөөд нийт криптовалютын гүйлгээний 70 орчим хувь нь гэмт хэрэгтэй холбоотой байна хэмээн тооцоолжээ

Иймээс улс орнууд цахим гэмт хэрэгтэй тэмцэхэд анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай байгаа бөгөөд манай улсад энэ төрлийн гэмт хэрэг нийлээд ажиглагдах, цаашлаад өсөх хандлага харагдаж байгаа юм. Монгол улсын эрүүгийн хуульд энэ төрлийн гэмт хэргийн үйлдэл, эс үйлдэхгүйг нарийвчлан тусгах нь цаашид энэ төрлийн гэмт хэргийг зөв ангилан оногдуулах зүйл заалтад чухал ач холбогдолтой юм.

Үндсэн хэсэг

Манай улсын хувьд цаг тутамд өсөн нэмэгдэж буй компьютер, ухаалаг утасны хэрэглээг дагаад цахим гэмт хэргийн тоо жил бүр нэмэгдэж байгаа билээ. Цахим гэмт хэргийн талаар төдийлөн хангалттай мэдээлэл байхгүй ухаалаг үйлдэлд суурилсан ажлыг хөнгөвчилсөн гэх ойлголтууд нь нийтлэг яригдах боловч түүнээс үүсэх үр дагавар аюулгүй байдал одоо цагт хурцаар тавигдаж байгаа зүйл юм.

Монгол улсын эрүүгийн хуулийн тусгай ангийн

- 13.10 дугаар зүйл. Хувь хүний нууцад халдах хэсэгт “Хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг хууль бусаар олж авсан, бусдад дамжуулсан бол...” Энэ

гэмт хэргийг харилцаа холбоо, цахим хэрэгсэл ашиглаж үйлдсэн бол хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй.

- 16.9 дүгээр зүйл. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах "Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэсэн, борлуулсан, тараасан, хадгалсан бол .." Энэ гэмт хэргийг цахим сүлжээ ашиглаж үйлдсэн.

- 17.3 дугаар зүйл. Залилах "Хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан бол ....."

- 26.1 дүгээр зүйл. Цахим мэдээлэлд хууль бусаар халдах "Цахим төхөөрөмж, мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдаж компьютерийн өгөгдөл, системд нэвтэрсэн, танилцсан бол..."

мөн "Цахим төхөөрөмж, мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдаж мэдээллийг устгасан, гэмтээсэн, өөрчилсөн, засварласан, хуулбарлаж авсан, мэдээлэл нэмж оруулсан, программ хангамж, сүлжээг ашиглах боломжгүй болгосон, хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан; компьютерийн өгөгдлийг нуусан, хандалтад хязгаарлалт тогтоосон, компьютерийн системд санаатайгаар хууль бусаар мэдээлэл дамжуулсан, үйл ажиллагааг хязгаарласан; мэдээлэл хадгалагдаж байгаа төхөөрөмжийг устгасан, гэмтээсний улмаас бусдын хууль ёсны ашиг сонирхолд хохирол учирсан бол....."

- 26.2 дугаар зүйл. Цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдах программ, техник хэрэгсэл бэлтгэх, борлуулах "Цахим төхөөрөмж, мэдээллийн хамгаалалттай сүлжээнд хууль бусаар нэвтрэх тусгай программ, техник хэрэгслийг бэлтгэсэн, борлуулсан бол..."

- 26.3 дугаар зүйл. Хор хөнөөлт программ хангамж бүтээх, ашиглах, тараах" Цахим төхөөрөмжид хадгалагдаж байгаа мэдээллийг зөвшөөрөлгүйгээр устгах, гэмтээх, өөрчлөх, хуулбарлах, мэдээлэл олж авах, программ хангамж, мэдээлэл хадгалагдаж байгаа төхөөрөмж, сүлжээг ашиглах боломжгүй болгох, хэвийн үйл ажиллагааг алдагдуулах зориулалттай хор хөнөөлт программ хангамжийг тусгайлан зохиосон, зориудаар ашигласан, санаатай тараасан бол ....."

Гэх зүйлчлэлээр тусгасан байдаг нь гэмт хэргийн өнөөгийн нөхцөлд төдийлөн ханалттай хэмжээнд шалгагдахгүй гэмт хэргийн шинжийг агуулсан зарим үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохгүй өнгөрөх зэрэг цахим гэмт хэргийн нийгэмд учруулж буй хор хөнөөлийг бүрэн тодорхойлох зөв зүйлчлэл хийхэд хүндрэл учруулж байна.


Монгол улсын цагдаагийн ерөнхий газрын нийт гэмт хэргийн талаарх мэдээллээс үзэхэд

Хүснэгт №1[118]

[118] Цагдаагийн ерөнхий газрын статистек мэдээ 2020 он

№	Цахим мэдэлэллийн аюулгүй байдлын эсрэг				
Эрүүгийн хуулийн 26.1. - 26.3.	2017	2018 он	2019 он	2020 он	2021 он Эхний 3-р сарын байдлаар
	43	42	47	119	134

График №1



Энэхүү хүснэгтээс харахад 2017 оноос хойш монгол улсад цахим гэмт хэрэг буюу цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн гаралтын тоон үзүүлэлт өссөн харагдаж байна. Энд зөвхөн гэмт хэргийн талаарх санал гомдол хүлээн авч хэрэг нээсэн талаарх мэдээлэл байгаа бөгөөд иргэдээс ирсэн гомдол санал нь сүүлийн жилүүдэд 500-аас дээш бүртгэгдэж байгаа гэж мэдээлсэн байдаг.

Баримт1: Улаанбаатар хотод оршин суух эрхэлсэн тодорхой ажилгүй М, Б нар нь цахим орчинд бусдын зургийг зөвшөөрөлгүй байршуулан хуурамч фэйсбүүк хаяг үүсгэж иргэдтэй танилцан дотносох замаар хувийн мэдээлэл видео бичлэгийг цуглуулсан байна.

Эдгээр залуус хувь хүний мэдээллийг олон нийт, найз нөхдөд нь тараана хэмээн сүрдүүлж зургаан иргэнээс их хэмжээний мөнгө авсан гэмт үйлдлийг бүлэглэн үйлдэж байсныг таслан зогсоож, Чингэлтэй дүүргийн цагдаагийн нэгдүгээр хэлтэст эрүүгийн хэрэг үүсгэн тус тус шалгагдаж байна[119].

Баримт2: Facebook орчинд садар самууныг сурталчилсан группүүдэд эмэгтэй хүний зураг ашигласан хуурамч хаягаар “Video call” хийнэ, “Video чат” хийнэ гэх мэт утгатай зар байршуулж, урьдчилгаа мөнгө авах замаар бусдыг залилан мэхэлдэг, мөн хохирогч өөрийн жинхэнэ хаягаар харилцсан тохиолдолд бичсэн чат мэдээлэл болон илгээсэн зураг зэргийг гэр бүл, найз нөхөд рүү тараана гэх мэтээр мөнгө нэхэн заналхийлэх үйлдэл хийдэг тодорхой эрхэлсэн ажилгүй

[119] Цахим гэмт хэрэгтэй тэмцэх алба 2016 он /https://police.gov.mn/a/2287/

“Д” гэгчийг Эрүүгийн цагдаагийн албаны Cyber гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс илрүүлэн шалгаж байна.

Уг этгээд нь урьдчилгаа хэлбэрээр хохирогчоос 10.000 – 40.000 төгрөг авч видео дуудлага хийнэ гэж залилдаг, мөн харилцах явцдаа олж авсан мэдээллээ барьцаалж мөнгө нэхдэг, мөнгө өгөхгүй бол гэр бүл, найз нөхөд рүү нь мэдээллийг нь олон нийтийн сүлжээгээр тараана гэх зэргээр заналхийлж 100.000–300.000 төгрөгийг бусдаас авч байсан талаараа мэдүүлсэн.

Монгол улсын цагдаагийн ерөнхий газар нийт гэмт хэргийн судалгаа нь эрүүгийн хуулийн тусгай ангийн 26.1-26.3 хүрээнд авагдсан нь цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт холбогдуулан завдсан учир энэ төрлийн гэмт хэргийн бүрэн шинжийг илэрхийлж чадахгүй байна. Цахим гэмт хэрэгт өөр төрлийн гэмт хэрэг давхар зүйлчлэлийн шинжийг агуулж байгаа тул гэмт хэрэг зүй тогтлыг харгалзах нь чухал зүйл болоод байна.

Хүснэгт №2 [120] Энэ төрлийн гэмт хэргийн шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн хэргийг шүүхийн шийдвэрээс түүвэр хийн харуулбал:

№	Шүүхийн нэр	Огноо	Дугаар	Шүүгч	Зүйл хэсэг
1	Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2018-11-29	914	Ц.Д	26.1.1.,
2	Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2018-08-28	735	Б.Д	17.6.1., 26.1.2.,
3	Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2018-05-01	156	Д.А	26.1.2.,
4	Баян-Өлгий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2018-01-29	023	П.Д	26.1.1.,
5	Сонгино хайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2019-12-19	1354	Б.Б	17.3.1., 26.1.1.,
6	Сонгино хайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2019-08-30	812	Б.Б	17.1.1., 26.1.1.,

[120] Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сан 2018-2021 онд шийдэгдсэн хэргүүд https://shuukh.mn/cases

7	Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2019-12-02	1813	Т.Ш	26.1.2.,
8	Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2019-08-08	1255	Д.М	26.1.2.,
9	Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2019-05-27	852	Н.Б	26.1.2.,
10	Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2019-05-21	815	Н.Б	26.1.2.,
11	Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2019-07-22	731	Д.М	26.1.2.,
12	Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2019-03-29	299	Б.Д	18.6.1., 26.1.1.,
13	Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2019-01-03	34	Д.Р	26.1.2.,
14	Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2019-01-02	20	Ё.Ц	26.1.2.,
15	Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2020-08-18	747	Ц.М	26.1.2.,
16	Дорнод аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2020-08-05	2020/Ц ШТ/245	Г.Н	26.1.2.,
17	Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2020-06-04	537	Б.М	17.3.1., 26.1.1.,
18	Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2020-06-03	1028	Ц.А	26.1.2.,
19	Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2020-06-03	00188	М.Э	26.1.1.,

20	Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2020-05-27	406	Д.Р	26.1.2.,
21	Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2020-04-24	254	И.Г	26.1.2.,
22	Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2020-04-24	256	Н.М	26.1.2.,
23	Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2020-04-10	351	А.А	17.3.1., 26.1.2.,
24	Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2020-03-30	305	Ц.М	26.1.2.,
25	Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2020-01-28	94	С.Б	26.1.2.,
26	Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2021-01-25	2021/ШЦТ/35	М.Э	17.3.1., 26.1.1.,
27	Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	2021-03-09	2021/ДШМ/236	Н.Б	26.2.1.,
28	Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	2020-07-07	878	С.С	23.2.1., 26.1.2.,
29	Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	2020-06-04	730	Ш.Б	26.1.2.,
30	Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	2020-05-14	618	Н.Б	26.2.1.,
31	Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	2020-04-02	580		26.1.2.,
32	Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	2020-01-30	151		26.1.2.,

33	Булган аймгийн эрүү, иргэний давж заалдах шатны шүүх	2020-04-02	16		26.2.1.,

График 2



2017 онд Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг шүүхээр шийдвэрлэсэн байхгүй. Харин он өнгөрөх тусам, сүүлийн жилүүдэд илүү нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. 2021 оны үзүүлэлтийн хувьд 2021 оны эхний 3 сарын хугацаанд шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг тул цаашид нэмэгдэх хандлагыг тодорхойлж болохоор байна.[121]

Харилцаа холбооны зохицуулах хорооноос гаргасан судалгаагаар 2017 оны арван хоёрдугаар сарын 31-ний өдрийн байдлаар манай улсад 2.910.778 интэрнет хэрэглэгч байгаагаас Мобил дата, буюу ухаалаг гар утсаар интэрнет хэрэглэгч 90.21 хувийг эзэлж байна. Өрх гэр болгон интэрнеттэй, хүн болгон ухаалаг гар утас хэрэглэгч, интэрнет хэрэглэгч болсон гэхэд хилсдэхгүй. Гэвч энэ өсөлт хөгжлөө дагаад цахим орчинд хуурамч нэр хаягаар өсвөр насны хүүхдүүдийг буруу, хорт зуршил уруу татах, хүчирхийлэл, садар самууныг сурталчлах, дарамтлах, залилах, хууран мэхлэх гэмт хэргүүд ихээр гарах болсон. Эдгээр хүчин зүйлсийг авч үзвэл эцэг, эхчүүд, асран хамгаалагч нарын хяналт сул, анхаарал болгоомж, мэдээлэлгүй гээс болоод энэ төрлийн гэмт үйлдлүүд гарсаар байгааг цагдаагийн байгууллагаас сануулж, олон талын урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлуудыг зохион байгуулсан бөгөөд Цагдаагийн Ерөнхий Газраас зөвлөмж болгож кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нийтлэг 10 аргыг танилцуулсан.

Иргэд, олон нийтэд гэр бүлээ цахим гэмт хэрэгт өртөхөөс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар ямар алхмуудыг хийх ёстой вэ. Үүнд:

- Компьютерын системээ шинэчилж байх
- Системийн тохиргоогоо хамгаалах

[121] Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сан 2018-2021 онд шийдэгдсэн хэргүүд https://shuukh.mn/cases

- Нэвтрэх үг буюу нууц үгээ сайжруулж, хамгаалах
- “Галт хана”-аа асаалттай байлгах
- Вирусны эсрэг программ суулгах буюу түүнийгээ шинэчилж байх
- Хувийн мэдээллээ хамгаалах
- Веб сайтын нууцлалын бодлогыг хэвлэн авч, анхааралтай унших
- Санхүүгийн мэдээлэл, дансны хуулгаа тогтмол хянах
- “Үнэгүй зүйл зөвхөн хавханд л байдаг” буюу танд маш их аз тохиолдоход эргэлзэн нягтлан шалгаж байх
- Компьютероо унтраах[122]

Гэх арга зааварчилгааг гарган танилцуулж байсан нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний нэг хэлбэр болгон танилцуулж байгаа боловч иргэдэд төдийлөн хүрч хүрч чадахгүй сайтад мэдээлэл хэлбэрээр байршуулсан байдал хангалттай бус харагдаж байна.

Олон улсын хэмжээнд цахим халдлагын талаар дараах хэлбэрүүд их түгээмэл шинжтэй болсон байна. Үүнд: Олон нийтийн мэдээллийн хэрэгслийг таны цахим аюулгүй байдлыг хорлох түгээмэл аргуудын хэсгээс

1. Хэт их хувийн мэдээлэл өгөх. /Та өөрийгөө эсвэл танай компанийг төлөөлж байгаа эсэхээс үл хамааран төрсөн он сар өдөр, сургуульд сурч байсан газар, гэр бүлийн гишүүдийн нэр, зураг зэргийг хуваалцахаас зайлсхий. Эдгээр нь таних хулгайч нарын ихэнх нь таны дансанд нэвтрэх, эсвэл хувийн мэдээллээ ашиглан зээлийн карт авахад хангалттай юм.
2. Хортой программ. Ихэнх хортой программууд имэйл, татаж авах холбоосууд дотроо нуугддаг бол богиносгосон URL-уудаар дамжуулан олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тарааж, эсвэл нийгмийн мэдээллийн зар дотор нуугдаж болно. Хэрэглэгч холбоос дээр дарж, Instagram-ийн ердийн профайлыг үзэх гэж байгаа бөгөөд дараа нь өөрсдийгөө кибер халдлагад өртөх боломжтой гэж бодож байна.
3. Муурын загас. Гэсэн хэдий ч онлайн болзооны хамгийн нийтлэг бэрхшээлүүдийн нэг бол загас барих явдал бөгөөд таны хамтрагч таних тэмдгээ хуурамчаар үйлддэг.
4. Нүүр хуудас. Та амралтаараа баяртай байх болно, гэхдээ та үндсэндээ танихгүй хүмүүст гэртээ байхгүй цагийг яг хэлж байгаа нь тэдэнд үнэ цэнэтэй зүйлийг нэвтэрч, хулгайлахад хангалттай цаг хугацаа өгдөг.
5. Баталгаагүй гар утасны төхөөрөмжүүд. Өөр хэн нэгэн таны хамгийн хувийн мэдээлэл, харилцан ярианд шууд нэвтрэх боломжтой болох юм. Та ядаж утсаа хүчтэй нууц үгээр хамгаалаарай.[123]

Улс орнууд картын дугаартаа 4-н оронтой 80% болон 6-н оронтой 20% хэлбэрээр оруулдаг энэ нь “All credit card PIN numbers in the World leaked” Дэлхийн

[122] Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмж нийтлэлэ 2018 он http://eagle.mn/r/49343

[123] https://www.ccsinet.com/blog/social-media cybersecurity/?fbclid=IwAR1evXVbnziQynM01VwoG0KUNUVwCw3uxZfNbZvNu4Gn0at82UL9SSPRW5w

бүх зээлийн картын ПИН дугаарууд ил боллоо гэх мэдээлэл дээр суурилагдаг пин кодийг хэрхэн олох таамаглах талаар pin analysis –ийн судалгаанаас харж болох юм.

- Хамгийн алдартай нууц үг бол 1234 3.4 сая нууц үгийн бараг 11% нь 1234 байна !!!
- Ашиглагдаж буй хамгийн алдартай 4 оронтой PIN код нь 1111 бөгөөд 6% -иас дээш нууц үг ашигладаг.
- Гуравдугаарт 0000 бараг 2% -тай байна.
- Шилдэг 20 нууц үгийн хүснэгтийг доор харуулав. Эдгээр 20 хослолыг туршиж үзэхэд бүх нууц үгсийн 26.83% -ийг таамаглаж болох юм!

(Статистикийн хувьд 10,000 боломжит хослолтой бол нууц үгийг санамсаргүй байдлаар тараасан тохиолдолд эдгээр хорин нууц үгийг нийт дүнгийн 26.83% -ийг биш зөвхөн дөнгөж 0.2% -ийг эзэлнэ гэж найдаж байна)

1122 ба 1313 гэх мэт загварууд жагсаалтад дээгүүр гарч ирдэг.

2001 он #19-т гарч ирэв. 1984 он 26-р байрнаас холгүй араас нь дагаж яваа бөгөөд Жеймс Бондын фэнүүд 237-р байрын хооронд 0007 байгааг олж мэдэхийг сонирхож магадгүй юм (өөр хувилбар 0070 # 28-ийн ард нэг их удаагүй байна)[124].

Хүснэгт №3

PIN	Freq	%	PIN	Freq	%
#1	1234	10.713%	#11	9999	0.451%
#2	1111	6.016%	#12	3333	0.419%
#3	0000	1.881%	#13	5555	0.395%
#4	1212	1.197%	#14	6666	0.391%
#5	7777	0.745%	#15	1122	0.366%
#6	1004	0.616%	#16	1313	0.304%
#7	2000	0.613%	#17	8888	0.303%
#8	4444	0.526%	#18	4321	0.293%
#9	2222	0.516%	#19	2001	0.290%
#10	6969	0.512%	#20	1010	0.285%

Хакерууд нууц үгийг таамаглаж олдог бөгөөд тэд гэрийн тэжээвэр амьтадын нэрийг, хүүхдийнх нь төрсөн өдөр, эсвэл тэмдэглэлт ойн баярын өдөр зэргийг нь олон нийтийн сүлжээ болон нээлттэй бусад интернэт эх сурвалжаас олж мэддэг байна. Энд иргэд хамгийн ойрын эсвэл хамгийн дурсамжит зүйлдээ тулгуурлан нууц үгийг оруулдаг нь алдаа болдог байна.

Мөн Фишинг имэйлүүд нь танай банк, таны ажил олгогч эсвэл найз гэх мэт найдвартай эх сурвалжаас ирсэн мэт харагддаг, гэхдээ үнэхээр хакерууд болон

[124] Nicole Dahya, Information Technology Services, 2019 https://now.uiowa.edu/2019/09/avoid-these-10-common-phishing emails?fbclid=IwAR0bOsWc2QthtFDFNgH0ag7CL6p0BmaCIJY2jaTjmomNd_iBkiikgbJg6XE

хуурамч уран бүтээлчдээс ирдэг. Имэйл нь таныг компьютерт хортой программ татаж авах эсвэл нууц үг, дансны дугаар эсвэл бусад хувийн мэдээллийг илчлэх линк дээр дарж хуурахыг оролддог[125].

Иймд цахим халдлага ба түүнээс урьдчилан сэргийлэх арга өнөөгийн бидний амьдралд зайлшгүй зүйлийн нэг ялангуяа монгол улсын хувьд энэ төрлийн гэмт хэрэг жил ирэх тусам нэмэгдэж байгаа нь сэтгэл түгшээсэн зүйлсийн нэг юм.

Дүгнэлт, санал:

Цахим гэмт халдлагын үндсэн дараах төрлүүд голлох байр эзэлж байгаа бөгөөд эдгээр шинжүүд монгол улсын хэмжээнд сүүлийн жилүүдэд ихсэх хандлагатай байгаа нь харамсалтай. Жишээ нь:

- Танаас хувийн мэдээлэл хүссэн сэжиг бүхий мэйл, хуудас нь хэрэгтний өгөөш, гэмт үйлдлийн халхавч байдаг бөгөөд таны мэдээллийг ашиглан залилан мэхлэх шинж.
- Фэйсбүүктээ гар утас, ажил болон гэрийн хаяг зэргээ бичихгүй байх, Ямар нэгэн зүйл бичихдээ "Location" буюу байршлаа бусдад мэдэгдэхгүй байх энэ нь гэмт этгээдэд өөрийн орон байр эзэнгүй байгааг мэдээлж байгаа хэлбэр болдог.
- Чатаар найз орж ирээд сэжигтэй яриа өрнүүлбэл, мөн ямар нэгэн тусламж хүсэхдээ мөнгөн хэлбэрээр яаралтай тусламж хүссэн хүн рүү шууд утсаар холбогдон баталгаажуулах.
- Эх үүсвэрийг нь мэдэхгүй болон бусад сугалаа шалгах холбоос дээр дарахгүй байх. Энэ нь сэжиг бүхий дүрс бичлэг, зураг нь үнэндээ таны хувийн мэдээллийг хулгайлах зорилготой хортой программ байдаг. Спам, хуурамч мэйлд хуурагдсанаар та хувийн чухал мэдээллээ кибер гэмт хэрэгтэнд алдах нөхцөл болдог. [126]

Эдгээр үндсэн аргууд нийтлэг хэрэглэгдэж бусдыг хохироох үйлдэл гарсаар байна. Цахим гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх арга замыг нарийн тодорхойлох нь энэ төрлийн гэмт хэрэг хэрхэн гардаг Монгол улсын эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар илүү нарийн гэмт хэргийн шинжийг тусган хуульчлан оруулах нь зайлшгүй тулгамдсан асуудлын нэг болж байна. Үүнд урьдчилан сэргийлэх дараах хэлбэрүүдийг хувь хүн болгон хэрэглэж сурах үүнд:

- 2 factor authentication буюу тухай бүр солигдох шинжтэй давхар код оруулж хэвшүүлэх
- Нууц код ашиглахдаа өөрийн том жижиг үсэг, тоо, тусгай тэмдэг орсон байх мөн олон төрийн нууц кодыг нэгэн ижил хэлбэрээр оруулахгүй байх нь маш чухал

---

[125] Nicole Dahya, Information Technology Services, 2019 https://now.uiowa.edu/2019/09/avoid-these-10-common-phishing-emails?fbclid=IwAR0bOsWc2QthtFDFNgH0ag7CL6p0BmaCIJY2jaTjmomNd_iBkiikgbJg6XE

[126] Л.Ганбаатар, мэдээллийн аюулгүй байдлын эрх зүйн асуудал: цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь http://galbaatar.blogspot.com/ 2018 он

- Хэд хэдэн хаяг үүсгэж түүнийг эргэх холбоо бүхий ашиглах, нэг майл хаягт бусад хаяг болон мэдээлэл авах болгон холбохгүй байх.
- Танд ирж байгаа мэйл нь бодит уу мэйл хаягтай холбоотой, нууц үг солих болон шинээр авах гэсэн мэйлыг заавал шалгах

Одоо мөрдөгдөж байгаа монгол улсын эрүүгийн хуулийн тусгай ангийн 26-р бүлэг "Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг" нэмэлтээр дээрх нөхцөлөөр халдаж байгааг гэмт хэргийн зүйлчлэл болгон ял ногдуулахаар хуульчлан оруулах нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хийгээд энэ төрлийн гэмт хэрэг дахин үйлдэгдэхээс сэргийлэх гол хүчин зүйл болно. Жишээ нь: "Хуурамч мэйл хаягаар бусад хүний нууц үгийг олж аван өөрчилсний улмаас харилцах данснаас нь мөнгө хулгайлсан, завшсан, бусад найз нөхдөөс нь мөнгөн тусламж үзүүлэхийг шаардсан, бусадтай харилцдаг нэр төрийг буруугаар ашиглан хохирол учруулсан, бусдад буруу ойлголт төрүүлэн нэр төрд халдсан бол.." гэх нарийн зохицуулалтаар зүйлчлэл оруулах нь зүйтэй байна.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

Монгол эх сурвалж

1. Ч.Батзориг., "Цахим орчин дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох эрх зүйн зохицуулалт /харьцуулсан судалгаа/" 2018 он,
2. Г. Бямбажаргал, "Цахим гэмт хэргийн талаарх онцлох баримтууд" 2020 он нийтлэл
3. Л.Ганбаатар, "Мэдээллийн аюулгүй байдлын эрх зүйн асуудал: цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь" 2018 он эрдэм шинжилгээний өгүүлэл
4. Д.Сумъяацэрэн, "Монгол Улс дахь кибер гэмт хэргийн нөхцөл байдал, үйлдлийн арга, урьдчилан сэргийлэх асуудал", 2017 онд хэвлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүлэл.

Эрх зүйн эх сурвалж

1. Монгол улсын үндсэн хууль 1992 он
2. Монгол улсын эрүүгийн хууль 2015 он

Бусад эх сурвалж

1. Тагнуулын ерөнхий газрын цахим мэдээллийн сан: сонирхуулах булан
2. Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сан 2018-2021 онд шийдэгдсэн хэргүүд https://shuukh.mn/cases
3. Цагдаагийн ерөнхий газрын статистик мэдээ 2020 он
4. Цахим гэмт хэрэгтэй тэмцэх алба 2016 он https://police.gov.mn/a/2287
5. Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмж нийтлэл 2018 он http://eagle.mn/r/49343

Гадаад цахим эх сурвалж

1. https://gia.gov.mn/49/item/643?fbclid=IwAR0ZHXKUWskShqpJGK9diBw1V0eAwqhrDL6Bnh4ucrBy1McuDEuka-i1Qg8

2. https://www.ccsinet.com/blog/social-media-cybersecurity/?fbclid=IwAR1evXVbnziQynM01VwoG0KUNUVwCw3uxZfNbZvNu4Gn0at82UL9SSPRW5w
3. https://www.datagenetics.com/blog/september32012/?fbclid=IwAR03KjzN8-IlekRMMD_44skY1KY0xlq3AKv0z7ZA3ASkMk0D_kmZVwg9dQU
4. Megan Kaczanowski 2020 /#INFORMATION SECURITY https://www.freecodecamp.org/news/an-intro-to-password-cracking/?fbclid=IwAR1sbA0FLerhWnZqxWGt8DN_0K3z1H6CudYWxuUeNCoSmoF-v1oi3gHN_
5. Nicole Dahya, Information Technology Services, 2019 https://now.uiowa.edu/2019/09/avoid-these-10-common-phishing-emails?fbclid=IwAR0bOsWc2QthtFDFNgH0ag7CL6p0BmaCIJY2jaTjmomNd_iBkiikgbJg6XE

---o0o---

СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРЛЫГ ТООЦОХ, АРИЛГАХ ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРОН БОЛОН МОНГОЛ УЛСЫН ТУРШЛАГЫГ ХАРЬЦУУЛАН ДҮГНЭСЭН БАЙДАЛ

EXPERIENCE OF FOREIGN COUNTRIES IN CALCULATING AND ELIMINATING MORAL DAMAGE



Ч.Отгонсүрэн
Дотоод хэргийн их сургуулийн
Хилийн албаны сургуулийн ахлах багш,
хууль зүйн ухааны магистр, докторант, дэд хурандаа

Товч агуулга: Сэтгэл санааны хохирлыг тооцож буй олон улсын туршлага, Монгол Улсад хийгдэж байгаа сэтгэл санааны хохирлыг тооцох үнэлгээний аргачлалыг харьцуулан дүгнэлт, саналаа дэвшүүлсэн болно.

Abstact: In this work international experience in calculating moral damage, comparative conclusion of applied methods of calculating moral damage in Mongolia and suggestions are proposed.

Түлхүүр үг: Гадаад улс орнуудын сэтгэл санааны хохирлыг үнэлэх, арилгах талаарх туршлага.

Key word: experience of foreign countries in calculating and eliminating moral damage

Манай Улсад Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14-т Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр заасан нь гэмт хэргийн улмаас хүний сэтгэл санаанд учирсан хор уршгийг арилгуулахаар шүүхэд гомдол гаргаж, шийдвэрлүүлэх эрх зүйн үндсийг зааж өгсөн байдаг. Гэвч эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хийгдсэн Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шинжилгээний тухай хуулиудад гэмт хэргийн улмаас хүний бие, эд хөрөнгөд учирсан бодит хохирол, гэм хорыг арилгах талаар зохицуулалтыг боловсронгуй болгосон боловч эдийн бус гэм хор тэр дундаа сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох, шүүхээр шийдвэрлүүлэх эрх зүйн орчин саяхныг хүртэл тодорхойгүй байсан билээ[127].

[127] Монгол Улсын үндсэн хууль 16.14

Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд, сэтгэл санаанд буюу сэтгэцэд учирсан хор уршгийг хэрхэн ойлгох, ямар гэмт хэргийн улмаас хохирсон хохирлыг ямар шаардлагыг үндэслэн тооцох, ямар шалгуур үзүүлэлттэй байх зэрэг зохицуулалт байхгүй байна.

Ийнхүү эрх зүйн зохицуулалт дутмаг байгаагаас гэмт хэргийн улмаас хохирсон хохирогч өөрт учирсан хохирлоо бодитой, бүрэн төлүүлэх эрхээ эдэлж чадахгүй байна

Энэ нь нэг талаас Монгол Улсад гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн амь нас, эрүүл мэнд, сэтгэл санааны хохирол, эсхүл сэтгэцийн хор уршгийг тооцохдоо зөвхөн нотлох баримтад тулгуурлан эмчилгээ, оршуулга, тээврийн зардлын баримтыг харгалзан хохирлыг тооцож байна. Өөрөөр хэлбэл зөвхөн учирсан бодит хохирлыг шүүхээс тооцож байгаа бол эдийн бус хохирол болох сэтгэл санааны хохирол буюу сэтгэцийн хор уршгийг хэрхэн тооцох нь тодорхойгүй байгаагаас хохирлыг тооцолгүй орхигдуулж байна.

Нөгөөтэйгүүр гэмт хэргийн улмаас сэтгэл санааны хохирол буюу сэтгэцийн хор уршиг хүлээсэн этгээд нь өөрт учирсан сэтгэл санааны хохирлоо нэхэмжилдэггүй, шүүхэд гаргасан цөөн нэхэмжлэлийг шүүхээс хэрэгсэхгүй болгодог зэргээр хүний эрхийг бодитой эдлүүлэх боломжоор хангахгүй байсан хэдийч өнөөдрийн байдлаар Монгол Улсад Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг эцэслэн баталагдаж, хуулиар шүүх шинжилгээ хийх процессыг нарийвчлан зохицуулж, олон нийтийн дунд сэтгэл санааны хохирол гэж яригдаж ирсэн сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг шүүх шинжилгээгээр тогтоох, шүүх мөнгөн дүнгээр үнэлэх, хохирлыг барагдуулах үйл ажиллагааг тусгаж, эрүү, иргэний зэрэг хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулж хуульчилсан.

Гэмт хэргийн хохирогчид сэтгэл санааны хохирлыг ялгамжтай тогтоож ирсэн байдал арилж, хүн бүрт хууль тэгш, хүртээмжтэй үйлчлэх боломж бүрдэж, хохирогчийн хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах, эдийн болон эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх харилцаанд ахиц дэвшил гарах боломжтой болсон гэж үзэж байна[128].

Хуульд сэтгэл санааны хохирлыг тодорхойлохдоо хүний сэтгэл зүйн хямрал янз янзын байдлаар илэрдэг ба энэ талаарх тодорхой аргачлалыг ХЗДХЯ болон ЭМЯ-аас баталж, Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгээс сэтгэл зүйд учраад буй хямралын зэрэглэлийг тогтоож шүүх нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тодорхойлно гэж заасан байна.

Хүний сэтгэл санаанд учирч буй хор уршгийг мөнгөөр үнэлж баршгүй хэдий ч уг асуудлыг орхигдуулж болохгүй гэж үзэн Шүүх шинжилгээний тухай хуулиар шинэчлэн оруулж баталсан нь бидний нэг том алхам гэж үзэж байна.

Зарим Улс орнуудад иргэнээ хохироохгүйн тулд сэтгэл санаа, эд эрхтэн, амь насыг “үнэлдэг” жишиг олон улсад аль хэдийнээ тогтсон байна. Бусдын болон хууль шүүхийн байгууллагын буруутай үйл ажиллагаанаас болж зовж шаналсан, сэтгэл санаа тайван бус болсноос аз жаргалгүй болсон, мөн эд эрхтнээрээ тахир дутуу болж хөдөлмөрийн чадвар, амь насаа алдахад мөнгөн дүнгээр хохирол барагдуулдаг эрх зүйн орчин, туршлага бүрдсэн байдаг.

---

[128] ШШТХ-ийн 40 дүгээр зүйл заасан

Тэр бүү хэл зарим улс оронд ёс суртахууны шинжтэй эдийн бус хохирлыг нөхөн барагдуулах тогтолцоо бүрджээ. Хохирогчийн сэтгэл санааны хохирлыг төлөх хөрөнгө буруутай этгээдэд байхгүй бол улсын төсвөөс гаргадаг. Ихэнх улс оронд сэтгэл санааны нөхөн төлбөр олгох улсын тусгай сан байдаг бөгөөд хөрөнгийг улсын төсвөөс санхүүжүүлдэг жишиг бий.

Европын улс орнуудад сэтгэл санааны хохирлыг олгохдоо насны ангилал, хөдөлмөрийн чадвараа алдсан хувь, гоо сайхнаараа хохирсон эсэх, хөл, гар, тархины гэмтлийг нарийн харгалзан үзэж мөнгөн төлбөр өгдөг. Тухайлбал, Бельгид нүүрэндээ эдгэшгүй сорви авсан 16 настай хүүхдэд 18600 евро, Гааг дахь шүүхээс баруун нүдээ алдаж, хоёр жилийн турш ажиллах боломжгүй болж, хөдөлмөрийн чадвараа 15 хувь алдсан хүнд 20 мянган еврогийн нөхөн төлбөр, хөлөө гурван см тайруулж, 4, 12, 14 см-ын сорви авч, хичээл сургуулиа хойшлуулсан эмэгтэйд 14500 еврогийн нөхөн төлбөрийг олгожээ.

Гэтэл манай улсад өнөөг хүртэл эдийн бус буюу сэтгэл санааны гэм хорыг хэрхэн нөхөн төлүүлэхийг хуульд тодорхой зааж өгөөгүй. Сэтгэл санааны гэм хорыг тусгайлан авч үздэггүй нь амь нас, эрүүл мэндээрээ хохирсон, хилс хэргээр шийтгэгдсэн иргэд хохирч үлдэж байгаа юм.

Цөөн тохиолдолд сэтгэл санааны хохирлыг нэхэмжилдэг ч шүүхээс нотлох баримтгүй гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгодог. Өөрөөр хэлбэл, манай өнөөгийн практикаар бол иргэн зовж шаналснаа шүүхийн өмнө нотлохоос өөр гарц шийдэлгүй байна. Тиймээс сэтгэл санааны хохирлыг төлдөг бусад улс орны жишгийг хүргэж байна.

Европын ихэнх орон хохирлыг нөхөн төлөх хоёр аргыг хэрэглэж байна. Зарим улс тодорхой өгөгдлийн бүдүүвч ашиглах буюу “нөхөн төлбөрийн хүснэгттэй улсууд” гэж нэрлэж болно. Мөн шүүгчийн үзэмжээр эрх зүйн практик дээр тулгуурлан хохирлыг барагдуулж байна. “Нөхөн төлбөрийн хүснэгттэй улсууд”-д Испани, Франц, Бельги, Итали, Чех багтдаг бол Герман, Швейцарь, Австри, Голланд, Польш “жишгийн эрх зүйт улсууд” юм.

Гадаад улс орнуудын сэтгэл санааны хохирлыг үнэлэх, арилгах, зөрчсөн эрхийг сэргээх асуудлыг улс тус бүрээр нь авч үзье:

АНУ нь хувь хүний эд хөрөнгийн бус ашиг сонирхлыг мөнгөн төлбөр хэлбэрээр хамгийн үр нөлөөтэй хамгаалж, их амжилт олж байгаа улс юм. Английн эрх зүйгээс ялгарах америкийн өөр нэг онцлог бол “сэтгэл санаанд зориуд санаатайгаар хүнд дарамт учруулсан” («intentionally causing of severe emotional distress») тохиолдолд хариуцлага хүлээлгэнэ. Энэ деликтийн төлөө хүлээлгэх хариуцлагын үндсэн зарчим нь Деликтийн эрх зүйн (The Restatement (Second) of Torts, § 46, 1965) эмхэтгэлийн хоёр дахь засварт: “аливаа этгээд нь өөрийн онцгой болон доромжилсон зан үйлээр, санаатай буюу болгоомжгүй байдлаар бусад этгээдэд сэтгэл санааны хүнд дарамт учруулсан бол энэ сэтгэл санааны дарамтынхаа төлөө хариуцлага хүлээх ёстой[129]” гэсэн агуулгаар илэрхийлэгдсэн байна.

---

[129] Bernstein R. D. First Amendement Limits on Tort Liability for Words Intended to Inflict Severe Emotional Distress// Columbia Law Review. 1985. Vol. 85. № 8. P. 1749. Falwell v. Flynt. № 83—0155 (April, 19. 1985) хэрэг нь жишээ болж болох юм. “Хустлер” (Hustler) сэтгүүл нь Жерри Фэлвелтэй хийсэн хошин ярилцлагандаа түүнийг “засаршгүй архичин” мэтээр гаргасан байна. Шүүх Фэлвелд 200 мянган долларыг сэтгэл санааны хүнд дарамтанд оруулсаны торгууль, нөхөн төлбөр хэлбэрээр олгохоор шийдвэрлэжээ

ОХУ, Украин. Сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг шүүхийн журмаар олгохдоо буруутай этгээдээс нэхэмжилдэг. Эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхэд Иргэний, Хөдөлмөрийн тухай хууль болон Эрделевскийн хүснэгтийг ашиглаж байна. Буруутай этгээдэд нөхөн төлбөр олгох хангалттай хөрөнгө байхгүй бол улсын төсвөөс олгодог. Нөхөн төлбөр олгох улсын сангийн хөрөнгийг улсын төсвөөс санхүүжүүлдэг. Жил бүр энэхүү сангийн санхүүжилтийг ОХУ-ын Засгийн газраас баталж өгдөг бөгөөд Улсын төсвийн тухай хуулиар зохицуулдаг.

Герман улсад. Гэмт хэргийн улмаас тодорхой этгээдэд оюун санааны, бие махбодын, эд хөрөнгийн хохирол учирдаг гэж үзнэ. Сэтгэл санааны хохирол нь ямар ч төрлийн гэмт хэргийн зайлшгүй үр дагавар байдаг бол бие махбодын болон эд хөрөнгийн хохирол нь гэмт хэргийн шинж чанараас хамаарна. Гэвч ямар ч тохиолдолд учирсан хор, хохирлыг арилгах, хохирогчийг хамгаалах асуудалтай байнга тулгарч байдаг.

Герман улсад сэтгэл санааны хохирол арилгах асуудлыг нийтлэг эрх зүйн тогтолцоотой улс орнуудаас өөрөөр шийдвэрлэнэ. Энэ нь юуны түрүүнд урд өмнө нь ёс суртахууны ашиг сонирхлыг бараг тооцож байгаагүй ромын эрх зүйн хүчтэй нөлөөгөөр тайлбарлагдана. Гэвч энэ үзлийг зарим эрдэмтэд буруу гэж үздэг. Сэтгэл санааны хохирлыг арилгах үзэл санаа ромын эрх зүйд зарим талаар тусагдаж байсан нь эргэлзээгүй. Энэ үзэл санаа нь цэгцтэй хэлбэрээр илэрхийлэгдээгүй боловч энэ нь түүхэн хөгжлийн турш байнга хөгжиж, он цагийн урсгалд хохирол, алдагдлын тухай сургааль болон хөгжих нь дамжиггүй.

Германы шүүхүүд нь сэтгэл санааны хохирлыг арилгах зайлшгүй нөхцөл байдал илэрсэн тохиолдолд хуулийн шууд заалтыг тойрон гарахын тулд нийтлэг эрх зүйн тогтолцоотой улс орнуудад сэтгэл санааны хохирол арилгах тогтолцоог ашиглах арга техникийг нэвтрүүлж эхлээд байгаа юм. Жишээлбэл, германы эрх зүй нь нийтлэг эрх зүйн нэгэн адил, хэрэв сэтгэл санааны хохирлыг арилгах нийтлэг зарчим байхгүй бол түүнийг яаравчлан хөгжүүлэх шаардлагатай гэж үздэг[130].

Белорусс Улс:

Хуулийн байгууллагууд нь хууль тогтоомжид заасны дагуу хүнд, онц хүнд гэмт хэргийн улмаас хүн ам хохирох явдлаас урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан эд хөрөнгө, эрүүл мэнд, сэтгэл санааны хохирлыг бүрэн төлөх талаарх үндэсний болон олон улсын эрх зүйн нэг гол зарчмыг амьдралд нэвтрүүлэх талаар ихээхэн ажлыг хийж байна. Энэ асуудалд хууль сахиулах төв, орон нутгийн байгууллагуудын ажлын үр дүнг тооцоход энэ асуудал гол байр суурийг эзэлж байна. 2000 онд 1999 онтой харьцуулахад гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах ажил нь 71.4% -иас 73% болж өссөн байна. Мөн виктимологийн урьдчилан сэргийлэх олон талт ажил зохиож эхлээд байна[131].

Франц Улс:

Францын иргэний хууль нь эд хөрөнгийн болон сэтгэл санааны хохирлын ялгааг авч үздэггүй. Иргэний хуулийн 1149 дүгээр зүйл нь алдагдлыг

---

[130] Иеринг Р. Ф. Интерес в праве. Ярославль, 1880. С. 32.

[131] Концепция статуса жертвы преступдения в республике Беларусь и предупреждения виктимизации населения от тяжких насильственных преступлений. //Юстиция Беларуси, №3 2002. Минск., 2002.

тодорхойлохдоо, хохирлыг арилгах буюу нийт алдагдлыг арилгах тухай асуудлыг зөвхөн мөнгөн төлбөрөөр үл хязгаарлана. Сэтгэл санааны болон эд хөрөнгийн хохирлыг арилгахын тулд хариуцагч нь хохирлыг арилгах гэм буруутай байх ёстой. Францын иргэний хууль нь түүний үүссэн шалтгаан нь деликт, эсхүл гэрээний зөрчил байсан ч үл хамаарч, оюун санааны хохирлын төлөө нөхөн төлбөр авах боломжтой учраас Германы иргэний хуулиас ялгаатай байдаг. Гэвч Франц улсад сэтгэл санааны хохирлыг арилгах хэмжээ нь нийтлэг эрх зүй (Common Law) үйлчилж байгаа орнуудаас бага байдаг уламжлалтай.

Францын деликтийн эрх зүйн үйлчлэлийн хүрээн дэх сэтгэл санааны хохирлыг арилгах институци нь иргэдийн дараах ашиг сонирхол, тухайлбал: бие, нэр төр, алдар хүндийн халдашгүй эрх; хувь хүний бодгаль чанарын бүх эрх /нэр, дүр төрхийн эрх орно/; мэргэжлийн үйл ажиллагааны болон захидал харилцааны нууцыг хадгалах эрх; зохиогчийн эрх; мэргэжлээ чөлөөтэй сонгох, чөлөөтэй зорчих эрх зэрэг ашиг сонирхлуудыг хамгаална.

Бельги Улс:

Эрүүгийн болон иргэний журмаар хохирол нөхөн төлүүлэх боломж нээлттэй бөгөөд хохирогч нэхэмжлэхийг өөрөө сонгох эрхтэй. Нийтийн сангаас эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжилж болно. Жишээ нь, амьдралаас таашаал авах боломжоо алдсаны хохирол, бэлгийн харилцааны хэм алдагдсаны хохирол, сэтгэл санааны тайван бус байдалд оруулсны хохирлыг эдийн бус гэм хорын хэлбэрээр тооцож барагдуулдаг.

-Хөдөлмөрийн чадвараа 100 хувь алдсаны нэг өдрийн 25 евро
-Хөдөлмөрийн чадвараа 50 хувь алдсаны нэг өдрийн 13 евро
-Нэмэлт өвдөлт, шаналал зовиурт мөн нөхөн төлбөр өгнө.

Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хохирогчийг насны байдлаар нь ангилдаг.

-10 ба түүнээс доош настай хүнд 3300 евро
-35 ба түүнээс доош настай хүнд 2425 евро
-64 ба түүнээс доош настай хүнд 1410 евро.

Гоо сайхны хохирлыг 1-7 хүртэлх түвшингээр үнэлнэ.

-1-р түвшин 250-750 евро
-4-р түвшин 2250-8700 евро
-5-р түвшин 8700 евро ба түүнээс дээш
-7-р түвшин 24800 евро ба түүнээс дээш

Голланд Улс:

Гадаад гэмтэл /хөдөлмөрийн чадвараа алдсан 1 долоо хоногт/ 100-500 евро
-тархи хөдлөх / хөдөлмөрийн чадвараа алдсан 1 долоо хоногт / 300-1000 евро
-хүндрэлгүй эмчлэгдэх боломжтойгоор нэг гар хугарсан бол 600-2000 евро
-хүндрэлгүй эмчлэгдэх боломжтойгоор нэг хөл хугарсан бол 1250-3500 евро
-өвдөгнөөс доошх нэг хөлөө алдсан бол 15000-20000 евро
-нүд хараагүй бол нэг нүдэнд 15000-25000 евро
-нуруу сээрний гэмтлээс болж саажилт үүссэн бол 50000-аас дээш евро

Монгол Улсад сэтгэл санааны хохирлыг үнэлж буй аргачлал

Монгол Улсын Эрүүгийн хуульд “Бусдын нэр төр, алдар хүндийг олон нийтийн өмнө, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгслээр доромжлох /insult/”, мөн “хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг /blackwash/ тараасан бол” эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан юм. Хэрэв гүтгэлгийг

хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тараасан, эсхүл доромжлох, гүтгэх гэмт хэрэгт урд нь ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол ялыг хүндрүүлэхээр заажээ.

Ийм учраас Монгол Улсад нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаах гэмт хэрэгтэй тэмцэх, нөгөө талаас сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагааг эрүүгийн хуулиар хамгаалах асуудал хурцаар тавигдаж байна[132].

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар "иргэний нэхэмжлэгч нь өөрийн эд хөрөнгийн бус хохирлоо нөхөн төлүүлэх, сэргээлгэх эрхийг"[133] заасан юм. Ийм учраас эд хөрөнгийн бус хохирол нь амь нас хохирсон, эрүүл мэнд сарниулсан, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан үнэ өртгөөр илэрхийлэгддэггүй, гэм хор бөгөөд хохирогчийг санаа сэтгэлийн дарамтад оруулсан үр дагавар байна. Энэ үр дагаврыг: учирсан материаллаг гэм хорыг арилгах, сэтгэл санааны гэм хорыг мөнгөн төлбөрөөр нөхөн төлбөр гаргуулах, нэр төр, алдар хүндийг сэргээх зэргээр арилгана[134].

Монгол Улсын Иргэний хуулийн 230 дугаар зүйлд: "Эдийн бус гэм хорыг арилгуулахаар хохирогч шаардах эрхтэй" гэж заасан юм. Гэвч энэ хуульд зааснаар: "гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө" гэж заасан юм. Ийм учраас эдийн бус гэм хорыг арилгах нөхөн сэргээх (төрөлх байдлаар), хуульд заасан бол нөхөн төлбөр (мөнгөн хэлбэрээр нөхөн төлөх) хэлбэрийг тогтоожээ[135].

Монгол Улсын Дээд Шүүхийн "Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай" 2000 оны нэгдүгээр сарын 19-ний өдрийн 03 тоот тогтоолд:" нэр төр, алдар хүнд, санаа сэтгэлийн" талаар хохирол хүлээсэн этгээдийн хохирлын хэмжээг ихэнхдээ мөнгөн илэрхийллээр тогтоох боломжгүй бөгөөд дээрх үндэслэлээр хохирогчоор тогтоогдсон этгээд эд материалын хохирол хүлээснээ үндэслэл бүхий нотлох баримтаар нотолж хохирлын тухай тооцоогоо мөнгөн илэрхийллээр гаргаж ирсэн тохиолдолд шүүх түүнийг ердийн журмаар хянан шийдвэрлэх үүрэгтэй" [136] гэжээ.

Гэм хор учрах буюу түүнээс урьдчилан сэргийлэх, учирсан гэм хороос үүдэн гарах хохирлын хэмжээ нэмэгдэхэд хохирогчийн буюу эрх бүхий этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй) нөлөөлсөн бол гэм хорыг арилгах үүрэг болон түүний хэмжээг тодорхойлохдоо тэдгээрийн гэм бурууг харгалзана (ИХ 230.3§). Энэ

---

[132]Үз.: С.Жанцан. Сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагааг эрүүгийн хуулиар хамгаалах зарим асуудал // Гэмт явдалтай тэмцэх асуудал.2004.№1 (8). 19-20-р тал.

[133] Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. Уб., 2017. 8.6 дүгээр зүйл.

[134]Д.Наранчимэг. Иргэний эрх зүйн үндсэн асуудал. I дэвтэр. УБ.,1999. 89-р тал.

[135] Үз.: Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар. Ерөнхий анги. Туршилтын хэвлэл. УБ., 2005. 1030-р тал.

[136] Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхэтгэл. I .УБ., 2001. 205-р тал.

тохиолдолд: “хэрэв хүн өөрөө буруутай бол бүрэн хэмжээний хохирлыг шаардах эрхгүй”[137] гэсэн үзэл баримтлалыг удирдлага болгоно.

Монголын хохирол үнэлэгчдийн холбооноос сэтгэл санааны хохирлын хэмжээг тооцох аргачлалыг 2016 онд боловсруулжээ.

Аргачлалыг хэрхэн хэрэгжүүлэх талаар товч харуулахад:

Алдагдсан боломжийн үнэлгээ

Сэтгэл санааны хохирлын үнэлгээ

Шууд зардал буюу баримтаар нотлогдох хохирлуудыг багтаан эрүүл мэнд, сэтгэл санааны хохирол үнэлгээг тооцоолохоор тогтоосон.

Алдагдсан боломжийн хохирлын үнэлгээ (АБХҮ):

Статистик мэдээнээс Монгол хүний дундаж наслалтын мэдээллийг авч, тэтгэвэрт гарах нас, ажил эрхлэх насны зөрүүгээр идэвхтэй ажиллах жилийг тооцоолно. Тухайн хохирсон хүний ажлаас гарсан өдрөөс тэтгэвэрт гарах өдрийг хүртэл тооцоолж нийт хэдэн өдөр ажиллах боломжоо алдсаныг сард (АБА) шилжүүлж сарын цалингаар (СЦ) үржүүлэн нийт цалингийн алдагдлыг гаргана.

АБХҮ=АБА сарын тоо* СЦ

Шууд зардал буюу шууд хохирлын үнэлгээ (ШЗХҮ):

Шууд зардлыг тухайн хохиролтой холбогдон гарсан баримтаар нотлогдох эмчилгээний зардал (ЭЗ) болон бусад баримтаар нотлогдох зардлуудын (ББНЗ) нийлбэрээр тооцоолно.

ШЗХҮ= ЭЗ+ББНЗ

Сэтгэл санааны хохирлын үнэлгээ (ССХҮ):

Сэтгэл санааны хохирол тооцооллыг мөнгөн дүнгээр илэрхийлэхэд дотоодын нийт бүтээгдэхүүнийг (ДНБ) хүн амын тоонд харьцуулан нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг (НХНДНБ) гаргаж үржүүлэгчээр (МХҮХ-ноос гаргасан 5.5) үржүүлэн хүний амь насны үнэлгээг гарна. Гарсан тоог хуанлийн хоногт (ХХ) харьцуулахад нэг өдрийн сэтгэл санааны хохирлын суурь үнэлгээ(НӨССХСҮ) гарна.

Хохирлоос үүссэн үйлдэл байдал	Итгэлцүүр
Сэхээн амьдруулах	5.0
Мэс засал, хагалгаа	4.0
Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн	2.0
Зовиуртай байсан	2.0
Энгийн зовиур	1.0
Хөдөлмөрийн чадвар алдалтын хувиар	0-1.0

Энэхүү үржүүлэгч болон итгэлцүүрийг МХҮХ-ноос боловсруулан гаргасан болно.

Сэтгэл санааны хохирлын нийт үнэлгээг гаргахад эмнэлэгт хэвтсэн хоногийг (ЭХХ) дээр тооцоолон гаргасан сэтгэл санааны хохирол тооцох нэг өдрийн суурь үнэлгээг холбогдох итгэлцүүрээр үржүүлэн гаргана. Бусад дээрх итгэлцүүрт хамаарах хохирол үүссэн байвал энэ аргачлалаар тооцоолон гаргах боломжтой байна.

ССХҮ=(НХНДНБ*Үржүүлэгч)/ ХХ)*ЭХХ*итгэлцүүр

[137] Үз.: Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар. Ерөнхий анги. УБ., 2005. 1031-р тал.

Дээрх алдагдсан боломжийн хохирлын үнэлгээ, сэтгэл санааны хохирлын үнэлгээ, шууд зардлуудын хохирлын үнэлгээний нийлбэр нь эрүүл мэнд, сэтгэл санааны нийт хохирлыг (ЭМССХУ) тооцоолох үнэлгээ болж байна.

ЭМССХУ=АБХУ+ШЗХУ+ССХУ138

Дээрх аргачлалын томьёоллын дагуу шүүхэд гомдол гаргасан иргэний сэтгэл санааны хохирлыг үнэлсэн жишээг харуулбал[139]:

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Дундаж
1	Дотоодын нийт бүтээгдэхүүн /2018 он/	Сая.төг	32,306,653,450.00
2	Хүн амын тоо /2015-01-01/	Хүн	3,238,479.00
3	Нэг хүнд ногдох ДНБ	Мян.төг	9,975.87
4	Үржүүлэгч /МХҮХ-ноос тогтоосон/	Итгэлцүүр	5.50
5	Хүний амь насны үнэ /2016 оны байдлаар/	Мян.төг	54,867.30
6	Нэг өдрийн сэтгэл санааны хохирлын суурь үнэ	Мян.төг	30.06

№	Цагдан хорих хугацааны сэтгэл санааны хохирол	Хэмжих нэгж	Тооцоолол
1	Нэг өдрийн сэтгэл санааны хохирлын суурь үнэ	Мян.төг	30.06
2	Хоригдсон хоног 2018.11.06-2019.01.04	хоног	60.00
3	Үржүүлэгч /МХҮХ-ноос тогтоосон/	Итгэлцүүр	5.00
4	Хоригдсон хугацааны сэтгэл санааны хохирол дүн	Мян.төг	9,018.00

№	Хязгаарлалттай хугацааны сэтгэл санааны хохирол	Хэмжих нэгж	Тооцоолол
1	Нэг өдрийн сэтгэл санааны хохирлын суурь үнэ	Мян.төг	30.06
2	Хоригдсон хоног 2018.11.05-2019.10.23	хоног	291.00
3	Үржүүлэгч /МХҮХ-ноос тогтоосон/	Итгэлцүүр	4.00
4	Хоригдсон хугацааны сэтгэл санааны хохирол дүн	Мян.төг	34,994.81

№	Сэтгэл санааны хохирол тооцоолол	Хэмжих нэгж	Нийт дүн
1	Цагдан хорих хугацааны сэтгэл санааны хохирол	Мян.төг	9,018.00
2	Хязгаарлалттай хугацааны сэтгэл санааны хохирол	Мян.төг	34,994.81
	Нийт дүн		44,012.81

Дээрх Монгол Улсын иргэний сэтгэл санааны хохирлыг тооцсон жишээг ОХУ-ын эрдэмтдийн зохиосон сэтгэл санааны хохирлыг тооцох аргачлалаар тооцоолбол:

---

[139]2016 онд Монголын хохирол үнэлгээчдийн холбооноос “сэтгэл санааг тооцох аргачилал”

1. В**.Я. Понаринийн сэтгэл санааны хохирол (ССХ) тооцох арга.** Үүнд ССХ тооцох 2 аргачлал багтсан: өдрийн үзүүлэлт болон хориг арга хэмжээний үзүүлэлт. Эхний аргачлалыг хэрэглэхэд:

   ССХ = n × Д,

   Тухайн хохирогчийн дундаж цалин тооцоолол

   19 145 450=1200000/22*351

   n - шүүх ССХ нэхэмжлэх өдрүүдийн тоо

   Д - шүүгдэгчийн нэг өдрийн дундаж орлого.

   Ийм тохиолдолд ССХ нь зөвхөн шүүгдэгчийн орлогоос хамаарна, хохирогчийн тарчлал, түүний хувь хүний шинж чанар тооцогдохгүй байна.

2. **ОХУ–д Эрделевскийн доорх томьёог ашиглан сэтгэл санааны хохирлыг** тооцож байна.

Эрделевскийн хүснэгтийг бусад улс орон загвар болгон ашиглах тохиолдол бий. Эрделевскийн хүснэгтэд D=d*fv*i*c*(1-fs) буюу D -Сэтгэл санааны хохирлын нийт дүн, d – Сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийн хэмжээ, fv-Гэмт этгээдийн үйлдсэн гэм хорын хэмжээ. Гэм хор нь 0-ээс их нэгээс бага байх бөгөөд i-хүвь хүний онцлог өөрөөр хэлбэл тухайн хохирогч нь сэтгэл санааны хувьд дунд зэргийн байдалтай бол i=1, хэрэв сэтгэл санааны хувьд хүндээр тусгаж авсан бол i>1, харин эсрэгээрээ байхын бол i<1 байна. Хохирогч өөрөө сэтгэл санааны хувьд тогтвортой, гомдолгүй бол i=0 байна.

С- хор хөнөөл учируулсан бодит нөхцөл байдлын итгэлцүүр.

I, С– гэмт хэргийн төрөл бүр нь тодорхой онцлог шинж чанараар 0-2 итгэлцүүрээр тодорхойлогддог.

fs – хохирогчийн гэм буруутай байдлыг харгалзан үздэг байна.

Хүснэгт:

Зөрчил	**Нөхөн төлбөрийн хэмжээ**	
	Итгэлцүүр	**Цалингийн доод хэмжээ**
Бие махбодид хүнд гэмтэл учруулах	0,80	576
Хэрвээ хохирогчийг зовоон тарчлаасан бол (тамласан)	1,00	720
Бие махбодид дунд зэргийн гэмтэл учруулах	0,30	216
Хэрвээ хохирогчийг зовоон тарчлаасан бол (тамласан)	0:5	360
Бие махбодид хөнгөн гэмтэл учруулах	0,03	24
Зодох	0,025	18
Тамлах	0,30	216
Хүн алах, хүний бие махбодид хүнд гэмтэл учруулахаар заналхийлэх	0,20	144
Хүний эрхтэн, эд эсийг шилжүүлэн суулгахыг шаардах	0,40	288
Бусдаас хамааралтай болон хүнээс шаардах	0,5	360
Бэлгийн замын халдварт өвчин халдаах	0,05	36

ДОХ халдаах	0,50	360
Өвчтөнд тусламж үзүүлээгүйгээс болоод өвчтөний эрүүл мэндэд дунд зэргийн хохирол учруулах	0,03	24
Өвчтөнд тусламж үзүүлээгүйгээс болоод өвчтөний эрүүл мэндэд хүнд зэргийн хохирол учруулах	0,30	216
Хүн хулгайлах	0,80	576
Бие махбодийн зовлон учруулсан тохиолдолд	1,00	720
Эрүүл мэндэд хүнд буюу дунд зэргийн хохирол учруулсан тохиолдолд	1,50	1080
Хууль бусаар хүний эрх чөлөөг хязгаарлах (нэг өдрийн)	0,30	216
Бие махбодийн зовлон учруулсан тохиолдолд	0,50	360
Эрүүл мэндэд хүнд буюу дунд зэргийн хохирол учруулсан тохиолдолд	0,80	576
Сэтгэцийн эмнэлэгт хууль бусаар байрлуулсан (нэг өдрийн)	0,30	216
Эрүүл мэндэд хүнд буюу дунд зэргийн хохирол учруулсан тохиолдолд	0,70	504
Хуурамч, нэр төр гутаасан мэдээлэл түгээх	0,03	24
Хэвлэл мэдээллийн хэрэгслээр	0,05	36
Хүнд гэмт хэрэгт холбогдсон мэдээлэл түгээсэн тохиолдолд	0,30	216
Доромжлох	0,015	12
Хэвлэл мэдээллийн хэрэгслээр	0,03	24
Хохирогчийн хүчирхийлэл, заналхийлэл, хохирогчийн биэ авч явах чадахгүй байдлыг ашиглан бэлгийн харьцаанд орох эсвэл бэлгийн шинжтэй бусад хүчирхийлэл үйлдэх	0,60	432
Хүн алах, хүний бие махбодид хүнд гэмтэл учруулахаар заналхийлсэн тохиолдолд	1,00	720
Эрүүл мэндэд хүнд буюу дунд зэргийн хохирол учруулсан эсвэл ДОХ халдаасан тохиолдолд	1,50	1080
Өөрийхөө автанд оруулах, сүрдүүлэх замаар бэлгийн шинж чанартай үйлдэл хийхийг албадах	0,10	72
Иргэний ялгаварлан гадуурхалт	0,20	144
Хувийн нууцлалыг зөрчих	0,03	24

Утасны яриа, захидал болон шуудан холбооны мэдээллийн нууцлалыг зөрчих	0,03	24
Гэрийн халдашгүй байдлыг зөрчих	0,025	18
Хүчирхийлэл ашигласан болон сүрдүүлсэн тохиолдолд	0,20	144
Иргэдэд мэдээлэл өгөхөөс хууль бусаар татгалзах	0,025	18
Сонгуулийн эрхийг хэрэгжүүлэхэд саад учруулах	0,03	24
Ажилд авахаас хууль бусаар татгалзах	0,03	24
Хууль бусаар ажлаас халах	0,1	72
Хөдөлмөрийн бусад эрхийг зөрчих	0,05	36
Зохиогч, зохион бүтээгчийн оюуны өмчийн эрхийг зөрчих	0,20	144
Шашин шүтэх эрх чөлөөг зөрчих	0,025	18
Хүүхэд үрчлэх болон үр шилжүүлэн суулгах нууцыг задруулах	0,20	144
Хүүхэд солих	0,50	360
Хэрэглэгчийн өмчийн эрхийг зөрчих	0,05	36
Их хэмжээний хохирол учруулсан тохиолдолд	0,20	144
Ойр дотны хамаатныхаа үхэлд хүргэх	0,30	216
Харгисаар үхэлд хүргэсэн тохиолдолд	0,80	576
Ойрын хамаатныхаа цогцос буюу булшид зүй бусаар харьцах	0,025	18
Гэмгүй хүнийг хэлсээр эрүүгийн хариуцлагад татах	0,50	360
Хүнд гэмт хэрэгт тулгах	1,00	720
Гэмгүй хүмүүсийг буруутгах	0,40	288
Ноцтой үр дагавар дагуулсан	1,00	720
Хууль бусаар баривчлах	0,20	144
Хууль бусаар цагдан хорих (нэг өдрийн)	0,04	28,8
Хууль бусаар эрх чөлөөг хязгаарлах бусад тохиолдлууд (нэг өдрийн)	0,01	7,2
Мэдүүлэг өгөхийг албадах	0,30	216
Хүчирхийлэл хэрэглэсэн болон тамласан хослуулан	0,80	576
Эрх бүхий байгууллага, захиргааны хууль бус үйлдэл, шийдвэрээр иргэний эрх, эрх чөлөөг бусад хэлбэрээр зөрчих	0,05	36

Их хэмжээний хохирол учруулсан тохиолдолд	0,20	144

Итгэлцүүрийг сонгох үзүүлэлтүүдийг харуулбал:

Сэтгэл санааны хүнд зэргийн хохиролтой хохирогч хүнд зодуулсан хүн нь бие мах бодь болон сэтгэл санааны хохирлын хувьд өөр өөрийн онцлогтой. Хүнд зодуулж бие мах бодийн гэмтэл авсан бол тодорхой хугацаанд эмчлэгдэж болдог бол сэтгэл санааны хохирлыг тэр хэмжээгээр эмчлэх боломжгүй гэж үзэж байна. Тухайн хохирогч хүнд зодуулсны дараа өвчин мэдэрч буй байдал нь их багаас шалтгаалан I итгэлцүүр нь 1-ээс дээш буюу доош гэж тодорхойлно.

Хэрвээ жирэмсэн хүн зодуулаад хүүхэд зулбуулсан бол тухайн иргэн дахин хүүхэд тээх боломжтой юу гэдгээс шалтгаалан итгэлцүүр нь өөр өөр байна.

- Хэрэв тухайн эмэгтэй санаатайгаар зодуулсан бол /жирэмслэлтээ зогсоох санаатай бол/ сэтгэл санааны хохирол байхгүй шүүгч I итгэлцүүр байхгүй гэж үзнэ.
- Хэрэв тухайн зодуулсан жирэмсэн эмэгтэй урд өмнө удаа дараа аборт хийлгэж байсан бол 0,5 итгэлцүүр
- Зодуулсны дараа хүүхэд тээх боломжтой бол – 1 итгэлцүүр
- Эмчилгээ хийлгэх шаардлагатай бол – 1,5 итгэлцүүр
- Хэрэв зовоон тарчлаасан бол /тамласан/ 2 итгэлцүүр
- Хүүхэд тээх бүүр боломжгүй гэж үзвэл 2 итгэлцүүр

Хэрэв ойрын хамаатан нас барсан бол ямар хамаатнаас шалтгаалж:

- Хэрвээ гэр бүлийн гишүүн бол хэр удаан хугацаанд амьдарч байсан итгэлцүүр өсөх
- Цаашид гэрлэх үү үгүй юу гээд насыг харгалзаж үзэх итгэлцүүр нь өөрчлөгдөх
- Нас барсан хохирогчийн хамаатан садан тус бүр нь сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх эрх үүснэ

Хэрэв хохирогчийн нэр төрд халдсан бол итгэлцүүрийг тооцоолоход нэр төр гутаасан шинж чанараас хамаарна. /хамрах хүрээ, үр дагавар/ /Нэр төрийг гутаан доромжлохдоо хэр өргөн хүрээнд тараасан, бас хэр олон мэдээллийн хэрэгслээр тараасан/

Хохирогчийн итгэлцүүрийг тодорхойлохдоо тухайн хохирогчийн зан чанар характерыг судалж үзэж байж тодорхойлдог

Үр дагавар нь:

- Ажлаас халагдах
- Сонгох эрх, нөлөөнд хууль бусаар халдсан
- Гэр бүл салах гэх мэт...

Ажлын байран дээр нэр хүндэд халдсан байдал

Хэрэв хууль бусаар хүний эрхийг хязгаарлаж саатуулсан тохиолдолд итгэлцүүр i- 1 болно.

Хэрэв хохирогчийг барьцаалан хууль бусаар эрхэнд нь халдсан тохиолдолд **итгэлцүүр с- 1** ба түүнээс дээш байна.

- Хэрэв хууль бусаар ял эдэлсэн тохиолдолд:
- Хохирогч хэрэв өмнө нь ял эдэлж байсан бол өмнө нь ял эдэлж байгаагүй хохирогчоос итгэлцүүр нь 1-ээс бага байна

- Нэг хүнд оногдох талбайн хэмжээнээс хамаарна /ялын төрлөөс, бусад хоригдлуудыг дарамталсан, зөрчил гаргах, хорих ангийн журмыг зөрчих, ажил дээр сөрөг үр дагавар/ гарсан зэрэг байдлаас хамаарч итгэлцүүр **С-г** өсгөх буюу бууруулна
- Хувь хүний бүрэн эрхийг хязгаарлах:
- Өөрийн хүсэлгүй бэлгийн харилцаанд оруулах
- Бэлгийн чиг хандлагыг нь албадан өөрчлөх
- Мэргэжлийн бие үнэлэгч хүчиндүүлсэн бол итгэлцүүрийг багасгаж тооцох гэх мэт...
- Хохирол учруулахдаа ямар нөхцөл байдалтай байсан талаар /хүчиндэх үед хүний биед хохирол учруулсан байдал, бэлгийн замын халдварт өвчин авах, хүчингийн улмаас жирэмслэх, хүүхэд эхнэр, нөхрийн өмнө эсвэл бусдын өмнө хүчиндэх, гэр бүл салах, сэтгэцийн өвчтэй/ зэргээс хамаарч **С итгэлцүүр** өөрчлөгдөнө.
- Согтууруулах болон мансууруулах бодис хэрэглэсний улмаас /эсвэл өөрөө өдсөн бол/ хүчиндүүлсэн тохиолдолд итгэлцүүрийг бууруулж тооцно.
- Хувь хүн /хуулийн этгээдийн/ нууцыг задруулах
- Банк санхүүгийн байгууллага хувь хүн, хуулийн этгээдтэй холбоотой дансны мэдээллийг нийтэд дэлгэх /түүнээс хамаарч тухайн хохирогчийн санхүүгийн байдал дордсон бол **С итгэлцүүр** 2 болно/
- Эмчлэгч эмч өвчтөний өвчний түүхийг задруулах /үр дагавраас хамаарч итгэлцүүр нь өсөх буюу буурна/

Fs – хохирогчийн гэм буруугийн зэрэг 0-1

Тухайн хохирогчийн өөрөө зорилготойгоор хохирол амсаж сэтгэл санаанд хохирол үүссэн бол fs-1 гэж үзээд өөрөөр хэлбэл сэтгэл санааны нөхөн төлбөрийг олгохгүй 0 гэж үзнэ. D=d*fv*i*c*(1-fs).

Хэрэв тухайн хохирогч нь өөрөө буруугүй тохиолдолд сэтгэл санааны хохирол учирсан бол Fv – ийг орхиж тооцоолно. D=d*i*c*(1-fs)

420000=d*0.3*2(1-0) d=27 300 000

4. А.Л. Южаниновагийг ССХ тооцох арга.

Дараахь бүтэцтэй томьёог санал болгосон:

ССХ = (биеийн тарчлалын хэмжээ + сэтгэл зовнилын хэмжээ) × (үр дагавар) × (нөлөөллийн мөн чанар)

Южаниновагийн тооцооллоор Тарчлалын зэрэг нь бие махбодын зовлон зүдгүүр, тарчлал нь (хүнд, дунд, хөнгөн), түүний үр дагавар (үйл ажиллагаа, органик, архаг), түүнчлэн бие махбодийн зовлонтой холбоотой (хүчтэй, дунд зэрэг, сул) үнэлэгдэх ёстойг харгалзан үздэг. Харамсалтай нь биеийн тарчлалын хэмжээ болон сэтгэл зовнилын хэмжээг тодорхойлох томьёо байдаггүй. Гэсэн хэдий ч шинжээчдийн аргыг ашиглах боломжтой.

5. Е.Н. Холоповагийн ССХ тооцох арга.

ССХ-г дараах томьёогоор тооцоолно:

ССХ = ССХДХ × Хб × Бб × Ис

ССХДХ - хууль тогтоогчоор тогтоосон сэтгэл санааны хохирлын доод хэмжээ,

Хб - хохирогчийн буруугийн итгэлцүүр,

Бб - Буруутай этгээдийн буруугийн итгэлцүүр,

Ис - Сэтгэл зүйн итгэлцүүр эсвэл хувь хүний шинж чанарын итгэлцүүр.

Г.Г. Горшенковийн ССХ тооцох арга.

ССХ-г дараах томьёогоор тооцно:

ССХ = Иш × ХХДХ × Иэ,

Иш - шийтгэлийн дундаж индекс (жишээ: хүчингийн хэрэгт (ОХУ-н Эрүүгийн Хууль 131 заалт): 1-р хэсэг - 3-аас 6 хүртэлх жилээр эрх чөлөө хязгаарлах; 2-р хэсэг - 4-өөс 10 жил; 3-р хэсэг - 8-аас 15 жил. Эндээс Ин = 3 + 6 = 9/2 = 4,5; Ин = 4+10 = 14/2 = 7; Ин = 8 + 15 = 23/2 = 11,5.

ХХДХ - хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ;

Иэ - эрүүл мэндийн хохирлын итгэлцүүр (ОХУ-н Эрүүгийн Хуулийн 111-115).

Горшенков өөрийн арга зүйгээ зөвхөн субьектив алдагдал, тэдгээрийн нөхөн төлбөрийн хэмжээг эрх зүйн үнэлэмжээр үнэлэх шалгуурын тогтолцоог боловсруулах анхны санаа гэж үздэг.

7. А.В. Черкуновагийн ССХ тооцох арга.

Судалгаан дээр ССХ-г энэхүү томьёогоор тооцоолсон.

ССХх.э. = (ССХ х.х.с. + ССХ х.х.б.)

ССХ х.э. - хуулийн этгээдийн сэтгэл санааны хохирлын нөхөн олговор.

ССХ х.х.с - хувь хүний сэтгэл санааны хохирлын нөхөн олговор

ССХ х.х.б.-хувь хүний бие махбодийн хохирлын нөхөн олговор

Хуулийн этгээдийн хувь хүн гэдэгт байгууллагын удирдлага (захирал, үүсгэн байгуулагч-хувь хүн), сэтгэл санааны хохирол амссан ажилтнууд орно. Хувь хүн бүрт учирсан сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг ажлын үр дүнгийн байдлаар тодорхойлно [8].

Судалгаан дээр ССХ-г тооцоолох томьёог санал болгож байна:

КМВ=Ач Ест U Тст

Ач - хэмжих нэгж бууруулах итгэлцүүр,

Ест - тарчлалд зарцуулсан эрч хүч

U-эрч хүчийн хэлбэлзлийн давтамж

Тст-тарчлалын цаг

Дүгнэлт, санал

Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлын хэмжээг бодитой тогтоох шийдвэрлэх, нөхөн төлүүлэх нь хууль зүйн болон нийгмийн тулгамдсан асуудлын нэг мөн бөгөөд эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирол, хор уршгийг барагдуулах талаар гадаад улс орны аргачлалаас ОХУ-ын эрдэмтдийн боловсруулсан аргачлалд цалингийн доод түвшин болон дотоодын нийт бүтээгдэхүүнийг хохирол тооцоолох суурь үзүүлэлтээр тооцоолж байгаа нь манай орны үнэлгээний байгууллагуудын хэрэглэж байгаа суурь үзүүлэлт ашиглах аргачлалтай ижил байна.

Монгол Улсын иргэнийг гэм буруутайн тогтоодоггүй байхад эрхийг хязгаарласан, цагдан хорьсон хугацааны сэтгэл санааны хохирлын үнэлгээг тогтооход оролцсон туршлагаасаа авч үзэхэд:

- ✓ Хохирогч нь тухайн хугацаанд эрхэлсэн ажилгүй;

- ✓ Хохирогч нь ажлаа үргэлжлүүлэн хийх бололцоотой ч хуучин ажлын удирдлагын зүгээс итгэлгүй хандаж, ажил, албан тушаалд эргүүлэн авмааргүй байгаагаа илэрхийлсэн;
- ✓ Өргөдлөө өгөхийг хохирогчоос хүсэж, шинэ хамт олон дунд хэл аманд ороцолдон хэрэгт шалгагдаж байсан хүн орж ажиллах нь нийгэмд сөргөөр харагдах гээд байгаа талаар тайлбарлаж байгаа нь хохирогчийн бие организмд бодит байдлаар болон орчноос хүртэх сэтгэл санааны хохирол гэж үзэхээр байсан.
- ✓ Хохирогчийн ар гэр болох өндөр настай эцэг эх, эхнэр, өсвөр насны хүүхэд, түүний хүрээлэн буй орчин, найз нөхөд нь энэ хугацаанд танай хүү, нөхөр, аав, найз албан тушаалаа урвуулан ашигласан хэрэгтэн гэж дуудуулж байгаа нь хохирогчид болон ойр дотнын хүмүүст сэтгэл санааны ихээхэн хохирол учруулсаар байхаар байсан боловч шууд хохирлыг тооцоолсноос ойр дотнын дам хохирлыг тооцоолох боломжгүй байгаа нь үнэлгээний явцад харагдаж байсан. Үүнээс үзэхэд сэтгэл санааны хохирол нь тухайн иргэний асуудал биш ойр дотнын хүмүүс мөн адил хохиролд өртдөг боловч энэ талаар манай оронд одоогоор хохирол нэхэмжилсэн түүхэн мэдээлэл гараагүй буюу шийдвэрлээгүй байна.

Гадаад улс орнуудын сэтгэл санааны хохирол арилгах аргачлалыг Монгол Улсад хэрэглэж байгаа аргачлалтай харьцуулан үзэхэд дээрх аргуудаас ОХУ–д Эрделевскийн сэтгэл санааны хохирол тооцох аргачлал нь ойролцоо байна. Бидний гарган ашиглаж байгаа итгэлцүүрийг шүүх эмнэлгийг сэтгэц гэм судлалын шинжлэх ухаантай хослуулан хөгжүүлж хохирогчийн сэтгэл санааны хохирол тооцох жишиг аргачлалын итгэлцүүрийг гаргах шаардлагатай байна гэж үзлээ.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

1. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2016
2. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2017
3. https://police.gov.mn/resource/policegovmn/File/2018/11/06/n3vggzukdbbb4vmw/1.%202018.10%20sar%20medee%20Burtgegdsen%20hereg.pdf
4. Монгол улс дахь гэмт хэргийн статистикийн үйл ажиллагааны өнөөгийн байдал 2017
5. Квашис В.Е. Основы виктимологии. М., 1999. С.179-185.
6. Квашис В.Е. Основы виктимологии. М., 1999.С.218.
7. Lab, S. P. (1997). Crime Prevention: Approaches, Practices and Evaluations. Third Edition. Cincinnati, OH. Anderson Publishing Company.
8. Prosser W. L. Privacy//Calif. Law Review. 1960. Vol. 48. P. 388—392.
9. Постановление Пленума Верховного суда РФ от 20.12.1994 г. № 10 «Некоторые вопросы применения законодательства о компенсации морального вреда» // Российская газета. № 29. 08.02.1995
10. Шнайдер Г.Й. Криминология М., 1994.С.364-365.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЯЛЫН ТӨРЛИЙГ БНХАУ-ЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЯЛЫН ТӨРӨЛТЭЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

TYPES OF PUNISHMENT IN CRIMINAL LAW OF MONGOLIA TYPES OF PENALTIES UNDER PRC CRIMINAL LAW COMPARATIVE STUDIES



С.Уганбаатар
Дотоод хэргийн их сургуулийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
магистрант, ахмад

Товч утга: Монгол улсын хувьд газар зүй геополитекийн мөнхийн хөрш болсон ОХУ, БНХАУ-ын улс төр, нийгэм эдийн засгийн байдал, соёл уламжлал, зан заншил, эрх зүйн тогтолцоо, хууль тогтоомж зэргийг зайлшгүй судлах шаардлагатай билээ. Монгол улсын Эрүүгийн хуулийн ялын төрлийг БНХАУ-ын Эрүүгийн хуулийн ялын төрөлтэй дараах эх сурвалжийн хүрээнд харьцуулсан судаллаа.

Түлхүүр үгс: Монгол улс, эрүүгийн хууль, ялын төрөл, ялын бодлого, эрүүгийн хариуцлага, эрх зүй, хэм хэмжээ.

Abstract: For Mongolia, it is necessary to study the political, socio-economic situation, culture, traditions, customs, legal system and laws of Russia and China, which are the eternal neighbors of geography and geopolitics. The types of punishments under the Criminal Law of Mongolia have been compared with the types of punishments under the Criminal Law of the People's Republic of China in the context of the following sources.

Keywords: Mongolia, criminal law, type of punishment, punishment policy, criminal responsibility, law, norms.

Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Улсын их хурлаас Эрүүгийн хуулийг 2015 оны 12 дүгээр сарын 03-ны өдөр шинэчлэн баталж, мөн оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж байна.

БНХАУ-ын эрүүгийн хуулийг БНХАУ-ын 8-р хуралдааны тус улсын Ардын төлөөлөгчдийн их хурлын 5-р хуралдаанаас 1997 оны 3 дугаар сарын 14-ний өдөр

засвар оруулж тогтоожээ.[140] Уг хуулийг 1997 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж байна.

Монгол улсын болон БНХАУ-ын Эрүүгийн хуульд заасан ялын төрлүүдийг харьцуулалтын аргаар зэрэгцүүлэн жишиж тодорхойлох замаар харьцуулан судаллаа.

Харьцуулсан эрүүгийн эрх зүйн шижлэх ухааны дээрх аргыг, хууль зүйн шинжлэх ухааны доктор Д.Баярсайхан өөрийн бүтээлдээ "Дэлхийн улс орнуудын эрүүгийн хууль тогтоомж, тэдгээр актуудыг бүхэлд нь буюу институт бүлэг, хэсгээр нь нормативийн аргаар харьцуулах, улмаар гэмт хэрэг, ялын талаар эрх зүйн хэм хэмжээний хэлбэр, бүтэц, агуулга тогтолцоог зэрэгцүүлэн жишиж тодорхойлох зэргээр институцын түвшинд харьцуулж авч үзэх нь арга зүйн хувьд чухал нөлөө үзүүлнэ.[141] " гэж тодорхойлсон байдаг.

Монгол улсын Эрүүгийн хуулийн **тавдугаар бүлэгт эрүүгийн хариуцлагын зорилго, ялын төрлийг тодорхойлж, ялыг** үндсэн ба нэмэгдэл ялын чанартай хэрэглэхээр ангилжээ.

БНХАУ-ын Эрүүгийн хуулийн гуравдугаар бүлэгт эрүүгийн шийтгэлийн төрлийг тодорхойлж гол эрүү ба нэмэлт эрүү гэж хуваасан байна.

Монгол улсын эрүүгийн хуульд үндсэн ял 4, нэмэгдэл ял 1 байхаар хуульчилсан.

Харин БНХАУ-ын эрүүгийн хуульд гол эрүүгийн төрөл /үндсэн ял/ 5, нэмэлт эрүүгийн төрөл /нэмэгдэл ял/ 3 байхаар хуульчилсан бөгөөд нэмэлт эрүүгийн төрлийг дангаар нь тохируулан хэрэглэж болохоор хуульчилжээ.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ	**БНХАУ-ын ЭРҮҮГИЙН ХУУЛЬ**
Тавдугаар бүлэг **Эрүүгийн хариуцлагын зорилго, төрөл**	**Гуравдугаар бүлэг** **Эрүү шийтгэл** **Нэгдүгээр хэсэг** **Эрүүгийн шийтгэлийн төрөл**
5.1 дүгээр зүйл. **Эрүүгийн хариуцлагын зорилго** Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт	**32-р зүйл.** Эрүүгийн шийтгэлийг гол эрүү ба нэмэлт эрүү гэж хуваана

[140] Г.Батзориг, Э.Зуунасан. БНХАУ-ын Эрүүгийн ба Эрүүгийн заргын хууль орчуулга УБ хот. 2006 он.
[141] Д.Баярсайхан. Харьцуулсан эрїігийн эрх зүй. УБ хот. 2012 он. 22 дахь тал

хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино.	
5.2 дугаар зүйл. **Ялын төрөл** Гэмт хэрэг үйлдсэн хүнд доор дурдсан ял оногдуулна: 1.торгох ял; 2.нийтэд тустай ажил хийлгэх ял; 3.зорчих эрхийг хязгаарлах ял; 4.хорих ял; 5.эрх хасах ял.	**33-р зүйл.** Гол эрүүгийн төрөл зүйл нь доорхи мэт байна. (Нэг) Захиран хамаарах; (Хоёр) Хорьж хөдөлмөрлүүлэх; (Гурав) Хугацаатай хорих; (Дөрөв) Хугацаагүй хорих; (Тав) Алахаар шийтгэх;
-Торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих ялыг үндсэн, -Эрх хасах ялыг нэмэгдэл ялаар хэрэглэнэ.	**34-р зүйл.** Нэмэлт эрүүгийн төрөл зүйл нь доорх мэт байна. **(**Нэг) Зоосоор ялгах; (Хоёр) Улс төрийн эрхийг хасах; (Гурав) Эд хөрөнгийг хурааж авах; Нэмэлт эрүүг дангаар нь тохируулан хэрэглэж ч болно.

Торгох ял

Монгол улсын хувьд үндсэн ял бөгөөд Эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдсэн хүнд дөрвөн зуун тавин нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний мөнгөн төлбөр оногдуулж, торгох ялыг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол биелэгдээгүй торгох ялын арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг нэг хоногоор тооцож хорих ялаар сольж болохоор хуульчилсан. Эрүүгийн хуульд заасан нэг нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байх бөгөөд Шүүх ялтны хөрөнгө, цалин хөлс, бусад орлого олох боломжийг харгалзан торгох ялыг гурван жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлөхөөр тогтоож болдог.

БНХАУ-ын хувьд нэмэлт ялд тооцдог. Эрүүгийн хуульд торгуулийн хэмжээг хэд байхыг томьёолоогүй байна. Харин хориглогдошгүй гай гамшиг учирвал, нөхцөл байдлыг тодруулж торгуулийн хэмжээг багасгах эсвэл бүрэн хэлтрүүлж болохоор хуульчилсан нь дэвшилттэй зүйл байна гэж үзэж байна.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ	**БНХАУ-ын ЭРҮҮГИЙН ХУУЛЬ**

5.3 дугаар зүйл. Торгох ял	Зургаадугаар хэсэг Зоосоор яллах
1.Гэмт хэрэг үйлдсэн хүнд энэ хуулийн тусгай ангид заасан торгуулийн нэгж /цаашид "нэгж" гэх/-тэй тэнцүү хэмжээгээр мөнгөн төлбөр оногдуулахыг торгох ял гэнэ. 2.Торгох ялын хэмжээ нь дөрвөн зуун тавин нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна. 3.Энэ хуульд заасан нэг нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байна. 4.Шүүх ялтны хөрөнгө, цалин хөлс, бусад орлого олох боломжийг харгалзан торгох ялыг гурван жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлөхөөр тогтоож болно. 5.Ялтан торгох ялыг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол шүүх биелэгдээгүй торгох ялын арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг нэг хоногоор тооцож хорих ялаар солино. 6.Нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих ялыг торгох ялаар солихгүй.	**52-р зүйл.** Зоосоор яллахаар шийтгэхдээ хийсэн ялынх нь үйл байдлыг үзэж яллах зоосны тоог тогтоох ёстой. **53-р зүйл.** Ялласан зоосыг шүүн таслалт тогтоосон хугацааны дотор нэг удаад буюу хугацаа хувааж тушаана. Хугацаа дүүргэлт тушаахгүй байвал албадан тушаалгана. Ялласан зоосыг бүгдийг тушааж дийлэхгүй байвал Ардын шүүх хороо гүйцэтгэгч хүнд гүйцэтгэж болох эд хөрөнгийг нь олж мэдмэгц цаг тухайд нь нэхэмжилж тушаалгах ёстой. Хориглогдошгүй гай гамшиг тушаахад үнэхээр учиртай болон байвал байдлыг нь үзэж багасгах буюу хэтрүүлж болно.

Нийтэд тустай ажил хийлгэх ял

Дээрх ял шийтгэл БНХАУ-ын эрүүгийн хуулийн ял шийтгэлийн төрөлд байдаггүй бөгөөд Монгол улсын ялын төрөлд дараах байдлаар тодорхойлжээ. Уг ялыг үндсэн ялын чанартай хэрэглэх бөгөөд гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг нийтэд тустай ажил хийлгэх ял гэнэ. Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт наймаас дээшгүй цагаар, нийт хоёр зуун дөчөөс долоон зуун хорин цагаар тогтооно.

Нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтан уг ялыг биелүүлээгүй бол нийтэд тустай ажил хийлгэх ялын найман цагийн ажлыг нэг хоногоор тооцож хорих ялаар тооцож сольж болохоор зохицуулсан бөгөөд

хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүнд, биеийн эрүүл мэндэд шууд нөлөөлөхүйц нийтэд тустай ажил хийлгэх ялыг жирэмсэн эмэгтэй, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй хүнд оногдуулахгүй байхаар хуульд заасан байна.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
5.4 дүгээр зүйл. **Нийтэд тустай ажил хийлгэх ял** 1.Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг нийтэд тустай ажил хийлгэх ял гэнэ. 2.Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт наймаас дээшгүй цагаар, нийт хоёр зуун дөчөөс долоон зуун хорин цагаар тогтооно. 4.Ялтан нийтэд тустай ажил хийлгэх ялыг биелүүлээгүй бол нийтэд тустай ажил хийлгэх ялын найман цагийн ажлыг нэг хоногоор тооцож хорих ялаар солино. 5.Нийтэд тустай ажил хийлгэх ялыг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүнд, биеийн эрүүл мэндэд шууд нөлөөлөхүйц нийтэд тустай ажил хийлгэх ялыг жирэмсэн эмэгтэй, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй хүнд оногдуулахгүй.

Зорчих эрхийг хязгаарлах ял

Дэлхийн улс орнуудын хууль, эрх зүйн хөгжил нь нийгмийн хөгжлийнхөө үйл явцтай зэрэгцэн шинэчлэгдэж боловсронгуй болсоор байгаагийн тод жишээ нь технологийн дэвшлийг ашиглан цахим төхөөрөмжийг гэм буруутай хүний биед зүүж байршлыг тогтоон, зорчих маршрутыг хязгаарлан, хяналт тавьдаг болсон ядвал юм.

Манай улсын хууль тогтоомж, бодлого боловсруулагчид энэхүү ялыг улсынхаа хөрсөнд буулгах гэж 2015 онд Эрүүгийн хуульд ялын бодлогыг тусгаж, 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хэрэгжих арга замыг батлуулж, хэрэгжилтийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлүүлэхээр тус тус заасан.

Монгол улсад шүүхээс ял шийтгэгдсэн этгээдийн зорчих хөдөлгөөнд хяналт тавих зарчмаар ашигладаг цахим тоног төхөөрөмжийг ял эдлүүлэх ажиллагаанд 2021 оноос хэрэглэж эхэлсэн бөгөөд, боловсронгуй болгох үйл явц явагдсаар байна.

Шүүхээс оногдуулсан хязгаарлалтын дагуу хориглосон болон зөвшөөрсөн бүс, замын чиглэлийг тогтоон өгч, тухайн ялтанд аюулгүй ажиллагааны болон ашиглалтын талаар тайлбар, танилцуулга, зааварчилгааг өгдөг бөгөөд хэрэв заасан

хориглолт, хязгаарлалтыг зөрчих, цахим бугуйвчийг таслах, гэмтээх зэрэг зөрчлийг гаргавал сануулга өгөх, гаргасан зөрчлөө дахин давтан гаргах, хориглолт хязгаарлалтыг ноцтой зөрчсөн тохиолдолд зорчих эрх хязгаарлах ялыг хорих ялаар солихоор хуульчилж өгсөн.

Зорчих эрхийг хязгаарлах ял нь хүний зан төлөв, үйлдсэн гэмт хэргийн байдал, нийгэмд учруулсан хор уршгийг харгалзан нийгэм, хамт олныхоо дунд ажил хөдөлмөр эрхлэх, сурч боловсрох, гэр бүл үр хүүхдээ тэжээн тэтгэх үүргээ биелүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлсэн ял шийтгэлийн нэг хэлбэр бөгөөд ялтан этгээдийг нийгэм, хамт олон, гэр бүлээс нь тусгаарлахгүйгээр ажиллаж, сурч байх явцдаа хүмүүжих, засрал төлөвшлийг олох боломжийг бий болгодог.

Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэл нь хүмүүнлэг ёсны үзэл санаа давамгайлснаараа уг ялаар шийтгэгдсэн ялтандаа, эдийн засгийн хувьд хэмнэлттэй байдлаараа улс эх орондоо давуу талыг олгодог бөгөөд орчин үеийн техник технологийн дэвшлийг ашиглан ялтан этгээдийн чөлөөтэй зорчих эрхэнд хязгаарлалт тогтоон, ялын мөн чанар, ялын зорилгыг хэрэгжүүлдгээрээ хүмүүнлэг энэрэнгүй нийгмийн сонгодог хэлбэрийг бүрдүүлдэг байна.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

5.5 дугаар зүйл.

Зорчих эрхийг хязгаарлах ял

1.Гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрх бүхий байгууллагын хяналтад өөрийн оршин суух газраас явахыг хориглох, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүргийг нэг сараас таван жил хүртэл хугацаагаар хүлээлгэхийг зорчих эрхийг хязгаарлах ял гэнэ.

2.Шүүх тухайн гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан ялтныг буcдад аюул учруулах эрсдэлтэй гэж үзвэл тодорхой хүнтэй, бусадтай харилцахыг хориглож болно.

3.Ялтан зорчих эрхийг хязгаарлах ялыг биелүүлээгүй бол ялтны зорчих эрхийг хязгаарлах ялын эдлээгүй үлдсэн хугацааны нэг хоногийг хорих ялын нэг хоногоор тооцож хорих ялаар солино.

4.Гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан шүүх энэ хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.1, 1.2-т заасан байдлаар зорчих эрхийг хязгаарлах ялыг хөнгөрүүлж, ялаас чөлөөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

Хорих ял

Монгол улсад хорих ялын үндсэн хугацаа адил 6 сараас 20 жил хүртэл байх бөгөөд эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд бүх насаар хорих хугацаагаар хорих ял шийтгэхээр хуульчилсан бол БНХАУ-д зарим гэмт хэрэгт оногдуулах ялыг хугацаагүй хорихоор шийтгэдэг байна.

Хуульд хорих дэглэмийг зааж өгсөн нь 2 улсын эрүүгийн хуульд адил мэт боловч Монгол улсын хувьд гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан хугацаатай хорих ял эдлэх дэглэмийг хуульчилж өгснөөрөө онцлог байна.

БНХАУ-ын хувьд хорих ял шийтгүүлсэн этгээд хөдөлмөрлөх чадалтайл бол заавал хөдөлмөрт оролцож хүмүүжигдэн өөрчлөгдөх талаар хуульчилжээ.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ	**БНХАУ-ын ЭРҮҮГИЙН ХУУЛЬ**
5.6 дүгээр зүйл. **Хорих ял** 1.Гэмт хэрэг үйлдсэн хүний эрх чөлөөг тодорхой хугацаагаар, эсхүл бүх насаар нь хязгаарлаж нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад байлгахыг хорих ял гэнэ. 2.Нээлттэй, хаалттай хорих байгууллагын нөхцөлийг хуулиар тогтооно. 3.Энэ хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн хүнийг зургаан сараас хорин жил хүртэл хугацаагаар нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад тусгаарлаж хугацаатай хорих ялыг эдлүүлнэ. 4.Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан хугацаатай хорих ялыг нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад эдлүүлэхээр тогтооно. 5.Энэ хуульд заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн хүнийг хаалттай хорих байгууллагад тусгаарлаж бүх насаар хорих ял эдлүүлнэ.	**Хугацаатай хорих, хугацаагүй хорих** **45-р зүйл.** Хугацаатай хорих хугацааг тус хуулийн 50-р зүйл, 69-р зүйлд тогтоосныг гаргавал 6 сараас дээш арван таван жилээс доош байлгана. **46-р зүйл.** Хугацаатай хорих, хугацаагүй хорихоор шийтгэгдсэн ялт этгээдийг гянданд буюу бусад гүйцэтгэх талбарт гүйцэтгэнэ. Хөдөлмөрөх чадалтай нь цөм хөдөлмөрт оролцож, хүмүүжигдэн өөрчлөгдөх ёстой. **47-р зүйл.** Хугацаатай хорих эрүүгийн хугацааг шүүн таслалтыг эрхлэн гүйцэтгэх өдрөөс тооцно. Шүүн таслалтыг гүйцэтгэхээс өмнө урьдаар хорьсон байвал хоригдсон нэг өдрийг нь эрүүгийн хугацааны нэг өдрөөр тооцно.

6.Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хүн хорин таван жил хоригдсоны дараа шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, ялтны хувийн байдлыг харгалзан суллах эсэхийг шийдвэрлэнэ. 7.Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан журмаар ялтныг суллаагүй бол хоёр жил тутам энэ талаар дахин хэлэлцэнэ. 8.Арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн хүнд бүх насаар хорих ял оногдуулахгүй. 9.Торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн этгээд шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийсэн бол ял шийтгүүлсэн гэмт хэрэгт нь хорих ял оногдуулахаар заасан эсэхээс үл хамааран эдлээгүй үлдсэн ялыг энэ хуулийн 5.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан журмын дагуу сольж хорих ял оногдуулна.	

Эрх хасах ял

Монгол улсын хувьд гэмт хэрэг үйлдсэн хүний нийтийн албанд ажиллах, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, эсхүл бусад тодорхой эрхийг, нэмэгдэл ялын чанартай хэрэглэхээр, ялын хугацаа болон ялыг хэрхэн тоолох зэргийг нарийвчлан зохицуулсан байхад БНХАУ-д нэмэгдэл ялын чанартай хэрэглэж Улс төрийн эрхийг нь хасаж шийтгэдэг байна.

Улс төрийн эрхэд сонгох сонгогдох эрх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, хурал цуглаан хийх, эвлэн нэгдэх, жагсаал цуглаан явуулах, Төрийн байгууллагад албан тушаал хаших, Улсын өмчлөлийн компанид аж ахуйлал, ажил үйлсийн нэгж хийгээд ардын байгууллагад удирдах албан тушаал хаших зэргийг хамааруулдаг байна.

Монгол улсад эрх хасах ялыг нийтийн албан тушаалтан болон тодорхой эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй этгээдэд оногдуулдаг бол БНХАУ-д улсын болон хувийн хэвшлийн удирдах ажилтан болон жирийн иргэнд ч оногдуулж болох байдлаар зохицуулжээ.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ	БНХАУ-ын ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
5.7 дугаар зүйл. **Эрх хасах ял** 1.Гэмт хэрэг үйлдсэн хүний нийтийн албанд ажиллах, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, эсхүл бусад тодорхой эрхийг нэг жилээс найман жил хүртэл, эсхүл энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар хориглохыг эрх хасах ял гэнэ. 2.Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан оногдуулсан үндсэн ял дээр нэмж эрх хасах ялыг оногдуулж болно. Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд эрх хасах ялыг заавал оногдуулна. 3.Шүүх эрх хасах ялыг хорих ял дээр нэмж оногдуулсан бол уг ялыг эдэлж дууссаны дараа, эсхүл торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ял дээр нэмж оногдуулсан бол ял оногдуулсан үеэс, эсхүл хорих ял оногдуулахгүйгээр үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авсан бол албадлагын арга хэмжээ авсан үеэс хугацааг тоолно. 4.Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан шүүх энэ хуулийн 12 дугаар бүлэгт заасан гэмт хэргийг хүүхдийн эсрэг, эсхүл 16 дугаар бүлэгт заасан гэмт хэргийг үйлдсэн эцэг, эх, асран хамгаалагч,	**Долдугаар хэсэг** **Улс төрийн эрхийг нь хасах** **54-р зүйл.** Улс төрийн эрхийг нь хасах гэж доорх эрхүүдийг хасах болно. 1, Сонгох эрх ба сонгогдох эрх; 2, Үг яриа тавих, хэвлэн нийтлэх, хурал цуглаан хийх, эвлэн хорших, жагсаал явуулах, сүр үзүүлэх чөлөөт эрх; 3, Төрийн байгууллагад тушаал үүрэх эрх; 4, Улсын өмчлөлийн компанид аж ахуйлал, ажил үйлсийн нэгж хийгээд ардын бүлгийг жолоодох тушаал үүрэглэх эрх; **55-р зүйл.** Улс төрийн эрхийг нь хасах хугацааг нь тус хуулийн 57-р зүйлд тогтоосныг гаргавал нэг жилээс дээш, таван жилээс доош байлгана. Захиран хамаарахаар шийтгээд улс төрийн эрхийг нь хасахаар нэмж шийтгэсэн байвал улс төрийн эрхийг хасах хугацаагаар захиран хамаарахын хугацаатай адил байлгах зэргээр гүйцэтгэнэ. **56-р зүйл.** Улсын амар төвшинд хор хөнөөл учруулсан ялт этгээдэд улс төрийн эрхийг нь хасахаар нэмж шийтгэх ёстой. Зориуд хүн алсан, хүчиндсэн, гал тавьсан, хор хаясан, тонон дээрэмдсэн зэрэг нийгмийн эмх дэглэмийг хүнд ноцтой эвдсэн ялт этгээдийн улс төрийн эрхийг нь хасахаар нэмж шийтгэж болно. Улс төрийн эрхийг нь хасахаар дангаар тохируулан хэрэглэвэл хуулийн

харгалзан дэмжигчид оногдуулсан үндсэн ял дээр нэмж эрх хасах ялыг оногдуулж болно.	хуваарь дүрмийн тогтоолыг үндэслэнэ. **57-р зүйл.** Алах эрүү ба хугацаагүй хорих ялаар шийтгэгдсэн этгээдийн улс төрийн эрхийг нь нэг насаар нь хасах ёстой. Алах эрүүг нь алгуурлан гүйцэтгэх эрхийг нь хугацаатай хорих болгон хөнгөрүүлэх үед улс төрийн эрхийг нь хасах нэмэлт эрүүг нь гурван жилээс дээш арван жилээс доош болгож бууруулах ёстой. **58-р зүйл.** Улс төрийн эрхийг нь хасах нэмэлт эрүүгийн хугацааг хорих эрүү, хорьж хөдөлмөрлүүлэх эрүү дуудсан өдөр буюу тэнсэн сулласан өдрөөс эхлэн бодно. Улс төрийн эрхийг хасах эрүү нь гол эрүүгийн гүйцэтгэлийн хугацаанд хүчинтэй. Улс төрийн эрх нь хасагдсан ялт этгээд гүйцэтгэлийн хугацаанд хууль цааз, засаг захиргааны хууль тогтоол болон төрийн албаны хорооны дотоодыг хамгаалах салаа мөчрийн хамаа бүхий хянан хамааралтын тухай тогтоолыг журамлан сахиж хяналтыг дагах ёстой. Тус хуулийн 54-р зүйлд тогтоосон эрхүүдийг хэрэглэж болохгүй.

ХОРЬЖ ХӨДӨЛМӨРЛҮҮЛЭХ ЯЛ

Дээрх ял нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар хорих бөгөөд ял шийтгэгдсэн этгээдийг хорьж хөдөлмөрлүүлж, мөн ажлын хөлсийг тооцож олгодог байхаар зохицуулжээ. БНХАУ-ын хувьд дээрх ялыг үндсэн ялын чанартайгаар хэрэглэж байна.

БНХАУ-ын ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
Гуравдугаар хэсэг **Хорьж хөдөлмөрлүүлэх**

42-р зүйл. Хорьж хөдөлмөрлүүлэх хугацааг нэг сараас дээш зургаан сараас доош байлгана.

43-р зүйл. Хорьж хөдөлмөрлүүлэх шийтгэгдсэн ялт этгээдийг дотоодын хамгаалах байгуулагад ойрхон газарт нь гүйцэтгэнэ.

Гүйцэтгэлийн хугацаанд хорьж хөдөлмөрлүүлэхээр шийтгэгдсэн ялт этгээд сард нэгээс хоёр өдрийн чөлөөгөөр гэртээ харьж болно. Хөдөлмөрт оролцвол зохих хэмжээний хөлс хүч олгож болно.

44-р зүйл. Хорьж хөдөлмөрлүүлэхийн эрүүгийн хугацааг нь шүүх таслалтыг эрхлэн гүйцэтгэх өдрөөс бодно. Шүүн таслалтыг гүйцэтгэхээр өмнө урьдаар хорьсон байвал хоригдсон нэг өдрийг нь эрүүгийн хугацаанд нэг өдрөөр тооцно.

Цаазаар авах ял

Монгол улсын хувьд Монгол улсыг цаазын ялгүй орон хэмээн даян дэлхийд зарлаж, цаазаар авах ялыг 2015 онд шинэчлэн баталсан Эрүүгийн хуульд тусгаагүй явдал нь хүний эрхийг хангах баталгаа болсон билээ.

Харин БНХАУ-д ял үйлдэх үедээ 18 насанд хүрээгүй болон шүүн таслах үед жирэмсэн байгаа эмэгтэйд алах ялыг хэрэглэхгүй бөгөөд бусад этгээдэд хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн бол алах ялыг хэрэглэхээр зохицуулжээ.

БНХАУ-ын хувьд Ардын шүүх хорооны шүүн таслахаас бусад алах эрүүг бүгдийг нь Ардын дээд шүүх хороонд мэдүүлж хянан зөвшөөрүүлэх ёстой бөгөөд алах эрүүг алгуурлан гүйцэтгэхийг ардын өндөр зэргийн шүүх хороо шүүн таслах буюу хянан зөвшөөрч болно. Алгуурлан гүйцэтгэх хугацаа 2 жил байхаар зохицуулсан бөгөөд энэ хугацаанд зориуд ял хийгээгүй байвал хоёр жилийн хугацаа нь дууссаны дараа хугацаагүй хорих болгож хөнгөрүүлнэ. Үнэнхүү чухал их гавьяа байгуулсан нь илрэлтэй байвал хоёр жилийн хугацаа дууссаны дараа арван таван жилээс дээш, хорин жилээс доош хугацаатай хорих болгон хөнгөрүүлдэг байна.

БНХАУ-ын ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

Тавдугаар хэсэг

Алахаар шийтгэх

48-р зүйл. Эрүүг гагцхүү туйлын хүнд ял хийсэн ялт этгээдэд л тохируулан хэрэглэнэ. Алахаар шийтгэх ёстой ялт этгээдийг заавал доор нь гүйцэтгэх хэрэгтэй биш байвал алахаар шийтгэхийг хоёр жил алгуурлан гүйцэтгэж болно.

Хууль ёсоор Ардын шүүх хорооны шүүн таслахаас бусад алах эрүүг бүгдийг нь Ардын дээд шүүх хороонд мэдүүлж хянан зөвшөөрүүлэх ёстой. Алах эрүүг алгуурлан гүйцэтгэхийг ардын өндөр зэргийн шүүх хороо шүүн таслах буюу хянан зөвшөөрч болно.

49-р зүйл. Ял хийх үедээ бүх л арван найман насанд үл хүрсэн ба шүүх таслах үед жирэмсэн байх эмэгтэйд алах ялыг тохируулан хэрэглэхгүй.

50-р зүйл. Алахаар шийтгэхээр алгуурлан гүйцэтгэгсэд алахыг алгуурлан гүйцэтгэх хугацаа нь хэрвээ зориуд ял хийсэнгүй байвал хоёр жилийн хугацаа нь дууссаны дараа хугацаагүй хорих болгож хөнгөрүүлнэ. Үнэнхүү чухал их гавьяа байгуулсан нь илрэлтэй байвал хоёр жилийн хугацаа дууссаны дараа арван таван жилээс дээш, хорин жилээс доош хугацаатай хорих болгон хөнгөрүүлнэ. Хэрвээ зориуд ял хийсэн бөгөөд байцаан тодлоод үнэн магад байвал. Ардын дээд шүүх хороогоор хянан зөвшөөрүүлээд алах эрүүг гүйцэтгэнэ.

51-р зүйл. Алахаар шийтгээд алгуурлан гүйцэтгэх хугацааг нь шүүх таслалтыг нь тогтоосон өдрөөс эхлэн бодно. Алах эрүүгийн алгуурлан гүйцэтгэхийг хугацаатай хорих болгон хөнгөрүүлсэн байвал түүний эрүүгийн хугацаатай хорих болгон хөнгөрүүлсэн байвал түүний эрүүгийн хугацааг түүний алах эрүүгийн алгуурлан гүйцэтгэх хугацаа дууссан өдрөөс эхэлж болно.

Захиран хамаарах ял

БНХАУ-н эрүүгийн хуулийн 38-р зүйлд Захиран хамаарах хугацааг гурван сараас дээш, хоёр жилээс доош байлгана. Захиран хамаарагдахаар ял этгээдийг Дотоод хамгаалах байгууллагаас гүйцэтгэнэ.

Доктор Д.Баярсайхан дээрх ялыг Хяналт тогтоох ял[142] гэж тодорхойлоод 2 сараас 3 жил хүртэл хугацаатай байх бөгөөд дотоодыг хамгаалах байгууллагын шууд хяналтад ялыг хэрэгжүүлдэг байна. Монгол улсын хувьд дээрх ялын төрөл хуульчлагдаагүй байна.

БНХАУ-ын ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

Захиран хамаарах

38-р зүйл. Захиран хамаарах хугацааг гурван сараас дээш, хоёр жилээс доош байлгана. Захиран хамаарагдахаар ял этгээдийг Дотоод хамгаалах байгууллагаас гүйцэтгэнэ.

39-р зүйл. Захиран хамаарагдахаар шийтгэгдсэн ялт этгээд гүйцэтгэлийн хугацаандаа доорх тогтоолуудыг журамлан сахих ёстой.

(Нэг) Хууль цааз, засаг захиргааны хууль, тогтоолыг журамлан сахиж,

(Хоёр) Гүйцэтгэх байгууллагын зөвшөөрөлгүйгээр үг яриа тавих, хэвлэн нийтлэх, хурал цуглаан хийх, эвлэрэн хорших, жагсаал явуулах, сүр үзүүлэх чөлөөт эхийг хэрэглэж болохгүй

[142] Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ хот. 2006 он. 259 дэх тал

(Гурав) Гүйцэтгэх байгууллагын тогтоолоор өөрийн ажиллагааны байдлаа мэдүүлэх үүрэгтэй

(Дөрөв) Зочинтой уулзах тухай Гүйцэтгэх байгууллагын тухай журмыг журамлан сахих хэрэгтэй.

(Тав) Сууж байгаа хот, суурьнаас салах буюу нүүж явбал гүйцэтгэх байгууллагад мэдэгдэж зөвшөөрүүлэх ёстой.

Захиран хамаарагдахаар шийтгэгдсэн ялт этгээдэд хөдөлмөрийн дунд адил хөдөлмөрт адил хөлс авах ёстой.

40-р зүйл. Захиран хамаарагдахаар шийтгэгдсэн ялт этгээдийн захиралтын хугацааг нь дүүрвэл гүйцэтгэх байгууллага нь тус хүн ба түүний байгаа нэгжид нь буюу сууж байгаа газрынх нь олон түмэнд захирагдлаас чөлөөлснийг нь захирвал зохино.

41-р зүйл. Захиран хамаарах эрүүгийн хугацааг нь шүүн таслалтыг гүйцэтгэсэн өдрөөс эхэлж бодно. Шүүн таслалтыг нь гүйцэтгэхээс өмнө урдаар хорьсон байвал хоригдсон нэг өдрийг нь эрүүгийн хугацааны хоёр өдрөөр нугалан бодно.

Монгол улсын Эрүүгийн хуулийн ялын төрлийг БНХАУ-ын Эрүүгийн хуулийн ялын төрөлтэй харьцуулан судлахад 2 улсын ял шийтгэлийн төрөл ерөнхийдөө адил төстэй бөгөөд тухайн орны нийгэм эдийн засгийн байдал, соёл, өв уламжлал, ёс заншил, төрийн тогтолцоо, эрх зүйн бүлээсээ хамаарч тус тусын онцлогтой байна.

Монгол улсын хувьд дэлхий нийтийн эрүүгийн эрх зүйн чиг хандлагатай хөл нийлүүлэн эрүүгийн ялын бодлогодоо хорихоос өөр төрлийн ялыг түлхүү оруулж өгсөн нь судалгаанаас харагдаж байна.

Тухайлбал шинэчлэн баталсан эрүүгийн хуульд 215 төрлийн үйлдэл /эс үйлдэхүй/-ийг гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан байдаг бөгөөд тэдгээрийн 127 гэмт хэрэгт шинэ тутам хэрэгжиж байгаа зорчих эрхийг хязгаарлах ялыг оногдуулахаар хуульчилжээ.

Судалгааны явцад БНХАУ-ын хорих ялын бодлого нь хорих ялаар шийтгэгдсэн этгээдийг заавал ажил хөдөлмөр эрхлүүлэхэд оршдог бөгөөд энэ нь уг хуулийн хөдөлмөрлөх чадалтай л бол заавал хөдөлмөр эрхлүүлнэ гэж томьёолсноос тодхон харагдана.

Мөн торгох ялыг хэмжээг хуульд тодорхой зааж өгөөгүй байгаа нь тухайн гэмт этгээдийн хөрөнгө чинээ, орлого зэргийг харгалзан шүүхээс тогтоож болохоор нээлттэй байгааг Монгол улсад тусган авч хэрэгжүүлэх зүйтэй байна. Хуулийн дээрх заалт өдгөө манай улсад шүдний өвчин мэт асуудал үүсгэж байгаа торгуулийн ялын биелэлтэд чухал ахиц гаргана гэж судлаачийн хувьд үзэж байна.

Гэмт этгээдийн эд хөрөнгийг хураахаас өмнө төлбөр авагч, хохирогчийн хохирол төлбөрийг эхлэн барагдуулж байгаа нь сайшаалтай байна.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

Хууль тогтоомж:

1. Эрүүгийн хууль 2015 он

Ном гарын авлага:

1. Г.Батзориг, Э.Зуунасан. БНХАУ-ын Эрүүгийн ба Эрүүгийн заргын хууль орчуулга УБ., 2006
2. Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2006.
3. Д.Баярсайхан. Орчин үеийн эрүүгийн эрх зүйн хөгжлийн хандлага. Шударга ёс сэтгүүл. УБ., 2010

Цахим эх сурвалж:

1. https://www.criminology.mn
2. https://www.legalinfo.mn

---o0o---

ГЭР БҮЛ БА ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН
/алслагдсан сумдын жишээ нь дээр/



Л.Лхагвасүрэн
Хилийн албаны сургуулийн
Ар тал, эдийн засгийн тэнхимийн дэд профессор,
Хил судлал, боловсрол судлалын магистр, хошууч

Товч утга: Миний судалгааны ажилд Монгол Улсын сүүлийн 5 жилийн гэр бүл төлөвлөлтийн байдал түүнийг дагасан шилжилт хөдөлгөөний талаар судалж түүнд үнэлэлт дүгнэлт өглөө. Судалгаанаас харахад сүүлийн 5 жилийн хугацаанд өмнөх оны мөн үеэс гэр бүл салалт нь харьцангуй ихсэж, гэрлэлтийн тоо нь буурч хоорондын хамаарал нь урвуу хамааралтай байна. Энэ хамаарал нь хилийн анги салбарт тодорхой хэмжээгээр оршиж байгааг анхаарал татаж байна. Монгол Улсад өнөөдрийн байдлаар гэр бүлээс гадуурх амьдралыг хуульчилсан эрх зүйн акт байхгүй байна. Төрөөс залуу гэр бүлийг дэмжих талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ болон бусад нөлөөлөх хүчин зүйлийн талаар товч өгүүлэх болно.

Түлхүүр үгс: Залуучууд, гэр бүл, шилжилт, хөдөлгөөн, хил хамгаалах байгууллага.

Abstract: In my research, the family of Mongolia over the past five years analyzed the planning situation that followed him and evaluated him. Studies have shown that over the past five years, divorce rates have increased relatively from the same period the previous year, and the correlation between the number of marriages decreases is treacherous. It's noteworthy that this dependency is somewhat present in the border class sector. In Mongolia today, there is no legal action against extramarital life. The Government will provide a brief overview of the measures being taken to support young families and other influencing factors.

Keywords: Youth, family, migration, movement and border protection organization..

Өнөөгийн Монгол Улсын нийгэмд төрөлт буурч, хүн амын хөгшрөлт, гэр бүл, хүн амын хомсдол, эдийн засгийн тогтворгүй байдал, бүс нутгийн хүмүүсийн

харилцаа суларч байна. Хүмүүсийн амьдралыг тойрсон хүрээлэн буй орчны томоохон өөрчлөлтүүдийн дунд амьдралын янз бүрийн асуудал үүсэн бий болж байна.

Нэг талаараа ард иргэдийн амьдралд төрийн тогтолцоо болох тэтгэвэр, эмнэлгийн даатгал, халамжийн тогтолцоо зэрэг нийгмийн хамгааллын тогтолцоо нь иргэдийн асуудлыг дэмжих үүднээс хувьсан өөрчлөгдөж байгаа боловч ар араасаа гарах нийгмийн сөрөг зүйлсээс шалтгаалж тогтвортой байдал ганхаж, хөдөлмөр эрхлэлтийн байдал хүндэрч, орон нутгийн засаг захиргаа санхүүгийн хувьд бэрхшээлтэй байдалд орж байна. Үүнийг дагаад ард түмний амьдралыг тэтгэдэг нийгмийн тогтолцоо маш их ганхаж олон төрлийн эрсдэлд оруулж байгаа юм.

Энэ нийгмийн ганхалтыг үед хамгийн эмзэг дусах хэсэг бол Монголын залуу гэр бүлүүдэд хамгийн хүнд тусах магадлалтай юм. Судлаач миний судалгааны ажилд Монгол Улсын залуу гэр бүлийн өнөөгийн байдал тэдэнд үзүүлэх нийгмийн халамжийн байдал төрөөс авах дэмжлэгийн талаар болон хилийн салбар, ангид шинээр гэр бүл болж байгаа залуусыг хэрхэн урамшуулж нийгмийн баталгааг хангах талаар судлахыг зорилоо.

Судалгааны ажлын арга зүй: Баримт материал судлах, ажиглалтын арга, түүхэн ба логик арга, түүврийн арга, статистик боловсруулалтын аргуудыг ашигласан.

Судалгааны үр дүн: Гэрлэлт гэж юу вэ? Гэрлэлт гэдэг бол ирээдүйн амьдралын аз жаргалын эхлэл юм. Бид та бүхэнд гэрлэлтийг хэдхэн өгүүлбэрээр, хөгжилтэй байдлаар маш товчхоноор тайлбарлая.

1. Зөвхөн түүний тухай бодно.
2. Түүнийг гэртээ ирэхэд нь гэрийн шаахайг нь авчирч өгнө
3. Бие биедээ сайхан санагдах өхөөрдсөн нэр өгнө
4. Нэг зүйлрүү тэмүүлж амьдарна
5. Хамтдаа дэлгүүр хэснэ
6. Түүнийгээ тэвчээртэйгээр хүлээнэ
7. Хамтдаа TV-н нэг суваг үзнэ.
8. Асуудлаа хамтдаа шийдвэрлэнэ
9. Насан туршдаа хамтдаа байна
10. Гэрлэх зорилгын талаар явуулсан сэтгэл судлаач Мацковскийн судалгаагаар:

- Хvvхэдтэй болж удам угсаагаа vргэлжлvvлэх-66%
- Эсрэг хvйсийн хvнтэй дотны харилцаатай байх хэрэгцээ- 37%
- Гэр бүлээр дамжуулан хүн өөрчлөгдөн, төлөвшдөг- 27%
- Ганцаардлаас ангижрах зорилготой-26%
- Шинэ амьдрал бүтээх зорилготой-24 %
- Хайртай хүнээсээ хагацахыг хүсээгvй учраас-19% нь гэр бүл болсон гэж

хариулсан байна. Гэрлэлтийн үр дүнд бий болсон тодорхой эрх үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг “гэр бүл” гэнэ.

Энэ судалгаанаас үндэслээд гэр бүл гэж чухам ямар үүрэгтэй мөн үг зүйн утга агуулгыг нь судалж үзэхэд

Гэр бүл: “Гэрийн доторх хүн ам”[143]

Гэр бүл гэж хамтдаа амьдардаг, бие биетэйгээ ямар нэгэн холбоотой (цусан холбоотой, гэрлэсэн г.м.) бүлэг хүмүүс буюу амьтдыг (зарим амьтад нь үр төлөө асарч гэр бүлтэй төсөөтэй зүйлийг бүрдүүлдэг) хэлнэ. Гэр бүлийн анхдагч үүрэг нь үр удмаа нөхөж үйлдвэрлэх, өсгөж хүмүүжүүлэх явдал юм гэж ойлгож болохуйц байна.

Өнөөдөр Монгол улсад өдөрт дунджаар 40 хос гэрлэлтээ батлуулж байхад 10 нь гэр бүлээ цуцлуулдаг байна. Энэ нь жилд 16-17 мянган хос гэрлэлтээ батлуулдаг ч дөрвөн мянга нь гэр бүлээ цуцлуулдаг гэсэн үг.

Орчин цагт гэр бүл төлөвлөж амьдарна гэдэг нь нийгмийн нэг давалгаанд нэгдэн орж амьдралын өмнө тэнцвэртэй орших уу эс орших уу гэдэг нь их чухал болсон байна. Монгол Улсад сүүлийн таван жилийн байдлаар харуулахад


Хүснэгт.1 Гэр бүл салалт тоон судалгаа

Статистик үзүүлэлт	Насны бүлэг	2017	2018	2019	2020
Эрэгтэй	18-19	181	188	221	156
	20-24	4,783	4,730	4,511	3,510
	25-29	8,275	8,018	7,481	5,168
Эмэгтэй	18-19	652	602	641	531
	20-24	6,619	6,408	6,279	4,657
	25-29	7,390	7,534	6,827	4,728

Дээрх судалгааг нэгтгэж графикаар харуулбал

Зураг.1 Гэр бүл салалт хүйсийн харьцаагаар

Судалгаанаас харахад 25-29 насны эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гэр бүл салалтын тоо харьцангуй их байгаа нь ажиглагдаж байна. Сүүлийн жилүүдэд гэр



[143] Монгол хэлний их тайлар толь

бүл салалтад олон хүчин зүйл нөлөөлж байгаа боловч эсрэгээрээ гэрлэлтийн байдлыг үзэхэд

Хүснэгт.2 Гэрлэлтийн байдал /Улсын дүнгээр/

Аймаг	Аймгийн код	Гэр бүлийн байдал	2017	2018	2019	2020
Улсын дүн	0	Гэрлэлт	20,470	21,020	20,043	14,252

Хүснэгт.3 Гэрлэлтийн өсөлт бууралт

Аймаг	Гэр бүлийн байдал	Аймгийн код	2017 Өсөлтийн хувь	2018 Өсөлтийн хувь	2019 Өсөлтийн хувь	2020 Өсөлтийн хувь
Улсын дүн	0	Гэрлэлт	0	2.7	-2.1	-30.4

Улсын дүнгээр 2017 оныхтой харьцуулахад гэрлэлтээ батлуулсан айл өрх 30,4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ тоо жил ирэх тусам гэрлэлт баталгаажуулж буй айл өрхийн тоо буурсаар байна. Хил Хамгаалах байгууллага хилийн анги, салбар дээр алба хааж байгаа залуу гэр бүлүүдэд ч гэсэн дээрх судалгаануудад хамааралтай бөгөөд сүүлийн жилүүдэд хилийн анги, салбарт гэр бүл салалт огцом нэмэгдэх хандлагатай байна. Судлаач миний бие уг асуудлыг хөндөх болсон гол шалтгаан нь хил дээр алба хааж байгаа залуу гэр бүлүүдэд нөлөөлж буй хүчин зүйлүүд болон түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар санал зөвлөмж хүргэх зорилготой юм. Гэр бүл салалтад нийгмийн олон хүчин зүйлсээс болсон байх боломжтой. Гэр бүл салалтад дараах зүйлс нөлөөлж байна.Үүнд

- Соёлын ялгаа, Харь орны хүнтэй гэрлэсэн, Мөн хоёр өөр гэр бүлийн соёлын мөргөлдөөн.
- Гэр бүлийн гишүүд хариуцлагаа бүрэн ухамсарлаагүй
- Гэрлэх хүнээ сайн таньж мэдээгүй
- Санхүүгийн хомсдол, цалин орлого, амьдралын баталгаа
- **Шилжилт хөдөлгөөн**
- Архидалт, муу зуршил
- Гэр бүлээс гадуурх харилцаа, Хууралт.
- Хэрүүл маргаан, Үл ойлголцол.
- Хүчирхийлэл, Дарамт шахалт гэх зэрэг хүчин зүйлүүд нөлөөлөх боломжтой юм. Дээрх олон хүчин зүйлээс зөвхөн шилжилт хөдөлгөөний талаар товч судалбал.

Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний өнөөгийн байдал, түүний шалтгаан нь

Шилжилт хөдөлгөөний суурь шалтгааныг тодруулснаар богино хугацаанд сааруулах, дунд хугацаанд зогсоох, удирдах төрийн нэгдсэн бодлого боловсруулахад чухал ач холбогдолтой. Иймд энэхүү хэсэгт хүн амын шилжих хөдөлгөөний шалтгааныг улсын хэмжээнд (том зургаар) авч үзсэн болно.

Уугуул нутгаа орхин шилжигчдийн насны бүтцийн тархалтыг ажиглахад дийлэнх хэсгийг ихэвчлэн залуу, хөдөлмөрийн насны хүн ам эзэлж байна. Шилжин суурьшиж байгаа өрхийн хүн амын дийлэнх хувийг 25–39 насны залуучууд ба тэдгээрийн даган шилжиж буй 10 ба түүнээс доош насны хүүхдүүд, ахмад настнууд эзэлж байна.

Шилжигч өрхийн хүн амын ачаалал харьцангуй өндөр байгаа нь тус чиглэлээр хийгдсэн судалгаагаар нотлогдож байна[144]. 0–14 насны хүүхэд, 65–аас дээш насны хүн ам нь гэр бүлийн залуу өрхийг даган өөр орон нутагт шилжин явдаг гэж үзвэл, шилжигч өрхийн бүтцэд ахмадууд болон хүүхдүүдийн эзлэх тоо шилжигч бус өрхийн бүтцээс 13 хувиар өндөр байна[145]. Шилжигч бус өрхийн хөдөлмөрийн насны 10 хүнд 6–аас доош ахмад настан болон хүүхэд ногдож байхад шилжин явсан өрхийн 10 хүн тутамд 7 ахмад настан болон хүүхэд ногдож байна.

Шилжигсдийн дунд боловсролтой шилжигчдийн эзлэх дүн өндөр байгаа нь залуучууд сурч боловсрох боломжоор илүүтэйгээс гадна их дээд боловсрол эзэмшихээр шилжих хөдөлгөөнд илүү оролцож байгааг харуулж байна. Шилжигсдийн 38 орчим хувь нь бүрэн дунд боловсролтой байгаа бол тэдний 23% нь дээд боловсролтой, түүний дотор бакалавр, магистрын зэрэгтэй хүмүүс байна. Энэ тоо баримт нь шилжигчдийн дийлэнх залуу насны хүн ам байгаа учир тэд ахмад настай хүмүүстэй харьцуулахад, боловсрол эзэмших боломжоор илүү, мөн мэргэжил үйлдвэрлэл, их дээд сургуульд суралцахын тулд шилжилтэд оролцдог эсвэл мэргэжлийн дагуу ажиллах боломжийг хайн шилжиж байгааг харуулна (ОУШХБ, 2016 он).

[144] Монгол Улс: хүн амын дотоод шилжих хөдөлгөөний судалгаа, 2016
[145] Монгол Улс: хүн амын дотоод шилжих хөдөлгөөний судалгаа, 2016

Зураг. 2 Шилжин явагчдын боловсролын байдал




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хөдөөнөөс хот, суурин газарт шилжих хөдөлгөөний шалтгаан

Хүн ам зүйн шилжих хөдөлгөөнийг хөдөөгөөс сум, аймгийн төврүү чиглэсэн хөдөлгөөн, Аймгийн төвөөс томоохон хот,нийслэл рүү зэрэг хотруу чиглэсэн хөдөлгөөн гэж хоёр ангилж үзсэн. Энэхүү 2 төрлийн шилжилт хөдөлгөөн нь харилцан уялдаатай байгаа бөгөөд ихэвчлэн шилжигчид эхний ээлжинд сум, аймгийн төврүү шилжилтийг хийж, дараагийн ээлжид аймгийн төвөөс хот руу чиглэсэн шилжилтийг үйлдэж байна.

Хөдөөгөөс сум, аймгийн төв рүү шилжиж байгаа шалтгааны 81.7 хувийг эдийн засгийн , 10 хувийг гэр бүлийн шалтгаан эзэлж байна. Гэр бүлийн шалтгаан нь эхнэр эсвэл нөхрийн ажлын байрыг даган шилжих хөдөлгөөн эсвэл нэгэнт аймаг, сумын төвд ажил хөдөлмөр эрхэлж, амьдран сууж буй гэр бүлийн гишүүнтэйгээ ойртох шалтгаан зонхилж байна.

Харин томоохон хот,нийслэл рүү шилжих шалтгааны 46.9 хувь нь эдийн засгийн, 25.8 хувь нь гэр бүлийн, 12.5 хувь боловсрол, эрүүл мэндийн 11.5 хувь амьжиргааны нөхцөл байдлаа сайжруулах, 3.3 хувь бусад нөхцөлөөр тайлбарлагдаж байна.



Зураг. 3 Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудруу шилжигсдийн шалтгаан


Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо

Зураг. 4 Аймаг, аймгийн төврүү чиглэсэн шилжих хөдөлгөөний шалтгаан

Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо

Эдийн засгийн шалтгааныг авч үзвэл :

- Цаг уурын хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалан малаа алдсан иргэд цалин хөлстэй ажил хийхээр хот, суурин газар руу шилжих;
- Дээд болон дунд боловсрол эзэмшсэн залуус орон нутагт нь ажлын байр



байхгүйгээс хот суурин газарт ирж мэргэжлийн дагуу ажил хөдөлмөр эрхлэх;


- Амьжиргааны болон байр орон сууцны нөхцөлөө сайжруулж, хүүхдээ цэцэрлэг сургуульд ойртуулах зэрэг орж байна.

Шилжилт хөдөлгөөний нөгөө өнцөг нь тусдаа ажиллаж амьдарч байгаа залуу хосууд маш их байна. Улаанбаатар их сургуулийн Гэр бүлийн тэнхимийн

эрхлэгч доктор, дэд профессор Б.Оюун-Эрдэнийн ярилцлагад дурдсанаар “Шүүхээр гэр бүлээ цуцлуулж байгаа хосуудын мэдүүлэг болон судалгаанаас авч үзэхэд гурван шалтгаан байна. Нэгдүгээрт, гэр бүлийн хүчирхийлэл, архидалт, үл ойлголцлын асуудлууд байна. Хоёрдугаарт, гэрлэлтээс гадуурх бэлгийн харилцаанд ордог. Гуравдугаарт, хол тусдаа байсан гэсэн шалтгаанаас үүдэж гэр бүл салж байна”[146] гэж дурдсан байдаг. Хилийн анги салбарт алба хааж байгаа залуу офицеруудын 30-40 хувь нь гэр бүлээсээ тусдаа ганцаараа амьдарч байгаа нь онцгой анхаарал татахуйц байгаа юм. Ийнхүү хөдөлмөр шилжилтийн улмаас тусдаа амьдарч байгаа гэр бүлүүд уул уурхай, төрийн болон цэргийн байгууллага, гадаадад ажиллаж буй залуучууд гэх зэрэг Монгол Улсын гэрлэх насанд хүрсэн болон гэрлэлтээ батлуулсан хүмүүсийн 20 гаруй хувийг эзэлж байгаа нь Улсын хувьд ирээдүйд хүн амын өсөлтөд сөргөөр нөлөөлөхүйц байгаа юм.

Төрөөс залуу гэр бүлийг залуу гэр бүлийг дэмжсэн орчин, нөхцөл бүрдүүлж, цогц үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх чиглэлээр хангахын тулд дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна.[147]

- Алсын хараа 2050
- Хүүхдийн тоо, наснаас хамааруулан хөнгөлөлт эдлүүлэх, хуримтлал бий болгох тогтолцоо бүрдүүлнэ.
- Залуучуудын эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжих, бодит хуримтлал бий болгоход чиглэсэн “Залуу гэр бүл” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Ажил хөдөлмөр эрхэлдэг эцэг эхэд ажлаар гэрийн амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлнэ. (эцэг эхийн ажлын цагийн зохицуулалтыг оновчтой, сонголттой болгох, хагас цагийн хөдөлмөр эрхлэлт, зайнаас ажиллахыг дэмжих),



ГЭР БҮЛ

ЗОРИЛТ 2.3 Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжиж идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлнэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, УЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
ГЭР БҮЛД ЭЭЛТЭЙ ТОГТОЛЦОО	БҮТЭЭЛЧ ГЭР БҮЛ	ӨРХ, ГЭР БҮЛ, ЧАНАРТАЙ АМЬДРАЛ
Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжих үе	Идэвхтэй бүтээлч иргэн, гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх үе	Нийгмийн идэвхтэй, бүтээлч гэр бүлийг дэмжих орчинг бүрдүүлэх үе
1. Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжсэн судалгаа, нотолгоонд суурилсан гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын үр ашиггүй тогтолцоо бүрдүүлэх 2. Залуу гэр бүлийг дэмжсэн орчин, нөхцөл бүрдэж, цогц үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх	1. Хүн амын бүлгүүдийг, тэр дотроо залуу болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дэмжсэн, бүтээмжтэй ажил, хөдөлмөр эрхлүүлж, ижил үнэ цэнтэй ажилд ижил цалин хөлс олгох тогтолцоог бүрдүүлэх олон талт хөгжил, хамгааллын цогц тогтолцоо төлөвшүүлэх 2. Гэр бүл, хувь хүний хөгжлийн хэрэгцээг дэмжсэн орчин, нөхцөл бүрдүүлж, цогц үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх	1. Хүн амын амьдралын чанарыг сайжруулахад чиглэсэн цогц үйл ажиллагааг хэрэгжүүлж, дэлхийд үнэлэгдэхүйц Монгол иргэнийг төлөвшүүлэх

- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Оюутны хөдөлмөрийн бирж” байгуулж хөгжүүлнэ.

[146] http://newsmedia.mn/9245
[147] Алсын хараа 2050

- Гадаадад сурч, ажиллаж, амьдарч байгаа иргэдийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Залуу гэр бүлд сэтгэл зүйн чиглэлээр зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлж, мэргэжлийн, судалгааны болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллана.

Ганцхан төрөөс ч гэлтгүй бусад төрийн бус байгууллага болон олон улсын байгууллагуудаас залуу гэр бүлийг дэмжих талаар олон төрлийн хөтөлбөр, төсөл арга хэмжээнүүдийг авч байгаа боловч сүүлийн жилүүдэд гэрлэлтээ батлуулж буй залуучуудын тоо эрс буурч эсрэгээрээ гэр бүл салалт олширч байгаа нь анхаарал татаж байна. Учир нь дэлхий нийтийг хамарсан цар тахал болон нийгэм эдийн засгийн хүндэвтэр байгаа өнөө цагт залуу гэр бүлүүдэд санхүүгийн эрх чөлөөнд хүрэх хүсэл эрмэлзлэлийг нухчин дарж үгүйсгэж байна. Нэг өрхийн дундаж орлого өнөөдрийн байдлаар 1,508,837 төгрөг байгаа нь зах зээлийн нийгэмд шилжсэн өнөө үед бол өдрийн хэрэглээгээ хангахуйц л хэмжээнд байна. Гэтэл хүний хэрэгцээ хязгааргүй байдаг нь өрх бүр өөрсдийн орлогыг тодорхой хувиар өсгөх, хязгаагүй хэрэгцээгээ хангах, нийгэм орчиндоо дасан зохицон амьдрахын тулд гэр бүлийн нэг гишүүн нь алслагдсан сум эсвэл хилийн дээс алхан ажиллах болсон байна. Үүнээс үүдэж гэр бүлийн уур амьсгалд өөрчлөлт орж энэ өөрчлөлт нь тодорхой хугацааны дараа салалт болон хувирч байна.

Аливаа гэр бүл салалтын гол хохирогч нь хүүхэд юм гэдгийг сүүлийн үед нийтэд ил болж байгаа хүүхдийн эсрэг хүчирхийллийн гэмт хэргүүд бэлхнээ батлан харуулж байна. Алслагдмал байдалд ажиллаж байгаа гэр бүлийн хүүхдүүд хүртэл жирийн хүүхдүүдийг бодвол тодорхой хэмжээний сэтгэлийн шархтай эрх чөлөө хязгаарлагдмал байдалтай байгаа нь тус сэдвийг хөндөхгүй байхын аргагүй юм.

Гэр бүл салалт зөвхөн Монгол Улсад сүүлийн жилүүдэд ихсэж байгаа юм биш дэлхий нийтээр гэр бүл төлөвлөлт улам хөгширч ганцаарчилсан хувь хүнээрээ амьдрах байдал давамгайлсан шинж чанартай байна. Гэхдээ дэлхийн ихэнх орон өөрсдийн асуудлаа шийдвэрлэж чадсан байдаг жишээ нь Австралид гэр бүлийн мэргэжлийн үйлчилгээ маш сайн хөгжсөн бөгөөд гэр бүлийн харилцааны төрийн болон төрийн бус олон тусгай байгууллага ажилладаг байна.Тэдгээр байгууллагаас гэр бүлүүд хүүхэд хүмүүжлийн тухай, гэр бүлийн маргааны үед асуудлаа хэрхэн шийдвэрлэж, харилцаагаа сайжруулах талаар олон төрлийн зөвлөгөө авах боломжтой байдаг аж. Энэ тухай Австрали улсын шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч, хуульч, сэтгэл зүйч Катерин Жонсон "Гэр бүлд асуудал үүсэж, хосууд салах эсэх нь өөрсдийнх нь сонголт байдаг ч салсныхаа дараа тэд хамтдаа үр хүүхдэдээ анхаарал, халамж тавьж, цаашдын амьдралаа ямар нэг сэтгэлийн шархгүй өнгөрүүлэх хэрэгтэй.Салсан ч тэд хүүхдийнхээ хувьд нэг гэр

бүл хэвээрээ байх ёстой. Ийм зарчмыг бид баримталж, зөвлөгөө өгч ажилладаг”[148] гэж тэмдэглэсэн байдаг.

Аль ч улс үндэстэнд, ямар ч гэр бүл сайхан харилцаатайгаа үлдэж салдаггүй. Харин салах үед нь тэднийг салсан ч эцэг, эх хэвээрээ үлдэнэ гэдгийг хажуугаас нь мэргэжлийн хүн хэлэх хэрэгтэй. Энэ бол гэр бүлийг дэмжих үйлчилгээний хамгийн чухал асуудал. Гаднын улсуудад гэр бүл маргалдах тохиолдолд хүүхдийнх нь хүмүүжилд сөргөөр нөлөөлдөг тухай эцэг, эхэд нь зөвлөж, зан үйл засах сургалтад хамруулдаг үйлчилгээ бий. Үүнийг хуулиар нь зохицуулсан байдаг бөгөөд шүүхийн шийдвэрээр гүйцэтгэдэг.

Өөрөөр хэлбэл, гэр бүл бол маш үнэ цэнтэй бөгөөд бат бөх харилцаан дээр тулгуурладаг. Харин тэр үнэ цэнийг нь гэр бүлийг дэмжих үйлчилгээгээр дамжуулж ойлгуулж байх учиртай гэж үзэж байна.

Дүгнэлт

Орчин үед залуучуудын гэр бүл төлөвлөлт хэт оройтож нийгэмд ганцаараа амьдрах хүсэл эрмэлзэл бий болсон байна. Нийгмийн шилжилт хөдөлгөөн нь залуу гэр бүлийн тогтвортой байдлыг алдагдуулж сөргөөр нөлөөлж байна. Энэ нь өөр өөр орчинд бие биеээсээ зайтай байгаа нөхцөлд сэтгэл зүйн өөрчлөлтөд орж гэр бүл салалт олширч байна. Нөгөө талаасаа эдийн засгийн байдал шинээр залуу гэр бүл болсон айл өрхүүдэд хүндээр тусаж байгаа нь дээрх судалгаа болон олон улсын судлаачдын дүгнэлтэд гарч ирсээр байна. Тухайлбал цар тахал нь улс орны эдийн засагт нөлөөлөөд зогсохгүй айл өрхийг санхүүгийн гүн хямралд өртүүлж шинээр гэр бүл болсон залуус байр, хувцас хэрэглэл болон анхдагч болон хоёрдогч хэрэгцээгээ хангахад хүндрэл учруулж байгаа юм. Нийгмийн тойрсон гэр бүл салалт нь Хил Хамгаалах Байгууллагыг тойрч гаралгүй дайран өнгөрч байгаа нь илт харагдаж байна. Хилийн анги , салбарт алба хааж байгаа залуучуудын 40-50 хувь гэр бүлгүй эсвэл гэр бүлээсээ салж хоёрдогч амьдралыг сонгосон нь дээрх судалгаанаас харагдаж байна. Ирээдүйд энэ тоо улам өсөх хандлагатай байгаа юм. Хэрэв гэр бүл салалт одоогийн байдлаасаа илүү их нэмэгдвэл Үндэсний аюулгүй байдлын хэмжээнд хүрч болзошгүй юм.

Санал

Гэр бүл төлөвлөлт болон залуу гэр бүлийг дэмжсэн төрөөс олон төрөлт арга хэмжээг авсаар байгаа боловч сүүлийн 3 жилийн хугацаанд гэр бүл салалт нь харьцангуй ихсэж байгаа нь уг төсөл арга хэмжээнүүд нүдээ олохгүй байна уу эсвэл хэрэгжүүлэх арга хэмжээ нь буруу явагдаж байна уу ямартай ч судалгаанаас үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Хүн ам зүйн бодлогын хүрээнд:

- Тухайн нутаг дэвсгэрт ажиллаж буй төрийн албан хаагчдад бусад бүс нутгаас давуу урамшуулал олгох, байр орон сууцны хөнгөлөлттэй нөхцөл олгох, гэр бүлийн гишүүдийн төв рүү зорчих зардалд дэмжлэг үзүүлэх, жилд 1-ээс 2 удаа

[148] https://ikon.mn/opinion/1rn6

нарийн мэргэжлийн эмнэлгийн үзлэгт оруулах гэх мэт бодлогын арга хэрэгслийг ашиглах

- Гэр бүлээс гадуур харилцааны тухай хуулийн зохицуулалт хийх
- Төрөөс залуу гэр бүлийн санхүүгийн байдалд онцгой анхаарах /цар тахлын нөхцөл байдлын үед/
- Хилийн анги салбарт шинээр гэр бүл болж байгаа айл өрхөд тодорхой гэрээний үндсэн дээр өөрийн хүссэн газар нь 1-3 хувийн хүүтэй орон сууцны зээлд хамруулах
- Хил Хамгаалах Байгууллагад ажиллаж буй алба хаагчийн гэр бүлийн гишүүнийг ажлын байраар хангах, өөр байгууллагад шилжин ажиллахад дэмжлэг үзүүлэх зэрэг саналыг дэвшүүлж байна

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

1. Арвай.Ш., (2013) он.Улсын хил, хязгаарын аюулгүй байдал, тулгамдсан асуудлууд шийдвэрлэх арга зам.УБ хот
2. Намжил Т., Оюунбилэг Г., (1999),“Монгол гэр бүл: цуврал-1”
3. Д.Ганбаатар., М.Баярсайхан., Э.Энхтайван., Л.Лхагвасүрэн., (2020) Хил орчмын бүс нутгийн эдийн засгийн хөгжил, Хил дагуух орон нутгийн хөгжлийн бодлого
4. Алсын хараа 2050
5. Монгол Улс: Хүн амын нэгдсэн тооллого, 2016, 2017, 2018, 2019, 2020
6. Монгол Улс: хүн амын дотоод шилжих хөдөлгөөний судалгаа, 2016
7. Монгол хэлний их тайлбар толь
8. https://ikon.mn/opinion/1rn6

---o0o---

УЛСЫН ХИЛЭЭР ХАР ТАМХИ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛЛӨХ МАНСУУРУУЛАХ БОДИС НЭВТРҮҮЛЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

PREVENTION OF SMUGGLING OF DRUGS AND PSYCHOACTIVE SUBSTANCES ACROSS STATE BORDERS



Б.Ням-Очир
Дотоод хэргийн их сургуулийн
Хилийн албаны сургуулийн
Хилийн албаны тэнхимийн ахлах багш, дэд хурандаа

Товч утга: Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр нэвтрүүлэхгүй байх, хилийн хяналтын байгууллагын хяналтыг сайжруулах арга замын талаар товч өгүүлэх болно.

Түлхүүр үгс: Улсын хил, хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодис

Abstract: Prevent smuggling of drugs and psychoactive substances across state borders and improve the inspection of border control institutions.

Keywords: State border, drugs, psychoactive substances.

Судалгааны зорилго нь мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэрэг зөрчил сүүлийн жилүүдэд монгол улсад их гарах болсон нь хилийн боомтод ажиллаж байгаа хилийн хяналтын байгууллагын алба хаагчдыг энэ чиглэлд мэргэшүүлж сурган анхаарал хандуулж ажиллах шаардлага тулгарч байна.

Мансууруулах бодис гэж юу вэ?

“Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодис”-ын тодорхойлолтыг хууль зүй, анагаах ухаан, химийн зэрэг шинжлэх ухаануудын тус тусын тодорхой шалгууруудын үндсэн дээр гаргаж болдог.

Наркологи буюу мансуурал судлалын үүднээс авч үзвэл бүх мансууруулах бодис сэтгэцэд нөлөөт бодис багтана. Мансууруулах бодисын тоонд бидний нэрлэж заншсанаар хар тамхи буюу опиумын гаралтай мансууруулах бодисууд мөн ордог. Хар тамхи гэдэг нь

опиумуудад оноож өгсөн хар ярианы хэллэг бөгөөд албан ёсны баримт бичигт хэрэглэгдэх шинжлэх ухааны нэр томъёо биш юм.

Хүн амьдралдаа ямар нэг таашаал авахын тулд тодорхой нэг зүйлийг хийж, бүтээж, түүний төлөө хичээл зүтгэл гаргаж байж тэрхүү таашаалаа хүртдэг бол мансууруулах бодис нь энэ үйл явцыг эвдэж, ямар ч зүйл хийлгүйгээр дээд таашаал авч буй мэт мэдрэмж төрүүлдэг байна. Хар тамхи буюу narcotics нь “narcosis” гэх Грек үгээс гаралтай ба хөдөлгөөнгүй болон, нойронд автах, саажих гэсэн агуулгатай.

Хар тамхи ба Монгол улс

НҮБ-ын дэргэдэх Дэлхийн хар тамхитай тэмцэх алба 2010 онд Монгол Улсыг хар тамхи, мансууруулагч бодис тээвэрлэгч орон гэж үзэж байсан бол дөрвөн жилийн дараа хэрэглэгч орон хэмээн үзжээ. Ингэхдээ химийн аргаар гаргаж авсан сэргээшийн төрлийн синтетик бодисын хэрэглээ нэмэгдэх хандлагатай орон гэж тодотгожээ. Монгол улсад каннабис буюу олсны ургамлын байгалийн тархац их учраас каннабисын хэрэглэгч ихтэй орон гэж бас дүгнэсэн. Энэ дүгнэлт нь дараах судалгаанаас батлагдаж байна.

Судалгаанд оролцогчид, хугацаа, хамрах хүрээ

Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Сонгино-хайрхан дүүрэг, Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул аймгуудын ерөнхий боловсролын сургуулийн 1067 хүүхдийг хамруулан 2020 оны 10 дугаар сарын 23-наас 11 дүгээр сарын 26-ны хооронд тест болон ярилцлагын аргаар авсан судалгааг статистикийн SPSS программаар боловсруулж, дүгнэлт хийж нэгтгэсэн. Үүнд:

Судалгааны нэгтгэсэн үр дүн




График 1




График 2



Судалгаанд орон нутаг болон нийслэлийн нийт 1067 сурагч оролцсоноос 529 нь эрэгтэй, 538 нь эмэгтэй сурагч байна. /график 1/ Үүнээс 7 дугаар ангийн 60 хүүхэд, 8 дугаар ангийн 157 хүүхэд, 9 дүгээр ангийн 215 хүүхэд, 10 дугаар ангийн 243 хүүхэд, 11 дүгээр ангийн 189 хүүхэд, 12 дугаар ангийн 203 хүүхэд оролцсон байна. /график 2/

Судалгаанд оролцогчдын хувьд энэ төрлийн бодисын талаар ер нь сонсдог 37%, заримдаа сонсдог 41%, маш их сонсдог 18% бол огт сонсоогүй 4% байна. ЕБС-ийн сурагчдын 96% нь мансууруулах бодисын талаар мэдээлэлтэй байна /График 3/. Судалгаанд оролцогчдын 28% нь мансууруулах бодисын талаарх мэдээллийг телевиз, киноноос, 27% нь интернэт, 15% сонин сэтгүүл, 10% нь гэр бүл хамаатан садан, 12% нь найз нөхдөөс мэдээлэл авсан гэсэн бол 4% нь энэ талаарх мэдээлэл огт аваагүй байна.




Судалгаанд оролцогчдын 44% нь уг бодисын 1-3 төрөл, 21% нь 3-5 төрлийг мэднэ, 20% нь огт мэдэхгүй, 5% нь 5-8 төрөл, 10% нь 8-аас дээш төрлийг тус тус мэднэ гэсэн байна.



Судалгаанд оролцогчдын 74% нь мансууруулах бодис огт



хэрэглэж байгаагүй, 13% нь ганц удаа хэрэглэж байсан, 2% нь хааяа хэрэглэдэг гэсэн бол 11% нь олон удаа хэрэглэж байсан гэсэн байна.



Дээрх судалгаанд оролцсон ерөнхий боловсролын сургуулийн сурагчид хар тамхи, мансууруулах бодисын талаар тодорхой мэдээлэлтэй, хэрэглэж байгаа, хэрэглэж үзсэн байгаа нь эцэг эх, сурган хүмүүжүүлэгч нар нь анхаарах, хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагууд гарч байгаа нь харагдаж байна.

Хилийн хяналтын байгууллагуудын хяналт шалгалтын ажиллагаа:

Хар тамхи мансууруулах бодисын 40-50 хувь нь хилийн боомтуудаар нэвтэрдэг гэсэн судалгаа байдаг.

Монгол улсын хувьд 2016-2020 онд улсын хилээр хар тамхи мансууруулах бодистой холбоотой 11 үйлдлийг таслан зогсоож 15,3 кг бодис хурааж авсан.

Монгол улсын томоохон боомтууд болох Чингис хаан, Замын үүд, Алтанбулаг боомтууд нь гол гарц чиглэлүүд болоод байгаа бөгөөд сүүлийн үед жижиг хөгжиж эхэлж байгаа боомтууд руу хар тамхины наймаачид бүлэглэлүүд үйл ажиллагаагаа чиглүүлж байгаа мэдээлэлтэй байна.

Хөгжиж эхэлж байгаа жижиг хилийн боомтууд дээр хар тамхи, мансууруулах бодис илрүүлэх техник тоног төхөөрөмж дутагдалтай, хяналт шалгалт сул, мэргэшсэн ажилтан дутмаг, байгаа зэрэг нь сул тал болж байна.

Сүүлийн үед хар тамхийг маш бага граммаар зөөж тээвэрлэж байгаа нь зарим техник технологиор илрүүлэх боломжгүй байна. Ер нь 100 хувь багажид найддаггүй бөгөөд алба хаагч буюу хүнийг мэргэшүүлж, техник технологийн дэвшлийг хослуулан хэрэглэвэл уг зөрчлийг таслан зогсоох, илрүүлэх боломжтой.

Хар тамхи мансууруулах бодисууд нь цаг үеэ даган шинэчлэгдэн өөрчлөгдөж энгийн хүний нүдээр хараад таних ямар ч боломжгүй болж байгаа зэрэг нь илрүүлэхэд ихээхэн хүндрэлтэй байна.

Хөрш зэргэлдээ улс орнууд бодлогоор хилийн боомтод ажиллаж байгаа болон хууль хяналтын байгууллагын алба хаагчдад нэгдсэн сургалт зохион байгуулах хэлбэрээр мэдлэг олгож байна.

Дүгнэлт:

1.Судалгаанаас үзэхэд ерөнхий боловсролын сургуулийн сурагчид нь хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодисын талаарх мэдээлэлтэй, сонссон, харсан, хэрэглэж үзсэн, хэрэглэж үзэх юмсан гэсэн бодолтой явж байгаа нь монгол улсад энэ төрлийн бодис хяналтгүй зарагдаж байгаа бөгөөд хяналт тавих, урьдчилан сэргийлэх ажил хангалтгүй явагдаж байна.

2.Монгол улсад хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн иргэдэд хүлээлгэх хуулийн хариуцлага нь олон улсын хууль эрх зүйтэй харьцуулахад харьцангуй хөнгөн ял шийтгэл ноогдуулдаг.

3.Хар тамхи мансууруулах бодисыг бусад улс орнуудаас нууцаар тээвэрлэн хилийн боомтуудаар нэвтрүүлж, Монгол улсын иргэдэд олон нэр төрлийн бодисыг дамжуулан зарж ашиг олдог байж болзошгүй гэж дүгнэж байна.

Санал:

1.Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын программд анхаарч хар тамхи мансууруулах бодисын хор хөнөөлийн талаар тодорхой хэмжээний үнэн зөв бодит мэдээллийг өгч урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

2.Монгол улсын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хууль эрх зүйг шинэчлэн боловсруулж, хүлээлгэх хариуцлагыг чангатгах.

3.Улс эх орныхоо үүдэн хил хязгаарыг хамгаалж байгаа хилийн хяналтын байгууллагын алба хаагчдад хар тамхийг таньж илрүүлэх, хууль зүйн дагуу шийдвэрлэх арга зүйн талаар сургалт зохион байгуулж явуулах, хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг илрүүлсэн алба хаагчдыг хуулийн хамгаалалтад авах арга хэмжээг зохион байгуулснаар улс эх орны үндэсний аюулгүй байдал хангагдан хэмээн үзэж байна.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр. УБ 2017 он
2. “Хүүхэд, өсвөр насныхны мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодист автах эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ” криминологи судалгааны тайлан. УБ 2020 он
3. Монгол улс дахь мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэрэгт ноогдуулж буй ял шийтгэл, тулгамдаж буй асуудал /Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Нийслэлийн шүүх, Хүний аюулгүй байдлын судалгааны төв ТББ, бусад судлаачидын хамтарсан судалгааны ажил/. УБ 2013 он

---o0o---

БИДНИЙ НИЙГЭМ ДЭХ ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ

SOME OF THE PROBLEMS IN OUR SOCIETY



Д.Энхтайван
Дотоод хэргийн их сургуулийн
Хилийн албаны сургуулийн
Сэтгэл зүйн тэнхимийн ахлах багш, хошууч

Товч утга: Нийгмийн хөгжлийг дагаад урган гарч буй сөрөг асуудлын талаар судлан үзнэ.

Түлхүүр үгс: Нийгэм, нийгмийн сэтгэл зүй, хандлага.

Abstract: Following the development of society, we will explore the negative issues that arise.

Keywords: Social, social psychology and attitudes.

Бид сүүлийн жилүүдэд ард иргэдийн санаа сэтгэлийг багагүй зовоон нийгмийн хөгжилд сөргөөр нөлөөлж буй цөөнгүй асуудлуудыг хамтран судалж дүн - шинжилгээ хийсний үр дүнд тухайн цаг үетэйгээ холбоотойгоор, ”Төрийн тогтворгүй байдал”, ”Байгалийн гамшиг”, “Корона”, “Цаг уурын өөрчлөлт”, “Цөлжилт”-ийн асуудал ..... зэрэг сэтгэл зовоосон цаг зуурын шинжтэй асуудлууд өндөр хувьтай гарч байгаа бөгөөд үүнийг статистикийн мэдээлэл болон төрөл бүрийн чиглэлээр хийгдсэн судалгаануудаас давхар олонтаа олж үздэг.

Эдгээрээс байнга өндөр хувьтай гардаг бөгөөд манай нийгмийн хөгжилд сөргөөр нөлөөлж буй олон хүчин зүйлүүдийн суурь үндэс нь:

- **Ажилгүйдэл**
- **Ядуурал**
- **Архидалт** гурав юм.

Үүнээс үзвэл энэхүү гурван асуудал нь нийгмийн хувьд хамгийн тулгамдсан, суурь шинжтэй, нэн тэргүүнд анхаарах ёстой асуудлууд болж байна. Иймд эдгээрийг дангаар нь биш цогцоор шийдвэрлэх нэн шаардлагатай чухал асуудал хэмээн үзэж байна. (Хүснэгт 1.)

Энэхүү эрдэм шинжилгээний илтгэлийн зорилго нь дээрх асуудлуудын онцлог шинж, хамаарлыг гаргахын зэрэгцээ ажилгүйчүүдийн тоог бууруулахад нийгмийн хүчин зүйлийг гол болгон бодит нөхцөлд судлан үзэж түүнийг

бууруулах шинэлэг арга замыг дэвшүүлснээр хангагдана. Судалгааны хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж байгаа болно.

- Нийгмийн хөгжилд сөргөөр нөлөөлж буй гол хүчин зүйлсийг илрүүлж тогтоох;
- Өнөөгийн ажилгүйдлийн хэлбэр, тархалтад нөлөөлөх нөлөөллийг судлах;
- Ажилгүйдлийг бууруулах зарим арга замыг дэвшүүлэх;
- Ажилгүйдэл, Ядуурал, Архидалтыг цогцоор нь шийдвэрлэх боломж.

Мөн санал – асуулга авч, харьцуулалт хийхийн зэрэгцээ судалгааны баримтад задлан шинжилгээ хийх математик – статистикийн арга болон хоорондын хамаарлыг Юлийн коэффициентээр бодож гаргахад:

Таны санааг зовоож байгаа асуудлууд *Хүснэгт 1*

	Асуудлууд	2010 [149]	2016 [150]	2020[151]	2022 [152]
1	Тэнүүчлэл	17,3	11,5	-	-
2	Халдварт өвчин	-	26,0	-	-
3	Байгалийн гамшиг	28,1	31,1	36,3	-
4	Ажилгүйдэл	45,2	45,6	66,7	29,5
5	Ядуурал	51,2	51,9	50,4	27,9
6	Архидалт	54,7	45,9	52,6	10,3
7	Авлига	19,5	-	12,3	7,3
8	Гэмт хэргийн өсөлт	30,6	36,9	14,2	-
9	Татварын ачаалал	-	-	-	-
10	Үнийн өсөлт	-	-	-	
11	Төр засгийн байдал	38,3	33,3	-	-
12	Хүний эрхийн зөрчил	-	-	12,7	-
13	Хүнд суртал	-	-	18,0	-
14	Бусад	2,6	2,7	1,7	25

Одоогийн нөхцөл:Дээрх гурван асуудлыг гүнзгийрүүлэн судлахад өөр хоорондоо салшгүй холбоотой, бие биедээ харилцан нөлөөлдөг төдийгүй цогцоороо нийгмийн бусад тулгамдсан асуудлуудыг үүсгэж тэдгээрийг тодорхойлох үндсэн хүчин зүйл болдог. Нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхдээ цаад мөн чанарыг нь таньж, түүнийг нөхцөлдүүлэгч шалтгааныг

[149] “УИХ-ын сонгууль 2012” Удирдлагын академи. Түүвэр 600
[150] “Ерөнхийлөгчийн сонгууль 2016” Удирдлагын академи. Түүвэр 500
[151] “Эдийн засгийн боловсрол” 2020 он, МУИС-ийн Эдийн засгийн сургууль
[152] “Нийгэм, улс төр, эдийн засгийн нөхцөл байдал” 2022 он. Түүвэр 850

эхлээд тодруулах учиртай. Шалтгааныг тогтоосны дараа шийдвэрлэх арга замаа сонговол илүү оновчтой, үр дүнтэй байдгийг практик бидэнд хэдийнээ харуулсан.

Эдгээр асуудлуудын хамаарлыг гаргаж нийгмийн бусад хүчин зүйлүүдэд хэрхэн нөлөөлөх нөлөөллийг илрүүлэн гаргах оролдлогыг эрэлхийллээ. Дээрх санаа зовоож буй асуудлуудын хооронд хамаарал байна уу? гэдгийг тогтоохын тулд тэдгээрийн хоорондын корреляцийн коэфициентийг бодож үзэв.

Корреляцийн матриц *Хүснэгт 2*

№		Ажилгүйдэл	Ядуурал	Архидалт	Гэмт хэргийн	Авлига	Татварын ачаалал	Байгалийн гамшиг	Үнийн өсөлт	Тэнүүчлэл
1	Ажилгүйдэл	**1**	0,583	0,578	0,402	0,105	0,119	0,108	0,023	0,165
2	Ядуурал	0,583	**1**	0,675	0,197	0,149	0,279	0,301	0,228	0,383
3	Архидалт	0,578	0,675	**1**	0,785	0,125	0,096	0,101	0,131	0,087
4	Гэмт хэргийн өсөлт	0,402	0,197	0,785	**1**	0,302	0,107	0,183	0,203	0,312
5	Авлига	0,105	0,101	0,125	0,302	**1**	0,383	0,211	0,245	0,017
6	Татварын ачаалал	0,119	0,279	0,096	0,107	0,383	**1**	0,133	0,421	0,075
7	Байгалийн гамшиг	0,108	0,301	0,101	0,183	0,211	0,133	**1**	0,210	0,165
8	Үнийн өсөлт	0,023	0,228	0,131	0,203	0,245	0,421	0,210	**1**	0,078
9	Тэнүүчлэл	0,165	0,383	0,087	0,312	0,017	0,075	0,165	0,078	**1**

Шинж тэмдгүүдийн хоорондын хамаарлыг Юлийн коэфициентоор бодож гаргав.

Ийм учир ажилгүйдэл, ядуурал[153], архидалт гурвыг нийгмийн хөгжилд саад болж байдаг ***"Хар гурвалжин"*** гэж нэрлэсэн юм.

Онцлон авч үзсэн асуудлуудын оршин байгаа хэлбэр болон нийгэмд үзүүлэх нөлөөллийг авч үзвэл:

Ажилгүйдэл нь:

- Гологдсон ба шоовдор ажилгүйчүүд, цамаан ажилгүйчүүд гэх мэт ажилгүйчүүдийн янз бүрийн бүлгийг төрүүлэх;
- Архидалт гэмт хэрэг өсөх нөхцөлийг бүрдүүлдэг;
- Эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлнө
- Хөдөөнөөс хот уруу шилжих хөдөлгөөнийг нэмэгдүүлдэг г. м

[153] Илтгэлийн хүрээнд ядуурал гэсэн ойлголтын доор голчлон орлогын ядуурлыг авч үзсэн болно. Учир нь дээрх судалгаануудад оролцогчид ядуурлыг ихэвчлэн орлогын ядууралтай холбон авч үзсэн байна. Нөгөө талаас орлогын ядуурал нь оюуны ядуурал, чадавхийн ядуурал, улмаар үе дамжсан ядууралд хүргэдэг суурь мөн гэж үзэж байна.

Ядуурал нь:

- Бэлэнчлэх сэтгэлгээг;
- Авлига хээл хахууль;
- Урт хугацааны ядуурал, улмаар үе дамжсан ядууралд хүргэх;
- Нийгмийн социаль хүрээнээс салгах;
- Боловсронгуй хүмүүс г. м

Архидалт нь:

- Гэмт хэрэг;
- Эрүүл мэндийн хохирол;
- Гэр бүлийн хүчирхийлэл г. м

Архидалттай хийж буй тэмцэл

Архидалттай тэмцэх олон янзын арга хэмжээ авч байгаа ч өнөөгийн түвшингөөс харахад маш олон сөрөг асуудлуудыг бий болгож байна. Архидалттай тэмцэхэд үйлчилгээний газруудыг 24 цагаас хойш согтууруулах ундаа зарахгүй, үйлчлэхгүй байх талаар Засгийн газрын тогтоол гарсан юм. Гэсэн ч энэ нь нууцаар архи зарах "дамлах" үзэгдлийг улам хөөрөгдөж байна. Урьд өмнөхөөс согтуугаар үйлдсэн гэмт хэрэг ихсэн, цагдаагийн газарт эрүүлжигч, эмнэлэгт согтуугаар хүргэгдэгсдийн тоо нэмэгдсээр байна. Түүнчлэн далд эдийн засаг буй болох, татвараас зайлсхийх зэрэг сөрөг үр дагаврыг араасаа дагуулах боллоо. Энэхүү байдал нь дараах экспертийн яриагаар батлагдсан юм.

... СБД-ийн Цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх тасагт дунджаар хоногт 30 хүн ордог байсан бол сүүлийн саруудад хамгийн багадаа 30 хүн хоногт ордог болсон ба энэ нь хүмүүс гэртээ болон бусад газар агсан согтуу тавьснаас болж дуудлагаар баригдах гол үндэс нь хулгайн хямд архи их зарагдах болсон гэж ..... СБД цагдаагийн хэлтсийн ажилтан хэлжээ.

Үүнээс архидалт гэмт хэрэг ахуйн хүрээнд гэр бүлийн хүрээнд шилжсэн зэрэг олон сөрөг үр дагаврыг нийгэмд учруулж байгаа.

Ядууралтай хийж буй тэмцэл Ядуурлыг бууруулах олон хөтөлбөр төсөл хэрэгжсэн. Гэтэл үр дүн нь харагддаггүй, харин ч ядуурал буураагүй нэмэгдсэн гүнзгийрсэн гэсэн дүгнэлт гардаг.

Одоогийн ядуурлыг бууруулах чиглэлээр ажиллаж байгаа байгууллага хувь хүмүүсийн үйл ажиллагаа нь хүмүүст бэлэн мөнгө өгөх, хувцас бэлэглэх, гурил олгох, хичээлийн хэрэгсэл, ногооны үр, мал, өвс тэжээл .... өгөөгүй юм байхгүй ба энэхүү нэг удаагийн бэлэн тусламж ядуучуудад тухайн үед нь гал унтраахаас өөрөөр бодитой нөлөөлдөггүй бөгөөд харин ч тусламж авах гэсэн бэлэнчлэх сэтгэлгээг өөгшүүлдэг, энэ нь улмаар ядууралд хүргэх ядуурлыг гүнзгийрэхэд нөлөөлдөг гэж хэлж болно.

Ядуу өрх, орлого багатай өрх, өрх толгойлсон эхчүүд, эмзэг бүлгийн хүүхдүүд, ядуу хүүхдүүд гэх мэтээр хаяглан тусламж олгох болсноор уг тусламжаас хүртэх гэсэн хүмүүсийн тоо механикаар өсдөг байна. Үүний зэрэгцээ айл өрхийг ядуу, орлого багатай амьдралын боломжгүй хэмээн тэднийг бусдаас улам хөндийрөх, нийгмээс тусгаарлагдах социал зайг үүсгэдэг гэж хэлж болно. Энэхүү социаль зай бий болсноос тэд өөрсдийн хамт олонгүй бэлэнчлэх сэтгэлгээтэй, өөрийн үнэлэмж үнэт зүйлсгүй, гутранги үзэлтэн бий болоход нөлөөлдөг.

Мөн тусламжийн ихэнх хэсэг нь зориулалтын бус хүмүүст очих явдал гардаг бөгөөд ядуурлаар бизнес хийж мөнгө олдог төрийн бус байгууллагууд, хувь хүмүүс байдаг нь нууц биш. Энэ талаар хийсэн судалгаанаас харвал иргэдэд олгож буй тусламж ихэнхдээ очих эзэндээ биш шат шатны дарга нарын хамаатан саданд очдог гэж судалгаанаас харагдаж байна. Тухайлбал Хэнтий аймагт авсан судалгаанд оролцогчдын 41,2 хувь нь дээрх хариултыг өгчээ.

Архидалттай тэмцэх, ядуурлыг бууруулах, ажилгүйдлийг багасгах ажлыг цогцоор шийдвэрлэж ажилгүйдлийг багасгахад чиглэх ёстой гэсэн санааг дэвшүүлж байна. Учир нь дээр өгүүлсэнчлэн энэ гурван асуудал салшгүй холбоотой, бие биедээ харилцан нөлөөлж байдгийн зэрэгцээ ажилгүйдэл нь илүү тодорхойлох шинжтэй хүчин зүйл болж байгаа юм.

Энэхүү илтгэлд “Хар Гурвалжин”-г “Алтан гурвалжин” болгоход нөлөөлөх байдлаар үзэж дан ганц асуудлыг эдийн засгийн талаас биш хүний хүчин зүйл, нийгмийн талаас нь хөндөхийг зорьсон болно.

Хэрхэн шийдэх вэ? Нийгмийн хөгжилд чөдөр тушаа болж буй гурван зүйлийг урвуу хэлбэрээр авч үзвэл ядуурал, архидалт хоёрын суурь үндэс нь ажилгүйдэл юм.

Та хэрвээ УИХ-ийн гишүүн байсан бол юуг нэн түрүүнд шийдэх вэ? гэсэн асуултад хариулсан байдлыг бүдүүвчид оруулав.

	Энгийн нийгэм	
Ядуурал	**32.8%**	**19.5%**
	47.7%	
	Ажилгүйдэл	

Дээрх гурван хүчин зүйлийн нэн чухал нь 47,7 % нь ажилгүйдлийг шийднэ гэснээс харагдаж байна. Хөгжлийн энэхүү бүдүүвч нь урвуу хамааралтай болж дээшээ харсан нөхцөлд нийгэм хэвийн хөгжих бололцоотой болж байгаа юм.

Судалгааны явцад нийгмийн хөгжил болон дээрх бүдүүвчийг эргүүлж нийгмийн зүг харуулахад ажилгүйчүүдийн дараах хэлбэрүүдийг нэн тэргүүнд залуурдаж засах нь зүйтэй гэж үзэж байна. Өнөөдөр ажил эрхлэхийг хүсэж буй ажилгүй хүмүүс албан ёсны бүртгэлтэй ажилгүйчүүдийн тооноос хэд дахин илүү байгаа.

Хөгжлийн гурвалжинг Алтан гурвалжин болгох, урвууг эргүүлэхэд ажилгүйдлийн дараах хэлбэрүүдийг шийдвэрлэх нь чухал юм. Мөн сүүлийн жилүүдэд гологдсон буюу **Шоовдор ажилгүйчүүд** ихэссэн байна.

Хүмүүс:

- Нас
- Хүйс
- Биеийн хөгжил
- Царай зүс
- Танил тал
- Мэдлэг чадвар зэргээрээ гологдож ажилгүйчүүдийн эгнээнд орж байна.

Үүнийг 2019 оны эхний улирлын зарын сонинуудад хийсэн контент анализын дүнгээс харж болно.[154] Дээрх үзүүлэлтүүдийг тусгаж ажилд авна гэсэн зар нийт зарын 76% эзэлж байгаагаас өнөөгийн түвшинд царай зүс, нас хүйсээр нь ялгаварлах нь нийтлэг болох төлөв байдалтай байна.

Цамаан ба үнэ хүндийн ажилгүйчүүд: Энэхүү төрлийн ажилгүйчүүд сүүлийн жилүүдэд жин дарж байгаа нь илт байгаа. 2-3 их, дээд сургууль төгсчхөөд хийх ажилгүй **“Бохир”** хэмээх ажил хийхгүй байна. **Та яагаад ажилд орохгүй байгаа вэ?** гэсэн асуултад 48% нь тухайн ажлын байрны орчин муу гэхэд, 39% нь ажлын нэр хүнд муу гэж хариулсан байна. Үүнээс харахад өнөөгийн залуучуудын өөрсдийн орон зайг мэдэрч хаана ажиллахаа олж чадаагүй байгаа нь цамаан ажилгүйчүүдийн тоонд орж байна.

Нэг талаас төр энэхүү ажиллаж, хөдөлмөрлөх нөхцөлийг илүү боловсронгуй болгох нь чухал тэрнээс ажил хийх сонирхолгүй биеийн амрыг бодоогүй байгаа нь судалгаанаас харагдсан.

Завсрын шинжтэй ажилгүйчүүд Энэ ажилгүйчүүдийн эгнээнд малчид, жижиг бизнес эрхлэгчид, ченж, хувиараа жижиг бизнес эрхлэгчид орж байгаа юм. Тэд өөрсдийнхөө хөдөлмөрийг эрхэлж тодорхой хэмжээний татвар төлөөд явж байгаа хэдий ч төрийн зүгээс буцаад авах дэмжлэг туслалцаа ямар нэгэн халамж үйлчилгээ хүртэхгүй байгаагаараа завсрын шинжтэй ажилгүйчүүдийн тоонд орж байгаа юм.

---

[154] *“Шуурхай”* сонин 2019 оны сүүлийн 3 сарын дугаарт контент анализ хийсэн.

...Сүүлийн жилүүдэд татвар нэмэгдэж байгаа, үйлчилгээ явуулахад хорооноос эхлээд бичиг баримт гээд хэцүү. Тэгсэн хэрнээ төрөөс бидэнд ямар нэгэн дэмжлэг туслалцаа байдаггүй энэ талыг л уламжлах хэрэгтэй байна.....

Чингэлтэй дүүргийн худалдагч

Амиа зогоогчид Эдгээр нь гар дээрээс наймаа хийж борлуулагч албан ёсоор бүртгүүлээгүй хулгайн журмаар ажил хийж хоолныхоо мөнгийг олдог хэдий ч төрөөс дэмжлэг авах боломжгүй далд эдийн засгийг бүрдүүлэгч нар орно. Зөвхөн өөрсдийнхөө л хэрэгцээгээ хангадаг.

Ажилгүйдлийг арилгах арга зам дээрх хэлсэнчлэн ядуурлыг бууруулах, архидалтыг багасгах үйл ажиллагааны үндсэн чиглэл нь ажилгүйдлийг бууруулах ажлын байр буй болоход чиглэгдэх ёстой. Ажил олгогч болон ажил хайгчдын хооронд зуучлах баазыг бий болгох нь нэн чухал.

Нэг талаас ажил олгогчдод найдвартай чадвартай ажилчид хэрэгтэй байдаг боловч тэднийг сонгож авах тал дээр алддаг боловсон хүчний бодлого дээр гаргадаг алдаа нь ажил олгогчдын гаргадаг үндсэн алдаа болж байна.

Энэ нь манай судалгаанд оролцсон хүмүүсээс та яагаад хөдөлмөрийн биржээр дамжуулж ажилтнаа авдаггүй юм бэ гэсэн асуултад энэ алба нь:

1. Төлөвшиж амжаагүй
2. Хүмүүс үйлчлүүлж сураагүй
3. Монгол хүмүүс ажилтнаар орох гэж байгаа хүнээ өөрөө харж үзэж сонгодог хэв маягт баригдсан.

Нөгөө талаас ажилд орохыг хүссэн ажилгүйчүүдийн боловсрол, мэргэжлийн түвшин, хөдөлмөрийн бүтээмж доогуур, хөдөлмөрийн сахилга бат тааруу, ажил тасалдаг, архи уудаг, хулгай хийдэг зэрэг дутагдал их гаргадаг.

Энэхүү зөрчлийг багасгаж зуучлах үүрэг, ажил хайгч, олгогч хоёрыг холбогч нь мэргэжлийн хүн байхыг шаардаж сүүлийн үед манайд ихээхэн үүрэг роль гүйцэтгэж байгаа *НИЙГМИЙН АЖИЛТАН* гүйцэтгэх ёстой гэсэн саналыг дэвшүүлж байна.

Гэхдээ энэ нь хөдөлмөрийн биржийн үйл ажиллагаанаас ялгаатай. Гол нь хүндээ чиглэсэн бодлогыг барьж байх ёстой.

Нийгмийн ажилтан байх давуу тал нь

- Монгол улсын хэмжээгээр нийт 70-80 гаруй нийгмийн ажилтан мэргэжлээр сэхээтнүүд төгсөж байгаа.
- Олон байгууллага болгон өөрсдийн Нийгмийн ажилтантай болсон.
- Хүний мөн чанар болон нийгмийн өмнө хүлээх эрх үүргийг сайн мэдэх.

- Ямар ч түвшний хүнтэй харилцах боломжтой.

Хүний эрхийг өндөрт тавьсан өнөөгийн нийгэмд ажлаасаа илүүтэйгээр хүнээ онцлон үзэж ажиллуулах, дадлагажуулах, голохгүй байх шаардлагыг төр засгаас хууль дүрэмд авч үзэх хэрэгтэй.

Эдийн засгийн хүрээнд хувийн хэвшил давамгайлах болсонтой холбоотойгоор ажилчдын эрх ашгийг хамгаалах шаардлага тулгарч байна. Өнөөдөр манай оронд хуульч эсвэл хуулийг сайн мэдэхгүй хүмүүс биш л бол хөдөлмөрийн хуулийн талаар ямар ч мэдлэггүй байгаа нь 2013 онд “Парадигм” клубээс авсан судалгаанаас харагдаж байна. Энэхүү судалгаанд төрийн захиргааны 5 байгууллага, хувийн аж ахуйн 10 байгууллагын 150 ажилчид оролцсон юм.

Та хөдөлмөрийн тухай хуулийг уншиж үзсэн үү, мэдэх үү гэсэн асуултад 68% нь үгүй буюу хараахан амжаагүй байна, харин та өөрийн ажлын дүрэм журамтай танилцсан уу гэхэд танилцаагүй буюу байхгүй гэж 53% нь хариулснаас өнөөгийн ажилчид хуулиа хэрхэн мэддэг нь харагдаж байна. Дээрх ажилтанд тулгарч байгаа асуудлыг хүртэл Нийгмийн ажилтан зохицуулж биелүүлж явах бүрэн боломжтой юм.

Ажилгүйдлийг арилгахад төрийн оролцоо яагаад бага байх ёстой вэ? Ажлын байр бий болгоход төрийн оролцоог маш бага, төрийн бус байгууллагууд болон нийгмийн ажилтнуудын үүрэг оролцоог өндөр байлгах нь чухал. Төрийн оролцоо өндөр байх тусам энэ нь эргээд дээр дурдсан болон маш олон сөрөг үр дагаврыг авчирдаг. Угаасаа одоо байгаа оролцоо баталж гаргасан хууль, журам, дүрэм заавар нь энэ тал дээр хангалттай олон сөрөг үр дагаврыг төрүүлж хөгжилд чөдөр тушаа болж байна.

Жишээ нь: Ажлын байр буй болгох нэрийдлээр улсын болон тусламжийн, хандивлагчдын мөнгийг үр ашиггүй зарцуулах, эдгээрийг танил талдаа өгөх авлигал хээл хахуульд өртөх гэх мэт. Харин төрийн зүгээс:

Улс орныг хөгжүүлэх ажилгүйдлийг арилгах талаар макро болон микро түвшинд стратегийн бодлого, үйл ажиллагаа явуулахдаа:

- Ажил эрхлэлтийн байдлаар нь оюуны болон биеийн хүчний ажил хэмээн төрөлжүүлэн үйлчилгээ үзүүлж болно.
- Шоовдор ажилгүйчүүдийг дэмжих тэднийг нийгмийн ажилтнаар дамжуулан бусад байгууллагатай холбож өгөх
- Ажилгүйчүүдийг сургалт семинарт байнга хамруулж байх болно.

Ажилгүйдлийг арилгахад: Нийтийг хамарсан компанит ажилд ажилгүй ядуучуудыг татан оролцуулах, хог цэвэрлэх, хот тохижуулах, далан шуудуу татах, гал унтраах, хадлан тэжээл бэлтгэх, ойжуулах, мянганы зам гэх мэт. Энэ нь дор хаяж дараах ач холбогдолтой

1. Ажил хийвэл ам тосдоно гэдэг зарчмаар зүгээр сууж байгаад тусламж авдаг сэтгэлгээнээс салгах.

2. Нийтийг хамарсан ажлаар дамжуулж зарим нэг хөрөнгө оруулалт төслийн хэрэгжилтийг ядуучуудын орлогыг нэмэгдүүлэх тусламжийн хэлбэрт шилжүүлэх /ойжуулах ажлыг ажилгүйчүүдийн хүчээр хийх, ойжуулах төсөл хэрэгжихийн зэрэгцээ, ажилгүйчүүдийн орлогыг нэмэгдүүлэх бололцоотой болох/

3. Төслөөр дамжуулан ажил олгогч болон ажилгүйчүүдийг хооронд нь холбох

4. Нийтийг хамарсан ажлаар дамжуулж зарим ажилгүйчүүдийн хөдөлмөрт хандах хандлага, ажил мэргэжлийн бэлтгэлийг дээшлүүлэх

5. Ажлын байрны тоог нэмэгдүүлэх зэрэг ач холбогдолтой юм.

6. МСҮТ-ийн сургалтыг чанаржуулах энэ нь цамаан ажилгүйчүүдийн тоог багасгахад оршино.

Илтгэлтэй холбогдуулж дараах дүгнэлтийг хийж байна.

- Ажилгүйдэл, ядуурал, архидалт гэсэн 3 асуудлыг гүнзгийрүүлэн судлахад өөр хоорондоо салшгүй холбоотой, бие биедээ харилцан нөлөөлж байдаг, түүгээр ч зогсохгүй цогцоороо нийгмийн бусад тулгамдсан асуудлуудыг үүсгэдэг, тэдгээрийг тодорхойлдог үндсэн хүчин зүйл болдог ажээ.

- Монголын нийгмийн хөгжилд сөргөөр нөлөөлж буй Ажилгүйдэл, Ядуурал, Архидалт зэрэг асуудлуудыг дан дангаар нь биш цогцоор нь шийдвэрлэх нь нэн шаардлагатай төдийгүй илүү үр дүнтэй юм.

- Нийгмийн Ажилгүйдлийн хэлбэрийг судалж үзээд, гологдсон ба шоовдор ажилгүйчүүд, цамаан ажилгүйчүүд, завсрын шинжтэй ажилгүйчүүд, амиа зогоогч ажилгүйчүүд хэмээн хэв маягчилж болмоор байна гэж үзлээ.

- Ажилгүйдлийг бууруулахад нийгмийн ажилтнуудын идэвх оролцоог нэмэгдүүлэх нь чухал байна.

- Нийгмийн ажилтнуудыг дадлагажуулах сургалт семинарт хамруулж байх шаардлагатай.

- Ажилгүйчүүдийг бүх нийтийг хамарсан ажилд хамруулан хамт олны уур амьсгал бүрдүүлэн төлөвшүүлэх

- Төрийн бус байгууллагуудтай хамтарч ажилгүйдлийг арилгах шинэлэг замыг хайж тэдний оролцоо эрх мэдлийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

- Нийгмийн өмнө тулгамдсан эдгээр асуудлуудыг цаашид гүнзгийрүүлэн нарийвчлан судлах шаардлагатай байна.

Ашигласан материал:

1. Ц.Пүрэв Социологийн мэдээллийг шинжлэх статистик арга УБ 2004 он
2. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг

3. М. Фридман, Р. Фридман Хувь заяагаа сонгах нь УБ 2001 он
4. Монгол Улсын Статистикийн эмхэтгэл УБ 2012, 2013 он
5. Социологи сэтгүүл-2, 3, 4
6. *Зууны мэдээ* сонины 2013-11-15 6 тал
7. Х.Гүндсамбуу Монголын нийгмийн давхраажилийн хөгжил хандлага УБ 2002 он
8. О. Лхагварэнцэн Далд эдийн засаг УБ 2008 он
9. Парадигм клубын судалгаа 2012-2014 он
10. Аймгуудад *Сонгууль*, *Авилгал*, *Иргэдийн нийгэм, эдийн засгийн төлөв байдал* гэх мэт цогц судалгаа 2012 он, 8-р сар / Хэнтий, Хөвсгөл, Архангай, Булган/

---o0o---

УДИРДЛАГЫН УХААНЫ ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА

MODERN TRENDS IN MANAGEMENT SCIENCE



Ж.Баттөгөлдөр
Дотоод хэргийн их сургуулийн
Хилийн албаны сургуулийн Хил судлалын магистрант, ахлах дэслэгч
Удирдсан багш: **Ч.Чулуунхүү**
Хилийн албаны сургуулийн
Хилийн албаны тэнхимийн дэд профессор, дэд хурандаа

Товч утга: Уг сэдвээр урьд өмнө нь хил судлалын магистр О.Баттулга “Хилийн тусгай ангийн захирагчийн удирдах ажиллагааг сайжруулах арга зам” Н.Бат-Итгэл “Хил хамгаалах байгууллагын удирдах ажилтны манлайллыг дээшлүүлэх арга зам”, Э.Майдар “Хил хамгаалах байгууллагын цэргийн мэргэжлийн удирдлагыг боловсронгуй болгох арга зам”, К.Алтанбек “Хилийн цэргийн ангийн удирдах албан тушаалтны мэдлэг, чадвар албанд нөлөөлөх нь” зэрэг сэдвүүдээр магистрын ажил горилсон бүтээл бичиж байсан ба миний бичсэн энэхүү илтгэл “Удирдлагын ухааны орчин үеийн чиг хандлага” гэдэг үгийг тайлбарлах, одоогийн хил хамгаалах байгууллагын бүх шатны удирдлагын арга барил, чадвар чадамжийг дээшлүүлэх талаар үнэлэлт дүгнэлт өгөхөд оршино.

Түлхүүр үгс: Удирдлага, чиг хандлага

Abstract: On this subject, master of border studies O. Battulga "How to improve the management of the head of the special border unit" N. Bat-Itgam "How to improve the leadership of the manager of the border protection organization" E. Maidar wrote master's theses on topics such as "Ways to improve military professional management of the Border Guard Organization", K. Altanbek "Influencing the knowledge and skills of the border guard unit's senior officers", and this report I wrote The aim is to explain the term "modern trends in management science" and to give an assessment of the management methods and capabilities of all levels of the current border protection organization.

Keywords: Management and trends.

Цэргийг удирдана гэдэг нь юуны түрүүнд хүн хүнээ удирдахыг хэлнэ. Тийм болохоор цэргийг бат тууштай атлаа шуурхай, уян хатан

удирдах захирагчийн чадвар нь түүний хувийн зан төлөвөөр илэрч байдаг. Цэргийн дарга бол мэргэжлийн болон сэтгэл зүйн өндөр бэлтгэлтэй, цагийн байдлын ямарч хүнд нөхцөлд тэвчээр алдахааргүй хатуужилтай, өөртөө хатуу шаардлага тавьж чаддаг, хариуцлагыг өөрөө үүрэхэд бэлэн байхын дээр хамгийн гол нь захирагсдадаа халамжтай, хүндэтгэлтэй ханддаг байх учиртай.

Шинжлэх ухаанд ерөнхий асуудлаас тодорхой руу шилжин судлах арга зүй байдаг. Энэ нь тухайн тодорхой асуудалд хандахдаа ерөнхий асуудлаа эхнээс нь зөв ойлгож, нэгдсэн тодорхой ойлголттой болох зайлшгүй шаардлагатай байдаг.

Монгол Улсын төрийн цэргийн байгууллын тогтолцоо нь тайван цагт зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагаас бүрдэнэ[1551.] гэж Батлан хамгаалах хуульд тусгасан бөгөөд Хил хамгаалах байгууллага нь Монгол улсын төрийн цэргийн байгууллагын бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд чиг үүрэг, үйл ажиллагааны онцлог нь байгууллагын удирдан зохион байгуулахад удирдахуйн ухаанаас гадна, цэргийн удирдлагыг онолын талаас нь судалж, хэрэгжүүлэх шаардлагатай байдаг.

Цэргийн удирдлага бол удирдлагын онцгой төрөл байдгийн учир нь байлдааны зэвсэг, тусгай зориулалтын техниктэй, түүнийгээ хуулийн дагуу хэрэглэх эрх бүхий төрийн цэргийн байгууллагуудыг удирддагт оршино.

Цэргийн удирдлагыг судлахын тулд нэр томьёоны ойлголтыг мэдэх нь чухал бөгөөд "Удирдлага" гэдэг ойлголтыг шинжлэх ухааны талаас нь ойлгох нь чухал юм. Монгол хэлний их тайлбар толь бичигт "Удирдлага гэдэг үг нь удирдах үйл ажиллагаа, удирдах үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэгч, удирдамж буюу заавар өгөх"[156] гэсэн утгыг агуулсан байна.

Винер.Н.-ын "Удирдагч хүн" гэдэг номондоо удирдлагын тухай нэлээд өргөн хэмжээнд авч үзэж, "Удирдлага нь механик, биологийн болон нийгмийн системд байдаг хамгийн ерөнхий /өргөн хүрээтэй/ шинж чанар, харилцан ажиллагаа"[157] гэж тодорхойлсон бол зохион байгуулалт болон удирдлагын салбарын тэргүүний онолчдын нэг Питер Фердинанд Друкер "Удирдлага гэдэг нь зохион байгуулалтгүй бөөгнөрсөн хүмүүсийг үр ашигтай, бүтээмжтэй бүлэг болгон өөрчлөх үйл ажиллагааны онцгой хэлбэр юм" гэжээ.

---

[155] Батлан хамгаалах тухай хуулийн 2-р бүлгийн 9-р зүйл Төрийн мэдээлэл. 2016. №36
[156] Монгол хэлний их тайлбар толь бичиг. УБ 2015
[157] Н. Винер,Удирдагч хүн.УБ. 1998

XIX зууны сүүлчээр ОХУ-ын Цэргийн шинжлэх ухааны тайлбар тольд удирдлагын тухай анхны тайлбарыг хийж "Цэргийн удирдлага гэдэг нь олон тооны, янз бүрийн салбарыг нэгтгэн захирахаар байгуулагдсан тусгай байгууллага" гэж тодорхойлсон байна.

"Цэргийн удирдлага" гэдэг нэр томьёог бүх талаас нь бүрэн тодорхойлсон тодорхойлолт байхгүй боловч Шинжлэх ухааны ном, зохиолуудад "Цэргийг удирдах" гэдэг ойлголтыг "Цэргийн удирдлага" гэдэгтэй адилтган тайлбарлаж байгаа нь бүрэн оновчтой бус бөгөөд нэлээд өргөн ойлголт юм. Энэ бүгдээс үзэхэд “Удирдлага” гэдэг нэр томьёо нь хүмүүс объектууд болон ажиллагааны үйл явцад зориудаар, зорилго-чиглэлтэй нөлөөлж байгаа хүний үйл ажиллагааны нэг төрлийг хэлнэ.

Удирдагч хүн өөрийн гаргасан тушаалын хүрээнд болон түүнээс гадна хүмүүсээс хамаарч байдаг тул түүнд албан ёсны бүрэн эрхээс гадна эрх мэдэл хэрэгтэй. Энэ

талаар Джон Л.Коттер тэмдэглэхдээ “Удирдагч хүн эрх мэдлийг хөгжүүлэх шаардлагатай байдаг. Яагаад гэвэл нэгдүгээрт: удирдагч хүн захиргаандаа байдаг хүмүүсээс үргэлж хамаарч байдаг, хоёрдугаарт: орчин үеийн байгууллагад түүний гаргасан тушаал зааврууды бараг хэн ч хүлээн авч бүрэн захирагддаггүй.

Удирдлага нь удирдагч, удирдуулагч хоёрын хооронд үүсэх нийгмийн харилцаа бөгөөд хамтын хөдөлмөр үүссэн үеэс удирдлага үүсжээ. Өөрөөр хэлбэл нэг хэсэг нь хийж нөгөө хэсэг нь хийлгэж ирсэн. Хүмүүсийн хамтын үйл ажиллагаанд удирдлагын тухай ойлголт ямагт байсаар ирсэн. Удирдлагын үйл ажиллагаа шийдвэр гаргах, шийдвэрийг хэрэгжүүлэх, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх үнэлэлт өгөх үйл явцаас бүрдэнэ. Хүнийг удирдаж зална гэдэг үнэнхүү бэрх ажил бөгөөд чаддаг хүндээ урлаг, чадахгүй хүндээ дарамт болдог. Хүнийг удирдан чиглүүлэх үйл ажиллагаа урьд ч байсан, одоо ч байгаа, хойшид ч байх болно. Удирдах ажил бол ухамсарт үйл ажиллагаа бөгөөд менежментийн шинжлэх ухаанд тулгуурлана. Хүний сэтгэлийн “багш” байж, сэтгэл зүйн ухааныг ашиглаж хүний өөрийнх нь дотоод нөөц хүчийг илрүүлж чаддаг тийм байгууллага л үр дүнд хүрдэг явдал нотолгоо шаардахгүй үнэн болж хувирчээ. Хамт олны сэтгэл зүйн уур амьсгал, хувийн сонирхол, онцлог, удирдах ажилтны нэр хүнд, хүнтэй хамтран ажиллах чадвараас ажлын амжилт шалтгаалж байна. Тэр тусмаа менежерийн хүнтэй ажиллах чадвараас хамт олны доторх сэтгэл зүйн уур

амьсгал нэлээд шалтгаалдаг. Нийгэм эдийн засгийн хөгжлийг хэр зэрэг задлан шинжилж, оновчтой шийдвэр гарган хэрэгжүүлж байгаагаар нь тухайн улс орны шинжлэх ухаан, оюуны чадавхыг хэмжиж, удирдах ажилтны чадавхыг харж болно. Төрийн байгууллагын удирдах ажилтан хүн, хүнийг өөртөө татах дээд зэргийн чадварыг эзэмшсэн байхыг хаа хаанаа л номлодог. Хүнтэй хамтран ажиллах чадвар мөхөс удирдах ажилтан үүргээ биелүүлэхэд үлэмж бэрхтэй байдаг. Хүнтэй ажиллах урлаг төрөлхөөс заяадаггүй. Тэр нь сургалтын янз бүрийн хэлбэр амьдралын туршлага, өөрөө өөртэйгөө ажиллах зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалдаг буюу удирдах ур чадвар амьдралын туршид төлөвшдөг. Хүнийг, хүний сэтгэл зүйг танин мэдэх явдал удирдах ажилтны маш чухал чанар юм.

Удирдлагын системд хүмүүсийн оролцоо тэргүүлэх үүрэгтэй учраас зарчимч бүтээлч удирдагч тухайн системийн нэн чухал бүрэлдэхүүн байдаг. Удирдлагадаа өндөр итгэл хүлээлгэх, захирах, захирагдах ёсыг хатуу баримтлах нь цэргийн удирдлагын онцлог тал юм. Энэ нь захирагч бие бүрэлдэхүүнийхээ бүх талын өсөлт хөгжилтийг хөхүүлэн дэмжиж тэднээс хувийн сахилга батаа өндөрт авч явахыг шаардах, захирагдагсад нь түүний шаардлага, дэмжлэгийн хариуд үнэн сэтгэл гаргаж хөдөлмөрлөх зэргээр илэрч байдаг. Захирагдагсад өөрсдийн амлалт, үүргээ нээлттэй, мэдээлэлтэй байлгах нь удирдлагын нэг зорилго бөгөөд ажил, үүргийг эзэнгүйдүүлж, саланги, тусгай байдалд тэмүүлэх хандлагыг үл дэмжих нь захирагчийн эрхэлвбэл зохих нэг чанар юм.

Захирагч өөрийн үүрэг, тушаал, ажиллагааны тактикийг боловсруулахдаа хэрхэн гүйцэтгэхийг нарийвчлан тодорхойлох албагүй бөгөөд түүний хамгийн тэргүүний үүрэг бол захирагдагсдын бие даасан ажиллагаанд удирдамж болохуйц өөрийн бодлогыг тодорхой илэрхийлэх асуудал байдаг. Удирдлагын өөр нэг чухал үүрэг бол байгууллагын хэмжээнд итгэлцэх, ойлголцлыг бүрдүүлэхийн суурь болох баг, бүлгийн найрсаг, ойр дотно харилцааг төлөвшүүлэх асуудал юм. Захирагч хүн бие бүрэлдэхүүний итгэл, үнэмшил төгс ойлголцллын суурь болох хамт олны уламжлалт үнэт зүйлсийг хөхүүлэн дэмжиж ажиллах ёстой. Захирагч нь бие бүрэлдэхүүн санаачилгатай ажиллах, хамт олон дотроо учраа ололцоход бүх нийтээрээ дэмжлэг үзүүлэх уур амьсгал бий болгоход хүчтэй нөлөө үзүүлэгч байх ёстой.

Хүн удирдана гэж үндсэндээ хүний зүрх сэтгэлийг таньж мэдэх, түүнийг эзэмдэх ур чадвар юм. Өөроор хэлбэл удирдах ажилтан хүн бусдын

зүрх сэтгэлийг таньж чаддаг ондор мэдрэмжтэй байх ёстой. “Биеийг нь хураах гэвэл сэтгэлийг нь тат, сэтгэлийг нь татвал бие нь хаа холдох вэ?” хэмээн Чингис хаан айлджээ. Хүний сэтгэлийг хураах хамгийн сайн эрдэм бол удирдаж буй хүнийхээ сэтгэлийг ойлгох. Үүний тулд хэлж буй бүхнийг нь сонсч, хүсч буй бүхнийг нь мэдэрч түүнд нийцүүлж шийдвэр гаргах явдал юм.

Хүнтэй ажиллах нь түүний ур чадвар бөгөөд удирдах ажилтны шинж чанарыг тодорхойлж байдаг. Тийм ажлын хэлбэр нь хамт олныг зохион байгуулах идэвхжүүлэх зарим тохиолдолд цаг үеэ олон шийтгэл, зэмлэлтэй хослуулахыг шаарддаг. Хүн гэдэг өөрөө байгалийн амьтан төдийгүй бас нийгмийн амьтан мөн. Иймээс хүний амьдралын мөн чамар түүний дотоод сэтгэлээр илэрч байдаг. Удирдах ажилтан хүний дотоод сэтгэлд дараах шинжүүд ямагт байх ёстой гэж үздэг. Үүнд:

- Удирдах ажилтан хүний хамгийн эрхэм чанар нь “Өөрийгөө бусдын төлөө зориулах явдал” өөрөөр хэлбэл өрөөлийн төлөө өөрийгөө залж зориулахад оршино. Энэ утгаараа удирдах ажилтан байна гэдэг “Өөрийгөө ялан гарах аугаа их сорилт болой”. Учир нь би гэхээсээ илүү тэд гэж бодож тэдний төлөө ухамсарт амьдралаа зориулах учиртай.

- Удирдах ажилтан хүн бусад хүмүүсээр хүлээн зөвшөөрөгдсөн чанаруудыг өөртөө төлөвшүүлэх ёстой. Хүний олон талт үйл ажиллагаанаас илэрсэн “сайн талууд”-ын үндсэн дээр бий болсон итгэл хүндлэлийг нэр хүнд гэж ойлгодог. Нэр хүнд төлөвшин тогтох үндсэн зам нь тэрээр хамт олныхоо төлөө зүтгэх явдал юм. Алдар нэрийг олж авах хэцүү, олж аван хадгалах бүр хэцүү гэсэнчлэн удирдах ажилтан нэр төрөө ямагт хайрлах ёстой.

- Хүн удирдана гэж үндсэндээ хүний зүрх сэтгэлийг таньж мэдэх, түүнийг эзэмдэх ур чадвар юм. Өөрөөр хэлбэл удирдах ажилтан хүн бусдын зүрх сэтгэлийг таньж чаддаг ондор мэдрэмжтэй байх ёстой. “Биеийг нь хураах гэвэл сэтгэлийг нь тат, сэтгэлийг нь татвал бие нь хаа холдох вэ?” хэмээн Чингис хаан айлджээ. Хүний сэтгэлийг хураах хамгийн сайн эрдэм бол удирдаж буй хүнийхээ сэтгэлийг ойлгох. Үүний тулд хэлж буй бүхнийг нь сонсож, хүсч буй бүхнийг нь мэдэрч түүнд нийцүүлж шийдвэр гаргах явдал юм.

- Удирдах ажилтан хүний сэтгэл, сэтгэлгээ гэдэг үргэлж залуу, шинэлэг байх ёстой. Ийм ч учраас “Улиг домог болсон нэг хэвийн

зүйлсийг үгээрээ ч үйл ажлаараа ч тойрч бай” хэмээн эртний их сэтгэгч Пифагор айлджээ.

- Удирдах ажилтан хүний онцлог шинж нь түүний зарчимтай ажиллагаагаар тодорхойлогдоно. Иймээс жинхэнэ удирдагч хүн өөрийн гэсэн удирдахуйн философи, амьдралын зарчимтай байх ёстой Жишээ нь: Чингис хааны удирдахуйн гол философи нь “Хүчтэй байх явдал бөгөөд чамайг няц дарна, тэгээгүй цагт чи намайг няц дарна” Би юу? Чи юу? гэсэн зарчимд тулгуурлаж байжээ.

Дүгнэлт:

Цэргийн анги байгууллагууд нь улс орныг цэргийн хүчээр батлан хамгаалах зорилго бүхий төрийн цэргийн байгууллагын тогтолцоо мөн учир “төвлөрүүлэн удирдах, нэгтгэн захирах” зарчимд тулгуурлах нь хэн бүхэнд ойлгомжтой боловч аливаа асуудлыг захиран тушаах журмаар биш аль болох хүн рүү чиглэсэн хүмүүнлэг аргаар шийдэхийг цаг ямагт анхаарах нь чухал болов. Гэхдээ шаардлагатай үед ямар ч үүргийг биелүүлэх чадварыг хадгалж байх нь цэргийн анги байгууллагын менежерүүдийн онцлог чанар байх ёстой. Үүний тулд цэргийн шинжлэх ухаан, хил судлалын шинжлэх ухааныг менежментийн шинжлэх ухаантай чадварлаг зов хослуулан ажиллах авьяасыг эзэмших шаардлагатай.

Цэргийн анги байгууллагын дунд шатны менежерүүдийн манлайлалыг дээшлүүлж тэдэнд алба салбарынхаа менежмент, ажлын стандартыг бие даан шинэ төвшинд хүргэх бололцоог аль болох олгох хэрэгтэй. Учир нь энэ түвшний менежерийн зорилтын цар хүрээ өргөн, үр дүнгийн хэмжүүр өндөр, хийж бүгээх ажил нь их байдаг. Менежментийг анги байгууллагадаа хэрэгжүүлж байгаа явц үндэслэн дэвшүүлж буй дээрх саналуудыг цогцолбор байдлаар хэрэгжүүлбэл орчин үеийн цэргийн анги байгууллагуудын менежмент шилдэг тэргүүний төдийгүй олон улсын жишиг, төвшинд хүрэх бололцоотой гэж дүгнэж байна.

Ашигласан материал:

1. “Хилийн тусгай ангийн захирагчийн удирдах ажиллагааг сайжруулах нь” 2014 он
2. Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966 он
3. Батлан хамгаалах тухай хууль УБ., 2016 он

---o0o---

Шинжлэн магадлах ухаан

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНД КРИМИНАЛИСТИКИЙН ТЕХНИК ЗҮЙН МЭДЛЭГ АШИГЛАХ НЬ

THE PROBLEM OF USING CRIMINALISTICS TECHNICAL KNOWLEDGE IN THE EXECUTION OF COURT DECISIONS



Э.Батбаяр
Дотоод хэргийн их сургууль,
Шинжлэн магадлахуйн институтийн ахлах багш,
магистр, цагдаагийн хошууч



О.Одонтуяа
Дотоод хэргийн их сургууль,
Шинжлэн магадлахуйн институтийн эрдэм шинжилгээний ажилтан-багш, докторант,
цагдаагийн дэд хурандаа

Товч утга: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд криминалистикийн техник зүйн мэдлэг ашиглах тухай ойлголт, нөхцөл, эрх зүйн зарим зохицуулалт, анхаарах асуудлын талаарх мэдлэгийг хүргэхийг зорьсон.

Түлхүүр үгс: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, хойшлуулшгүй тохиолдол, мөр мөшгөх, криминалистикийн гэрэл зураг, криминалистикийн бүртгэл, криминалистикийн хэл.

Abstract: It is intended to bring together the concepts, conditions, legal regulations, and the issues to be considered regarding the use of forensic technical knowledge in the execution of court decisions.

Keywords: Court order enforcement, case of delay, trace, evidence, criminalistics registration.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хүний эрх, эрх чөлөөг зөвхөн хуульд зааснаар хязгаарлах, энэрэнгүй, шуурхай байх зарчмыг баримталдаг. Криминалистикийн шинжлэх ухааны мэдлэг нь хүний эрхийг хангах шинжлэх ухааны баталгаа болдог. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд криминалистикийн шинжлэх ухааны мэдлэгийг ашиглах зайлшгүй шаардлага тулгардаг.

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд криминалистикийн мэдлэгийг ашиглах нь. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хорих ангийн харьяа нутаг дэвсгэрт хоригдлын үйлдсэн гэмт хэрэгт хорих байгууллагын эрх бүхий албан тушаалтан дараах мөрдөн шалгах ажиллагааг хойшлуулшгүй тохиолдолд явуулж, прокурорт даруй шилжүүлэх үүрэгтэй[158] байдаг. Үүнд:

1.Үзлэг хийх;

2.Шинжилгээнд зориулж дээж, хурууны хээ, ул мөрний хэв авах;

3.Хохирогч, гэрчээс мэдүүлэг авах;

4.Хэрэгт ач холбогдол бүхий тээврийн хэрэгсэл, мөнгө, эд зүйлийг хурааж авах;

5.Эд хөрөнгийг битүүмжлэх;

6.Шинжилгээ хийлгэх шийдвэр гаргах.

Хорих байгууллагын эрх бүхий албан тушаалтан хойшлуулшгүй тохиолдолд л дээрх мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлнэ. Хойшлуулшгүй тохиолдолд дараах нөхцөл байдал багтдаг:

1. Хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах;
2. Сэжигтэн, яллагдагч оргон зайлах;
3. Хэргийн ул мөр, эд мөрийн баримт устах, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдэх бодит аюул байгаа.

Хорих ангийн харьяа нутаг дэвсгэрт хойшлуулшгүй тохиолдлын 1, 2-т заасанг эрх бүхий албан хаагчид тэр даруй гүйцэтгэж таслан зогсоох, сэргийлдэг. Харин “хэргийн ул мөр, эд мөрийн баримт устах, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдэх бодит аюул байгаа” тохиолдолд хэргийн газрын хамгаалалт болон үзлэгийг бүрэн дүүрэн хийж гүйцэтгэх шаардлага бий болдог.

Хорих ангийн харуул хамгаалалтын журамд[159] “хоригдлын зүгээс үйлдсэн орголт, гэмт хэрэг, зөрчлийг мэдсэн, илрүүлсэн алба хаагч хорих ангийн ерөнхий жижүүрт дариу мэдэгдэнэ, ерөнхий жижүүр нөхцөл байдлыг үнэлэн хойшлуулшгүй арга хэмжээг шуурхай авч, онцгой нөхцөл бий болсон үед ажиллах ерөнхий болон чиглэлийн төлөвлөгөө, оператив жижүүр, шуурхай штабаас өгсөн

[158] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он. № 30.7 зүйл

[159] Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/197 дугаар тушаалын хавсралт.

үүрэг чиглэлийн дагуу дараагийн ажиллагаанд шилжинэ” гэж заасны дагуу хорих ангийн хамгаалалтын ажилтнууд тухайн орон нутгийн цагдаагийн байгууллагад нэн дариу дуудлага мэдээлэл өгч, хэргийн газрын хамгаалалтыг зохион байгуулах үүргийг хүлээдэг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан “хэргийн ул мөр, эд мөрийн баримт устах, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдэх бодит аюул байгаа” тохиолдолд “Үзлэг хийх”[160] прокурорт даруй шилжүүлэх үүргээ биелүүлэхээс илүүтэйгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын журмыг баримтлан орон нутгийн цагдаагийн байгууллагад нэн дариу дуудлага мэдээлэл өгч, хэргийн газрын хамгаалалтыг зохион байгуулж байгаа практикт үйл ажиллагаанд түгээмэл байдаг.

Хорих байгууллагын эрх бүхий албан тушаалтан хэргийн газрын орчинд үүссэн ул мөр, эд мөрийн баримтыг цас, бороо, салхи шуурга гэх мэт байгаль цаг уурын нөхцөл болон бусад шалтгааны улмаас устах нөхцөл байдал үүссэн үед мөр илрүүлж, бэхжүүлэх ажиллагааг хийх онолын мэдлэг болон хэргийн газрын үзлэгийн техник хэрэгслийг ашиглах боломж бүрдсэн, түүнийг ашигладаг байх ёстой.

Хорих ангид үйлдэгддэг гэмт хэргийн онцлог нөхцөл байдлыг харгалзан хэргийн газрын хамгаалалт болон үзлэгийг зөв зохион байгуулах нь хэрэг үйлдэгдсэн байдал, гэмт этгээдийн тухай болон бусад байдлын талаар анхны мэдээлэл цуглуулах, гэмт хэрэгтнийг халуун мөрөөр нь эрэн сурвалжлах, бусад гүйцэтгэх ажлын мэдээ, мэдээллийг олж авах, гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг тогтоох, хэрэгт ач холбогдолтой ул мөр, эд мөрийг устах, гэмтэхээс сэргийлж нотлох баримт болгох боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой.

Хорих ангид үйлдэгдсэн гэмт хэргийн газар түрүүлж ирсэн алба хаагч /ахлагч, офицер/ хэргийн газарт үүссэн ул мөрийг гэмтээхгүй, устгахгүй байх, мөн өөрсдийн ул мөрийг нэмэлтээр үлдээхгүй байх тал дээр сайтар анхаарах шаардлагатай.

Хэргийн газар, мөрний талаар мэдээлэл багатайгаас мөрийг санаандгүй устгах, гэмтээх эрсдэл байдаг.

Хойшлуулшгүй ажиллагааны хүрээнд үзлэг хийхэд криминалистикийн мөр судлалын мэдлэг түүний дотор мөртэй ажиллах зарчим, мөр цуглуулах (илрүүлэх, бэхжүүлэх, битүүмжлэх, хадгалах) болон хэргийн газрын орчин нөхцөлийг бодитойгоор дүрслэн, харуулахын тулд криминалистикийн гэрэл зургийн арга барилыг ашиглах шаардлага зүй ёсоор тулгардаг.

---

[160] Үзлэгийн төрөлд хэргийн газрын үзлэг, цогцосны үзлэг, хүний биед, эд зүйлд гэх мэт үзлэг хамаардаг.

Мөн гэмт этгээд оргон зугтсан хэргийн газар криминалистикийн мөр мөшгөх аргыг тогтсон аргачлалын дагуу явуулах нь чухал үр нөлөөтэй. Түүнчлэн мөр мөшгөхөд хөлийн мөр болон үнэрийн мөрийг ашигладаг. Хөлийн мөрөнд агуулагдаж байгаа шинж тэмдэг, шинж чанарыг ашиглан мөрийг мөшгөнө. Мөн хөлийн мөр үүссэн цаг хугацаа, үүссэн зүй тогтол, хүлээн авагч обьектын онцлог зэрэг шинж чанарыг анхаарна. Хөлийн мөр мөшгөхдөө гутлын мөрийн нийт урт, өсгийн өргөн, өлмийн өргөн, түүнд агуулагдаж буй дахин давтагдашгүй хувийн онцлог шинж тэмдгийг тогтоох, түүнийг гар зураг болон гэрэл зургаар бэхжүүлнэ. Ингэснээр мөрийг мөшгөх явцад мөр бүдгэрэх, ижил төрлийн хөлийн мөрийн хээ зураглалтай холилдох үед ялган таних боломжийг криминалистикийн мөр судлалын мэдлэг олгоно. Мөрийг мөшгөхөд ач холбогдолтой нэг мөр нь үнэрийн мөр юм. Үнэрийг мөрийг илрүүлэхэд тулд үнэрч нохой, мэргэжилтэн /нохой хөтлөгч/ байх шаардлагатай байдаг.

Дараагийн чухал ажиллагаа бол криминалистикийн гэрэл зураг бөгөөд дараах байдлаар ашигладаг. Үүнд:

1. Гэмт хэрэг үйлдэгдсэн орчин, нөхцөл, ул мөр, эд мөрийн баримтын харилцан байрлал, шинж чанар, шинж тэмдэг зэргийг бэхжүүлэх;
2. Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны явц, үр дүнг баримтжуулах /эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа гэх мэт/;
3. Хоригдлыг таниулах гэрэл зураг /нүүр, содон шинж тэмдэг гэх мэт/;
4. Хорих ангийн дотоод журам зөрчсөн үйл явцыг баримтжуулах.

Мөн криминалистикийн бүртгэлийн мэдлэгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ял эдэлж байгаа хоригдогч, хоригдол, ялтны гэрэл зураг, гарын хээ болон бусад мэдээллийг төрөл бүрийн санд бүрдүүлэх ашиглан хөтөлдөг. Мөн криминалистикийн бүртгэлийн шуурхай лавлагааны тоо бүртгэл, туслах лавлагааны тоо бүртгэлийг түгээмэл ашиглаж болно. Жишээлбэл “Гэмт хэрэгтний фото, видео дүрсийн сан”-г бүрдүүлэхэд ашиглана.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд криминалистикийн мэдлэгийг ашиглахын тулд мэргэжилтний мэдлэг, ур чадвараас гадна хэргийн газрын үзлэг хийхэд тусгай зориулалтын техник хэрэгсэл бүхий иж бүрэн цүнхийг хорих ангийн жижүүрийн шуурхай албанд байлгах шаардлагатайг анхаарах зүйтэй.

Хууль зүй, дотоод хэргийн Сайдын 2009 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 110 дугаар тушаалаар баталсан журмаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хоригдогч, хоригдол, ялтны гэрэл зураг, гарын хээний бүртгэлийг хөтлөх үүргийг хүлээсэн боловч ялангуяа гарын хээний бүртгэлийг хөтөлж байгаа

өнөөгийн байдлын хэрэгжилт хангалтгүй байна гэж үзэж болохоор байна.[161] Гарын хээний санд гарын дардас авч бүртгэх, гарын хээний санг зориулалтын дагуу үйл ажиллагаандаа хэрэглэх албан хаагчийг ДХИС-ийн Шинжлэн магадлахуйн институтэд бэлтгэх бүрэн боломжтой юм.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд криминалистикийн мэдлэгийг ашиглах нь. Тус ажиллагааны хэрэгжилтийг хангахад "Шийдвэр гүйцэтгэлийн хувийн хэрэг" хөтлөх, баримт бичгийн бүрдлийг баталгаажуулахад шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэр, тэмдэглэл (бичгийн машин, компьютер, эсхүл гар бичмэл, гарын үсэг зурж, албадлагын арга хэмжээний үйл явц, үр дүнг дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлэх) дээрх мэдээллийн үнэн, зөвийг шалгах шаардлага гарах үед криминалистикийн бичиг судлал, бичиг техник судлалын мэдлэг ашигласан үед ямар нэгэн зөрчилдөөн бий болох үед нотломж болох ач холбогдолтой.

Мөн эд хөрөнгө битүүмжлэх, хураан авах ажиллагааг тэмдэглэлээс гадна гэрэл зургийн арга, дүрс бичлэгийг аргаар давхар бэхжүүлэх нь тухайн цаг хугацаанд байсан эд хөрөнгийн гадаад бүтцийн шинж чанар, шинж байдалд болон тодорхой хугацааны дараа эд зүйлд гарсан гадаад бүтцэд гарсан өөрчлөлт, тоо, ширхэг, чанар зэргийн талаарх мэдээллийг баримтжуулахад дэмжлэг үзүүлдэг.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд эд зүйлс, түүний бүрдэл хэсгүүдийг нэрлэхэд оноосон нэрийг зөв хэрэглэхэд хүндрэл учирдаг. Эртний эдлэл, мал аж ахуйн тоног, автомашин, бусад техник хэрэгсэл гэх мэтийг нэрлэхэд криминалистикийн хэл, нэр томьёог ашиглах шаардлага гардаг. Тухайлбал, шинжлэн магадлахуйн эрдэмтэд болох А.Доржготов, Ч.Сонгино нарын "Зурагт толь" бүтээлд бүх төрлийн эд зүйлс, тэдгээрийн бүрдэл хэсгүүдийг нарийвчлан нэрлэсэнийг ашиглаж болно.

Дүгнэлт, санал:

Криминалистикийн мэдлэгийг эрүүгийн болон иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд бүрэн, оновчтой ашигласнаар хорих байгууллагад үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, мөн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хойшлуулшгүй ажиллагааны хүрээнд үзлэг хийхэд мөр судлал, мөртэй цуглуулах ажиллагааг хэрэгжүүлэх, мөр мөшгөх, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны явц, үр дүнг баримтжуулахад

[161] Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги, Нэгдсэн эмнэлэг 401 дүгээр хаалттай ангид гарын хээний бүртгэлийн "Живой-сканнер" ажлын станцыг суурилуулан ашиглалтад оруулсан хэдий ч 2020 онд бэлтгэгдсэн ажлын хэсгийн оператор ажлаас чөлөөлөгдснөөр уг станцыг ажиллуулах, гарын хээний тоо бүртгэлийг хөтлөөгүй байна.

криминалистикийн гэрэл зураг, дүрс бичлэг ашиглах, хоригдогч, хоригдол, ялтны бүртгэл, мэдээллийг сан, бүртгэл бүрдүүлэхэд криминалистикийн бүртгэл ашиглах, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд эд зүйлс, түүний бүрдэл хэсгүүдийг зөв оноон нэрлэх зэргээр өргөн ашиглах боломжтой.

Иймээс шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдын криминалистикийн мэдлэгийг дээшлүүлэхэд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад хэргийн газрын хамгаалалт, үзлэгийн чиглэлийн дадлага сургалтыг зохион байгуулах,

- Мөн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд криминалистикийн мөр судлал, бичиг судлал, бичиг-техник судлал, үнэр судлал болон бүртгэлийн талаарх мэдлэг, чадварыг олгох давтан сургалтыг зохион байгуулах;

- Хорих ангид хэргийн газрын хамгаалалт, үзлэг зохион байгуулах чиглэлээр “Дадлага сургалт”-ыг харьяа орон нутгийн цагдаа, шүүх шинжилгээний байгууллагатай хамтран зохион байгуулах;

- Хорих ангийн жижүүрийн техник хэрэгслийн нөөцөд хэргийн газрын үзлэгийн цүнхийг нэмж оруулах.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

1. Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1992 он, №1
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №24
3. Шүүх шинжилгээний тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2023 он, №05
4. Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №23
5. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2002, №8.
6. “Хорих ангийн харуул хамгаалалтын журам”. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/197 дугаар тушаалын хавсралт
7. “Гарын хээний нэгдсэн сангийн журам”. Хууль зүй, дотоод хэргийн Сайдын 2009 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 110 дугаар тушаалын хавсралт
8. Б.Баяр нар., Хамтын бүтээл “Гэмт хэрэг илрүүлэхүй”. Уб., 2015 он
9. Б.Жаргалсайхан., “Учралын газрын үзлэг”. Уб., 2008 он
10. Б.Лхагвасүрэн., “Мөр”. Уб., 2015 он
11. Ч.Батболд., “Хорих ангид үйлдэгдсэн гэмт хэрэгт хэргийн газрын үзлэг зохион байгуулахад анхаарах асуудал” сэдэвт илтгэл. “Хүний эрх ба Шинжлэн магадлах ухаан” ОУЭШХ-ын илтгэлийн эмхэтгэл. Уб., 2022 он

12. Б.Замбага., “Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэг талуудын эрхийг хангах нотлох баримт болох нь” сэдэвт илтгэл. “Хүний эрх ба Шинжлэн магадлах ухаан” сэдэвт ОУЭШХ-ын илтгэлийн эмхэтгэл. Уб., 2022 он

13. Г.Хосбаяр., “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад криминалистикийн бүртгэлийг ашиглаж буй өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудал” сэдэвт илтгэл. “Хүний эрх ба Шинжлэн магадлах ухаан” сэдэвт ОУЭШХ-ын илтгэлийн эмхэтгэл. Уб., 2022 он

---o0o---

ХҮНИЙ БИЕД УЧИРСАН ГЭМТЛИЙН ЗЭРЭГ ТОГТООХ ШҮҮХ ЭМНЭЛГИЙН ШИНЖИЛГЭЭГ СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН МАТЕРИАЛААР СУДАЛСАН ДҮН

THE RESULTS OF THE FORENSIC EXAMINATION OF THE DEGREE OF INJURY CAUSED TO THE HUMAN BODY, BASED ON THE MATERIAL OF THE LAST 5 YEARS



Ц.Нандинцэцэг
Дотоод хэргийн их сургуулийн
Шинжлэн магадлах институтын
Байгалийн ухаан техник зүйн шинжилгээний
тэнхимийн багш, цагдаагийн ахмад



Б.Ундармаа
Клиникийн профессор, тэргүүлэх зэргийн эмч,
анагаах ухааны магистр, цагдаагийн хошууч



Б.Долгормаа
Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн,
Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын тэргүүлэх
зэргийн эмч, анагаах ухааны магистр, цагдаагийн ахмад

Товч утга: Шүүх эмнэлгийн шинжилгээний үндсэн объект бол амьд хүнд хийгдэх шинжилгээ бөгөөд шинжээч эмч хүний биед учирсан гэмтэл, гэмтлийн зэргийг тогтоох, бэлгийн холбогдолтой асуудал болон нас тогтоох, хүйс тогтоох,

эрүүл мэндийн байдлыг тогтоох зэрэг шинжилгээнүүдийг хийж, шинжээчийн дүгнэлт гаргадаг.

Сүүлийн жилүүдэд хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, хүний эрүүл мэндэд хүнд болон хүндэвтэр, хөнгөн хохирол учруулах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зэрэг гэмт хэрэг, мөн зам тээврийн осол гэмтэл ихэссэнээр шүүх эмнэлэгт хийгдэх хүний биед учирсан гэмтлийн зэргийг тогтоох шинжилгээ нэмэгдсээр байна.

Бид ШШЕГ-ын сүүлийн 5 жилийн материалаар хүний биед учирсан гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг тоон үзүүлэлтээр нарийвчлан судлах, Улаанбаатар хотод ШШЕГ-т болон аймгуудын ШША-нд хийгдсэн хүний биед учирсан гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний тоон үзүүлэлтийг харьцуулан судлахыг зорилоо.

Түлхүүр үгс: Залуучууд, гэр бүл, шилжилт, хөдөлгөөн, хил хамгаалах байгууллага.

Abstract: The main purpose of the forensic examination is to conduct an examination of a living person, and the expert doctor makes an expert opinion by determining the degree of injury and damage to the human body, sexual problems and determining the age.

In recent years, crimes against the inviolability of human health, serious or minor damage to human health, family violence, and the increase in traffic accidents have resulted in the number of tests to determine the degree of injury to the human body.

We aim to conduct a detailed quantitative analysis of the assessment of the degree of injury caused to the human body using the materials of the last 5 years of the National Health Service, and to compare the quantitative indicators of the analysis of the degree of injury caused to the human body in the city of Ulaanbaatar and the National Health Service of the provinces.

Keywords: Injury to the human body, degree of injury, statistics.

Судалгааны зорилго: ШШҮХ-ийн сүүлийн 5 жилийн материалаар хүний биед учирсан гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний өсөлт, бууралт, нас, хүйсийн байдал, гэмтэл үүсгэсэн шалтгаан, төрөл болон гэмтлийн зэргийг тогтоосон тоон үзүүлэлт, ШЭШГ ба аймгуудын ШША-ны гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний тоон үзүүлэлтийг харьцуулан судлахад оршино.

Судалгааны зорилт:

1.ШШҮХ-нд хийгдэж буй шинжилгээнд шүүх эмнэлгийн шинжилгээний эзлэх хувь, ШЭШГ ба аймгийн албадад хийгдсэн хүний биед учирсан гэмтлийн

зэргийг тогтоох шинжилгээний тоон үзүүлэлт, хувь хэмжээ, өсөлт, бууралтыг судлах

2.ШЭШГ-т хийгдсэн хүний биед учирсан гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг нас, хүйсийн байдлаар судлах

3.ШЭШГ-т хийгдсэн хүний биед учирсан гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг гэмтэл үүсгэсэн шалтгаан, төрлөөр нь судлах

4.ШЭШГ-т болон аймгуудын ШША-нд хийгдсэн хүний биед учирсан гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг гэмтлийн зэрэг тогтоосон байдлаар нь харьцуулан судлах

5.Сүүлийн 5 жилийн хугацаанд Улаанбаатар хотод гарсан Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн тоон үзүүлэлтийг нийслэлийн 9 дүүргийн цагдаагийн газар, хэлтсээр нь харьцуулан судлах

Судалгааны арга зүй:


Улаанбаатар хотод болон аймгуудын шүүхийн шинжилгээний албадад хийгдсэн шүүх эмнэлгийн гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний сүүлийн 5 жилийн материалд судалгаа хийж, судалгааны зорилтын дагуу тоон үзүүлэлтийг гарган, статистик боловсруулалт хийж, график байгуулав.

Хүснэгт №1 ШШҮХ-д сүүлийн 5 жилд хийгдсэн шинжилгээний тоон үзүүлэлт

Он Үзүүлэлт	2017		2018		2019		2020		2021		Нийт
	тоо	хувь	тоо	хувь	Тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	
ШШЕГ-д хийсэн нийт шинжилгээ	65525		69119		69710		64369		58424		327147
Шүүх эмнэлгийн нийт шинжилгээ	38090	58.1	39779	57.6	40155	57.6	36974	57.4	33631	57.6	188629 (57.7%)
ШЭШГ-т хийсэн нийт шинжилгээ	21415	56.2	22124	55.6	22572	56.2	20393	55.2	19047	56.6	105551 (56%)
Гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ	15388	71.9	14627	66.1	14617	64.8	13532	66.3	11927	62.6	70091 (66.4%)

Аймгуудын ШША-нд хийсэн нийт шинжилгээ	16675	43.8	17655	44.4	17583	43.8	16581	44.8	14584	43.4	83078 (44%)
Гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ	12546	75.2	12866	72.9	12521	71.2	12387	74.7	11022	75.6	61342 (73.8 %)


График №1. ШШҮХ-д сүүлийн 5 жилд хийгдсэн шинжилгээний тоон үзүүлэлтийг графикаар дүрсэлбэл:



Дээрх хүснэгт №1, график №1-ээс харахад сүүлийн 5 жилд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд нийт 327147 шинжилгээ хийгдсэнээс 57.7% нь Шүүх эмнэлгийн шинжилгээ байна. Шүүх эмнэлгийн нийт шинжилгээний 56% нь Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт, 44% нь аймгуудын шүүхийн шинжилгээний албадуудад хийгджээ. Мөн 2017 онд хийгдсэн шинжилгээний тоог харьцуулан судлахад 2021 онд ШШҮХ-нд хийгдсэн шинжилгээний тоо болон ШЭШГ, аймгийн ШША-дын шинжилгээний тоо аль аль нь буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт №2. Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт хийгдсэн гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг насны ангилал, хүйсээр нь авч үзвэл:


Он Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	Нийт
Эрэгтэй	9017	8805	8804	8055	7481	42162
Эмэгтэй	6371	5822	5813	5477	4446	27929
Нийт	15388	14627	14617	13532	11927	70091



Он Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	Нийт
0-1 нас	0	68	12	21	13	114
1-4 нас	268	201	203	220	136	1028
5-9 нас	417	366	464	335	237	1819
10-14 нас	493	505	591	478	383	2450
15-19 нас	1089	1004	1048	957	896	4994
20-24 нас	2006	1865	1859	1620	1523	8873
25-29 нас	2937	2687	2253	2018	1675	11570
30-34 нас	2465	2470	2345	2325	2081	11686

35-39 нас	1693	1637	1857	1651	1572	8410
40-44 нас	1370	1245	1288	1250	1110	6263
45-49 нас	931	882	935	919	822	4489
50-54 нас	733	669	713	727	583	3425
55-59 нас	481	480	529	494	433	2417
60-64 нас	247	272	265	279	274	1337
65-аас дээш	258	276	255	238	189	1216
Бүгд	15388	14627	14617	13532	11927	70091

График №2. Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт хийгдсэн гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг насны ангиллаар графикт дүрсэлбэл:




Бид сүүлийн 5 жилд Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт хийгдсэн хүний биед учирсан гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний тоон үзүүлэлтийг судлахад нийт 70091 хүнд шинжилгээ хийсэн байх ба 60.1% нь эрэгтэйчүүдэд, 39.9% нь эмэгтэйчүүдэд хийгджээ. Насны хувьд 25-29 ба 30-34 насны хүмүүс хамгийн өндөр буюу 16.5% ба 16.7%-ийг эзэлж байна

Хүснэгт №3. Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт хийгдсэн гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг төрлөөр нь авч үзвэл

Он/ Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	Нийт
Мохоо зүйлийн үйлчлэл	10661	10134	9409	7685	6858	44747
Хурц ир үзүүртэй зүйлийн үйлчлэл	295	347	312	355	486	1795
Зам тээврийн осол	3588	2875	3671	3076	2324	15534
Бусад шалтгаан	844	1271	1225	2416	2259	8015
Бүгд	15388	14627	14617	13532	11927	70091

График №3. Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт хийгдсэн гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг төрлөөр нь графикаар дүрсэлбэл:




Гэмтлийн зэрэг тогтоосон шинжилгээг гэмтэл үүсгэсэн хүчин зүйл, төрлөөр нь судлахад мохоо зүйлийн үйлчлэлээр үүссэн гэмтэл дийлэнх буюу 63.8 хувийг эзэлж байна.

Хүснэгт №4. Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт хийгдсэн гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг зэргээр нь авч үзвэл

Үзүүлэлт \ Он	2017	2018	2019	2020	2021	Нийт
Хүнд зэрэг	836	762	768	681	599	3646
Хүндэвтэр зэрэг	1425	1509	1515	1401	1093	6943
Хөнгөн зэрэг	9380	8330	7822	7168	6313	39013
Гэмтлийн зэрэгт хамаарахгүй	1920	2092	2770	2612	2659	12053
Гэмтэлгүй	1827	1934	1742	1670	1263	8436
Бүгд	15388	14627	14617	13532	11927	70091

График №4. Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт хийгдсэн гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг зэргээр нь графикт дүрсэлбэл:




Дээрх хүснэгтийн тоон үзүүлэлтээс харахад Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт хийгдсэн гэмтлийн зэрэг тогтоосон 70091 шинжилгээг гэмтлийн зэрэг тогтоосон байдлаар нь авч үзвэл хамгийн өндөр буюу 55.7% нь Хөнгөн зэргийн гэмтэл, 9.9% нь хүндэвтэр зэргийн гэмтэл, 5.2% нь хүнд зэргийн гэмтэл гэж тогтоогдсон бол 29.2% нь гэмтлийн зэрэгт хамаарахгүй гэмтэл ба гэмтэл тогтоогдохгүй байна гэсэн дүгнэлт гарсан байна.

Хүснэгт №5. Аймгуудын ШША-нд хийгдсэн гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг зэргээр нь авч үзвэл:


Он Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	Нийт
Хүнд зэрэг	566	545	583	519	438	2651
Хүндэвтэр зэрэг	939	927	872	828	659	4225
Хөнгөн зэрэг	5668	5163	4695	4512	4177	24215
Гэмтлийн зэрэгт хамаарахгүй	2884	3411	3588	3604	3146	16633
Гэмтэлгүй	2489	2820	2783	2924	2602	13618
Бүгд	12546	12866	12521	12387	11022	61342

График №5. Аймгуудын ШША-нд хийгдсэн гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг зэргээр нь графикт дүрсэлбэл:



Графикаас харахад Аймгуудын шүүхийн шинжилгээний албатуудад хийгдсэн гэмтлийн зэрэг тогтоосон 61342 шинжилгээг гэмтлийн зэрэг тогтоосон байдлаар авч үзвэл хамгийн өндөр буюу 39.8% нь Хөнгөн зэргийн гэмтэл, 6.9% нь хүндэвтэр зэргийн гэмтэл, 4.3% нь хүнд зэргийн гэмтэл гэж тогтоогдсон бол 49% нь гэмтлийн зэрэгт хамаарахгүй гэмтэл ба гэмтэл тогтоогдохгүй байна гэсэн дүгнэлт гарчээ.

График №6. Улаанбаатар хотод гарсан Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтийг нийслэлийн 9 дүүргийн цагдаагийн газар, хэлтсээр нь графикаар дүрсэлбэл:



Графикт үзүүлснээр сүүлийн 5 жилийн хугацаанд Улаанбаатар хотод гарсан Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтийг нийслэлийн 9 дүүргийн цагдаагийн газар, хэлтсээр нь судалж үзэхэд Баянзүрх дүүргийн болон Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газрууд өндөр үзүүлэлттэй байна.

Дүгнэлт

1. ШШҮХ-ийн шинжилгээний сүүлийн 5 жилийн материалыг судлахад Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн болон Шүүх эмнэлгийн шинжилгээний газар, 21 аймгийн шүүхийн шинжилгээний албадад хийгдсэн нийт шинжилгээ, хүний биед учирсан гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний тоог 2017 оныхтой харьцуулахад 2021 онд буурсан үзүүлэлттэй байна.
2. Сүүлийн 5 жилд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд нийт 327147 шинжилгээ хийгдсэн байна. Үүнээс 188629 шинжилгээ буюу 57.7% нь Шүүх эмнэлгийн шинжилгээ байгаа нь хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн гаралт их байгаатай холбоотой гэж үзлээ. Мөн тухайн шинжилгээний 56% нь Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт, 44% нь аймгуудын шүүхийн шинжилгээний албатуудад хийгдсэн байгааг харахад Улаанбаатар хотод хүн амын тоо, төвлөрөл ихтэй байгаагаас гэмт хэргийн гаралт их байгааг илтгэж байна.
3. Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт хийгдсэн хүний биед учирсан гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний тоон үзүүлэлтийг харьцуулан судлахад

нийт шинжилгээнд хамрагдагсдын 60.1%-ийг эрэгтэйчүүд эзэлж байна. Насны хувьд 30-34 насныхан 16.7%, 25-29 насныхан 16.5%-тай байгаа нь хамгийн өндөр үзүүлэлттэй гарчээ. Шинжилгээнд хамрагдагсдын дийлэнх нь эрэгтэйчүүд ба 25-34 насныхан байгаа нь залуучуудын дунд архидалт, ажилгүйдэл, нийгмийн бухимдал их байгаагаас үүдэлтэй гэж үзэж байна.

4. Шинжилгээнд хамрагдагсдын гэмтлийн шалтгаан, гэмтээгч хүчин зүйл, төрлийг авч үзвэл мохоо зүйлийн үйлчлэлээр гэмтсэн тохиолдол 63.8%, зам тээврийн ослын улмаас гэмтсэн тохиолдол 22.2%-ийн эзэлж байна.

5. Шүүх эмнэлгийн шинжилгээний газар болон аймгуудын шүүхийн шинжилгээний албадад хийгдсэн гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг харьцуулан судлахад ШЭШГ-т нийт шинжилгээний 56%, аймгуудын ШША-нд 73.8%-д нь гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ хийжээ. Эндээс дүгнэхэд хөдөө орон нутагт архидалт, ажилгүйдэлтэй холбоотой хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн гаралт их байна гэж үзлээ. Гэмтлийн зэрэг тогтоосон байдлаар нь авч үзвэл гэмтлийн Хөнгөн зэрэг тогтоосон шинжилгээ Улаанбаатар хот болон аймгуудад өндөр хувьтай /55.7%, 39.8%/ байх ба ШЭШГ-т 29.2% нь, аймгийн ШША-дад 49% нь гэмтлийн зэрэгт хамаарахгүй гэмтэл болон гэмтэл тогтоогдоогүй гэсэн дүгнэлт гарсан байна.

6. Сүүлийн 5 жилийн хугацаанд Улаанбаатар хотод гарсан Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтийг нийслэлийн 9 дүүргийн цагдаагийн газар, хэлтсээр нь судалж үзэхэд Баянзүрх дүүргийн цагдаагийн газарт 11907 хэрэг буюу 24.7%-ийг, Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газарт 8903 хэрэг буюу 18.5%-ийг эзэлж байгаа нь хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа ба тус дүүргүүдэд хүн амын тоо их, гэмт хэргийн гаралт буурахгүй байгаа нь харагдаж байна.

---o0o---

КРИМИНАЛИСТИКИЙН БЭХЖҮҮЛЭХ ГЭРЭЛ ЗУРГИЙН ОНОЛ, ЭРХ ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ

FORENSIC PHOTOGRAPHY THEORY AND SOME LEGAL PROBLEMS



Б.Хонгор
Дотоод хэргийн их сургууль,
Шинжлэн магадлахуйн институт,
Шинжлэн магадлахуйн магистрант,
цагдаагийн ахлах дэслэгч

Товч утга: Криминалистикийн бэхжүүлэх гэрэл зургийн онол, эрх зүй зарим асуудлыг хөндөж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заагдсан ажиллагаа нь өнөөгийн бэхжүүлэх гэрэл зургийн арга, арга барил, төрөлтэй тохирч байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно.

Түлхүүр үгс: Криминалистик, гэрэл зураг, бэхжүүлэх гэрэл зураг, арга, арга зүй, арга барил.

Abstract: The theory and jurisprudence of forensic enhancement photography aims to determine whether the procedure prescribed in the Criminal Procedure Law is compatible with the current methods, methods and types of enhancement photography.

Keywords: Forensics, photography, strengthening photography, methods, techniques.

Шүүхийн шинжилгээний байгууллагад ажиллаж буй шинжээч мэргэжилтний үндсэн үйл ажиллагааны нэг бол гэмт хэргийн дуудлагад явж хэргийн газрын үзлэг хийж ул мөр, эд мөрийн баримт илрүүлэх, бэхжүүлэх, битүүмжлэх, орчны байдлыг гэрэл зургаар бэхжүүлэх, дүрс бичлэг хийх үүрэгтэй юм. Дээрх үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд Монгол улсад одоогийн байдлаар тогтсон стандарт байхгүй байгаа юм. Жишээлбэл зургийн хэмжээг хэд хэдийн харьцаатай хэвлэх, тэмдэглэгээ, тайлбарыг хэрхэн бичих, тэмдгийг хаана нь дарах, хэдэн удаа дарах, ямар нягтралтай хэвлэх, ямар хэвлэх төхөөрөмж ашиглаж хэвлэх, ямар зургийн цаасанд хэвлэх, хэвлэмэл хуудасны үсгийн хэмжээ зэрэг нь ямар ч стандартад орсон зүйл байхгүй байгаа нь шинжээч, мэргэжилтний эрх зүйн байдалд эрсдэлтэй байгаа юм. Тиймээс шинжээч өөрийн ажилласан хэргийн газар, мөрдөн шалгах ажиллагааны үеийн гэрэл зургийн үзүүлэлтийг батлагдсан стандарт, арга зүйн дагуу хийх нь нэн тэргүүний асуудал тул дээрх

сэдвийг сонгосон үндэслэл болов. Гэрэл зургийг анх 1839 онд Францын эрдэмтэн Ж.Ньепс, Л.Ж.Дагер нар нээж байжээ. Германы эрдэмтэн Э.Стенгер гэрэл зураг анх бий болсон өдрөөс эхлэн хэрэг шүүх ажиллагаанд ашиглагдаж эхэлсэн гэж нотолдог. Орост 1867 онд, Англид 1870 онд гэмт хэрэгтнүүдийн гэрэл зургийн цуглуулгатай болсон байна. 1859 оноос гэрэл зургийг хэргийн газрын үзлэгт ашиглаж эхэлсэн бол Монгол улсад 1928 оноос гэрэл зургийг гэмт хэрэгтэй тэмцэхэд ашиглаж эхэлсэн байна.

Криминалистик нь гэмт хэргийн бүтцийн зүй тогтол, гэмт хэрэг ба түүнд оролцогчдын тухай мэдээлэл бий болох зүй тогтол түүнчлэн нотлох баримт цуглуулах, шинжлэх, үнэлэх, ашиглах зүй тогтлууд тэдгээрийн танин мэдэхүйн дор суурилсан гэмт хэрэг илрүүлэх, мөрдөх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэрэгслийн тухай шинжлэх ухаан мөн хэмээн тодорхойлжээ[162].

Монголын криминалистикийн байгууллагын хөгжлийн цаг хугацааны үе шатыг ажиглахад:

1928 онд Гэрэл зургийн лаборатори;

1944 онд УЦСГ-ын гүйцэтгэх хэлтэст шинжлэн магадлах техникийн IY тасаг;

1949 онд УЦСГ-ын Онцгой хэлтсийн гарын хээ судлалын тасаг;

1950 онд ДЯЯ-ны Онцгой хэлтсийн дэргэдэх Төвлөрсөн дактилоскопийн тасаг;

1956 онд УЦСГ-ын Шинжлэх ухаан техникийн тусгай тасаг;

1962 онд УЦСЕГ-ын криминалистикийн хэлтэс /ШУТ хэлтэс/;

1988 онд УЦСЕГ-ын криминалистикийн шинжилгээний төв;

Одоо үед Монголын криминалистикийн байгууллага нь гэмт хэргийг мөрдөн байцаах практикт криминалистикийн арга хэрэгслийг нэвтрүүлэхэд ихээхэн роль гүйцэтгэж яруу алдарт замыг туулж байна[163].

Криминалистикийн гэрэл зураг гэдэг нь гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, гэмт хэрэгтнийг эрэн сурвалжлах, илчлэх зорилгоор нотлох баримт цуглуулах, шинжлэх үед ашиглах гэрэл зургийн хэрэгсэл, арга, арга барил, түүний үндэс болсон шинжлэх ухааны мөрдлөг боловсруулах криминалистикийн техникийн хэсэг юм[164].

Гэрэл зураг үүсэж хөгжиж гэмт хэрэгтэй тэмцэх, түүнийг илрүүлэх, нотлох ажиллагааны нэг үндсэн шалгуур болж байгаа юм. Техник технологи хөгжиж буйтай холбоотой шүүх гэрэл зургийн арга зүйг боловсронгуй болгох шаардлага нийгмээ дагаад тулгарч байгаа юм. Тиймээс дараагийн дэд бүлэгт бэхжүүлэх гэрэл

---

[162] Ж.Хурцгэрэл – Криминалистик 1. УБ. 2002.

[163] С.Бадарчи - Хууль хамгаалах байгууллагуудын практикт криминалистикийн арга хэрэгслэл нэвтэрсэн нь. 2017. УБ.

[164] Ж.Хурцгэрэл – Криминалистик 1. УБ. 2002 он.

зургийн эрх зүйн асуудлыг хөндөхөөр болсон.

Криминалистикийн гэрэл зургийн тухай ойлголт

Криминалистикийн гэрэл зураг гэдэг нь гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, гэмт хэрэгтнийг эрэн сурвалжлах, илчлэх зорилгоор нотлох баримт цуглуулах, шинжлэх үед ашиглах гэрэл зургийн хэрэгсэл, арга, арга барил, түүний үндэс болсон шинжлэх ухааны мөрдлөг боловсруулах криминалистикийн техникийн хэсэг юм[165].

Гэрэл зургийн **объект** нь гэмт хэрэг илрүүлэх, мөрдөх үед зайлшгүй зургийг нь авах шаардлагатай болсон аливаа материаллаг юмс, тэдгээрийн хэсэг, эсвэл нийлбэр цогц байна. Жишээлбэл: Хэргийн газрын орчин, түүний хэсэг, мөр, биет баримт, хүн байж болно.

Гэрэл зургийн хэрэгсэл нь гэрэл зураг авах, хэвлэх төхөөрөмж болох фотоаппарат, дагалдах хэрэгсэл, лабораторийн төхөөрөмж, гэрэл зургийн хэрэглэгдэхүүн фотохальс, ялтас, фотоцаас, химийн уусмал.

Криминалистикийн гэрэл зургийн субьект, чиглэл:

- Эрэн сурвалжлах гэрэл зураг;
- Шүүх-хэрэг бүртгэлт - мөрдөн байцаалтын гэрэл зураг;
- Криминалистикийн шинжилгээний гэрэл зураг;

Криминалистикийн гэрэл зургийн зорилго:

- Бэхжүүлэх гэрэл зураг;
- Шинжлэх гэрэл зураг;

Бэхжүүлэх гэрэл зураг:

- Байцаан шийтгэх ба эрэн сурвалжлах ажиллагааны явц, үр дүнг гэрэл зургаар бэхжүүлэхийн тулд ашиглах арга, арга барил, хэрэгсэл, түүний үндэс болсон шинжлэх ухааны мөрдлөгийн тогтолцоо.
- Бэхжүүлэх гэрэл зургаар хүний нүдэнд ил тодорхой харагдах объектыг дүрсэлдэг.

Бэхжүүлэх гэрэл зургийн арга:

- Дэлгэмэл гэрэл зураг. /тойргийн, шугаман/
- Хэмжихүйн гэрэл зураг. /шугаман, гүний, квадрат дүрст/
- Стерео гэрэл зураг. /эзлэхүүнтэй, гурван хэмжээст дүрст/
- Хуулбарлах гэрэл зураг. /төхөөрөмж ашиглах, фото цаас ашиглах/
- Макро гэрэл зураг. /өсгөлттэй, цагаригийн тусламжтай/
- Таних гэрэл зураг. /хүн, цогцос, эд зүйл/
- Микро гэрэл зураг. /бянт, цохигчийн мөр/

[165] Ж.Хурцгэрэл – Криминалистик 1. УБ. 2002 он.

Бэхжүүлэх гэрэл зургийн төрөл:

- Хэргийн газрын.
- Нэгжлэгийн үеийн.
- Туршилтын үеийн.
- Гэмт хэрэгтний.
- Цогцосны.
- Бичиг баримтын.
- Мөр биет баримтын.

Доктор (Ph.D.), профессор Б.Бат-Эрдэнэ багшийн криминалистик (лекцүүд) 2017 оны номдоо дээрх байдлаар томьёолж, бүлэглэж бичсэн байдаг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.3 дугаар зүйлд шаардлагатай тохиолдолд мөрдөн шалгах ажиллагааны явцад, эсхүл шүүх хуралдаанд ул мөр, эд мөрийн баримт илрүүлэх, бэхжүүлэх, хамгаалах, техник хэрэгсэл, төхөөрөмж ашиглах, ажиллуулахад дэмжлэг үзүүлэх, хүний амь нас, эрүүл мэндэд аюул, эсхүл орчинд хөнөөл учруулж болзошгүй тэсэрч дэлбэрэх, химийн хортой бодис, бусад эд зүйл байвал тэдгээрийг аюулгүй болгох, зөвлөгөө авах зорилгоор тухайн хэрэгт хувийн сонирхолгүй тусгай мэдлэг, туршлага бүхий хүнийг шүүх, прокурор, мөрдөгчийн шийдвэрээр мэргэжилтнээр оролцуулж болно гэж заасан байдаг тул шүүх шинжилгээний байгууллагын алба хаагч мөрдөн шалгах ажиллагаанд оролцож ул мөр, эд мөрийн баримт илрүүлж, бэхжүүлж, битүүмжилж, мөрдөгчид хүлээлгэн өгч ажилладаг.

Тэгвэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд дараах байдлаар мөрдөн шалгах ажиллагааг төрөлжүүлсэн байдаг байна.

ЭХХШТХ-ийн 23 дугаар бүлэг. Үзлэг, мөрдөн шалгах туршилт.

- 23.1 дүгээр зүйл. Үзлэг хийх;
- 23.2 дугаар зүйл. Хүний биед үзлэг хийх;
- 23.3 дугаар зүйл. Хэргийн газрын үзлэг;
- 23.4 дүгээр зүйл. Цогцост үзлэг хийх;
- 23.5 дугаар зүйл. Мөрдөн шалгах туршилт хийх;

ЭХХШТХ-ийн 24 дүгээр бүлэг. Нэгжлэг хийх, хураан авах.

- 24.1 дүгээр зүйл. Нэгжлэг хийх;
- 24.2 дугаар зүйл. Хүний биед нэгжлэг хийх;
- 24.3 дугаар зүйл. Орон байр, бусад газарт нэгжлэг хийх;
- 24.4 дүгээр зүйл. Эд мөрийн баримт хураан авах;

ЭХХШТХ-ийн 25 дугаар бүлэг. Мэдүүлэг авах, нүүрэлдүүлж мэдүүлэг авах, мэдүүлгийг шалгах, таньж олуулах.

- 25.6 дугаар зүйл. Мэдүүлгийг газар дээр нь шалгах;
- 25.7 дугаар зүйл. Таньж олуулах;

Криминалистикийн бэхжүүлэх гэрэл зураг нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг арга зүй учир дээрх хуультай төрөл, агуулгатай таарч байх шаардлагатай юм.

Өнөөгийн криминалистикийн бэхжүүлэх гэрэл зургийн арга, арга зүй, төрөл нь стандартчилагдаагүй, хууль, эрх зүйгээр зохицуулагдаагүй, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай таарахгүй байгаа нь шинжилгээний байгууллагын алба хаагчдын эрх зүйн байдалд эрсдэлтэй байгаа юм.

Мөн гэмт хэргийг илрүүлэх, шийдвэрлэхэд ач холбогдол бүхий хэргийн газрын, мөрдөн шалгах ажиллагааны гэрэл зургийг хэн ч харсан ойлгомжтой байдлаар хийх, зургийн хэмжээг олон улсын стандартын дагуу тогтоож стандартчилах, тайлбар, тэмдэглэгээг зөв оновчтой хийх нь хэргийг илрүүлэх болон шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой юм. Тиймээс криминалистикийн бэхжүүлэх гэрэл зургийн үзүүлэлт үйлдэх арга зүйг боловсронгуй болгох стандартчилах нь нийгмээ дагаад зайлшгүй хэрэгцээтэй зүйл болж байгаа юм. Мөн “Шүүх шинжилгээ-эрх зүй” мэргэжлийн хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутнууд суралцах хугацаандаа хэргийн газрын үзлэгийн гэрэл зураг, мөрдөн шалгах ажиллагааны гэрэл зургийг хэрхэн авах, гэрэл зургийн үзүүлэлтийг хэрхэн үйлдэх ойлголт бага байдаг тул тэдэнд гарын авлага болгох мөн хэргийн газрын үзлэгийн гэрэл зургийн үзүүлэлт үйлдэх арга зүйг боловсронгуй болгоогүй орон нутгийн Шүүхийн шинжилгээний алба тус бүр өөрсдийн хэвшсэн гэрэл зургийн үзүүлэлт үйлдэх арга зүйтэй байгаа тул бэхжүүлэх гэрэл зургийн төрлийг дараах байдлаар ангилах нь зүйтэй гэж үзэж байна. Иймд доорх ангиллын дагуу цааш нь судалж, стандартчилах шаардлагатай байна.

Бэхжүүлэх гэрэл зургийн төрөл

1. Үзлэг, туршилтын

1.1. Хүний биед үзлэг хийх;
1.2. Хэргийн газрын үзлэг;
1.3. Цогцост үзлэг хийх;
1.4. Мөрдөн шалгах туршилт хийх;
1.5. Эд зүйлд үзлэг хийх;
1.6. Баримт бичигт үзлэг хийх;
1.7. Тээврийн хэрэгсэлд үзлэг хийх;
1.8. Ачаа тээшинд үзлэг хийх;
1.9. Мал, амьтанд үзлэг хийх;

2. Нэгжлэг хийх, хураан авах

2.1. Хүний биед нэгжлэг хийх;
2.2. Орон байр, бусад газарт нэгжлэг хийх;
2.3. Эд мөрийн баримт хураан авах;

3. Мэдүүлгийг шалгах, таньж олуулах

3.1. Мэдүүлгийг газар дээр нь шалгах ажиллагааны;

3.2. Таньж олуулах ажиллагааны;

Бэхжүүлэх гэрэл зургийн арга барил

- Баримжаалах. /астрофото, аэрофото, кримфото/
- Тоймлох.
- Зангилаа.
- Нэг бүрчилсэн. /макро/
- Нарийвчилсан. /микро/

Бэхжүүлэх гэрэл зургийн нарийвчилсан арга барил нь мөр, биет баримтын онцлог хэсэг, шинж тэмдгийг судлах зорилгоор томруулж, эсвэл өндөр өсгөлттэйгөөр дүрсэлсэн микро гэрэл зураг гэж тодорхойлсон байдаг бөгөөд дээрх тодорхойлолтод байх “микро” гэх нэр томьёо нь өнөөгийн бэхжүүлэх гэрэл зургийн арга, төрөл, арга барилд багтаагүй нэр томьёо байх тул “Бэхжүүлэх гэрэл зургийн арга”-д шинээр оруулах шаардлагатай байна.

Дүгнэлт

Судалгааны ажлын зорилго, зорилтын хүрээнд бэхжүүлэх гэрэл зургийн онол, эрх зүйн талаар нэгдсэн ойлголттой болов. Гэрэл зураг үүсэж хөгжиж эхэлсэн үеэс эхэлж түүнийг гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаанд ашиглаж ирсэн байдаг байна. даяаршиж буй нийгэмд нийгмийн хөгжлөө дагаад шинэ төрлийн гэмт хэрэг гарч байгаа нь криминалистикийн гэрэл зургийн онолын үндэс арга зүйг боловсронгуй болгох асуудал тулагч байгаа юм.

Шинжилгээний байгууллагын шинжээч шинжилгээ хийхдээ тогтсон стандарт арга зүй байхгүй, гэрэл зургийн үзүүлэлт үйлдэх тодорхойгүй нь түүний ажлын хүндрэлтэй мөн эрсдэлтэй болгож байгаа юм.

Шинжилгээний байгууллагын мөрдөн шалгах ажиллагааны үеийн тодорхой төрлийн гэрэл зургийн үзүүлэлтэд судалгаа хийж үзэхэд зургийн төрөл, арга, арга зүй, тодрол, хэмжээ, дэс дараалал, тэмдэг тэмдэглэгээ, талбайн ашиглалт, зургийн тоо дутсан, стандарт байхгүй, албан хэрэг хөдлөлтийн стандартын дагуу хийгдээгүй зэрэг алдаатай зүйлүүд байв. Тиймээс энэ алдааг гаргахгүй болон шинжээчийн эрх зүйн байдлыг баталгаатай болгохын тулд бэхжүүлэх гэрэл зургийн арга, арга зүй, төрлийг стандартад оруулах нь зайлшгүй шаардлагатай байгаа юм.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

- С.Бадарчи – Хууль хамгаалах байгууллагуудын практикт криминалистикийн арга хэрэгсэл нэвтэрсэн нь. 2017. УБ.
- Ж.Хурцгэрэл – Криминалистик 1. УБ. 2002.
- Б.Бат-Эрдэнэ – Криминалистик. УБ. 2017.
- Б.Жаргалсайхан – Учралын газрын үзлэг. УБ. 2018.

- Т.Очирбат – Диссертаци. УБ. 2019.
- Б.Лхагвасүрэн – Мөр. УБ. 2015.
- Я.Цэвэл – Монгол хэлний товч тайлбар толь. УБ. 1996.
- Т.В.Аверанова, Р.С.Белкин, Ю.Г.Корухов, Е.Р.Россинская – Криминалистик. 2002.
- Г.Мөнхбат, М.Энхбаяр, Г.Дагиймаа – Хагас зууны хөгжлийн түүх. 2010.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН АКТ:

- Эрүүгийн хууль
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
- Шүүх Шинжилгээний тухай хууль

---o0o---

ЦАХИМ СУРГАЛТЫГ ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ХЭЛБЭР, АРГА ЗҮЙД НИЙЦҮҮЛЭХ НЬ

ELECTRONIC LEARNING IN UNIVERSITIES AND UNIVERSITIES, COMPLIANCE WITH METHODOLOGY



Ч.Чулуунхүү
Дотоод хэргийн их сургуулийн
Хилийн албаны сургуулийн
Хилийн албаны тэнхимийн дэд профессор, дэд хурандаа,

Товч утга: Мэдээллийн технологийн эрчимтэй хөгжлийн эрин үед нийгмийн аль ч салбарт түүний хэрэглээг нэвтрүүлэх нь чухал болж байна. Ялангуяа сургалтын байгууллагуудад мэдээллийн технологийн дэвшлийн үр дүнг ашиглах нь нэн түрүүнд тавигдаж байгаа шаардлага болоод байна.

Энэхүү судалгааны ажлаар дээд боловсролын сургалтын байгууллагад мэдээллийн технологи ашиглахад анхаарах зүйлсийг илрүүлэх, сургалтын онцлогт тохируулахад анхаарал хандуулсан болно.

Түлхүүр үгс: Э-сургалт, зайн сургалт, дээд боловсрол, мэдээллийн технологи.

Abstract: In the era of rapid development of information technology, it is becoming important to introduce its use in any sphere of society. Especially in educational institutions, the use of the results of the advancement of information technology has become a priority.

In this research work, attention is paid to identifying the points to be considered in the use of information technology in higher education educational institutions and adjusting them to the characteristics of training.

Keywords: E-learning, distance learning, higher education, information technology.

Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээр сургалтын технологийн хөгжил уламжлалт хэлбэрээсээ шинэлэг хэлбэрт шилжих олон оролдлого хийсэн билээ. Тухайлбал, “багш төвтэй сургалт”- аас “шавь төвтэй сургалт”, “мэдлэг

төвтэй сургалт” гэх мэт олон арга зүй, технологи турших, хэрэгжүүлэх ажлыг өрнүүлж ирсэн. Үүнээс гадна шинэ эринд мэдээллийн технологид тулгуурласан э-сургалт /цахим сургалт, онлайн сургалт, зайн сургалт, и-сургалт, е-сургалт гэх мэт/- ын хувилбар гарч ирээд байна. Уламжлалт сургалт маань яагаад “болохгүй” болов? Яагаад заавал сургалтын шинэ технологи хэрэгтэй болов? гэдэг олон асуулт гарч болох юм.

Цахим сургалтын онолоос

“Надад хэлбэл би мартана. Надад харуулбал би тогтооно, Надаар хийлгэвэл би ойлгоно ”Күнзийн сургаалиас.

Өнөө үед Мэдээлэл Холбооны Технологийг (МХТ) багшлах үйл ажиллагаандаа хэрэглэх, хичээлийн агуулгад интеграцчлах асуудал багш бүрийн өмнө тавигдаж байна.

Цахим сургалтыг хэрэгжүүлэхэд МХТ-ийг сургалтад ашиглах зайлшгүй шаардлагатай бөгөөд МХТ-ийг ашиглах сургалтын дидактик боловсруулах нь чухал юм.

Өнөөдөр Монгол Улсад дээд боловсрол эзэмшихээр суралцаж байгаа хүмүүсийн хувийн жин харьцангуй өндөр байгаа хэдий ч олон улсын хэмжээнд нийтлэг ажиглагдаж буй хамралтын түвшин, түүнд гарч буй өсөлттэй үндсэндээ адил шинж төрхтэй байна. Ялангуяа иргэдийн боловсрол эзэмших хүсэл сонирхол өндөр, эдийн засагт мэдлэгт суурилсан технологи нэвтэрч, хүмүүсийн өдөр тутмын хэрэглээ нэр төрөл, тоо чанар арвижин баяжиж, нийгмийн анги давхаргын хооронд шилжилт, дэвшил хийхэд боловсрол шийдвэрлэх хүчин зүйл болж байгаа нөхцөлд одоо ажиллаж буй сургууль, сурч буй суралцагчийн тоог цөөлөх нь туйлын зорилго хараахан бус юм. Үүний зэрэгцээ захиргааны аргаар хамралтыг хязгаарлах шийдвэр гаргавал үүсгэн байгуулагчдын эсэргүүцэл нэмэгдэх, сурах хүсэл эрмэлзэлтэй хүмүүсийн урсгал хилийн чанад руу зардал өндөртэй, чанар муутай сургууль руу чиглэж, тэдэнд нэмэлт зардал, эрсдэл үүсэх магадлалтай. Иймд сургууль, суралцагчийн тоог цөөрүүлэх тоон үзүүлэлтээр зорилго дэвшүүлэх нь зохимжгүй гэж үзнэ...” гэжээ.

Өнөөдрийн нийгмийн захиалга бол бүхнийг мэддэг хүн биш, чаддаг хүн л хэрэгтэй. Ийм хүн бий болгоход багш хүн төв нь байх учиртай.

Сургалтын олон арга, хэлбэр, технологи байна. Эдгээрийг тус бүрт нь авч үзье.

Технологи гэж юу вэ? Үүнийг эрдэмтэн Д.Ванчигсүрэн “Технологи гэдэг нь сургах урлаг судлал буюу сургах, сурах арга ажилбар, эрэмбэ тогтолцоог тэмдэглэсэн ухагдахуун юм” хэмээн тодорхойлжээ. Харин ОХУ-ын эрдэмтэн Н.Ф. Талызина “Технологи бол нэг талаас ур чадварын шинжлэх ухаан, нөгөө талаас аливаа бүтээгдэхүүнийг янз бүрийн аргаар боловсруулах дамжлага гэж ойлгож

болно” гэсэн бол В.П. Беспалько “Аливаа үйл ажиллагаа нь технологи эсвэл урлаг байх ёстой. Урлаг нь хүний зөн билэг, уран сэтгэмж юм, харин технологи нь шинжлэх ухаанд үндэслэдэг” гэжээ.

Сургалтын технологи гэсэн ойлголт анх шинжлэх ухаан, техник, технологийн ололтыг сургалтад нэвтрүүлэхтэй уялдаж 1950-иад онд АНУ-ын сургалтын онол, практикт гарч ирсэн бөгөөд онолын үндэс нь бихеровизм юм. Үүнийг үндэслэгчид нь Б. Скиннер, С. Пресс, Э. Торндайка нар юм.

ОХУ-ын хувьд Н.Ф. Талызина, М.В. Беспалько, В.Я. Полиповский, П.У. Крейтсберг, З.И. Кальмыкова, Е.Н. Кабанова-Меллер, П.Я. Гальперин, В.М. Полонский нарын эрдэмтэн судлаачид сургалтын технологийн онол, арга зүйн асуудлуудыг судалжээ. Дээрх эрдэмтэн судлаачид сургалтын онол, багшлах ур чадвар, техник зэрэг чиглэлүүдийг арга судлал, онол, заах аргын төвшинд судалсан байна.

Манай орны хувьд сургалтын технологийн шинэчилэлийн онол, арга зүйн асуудлаар 1990-ээд оноос хүчтэй яригдах эхэлсэн байна.

- Сурагч төвтэй сургалтын технологи Сурагч төвтэй сургалт гэсэн ойлголтыг анх Францын нэрт соён гэгээрүүлэгч Жан Жак Руссо 1762 онд хэвлүүлсэн “Эмиль буюу хүмүүжлийн тухай” зохиолдоо хэрэглэсэн бол Ш.Ичинхорлоо, Г.Долингор нар сургалтын энэ хэлбэрийг “Сурагч төвтэй сургалт бол хүүхдийн авъяас, чадавхи, хэрэгцээ, сонирхол, эрх, эрх чөлөө зэргийг эрхэмлэсэн, түүнд чөлөөтэй хөгжих боломжийг олгосон, тэр хэрэгтэй мэдлэг туршлагыг өөрөө амьдрал орчноос олж авдаг сургалтын нэг чиглэл юм” гэж тодорхойлсон байдаг.

Тэгвэл сурагч төвтэй сургалтын технологи гэж юу вэ? Сургалтын онолын үүднээс авч үзвэл, сургалтын технологи нь зорилго, үйл явц, үр дүн гэсэн бүтэцтэй байх бөгөөд түүнийг сургалтын зорилгыг хамгийн бага хугацаанд өндөр үр дүнтэй хэрэгжүүлэх арга зүй гэж товчоор ойлгож болно.

Европын орнуудад сургалтад дэвшигдсэн зорилт, түүнийг хэрэгжүүлэхэд баримтлах зүй тогтол, зарчим, зохион байгуулах хэлбэр, арга, хэрэглэлийг хэрэглэх дэс дарааллыг сургалтын технологи гэж томьёолдог ерөнхий хандлага байна

2. Цахим сургалтын өнөөгийн байдал

Цахим сургалт нь олон улсад, олон янзаар хэрэгжиж байгаа боловч цаад суурь нь нэг л технологи дээр суурилж байна. Тэр нь мэдээллийн технологи буюу Цахим засаглал, Мэдээллийн технологи хэрэгсэл, тэдгээрийг холбох сүлжээний технологиуд юм.

Цахим сургалт нь өөрийн гэсэн давуу болон сул талуудтай.

Давуу талууд:

1. Багш сурагчдын хувийн харьцааны ойлголт байхгүй
2. Суралцагч цагт баригдахгүй мэдлэг олж авах боломж
3. Байршлаас үл хамааран суралцах
4. Сургалтын агуулга хязгааргүй
5. Сургалтын материалуудын шинэчлэл, хүргэлт шуурхай
6. Мэдээллийн технологийн хэрэгслүүд ашиглах боломж
7. Үнэлгээний харьцангуй байдал үгүй болох

Сул талууд:

1. Бодит харилцааны дутмаг байдал
2. Асуух, тодруулах боломж байхгүй /сүүлийн үед форум хэлбэрээр шийдэж байгаа/
3. Мэдээллийн технологийн дэд бүтэц шаардлагатай
4. Суралцагчдын хоорондын холбоо сул
5. Үнэлгээний арга хэрэгсэл явцуу гэх мэтчилэн сул талууд байна.

Дүгнэлт

Дээрх онолын болон практик судалгаанаас нэгтгэн дүгнэж их, дээд сургуулиудын сургалтын технологид оруулах өөрчлөлтийг дараах байдлаар хийх санал оруулж байна.

Дээд боловсролын байгууллагын сургалтад дараах байдал зонхилж байна.

Дадлага	Бие даалт	Лаборатори	Семинар	Лекц	
Шавь төвтэй	Шавь төвтэй	Шавь төвтэй	Сурагч төвтэй	Мэдлэг төвтэй	Хэрэглэх технологи
Удирдамжийн дагуу	Удирдамжийн дагуу	Бүтээлч байдлыг дэмжих	Бүтээлч байдлыг дэмжих	Уламжлал хэлбэрээр голлосон	Арга зүй
Удирдамжийн дагуу	Удирдамжийн дагуу	Лекцийн агуулгыг бататгах хэмжээнд	Лекцийн агуулгыг бататгах хэмжээнд	Гол ойлголтууд	Агуулга
Удирдамжийн дагуу	Удирдамжийн дагуу	Тусгай зориулалтын төхөөрөмжүүд, цахим хэрэгсэл	Проектор, слайд, самбар, үзэг, шохой, заагуур	Проектор, слайд, самбар, үзэг, шохой, заагуур	Хэрэглэгдэхүүн
Дагалдуулан үзүүлэх, дэмжин туслах	Даалгавар өгч чиглүүлэх, шалгах	Дагалдуулан үзүүлэх	Дэмжих, туслах	Голлох	Багшийн оролцоо
Туслан гүйцэтгэх	Бие даан гүйцэтгэх зөвлөгөө авах	Голлох	Голлох	Сонсох, ойлгох, асуух	Сонсогчийн оролцоо

- Ойрын зорилт: Уламжлалт хэлбэрт сургалтын технологийг цахим хэлбэрийн сургалтын зарим хэрэглэгдэхүүнийг ашиглан сайжруулалт хийх.

- Алсын зорилт: Цахим сургалтыг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх.

Санал

Олон улсын болон монголын ихдээд сургуулиудын сургалтад мэдээллийн технологи ашиглаж байгаа байдал нь олон хэлбэртэй байна. Дээрх судалгааны материалуудаас дүгнэхэд манай сургууль мэдээллийн технологийн дэд бүтэц, хэрэглэдэг программ хангамж нь виртуаль лаборатори явуулах боломжоор хараахан хангагдаагүй гэж дүгнэж болох юм.

Сургалтын цахим хэрэглэгдэхүүн бэлтгэх нь ихээхэн цаг, хөдөлмөр шаардсан ажил юм. Өөрөөр хэлбэл цахим хичээл бэлтгэх ажлын 80% нь тухайн мэргэжлийн багшид ноогддог гэсэн судалгаа байдаг. Иймд цахим хичээл болон хэрэглэгдэхүүн бэлтгэхийн тулд ямар арга хэмжээнд авбал зохих дүгнэлтийг доорх байдлаар хийж байна.

Цахим хичээл боловсруулахад:

1. Хичээлийнхээ материалд шинжилгээ хийж, цахим хичээлийн төлөвлөгөө боловсруулах
2. Төлөвлөгөөнийхөө дагуу, материалаа боловсруулах
3. Боловсруулсан хичээлээ туршин, цаашид сайжруулах

2015 онд Хилийн сургуулийн 1, 3 дугаар дамжаануудын сонсогчдын оролцоотойгоор Хилийн заставын тухай ойлголт, улсын хил хамгаалалтыг зохион байгуулах, улсын хил хамгаалалтыг удирдах зэрэг 3 сэдвийн хүрээнд Төв аймгийн Баянчандмань дах сумын Сургалт хамгаалалтын заставт сургалт арга зүйн кино хийсэн билээ. Энэхүү киног хийснийхээ дараагаар танхимын сургалтад өдрийн болон эчнээ дамжаануудад туршилт хийж, дээр дурдсан сэдвээр хичээлийг зохион байгуулан явуулахад хичээлийн ойлгоц маш сайн байсныг онцлон тэмдэглэж хэлье.

Иймд багш бид сургалт арга зүйн киног хичээлийн сэдэв бүрээр хийж, хичээлдээ ашиглаж байвал сургалтын үр дүн дээшлэх нь дамжиггүй юм.

Багш нарын МХТ-ийг ашиглах чадварыг дээшлүүлэхийн тулд:

1. Цахим сургалт явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх
2. Гадны болон дотоодын сургалтад хамруулан суралцуулах
3. Цахим сургалт явуулах орчныг нь бүрдүүлэх
4. МХТ-ийг сургалтдаа ашиглаж байгаа багшийг дэмжин ажиллах, урамшуулах г.м

Багш ямар аргаар е-Хичээл бэлтгэж болох
бэ ?

1. Та өөрийн хамгийн сайн ашигладаг хэрэглээний программыг ашиглах
2. Та шинээр нэмэлт хэрэглээний программ сурах
3. Та зориулалтын е-Хичээл бэлтгэдэг программ хангамж ашиглах
4. Та мэргэшсэн хүнээр хийлгэх

5. “Multimedia studio”-ийн тусламжтай Е-хичээл хийх

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

1. Д. Цэдэвсүрэн. МХХТ-ийг нэвтрүүлж буй өнөөгийн байдал, цаашдийн чиг хандлага. УБ. 2010

2. Ц.Баасандорж. Сургалтын арга: Эрэл, олз УБ 2014 он

3. Ш.Ичинхорлоо. Шавь төвтэй хичээл УБ 2003 он

4. Д.Оюунгэрэл. Сургалт удирдлагын системийг цахим хэрэгслүүдтэй холбож ажиллах хэрэглээний судалгаа. ЭШ өгүүлэл. 2012

5. Л.Чойжооанчиг нар. Багш нарын мэдээлэл харилцааны технологийн боловсролд. Багш нарт зориулсан гарын авлага. БСШУЯ. УБ. 2008

6. Ч.Лодойравсал Бүтээлч монгол хүнийг хэрхэн төлөвшүүлэх вэ УБ 2019

7. “Цахим сургалтын арга зүй, технологи, үнэлгээ цаашдын чиг хандлага” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл УБ 2021

---o0o---

ИДЭВХТЭЙ СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

ACTIVE LEARNING METHODOLOGY



Ч.Чулуунхүү
Дотоод хэргийн их сургуулийн
Хилийн албаны сургуулийн
Хилийн албаны тэнхимийн дэд профессор, дэд хурандаа,

Товч утга: Идэвхтэй сургалтын арга зүйг хэрхэн ашиглаж байгаа талаар судаллаа

Түлхүүр үгс: Идэвхтэй сургалтын арга зүй.

Abstract: Whether in the classroom or in e-learning, engaging students directly in the learning process can help motivate and develop them. Some studies show that active learning methods are effective in improving student persistence and academic success.

Keywords: Active learning methodology

Идэвхтэй болон болон туршлага суулгах сургалт юм. Идэвхтэй сургалтын аргын онцлог нь сэтгэх болон асуудал шийдвэрлэх үйл ажиллагаанд суралцагчдыг шууд татан оролцуулна. Өөрөөр хэлбэл идэвхгүйгээр мэдээлэл дамжуулахгүйгээр суралцагчдад өөрсдөө гар бие оролцох, хэрэгжүүлэх, дүн шинжилгээ хийх, санаагаа хөгжүүлэх үйл ажиллагаанд гардан оролцох боломж олгоно гэсэн үг юм.

Суралцагчдад өөрийн суралцаж байгаа мэргэжлийн дадлага эзэмшүүлэхийн тулд идэвхтэй болон туршлага суулгах сургалтын аргуудыг ашиглах нь үр дүнтэй. /төсөлд суурилсан, туршилтад суурилсан, асуудалд суурилсан арга/ гэх мэт.

Сургалтын идэвхтэй арга болон туршлага суулгах сургалтын аргын харьцуулалт

Сургалтын идэвхтэй арга

-Асуулт, хариулт;
-Багийн хамтын ажиллагаа /хамтарч суралцах арга/;
-Хэлэлцүүлэг, мэтгэлцээн;
-Кейс, судалгаа;

Туршлага суулгах сургалтын арга

-Загварчлах, хэрэгжүүлэх замаар туршлага олгох;

-Төсөлд суурилсан сургалт;

-Дүрд тоглох ба симуляци хийх;

-Бодит байдалтай холбогдож ажиллах;

Туршлага суулгах сургалт

-Идэвхтэй төдийгүй амьд сургалт болно;

-Практиктай шууд холбогдоно;

-Бодит байдал дээр хилчид юу хийдгийг мэднэ.

Идэвхтэй болон туршлагад суурилсан сургалтын арга гэж юуг хэлэх вэ?

Мэдлэгийн тусламжтайгаар ур чадвар олж авах үйл ажиллагаа юм.

-Суралцагчид өөрсдөө гар бие оролцох;

-Алдаанаасаа суралцах;

-Үр дагаврыг тооцоолж, дүн шинжилгээ хийх;

-Зорилгод хүрэх, санаагаа хөгжүүлэх;

-Багаар ажиллах;

Сургалтын идэвхтэй аргууд нь суралцагчдыг бодож сэтгэх болон асуудал шийдэх үйл ажиллагаанд шууд татан оролцуулна. Багш мэдээллийг идэвхгүй байдлаар дамжуулах үед сонсогчдод бага анхаарал хандуулдаг. Харин сонсогчдод санаа бодлоо уралдуулах, түүнийгээ хэрэглэх, түүндээ анализ хийх, үнэлгээ хийх үйл ажиллагаанд илүү их анхаарал хандуулдаг.

Лекцэд суурилсан хичээлүүд дээр суралцагчдыг хооронд нь болон бага бүлгээр хичээлийн агуулгын талаар ярилцуулж санаа бодлыг нь солилцуулах, үндсэн ойлголтын талаар асуулт тавьж хэлэлцүүлэг хийлгэх, тодорхой жишээн дээр үзүүлж харуулах, юу сурч байгаа талаар сонсогчдоос гэдрэг холболтоор асуулга авах зэрэг аргуудаар идэвхтэй сургалтыг явуулна.

Мэргэжлийн практик үйл ажиллагаатай ижил төстэй ажлыг суралцагчдаар хийлгэх (жишээ нь зохион бүтээх төсөл хийх, симуляци хийх, бодит байдалд судалгаа хийх) идэвхтэй сургалтыг туршилт хийж суралцах сургалт гэж үзнэ.

Суралцагчид сонссон зүйлийнхээ талын талаас багыг, сонссон, харсан зүйлийнхээ зөвхөн талыг санадаг. Суралцагчдыг ойлголтын талаар тухайлбал шинэ санааг бодож сэтгүүлэх, нээлттэй хариулт шаардах үед тэд илүү их суралцаад зогсохгүй юуг хэрхэн сурч байгаагаа өөрсдөө танин мэднэ. Танин мэдэхүйн энэ процесс хөтөлбөрийн сургалтын үр дүнд хүрэх гэсэн хүсэл эрмэлзэлийг нэмэгдүүлэхэд, амьдралын турш суралцах дадал зуршлыг бий болгоход тусална. Идэвхтэй сургалтын аргуудын үед багш гол ойлголтуудын хооронд холболт хийхэд нь, мөн энэ мэдлэгийг шинэ нөхцөлд хэрэглэхэд нь зааж туслана.

Дараах онооны шалгууруар энэ стандартын хэрэгжилтийн түвшинг улирал, жил бүр үнэлнэ. Түвшин бүрийн шалгуурыг стандартын тайлбар, үндэслэлд тулгуурлан өөрчилж болно.

Оноо	Шалгуур

5	Идэвхтэй сургалтын аргуудын үр өгөөжид үнэлгээний баг байнга үнэлэлт дүгнэлт хийж тогтмол сайжруулалт хийх зөвлөгөө өгдөг болсон байна.
4	Оюутны сургалтад идэвхтэй сургалтын аргууд хэрхэн нөлөөлснийг баримтаар баталгаажуулсан байна.
3	Хичээлийн төлөвлөгөөний дагуу идэвхтэй сургалтын аргуудыг хэрэгжүүлсэн байна.
2	Сургалтын хөтөлбөрийн дагуу хичээлүүдэд идэвхтэй сургалтын аргуудыг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй болсон байна
1	Идэвхтэй сургалтын талаар мэдлэг ойлголттой болсон байна. Хичээлийн төлөвлөгөөнд идэвхтэй сургалтын аргуудыг туршиж байгаа.
0	Идэвхтэй сургалтын аргуудыг туршиж хэрэглэсэн баталгаа байхгүй.

Гадаадын их дээд сургуулиудад CDIO загварын 8-р стандартыг хэрэгжүүлсэн туршлага

Сонссон	5%	Идэвхгүй
Уншсан	10%	
Харсан	20%	
Харуулсан	30%	
Багаар хэлэлцсэн	50%	Идэвхтэй
Биетээр хийх дасгал	75%	
Бусдыг сургасан	90%	

Хүний танин мэдэхүйн үйл ажиллагаанд хийсэн судалгаагаар хүн сонсон зүйлийнхээ 5%–г, уншсан зүйлийнхээ 10%–г, харсан зүйлийнхээ 20%–г, харуулсан зүйлийнхээ 30%–г, ярилцаж хэлэлцсэн зүйлийнхээ 50%–г, биетээр хийсэн зүйлийнхээ 75%–г, бусдыг сургасан зүйлийнхээ зүйлийнхээ 90%–г тогтоодог болохыг тогтоосон байдаг. Энэ судалгаанд дүн шинжилгээ хийж сургалтыг идэвхгүй сургалт, идэвхтэй сургалт гэж CDIO санаачлагчид ангилсан байна.

Ямар нэгэн зүйл хийхэд суралцагчдыг татан оролцуулдаг, хийж буй зүйлийнхээ талаар бодоход хүргэдэг “ямар ч юмыг” идэвхтэй сургалт гэнэ.

“Ямар нэгэн зүйл” гэдэг нь унших, бичих, хэлэлцэх, биетээр хийх, үнэлгээ, дүгнэлт хийх, асуудал шийдэхтэй холбоотой зүйлс байна.

Өнөөгийн залуучууд удаан төвлөрөн суухыг хүсэхгүй, урт хугацаанд үргэлжлэх лекцэд дургүй, гэрийн даалгавар хийх сонирхолгүй, орчин үеийн IC технологи ашиглах сонирхолтой, олон нийтийн сүлжээ ашиглах хүсэлтэй, үе тэнгийнхэнтэйгээ хамтарч ажиллаж суралцах хүсэлтэй, аль болох өөрсдийн гараар хийж бүтээхийг хүсч байгаа тул энэ хүсэл сонирхолд нь тохирсон сургалтын арга нэвтрүүлэх шаардлага үүссэн.

“Суралцагчид идэвхгүй суугаад зүгээр л тэмдэглэл хөтөлж байвал суралцах хэлбэр биш гэтэл багш нарын 99% нь энэ аргыг ашигласаар л байна!” гэж Харвардын их сургуулийн физикийн багш Эрик Мазур энэ асуудалд шүүмжлэлтэй хандсан байдаг.

Суралцагч юу хийж байна вэ гэдэг нь багш юу зааж байна вэ гэдгээс илүү чухал болохыг анхаарч багш нар сургалтын үр дүнд хүргэхийн тулд суралцах үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах арга нэвтрүүлэх зайлшгүй шаардлагатай байгааг CDIO санаачлагчид хүлээн зөвшөөрсөн байна. Идэвхтэй сургалтын гол агуулга нь багш нар суралцагчиддаа зааж сургахаасаа илүүтэйгээр суралцагчдад сурахад нь туслахад оршино. Үүнтэй холбоотойгоор орчин үеийн сургалтын 10 зарчмыг сургалтад нэвтрүүлж байна.

Энэ 10 зарчмын хялбаршуулсан хувилбар:

1. Юу сургах гэж байгаагаа тэдэнд хэл;
2. Өнгөрсөн долоо хоногт юу сурсныг нь сануул;
3. Хэцүү зүйлийг бага багаар нь сурга, их ажлаар битгий дар;
4. Зорилго руугаа шууд яв. Тойрч битгий яв;
5. Номын сангаас, интэрнетээс мэдээлэл хайхад нь тусал;
6. Суралцагчдын анхаарлыг татахын тулд сургалтын шинэ аргууд хэрэглэ;
7. Хэтэрхий их зүйл, хэтэрхий хурдан битгий заа, тэд тогтоохгүй;
8. Идэвхтэй сургалтын аргаар хэрэглээний чадвар, мэдлэгийг заа;
9. Битгий загна, тэдэнд урам хайрласан сайхан үг хэл, битгий гомдоо;
10. Мэдлэг, ойлголт, ур чадварыг шалга, юу нь буруу байгааг, хэрхэн сайжруулахыг хэл

Идэвхтэй сургалтын аргууд

Идэвхтэй сургалтын арга нь CDIO арга зүйн үндсэн хэсгүүдийн нэг. Идэвхтэй сургалтын аргууд гол ойлголтуудаа хооронд нь холбоход нь, тухайн мэдлэгээ шинэ нөхцөл байдалд хэрэглэхэд нь тусалж дэмжинэ.

Идэвхтэй сургалтын аргыг бүх төрлийн хичээлд ялангуяа лекцэнд суурилагдсан олон суралцагчидтай хичээлүүдэд хэрэглэнэ.

Лекцээр олгох сургалтыг сайжруулахад тохиромжтой “шавартай” карт, бие биенээсээ суралцах сургалт, суралцагчдын удирдсан хичээл, туршилттай сургалт, төсөлд суурилсан сургалт, симуляц хийх сургалт зэрэг идэвхтэй сургалтын аргуудыг өргөн хэрэглэж байна.

“Шавартай” карт – Muddy cart:

“Шавартай” картыг лекцийн хамгийн их ойлгомжгүй хэсэг гэж мөн нэрлэдэг. Суралцагчдын ойлголтын зөрүүг тогтоох зорилгоор санал авахад хэрэглэгдэнэ.

Лекцийн эсвэл бусад сургалтын төгсгөлд юу сурснаа бичихийг хүснэ.. Суралцагчид хичээлийн хамгийн ойлгомжгүй хэсгүүдийн талаар санаа бодолоо бичнэ. Багш дараа нь санаа бодол бичсэн картуудыг цуглуулан авч дүгнэлт хийнэ.

Ойлгомжгүй хэсгүүдийг хэд хэдэн аргаар авч болно: хичээлийн веб сайтаар асуулт хариулт хийх, дараагийн хичээлийн эхэнд асуултад хариулах, хамгийн нийтлэг ойлгомжгүй хэсгүүдийн хариултыг хэвлэмэл хэлбэрээр тараах эсвэл е-мэйлээр явуулах.

“Шавартай” карт хэрэглэдэг багш нар энэ аргыг хэрэглэснээр олон тооны эерэг үр дүнг бий болгож байгаа талаарх өөрсдийн туршлагыг бүс нутгийн болон олон улсын хуралд тайлагнасан байна.

“Шавартай” карт суралцагчдад бодож эрэгцүүлэх хугацаа олгоно. Энэ нь суралцах хариуцлагын утга учрыг нэмэгдүүлнэ. Асуулт болон тайлбар бичих нь санаа бодлоо цэгцлэж илүү үр дүнтэй суралцахад нь тус болно.

Мөн дараагийн хичээлээр буруу ташаа ойлголтыг тэр дор нь залруулах, дараагийн хичээлийн сургалтын үйл ажиллагаагаа сайжруулахад тус дэм болох мэдээллийг багшид өгнө.

Үнэндээ “шавартай” карт хэрэглэхэд ихээхэн цаг хугацаа зарцуулах /ялангуяа анх удаа хэрэглэх үед/ боловч идэвхтэй сургалтын аргын хувьд ч үнэлгээний аргын хувьд ч маш ашигтай болохыг багш нар олж мэдсэн байна.

Бие биенээсээ суралцах сургалт-Peer instruction. Энэ сургалт баталгаанд суурилагдсан, оюутан төвтэй сургалтын арга. Энэ сургалтыг Харвардын профессор Эрик Мазур 1990-эд оны эхээр анх санаачилсан. Анх Харвардын их сургуулийн физикийн хичээлд хэрэглэж байсан бол өнөөдөр дэлхийн тэргүүлэгч ихэнх их дээд сургуулийн төрөл бүрийн хичээлд хэрэглэж байна. Энэ сургалтаар тухайн сэдвийн үндсэн санааг ойлгох суралцагчдын ойлголтыг эрс сайжруулсан байна.

“Peer Instruction (PI) -Бие биенээсээ суралцах арга” нь тухайн материалын хүнд хэцүү асуудлуудыг шийдүүлэхэд суралцагчдыг татан оролцуулж ангид харилцан суралцуулах сургалтын арга. Лекц, семинарын хичээл дээр ойлголтынхоо талаар хэлэлцүүлэг хийх боломжийг олгосноор бие биенээсээ суралцахыг зөвшөөрнө. Суралцагчид тухайн сургалтын материалын талаар зарим нэг үндсэн ойлголттой болж ангид ирэх үед энэ арга маш их үр өгөөж өгнө.

“Just-in-Time Teaching -Яг цагт нь сургах арга” нь бие биенээсээ суралцах аргын хамгийн гол салшгүй хэсэг байдаг. Хичээлийн өмнөх үеийн суралцагчдын уншлага, санал бодол авах, үндсэн ойлголтын тест авах зэрэг нь яг цагтаа суралцах аргыг бүрдүүлнэ. Иймд үндсэн ойлголтын тестийн үр дүнд үндэслэн багш PI сургалтын асуултуудыг хэцүү хүндрэлтэй байгаа хэсэгт чиглүүлэн өөрчилж болно. Яг цагтаа суралцах арга, бие биенээсээ суралцах арга хоёулаа тус тусдаа өөр өөр цаг хугацаанд сургалтад оролцсон суралцагчдаас сургалтын талаар үнэ цэнэтэй санал авна.

Тухайлбал яг цагтаа суралцах аргын үед оюутнууд хичээлийн бус цагаар нэгэн зэрэг бус байдлаар санал өгөх бол бие биенээсээ суралцах аргын үед бодит цаг хугацаанд санал өгнө. Энэ хоёр аргыг хамт хэрэглэснээр суралцагч төдийгүй багш нарт сургалт ямар болсныг хянахад тус нэмэр болно. Энэ хоёр арыг

хослуулан хэрэглэх нь сургалтын чанарыг сайжруулж ур чадварыг хөгжүүлэхэд ихээхэн ашиг тус өгч байна.

Энэ идэвхтэй сургалтын арга 3 үеэс бүрдэнэ:

• 1-р үе: Хичээлийн өмнөх үе

• 2-р үе: Хичээлийн үе

• 3-р үе: Хичээлийн дараах үе

Энэ 3 сургалт бүр бие биетэйгээ холбогдох боловч тус тусдаа ялгаатай сургалтууд байна. Хичээлийн өмнөх үеийн болон дараах үеийн сургалтыг яг цагтаа суралцах сургалт, хичээлийн үеийн сургалтыг бие биенээсээ суралцах сургалт гэнэ. Энэ идэвхтэй сургалтын арга нь тонгоруу сургалтаар явагдана. Хичээлийн өмнөх үе: Багш гэртээ хичээлээ видео, слайд хэлбэрээр бэлтгэнэ. Видео хичээл бэлтгэхдээ Screencast O Matic –ийг, хичээлийн слайд бэлтгэхдээ Power point хэрэглэнэ.

Ойлголтын асуулт хариулт - Quizzes for reflection.

Өмнөх лекцийн агуулгаар оюутнуудыг дүгнэх зорилгоор лекцийн эхэнд асуулт хариулт авахад хэрэглэнэ. Энэ аргыг Чалмерийн технологийн их сургуулийнхан шавартай картаас бага материал хэрэглэн ойлголтыг нэмэгдүүлэх оролдлогоор бий болгосон.

Суралцагчид багийхантайгаа 5 эсвэл 6 сонголттой асуулт хэлэлцэх учир багийн сургалтад хамаарагдана. Гэвч хэд хэдэн ялгаатай зүйлстэй. Суралцагчид асуултыг хэлэлцэхэд хичээлийн эхэнд ойролцоогоор долоон минут зарцуулна.

Суралцагчид бусад багтай ч хамтарч болно, мөн тэдний хичээлийн тэмдэглэгээг ч хэрэглэж болно. Багш сонголт бүрийг яагаад зөв эсвэл бурууг дуустал тайлбарлана. Энэ арга амжилттай болох нь харагдсан.

Асуулт хариултын үед суралцагчид өөр өөр арга хэрэглэнэ: зарим нь хэлэлцүүлэг хийнэ, зарим нь хичээлийн тэмдэглэгээгээ харахыг илүүд үзнэ, зарим нь зөв хариулт олохоор өрсөлдөнө.

“Яагаад буруу хариулт буруу болохыг ойлгох нь хамгийн сайхан агшин байсан” гэж суралцагчдын нэг нь дурдсан байдаг. Нэг оюутан энэ асуулт хариулт намайг хэт түгшсэн байдалд оруулахгүйгээр амар тайван ойлгох боломж олгосон гэж хэлсэн байна. Ийм асуулт хариулт шалгалтын үр дүнд ч эерэгээр нөлөөлсөн байна.

Дүгнэлт

Идэвхтэй сургалтын аргуудаас багийн хамтын ажиллагаа /хамтарч суралцах арга/, хэлэлцүүлэг, мэтгэлцээн, кейс, судалгаа, дүрд тоглох ба симуляци хийх, бодит байдалтай холбогдож ажиллах зэрэг аргууд нь Хилийн албаны сургуулийн сонсогчдод илүү үр дүнтэй байгаа нь харагддаг.

Дүрд тоглох буюу симуляци хийх гэсэн сургалтын идэвхтэй арга нь манай сургуулийн 1 дүгээр дамжааны сонсогчдод хилийн манааны ахлагч, 2 дугаар дамжааны сонсогчдод, харуулын дарга, 3, 4 дүгээр дамжаанд заставын орлогч, заставын дарга гэсэн албан тушаалтны дүрд тоглох, бие бүрэлдэхүүнд үүрэг,

тушаал, захирамж өгөх, улсын хил хамгаалалтыг зохион байгуулах, удирдах гэсэн мэргэжлийн агуулгын хүрээнд бодит байдалтай ажиллах зэрэг аргуудтай нягт уялдаж сургалтыг үр дүнтэй, идэвхтэй аргаар явуулах боломж бүрдүүлэн өгсөн байна.

Энэхүү сургалтын аргууд нь идэвхтэй төдийгүй амьд, практиктай шууд холбогдож, бодит байдал дээр хилчид юу хийдгийг мэдрэх боломжийг олгож байгаа юм.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

1. http://cdio.edu.mn/static/pdf_file/guidebook/4_3_ActiveLearning.pdf
2. http://erdenetis.edu.mn/web_2/resources/files/Surgaltuud-[2017.07.21nd]/surgalt-4.pdf
3. Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил. БСШУЯ, Хайка-ийн хамтарсан төсөл. УБ 2009 он
4. Идэвхитэй сургалтын арга зүй. Гарын авлага. УБ 2017 он
5. Идэвхтэй сургалтын арга зүй. УБ 2018 Дээд боловсолын төсөл.
6. Идэвхтэй сургалт явуулах арга зүйн зөвлөмж. УБ 2018 он

---o0o---

Судлаач сонсогч

ХОРИХ АНГИД ЯЛ ЭДЭЛЖ БУЙ ТӨЛБӨР ТӨЛӨГЧӨӨС ТӨЛБӨР ГАРГУУЛАХ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ

FEATURES OF THE EXECUTION OF THE DECISION TO COLLECT PAYMENT FROM THE PAYER WHO IS SERVING A SENTENCE IN PRISON



Б.Анун
Дотоод хэргийн их сургуулийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
541 дүгээр дамжааны ахлах түрүүч

Товч утга: Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа бүр өөр өөрийн гэсэн онцлогтой бөгөөд хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах ажиллагааны онцлог нь хоригдлыг хөдөлмөрөөр хүмүүжүүлэн, цалинжуулж хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийж хохирогчийн эрх ашгийг хамгаалах юм.

Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн хохирлыг барагдуулах гэм буруутан нь хорих ялаар шийтгэгдсэн гэх шалтгаанаар хохирогчийн сэтгэл санаа, эрүүл мэнд бусад хохирлын төлбөрийг төлөхгүй байж болохгүй бөгөөд харин ч цаг алдалгүй хохирлыг барагдуулах нь чухал. Гэвч хорих ял эдэлж буй хоригдлууд нь мөнгөн хөрөнгө, эд хөрөнгөгүй, дансан дахь хадгаламжгүйгийн улмаас хорих ангийн үйлдвэрт ажиллаж хөдөлмөрийн хөлснөөс сар бүр суутгуулах боломжтой болдог.

Хоригдол нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинждагаас шалтгаалан суутгал нь маш бага багаар төлөгддөг учраас төлбөр барагдуулахад хугацаа их шаарддаг. Тиймээс энэ ажиллагаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага анхаарал хандуулах шаардлагатай байгаа учир судлаач миний бие олон төрлийн судалгаа авч эрх зүйн түүхэн уламжлал болон өнөөгийн байдалтай харьцуулан шийдвэрлэх арга замыг эрэлхийлж санал зөвлөмжөө энэхүү өгүүлэлдээ тусгасан.

Түлхүүр үгс: Төлбөр төлөгч, төлбөр авагч, хохирогч, хохирол, хөдөлмөрийн хөлс, хөдөлмөр, төлбөр гаруулах ажиллагаа, хөрөнгө.

Abstract: Each decision enforcement process has its own characteristics, and the feature of the process of collecting payment from the payer who is serving a sentence

in the prison is to protect the rights of the victim by raising the prisoner with labor and paying him a salary.

Restitution to the victim of crime should not be done without paying for other damages due to the fact that the perpetrator has been sentenced to prison, and it is important to pay the damages without delay.

However, due to the fact that prisoners serving prison terms do not have money, assets, or savings in their accounts, they can work in prison factories and have monthly deductions from their wages. Because inmates are paid the minimum wage, deductions are paid in small increments, so it takes a long time to pay off. Therefore, due to the fact that the Court's execution organization needs to pay attention to this process, the researcher took five types of research, compared the legal historical tradition and the current situation, and found solutions in this article.

Keywords: Imprisonment, Payor, Payee, Victim, Damages, Wages, Labor, Settlement, Assets

Эрх зүйт төр нь хууль дээдлэх, төр, иргэний харилцан үүрэг хүлээх, хүний эрх, эрх чөлөөг хангах зэрэг зарчмыг баримтлахынхаа хүрээнд иргэдийнхээ зөрчигдсөн эрхийг хамгаалах механезмын нэг хэлбэр болох гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг шийдвэрлэх, арилгах буюу нөхөн төлүүлэх асуудлыг хуульчлан зохицуулсаар ирсэн. Хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээж буй этгээдийн нэг нь хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгч юм.

Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгч нь гэдэг нь нь ялын хамгийн хатуу төрөл болох хорих ял эдлэх хугацаандаа бусдад учруулсан гэм хор, хүүхдийн тэтгэлэг, бусад төлбөрийг төлөх үүрэг хүлээж буй хоригдол юм. Тэгвэл хорих ангид ял эдэлж буй хоригдол ямар тохиолдолд төлбөр төлөгч болох вэ?

- Гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөөгүй
- Хохирогчид гэм хорын хохирлын төлбөрийг олгоогүй гэх тохиолдлуудад

Хорих ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь ямар нэгэн дур зоргийн шинжтэй байж болохгүй. Энэхүү шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай нарийн судлахын тулд хорих ял, хорих анги, төлбөр төлөгч, төлбөр авагчийн тухай ойлголтыг товчхон дурдах нь логик дараллын хувьд оновчтой юм.

Ял нь латины “punitas” болон “peina”- цээрлэл залхаалт буюу гэмт үйлдлийн золиос, гэмт гарзын төлөөс гэсэн язгуур утгаас эх үндэстэй бөгөөд гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай нь нотлогдсон этгээдийг төрөөс цээрлүүлэх хэрэгсэл, гэмт этгээдийн хувьд гэмт хэрэг үйлдсэний өр төлөөс, үр дагавар юм.[166]

[166] С.Жанцан “Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол II боть” Уб., 2014 он

Ялын зорилго нь гэмт этгээдийг дахин бусдад хор уршиг учруулахад саад хийх, ахин хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх юм. Ялын зорилгыг тусгайлан судалсан эрдэмтэд, судлаачдын дийлэнх нь ял нь ялтныг хүмүүжүүлэх, түүнийг гэмт хэрэг дахин үйлдэх явдлаас урьдчилан сэргийлэх эрүүгийн ялын зорилтыг хангахад чиглэгдсэн хүмүүжлийн нөлөө үзүүлэх гэж үздэг.

Ялын онолыг ерөнхийд нь авч үзвэл дэлхийн улс орнуудад абсолют болон харьцангуй онолыг голчлон баримталдаг.

Абсолют онолын гол агуулга нь "Хохирлыг хохирлоор", "Гэмтнийг гэсгээлээр" гэсэн үндэслэгээ, зарчимд тулгуурлан, гэмт хэрэг хийсэн этгээдийг төрөөс /хашраах/ яллан цээрлүүлэх, гэмт хэрэгт нь тохирсон ялыг оноох, шаардлагыг хангахад чиглэгддэг.

Харин харьцангуй онол буюу ялыг нийгэмшүүлэх хандлага /Ж.Руссо, М.Вебер/ XX зууны II хагасаас эхлэн абсолют онолыг шүүмжлэх хандлага баруун Европт хүчтэй дэлгэрч, ялын зорилго нь ялтныг нийгмээс тусгаарлаж, залхаан цээрлүүлэхэд гол нь биш, харин эргээд нийгмийн амьдралд хөлөө олоход нь туслах, засч төлөвшүүлэх замаар нийгэмшүүлэхэд чиглэгдэх ёстой[167] гэж үзжээ.

Үүнээс үзэхэд засч төлөвшүүлнэ гэдэг нь хорих ангид хоригдож буй хоригдлыг хүмүүжүүлэх ойлголттой ижил утгатай юм.

Хоригдлыг хүмүүжүүлэх үед түүний үйлдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюулыг бүрэн дүүрэн ухамсарлуулах, сургалтаар болон хөдөлмөрөөр хүмүүжүүлэх нь үр нөлөө сайтай хэмээн судлаачид үздэг.

Хоригдлыг сургалтаар хүмүүжүүлэхэд ерөнхий боловсролын сургалт, мэргэжил эзэмшүүлэх сургалт, зан үйлд нөлөөлөх албадан сургалтаар хүмүүжүүлдэг. Гэхдээ зөвхөн сургалтаар хүмүүжүүлэх нэг талын үзэл баримтлалаар хүмүүжүүлнэ гэдэг нь өрөөсгөл бөгөөд аль ч улс орон, хувь хүний оршин тогтнохын эх сурвалж болсон хөдөлмөрөөр хүмүүжүүлэх сонгодог жишээг дурдахгүй байж болохгүй.

Оросын эрүүгийн эрх зүйн онолыг үндэслэгчид А.А.Пионтковский, М.Д.Шаргородский, И.Е.Ной С.В.Полубинская нар ялын зорилго бол цээрлүүлэлт биш, харин энэ нь ялын мөн чанар, агуулга бөгөөд ялтанд эхлээд итгүүлж үнэмшүүлэх дараа нь албадах аргыг хэрэглэх шаардлагатай гэсэн энэрэнгүй үзлийг баримталдаг.[168]

Монгол улсын хувьд ч хорих ял нь эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд томоохон байр суурь эзэлдэг бөгөөд 2015 оны эрүүгийн хуулиар буюу ялын бодлогод хоригдлыг нийгэмшүүлэх, хүмүүжүүлэх нийтлэг зорилгод хөдөлмөрлүүлэх ач холбодлыг тусгасан.

Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх үндсэн ба хамгийн хатуу ялын төрөл болох хорих ял нь (англ. Deprivation of liberty)-гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх

---

[167] Д.Баярсайхан. Эрх зүйн сэтгэлгээний орчин цагийн асуудал., 2012 он

[168] А.А.Пионтковский. Основные аспекты теории наказание. 1963., 25 дах тал

чөлөөг тодорхой хугацаагаар, эсхүл бүх насаар нь хязгаарлаж, нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад хүмүүжүүлэх юм. Эл ялыг хүнд гэмт хэрэг үйлдэгсдэд шүүх оногдуулах бөгөөд эрүүгийн хууль ба шүүхийн практикт өргөн хэрэглэгддэг.[169]

Хорих ял нь өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой хугацаагаар нь хугацаатай, хугацаагүй гэж ангилна. Хугацаатай ял нь 6 сараас 20 жил, хугацаагүй ял нь бүх насаар нь хорих юм. Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хүн 25 жил хоригдсоны дараа шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, ялтны хувийн байдлыг харгалзан суллах эсэхийг шийдвэрлэдэг. Хэрэв суллаагүй бол хоёр жил тутам энэ талаар дахин хэлэлцэнэ. 18 насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн бол бүх насаар хорих ял оногдуулахгүй.

Хорих анги нь төвлөрсөн бүтэцтэй байх бөгөөд нээлттэй, хаалттай, сургалт хүмүүжлийн тусгай байгууллага, цагдан хорих төв, байр, нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэг,мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвөөс бүрдэнэ.

Хорих ял эдэлж байгаа ялтныг хоригдол гэнэ.[170] Хоригдол нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар 15 эрх 9 үүрэгтэй.

Хоригдлын үүргүүдээс хоригдлыг хөдөлмөрөөр хүмүүжүүлэх аргад нийцэх нь Хорих байгууллагын алба хаагчаас даалгасан ажлыг заавал гүйцэтгэх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журмыг чанд сахих юм. Ажил хөдөлмөр эрхэлж хохирогчид учруулсан хохирлыг төлөх нь хорих ял эдэлж буй төлбөр төлөгчийн үндсэн үүрэг юм.

Төлбөр төлөгч гэж төлбөр авагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн, үүргээ биелүүлээгүй гэж гүйцэтгэх баримт бичигт заасан хүн, хуулийн этгээдийг хэлнэ[171]

Хорих ангид хорих ял эдэлж буй төлбөр төлөгчийн бусдад учруулсан хохирол нь үйлдсэн хэрэг, бусдад учруулсан гэм хороос шалтгаалан шүүхээс өөр өөрөөр тогтоогдсон байдаг. Хохирогч нь шүүхийн шатанд хохирогч гэж нэрлэгдэж байсан бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр авагч гэж нэрлэгддэг.

Төлбөр авагч нь хохирол нөхөн төлбөрөө төлбөр төлөгчөөс нэхэмжлэх эрхтэй бөгөөд эрх хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж түүнийг сэргээх хамгаалахаар гүйцэтгэх баримт бичигт заасан хүн хуулийн этгээд байна. Хохирогч буюу төлбөр авагчийн хөндөгдсөн эрх, ашгийг нөхөн сэргээх, хохирол төлбөрийг нөхөн төлүүлэх нь төрийн үүрэг бөгөөд гэмт хэрэг үйлдсэн этгээд бусдад учруулсан хохирлоо бүрэн барагдуулах нь эрх зүйт төрийн шударга ёсонд нийцнэ.

---

[169] С.Нарангэрэл. Монгол улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг. 2021.,491 дэх тал
[170] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл
[171] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл

Иймд хохирогчийн буюу төлбөр авагчид учруулсан гэм хорын хохирлыг хэрхэн түргэн, шуурхай төлж барагдуулах арга замыг тодорхойлох нь энэ цаг үед нэн чухал байгаа тул хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд онцгой анхаарах шаардлагатай байна.

Хорих ял эдэлж буй хоригдлын төлбөрийг түүний өмчлөлийн эд хөрөнгөөс төлүүлсний дараа дутуу хэсгийг төлүүлэхээр хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийх тухай мэдэгдлийг ял эдэлж байгаа хорих ангийн захиргаанд хүргүүлнэ.[172] Гэхдээ зөвхөн хорих ангийн захиргаанд даатгах бус шийдвэр гүйцэтгэгчийн зүгээс шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дараалал, эрх зүйн зохицуулалтыг зөрчилгүй ажиллагааг явуулах нь зүйтэй.

Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгч нь иргэн юм. Иймд төлбөр төлөгч-иргэний мөнгөн хөрөнгө болон бусад хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагааны дарааллаар бусдад учруулсан гэм хорын төлбөрийг төлүүлнэ.

Шийдвэр гүйцэтгэгч нь гүйцэтгэх баримт бичгийг үндэслэн эхний ээлжинд бэлэн мөнгө, эсхүл банк, эрх бүхий хуулийн этгээд дэх хадгаламжийн болон харилцах дансанд байгаа төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгө, бусад үнэт зүйлээс төлбөрийг гаргуулна.[173] Төлбөр төлөгч-иргэнд мөнгөн хөрөнгө байхгүй эсхүл мөнгөн хөрөнгө нь гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг гүйцэтгэхэд хүрэлцэхгүй бол төлбөр төлөгчийн өмчлөлийн банк, эрх бүхий хуулийн этгээд дэх хадгаламжийн болон харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө, эсхүл үнэт цаас, түүнчлэн үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, бусад хөрөнгөөс гаргуулна.

Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчийн төлбөр төлөлтийн талаарх сүүлийн 3 жилийн бодит биелэлтийн мэдээг дараах байдлаар боловсруулав.

2020-2023 оны Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчид холбогдох гүйцэтгэх баримт бичиг

	2020 он	2021 он	2022 он	2023 он эхний улирал
Гүйцэтгэвэл зохих гүйцэтгэх баримт бичгийн тоо	1902	1383	1621	1522
Гүйцэтгэвэл зохих гүйцэтгэх баримт бичгийн төлбөрийн хэмжээ	77,365,272.5	89,705,709.0	107,290,955.5	109,158,166.5
Дуусгавар болсон гүйцэтгэх баримт бичгийн тоо (хувь)	390 буюу 20.5%	299 буюу 21.6%	294 буюу 18.1%	74 буюу 4.8%

[172] Шийдвэр гүйцэтгэгчийн ном

[173] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл

Дуусгавар болсон гүйцэтгэх баримт бичгийн төлбөрийн хэмжээ (хувь)	1,244,592.3 буюу 1.6%	1,478,392.6 буюу 1.6%	2,054,177.1 буюу 1.8%	396,862.109 буюу 0.4%

Дээрх хүснэгтээс дүн шинжилгээ хийхэд хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь үр дүн муутай бөгөөд бодит биелэлтийн улсын дундаж үзүүлэлтээс 3 дахин бага үзүүлэлттэй байна. Иймд хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчийн төлбөрийг төлүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд цаашлаад хохирогч буюу төлбөр авагчийн хохирлыг барагдуулахад онцгой анхаарах шаардлагатай байгааг тодорхой харуулж байна.

Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж шийдвэрлэхийн тулд судлаач миний бие дараах 5 төрлийн судалгааг авч боловсрууллаа.

Нэгдүгээрт: Хөдөө орон нутгийн 45, нийслэлийн 55 шийдвэр гүйцэтгэгчээс Google form ашиглан санал асуулгын аргаар 16 асуулга бүхий судалгааг (Хавсралт 1) авахад:

1. Нэг шийдвэр гүйцэтгэгчид дунджаар 100-200 хүртэлх гүйцэтгэх баримт бичиг гар дээр ажиллагаатай байгаа бөгөөд үүнээс ердөө 10% хүрэхгүй хувийг Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах ажиллагаатай гүйцэтгэх баримт бичиг эзэлж байна.

2. Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчдийн 10% хүрэхгүй хувь нь мөнгөн хөрөнгө, эд хөрөнгөгүй учраас төлбөрийн мөнгийг хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс суутгахаас өөр сонголтгүй болж байна. Хорих ангид хөдөлмөр эрхэлж буй хоригдлуудын хөдөлмөрийн хөлсний үнэлэмж бага байгаатай холбоотойгоор хохирол, төлбөрийг төлүүлэх ажиллагаа нь урт хугацаа шаардаж байна. Мөн төлбөртэй хоригдол бүр ажлын байраар хангагдах боломж бага байгаа нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтэд сөргөөр нөлөөлж байна.

3. Хорих ял эдэлж буй төлбөр төлөгч төлбөрөө ямар хугацаанд төлдөг вэ? гэх асуултанд 10% нь 5-аас дээш жил, 32% нь сар бүр хөдөлмөрийн хөлснөөс суутгадаг, 58% нь хугацаанаас өмнө суллагдахдаа гэж хариулжээ. Үүнээс үзэхэд төлбөр төлөгч хорих ялын хугацаанаас өмнө суллагдах зорилгоор төлбөрийг төлж барагдуулах хандлага давамгайлж байна.

4. Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчид ямар гэмт хэрэгт холбогдсон байна вэ гэх асуултад 46% нь хулгайн гэмт хэрэг, 52% нь залилах гэмт хэрэг үйлдсэн гэж хариулсан ба дээрх гэмт хэргийн хохирогчдын тоо их бөгөөд төлбөрийн хэмжээ өндөр байдаг онцлогтой. Мөн гэм хорын хохирол, төлбөрөөс гадна хүүхдийн тэтгэлэг төлбөртэй хоригдлууд нийлээдгүй хувийг эзэлж байна.

Дээрх асуудлуудаас гадна шийдвэр гүйцэтгэгч нараас нээлттэй санал асуулга авахад Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчдөөс төлбөр гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахад хамгийн хүндрэлтэй зүйлс нь төлбөр төлөгч өөрийн гэсэн мөнгөн хөрөнгө, орлого, эд хөрөнгөгүй байдал байдаг талаар хариулсан байна. Мөн хоригдлууд ажлын байраар хангагдсан ч цалин хөлс нь бага байдаг учир ажиллагаа маш удаан явагддаг гэсэн байна. Ер нь хорих ял эдлэгдсээр хөдөлмөр хийлгэж, түүнээс тооцогдох цалингаас ялтны иргэн, байгууллагад учруулсан хохирлыг барагдуулах ажил үр дүн муутай явж ирснийг олон арван жилийн түүхт байдал харуулдаг билээ.[174]

Хоригдлын хөдөлмөрлөх эрхийг хангаж, хохирол төлбөрийг төлөх боломжийг олгож байгаа нь сайшаалтай боловч түүний хөдөлмөрийн хөлсний үнэлгээ буюу цалин , хөлс нь бага байгаа нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удаашруулах гол хүчин зүйл болж байна. Хэдийгээр гэмт хэрэг үйлдэж, ял шийтгэл эдэлж байгаа хэдий ч энгийн иргэнтэй яг адилхан ажиллаж, хөдөлмөрөө шударгаар үнэлүүлэх эрх тэдэнд бий. Тиймээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 215.1 дэх заалт болох “хоригдлын хийсэн хөдөлмөрт нь тооцож хөлс олгоно” гэсэн заалтын дагуу хоригдлуудыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулах явдал практикт өргөн хэрэглэгдэж байна.

Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгч бүгд ажлын байраар хангагдаж чадсан уу? гэх асуултад шийдвэр гүйцэтгэгчид Зан байдлын төлөвшлөөс шалтгаалаад бүгд хамрагдаж чаддаггүй гэж хариулжээ. Учир нь Хорих ангийн нийгмийн ажилтан зан байдлын төлөвшлийг тодорхойлохдоо зөвхөн хорих ангид ирэхэд нь ярилцаад тодорхойлчихдог. Үүний оронд хохирлын төлбөрөө төлөх заавал шаардлагатай хорих ангид цалинтай ажил хийхийн давуу талыг хоригдолд тайлбарлан өгч хоригдлын ажиллаж хөдөлмөрлөх сэтгэл зүй, зан байдлыг өөрчилж өгөх хэрэгтэй. Мөн хорих ангийн захиргаа төлбөртэй хоригдлыг заавал цалинтай ажил хийлгэх шаардлагатай бөгөөд үүнийг холбогдох хууль журманд тусгаж өгөх нь хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах ажиллагаанд маш чухал нөлөө үзүүлэх юм.

Хоёрдугаарт: 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн хоригдол Б.Н-тэй ярилцаж (Хавсралт 2) ярилцлагын аргаар судалгаа авахад:

Тэрээр залилах гэмт хэрэг үйлдсэн бөгөөд хохирогч олонтой бөгөөд нийт 395.875.050 төгрөгийн гэм хорын төлбөртэй. Хорих ангид ажлын байраар хангагдаж цалинтай ажил хийж гэм хорын төлбөрөө суутгуулдаг. Гэвч түүнтэй ярилцаж үзэхэд цалингийн 70%-иар суутгуулан төлбөрөө төлдөг ч ял эдэлж байх хугацаандаа төлбөрөө төлж барагдуулах ямар ч боломж байхгүй, магадгүй ажил хийснээрээ цаг хурдан өнгөрдөг тул ажил хийхээр шийдсэн гэж хариулж байв. Үүнээс харахд хорих ял эдлүүлэх хугацаанд хоригдолыг хөдөлмөрөөр

[174] .Лхагва, М.Ганхүү. Хорих ял эдлэгсдийг хүмүүжүүлэх-нийгэмшүүлэх ажлын зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал. Уб.2015 он. 176 дахь тал

хүмүүжүүлэх зорилго хангагдахгүй байна гэж үзэж болохоор байна. Учир нь хоригдол ажил хийхийг зөвхөн цаг нөхцөөх арга хэрэгсэл хэмээн ойлгож хүлээж авч байгаа нь ардаа хохирол төлбөрийг төлөх, хохирогчийн эрх ашгийг хангах, хөндөгдсөн эрхийг нөхөн сэргээх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах бусад зорилгыг үнэгүйдүүлж байгаа хэрэг юм.

Гуравдугаарт: Сүүлийн 3 жилд хорих ангид ял эдэлж буй төлбөртэй хоригдлын төлбөрөө хэрхэн төлж барагдуулсан талаарх мэдээллийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албан дахь Төлбөртэй хоригдлын мэдээнээс үзвэл:

2020 оны байдлаар нийт төлбөртэй 1902 хоригдлын 77,365,272.5 төгрөгөөс 79% буюу 1512 хоригдлын 75,857,684.2 төгрөгийн төлбөр бүрэн төлж барагдаагүй 18% буюу 336 хоригдлын 1,214,547.9 төгрөгийн төлбөр хоригдлын ар гэрээс төлөгдөж 3% буюу 54 хоригдлын 30,017.8 төгрөгийн төлбөрийг хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс төлж барагдуулсан.

2021 оны байдлаар нийт төлбөртэй 1383 хоригдлын 89,705,709.0 төгрөгөөс 78% буюу 1084 хоригдлын 87,551,162.9 төгрөгийн төлбөр бүрэн төлж барагдаагүй 21% буюу 277 хоригдлын 1,457,689.5 төгрөгийн төлбөр хоригдлын ар гэрээс төлөгдсөн 1% буюу 22 хоригдлын 20,703.1 төгрөгийн төлбөрийг хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс төлж барагдуулсан.

2022 оны байдлаар нийт төлбөртэй 1621 хоригдлын 107,290,955.5 төгрөгөөс 85% буюу 1327 хоригдлын 104,889,917.2 төгрөгийн төлбөр бүрэн төлж барагдаагүй 14% буюу 252 хоригдлын 2,032,502.6 төгрөгийн төлбөр хоригдлын ар гэрээс төлөгдөж 1% буюу 42 хоригдлын 21,647.5 төгрөгийн төлбөрийг хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс төлж барагдуулсан.

2023 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт төлбөртэй 1522 хоригдлын 109,158,166.5 төгрөгөөс 95% буюу 1448 хоригдлын 108,693,151.3 төгрөгийн төлбөр бүрэн төлж барагдаагүй 5% буюу 69 хоригдлын 395,629.109 төгрөгийн төлбөр хоригдлын ар гэрээс төлөгдөж. Харин ердөө 0.5% буюу 5 хоригдлын 1,233.0 төгрөгийн төлбөрийг хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс төлж барагдуулсан байна.

Энэхүү судалгаанаас үзэхэд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шуурхай байх зарчим алдагдаж харагдаж байгаа бөгөөд хамгийн ихдээ 2021 онд 22%-ийн бодит биелэлттэй байна. Энэ нь нэг талаас хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж буй асуудал бөгөөд нөгөө талаас нийт төлөгдсөн төлбөрийн ихэнх хувь нь хорих ангид ял эдэлж буй хоригдлын төлбөрийг ар гэрээс нь төлсөн байна. Энэ нь эрүүгийн хуулийн 1.3.3 дугаар зүйлд заасан “Гэмт хэрэг үйлдсэн хүнд өөрт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Эрүүгийн хариуцлагыг бусад хүнд халдаан хэрэглэж болохгүй” гэх заалтыг зөрчиж байгаа юм.[175]

[175] Эрүүгийн хууль. Уб., 2015. Төрийн мэдээлэл эмхэтгэл

Дөрөвдүгээрт: Монгол улсын Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх хууль тогтоомжийн түүхийн асуудлыг Монгол улсын гавьяат хуульч, хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор Авирмэдийн Лхагва тусгайлан судалж энэ чиглэлээр олон арван бүтээл туурвиж[176] байсан бөгөөд судлаачийн хувьд Хорих ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах эрх зүйн зохицуулалт, түүний цалин хөлсний асуудлыг салбарын 1931, 1966, 1981, 1995, 1996, 1999, 2002 оны хуулийн хүрээнд түүхэн эх сурвалжаас түүвэрлэн авч үзлээ.

-1931 оны "Монгол ард улсын дотор Аливаа хэрэгтэн ялтныг засан сайжруулах тухай хууль-ийн 4 дүгээр зүйлд Хөлсөөр ажил хийж буй хоригдогсдод нэжгээд дэвтэр олгож, түүнд төлөхөөр тогтоосон ба хөлс олгосон, жич суутгаж авсан хөлс, шагналын зүйлс хичнээн болохыг тэмдэглэвэл зохино.

Хуулийн 29, 30-р зүйлд

-зууны 25 хувиас доошгүйг ажил хийсэн хоригдогсдод

-зууны 25 хувийг улсын санд оруулах

-50 хувийг цэвэр ашиг болгон хуваарилна гэжээ.

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1966 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 50 дугаар зарлигаар батлагдсан БНМАУ-ын "Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль"-ийн 3 дугаар бүлгийн 25 дугаар зүйлд "Хоригдол нь ял эдэлж байх үедээ өөрийн буруугаас улсад учруулсан эд материалын үнийг төлүүлнэ",

-1981 оны "БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль"-ийн 38 дугаар зүйлд "Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колони, гянданд хорих ял эдэлж байгаа ялтны хөдөлмөрийн хөлснөөс ажлын тусгай хувцас, тусгай хоолны үнээс бусад хоол хүнсний болон хувцас, цагаан хэрэглэлийн үнийг суутгана. Хөдөлмөрийн хөлснөөс энэ суутгалыг хийсний дараа гүйцэтгэх хуудас болон бусад гүйцэтгэх баримт бичгийг үндэслэн БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуульд заасан журмын дагуу суутгал хийнэ", гэж заасан нь гүйцэтгэх хуудас болон гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөрийн хэмжээгээр суутгал хийнэ гэж заасан.

-1995 оны "Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хууль"-ийн 17 дугаар зүйлд "Цалин хөлснөөс суутгасан мөнгийг гүйцэтгэх хуудас байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн дансанд шилжүүлнэ" гэжээ энэ нь хорих ангиудын захиргаа нь энэ цаг үеэс хорих ял эдэлж буй хоригдлын бусдад учруулсан хохирлыг барагдуулахад түргэн шуурхай ажиллаж эхэлжээ.

-1996 оны Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль-ийн 61 дүгээр зүйлд "Хөдөлмөрийн хөлснөөс суутгасан мөнгийг гүйцэтгэх хуудас байгаа шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын дансанд шилжүүлнэ" гэдэг нь шинэ ойлголт нэмэгдсэн байх бөгөөд хөдөлмөрийн хөлснөөс суутгах гэж заажээ. Иймд хоригдлууд хөдөлмөрлөснөөр хөдөлмөрийнхөө тоо, чанарт тохирсон хөлс авах боломжтой болсон байна.

---

[176] Л.Чүлтэмсүрэн, А.Лхагва "БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын талаар "

- 2002 оны “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 121 дүгээр зүйлд Хорих ангийн ялтныг өөрийн үйлдвэрлэл дээр ажиллуулсны болон гэрээний үндсэн дээр ялтан ажиллуулсан ажил олгогчоос шилжиж ирсэн цалин хөлснөөс бүх төрлийн төлбөр суутгал хийж үлдэх хэсгийг нь ялтны нэрийн дансанд төвлөрүүлнэ. Хорих анги, эсхүл ажил олгогч нь ялтны хөдөлмөрийн хөлсийг тухайн үеийн үнэлгээ, ханшаар тооцно[177] гэж хуульчилж ирсэн. Тэгэхээр хоригдлын хөдөлмөрийг үнэлэх үнэлгээ нь хийж буй ажил ажлын гүйцэтгэлээсээ шалтгаалаад өөр байжээ.

Түүхэн дэх хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийж хоригдлыг хөдөлмөрөөр хүмүүжүүлсээр ирсэн түүхэн эх сурвалжууд байна. Мөн төлбөр авагчийн эрхийг хангах талаар хууль тогтоомжид тусгаж өгч төлбөр авагчийн эрх байр сууринд 1996 оноос хойш түлхүү анхаарал хандуулж иржээ.

Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах ажиллагаа нь өнөөгийн байдлаар Монгол улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Эрүүгийн хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг удирдлага болгон ажиллагааг явуулдаг. Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд “Хорих ял эдэлж байгаа хоригдлын төлбөрийг хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийж, иргэний шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст шилжүүлнэ” гэсэн заалт ерөнхийлөн энэ төрлийн харилцааг зохицуулж байна.

100 жилийн түүхт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах ажиллагаан дахь асуудлуудыг дотооддоо шийдэх боломжтой байтал хамтарч ажиллаж чаддаггүй, энэ төрлийн ажиллагааны үр дүнд анхаардаггүй, хамтын ажиллагаа муутай байгаагийн илрэл юм. Жишээ нь төлбөртэй хоригдлуудыг анхаарч бүгдийг нь ажлын байраар хангадаггүй, цалин хөлсгүй ажил буюу хорих ангийн аж ахуйн ажил, бусад ажлуудад хуваарилдагтай шууд холбоотой гэж үзэхээр байна.

Хэдийгээр үйлдсэн гэмт хэрэгт нь тохирсон ялыг буюу хорих ялыг оногдуулсан хэдий ч ард нь бусдад учруулсан гэм хорын асуудлыг шийдвэрлэхэд онцгой анхаарах шаардлагатай юм.

Хамгийн гол нь хохирч үлдсэн хүний эрүүл мэнд, сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг тэргүүн ээлжинд авч үзэх нь зүйтэй. Учир нь үйлдэгдсэн гэмт хэргээс шалтгаалаад хохирогч нь насан туршдаа хөгжлийн бэрхшээлтэй болох эсхүл насан туршдаа эдгэшгүй өвчин, эмгэгтэй болж болно. Иймд хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах ажиллагааг удаашруулж орхиж болохгүй.

---

[177] А.Лхагва М.Ганхүү Хорих ял эдлэгсдийг хүмүүжүүлэх-нийгэмшүүлэх ажлын зохион байгуулалт эрх зүйн зохицуулалтын зарим асуудал.,Уб., 2015 он

Дүгнэлт

Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгч гэдэг нь нь ялын хамгийн хатуу төрөл болох хорих ял эдлэх хугацаандаа бусдад учруулсан гэм хор, хүүхдийн тэтгэлэг, бусад төлбөрийг төлөх үүрэг хүлээж буй хоригдол юм. Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах ажиллагаа нь хорих ангиудын захиргаа болон Иргэний шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсүүдийн хамтын ажиллагаа шаардсан ажиллагаа юм.

Хорих ангийн захиргааны зүгээс төлбөртэй хоригдлыг өөрийн үйлдвэрлэл болон гэрээгээр ажиллуулдаг цалинтай ажилд хуваарилан хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийж хоригдлын гүйцэтгэх баримт бичиг байгаа шийдвэр гүйцэтгэх газар хэлтэст шилжүүлэх ажиллагаанд анхаарах. Харин шийдвэр гүйцэтгэгчийн зүгээс Хорих ангийн захиргаанд найдах бус хоригдлын нэр дээрх мөнгөн хөрөнгө, эд хөрөнгө, хадгаламжийн болон харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгийн талаарх мэдээллийг лавлан тухайн хөрөнгөөс гүйцэтгэх баримт бичигт заагдсан төлбөрийн хэмжээгээр суутгал хийх юм.

Гэвч Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах ажиллагаа нь сүүлийн 3 жилд дунджаар 0.5%-1.6% биелэлттэй байгаа нь судалгаанаас харагдсан. Энэ нь гэмт хэргийн улмаас бие, сэтгэл санаагаараа хохирсон хохирогчдын хохирол хангалттай хэмжээнд барагдахгүй байгаагийн илрэл юм.

Судлаач миний бие хорих ял эдэлж буй төлбөр төлөгчид холбогдох шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар судалж дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

1.Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчийн дийлэнх хэсэг нь ажлын байраар хангагдаж, хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийлгүүлэх замаар төлбөрөө хэсэгчлэн төлдөг ч төлбөрөө бүрэн барагдуулах тохиолдол цөөн. Хоригдлын хөдөлмөрийн хөлсийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулж байгаа учраас өндөр дүнтэй төлбөртэй хоригдлын төлбөр төлөгдөхгүй удааширч урт хугацааг шаардаж байна.

2. Хорих ангид ял эдэлж буй хоригдлын гэм хорын төлбөрийг ихэнх тохиолдож ар гэрийнхэн нь төлдөг нь судалгаанаас харагдаж байна. Энэ нь эрүүгийн хуулийн 1.3.3 дугаар зүйлд заасан Гэмт хэрэг үйлдсэн хүнд өөрт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Эрүүгийн хариуцлагыг бусад хүнд халдаан хэрэглэж болохгүй гэх заалтыг зөрчиж байгаа юм.[178]

4. Дийлэнх хорих ял эдэлж буй төлбөр төлөгч нь бусдад учруулсан гэм хороо хурдан төлж, хохирогчийн эрхийг хангах бус зөвхөн өөртөө ашигтай байдлыг харж хорих ялаас хугацааны өмнө суллагдах зорилгоор төлбөрөө төлж байгаа нь эрүүгийн ялын зорилго алдагдахад хүргэж байна.

Дэвшүүлж буй санал:

[178] Эрүүгийн хууль. Уб., 2015. Төрийн мэдээлэл эмхэтгэл

1. Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчийг хорих ангийн зүгээс заавал цалинтай ажлын байраар хангах. Ихэнх хоригдол зан байдлын төлөвшлөөс шалтгаалан ажлын байраар хангагдахгүй байх ба хөдөлмөрөөр хүмүүжүүлэх зарчмыг баримталж ажиллах нь ялын үр нөлөөг нэмэгдүүлнэ.
2. Хорих ангид хөдөлмөр эрхэлж буй хоригдлуудын цалинг дийлэнхийг нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулах бус хийсэн хөдөлмөрт тохирсон цалин олгож байх. Хоригдол гэдэг утгаараа нийгмийн амьдралд оролцох эрхээ хасуулсан ч хөдөлмөрийн хөлс авах, түүнийхээ үр шимийг хүртэх эрхийг хязгаарлаж үл болно.
3. Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчийн ар гэрийнхнээр төлбөрийг төлүүлэхээс зайлсхийж эд хөрөнгө, мөнгөн хөрөнгөө нуун дарагдуулахаас урьдчилан сэргийлж ажиллах
4. Гэмт хэргийн улмаас үүссэн хохирлыг яагаад төлөх ёстой талаар сургалт зохион байгуулж байх.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

I. Монгол эх сурвалж:

1. С.Жанцан “Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол II боть” Уб., 2014 он
2. С.Нарангэрэл. “Монгол улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг”. Уб., 2021 он
3. “Шийдвэр гүйцэтгэгчийн ном”., Уб., 2020 он
4. .Лхагва, М.Ганхүү. “Хорих ял эдлэгсдийг хүмүүжүүлэх-нийгэмшүүлэх ажлын зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал”. Уб.2015 он.
5. Л.Чүлтэмсүрэн, А.Лхагва “БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын талаар ”., Уб.,
6. Ч.Өнөрцэцэг. “Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дараалал, эрх зүйн зохицуулалт”., 2022 он
7. С.Буянзаяа, Б.Эрдэнэ-Очир, Ш.Энхжаргал, Б.Болор-Эрдэнэ, Б.Алтангэрэл. Иргэн “Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй”
8. Ш.Монтескье. “Хуулийн амин сүнс”
9. Д.Баярсайхан. “Эрх зүйн сэтгэлгээний орчин цагийн асуудал” 2012 он
10. Н.Гантулга. “Монгол улсын эрүүгийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй”., 2019 он

II. Гадаад эх сурвалж:

1. А.А.Пионтковский. Основные аспекты теории наказание. 1963 он

III. Бусад эх сурвалж:

1. Үндсэн хууль 1992 он
2. Эрүүгийн хууль 2015 он
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он

---o0o---

ТӨЛБӨР ТӨЛӨГЧИЙН ГАДААДАД ЗОРЧИХ ЭРХИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

LEGAL REGULATION OF EXECUTION OF THE DECISION TO SUSPEND THE PAYER'S RIGHT TO TRAVEL ABROAD



Б.Хүслэн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 541 дүгээр дамжааны сонсогч

Товч утга: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаан дахь төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх ажиллагааны онолын хувьд судалж, эрх зүйн зохицуулалтын онцлог, практикд суурилан, хэрэгжилтэд тулгарч буй зарим асуудлыг судлан, цаашид эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар судлаачийн зүгээс шинэ санал боловсруулсан.

Түлхүүр үгс: Хүний эрх, гадаадад зорчих эрх, гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх албадлагын арга хэмжээ, хууль эрх зүйн орчин, нийгэм, төлбөр төлөгч.

Abstract: Theoretical research in court decision enforcement will be studied in theory. The specifics of the legal regulation will be analyzed based on practical results. The some problems of restraining suspend debtors right to travel abroad will be identified. And proporsals will be developed.

Keywords: Human rights, right to free movement out of the country, suspend the rights of debtor to travel abroad, legal framework, society, debtor.

Төлбөр төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааны практикын тулгамдсан асуудлыг хөндөхөөс урьтаж хүний эрхийн талаарх суурь ойлголтыг авж үзэх нь зүйтэй юм. Аливаа эрх зүйн зохицуулалт нь бүгд угтаа хүний эрхийг хангах, хамгаалахад чиглэгдэх ба түүнийг хязгаарлах арга хэмжээ нь онолын болоод зайлшгүй шаардлагаас урган гарсан байх зүй тогтолтой.

Хүний жам ёсны эрхийн судлагдахуун нь хүн хэмээх бодгалаас салгаж үл болох ойлголт бөгөөд хүн байх мөн чанарыг илэрхийлдэг билээ. Эдгээр нь хувь хүнд заяагдсан давтагдашгүй өгөгдлөөс үл хамааран хүн бүрт ижил тэгш заяагдсан

зүйл юм. Иймд хүний жам ёсны эрхийн салшгүй нэг хэсэг болох чөлөөтэй зорчих эрхийг хязгаарлах хүний мөн чанарт нөлөөлөх агуулгыг өөртөө багтаах тул анхааралтай хандаж нь чухал.

Тэгвэл “Хүний эрх” гэж юу вэ? Хүний эрх (англи. Human right, орос. Права человека) гэдэг нь агуулгын хувьд та бидний төсөөлж буйгаас ч илүү өргөн цар хүрээтэй бөгөөд хүний төрөлхийн шинжээс урган гарч, хувь хүний нийгэмд оршин тогтнох үндсийг тодорхойлдог ухагдахуун гэж ойлгож болно.Үүнээс үзэхэд хүний эрх хэмээгч нь тэдгээрийн нийтлэг шинжийг илэрхийлж, хамтран амьдрах хэм хэмжээг тодорхойлох, чөлөөтэй байх боломжийг бий болгох ёстой.

Орчин үед хүний эрхийг дараах үндсэн шинж чанарыг агуулдаг гэж үзэх болсон. Үүнд: Түгээмэл, хүнээс салшгүй байх, харилцан хамааралтай, хуваагдашгүй байх, тэгш бөгөөд ялгаварлан гадуурхахгүй байх, эрх, үүргийн нэгдэл байна.

Хүний эрх нь хүн бүрд хамаатайн адил хүн бүрийн үүрэг хариуцлага байна. Хүн бусадтай харилцахдаа, нэг бүлэг нөгөө бүлэгтэйгээ харилцахдаа эрх, үүргийн харилцаанд ордог. Ялангуяа олон улсын хүний эрхийн хуульд зааснаар төр нь хүний эрхийг хангаж, хамгаалах үүрэг хариуцлагыг өөртөө хүлээдэг.[179] Эдгээр шинжүүд нь хэдийгээр хүний эрхийн халдашгүй байдлыг тодорхойлж байгаа боловч хүний эрхийг хязгаарлах нийтлэг шинжийг ч мөн адил дурджээ. Тухайлбал хууль, эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн хүний эрхийг хязгаарлахад хүргэх, зарим эрхийг зөрчсөн нь зарим эрхийг хязгаарлах нөхцөл болдог. Мөн хүний эрхийг хамгаалах зорилгын хүрээнд бусад эрхийг хязгаарлах боломж олгодог зэрэг хүний эрхийг хязгаарлах шаардлагыг тодорхойлжээ. Иймд төлбөр төлөгч буюу эрх зүйн зөрчил үйлдэгчийн зорчих эрхийг хязгаарлах асуудал зайлшгүй шаардлагаас урган гарсан ойлголт болох нь харагдаж байна. Гэхдээ хэрхэн яаж хязгаарлах арга журмыг нарийвлан судлах шаардлагатай.

Тус арга хэмжээг үүслийн хувьд авч үзвэл “Ромын сенат Октавианд хүндэт Август нь МЭӨ 27 онд Ромын эзэнт гүрнийг байгуулахдаа Египетийн Ромын шинэ мужийг хаант засаглалын эрх мэдэлд шилжүүлж, сенаторуудыг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр ийш, тийш зорчихыг хориглодог байсан.[180] Энэ үеэс дэлхийн түүхэнд зорчих эрхийг нь хязгаарлах гэдэг ухагдахуун үүссэн. Харин манай улсын хувьд хүний зорчих эрхийг хязгаарлах арга хэмжээг авч эхэлсэн түүхэн уламжлалын хувьд XI-XIII зууны үеийн хууль цаазын сурвалж бичгүүдэд тухайлбал Их засаг хуульнаа[181] тусгагдсан байдаг аж.


---

[179] Агар-Эрдэнэ.Г нар., Хүний эрхийн товч тайлбар., УБ.,2013., 229 дэх тал.,
[180] Cassius Dio., *Roman History*., Book LV, 26.
[181] Их засаг хууль (2023). www.wikipedia.org. Татаж үзсэн: 03.18.2023.,

Манай улсын тухайд харьцангуй сүүл үед буюу 1926 оны Засгийн газрын 26 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Шүүн таслах газраас аливаа хэргийг байцаан шийтгэх тухай хуулийн хорин зургаадугаар зүйлд "Аливаа хэрэгтэнг шүүн таслах газраас түр буюу байцаагч түшмэдүүдэд ирүүлэхэд эрх биш бэлэн байлгах аргад" сууж буй орон нутгаас зайлж үл гарч болно хэмээн гарын үсэг зурсан батлах хуудас авдаг байжээ[182]. Энэ нь нутаг заах хариуцлага, хан аймагт цөлөх хил давуулан цөлөх зэргээс нь мөн чанарын хувьд дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэхээс гадна, шийтгэх ажиллагаанд саад учруулж болзошгүй, оргон зугтахыг таслан зогсоох зэрэг одоогийн гадаадад зорчих эрхийг түдгүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шинж чанар, зорилтыг агуулсан. Эдгээрээс үзэхэд төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрх буюу эрх хязгаарлах арга хэмжээ нь анх эрүүгийн эрх зүйд бий болсон байх магадлалтай бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх, гэмт хэргийг илрүүлэхэд чухал ач холбогдол бүхий түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор прокурорын саналын үндэслэн шүүхээс авч хэрэгжүүлж буй хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ болон хөгжиж ирсэн байна.

[182] Сумьяабаатар.Б.,Ташкент.,2003., Чингис хаан "Их засаг" хэсэг шинээр олдов.,Cultural exchange between East and West" Олон улсын эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэлээс дам ишлэв.

Өнөөдөр Монгол Улсын иргэний эрхийг тэр дундаа гадаад зорчих эрхийг түдгэлзүүлэх арга хэмжээг дараах зайлшгүй шаардлага буюу хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж байна.



Хүснэгт: 1. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах эрхийг
түдгэлзүүлэх тухай

Дээр дурдсан үндэслүүдээс өөр бусад үндэслэлээр Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах эрхийг хязгаарлахыг хориглоно[183] хэмээн Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах тухай хууль заасан байдаг. Энэ нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон зөрчил шалган шийдвэрлэх

[183] Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих цагаачлах тухай хууль., УБ.,1993., Төрийн мэдээдэл эмхэтгэлийн №2., 5 дугаар зүйлийн 1 дахь хэсэг.

ажиллагааны хүрээнд Монгол улсын иргэний гадаадад зорчих эрхийг хязгаарлах нь нийтийн ашиг сонирхлыг хангах зорилгоор авч буй арга хэмжээ юм. Харин хувийн эрх зүйн буюу хувь хүний эрх, ашиг сонирхлыг хангах зорилгоор хүний эрхийг хязгаарлах ажиллагаанд хууль тогтоогч болон эрх бүхий байгууллагаас хойрго хандах эрсдэл байна. Учир нь нийтийн эрх ашгийг хувь хүний эрх ашигтай харьцуулан авч үзэлтгүй хэдий ч ардчилсан эрх зүйн тогтолцооны үндэс нь хувь хүний эрх байдаг гэдгийг санах хэрэгтэй. Иймд хувийн эрх зүйн салбарт ч шаардлагатай тохиолдолд иргэний гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх хэрэгцээ үүсдэг. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих цагаачлах тухай хуулийн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу "гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр байгаа бол" гэх заалт нь төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үндэслэл болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн харилцаа нь иргэний хэргийн талаарх шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэсэн буюу эрүүгийн ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон үеэс үүснэ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн харилцааны элемент нь агуулга, субьект, обьект гэсэн хоорондоо холбоо бүхий бүтэцтэй байдаг.[184] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа[185]-ны төрлүүдээс иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны албадлагын арга хэмжээний нэг болох төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагаа өөрийн гэсэн онцлогтой .

Иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлбөр төлөгч буюу төлбөр авагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн, үүргээ биелүүлээгүй гэж гүйцэтгэх баримт бичигт дурдсан иргэн, хуулийн[186] этгээдийг нэрлэдэг ба шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд нь эсрэг, тэсрэг ашиг сонирхол бүхий боловч хоорондоо харилцан хамааралтайгаар ажиллагаанд оролцдог. Үүнээс дараах тодорхойлолтыг гаргах нь зүйтэй бөгөөд төлбөр төлөгч иргэн гэдэг нь гүйцэтгэх баримт бичигт заасан хүн, төлбөр төлөгч хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан гэдэг нь гүйцэтгэх баримт бичигт заасан хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд, гүйцэтгэх удирдлага, төлөөлөн

---

[184] Дашзэвэг.Б .,Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй.,УБ., 2003.,103 дахь тал.,

[185] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль., УБ., 2017., Төрийн мэдээлэл эмхэтгэлийн №24., 6 дугаар зүйлийн 6.1., "Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд дараах ажиллагаа хамаарна. Иргэний хэргийн талаар гаргасан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, Захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, Зөрчлийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, Эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хамаарахаар хуульчилсан.

[186] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль., УБ., 2017., Төрийн мэдээлэл эмхэтгэлийн №24.

удирдах зөвлөлийн дарга, нэг хувьцаа эзэмшигч байгаа бол тухайн хувьцаа эзэмшигчийг ойлгоно.[187]

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэглэх явцад төлбөр авагч нь шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр хүсэлт гаргасан, шийдвэрийг шүүгч даруй биелүүлэх шаардлагатай гэж үзсэн бол шүүгч албадан гүйцэтгүүлэх захирамж гарган захирамж гарснаас хойш 7 хоногийн дотор уг захирамж, шүүхийн шийдвэр, шаардлагатай бусад материалыг хавсарган шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд ирүүлнэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх захирамж, гүйцэтгэх хуудас, зардлын гэрээ төлсөн эсэхийг шалган авч ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуульд зааснаар явуулна. Төлбөр төлөгч нь иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцохдоо эдлэх эрх[188], хүлээх үүрэг[189], хариуцлага[190], холбогдох хуулийн зүйл, заалтай танилцан хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрт заасан мөнгөн төлбөр болон хөрөнгийн шинжтэй шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр төлөгч-иргэн, төлбөр төлөгч-хуулийн этгээдийн удирдах албан тушаалтны гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх санал гаргаж, шийдвэрлүүлнэ.

---

[187] Өнөрцэцэг.Ч., УБ., 2020., Ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч нарт зориулсан гарын авлага., 82 дахь тал.

[188] Төлбөр төлөгчийн эрхийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 33 дугаар зүйлд тогтоосон байдаг ба- Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах хугацааны санал гаргах, хураах хөрөнгийн талаар хүсэлт гаргах, төлбөрт хураагдсан өөрийн өмчлөл, эзэмшлийн хөрөнгийг шинжээчийн тогтоосон үнээс багагүй үнээр худалдан борлуулах хугацаа тогтоолгох, дуудлага худалдаа явагдахаас өмнө бусдад гэрээний үндсэн хөрөнгөө худалдан борлуулах, дуудлага худалдаанд оролцох, албадлагын арга хэмжээ хянуулах, хүчингүйд тооцуулах хөрөнгийн үнэлгээ болон эрх хөндөгдсөн асуудлаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрх хэмээн Өнөрцэцэг Ч., УБ., 2022., Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дараалал, эрх зүйн зохицуулалт., 43 дахь талд тодорхойлсон байдаг.

[189] Төлбөр төлөгчийн үүргийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 33 дугаар зүйлд тогтоосон байдаг ба- Гүйцэтгэх баримт бичигт заасан тодорхой үүргийг биелүүлэх,тодорхой үйлдэл хийх эсхүл түүнээс татгалзах, эд хөрөнгө, мөнгө шилжүүлэх, оршин суугаа /байгаа/ хаягаа өөрчилсөн бол шийдвэр гүйцэтгэгчид даруй мэдэгдэх, хөрөнгийн мэдүүлэг өгөх, хөрөнгийн өөрчлөлтийг даруй мэдүүлэх, шийдвэр гүйцэтгэгчээс тавьсан шаардлагыг биелүүлэх, төлбөрт хураагдсан хөрөнгөнд нэвтрүүлэх, шинжээч ажиллах нөхцөлийг хангах, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг нөхөн төлөх үүргийг хүлээнэ хэмээн мөн тэнд тодорхойлсон байдаг.

[190] Төлбөр төлөгч нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удаашруулах зорилгоор шийдвэр гүйцэтгэгчийг дуудсан цаг, оршин суугаа хаяг дээрээ байхгүй, хөрөнгийн мэдүүлэг буруу гаргах, эд хөрөнгөө нуун дарагдуулах үед Эрүүгийн хуулийн 21.7 дугаар зүйлд зааснаар хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсвэл зургаан сараас нэг жил хүртэл зорчих эрх хязгаарлах, эсвэл зургаан сараас нэг жил хүртэл хорих ялаар шийтгэдэг.

Зөрчлийн тухай хуулийн 15.27 дугаар зүйлд зааснаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч бус этгээд төлбөр төлөгчийн хөрөнгийн талаарх мэдүүлгийг зориуд худал мэдүүлсэн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгодог байна.

Тавин сая төгрөгөөс дээш хөрөнгийн шаардлага бүхий эсхүл тэжээн тэтгэх үүргээ **3 сараас** дээш хугацаагаар биелүүлээгүй төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг тогтоосон хугацаанд үүргээ биелүүлээгүйгээс гадна санаатайгаар зайлсхийсэн, хөрөнгөө нуун дарагдуулсан, гадаад улсад зорчиж болзошгүй үндэслэл зэрэг үндэслэл[191] байгаа тохиолдолд гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх тухай санал гаргахдаа анхаарах асуудлыг доорх хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт: 2 "Шийдвэр гүйцэтгэгч санал гаргахдаа анхаарах асуудал"

Гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх санал гаргахад анхаарах асуудал:	
Нэг төлбөр төлөгчид холбогдох хэд хэдэн гүйцэтгэх баримт бичиг байгаа бол:	Нэг гүйцэтгэх баримт бичигт холбогдох хэд хэдэн төлбөр төлөгчийн үүрэг тодорхойгүй бол:
1. Тэдгээрийн нийт төлбөрийн хэмжээг нэгтгэх. **2. Хэд хэдэн гүйцэтгэх баримт бичиг нь өөр өөр тойрогт бүртгэлтэй бол саналыг нэгтгэн хүргүүлнэ.** **3. Нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх гүйцэтгэх баримт бичгийн мэдээлэл, саналыг Шийдвэр гүйцэтгэх албанд хүргүүлнэ.**	1. Тэдгээрийн нийт төлбөр төлөгчдийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх санал гаргана. 2. Хэрэв гүйцэтгэх баримт бичигт төлбөр төлөгчийн гүйцэтгэх үүрэг тодорхой заасан, уг үүрэг нь албадлагын арга хэмжээ тогтоолгох шаардлагад нийцэхгүй бол санал гаргахгүй.[192]

Ерөнхийдөө төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь:

1. Шийдвэр гүйцэтгэгч хуульд заасан үндэслэл байгаа тохиолдолд санал гаргах
2. Ахлах шийдвэр гүйцэтгэгч саналыг хянах
3. Ерөнхий шийдвэр гүйцэтгэгч санал шийдвэрлэх гэсэн үе шаттайгаар явагддаг.

Шийдвэр гүйцэтгэх албаны эрх бүхий албан тушаалтан нь Ерөнхий шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг, төлбөр төлөгчийн мэдээллийн хамт Хил хамгаалах ерөнхий газарт хүргүүлэх бөгөөд төлбөр төлөгч гадаадын иргэний гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахдаа гадаадын иргэн, харьяатын газарт мэдэгдэж, шийдвэрийн биелэлтийг хангуулж, нэгдсэн тоо бүртгэлд бүртгэн албадан гүйцэтгэх арга хэмжээг гүйцэтгэдэг. Төлбөр төлөгч-хуулийн этгээд нь улсын төсвийн байгууллага бол гадаадад зорчих эрх

[191] Өнөрцэцэг.Ч., УБ., 2020., Ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч нарт зориулсан гарын авлага., 83 дахь тал.
[192] Мөн тэнд.

түдгэлзүүлэх албадлагын арга хэмжээг гүйцэтгэхгүй, улсын төсвийн байгууллагаас төлбөр гаргуулах үндэслэл[193], журмын дагуу гүйцэтгэнэ.

Төлбөр төлөгчийн гадаадад зорчих шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн, зохицуулалт, журмын талаар авч үзье:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд "Гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх" гэсэн нэр томьёо, албадлагын арга хэмжээ нь 1996 оны болон 2002 оны хуульд тусгагдаагүй бөгөөд 2002 оны “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-д сүүлд буюу шинээр 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр шинээр оруулж ирсэн албадлагын арга хэмжээний нэг юм.

2002 оноос өмнө манай улсын нийгэм эдийн засгийн байдлаас шалтгаалан хүн бүр гадаадад зорчих, цагаачлах, ажиллаж амьдрах асуудал бага гардаг байв. Иргэдийн хувьд гадаадад сурч боловсрох, арилжаа наймаа хийх зорилгоор түлхүү гадаадад зорчиж байсан бол 2001 оноос хойш Монгол улсын иргэд гадаад улсад ажиллах сонирхол их болсонтой холбогдуулан гадаадад зорчих иргэдийн тоо эрс нэмэгдсэн байна. 2003 оны байдлаар нийт 959.873 иргэн ажил, хөдөлмөр эрхлэх зорилгоор гадаад улсад зорчсон ба эдгээр тоо нь жил ирэх тусам нэмэгдсээр байна.

Төлбөр төлөгч иргэний гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх ажиллагааг шийдвэр гүйцэтгэгч явуулдаг байсан бол 2002 онд батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шийдвэр гүйцэтгэгчийн бүрэн эрх 133.4.4 дахь хэсэгт [194]“...Шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх...” гэж 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн өөрчлөлтөөр нэмсэн. Мөн энэ хугацаанаас буюу 2014 оны 12 дугаар сараас эхлэн төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлж эхэлсэн юм. Энэхүү нэмэлт өөрчлөлтөөр Улсын Ерөнхий шийдвэр гүйцэтгэгч энэ албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхээр хуульчилснаараа шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлтэнд үр нөлөөтэй арга хэмжээ болсон гэж судлаачид үздэг байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн /2017/ 59 дүгээр зүйлд “Хуульд өөрөөр заагаагүй бол төлбөр төлөгчийн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэхийг хориглоно” хэмээн заасан байна.[195] Энэхүү зохицуулалтаар шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх эрхгүй болсон ба Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4-т заасан “шүүхийн шийдвэр

[193] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.,УБ., 2017.,Төрийн мэдээлэл эмхэтгэлийн №24., 93-р зүйл. 93.2 дахь заалт.
[194] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.2002 он. 133-р зүйл. 133.4.4.дэх заалт
[195] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.,УБ., 2017.,Төрийн мэдээлэл эмхэтгэлийн №24.. 59-р зүйл. 59.1 дэх заалт

гүйцэтгэх байгууллагын шийдвэр байгаа бол шийдвэрт заасан хугацаагаар түдгэлзүүлэх” зохицуулалт хүчин төгөлдөр хэвээр үйлчилсээр байжээ. Энэ хугацаанд төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх ажиллагааг хориглож, өмнөх хууль үйлчлэх үед гадаадад зорчих эрх түдгэлзүүлсэн “239,5



тэрбум төгрөгийн төлбөртэй Монгол Улсын 1569 төлбөр төлөгч, 20,5 тэрбум төгрөгийн төлбөртэй гадаад улсын 42 төлбөр төлөгчийн хилийн хоригийг цуцлах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдсан байна”.[196] Иймээс дахин хуульд 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулан одоогийн хэрэгжүүлж буй арга журмыг хуульчлан хэрэгжүүлэх болсон юм. Дээрх хуульд заасан үндэслэл бий болсноор мөнгөн төлбөр болон хөрөнгийн шинжтэй тодорхой үүргийг биелүүлэх хугацааг төлбөр төлөгчид тогтоож, биелүүлээгүй тохиолдолд үүсэх үр дагавар, холбогдох хуулийн зүйл, заалтыг тайлбарлан өгч мэдэгдэх хуудсаар мэдэгдэж ажиллахаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааг томъёолсон юм.

Хүснэгт: 3 “Журмын харьцуулсан байдал”

Дээрх хүснэгтээс харахад “Төлбөр авагч хүсэлт гаргасан бол үнийн дүн харгалзахгүй” түдгэлзүүлэх үндэслэл хасагдсан байна. Мөн одоогийн мөрдөгдөж буй журамд төлбөр төлөгч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас түдгэлзүүлсэн шийдвэрийг цуцлуулахаар хүсэлт гаргах, хүсэлтэд холбогдох баримт, нотлогоог хавсаргах талаар тодорхой зааж өгсөн байна.

[196] Шийдвэр гүйцэтгэх албаны 2018 оны тайлан.

Төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх үндэслэл болох шүүхийн шийдвэрт заасан мөнгөн төлбөрийн хэмжээ “Шүүхийн шийдвэр биелүүлэхээс санаатайгаар зайлсхийж байгаа төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх, сэргээх, хүлээн авах, тоо бүртгэл хөтлөх журам”-д /2012/ 5.000.000 төгрөг, “Шүүхийн шийдвэр биелүүлээгүй төлбөр төлөгчийн гадаадад зорчих цагаачлах эрхийг түдгэлзүүлэх, сэргээх, тоо бүртгэл хөтлөх журам”-д /2015/ журамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 40 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу тухайн үеийн дүнгээр 9.6 сая төгрөг, одоогийн хэрэгжиж буй журамд 50.000.000 төгрөгтэй тэнцэх хэмжээний төгрөг байхаар журамласан байгаа нь ихээхэн ялгаатай байдлыг илэрхийлж байна.

Мөн хүүхдийн тэтгэлэг төлөгч эхний 2 журамд мөн адил 6 сараас дээш хугацаагаар тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй, тэтгэлгийн хуримтлал 1.2-2.2 сая төгрөгийн хэмжээтэй тэнцэх, 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн журамд 2023 оны амьжиргааны баталгаажих доод түвшингийн хэмжээгээр бодоход 709.200-833.400 төгрөгийн хэмжээтэй тэнцэхээр бол гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх зохицуулалтай байжээ.

Төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх албадлагын арга хэмжээг гадаадын зарим орнууд хэрхэн авч, хэрэгжүүлдэг талаар харьцуулан судалбал:

“**Оросын холбооны улсын** гүйцэтгэх ажиллагааны тухай хууль” /2007 он/-[197]д Шийдвэр гүйцэтгэгчийн бүрэн эрхэд хариуцагчид хилийн хориг тавих эрхтэй бөгөөд хариуцагчийг Оросын холбооны Улсаас гарч түр хугацаагаар явахыг хязгаарлах хэмээн 67 дугаар зүйлд тусгаж албадлагын арга хэмжээг хуульд зааснаар болон шүүхийн шийдвэрийг үндэслэн хэрэгжүүлдэг байна.

1. Шүүхийн шийдвэрийн үндсэн дээр гаргасан гүйцэтгэх баримт бичиг болон гүйцэтгэх баримтын шинжтэй шүүхийн шийдвэрт заасан шаардлагуудыг хариуцагч тогтоосон хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь өөрийн санаачлагаар буюу нэхэмжлэгчийн хүсэлтээр Оросын Холбооны Улсаас гарч явахыг түр хязгаарлах тухай тогтоол гаргах эрхтэй[198] гэжээ. Үүнээс үзэхэд Оросын холбооны улсын хувьд хариуцагч буюу төлбөр төлөгч шүүхийн шийдвэрт заасан нэхэмжлэлийн шаардлагыг тогтоосон хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй бол шийдвэр гүйцэтгэгч нь өөрийн санаачилгаар болон төлбөр нэхэмжлэгчийн хүсэлтээр Оросын холбооны улсаас гарч явахыг түр хязгаарлах тухай тогтоол гаргах эрхтэйгээр хуульчлагдсан нь төлбөрийн үнийн дүн хязгаарлаагүй төдийгүй

[197] Оросын холбооны улсын гүйцэтгэх ажиллагааны тухай хууль.,2007., 67-р зүйл., Монгол, Орос, Солонгос улсын шийдвэр гүйцэтгэлийн хуулиудын эмхэтгэл., 59 дахь тал.
[198] Оросын холбооны улсын гүйцэтгэх ажиллагааны тухай хууль.,2007., 67-р зүйл., Монгол, Орос, Солонгос улсын шийдвэр гүйцэтгэлийн хуулиудын эмхэтгэл., 59 дахь тал.


шүүхийн шийдвэр заасан мөнгөн бус хэлбэрээр гаргасан шаардлага буюу нэхэмжлэлийн хувьд гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх боломжтой байна. Гадаадад хувийн хэргээр зорчих эрхийг түдзгэлзүүлэхэд тус улсад хэр удаан байх ёстойг яг таг тогтоох боломжгүй, хугацааг тодорхойлох нь түүний төрөл, шалтгаанаас шалтгаалдаг тул зөвхөн хувь хүний асуудал юм. Тус улсын хууль тогтоомжид нөхцөл байдал бүрт заасан тодорхой хугацаа байдаггүй бөгөөд үүнийг шүүх эсвэл шүүхийн шийдвэр гүйцэтгэгч тогтоож, тогтоосон хугацааны хоригийг баримт бичигт тусгайлан заасан байдаг. 2008.01.29-ний өдрийн "Өртэй этгээдийг ОХУ-аас гарахыг түр хугацаагаар хязгаарлах тухай журам"-ын 2.3 дахь хэсэгт заасны дагуу "Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай" Холбооны хуульд[199] зааснаар “шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид 6 сарын хугацаанд өртэй улсын нутаг дэвсгэрээс гарахыг хязгаарлах талаар шийдвэр гаргаж болно” гэж заасан байна. Энэ хугацаанд төлбөр төлөгч нь мөнгөн төлбөр болон хөрөнгийн шинжтэй шаардлагыг биелүүлэх эсвэл дараагийн арга хэмжээ буюу шийтгэгддэг буюу та өрийг бүрэн төлөх хугацаатай байх болно, гэхдээ хэрэв үгүй бол хэргийг хянаж, шинэ шийдвэр гаргах ёстой[200] гэх зарчим шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хэрэгждэг ажээ. Харин манай улсын хувьд төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэхдээ ямар нэгэн хугацаа заасан ойлголт байхгүй байна.

Оросын Холбооны улсад төлбөр төлөгч өөрийнхөө гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлсэн эсэхийг мэдэх эрх нь нээлттэй байдаг. Төлбөр төлөгч нь цахим сангаас өөрийн мэдээллийг харах боломжтой байгаа нь төлбөр төлөгчид санхүүгийн хүндрэл учруулах цаашлаад шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг төлбөрт орох эрсдэлээс давхар сэргийлэх зорилготойгоор хэрэгжүүлдэг байна.

Гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлсэн эсэхийг цахимаас дараах байдлаар татаж шалгах боломжтой байдаг.

1. Үндсэн цэснээс "Үйлчилгээ" -г сонгоно.
2. "Банк" хэсэгт очиж, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дээр дарна .
3. Хайлтын аргыг сонгоно (IP дугаар, ID, хувь хүн эсвэл хуулийн этгээд).
4. Байгууллага бол нэр, хаяг, овог нэр, төрсөн огноог бичээд "хайх" товчийг дарна.

[199] Оросын холбооны улсын гүйцэтгэх ажиллагааны тухай хууль.,2007., 67-р зүйл., Монгол, Орос, Солонгос улсын шийдвэр гүйцэтгэлийн хуулиудын эмхэтгэл., 59 дахь тал.
[200] Как поехать за границу если приставы закрыли выезд (2023). www.youtube.com Үзсэн: 03.30.2023.,



/ Зураг: 1,2. ОХУ-ын шүүхийн шийдвэр гүйцэтгэгчдийн вэбсайт /

Уг систем нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дэлгэрэнгүй мэдээлэл, мөн эхлэх, дуусах хугацааг харуулдаг байна. Хэрэв та ямар нэгэн өр төлбөртэй байж, таны хилээр гарах эрхийг хориглосон эсвэл хориглох үндэслэлүүд арилсан ч таны хилээр гарах эрх сэргээгдээгүй байгааг харах боломжтой юм.[201]

Манай Улсын хувьд Шийдвэр гүйцэтгэх албаны цахим хуудас 2021 онд шинэчлэгдэж дуудлага худалдаа, эрэн сурвалжлагдаж буй төлбөр төлөгч, цаг үеийн мэдээ, мэдээллийг байршуулсаны зэрэгцээ шийдвэр гүйцэтгэгчдийн өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэгдэх эрх зүйн акт, тогтоолын маягтын загвар, сургалтын гарын авлага зэрэг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны мэдээллийг нээлтэй ил тод шуурхай хүргэдэг боловч Оросын Холбооны Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэгчдийн вэбсайттай харьцуулахад төлбөр төлөгч болон өмнө нь төлбөр төлөгч байсан этгээд нь хилийн хоригтой эсэхээ мэдэх боломжгүйгээс үүдэж ямар нэгэн байдлаар хохирч эргээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас учирсан хохирлоо нэхэмжлэх тохиолдол нилээдгүй байдаг билээ. Монгол улсын хэмжээнд 2018 онд программ хангамжийн шинэчилсэн хувилбарыг боловсруулж, 2014 оноос хойш үйл ажиллагаанд ашиглагдаж байсан “Шийдвэр гүйцэтгэлийн бүртгэлийн систем”-д бүртгэгдсэн мэдээллээр шинэ цахим сан үүсгэсэн “талууд” системээс шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүхэлд нь хянах[202]

---

[201] Жишээ №1:

ОХУ-ын цахим сайт мэдээллийн хэрэгслүүдээр “Улсаас гарахыг хориглосон эсэхийг шалгаж болно. Гадаадад аялахыг зөвшөөрсөн эсэхийг яаж мэдэх вэ. Тасалбарын мөнгө зарцуулагдсан хэрнээ өртэй байвал яах вэ?” зэрэг гарчиг бүхий нийтлэл хэд хэд харагдсан тул судлаас би сонирхон уншиж үзлээ. Ерөнхий гол утга санаа нь ямар тохиолдолд “ОХУ- аас гарахыг хязгаарладаг” талаар тайлбарласан ба тэдгээрийн аль ч тохиолдолд тухайн хил давах гэж этгээдэд тохиолдлож болохуйц зардал тийз, аялалын багц, зочид буудал, машин түрээсний зардал урьдчилан гарах алдагдалаас сэргийлэх боломжтой гэдгийг харуулсан байна. Холбооны шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба (fssp russia). Гэх албан ёсны цахим сайтаас оршин суугаа газар, болон төрсөн огноо, нэр рд зэргээ оруулан дараа нь хайлт дээр дарж улсын хилээр чөлөөтэй зорчих эрхийг ямар хугацаатай түдгэлзүүлсэн талаар мэдээлэл өгдөг байна.
https://el-in.ru/mn/investicii/otchet-po-proizvodstvennoi-praktike-v-fssp-otchet-po-praktike.html

[202] Иргэн, захиргаа болон зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлт., УБ., 2018., 4 дэх тал.

боложтой байдаг бөгөөд үүнээс төлбөр төлөгч гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлсэн, сэргээгдээгүй байгааг мэдэх боломжтой юм.

Энэ нь талуудын тэгш эрхийг хангах мэдээлэл хүргэх, үйл ажиллагааг шуурхай явуулах зорилготой гүйцэтгэх баримт бичгийг цахим сангаас харах боломж боловч тус санд талууд нэвтрэх эрх, нууц үг олгогдож нэвтэрнэ. Энэ нь зарим тохиололд буюу ОХУ-ын туршлагатай харьцуулахад хязгаарлагдмал эх сурвалж аж.

Харин **Бүгд найрамдах солонгос улсын** Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуульд төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх асуудлыг тусгайлан зохицуулаагүй, энэ нь шийдвэр гүйцэтгэгч шүүхийн харьяанд үйл ажиллагаа явуулдагтай холбоотой бөгөөд “Хэрэв өр төлбөртэй этгээд хилийн чанадад байгаа буюу байгаа газар нь мэдэгдэхгүй тохиолдолд гүйцэтгэлийн ажиллагаатай холбоотой мэдэгдлийг хүргүүлэхгүй байж болно[203] гэж заажээ. Мөн "Гүйцэтгэх ажиллагааны явцад гадаад улсад мэдэгдэл хүргэх бол мэдэгдэлтэй хамт нэгэн зэрэг шүүхийн захирамж гаргаж, мэдэгдлийг БНСУ-д хүлээн авах газар, хүлээн авагчийг тайлагнах боломжит хугацааг тогтооно. Энэ хугацаанд тайлан ирээгүй бол аливаа нэмэгдэл мэдэгдлийг хүргүүлэхгүй байж болно” [204] гэжээ. Үүнээс үзэхэд төлбөр төлөгч гадаад улсад зорчсон эсэхээс үл хамаарч хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагааг тасралтгүй явуулах боломжтой нь давуу тал болж буй юм.

Манай улсын хувьд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний үндсэн дээр гадаадад шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах буюу төлбөр төлөгч-иргэн хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан нь өөр оронд зорчиж, хаягийн бүртгэл байхгүйгээс ажиллагаа явуулах эрх зүйн зохицуулалт тун хомс шүүхийн шийдвэрийг хэрхэн биелүүлэх нь тодорхойгүй байна.

Бүгд найрамдах Хятад ард улсын хувьд Хилийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу гадаад зорчих эрхийг түдгэлзүүлдэг бөгөөд иргэний хэрэг дуусгавар болоогүй тохиолдолд зөвхөн шүүхийн шийдвэрээр гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлдэг байна. Тус улсад “Social credit score” системээр үнэлдэг бөгөөд манай улсын адил мөнгөн шаардлага, үнийн дүн өндөр иргэдийг нэг жил хүртэлх хугацаанд зорчихыг хориглодог. Эдгээр улс орнуудын нийгмийн хөгжил, улс төр, эдийн засгийн байдал бас бус зүйлээс хамааран өөр өөр хэрэгждэг байна.

---

[203] БНСУ-ын Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль. 2002., Монгол, Орос, Солонгос улсын шийдвэр гүйцэтгэлийн хуулиудын эмхэтгэл., 59 дахь тал.
[204] Мөн тэнд.,

Швейцарь улс шүүхийн шийдвэрийг эсэргүүцсэн эсвэл оргон зугтах эрсдэлтэй гэх мэт хэд хэдэн үндэслэлээр зээлдэгчийн тус эрхийг түдгэлзүүлэхийг зөвшөөрдөг.

Ливан улсад зорчихыг хориглох /travel ban хэмээгддэг/ нь эсэргүүцлийн жагсаал зэрэг онц байдал бий болсон үед тус улсын төв банкнаас гарах мөнгөний урсгал, ихээхэн хэмжээний хөрөнгийн шинжтэй шаардлагаас гадна хилийн хориг хэт улс төрийн шинжтэй арга хэмжээний нэг ажээ.

Эдгээрээс үзэхэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд талууд нь аль болох зөвшилцөлд хүрэх, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр заавал биелэгдэх зэрэг зарчмын хэрэгжилт шийдвэрийн биелэлт хүртэл тодорхой цаг хугацааг хамарч, нэг нь нөгөөтэйгээ нөхцөлдсөн тодорхой үр дүнд чиглэсэн цогц ажиллагаа болох ёстой харагдаж байна.


Улсын хэмжээнд 50,0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 1.6 их наяд төгрөгийн төлбөртэй 2533 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаагаас 124.9 тэрбум төгрөгийн төлбөртэй 86 төлбөр төлөгч нэвтэрч шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас зайлсхийсэн үйлдэл, эс үйлдэхүй гаргасан байна. Нийт хүүхдийн тэтгэлгийн мөнгийг 46.2 хувь буюу 5223 гүйцэтгэх баримт бичигт холбогдох тэтгэлэг төлөгч хүүхдийн тэтгэлгийн мөнгийг сар бүр төлөөгүй, зайлсхийсэн үйлдлийг тус тус гаргасан байна. [205] Үүнээс үзэхэд хүүхдийн тэтгэлгээ 3 сараас дээш хугацаагаар төлөөгүй тэтгэлэг төлөгчийн гадаад зорчих эрхийг түдгэлзүүлэх үндэслэлийг мөнгөн дүнгээр бодвол 2023 оны хүн амын амьжиргааны баталгаажих доод түвшингийн хэмжээ Улаанбаатар хотод 100 хувь нь 313.400 төгрөг хэмээн тооцоолоход 4 сар хүүхдийн тэтгэлэг төлөөгүй гэж бодоход 1.253.600 төгрөг, төвийн бүсийн хэмжээнд 100 хувь нь 272.300 төгрөг гэхэд 4 сарын тэтгэлэг 1.089.200 төгрөг зүүн бүсийн хэмжээнд 100 хувь 271.800 төгрөг гэхэд 4 сарын хүүхдийн тэтгэлэг 1.087.200 болж байна. Тэтгүүлэгч хүүхэд 11 насанд хүрээгүй бол Улаанбаатар хотод 626.800 төгрөг, төвийн бүсэд 544.600 төгрөг төлөөгүй байхад гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлж болохоор байгааг харж болно.

Шийдвэр гүйцэтгэгч нараас “Төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар болон хэрэгжилтэнд тулгамдаж буй зарим асуудлыг тодорхойлох, түүний шийдлийг эрэлхийлэх зорилгоор судалгаа авсан бөгөөд судалгаанаас дараах үр дүнг харж болно.

---


[205] С.Бямба-Эрдэнэ., Гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх эрх зүйн зохицуулалтын зарим асуудал.,УБ., 2021., Иргэн захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн шинэтгэл илтгэлийн эмхэтгэлийн 266 дахь тал.


Асуулт 1: Төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх үндэслэл буюу 50 саяаас дээш төлбөрийн шаардлага орон нутаг болон нийслэлийн хэмжээнд хэр ялгаатай байгааг судалгаанд оролцогч нараар тодорхойлуулахад:



Хариулт 1: Судалгаанд нийт 70 шийдвэр гүйцэтгэгч оролцсоны 15 нь буюу 21.4% орон нутгийн харьяаллын, 55 нь буюу 78,6% нь нийслэлд харьяалагдах ба орон нутгийн нэгжид дээрх үндэслэлд хүрэх мөнгөн дүнгийн шаардлага бага гэх таамаглал дэвшүүлсэн болно.


Асуулт 2: Гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх ажиллагааг хэрэгжүүлж буй субьектуудын ажлын ачаалал хэр байна вэ? Үүнээс хэдэн гүйцэтгэх баримт бичигт тус албадлагын арга хэмжээг хэрэгжүүлсэн бэ?






Хариулт 2: Судалгаанд оролцогчдын 32% буюу 1 шийдвэр гүйцэтгэгчид ойролцоогоор 100-150 гүйцэтгэх баримт бичиг, гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх ажиллагаа явуулаагүй" 52.9% буюу 1 шийдвэр гүйцэтгэгчид дунджаар 15 хүртэлх гүйцэтгэх баримт бичгийн мөнгөн дүн 50 саяас дээш буюу үлдсэн талаас илүү гүйцэтгэх баримт бичигт энэхүү ажиллагааг гүйцэтгэхгүй аж. Ажиллагаанд байгаа гүйцэтгэх баримт бичгийн тоо болон тус албадлагын арга хэмжээг хэрэгжүүлж буй тоо нь ихээхэн ялгаатай бага байгаа нь 50.0 сая төгрөг ба түүнээс дээш хөрөнгийн шаардлага бүхий гүйцэтгэх баримт бичиг гэж оруулж өгсөн нь харьцангуй зохицуулалт гэж үзэхээр байна.

Асуулт 8: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр 50 саяаас дээш төгрөгийн төлбөртэй этгээдийн гадаадад зорчих эрхийг хязгаарлахаар зохицуулсан нь хэр оновчтой вэ?



Хариулт 8: Нийт оролцогчдын 51.4% буюу 36 шийдвэр гүйцэтгэгч нь үнийн дүнг багасгах шаардлагатай 42,9% буюу 30 шийдвэр гүйцэтгэгч нь үнийн дүнг 50 саяаас дээш гэж тогтоосон нь оновчтой 5,7% буюу 4 шийдвэр гүйцэтгэгч гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх шаардлагагүй, үнийн дүнг ихсгэх шаардлагатай гэж үзсэн байна.

Асуулт 7: Хүүхдийн тэтгэлгийг 3 сараас дээш хугацаагаар төлөөгүй тэтгэлэг төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлж байгаа нь хэр оновчтой зохицуулалт гэж үзэж байна вэ?



Хариулт 7: Нийт оролцогчдын 75% буюу 53 нь оновчтой, 10% буюу 7 шийдвэр гүйцэтгэгч нь эрхзүйн зохицуулалтыг өөрчлөх шаардлагатай, 8,6% буюу 6 шийдвэр гүйцэтгэгч нь оновчтой зохицуулалт гэж үзсэн байна.

Төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх үндэслэл, түүнийг өөрчлөх талаар санал байна уу? Хэмээн нээлттэй хариулах хэсэгт шийдвэр гүйцэтгэгчид өөр өөрийн саналаа үлдээсэн байна. Үүнд:

- Тогтоосон хугацаанд төлбөрийг төлөхгүй, биелүүлэхээс санаатай залсхийж байгаа тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч мөнгөн дүн хамаарахгүйгээр гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх саналыг гаргадаг байх нь оновчтой.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг 50 саяаас дээш төгрөгийн төлбөртэй этгээдийн эрхийг түдгэлзүүлэх үндэслэлийг 20 саяаас дээш мөнгөн дүнтэй тэнцэх хэмжээний төлбөртэй этгээдийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх, Хүүхдийн тэтгэлгийн 3 сараас дээш гэх хугацааг 6 сараас дээш болгох зохицуулалт шаардлагатай.

- Төлбөр төлөгчийн хувийн байдлыг харгалзан үзэж гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх үндэслэлийг уян хатан болгох ба сэргээх үндэслэл байгаа бол батлан даагч оролцуулан оргон зайлахаас сэргийлэх

- Түдгэлзүүлэхгүйгээр гадагш явуулснаараа төлбөр төлөгчийн төлбөрийн чадвартай болгоно гэж үзээд гадаадад байгаа төлбөр төлөгчид ажиллагаа явуулах эрхзүйн зохицуулалтыг боловсронгуй болгох

- Хүүхдийн тэтгэлэг төлөгчийн хуримтлагдсан төлбөр буюу мөнгөн дүнгээс хамааран түдгэлзүүлэх нь оновчтой, хэрвээ тогтмол төлж байгаа тэтгэлэг төлөгч гадагш гарах бол 6 сарын тэтгэмжээ урьдчилан төлөх талаар нэмж зохицуулах шаардлагатай.

- Төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх үндэслийг нэмэх шаардлагатай, Хил хаасан, нээсэн даруйд шийдвэр гүйцэтгэгчид шууд мэдэгдэх

- Төлбөр төлөгчийн эд хөрөнгө, орлогыг бүрэн тогтоох шаардлагатай үл хөдлөх хөрөнгөөр баталгаа гаргаад түр хугацаагаар хилийн хоригийг нээдэг байвал төлбөр төлөх боломж илүү бүрдэх байх, төлбөр төлөгч гадаадад гарсан тохиолдолд гүйцэтгэх баримт бичгийг түдгэлзүүлэхгүйгээр төлбөр төлөгчийг албадан авчирах, эрэн сурвалжлах ажиллагааг сайжруулах гэх мэтээр төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч талаар шийдвэр гүйцэтгэгч нар өөр өөрийн саналаа илэрхийлсэн байгаа юм. Зарим нэг утгаараа тус саналууд нь хэт нэг талыг баримталсан байж болзошгүй.

Дүгнэлт

Олон улсын хэмжээнд нийгэм, цаг үе өөрчлөгдөхийн хэрээр нарийн төвөгтэй хэвээр байсаар байгаа хүний аялал жуулчлал, цагаачлах, гадаадад хувийн хэргээр зорчих эрхийг хязгаарлах тэр дундаа өртэй этгээд буюу төлбөр төлөгчийн эрхийн хязгаарлалт нь ихээхэн өргөн цар хүрээг хамарсан асуудал билээ.

“Монгол Улсын иргэдийн чөлөөтэй зорчих, оршин суух газраа сонгох эрхийг Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 18 дахь хэсэгт заасан нь хүний хувийн эрх чөлөөний нэг чухал хэлбэр бөгөөд хүн бүрт өөрийн аж амьдралаа аятай таатай зохион байгуулах, оюун санаагаа хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой эрх чөлөө”[206] бөгөөд үүнийг хязгаарлаж буй үндэслэлүүдээс “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу гадаадад хувийн хэргээр зорчих цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр байгаа бол шийдвэр заасан хугацаагаар түдгэлзүүлнэ”[207] гэж тусгасан зохицуулалт нь олон улсын эрх зүйн суурь хэм хэмжээгээр нийгмийн ёс суртахуун, дэг журмыг алдагдуулсан үндэсний аюулгүй байдалд харшилсан, бусдын эрхэнд халдсан зэрэг хүний эрхийг хязгаарлах стандартад нийцэж буйд маргах зүйл үгүй билээ гэвч хүний эрхийг хязгаарлах үндсэн буюу “түр зуурын шинжтэй, тэнцвэртэй байх” зарчимын агуулгыг шингээсэн төдий зохицуулалт өнөөгийн хэрэгжилт тулгамдаж байна хэмээн үзэж байна.

---

[206] Совд.Г ... нар., УБ.,2000.,Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар.,125 дахь тал.

[207] Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих цагаачлах тухай хууль., УБ.,1993., Төрийн мэдээдэл эмхэтгэлийн №2.,

Энэ нь хязгаарлалт тогтоосон хууль тогтоомжид хамаарааd зогсохгүй мөн хуулийг хэрэгжүүлж байгаа субьектүүдын үйл ажиллагаанаас харагдаж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуульд төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх хугацаа заагаагүй нь цаашлаад төлбөр төлөгчийн эрх зүйн хариуцлагын асуудалтай холбогдох ба хөрөнгийн шаардлага тавин сая төгрөгийн үнийн дүн, хугацааны хувьд тэжээн тэтгэх үүргээ гурван сараас дээш хугацаагаар биелүүлээгүй гэх нөхцөлд эрэн сурвалжлагдаж байгаа, эсхүл төлбөр төлөхөөс санаатай зайлсхийсэн, хөрөнгөө нуун дарагдуулсан, төлбөр төлөхөөс зайлсхийх зорилгоор гадаад улсад оргон зайлж болзошгүй зэрэг үндэслэл байгаа нь харьцангуй тэгш бус хэрэгжилтээр илэрч байна.

Санал

1. Талууд программыг сайжруулж, мэдээллийн технологийг боловсронгуй болгох. Нэгдсэн санг илүү хүртээмжтэй байдлаар бий болгох буюу төлбөр төлөгчийн түдгэлзүүлсэн гадаадад зорчих эрх сэргээгдэхгүй байх механик алдаанаас сэргийлэх, энэ нь эргээд тус хориг арга хэмжээний сөрөг үр дагавраас сэргийлэх боломжтой.
2. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээг сайжруулан шийдвэр гүйцэтгэх ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх

Ингэснээр төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэхгүйгээр гадаад дахь орлогоос төлбөр төлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх

3. Төлбөр төлөгч төлбөр төлөхөөс санаатай зайлсхийсэн, хөрөнгө, орлогоо нуун дарагдуулсан эсэх үндэслэлээр санал гаргаж байгаа тохиолдолд төлбөр төлөгчийн хаягандаа оршин суудаггүй, хаягаа өөрчилсөн боловч шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэх үүргээ хэрэгжүүлээгүй, эд хөрөнгийн мэдүүлэг хуулийн хугацаанд гаргаагүй, худал мэдүүлсэн, тогтоох, баримтжуулах талаарх арга журмыг нарийвчлан тогтоож өгөх Шийдвэр гүйцэтгэх газар хэлтэс бүр өөр өөрөөр хэрэгжүүлэх, цаашлаад шийдвэр гүйцэтгэгч бүр өөр өөрөөр тодорхойлох явдал түгээмэл байгааг халах

4. Төлбөр төлөгчид түүний гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх талаар мэдэгдэх, ямар үндэслэлээр санал оруулж буйгаа тодорхой тусгах, Ерөнхий шийдвэр гүйцэтгэгчийн тогтоол гармагц төлбөр төлөгчид танилцуулж баримтжуулах зэрэг ажиллагааг цаг алдалгүй хийж гүйцэтгэх шаардлагатай.

5. Төлбөр төлөгчийн төлбөрийн шаардлага 50 сая болон хүүхдийн тэтгэлэг төлөгчийн төлбөрийн шаардлага хоорондын зөрүү 50 дахин ялгаатай байгаа ялгаатай байдлыг арилгах нь хүн бүр хууль шүүхийн өмнө тэгш эрхтэй байх эрхийг хангахад тустай.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

Нэг. Хууль, тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.
2. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль. 1993 он.
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хууль. 2002 он.
4. Монгол Улсын Шүүхий шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017 он.
5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017 он.
6. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль. 2017 он.
7. Компанийн тухай хууль. 2011 он.
8. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль. 2010 он.
9. Гүйцэтгэх ажиллагааны тухай Холбооны хууль. 2007 он.
10. БНСУ-ын Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль. 2002 он.
11. “Шүүхийн шийдвэр биелүүлэхээс санаатайгаар зайлсхийж байгаа төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх, сэргээх, хүлээн авах, тоо бүртгэл хөтлөх журам" ШШГЕГазрын даргын 2012 оны 5-р сарын 09-ний өдрийн А/62.
12. "Шүүхийн шийдвэр биелүүлээгүй төлбөр төлөгчийн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх, сэргээх, бүртгэл хөтлөх журам” ШШГЕГазрын даргын 2015 оны 4-р сарын 28-ны өдрийн А/199
13. "Шүүхийн шийдвэр биелүүлээгүй төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх, сэргээх, бүртгэл хөтлөх журам” ШШГЕГазрын даргын 2020 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн А/80

Хоёр. Ном, Сурах бичиг

1. Г. Совд, Н. Жанцан, Ж. Амарсанаа, С.Жанцан “ Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар толь”. 2000 он. Улаанбаатар хот
2. Сэнгэдорж.Т “Хууль зүйн шинжлэх ухааны судалгааны арга зүй”.2001 он. Улаанбаатар хот
3. Дашзэвэг.Б Монгол “Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй”.2003 он. Улаанбаатар хот
4. Нарангэрэл.С “Монголын эрх зүйн англи, орос, латин хадмал эх толь бичиг", УБ., 2015 он, дөрөв дэх хэвлэлт
5. Jérémiee Gilbert, Nomadic Peoples and Human Rights. 2014. USA

---o0o---

ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮРЭЛЦЭЭ БА ОРОН НУТГИЙН БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦООНЫ УРВУУ ХАМААРАЛ

GARDEN ACCESS AND LOCAL ORGANIZATION INVERSE RELATION OF PARTICIPATION



М.Маралмаа
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 521 дүгээр дамжааны дэд түрүүч

Товч утга: Монгол улсын цэцэрлэгийн насны буюу 2-5 насны бүх хүүхэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдах эрхтэй. Гэтэл улсын хэмжээнд хот, орон нутаг гэлтгүй цэцэрлэгийн барилга байгууламж хомс, багшлах хүчин дутагдалтай зэрэг шалтгаануудын улмаас хүүхэд бүр цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байна. Тиймээс цэцэрлэгийн хүрэлцээг нэмэгдүүлэхэд орон нутгийн байгууллагын оролцоо хэр чухал үүрэг гүйцэтгэдгийг энэхүү илтгэлээрээ харуулахыг зорьсон.

Түлхүүр үгс: Сурч боловсрох эрх, суурь боловсрол, эцэг эх, асран хамгаалагч, багш боловсон хүчин, барилга байгууламж, улсын төсөв, орон нутгийн төсөв, цэцэрлэгийн насны хүүхдийн тоо, цэцэрлэгийн тоо.

Abstract: All children of kindergarten age or 2-5 years of age in Mongolia have the right to participate in pre-school education services. However, not every child can attend kindergarten due to reasons such as lack of kindergarten facilities and lack of teaching staff, both in cities and rural areas. Therefore, this report aims to show how important the participation of local organizations is in increasing the availability of kindergartens.

Keywords: Right to education, basic education, parents, guardians, teaching staff, buildings, state budget, local budget, number of kindergarten age children, number of kindergartens.

Хүүхэд гэдэг улс орны ирээдүй бөгөөд бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих, сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх тухай асуудал нь нэлээдгүй чухал сэдэв юм. Тэгвэл бага насны хүүхэд бүр буюу Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 2 дугаар бүлгийн 7 дугаар зүйлийн 7.1 -т зааснаар хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны бүх хүүхдүүд нь Монгол улсын

үндсэн хуулийн 1 дүгээр бүлгийн 6 дугаар зүйлийн 6.1-т зааснаар бүх шатны боловсролыг хуульд заасан нөхцөл, журмын дагуу төлбөргүй буюу төлбөртэйгээр сурч эзэмших эрхтэй төдийгүй уг хуулийн 6.3-т зааснаар суурь боловсрол заавал эзэмших үүрэгтэй гэж заасан байдаг.

Гэтэл Монгол улсын хэмжээнд цэцэрлэгийн насны буюу 2-5 насны хүүхдүүд бүгд 100 хувь цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа нь сургуулийн өмнөх боловсролын байгууллага буюу цэцэрлэгийн хүрэлцээ дутмаг байгаатай холбоотой юм. Үүнд цэцэрлэгийн барилга байгууламж хомс, төсөв, санхүү дутагдалтай, багшлах боловсон хүчин хангалттай биш зэрэг олон олон асуудлууд хамаарна. Нийслэлийн хэмжээнд гэхэд хүн амын төвлөрөл ихтэй учраас цэцэрлэгийн насны хүүхдүүд их. Гэтэл тэдгээр хүүхдүүдийг бүгдийг нь хамруулах цэцэрлэг хангалтгүй бөгөөд үйл ажиллагаа явуулж байгаа цэцэрлэгүүд нь дийлэнхдээ багтаамжаасаа хэтэрсэн олон хүүхэдтэй буюу нэг ангид дунджаар 20-25 хүүхэд байх ёстой байтал 40-45 хүүхэд суралцдаг байна. Мэдээж багтаамжаасаа хэтэрсэн хүүхэдтэй байх нь багшийн ачааллыг нэмэгдүүлэхээс гадна орон зайн хувьд давчуу, хоол хүнс, ор дэр, тоглоомын хүрэлцээ дутах, хүүхэд бүрийг нэг бүрчлэн тав тухтай орчинд хөгжүүлэх зэрэгт сөргөөр нөлөөлдөг. Үүнээс авч үзвэл цэцэрлэгт хамрагдаж, сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байгаа хүүхдүүдийн Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан эрх төдийлөн хангагдаж чаддаггүй гэж хэлэхэд дэгсдэхгүй болов уу. Харин үүний нөгөө талд цэцэрлэгт огт хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүдийн эрхийг хэрхэн хангах, энэ чиг үүргийг хэн хэрэгжүүлэх ёстой вэ? Гэдэг асуулт бидний өмнө тулгарсан.

Тэгэхээр сургуулийн өмнөх боловсролыг эзэмшиж чадахгүй байгаа буюу цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүдийн сурч боловсрох эрх төдийгүй хамгаалуулах эрх нь зөрчигдөх тохиолдол цөөнгүй байна. Түүнчлэн хүүхдээ цэцэрлэгт хамруулж чадахгүй байгаа эцэг эхчүүдэд ажлаа хийхэд бэрхшээлтэй зарим тохиолдолд ажлаасаа гарах, эсхүл хүүхдээ гэрт нь цоожилж үлдээх, айлд орхих, ажилдаа дагуулж явах зэрэг түгээмэл хүндрэлүүд учирдаг байна. Ингэхлээр хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох эрхүүд нь зөрчигддөг билээ.

Нийслэлийн хэмжээнд төдийгүй орон нутагт ч мөн ялгаагүй цэцэрлэгийн хүрэлцээ муу байгаа бөгөөд эцэг эхчүүд хүүхдээ цэцэрлэгт хамруулахын тулд намар болгон харьяа дүүргийнхээ цэцэрлэгийн үүдэнд хэдэн өдрөөр оочирлодог. Гэсэн ч оочирлосон болгон хүүхдээ цэцэрлэгт хамруулж чаддаггүй бөгөөд жил бүр л энэ талаарх мэдээ мэдээлэл телевиз бүрийн мэдээллийн хөтөлбөрөөр гарч, мэдээллийн сайт болгоноор цацагддаг билээ. Хүүхдийн цэцэрлэг нь улсын төсөв болон орон нутгийн төсвөөс бүрддэг бөгөөд харьяа нутаг дэвсгэр, засаг захиргаа нэгжийн засаг дарга нар энэ талаар хэрэгжүүлэх чиг үүргийнхээ хүрээнд энэ талаарх асуудлыг шийдвэрлэх, гарц гаргалгааг олох үүрэгтэй билээ.

Тэгвэл орон нутгийн байгууллагууд хүүхдийн дээрх сурч боловсрох эрхийг хэрхэн хангах ёстой гэдэг талаар энэхүү илтгэлээрээ хөндөхийг зорьлоо.

Хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах талаар баталгаажуулсан хууль тогтоомжууд: Хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах, хамгаалах, түүнийг зохион байгуулах чиг үүрийн талаар олон улсын хийгээд үндэсний хууль тогтоомжид хэрхэн тусгасан байдаг талаар авч үзье.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 26 дугаар зүйлд хүн бүр сурч боловсрох эрхтэй. Наад зах нь анхан шатны болон ерөнхий боловсрол үнэ төлбөргүй байвал зохино. Анхан шатны боловсролыг заавал эзэмшүүлэх ёстой. Анхан шатны боловсрол гэдэг нь боловсролын эхний үе шатанд хэрэглэгддэг. Энэ нь сургуулийн өмнөх боловсролын тухай буюу өөрөөр хэлбэл, бага боловсролоос өмнө явагддаг сургалтын мөчлөг буюу цэцэрлэгийн үйл явц юм[208].

Монгол Улсын Үндсэн хуулийн[209] 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсэгт заасан сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно;

Хүүхдийн эрхийн тухай хуулийн[210] 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх хэсэгт зааснаар хүүхэд бага, суурь, бүрэн дунд боловсролыг үнэ төлбөргүй эзэмших эрхтэй;

Боловсролын тухай хуулийн хуулийн[211] 6 дугаар зүйлийн 6.3-д зааснаар Монгол Улсын иргэн суурь боловсрол заавал эзэмших үүрэгтэй;

Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн[212] 8 дугаар зүйлийн 8.3-т зааснаар цэцэрлэг нь сургуульд элсэхийн өмнөх насны бүх хүүхдэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хүргэж, сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана;

Хүүхэд хамгаллын тухай хуулийн[213] 23 дугаар зүйлийн 23.2 дахь заалтад “”Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга хүүхэд хамгаллын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор хүүхэд хамгаллын хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажил, үйлчилгээний зардал, нийгмийн ажилтны урамшууллыг улс болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлнэ”;

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн[214] 16 дугаар зүйлийн 16.3-т зааснаар аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийн

---

[208] “Оюутнуудын тухай бүх зүйл” Сурталчилгааны нийтлэлүүд 2023 он.
[209] Монгол Улсын Үндсэн хууль. Уб., 1992. Төрийн мэдээлэл эмхэтгэл №1.
[210] Хүүхдийн эрхийн тухай хууль. Уб., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл №9.
[211] Боловсролын тухай хууль. Уб., 2002. Төрийн мэдээлэл эмхэтгэл №19.
[212] Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль. Уб., 2008. Төрийн мэдээлэл эмхэтгэл №21.
[213] Хүүхэд хамгаллын тухай хууль. Уб., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл №9.
[214] Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль. Уб., 2021. Төрийн мэдээлэл эмхэтгэл №7.

хөрөнгийг энэ хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулна гэж заасан байдаг буюу уг чиг үүрэгт нь сургуулийн өмнөх боловсролын талаарх үйл ажиллагааг хангах чиглэл тусгагдсан байдаг юм[215].

Хүүхдийн сурч боловсрох эрхийн талаар дээр дурдсанчлан олон улсын гэрээ, конвенц, хууль, дүрэм журмуудад тусгагдаж эрх зүйн орчин нь баталгаажуулсан байгаа хэдий ч хэрэгжилт нь төдийлөн хангалттай байхгүй байна гэж судлаач оюутны зүгээс харж байна.

Хүүхдийн эрхийг хангахад орон нутгийн байгууллагуудын оролцоо: Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах чиг үүргийг эцэг, эх, асран хамгаалагч, боловсролын байгууллагын ажилтан, албан хаагчаас гадна засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, эрх бүхий албан тушаалтан ч тодорхой чиг үүрэгтэй оролцдог. Энэхүү чиг үүргийг холбогдох хууль, тогтоомжид хэрхэн тусгасан байдаг талаар авч үзье.

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хуулийн 20 дугаар зүйлд орон нутгийн чиг үүрэгт хамаарах асуудлуудыг заасан байдаг бөгөөд 20.1.18 дахь хэсэгт “Төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар” үйлчилгээг хангах, мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27.5-д зааснаар “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар дараах төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлнэ” гэсэн байдаг ба үүнд нь буюу 27.5.2-т сургуулийн өмнөх боловсрол тусгагдсан байдаг.


Хүүхдийн эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд Улсын их хурал, нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхийг тусгасан бөгөөд 11.1.1 дэх хэсэгт хүүхдийн эрхийг хангах талаарх төрийн болон орон нутгийн бодлогыг тодорхойлох, 11.1.2 дахь хэсэгт хүүхдийн эрхийг хангах, хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөр, үйл ажиллагааг санхүүжүүлэх, төсөв батлах, 11.1.3 дахь хэсэгт хүүхдийн эрхийн талаарх хууль тогтоомжид хяналт тавих хэмээн тус тус заасан байдаг байна.

Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлд аймаг нийслэлийн боловсролын газрын бүрэн эрхийг тусгасан бөгөөд 28.1.1 дэх хэсэгт боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах, 28.1.2 дахь хэсэгт ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах зөвшөөрөл олгох эсэх талаар дүгнэлт гаргаж аймаг, нийслэлийн Засаг даргад санал болгох, 28.1.6 дахь хэсэгт орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойрог тогтоох хэмээн тусгасан байна.

[215] Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 27 дугаар зүйлийн 27.5.2

Мөн хуулийн 30 дугаар зүйлд аймаг нийслэлийн засаг даргын бүрэн эрхийг хуульчилсан бөгөөд 30.1.2 дахь хэсэгт иргэнд суурь боловсрол эзэмшүүлэх, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, мэргэжил эзэмшүүлэх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх, 30.1.3.орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллага байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг аймаг, нийслэлийн боловсролын газрын дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэх, 30.1.4.өөрийн орлогоо нэмэгдүүлэхэд нь боловсролын байгууллагад дэмжлэг үзүүлэх, тэдгээрийг хичээлийн болон дотуур байр, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, ном, сурах бичгээр хангах ажлыг зохион байгуулах зэрэг чиг үүргүүдийг тусгасан байна.

Түүнчлэн уг хуулийн 31 дүгээр зүйлд сум, дүүргийн засаг даргын бүрэн эрхийг хуульчилсан бөгөөд 31.1.1 дэх хэсэгт боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, 31.1.2 дахь хэсэгт хүүхдэд сургуулийн өмнөх болон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, иргэнд суурь боловсрол нөхөн эзэмшүүлэх ажлыг захиргааны удирдлагаар хангах зэрэг бүрэн эрхүүдийг тус тус хэрэгжүүлэхээр хуульчлагдсан. Хүүхдийн эрхийг хангах, тэдний сурч боловсрох, гэмт хэрэг, халдлагаас хамгаалуулах, эрүүл, аюулгүй орчинд өсч бойжих эрхийн хууль зүйн хамгаалалтыг бид сайн хийсэн байна. Гэвч эдгээр хууль зүйн хамгаалалтын хэрэгжилт хууль тогтоогчийн зорилгод хүрч үйлчлэхгүй байгаатай хэн бүхэн санал нийлэх байх. Үүнийг дараах статистик үзүүлэлтээс илүү тодорхой харж болохоор байна.



Хүүхдийн хүмүүжил 0-6 насанд эрчимтэй явагдаж 10-12 нас гэхэд хүмүүжлийн суурь тавигдаж дууссаг[216].Тэгэхээр тэрхүү эрчимтэй явагдах насанд хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол зайлшгүй чухал шаардлагатай бөгөөд цэцэрлэгийн насны 2-5 насны хүүхдүүдийг бүрэн цэцэрлэгт хамруулах нь хүүхдийн хүмүүжил төлөвшилд чухал нөлөө үзүүлэх юм.

[216] "Тогтвортой хөгжил - Ерөнхий боловсрол" улсын II зөвлөгөөн,
“Монгол хүүхдийн хөгжлийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал” илтгэл


Монгол улсын хэмжээнд 2022 оны байдлаар төрийн өмчит цэцэрлэг 985, хувийн өмчит цэцэрлэг 428 бүртгэгдсэн байна[217].



Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ үзүүлдэг байгууллагын тоон үзүүлэлт нь сүүлийн 10 жилийн байдлаар 400 гаруй байгууллагаар нэмэгдсэн хэдий ч сүүлийн 5 жилийн хугацаанд 2-3 байгууллагаар л өссөн үзүүлэлттэй харагдаж байна[218].

Энэ нь хүн амын өсөлт, нийт тухайн үйлчилгээнд хамрагдвал зохих хүүхдийн тоотой харьцуулахад маш бага байгааг дараах судалгааныудаас харах боломжтой.

Монгол улсын хэмжээнд 2021 оны байдлаар цэцэрлэгийн насны буюу 2-5 насны 303766 хүүхэд бүртгэгдсэн бөгөөд үүнээс 190991 хүүхэд нь цэцэрлэгт хамрагдсан буюу цаана нь 112775 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж чадаагүй байна.



Харин энэ оны байдлаар 0-5 хүртэлх насны буюу цэцэрлэгт хамрагдвал зохих хүүхдийн тоон үзүүлэлт тодорхойгүй ч 2022-2023 оны хичээлийн жилд 266024 хүүхэд сургуулийн өмнөх боловсролын байгууллын үйл ажиллагаанд хамрагдаж байгаа статистик үзүүлэлт гарсан байна[219].

---

[217] СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН 2022-2023 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭ | Боловсрол, шинжлэх ухааны яам. (meds.gov.mn)

[218] Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ үзүүлдэг төрийн болон хувийн өмчийн байгууллагын судалгаа. Уб., 2023. Боловсрол, шинжлэх ухааны яам (meds.gov.mn)

[219] СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН 2022-2023 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭ | Боловсрол, шинжлэх ухааны яам. (meds.gov.mn)

Дараах хүснэгтээс 2021 оны байдлаар 2-5 насны хүүхдүүдийг насны бүлгээр нь ангилсан үзүүлэлтийг харуулъя.[220]



Дээрх судалгаанаас харахад 5 настай хүүхдүүд хамгийн их байгаа нь харагдаж байна. Цэцэрлэгийн бэлтгэл бүлэг буюу 5 настангууд нь сургуульд орохоос өмнөх бэлтгэлээ хангадаг хамгийн чухал үе билээ. Тэгэхээр энэ насны хүүхдүүд бүгд цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа нь учир дутагдалтай.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын салбарын 2022-2023 оны хичээлийн жилийн зорилго зорилтод “Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, 5 настай хүүхэд бүрийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулан сургуульд сурах бэлтгэлийг хангах” гэсэн зорилго тусгагдсан байдаг байна[221].


Мөн Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн насыг 3-5 болгож, 5 настай хүүхэд бүрийг сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана” гэсэн зорилтыг дэвшүүлсэн байна[222].

Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд 2021-2022 оны хичээлийн жилд 69749 хүүхэд хамрагдаагүй бөгөөд тэдгээр хамрагдаагүй хүүхдүүдийг нас, хувь, байршилаар нь харцгаая.[223]

Нас	Тоо	Эзлэх хувь
2 нас	40254	57.5%
3 нас	20665	29.6%
4 нас	5173	7.4%
5 нас	3657	5.2%

Дээрх нийт цэцэрлэгт хамрагдаагүй 69749 хүүхдийн 32553 нь хөдөө орон нутагт, 37196 нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна.[224].

[220] Үндэсний статистикийн хороо, Уб., 2023 он.
[221] Боловсрол соёл шинжлэх ухааны яам
[222] Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем
[223] Монголын үндэсний мэдээллийн агентлаг МОНЦЕМА, 2022 он.
[224] Боловсрол соёл шинжлэх ухааны яам



Мөн нийслэлийн 57 байршилд цэцэрлэгийн хэт өндөр ачаалал үүссэн бөгөөд цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа юм.

Дүүрэг	Төрийн өмчит цэцэрлэгийн тоо	Хэт өндөр ачаалалтай цэцэрлэгийн тоо	Эзлэх хувь
Баянгол	35	4	11.7%
Баянзүрх	52	19	36.5%
Налайх	10	2	20.0%
Сүхбаатар	35	7	20.0%
Сонгинохайрхан	60	9	15.0%
Хан-Уул	30	10	33.3%
Чингэлтэй	36	6	16.6%
Нийт	258	57	22.1%

Зөвхөн Улаанбаатар хотын хэмжээнд гэхэд л нийт 258 цэцэрлэгийн 57 нь хэт өндөр ачаалалтай үйл ажиллагаа явуулж байгаа нь тулгамдаж буй асуудал бөгөөд тэдгээр цэцэрлэгийг өргөтгөх, нэмж цэцэрлэг барих зэрэг асуудал тулгамдаж байгаа юм.

Дүгнэлт

Сургуулийн өмнөх боловсрол нь хүүхэд сургуульд орохоос өмнөх урьтал бэлтгэл үе бөгөөд хүүхдийн хүмүүжил төлөвшилд чухал нөлөө үзүүлэх боловсролын байгууллага билээ. Дээр дурдсан цэцэрлэгийн хүрэлцээгүй байдал, хэт ачаалал зэргээс шалтгаалж цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүдийн хувьд тэдний үндсэн хуулиар олгогдсон болон бусад холбогдох хууль

тогтоомжуудаар баталгаажсан сурч боловсрох эрх нь зөрчигдөж байгааг харуулж байгаа юм.

Цэцэрлэгийн хүрэлцээ хангалтгүй байгаагаас болж цэцэрлэгийн насны хүүхдүүд бүгд 100 хувь цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа бөгөөд ингэснээр дан ганц сурч боловсрох эрхээс гадна эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх нь ч мөн давхар зөрчигдөх нөхцөл байдал бий болж байгаа юм. Тиймээс хүүхдийн цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх, ачаалал ихтэй цэцэрлэгт өргөтгөл хийх зэрэг арга хэмжээнүүдийг авах шаардлагатай байгаа юм. мөн төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэхэд тухайн орон нутаг, засаг захиргааны дарга нар анхаарч ач холбогдол өгөн ажиллах шаардлагатай байна. Түүнчлэн дан ганц төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх гэж туйлширахаасаа гадна хувийн өмчийн цэцэрлэгийг нэмэгдүүлэхэд шаардлагатай нөхцөл боломжоор хангах хэрэгтэй.

Мөн боловсролын салбарт зориулах улсын болон орон нутгийн төсвийг нэмэгдүүлэх талаар шаардлагатай арга хэмжээг шат шатны засаг дарга, орон нутгийн байгууллагууд авч ажиллах хэрэгтэй.

Цэцэрлэгийн тоо өссөнөөр хүүхдийн сурч боловсрох эрх хангагдаж, ажлын байр ч нэмэгдэх боломжтой. Мөн хүүхэд нь цэцэрлэгт явж аюулгүй байдлаа хангуулж байгаа нөхцөлд эцэг, эхчүүд нь ажил хийх нь тухайн өрхийн амьжиргаа, орлогыг нэмэгдүүлэхээс гадна улс орны эдийн засагт ч сайнаар нөлөө үзүүлэх боломжтой гэж харж байна. Өнгөц харахад дан ганц цэцэрлэгийн хүрэлцээний асуудал мэт харагдаж болох ч нарийн харвал цаанаа олон олон асуудлыг давхар хамруулж байгаа юм. Тиймээс тэрхүү цэцэрлэгийн асуудал хангагдаж чадахгүй байгаагаас улс орны ирээдүй болсон хүүхдүүдийн суурь хүмүүжил, төлөвшил зөв тавигдахгүй, ажилтай, орлоготой иргэдийн тоо ч бага байгаа нь иргэдийн анхдагч хэрэгцээ болсон суурь боловсролыг чанартай эзэмших, эзэмших боломж хомс байгаатай холбоотой гэж харж байгаа юм.

Мөн цэцэрлэгийн үйл ажиллагаанд төдийлөн анхаарахгүй байгаа нь боловсролын чанарын үзүүлэлттэй шууд хамааралтай юм.

Тиймээс боловсролын асуудлын талаар, тэр дундаа сургуулийн өмнөх боловсролын талаарх үйл ажиллагааг дан ганц боловсролын байгууллагатай холбож, бүх үүрэг хариуцлагыг оноохоос илүүтэйгээр орон нутгийн байгууллагууд тус бүр энэ чиглэлд анхаарлаа хандуулж үйл ажиллагаагаа эрчимжүүлснээр энэ талын асуудлуудад анхаарлаа хандуулах байгууллагууд олширч авах арга хэмжээ нь ч мөн дорвитой болох юм. Өөрөөр хэлбэл орон нутгийн байгууллага, иргэдийн төлөөлөгчдийн хурал энэ тал дээр онцгой анхаарах цаг нь болсон гэж харж байна.

Санал

✓ Тухайн нийслэл, аймаг, сум дүүргийн засаг дарга нар өөрийн орон нутгийнхаа цэцэрлэгийн хүрэлцээ, цэцэрлэгт хамрагдах насны хүүхдүүдийн тоо зэргийг бүртгэж шаардлагатай нөөц бололцоог тодорхойлох;

✓ Улсын төсөв болон орон нутгийн төсвөөс энэ чиглэлийн боловсролын салбарт зарцуулагдах хөрөнгийг нэмэгдүүлэх, хувийн өмчийн цэцэрлэгийг олноор бий болгоход төрөөс дэмжлэг үзүүлэх;

✓ Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хуульд Аймаг, сум, дүүргийн засаг дарга нарын ажлын чиг үүрэгт “Жил бүр тухайн орон нутгийнхаа цэцэрлэгийн насны хүүхдүүдийг бүртгэж цэцэрлэгт хамруулах” гэх заалтыг тусгах;

✓ “Боловсролын мэдээллийн техналогийн төв” мэдээллийн санд сургуулийн өмнөх боловсролын талаарх мэдээ мэдээлэл, статистик мэдээллийг тодорхой дэлгэрэнгүй оруулдаг болох.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

1. Монгол Улсын Үндсэн хууль. Уб., 1992. Төрийн мэдээлэл эмхэтгэл №1.
2. Хүүхдийн эрхийн тухай хууль. Уб., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл №9.
3. Боловсролын тухай хууль. Уб., 2002. Төрийн мэдээлэл эмхэтгэл №19.
4. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль. Уб., 2008. Төрийн мэдээлэл эмхэтгэл №21.
5. Хүүхэд хамгааллын тухай хууль. Уб., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл №9.
6. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль. Уб., 2021. Төрийн мэдээлэл эмхэтгэл №7.
7. Тогтвортой хөгжил - Ерөнхий боловсрол" улсын II зөвлөгөөн,
8. “Монгол хүүхдийн хөгжлийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал” илтгэл
9. Сургуулийн өмнөх боловсролын 2022-2023 оны хичээлийн жилийн статистик мэдээ |Боловсрол, шинжлэх ухааны яам. (meds.gov.mn)
10. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ үзүүлдэг төрийн болон хувийн өмчийн байгууллагын судалгаа. Уб., 2023. Боловсрол, шинжлэх ухааны яам (meds.gov.mn)
11. Үндэсний статистикийн хороо, Уб., 2023 он.
12. Боловсрол соёл шинжлэх ухааны яам
13. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем

---o0o---

СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЭРХИЙН ТУХАЙ

ON THE RIGHTS OF HEARING IMPAIRMENT CITIZENS



М.Анхбаяр
Дотоод хэргийн их сургуулийн
Эрх зүй-Нийгмийн ухааны сургуулийн
233 дугаар дамжааны оюутан

Товч утга: Сонсголын бэршээлтэй иргэд төрийн байгууллагаар үйлчлүүлэхдээ өөрт хэрэгцээтэй үйлчилгээгээ авч чадахгүй байна. Учир нь төрийн албан хаагчтай ойлголцоход хэцүү, буруу, дутуу ойлголцох гэх зэрэг хүндрэл бэрхшээл ихээхэн тулгарч байна.

Түлхүүр үгс: Хүний эрх, тусгай хэрэгцээ, сонсгол алдагдал, төрийн үйлчилгээ.

Abstract: Hearing impaired citizens cannot get the services they need when they use public institutions. Because it is difficult to understand with the employee, there are a lot of difficulties such as misunderstanding.

Keywords: Human rights, special needs, hearing loss, services of public institutions.

Бид эмнэлэгт үзүүлэхдээ тухайн эмчдээ өөрийн биеийн аль хэсэг хаана өвдөж байгаагаа хэлж эмчтэй харилцан ойлголцсны үндсэн дээр эмч миний биеийн өвдөж байгаа хэсгийг үзэж оношлон шаардлагатай эмчилгээ хийж, зөвлөгөө өгч, эм бичиж өгдөг. Би эмчтэй харилцан ойлголцсоны улмаас өөрийн биеийн аль эрхтэн юунаас болж өвдсөн тухайгаа мэдэж эмчийн зөвлөсний дагуу эмчилгээгээ хийлгэнэ ээ. Хэрэв эмчтэй харилцан ойлголцож чадахгүй бол өөрийн биеийн аль эрхтэн юунаас болж өвдсөн тухайгаа ч мэдэх боломжгүй бөгөөд цаашлаад ямар эмчилгээ үйлчилгээ хийлгэхээ ч мэдэх боломжгүй болно. Тиймээс бид бие биетэйгээ аман болон аман бус байдлаар ойлголцож байж л нийгмийн харилцаанд бие даан оролцох боломж бүрдэж байна.

Сонсголын бэрхшээлтэй хүмүүс төрийн байгууллагаар ганцаарчлан үйлчлүүлэхдээ тухайн байгууллагын ачаалалтай байдлаас шалтгаалан харилцаж буй албан хаагчтай ойлголцох боломж хомс, буруу, дутуу ойлголцох, өөрийн хүссэн үйлчилгээгээ авч чадахгүй байх зэрэг асуудал тулгарч байна. Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 12 дэх хэсэгт “Төрийн байгууллага,

албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй.”, 16 дугаар зүйл 16 дахь хэсэгт “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй”, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгавларан гадуурхаж үл болно”[225] гэж хуульчилсан байдаг хэдий ч дээрх иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх зөрчигдөж байна.

Сонсголын бэрхшээлтэй иргэдэд тулгамдаж буй асуудлын талаар маш олон хэлбэрээр ярьдаг хэдий ч яг хэрэгжээд шийдвэрлэгдсэн асуудал тун цөөн юм. Энэхүү байдал тэднийг үл хайхрах гэсэн хүчирхийллийн нэг төрөлд өртөж байгааг харуулж байна. Тэд өөрийн эх орондоо амьдарч байгаа хэдий ч харь улсад амьдарч байгаа мэт бусадтай ойлголцох ямар нэгэн өөрт хэрэгцээтэй үйлчилгээ авах боломж нөхцөл нь маш хүндрэлтэй байна гэж үзэж байгаа тул энэхүү асуудлаар цааш судлах шаардлагатай гэдэг үүднээс “Сонсголын бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай” сэдэвт илтгэлээ бичихээр болсон. Сонсголын бэрхшээлийн талаар хүмүүс ихэнх нь буруу ойлголттой байдаг учраас энэхүү илтгэлээрээ илүү дэлгэрэнгүй судлан орууллаа.

Сонсголын бэрхшээлийн тухай ойлголт

Хүний үндсэн 5 мэдрэхүйн нэг нь сонсох билээ. Чихний үүрэг бол зөвхөн мэдээлэл хүлээн авагч бус түүнийг илэрхийлэх буюу хэл яриатай холбоотой. Хүний сонсгол хэвийн байснаар бусадтай харилцан ойлголцоход хүндрэлгүй байна.

Тэгвэл сонсгол гэдэг нь тархин дахь сонорын төв нь гадны дуу авианы хэлбэлзлийг сонсгол дамжуулах эрхтний тусламжтайгаар хүртэн хүлээж авч, гаднах орчинтой харилцахад хэрэглэдэг чадвар юм. Чих нь сонсох мэдрэхүйн дамжуулагч бөгөөд ерөнхий бүтцээрээ гадна, дунд, дотор гэж 3 хуваагдана. Бидний нүдэнд харагдаж байгаа чихний дэлбээнээс хэнгэрэг хүртэлх хэсгийг гадна чих гэж нэрлэдэг бөгөөд дууны долгионыг цуглуулаад дунд чихэнд дамжуулах үүрэгтэй. Хэнгэрэгнээс цааш дотор чих хүртэл хэсгийг дунд чих гэдэг бөгөөд хүний биед байдаг алх, дөш, дөрөө гэж нэрлэдэг хүний биеийн хамгийн жижиг 3 яснаас бүтдэг. Дунд чих нь гаднаас орж ирсэн дууны долгионд цохигдсон хэнгэрэгний доргилтыг дотор чихэнд дамжуулдаг. Дотор чих нь 3 ширхэг хагас цагираг агуулсан дун хэлбэртэй яс бөгөөд энэ нь шингэн болон дууны долгион мэдрэгч мэдрэлийн ширхэгийг агуулж байдаг. Дунд чихнээс ирсэн дууны долгион дотор чихэн дэхь шингэнийг цалгиулж хөдөлгөөнд оруулахад мэдрэлийн ширхэг нь цочирч, дууны долгионыг тархи руу дамжуулдаг. Тархи тэр мэдээллийг хүлээн

[225] Монгол улсын Үндсэн хууль. УБ. 1992. Төрийн мэдээлэл эмхэтгэл №1. 16 дугаар зүйлийн 12, 16 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.

авснаар дуу чимээг ялган боловсруулж, хариу үйлдэл хийдэг. Дээрх хэвийн үйл явц алдагдсанаас шалтгаалан муу дутуу сонсох, огт сонсохгүй байхыг сонсголын бэрхшээл гэж нэрлэдэг.

Сонсголын бэрхшээл: Аливаа гэмтэл, өвчлөлийн улмаас сонсголыг дамжуулах эрхтэн болох чих нь үүргээ гүйцэтгэж чадахгүй болсны улмаас сонсголын алдагдал буюу сонсголын бэрхшээл бий болдог.

Сонсголын бэрхшээлтэй хүн: - Сонсох эрхтний аливаа нэг гэмтэл, өвчлөлийн улмаас эсвэл удамшлын шалтгаанаар сонсголын эрхтэн өөрийн үүргээ ямар нэг хэмжээгээр гүйцэтгэж чадахгүй болсноос хүний хэл яриа хөгжөөгүй буюу хөгжих бэрхшээлтэй болсон, бие дааж хэл яриа эзэмших, хэл яриагаа сонсголын замаар хөгжүүлэх чадваргүй болсон хүнийг хэлнэ[226].

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага хүний сонсгол алдагдлын түвшинг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

Хүснэгт№1

д\д	Сонсгол алдагдлын хэмжээ /децибел-дб/	Хөгжлийн бэрхшээлийн түвшин
1.	25db- доош	Хэвийн /normal/
2.	26-40 db	Хөнгөн /mild/
3.	41-55 db	Дунд зэрэг /middle/
4.	56-70 db	Хүндэвтэр /middle- severe/
5.	71-90 db	Хүнд /severve/
6.	90 db- с дээш	Маш хүнд / profound/

Сонсгол алдагдлын төрлүүд:

- дамжуулалтын алдагдал
- мэдрэлийн гаралтай сонсголын алдагдал
- холимог хэлбэрийн алдагдал гэсэн төрлүүдтэй.

Дамжуулалтын алдагдал: гадна болон дунд чихээр дамжуулах дуу чимээний долгионыг ямар нэг зүйлс саатуулж зогсоохыг хэлнэ. Дууны долгион дотор чихэнд хүрч очихын тулд чихний суваг цэвэрхэн байх, чихний хэнгэрэг зөв цочрол өгч чадахуйц байх, мөн жижиг яснууд нь зүй ёсоороо цочирч байхын тулд дунд чихний хөндий агаараар дүүрсэн байх ёстой. Дамжуулагчийн алдагдал нь дараах шалтгаанаас үүсдэг. Үүнд:

- ✓ хулхи эсвэл өөр бусад зүйлс чихний сүвийг бөглөх
- ✓ чихний хэнгэрэгний хальсны цооролт

[226] https://apdc.mn/

- ✓ дунд чихэнд хуралдсан шингэн
- ✓ жижиг яс байхгүй гэх хөгжилтэй гэх мэт

Дамжуулалтын алдагдал нь дотор чихэнд хүрч очиж буй дуу чимээний тоо хэмжээнд нөлөөлдөг, ийм төрлийн алдагдалтай хүмүүст дуу чимээ сул мэт санагдах, зарим дуу чимээ огт сонсогдохгүй гэсэн үг. Ихэнх тохиолдолд энэхүү алдагдал нь түр зуурынх байдаг бөгөөд үүнийг анагаах ухаанд эмчилдэг.

Мэдрэлийн гаралтай сонсголын алдагдал: энэ нь чихний дундах мэдрэлийн эсүүд эсвэл сонсголын мэдрэлүүд нь бүрэн гүйцэт ажиллахгүй үед бий болдог. Мэдрэлийн гаралтай сонсголын алдагдал нь доорх шалтгаанаас үүдэлтэй байна. үүнд:

- ✓ удамшлын хүчин зүйлс
- ✓ өвчин
- ✓ удаан хугацааны турш чанга дуу чимээнд байсан
- ✓ өндөр нас

Мэдрэлийн гаралтай сонсгол алдагдал дууны тоо хэмжээ чанар хоёуланд нь нөлөөлдөг. Энэ нь дуу маш тод сонсогдох боловч зарим нь огт сонсогдохгүй энэ төрлийн алдагдал энэ үедээ эмчлэгддэггүй учир тогтсон гэж үздэг.

Холимог хэлбэрийн алдагдал: энгийнээр хэлэхэд энэ нь дамжуулагчийн гаралтай болон мэдрэлийн гаралтай сонсголын алдагдлын аль аль нь бий болсныг ойлгоно[227].

Сонсголын бэрхшээлтэй иргэдийн харилцааны хэлбэр: Үндэсний статистикийн хорооноос авсан судалгаагаар манай улсад сонсголын бэрхшээлтэй 8430 хүн байдаг гэсэн тоон судалгаа байдаг[228]. Эдгээр хүмүүс нийгмийн харилцаанд орохдоо бусадтай хэрхэн ойлголцох боломжтой вэ? Эх хэл гэдэг бол аливаа улс үндэстний оршин тогтнох, үндэсний онцлогоо харуулах нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хувь хүний боловсрол олж авах, нийгэмд өөрийн байр сууриа бий болгоход чухал үүрэгтэй байдаг. Тэгвэл сонсголын бэрхшээлтэй иргэдийн хувьд дохионы хэл нь тэдний эх хэл юм. Шинжлэх ухаанд дохионы хэл гэдгийг дактилология буюу хурууны үсэг болон дохио зангааны хэл гэсэн 2 том бүрэлдэхүүн хэсэгт хувааж хараагаараа хүлээн авах хэлний нэг томоохон салбар болгон судалж ирсэн байна. Хүний гар хуруу нь дохиог илэрхийлэх гол хэрэгсэл болно. Дэлхийн сонсголын бэрхшээлтэй иргэдийн холбооноос дохионы хэлийг сонсголын бэрхшээлтэй иргэдийн нэгдүгээр хэл хэмээн тунхагласнаар улс орон бүр өөрсдийн дохионы хэлийг бий болгон хөгжүүлж иржээ. Хэдийгээр монгол дохионы хэл нь монгол хэл шиг олон зуун жилийн төгс хөгжил, баялаг өв сангүй боловч аль тэртээ дөч гаран жилийн өмнө сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдэд

[227] https://apdc.mn/
[228] https://www.1212.mn/

ерөнхий боловсрол олгох тусгай сургууль байгуулагдсан тэр цагаас монгол дохионы хэл бүрэлдэн бий болох үндэс суурь нь тавигдаж, өдгөө сонсголын бэрхшээлтэй иргэдийн харилцааны гол хэрэглүүр болж, дохионы сан, хэл зүй, өгүүлбэр зүйн тогтсон дүрэмтэй, бие даасан нэг хэл болон бүрэлдэж чадсан байна[229].

Сонсголгүй хүн бусдын л адил оюун ухаан, сэтгэн бодох чадвартай. Гэвч зөвхөн сонсох чадваргүйгээсээ болж нийгмийн харилцаанд орох, төрийн үйлчилгээ авах, цагдаа хууль хяналтын байгууллагаар үйлчлүүлэх үед сонсголын бэрхшээлээсээ болж өөрсдийгөө илэрхийлж чаддаггүй зэрэг өдөр тутмын нийгмийн харилцаанд нь асуудал тулгарч байна. Энэ нь сонсголын бэрхшээлтэй иргэдийн үндсэн хуулиар олгогдсон эрх буюу Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16 хэсэгт “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх”, мөн хуулийн 16-р зүйлийн 12 дэх хэсэгт “Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрх”[230] тус тус хязгаарлагдаж зөрчигдөж байна. Сонсголын бэрхшээлтэй иргэд төрийн байгууллагаар үйлчлүүлэхдээ төрийн хаагчтай ойлголцоход хүндрэл бэрхшээлтэй байдаг учраас өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж чаддаггүй. Мөн өөрт тулгарч буй асуудлаа шийдвэрлүүлэх боломж хомс гэж үзэж байна. Учир нь төрийн байгууллагад сонсголын бэрхшээлтэй иргэдтэй харилцаж ойлголцдог хэлмэрч байхгүй, төрийн албан хаагчид нь тодорхой хэмжээний дохионы хэл мэдэхгүй байгаа нь сонсголын бэрхшээлтэй иргэдийн Үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөө зөрчигдөх нэг томоохон нөхцөл болж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол дохионы хэл бол сонсголгүй хүний эх хэл мөн бөгөөд сонсголгүй хүн дохионы хэлээрээ нийгмийн бүхий л харилцаанд оролцох эрхтэй”, мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Сонсголын бэрхшээлтэй хүн цагдаа, эрүүл мэндийн байгууллага, онцгой байдлын албаны тусгай дугаарт текст мессэж, дохионы хэлний хэлмэрчийн зайн дүрс, ярианы тусламжтайгаар хандаж, үйлчилгээ авах боломжийг төрөөс бүрдүүлнэ”[231] гэж хуульчилсан байдаг бөгөөд энэхүү хууль нь бүрэн дүүрэн хэрэгжихгүй байна. Сонсголын бэрхшээлтэй иргэд төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодруулах зорилгоор дараах судалгааг авлаа.


---

[229] http://tsagtur.mn/

[230] Монгол улсын Үндсэн хууль. УБ. 1992. Төрийн мэдээлэл эмхэтгэл №1. 16 дугаар зүйлийн 12, 16 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.

[231] Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай. Уб. 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл №9. 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг.


Энэхүү судалгаанд 1600 гишүүнтэй “Сонсголын бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн групп”, 1100 гишүүнтэй “Сонсголын бэрхшээлтэй иргэдийн соёлын төв ТББ” пэйж хуудсын 23 гишүүн оролцсон.



Зураг№1

Нийт судалгаанд оролцогчдын сонсгол алдагдлын түвшинг харуулав.

- 5 хүн буюу 22% нь 26-55 дб-н сонсгол алдагдалтай байна.
- 10 хүн буюу 44% нь 56-70 дб-н сонсгол алдагдалтай байна.
- 7 хүн буюу 30% нь 71-90 дб-н сонсгол алдагдалтай байна.
- 1 хүн буюу 4% нь 91-с дээш дб-н сонсгол алдагдалтай байна.




Зураг№2

Судалгаанд 22-55 насны хүн оролцсоноос


- 21 буюу 91% нь эмэгтэй
- 2 буюу 9% нь эрэгтэй байна. Үүнээс дүгнэхэд эрэгтэй иргэдийн хувьд оролцоо бага байдаг нь харагдаж байна.

Зураг№3



Төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд ямар нэгэн хүндрэл гардаг уу? гэсэн асуултанд бүгд төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд ямар нэгэн хүндрэл гардаг гэж хариулсан байна.


Зураг№4



Төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд ямар хүндрэл гардаг вэ? гэсэн асуултанд дараах байдлаар хариуллаа.


- 7 буюу 30% нь төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд ойлголцоход хүндрэлтэй байдаг.
- 16 буюу 70% нь төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд дээрх бүгд асуудал тулгардаг гэж хариулжээ. Үүнээс дүгнэхэд сонсголын бэрхшээлтэй иргэд төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд зөвхөн ойлголцоход хэцүү байдаггүй түүнээс шалтгаалан өөр хүндрэл бэрхшээлүүд гардаг байх нь харагдаж байна.

Зураг№5 Төрийн албан хаагчийн харилцаа, хандлага хүссэн үйлчилгээгээ авахал саад учруулдаг уу? гэсэн асуултанд дараах байдлаар хариулжээ.



- 14 буюу 61% нь төрийн албан хаагчдын харилцаа хандлага нь хүссэн үйлчилгээгээ авахад саад учруулдаг гэж хариулсан
- 9 буюу 39% нь төрийн албан хаагчдын харилцаа хандлага нь хүссэн үйлчилгээгээ авахад заримдаа саад учируулдаг гэж хариулсан байна. Үүнээс дүгнэхэд сонсголын бэрхшээлтэй иргэд төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд төрийн албан хаагчдын харилцаа хандлага ч мөн тэдний хувьд тулгамдаж буй асуудлын нэг болж байна.

Зураг№6



Төрийн албан хаагчид тодорхой хэмжээний дохионы хэл мэддэг бол таньд үйлчилгээ авахад хялбар байж чадах уу? гэсэн асуултанд нийт судалгаанд оролцогчид тийм гэж хариулжээ.

Төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд таньд тулгамдаж буй асуудал гэсэн асуулгын хувьд судалгаанд оролцсон иргэдийг өөрсдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж олгох үүднээс нээлттэй байдлаар авсан. Судалгаанд оролцсон иргэдийн хувьд төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд ойлголцоход хэцүү, хүнд суртал их, хэлмэрч байдаггүй, бичгээр ойлголцоход хэцүү байдаг учраас өөрийн хүссэн үйлчилгээгээ авахад хэцүү байдаг гэж хариулсан байна.

Дүгнэлт

Иргэдэд ямар нэгэн ялгаварлан гадуурхалтгүй, бүгдэд хүртээмжтэй, тэгш үйлчлэх цорын ганц байгууллага бол төрийн байгууллага юм. Түүний нэг болох

нэг цэгийн үйлчилгээ буюу төрийн олон төрлийн үйлчилгээг нэг дор үзүүлдэг байгууллагад сонсголын бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэхэд олон хүндрэл бэрхшээлтэй тулгарч байна. Тиймээс өөрийн илтгэлдээ сонсголын бэрхшээлтэй иргэд төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд ямар хүндрэл бэрхшээл асуудлуудтай тулгардаг талаар судлан өөрийн авсан бяцхан судалгаагаар нотлон харуулахыг хичээлээ.

Нэг үеэ бодоход төрийн байгууллага сонсголын бэрхшээлтэй иргэдэд тулгардаг асуудлын талаар мэддэг болсон бөгөөд телевиз, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээ мэдээлэл дамжуулахдаа дохионы хэлээр давхар хүрэгдэг болсон нь сайшаалтай. Гэхдээ сонсголын бэрхшээлтэй иргэд төрийн байгууллагаар үйлчлүүлэхдээ заавал гэр бүл, төрөл садангийн хэн нэгэнтэй цуг явах эсхүл өөрийн өмнөөс төлөөлүүлэх байдлаар үйлчилгээ авч байна. Учир нь сонсголын бэрхшээлтэй иргэд төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд төрийн албан хаагчтай ойлголцоход хэцүү байдаг учраас өөрийн хүссэн үйлчилгээгээ түргэн шуурхай авах, сэтгэл ханамжтай байдлаар авч чаддаггүй байна. Энэ нь төрийн байгууллагад сонсголын бэрхшээлтэй иргэдтэй харилцах хэлмэрч байхгүй, төрийн албан хаагчид нь тодорхой хэмжээнд дохионы хэл мэддэггүйтэй холбоотой байна.

Үүнээс үүдэн сонсголын бэрхшээлтэй иргэдийн хувьд Монгол улсын Үндсэн хууль болон бусад холбогдох хуулиудаар олгогдсон эрх, эрх чөлөө нь хязгаарлагдаж, зөрчигдөж байна. Тиймээс сонсголын бэрхшээлтэй иргэдэд хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөг бүрэн эдлүүлэх, төрийн үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэхийн тулд дараах саналыг дэвшүүлж байна.

Санал

1. Төрийн албан хаагчдыг тодорхой хэмжээний дохионы хэлний мэдлэгтэй болгох. Ингэснээр сонсголын бэрхшээлтэй иргэдтэй ойлголцоход дөхөм болох бөгөөд тухайн иргэд төрийн үйлчилгээг бие даан авахад хялбар болно;
2. Төрийн байгууллага бүр дохионы хэлмэрчтэй болох. Сонсголын бэрхшээлтэй иргэд ямар нэгэн саадгүйгээр эрхээ эдлэх боломж нээгдэнэ;
3. Төрийн бүх салбар байгууллагууд сонсголгүй иргэдэд зориулсан мэдээ, мэдээллийг хүртээмжтэй хүргэх;
4. Нэг цэгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагад сонсголын бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх боломжийг нээж өгөх үүднээс тэдгээрт үйлчилдэг дохионы хэлний мэдлэгтэй албан хаагчийг тусгайлан бэлдэж ажиллуулах;
5. Төрийн үйлчилгээг хүргэхдээ техник, технологи ашиглан мэдээлэл дамжуулах, тусгай хэрэгцээт иргэдэд тусламж, дэмжлэг шууд хүргэх, тэд мэдээлэл шууд авах боломжийг бүрдүүлэх.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

Нэг. Хууль, тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай. 2016 он
3. https://apdc.mn
4. http://tsagtur.mn/
5. https://legalinfo.mn/

---o0o---

ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫН ХЭРЭГЖИЛТ СУДАЛГААНЫ ТАЙЛАН: ТАНИЛЦУУЛГА



Э.Батбаяр
Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), дэд профессор, хурандаа

Монгол Улсад гэмт хэрэг үйлдсэн хүний зорчих эрхийг хязгаарлаж ирсэн эрх зүйн зохицуулалтын уламжлал

Зорчих эрхийг хязгаарлах ял нь манай улсын хууль тогтоомжийн түүхэнд байгаагүй боловч иргэний оршин суух газраа чөлөөтэй сонгох, зорчих эрхэд хязгаарлалт тогтоож байсан түүхийн эх сурвалж байна. Тухайлбал, цөлөх, уг нутгаас зайлуулах зэрэг ялыг хэрэглэж байсан практик бий. Эдгээр ял нь тухайн этгээдийн зорчин явах, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхийг хөндөж байгаагаараа зорчих эрхийг хязгаарлах ялтай төстэй гэж үзлээ.

- **Их засаг хууль**

Академич Ж.Болдбаатар, профессор Д.Лүндээжанцан нар “Их засаг хууль бол дэлхийн соёл иргэншлийн түүхийн бүхэл бүтэн нийгэм, улс төрийн байгуулал бүрэлдэн төлөвшихөд томоохон үүрэг гүйцэтгэсэн Эртний Вавилоны Хаммурапийн хууль, Энэтхэгийн Манугийн алдартай хуулиудтай эн зэрэгцэхүйц ач холбогдолтой цаазын нэн чухал баримт бичиг юм[232] гэж үнэлсэн байдаг.

Их засаг хуулиар хэдэн төрлийн ял хэрэглэхээр зааж байсан талаар судлаачдын дунд нэгдсэн ойлголт тогтоогүй хэдий ч профессор Г.Совд “цаазаар авах, ташуурааp занчих, **цөлөх**, гянданд хорих”,[233] АНУ-ын эрдэмтэн Ж.Вернадский “ цаазаар авах, гяндлах, **цөлөх**, ташуурдах ба шийдэмдэх, торгох, хөрөнгө хураах”[234] ялыг оногдуулж байсан хэмээн тус тус судлан дүгнэжээ.

- **Юан улсын нэвтэрхий хууль**

Их засаг хуулийн дараах түүний агуулга, зарчмыг хадгалсан хууль цаазын чухал эх сурвалж нь 1320 онд батлагдсан Их Юанийн нэвтэрхий хууль, Их

[232] Э.Авирмэд, Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ.,1997.77 дахь тал.
[233] Г.Совд. БНМАУ-ын Эрүүгийн эрхийн курс.УБ.,1973. 28 дахь тал.
[234] С.Жанцан.Монгол Улсын Эрүүгийн эрх зүй (ерөнхий анги).УБ.,2002. 36 дахь тал.

Юанийн хууль зүйлийн бичиг (1271), Ертөнцийг засах магад хууль зэрэг юм. Юань улсын хуульд:

1. Туйвандах (богино банзаар 57 хүртэл занчих);
2. Чавчрагдах (сурт банзаар 6717 хүртэл занчих);
3. Дөнгөлөх;
4. Үйлтгүүлэх (биеийн хүнд хүчир ажил хийлгэх);
5. **Цөлөх** (энэ ялаар шийтгүүлэгчдийг байнга оршин суугаа газраас нь алс хол бөгөөд дордуулсан газар зүйн орчин, хатуу хараа хяналтад байлгах);
6. Алах гэсэн ялын төрлийг заажээ.[235]

- **Монгол-Ойрадын цаазын бичиг**

Нэгдсэн улсын бутралын үед хамаарах хууль цаазын бичиг бол Монгол-Ойрадын цаазын бичиг юм. Тус цаазын бичигт олон төрлийн ялыг хуульчилж өгсөн ба тухайлбал, алах, хөрөнгийг хураах, ураг төрлийг хаах, эхнэр хүүхдийг нь хоосруулан хөөх, цаазаар авах, эрхтнийг нь гэмтээх, хэрэгтнийг хоосруулах, газар нүхэнд хорих, мод ташууураар жанчих, мал, үнэт зүйлээр торгох, албан тушаал бууруулах, хохирогчийн талд гэмт этгээд биеэ тушаах, **цөлөх**, мөчийг нь эрүүдэх, баривчлах, гутаах, шахаа зэрэг төрөлтэй байсан[236] талаар судлаачид дурдсан.

- **Халх журам**

Халх журмыг Монгол манжид эзлэгдсэнээс хойш 18 жилийн дараа буюу 1709-1795 оны хооронд халхын ноёд, төр, шашны том зүтгэлтнүүд 20 гаруй удаа цугларан хуралдаж, хэлэлцэж тогтоосон гэдэг. Халх журамд цаазаар авах, ташуурдах, **цөлөх**, хорих, хэргэм зэрэг эвдэх, торгох, хөрөнгө хураах зэрэг ялыг хэрэглэж байжээ.[237]

- **Монгол цаазын бичиг**

Гадаад Монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг нь Манж Чин улсын үеийн эрүүгийн эрх зүйн түүхэн эх сурвалж юм. Монгол цаазын бичиг өөртөө гэмт хэргийн ойлголт, төрөл, оногдуулах ялын төрөл, хэмжээ, гэмт хэрэгтний насны хязгаар, хөөн хэлэлцэх хугацаа зэрэг орчин үеийн эрүүгийн эрх зүйн ойлголтыг багтаасан.

Монгол цаазын бичигт торгох, цаазаар авах, **цөлөх**, албадан ажил хийлгэх ялыг үндсэн ялын чанартайгаар, эд хөрөнгө хураах, боол болгох, жанчих, дөнгө зүүлгэх, ташуурдах, хэргэм зэрэг, албан тушаалын зэрэг бууруулах, пүнлүү хасах ялыг нэмэгдэл шинжтэйгээр хэрэглэж байжээ.[238]

- **“Жинхэнэ дагаж явах хууль, дүрэм” (1913-1919)**

---

[235] Г.Гантөмөр, С.Гантулга нар. Эрүүгийн эрх зүй: ерөнхий анги.УБ., 2020. 54 дэх тал.

[236] Э.Авирмэд, Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ.,1997.75 дахь тал.

[237] С.Нарангэрэл. Халх журам Монгол Улсын эрүүгийн эрх зүйн түүхэн тулгуур эх сурвалж болох нь. ЭШХ-ийн эмхэтгэл. УБ., 1999. 42 дахь тал.

[238] Б.Баярсайхан. Монгол цаазын бичиг. УБ., 2001.99-133 дахь тал.

Богд хаант Монгол Улсын Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэх яамны “Олноо өргөгдсөний тэргүүн оноос нааш олон яамнаас айлтгаад тогтоосон ба тусгайлан зарлиг буулгаж нийтээр дагаж буй хэргийн товчоо дэвтэр” хэмээх данс бүртгэлд 1911 оноос 1917 оны 4 сар хүртэлх хугацаанд хааны зарлигаар тогтоосон хууль цаазын шинжтэй 63 бичиг бүртгэгдэж байжээ.[239] Тэдгээрийн нэг нь 1913-1919 оны хооронд “Таван яам хамт нийлж хувьсган тогтоож айлтгаад, одоогийн дагаж явах хууль, дүрэм” хэмээх 12 зүйл бүхий эрх зүйн актыг эмхэтгэн мөрдөж байжээ.[240]

Богд хаант Монголын хууль цаазын бодлогоор дараах ял шийтгэлийг оногдуулдаг байжээ. Үүнд:

1. Хөвчдөн алах;
2. **Цөлөх**;
3. Торгох; (малаар)
4. Занчих;
5. Үйлтгэх ял буюу албадан ажил хийлгэх;
6. Дөнгөлөх гэсэн ял оногдуулдаг байв.

- **Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг**[241]

“Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг” хэмээх хууль цаазын эх сурвалжийг зохиолгохоор 1915 онд Богд хааны зарлигаар комисс байгуулж, Манж Чин улсын үеийн “Зарлигаар тогтоосон Гадаад Монголын төрийг засах явдлын яамны Хууль зүйлийн бичиг” болон бусад хуулийг нягтлан монгол хэлээр орчуулж таван дэвтэрт нэгтгэн, 1918 онд уг хуулийг хэлэлцэн баталжээ.[242]

Хууль зүйлийн бичигт ташуур занчих ялыг 160 зүйлд, дөнгө дөнгөлөх ялыг 82 зүйлд, пүнлүү хасах ялыг 29 зүйлд, торгох ялыг 56 зүйлд, **цөлөх** ялыг 17 зүйлд, хөрөнгө хураах ялыг 2 зүйлд, цаазаар авах ялыг 48 зүйлд тусгасан байна.

- **Ардын хувьсгалын дараах үеийн эрүүгийн хууль тогтоомж**

МАХН-ын анхны программ хэмээх удирдамжийн баримт бичигт хувьсгалын эхний жилүүдэд хуучин ёс журмыг халж, шинэ журам тогтоохдоо “эрх биш боловсрол нь дундад зууны үеэс дэмий хол өнгөрөөгүй бүхнийг харгалзуулж эдүгээгийн байдлыг зүйгээр шинэчлэн халах явдлыг үйлдвэл зохино[243] гэжээ.

1922 оны 3 дугаар сарын 3-нд гаргасан захирах захирагдах журмын тогтоолд “...ардын эрхт хэмжээт цаазат засгийн ёсон болбоос захирах захирагдахын ёсон ба эрүү шүүлт яллах, залхаахыг бүрнээ устгасан бус гагцхүү

---

[239] Содовсүрэн. Б.Хувьсгалын өмнөх Монголын төр ба хууль цааз. 1911-1920. УБ., 1989 56 дахь тал.

[240] Б.Баярсайхан, С.Жанцан, Ж.Энхнасан, Д.Сумьяацэрэн “Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009). УБ., 2004. 19 дэх тал.

[241] Б.Баярсайхан, С.Жанцан “Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009) УБ., 2010. 36 дахь тал.

[242] Ж.Урангуа, Б.Баярсайхан “Жинхэнэ дагаж явах хууль дүрэм” (1913-1918) Эх бичгийн судалгаа. УБ., 2004.10 дахь тал.

[243] БНМАУ-ын түүх. УБ., 1984, 363 дахь тал: МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. УБ., 1966, I дэвтэр 17 дахь тал.

дээдэс нь доордыг учиргүйгээр эзэрхэж дарлах ба доордос нь мөн түүний эрх сүрт дарагдаж өгүүлэх газаргүй болон зүдэж дарлагдах муу суртлыг халж, ард түмэнд эрх чөлөө олгосон нь болой”[244] гэж тодорхойлжээ.

Ардын Засгийн газар 1921 оны 7 дугаар сарын 16-ны 4 дүгээр хурлын 8 дугаар тогтоолын 10, 11 дүгээр зүйлд тус улсад оршин сууж буй гадаадын харьяат ба ОХУ-ын харьяат хүнийг Монголын хуулиар шийтгэх, хэрэгт холбогдогчийн гэм бурууг тогтоохдоо эд мөрийн баримт, гэрчийн мэдүүлгийг баримтлах, бие махбодыг зовоох, эрүү шүүлт хэрэглэхийг хоригложээ.[245]

1921 оны 7 дугаар сарын 30-ны “Эрүү шүүлтийн тухай” Засгийн газрын 8 дугаар хурлын тогтоолын 10 дугаар зүйлд “Аливаа гадаад, дотоодын хүмүүсийн эрүү шүүлтийн тухай хэлэлцээд аливаа гадаадын хүнтэй холбогдсон Монгол хүнийг гадаадын хүний адил эрүү шүүлт хүлээлгэхгүй, эд мөр, хөндлөнгийн гэрчийг баримтлан шийтгэсүгэй. Дан ганц Монгол хүн гэрээ, гэрчгүйд хэргийг хүлээхгүй бол юуны урьд эрүү шүүлт хэрэглэхгүйгээр үнэнийг олохыг хичээх ба хэрэв үнэн өчиг илрэхгүйд хүрвэл шүүлтийг зохисыг нь үзэж хэвээр хэмнэн хэрэглэхээр тогтов”. Тогтоолын 11 дүгээр зүйлээр хуучин хуульд байсан алах, цөлөх, дөнгө дөнгөлөх, пүнлүү хасах, золио авах ялыг хувьсгаж хорих, торгох ял болгон өөрчилсөн.

1921 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн Ардын Засгийн газрын хурлын 9 дүгээр тогтоолын 5 дугаар зүйлд “Эх орноосоо урвах гэмт хэргээс бусад гэмт хэрэгт алах, **цөлөх**, дөнгөлөх ялыг өөрчилж алах ялыг 10 жил хорих, алгуурлан алах ялыг 7 жил хорих, улсын хязгаарт цөлөх ялыг 3 жил хорих, зэргэлдээ аймагт цөлөх ялыг 1 жил хорих ял болгон өөрчилж хоригдлын ял эдлэх хугацаанд нь хөдөлмөр хийлгэх болгожээ.[246]

Нэг. 1926 оны Шүүх цаазын бичиг

1926 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр БНМАУ-ын анхны Эрүүгийн хууль буюу Шүүх цаазын бичгийг батлан хэрэгжүүлж иржээ. Уг цаазын бичигт ялын төрлийг хуульчлахдаа онц аюултай гэмт хэрэгтнүүдэд шүүх цаазын бичгийн тусгай ангид хэрэглэхээр заасан алах, 1 өдрөөс 10 жил хүртэл хугацаатай албадан хөдөлмөрлүүлэх явдалтай хослуулан хэрэглэх хорих, 100 өдрөөс хэтрэхгүй хугацаатай засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, хөрөнгө хураах, 10 төгрөгөөс дээш хэмжээтэй торгох, албан тушаалаас огцруулах, БНМАУ-ын нутгаас хөөн зайлуулах, шүүхээс донгодох, аливаа эрхийг бүрэн буюу эсхүл заримыг хугацаагаар буюу үүрд эвдэх буюу **уг газраас бусад газарт шилжин явах эрхийг үүрд эвдэх** зэрэг үндсэн ба нэмэгдэл ялыг тогтоож өгсөн байна.

Хоёр. *1929 оны Шүүх цаазын бичиг*

---

[244] МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. I боть. УБ., 1996, 124 дэх тал.

[245] “Ардын засгаас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд” УБ.,1954.127-128 дахь тал.

[246] Б.Баярсайхан, С.Жанцан “Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009) 78 дахь тал.

Монгол орныг капиталист бус замаар хөгжүүлэх талаар МАХН-ын V, VI хурлаас дэвшүүлсэн зорилтыг шийдвэрлэх, улс оронд бий болсон дотоод, гадаадын нөхцөл байдал, хурцадмал байдлыг намжаах чухал нөхцөл болох хувьсгалт хууль ёсыг бэхжүүлэх, аливаа дайсагнасан үйл ажиллагааны эсрэг үр дүнтэй тэмцэл явуулах зорилгоор хууль цааз, тэр тусмаа эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тулгарсан байна.

Ийм учраас 1929 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр Засгийн газрын 30 дугаар хурлаар Шүүх цаазын бичгийг шинэчлэн батлан, 1926 оны хуулийг хүчингүй болгосон байна. 1929 оны Шүүх цаазын бичигт аливаа эрхийг бүрэн буюу эсхүл заримыг хугацаагаар буюу үүрд эвдэх гэсэн заалтыг хасаж **уг газраас бусад газарт шилжин явах эрхийг 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар хасахаар** хязгаартай тогтоож хүний эрхийг хангаж өгсөн байна.

Гурав. 1934 оны Шүүх цаазын бичиг

Улсын Бага Хурлаас 1934 оны 5 дугаар сарын 24-нд Шүүх цаазын бичгийг батлан гаргажээ.

Уг хуульд буудан алах, хорих, албадан ажил хийлгэх, улс төрийн болон хувийн зарим эрхийг 1-5 жилийн хугацаагаар хасах, **нутаг зайлуулах буюу нутаг зааж суулгах,** албан тушаалаас огцруулах буюу ажлаас хөөх, донгодох буюу олон нийтийн өмнө буруутгах, хөрөнгийг бүрэн буюу зорилгыг хураах, мөнгө торгох, учруулсан гэм хорыг арилгах үүрэг даалгах, гадаадын иргэдэд бол улсын хязгаараас хугацаагаар буюу бүр мөсөн хөөх гэж ялын тодорхой төрлүүдийг хуульчилсан төдийгүй эмнэлгийн чанартай албадах болон сурган хүмүүжүүлэх албадах арга хэмжээг нарийвчлан тогтоожээ.

Дөрөв. 1942 оны Эрүүгийн хууль

Улсын Бага Хурлаас 1942 оны 1 дүгээр сарын 17-нд тус хуулийг баталсан ба уг хуульд хорих ялыг засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн лагерьт байлгаж ял эдлүүлэх, хорихгүйгээр албан ажил хийлгэх гэж өөрчлөн найруулж, буудан алах ялыг хувьсгалт төр засаг хийгээд улс нийтэд онц аюултай хүнд гэмт хэрэг үйлдэгчдэд оногдуулах онцгой арга болгосон байна. Түүнчлэн эцэг эх байх эрхийг хасах, тэтгэвэр авах эрхийг хасах зэрэг шийтгэл хэрэглэж байхыг шинээр тодорхойлон, **нутаг зааж суулгах** ял хэрэглэж болох гэмт хэргүүдийг шууд нэрлэн зааж өгсөн байна.

Тав. 1961 оны Эрүүгийн хууль

1961 оны эрүүгийн хуульд буудан алах, хорих, **нутаг зааж суулгах, уг нутгаас зайлуулах**, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, ямар нэгэн тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу ажил хэрэг эрхлэхийг хориглох, торгох, олон нийтийн өмнө буруушаах зэрэг ялын төрөл байсан байна.

Дээрх ялын төрлүүдээс нутаг зааж суулгах ял шийтгэгдсэн этгээдийг оршин суугаа нутгаас нь хугацаатайгаар зайлуулан тодорхой нутаг зааж суулгахыг хэлэх ба үндсэн ба нэмэгдэл ялын шинжтэйгээр 2-5 жилийн хугацаагаар тогтоодог байсан байна. Нутаг заан суулгагдсан этгээдийг хөдөлмөрт хамруулах ажлыг

тухайн орон нутгийн Ардын депутатын хорооны гүйцэтгэх захиргаа хариуцдаг байсан бол уг нутгаас зайлуулах ял шийтгэгдсэн этгээдийг оршин суугаа нутгаас нь хугацаатай албадан зайлуулан, үндсэн ба нэмэгдэл ялын шинжтэйгээр 2-5 жилийн хугацаагаар тогтоодог байсан байна. Нутаг зааж суулгах ял шийтгэгдсэн этгээд уг нутагт очих замаасаа оргох буюу зааж суулгасан нутгаас оргон зайлсхийвэл гэмт хэрэг гэж үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байна.[247]

Нутаг заах ялын зорилго нь ялтныг гэмт хэрэг дахин үйлдэх орчны нөхцөлөөс тусгаарлаж, тэр этгээдийн нийгмийн эсрэг зан төлөв, сөрөг нөлөөллөөс бусдыг урьдчилан сэргийлэхэд оршино гэжээ. Нутаг заагдсан этгээд тогтоосон хугацааны дотор тэрхүү нутгаас гадагш гарч явах эрхгүй бөгөөд энэ нь ялтны засрал хүмүүжилд эерэг нөлөө үзүүлж чадна гэж үзсэн нөхцөлд уг ялыг оногдуулдаг байжээ.

Нутаг заах ялыг нэмэгдэл ял болгон оногдуулсан тохиолдолд үндсэн ялыг эдэлж дууссаны дараа эдлүүлдэг бол ялтан засран хүмүүжихэд нийгмээс тусгаарлан хорих ял оногдуулах шаардлагагүй гэж үзвэл үндсэн ялын чанартай хэрэглэдэг байжээ. Нутаг заах ялыг гэмт хэрэг үйлдэх үедээ 18 нас хүрээгүй байсан этгээд, 8 хүртэлх насны хүүхэдтэй болон жирэмсэн эмэгтэйчүүдэд оногдуулахыг хориглосон байна.

Харин уг нутгаас зайлуулах ялыг гэмт хэрэг үйлдсэн этгээдийн оршин байгаа тодорхой нутгийн орчин нь түүний цаашид дахин гэмт үйл ажиллагаа үргэлжлүүлэхэд нь нөлөөлөх юм уу эсхүл уг этгээд оршин суудаг нутагтаа байх нь бусад хүмүүсийг гэмт хэргийн замд татан оруулж болох муу нөлөөтэй нөхцөлд үндсэн болон нэмэгдэл ялын аль нэг хэлбэрээр оногдуулахаар зохицуулжээ.[248] Уг нутгаас зайлуулах ял нь ялтныг тодорхой нутагт оршин суух эрхийг шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор хасдаг учир заасан нутагт эргэж ирэх эрхгүй, харин оршин суух нутгаа сонгох эрхтэй байдаг байна.

Энэхүү ялыг ялтан засарч хүмүүжихэд нийгмээс тусгаарлан хорих ял оногдуулах шаардлагагүй гэж үзвэл үндсэн ялын чанартай хэрэглэдэг бол нэмэгдэл ял болгон оногдуулсан тохиолдолд үндсэн ялыг эдэлж дууссаны дараа эдлүүлдэг. Мөн нутаг зайлуулах ялыг гэмт хэрэг үйлдэх үедээ 18 нас хүрээгүй байсан этгээд, 8 хүртэлх насны хүүхэдтэй болон жирэмсэн эмэгтэйчүүдэд оногдуулахыг хориглодог бөгөөд хоёр жилээс доошгүй таван жилээс дээшгүй хугацаагаар оногдуулдаг зэрэг нь нутаг зааж суулгах ялтай ижил юм.

Зургаа. 1986 оны Эрүүгийн хууль

1986 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль нь бүтэц, хэлбэрийн хувьд өмнөх хуулиас харьцангуй сайжирсан хууль боловч социалист өмчийн харьцааг хамгаалан дэмжих, төлөвлөгөөт эдийн засаг, захиран тушаах дэглэмийн

[247] Б.Содовсүрэн. “БНМАУ-ын Эрүүгийн эрх”. УБ., 1969.
[248] БНМАУ-ын Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УБ., 1989. 39 дахь тал.

тогтвортой байдлыг албадлагаар баталгаажуулахад чиглэгдсэн заалт хадгалагдаж үлдсэн.[249]

Уг хуульд ялын төрлийг хорих, **нутаг заах**, **уг нутгаас зайлуулах**, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, торгох, сахилгажуулах ангид явуулах, олон нийтийн өмнө буруушаах, эд хөрөнгө хураах, цэргийн болон тусгай алдар цолыг хасах зэргээр хуульчилж өгчээ.

Дээрх ялын төрлүүдээс **нутаг заах** ялыг ялтныг оршин суугаа газраас нь зайлуулан тодорхой нутагт албадан суулгахыг хэлэх ба үндсэн ба нэмэгдэл ялын шинжтэйгээр 2-5 жилийн хугацаагаар тогтоодог байсан байна. Нутаг заан суулгагдсан этгээдийг хөдөлмөрт хамруулах ажлыг тухайн орон нутгийн Ардын депутатын хорооны гүйцэтгэх захиргаа хариуцдаг байсан бол уг нутгаас зайлуулах ялыг ялтныг тодорхой нутагт оршин суухыг хориглож, оршин суугаа газраас нь зайлуулахыг хэлэх ба үндсэн ба нэмэгдэл ялын шинжтэйгээр 2-5 жилийн хугацаагаар тогтоодог байсан байна.

- **1990-2015 он хүртэлх эрүүгийн хууль тогтоомж**

Нэг. 1993 оны Эрүүгийн хууль

1992 оны Үндсэн хууль нь Монголын ард түмний амьдралд түүхэн эргэлт хийж, эх орондоо иргэний, ардчилсан, хүмүүнлэг нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг тунхагласан билээ. Энэхүү Үндсэн хуулийн үзэл баримтлал, агуулгад нийцүүлэн Улсын Их Хурлаас Эрүүгийн хуульд 1993 оны 2 дугаар сарын 15, 6 дугаар сарын 7-ны өдрүүдэд томоохон өөрчлөлт хийсэн юм. Уг хуульд ялын төрлийг торгох, тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, эд хөрөнгө хураах, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, хорих, цаазаар авах гэж тогтоон нутаг заах, уг нутгаас зайлуулах, олон нийтийн өмнө буруушаах зэрэг ялыг хүчингүй болгожээ.

Хоёр. 2002 оны Эрүүгийн хууль

Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр Эрүүгийн хуулийг ерөнхий, тусгай ангиас бүрдсэн 11 хэсэг, 30 бүлэг, 305 зүйлтэйгээр баталсан бөгөөд хэрэгжих явцдаа 13 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон байна. Уг хуульд торгох, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, эд хөрөнгө хураах, албадан ажил хийлгэх, баривчлах, хорих, цаазаар авах гэсэн ялын төрлийг хуульчилсан. 2002 оны Эрүүгийн хуульд хүний зорчих эрхийг хязгаарлахтай холбоотой ял, шийтгэл тусгагдаагүй.

Монгол Улсад гэмт хэрэг үйлдсэн этгээдийн чөлөөтэй зорчих эрхийг хязгаарлаж ирсэн түүхэн баялаг уламжлалтай гэж үзэж болно. Харин зорчих эрхийг хязгаарлах ял гэж нэрлэн, цахим хяналт тавих ажиллагааг хуульчлан, хэрэгжүүлэх практик нь эхлэлийн шатандаа явж байна гэж үзлээ.

---

[249] Б.Баярсайхан, С.Жанцан “Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009) УБ., 2012. 105-109 дэх тал.

---o0o---

ДУУРСАХ НЭР БУЛАН

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ХУУЛЬ ЗҮЙН УХААНЫ ДОКТОР /PH.D/, ПРОФЕССОР, БЭЛТГЭЛ ХУРАНДАА Р.ОЮУНБАДАМЫН “ДУРСАМЖ ЯРИА”



Монгол Улсад хурандаа цол олгож эхэлсний 87 жилийн ойн өдөр 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр тохиож байгааг тохиолдуулан ШШГЕГ-ын дарга, хурандаа О.Амарсанаа, Захиргааны удирдлагын газрын дарга, хурандаа Б.Дашдаваа нар бусад ажилтнуудын бүрэлдэхүүнтэй “Одоогоос 29 жилийн өмнө Монгол Улсад анх удаа эмэгтэй цэргийн алба хаагч хурандаа цол хүртсэн нь Монгол Улсын гавьяат хуульч, хууль зүйн ухааны доктор /Ph.D/,профессор, бэлтгэл хурандаа Р.Оюунбадам байсан тул хүндэтгэл үзүүлж байна” хэмээгээд манай гэрт хүрэлцэн ирсэнд ахмад ажилтан надад маш их баярт үйл явдал тохиож баярлах, сандрах зэрэгцсэн юм. Энэ мөчид 40 жилийн өмнөх баярт өдрийн дурсамж сэтгэлд өөрийн эрхгүй ороод ирэв.

Миний бие 1980-аад оны эхээр Зүүнхараа дахь Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн клоноос удирдах газартаа дэвшин томилогдоод хэсэг нөхдийн хамт 1981 оны Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуулийн V бүлгийн заалтуудыг бүхлээр нь хэрэгжүүлэх ажилд ханцуй шамлан орж цаг завгүй ажиллаж байхдаа хүүхэд төрүүлээд 20-иод хонож байлаа. Энэ өдрүүдэд Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын удирдах газрын дарга, хошууч генерал Ж.Содном дарга манай гэрт ирсэн юм. Тэр үед манайх гэр хороололд, хашаанд монгол гэрт амьдардаг, олон жаахан хүүхэдтэй, нөхөр ээжийнхээ хамт амьдарч байв. Мөн л дээр дурдсанчлан баярлах, сандрах зэрэгцэн би өлгийтэй хүүхдээ тэвэрчихсэн ерөнхийдөө жаахан зутруухан амьдарч байлаа. Түүнээс хойно төдийлөн удалгүй ажилдаа орсон учир цаг нартай уралдаж хөхүүл нялх хүүхэдрүүгээ гүйх үү албан ажлаа сайн хийх хоёрын дунд хүндхэн байсан хэдий ч албандаа урамтай байсан нь генерал маань амьдрал ахуйтай танилцсанд байсан болов уу.

Одоогоос 29 жилийн өмнө анх удаа эмэгтэй цэргийн албан хаагч хурандаа цол хүртсэн нь Монгол Улсын гавьяат хуульч, хууль зүйн ухааны доктор /Ph.D/, профессор Р.Оюунбадам байсан юм. Тэрбээр ШШГБ-д 30 гаруй жил ажилласан бөгөөд түүнийхээ 20 жилд нь эмэгтэйчүүдийн хорих ангийн даргаар ажиллаж байгууллагын хөгжилд өөрийн ухамсарт амьдрал, залуу нас, сурсан эрдэм

мэдлэгээ зориулан хуулиар хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлсэн эрхэм хүмүүн билээ гэжээ...



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага бол төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага болохынхоо хувьд төрийн өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж, нийгэм, иргэдийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх байгууллага юм. Энэхүү төрийн байгууллагын удирдлагаар томилогдсон Хурандаа О.Амарсанаа энэ албыг удирдан энэ богино хугацаанд тус байгууллагын чиг үүрэг дээр суурилан олон шинэлэг үр дүнтэй ажил эхлүүлээд шийдвэрлэн ажиллаж байгааг дурдах нь зүйтэй.

Тухайлбал ШШГБ-ын боловсон хүчнийг тогтвор суурьшилтай үр бүтээлтэй ажиллуулах талаар анхаарч ажиллаж бага бүрэлдэхүүний цалин, хөлсийг нэмэгдүүлэх, байгууллагын гадаад харилцааг бэхжүүлж, өргөжүүлэх, байгууллагын үйл ажиллагааг нээлттэй болгох, ахмад настнуудаа эргэж, тойрч тусламж дэмжлэг үзүүлэх, боловсон хүчний бодлогыг зөв тодорхойлох талаар багагүй ажлуудыг хийж байна. Мөн алба хаагчдын мотивацижуулсан, урамшуулах тал дээр анхаарч ажиллах, нийгмийн асуудлын бодит байдлаар шийдвэрлэх, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиглэлээр бодит ажлуудыг зохион байгуулахдаа ажлыг судалгаа, шинжилгээг үндэслэж хэрэгцээ шаардлагаа тодорхойлох, алба хаагчдыг чадавхжуулах гэх мэт олон ажлуудыг хийж байна.

Энэхүү ажлуудыг оновчтой эхлүүлж, эхнээс нь үр дүнд хүрч байгааг харахын ялдамд улам ихийг бүтээх урам зоригтой ажиллаж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдлагуудын маань энэ өдөр надад хүндэтгэл үзүүлж байгаа нь өнөөдөр энэхүү албанд үүрэг гүйцэтгэж буй офицер, ахлагч бүрэлдэхүүн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны сургуульд суралцаж буй сонсогч, суралцагч нарт албандаа урам зоригтой ажиллах итгэл найдварыг өгч байгаа нь ач холбогдолтой юм.

---o0o---

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН АЛБАНЫ СУРГУУЛИЙГ СУРГАЛТ, СУДАЛГААНЫ 403 ДУГААР АНГИ-ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ СУРГУУЛЬ БОЛГОХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРДЛЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 204 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулж Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийг “сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургууль” болгон өөрчилж шийдвэрлэлээ.





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

Дотоод хэргийн их сургуулийн бүрэлдэхүүн сургуулиудын нэг Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургууль нь 1974 онд НАХЯ-ны Цэргийн тусгай дунд сургуульд Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын үндсэн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэж эхэлсэн цагаас хойш Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 1300 гаруй үндсэн болон удирдах албан тушаалтныг, ахисан шатны боловсрол олгох, давтан мэргэшүүлэх болон ахлагч бүрэлдэхүүнийг бэлтгэх сургалтаар 2700 гаруй албан хаагчийг тус тус сурган бэлтгэж ирсэн юм.

Энэхүү үйл явдал нь Монгол Улсын эрүүгийн ялын бодлого дахь шинэчлэл, нийгэм эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулдсан, шүүхийн шийдвэрийн биелэлтийг нэг мөр хангах, олон улсын хөгжлийн жишигт нийцүүлэн мэргэжлийн үйл ажиллагааг хөгжүүлэх, салбарын сургалт, судалгаа, эрдэм судлалын ажлыг шинэ шатанд гаргах нөхцөлийг бүрдүүлэх үйл явдал болсон юм.

---o0o---

“МОНГОЛ ЭРЭГТЭЙ ХҮНИЙ ДУНДАЖ НАСЛАЛТЫГ УРТАСГАХАД УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ” СЭДЭВТ ЛЕКЦ БОЛЛОО

Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулиас “Монгол эрэгтэй хүний дундаж наслалтыг уртасгахад Уламжлалт анагаах ухааны гүйцэтгэх үүрэг” сэдэвт лекцийг Их сургуулийн соёлын төвд (2023.03.21) зохион байгууллаа. Тус лекцийг Монголын Нэгдмэл Анагаах Ухааны тэргүүн, “Ачуут гол” уламжлалт эмнэлгийн зөвлөх эмч, анагаах ухааны доктор, профессор, элэг судлаач Г.Машбат уншиж, багш, алба хаагч, сонсогчдын сонирхсон асуултад хариулав.

Энэхүү лекцэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн алба хаагч, сонсогчид болон Цагдаагийн сургууль, Онцгой байдлын сургууль, Хилийн албаны сургууль, Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн 18-20 насны 550 гаруй сонсогч оролцсон.





Дотоод хэргийн их сургуулийн нийт бие бүрэлдэхүүн, сонсогч, суралцагчдын 70-аас дээш хувийг эрчүүд эзэлдэг бөгөөд энэхүү лекц нь ихээхэн сонирхолтой байсныг оролцогчид онцоллоо.

---o0o---

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ ТЭНХИМИЙН “ОФИЦЕР” ДАМЖААНЫ ТӨГСӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛЛОО

Дотоод хэргийн их сургуулийн харьяа Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тэнхимийн “Офицер” дамжааны ээлжит төгсөлтийн үйл ажиллагаа өнөөдөр /2023.03.10/ Их сургуулийн Соёлын төвд зохион байгууллаа.

Энэхүү үйл ажиллагаанд Ахлагчийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал, доктор (Dh.P), цагдаагийн хурандаа Г.Ганбаатар, ШШГЕГ-ын захиргааны удирдлагын газрын дарга, дэд хурандаа Б.Дашдаваа, АМСҮТ-ын ШШГАТ-ын эрхлэгч, доктор дэд хурандаа Д.Мягмарсүрэн, Онцгой байдлын тэнхимийн эрхлэгч, дэд хурандаа О.Батбилэг болон тус төвийн багш, албан хаагчид оролцсон юм.

Төгсөлтийн ёслолын үйл ажиллагаанд ахмад Н.Энхжаргал, ахлах дэслэгч Н.Эрдэнэсүх, дэслэгч Б.Төгөлдөр, “Соёмбо” чуулгын бүжигчид уран бүтээлийн дээжээс өргөн барьж, дэд ахлагч Б.Намуундарь төгсөгчдөө төлөөлөн үг хэлж, урлагийн тоглолт боллоо.





---o0o---

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЗӨВЛӨЛ ХИЛИЙН ЧАНАД ДАХЬ МОНГОЛЧУУДЫН ЗӨВЛӨЛТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХААР БОЛЛОО

“Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын “Эмэгтэйчүүдийн зөвлөл” Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөлтэй “Хамтран ажиллах санамж бичиг” байгууллаа. Санамж бичгийн хүрээнд тус байгууллагын эмэгтэй алба хаагчдын нийгмийн харилцаан дахь манлайлал, оролцоог нэмэгдүүлэх, өөрийгөө хөгжүүлэх боломжийг олгохын зэрэгцээ боловсролын чиглэлээр төсөл хөтөлбөр хамтран хэрэгжүүлж, харилцан мэдээлэл солилцохоор тогтлоо. Санамж бичиг байгуулснаар “Дэлхийн мөрөөдлийн сургууль” ТББ, Европ дахь Монгол эмэгтэйчүүдийн холбоо, Солонгос дахь Монгол эмэгтэйчүүдийн зөвлөл болон бусад улс орнуудын эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран эмэгтэй алба хаагчид гадаад улс орнуудад туршлага судлах, сурч боловсрох, мэдлэг чадвараа дээшлүүлэх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломж нээгдэж байгаа юм.





---o0o---

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН АЛБАНЫ СУРГУУЛИЙН НИЙГМИЙН АЖИЛ СЭТГЭЛЗҮЙН ТЭНХИМ БОУЛИНГИЙН ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Нийгмийн ажил сэтгэлзүйн тэнхимээс 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр тус сургуулийн багш, албан хаагчид, Ахлагчийн мэргэжил сургалтын үйлдвэрлэлийн төвийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тэнхимийн багш нар болон Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн судлаачдын дунд Боулингийн тэмцээн зохион байгууллаа.

Энэхүү лекцэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн алба хаагч, сонсогчид болон Цагдаагийн сургууль, Онцгой байдлын сургууль, Хилийн албаны сургууль, Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн 18-20 насны 550 гаруй сонсогч оролцсон.





Дотоод хэргийн их сургуулийн нийт бие бүрэлдэхүүн, сонсогч, сурагчдын 70-аас дээш хувийг эрчүүд эзэлдэг бөгөөд энэхүү лекц нь ихээхэн сонирхолтой байсныг оролцогчид онцоллоо.

---o0o---

МОНГОЛЫН АНХНЫ ЭМЭГТЭЙ ХУРАНДАА Р.ОЮУНБАДАМД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ

Монгол Улсад хурандаа цол олгож эхэлсний 87 жилийн ой 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдөр тохиосон.

Тус өдрийг тохиолдуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа О.Амарсанаа болон Захиргааны удирдлагын газрын дарга, дэд хурандаа Б.Дашдаваа нар Монгол Улсын гавьяат хуульч, Хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ахмад ажилтан, Монголын анхны эмэгтэй хурандаа Р.Оюунбадамд хүндэтгэл үзүүллээ.

Одоогоос 29 жилийн өмнө анх удаа эмэгтэй цэргийн алба хаагч хурандаа цол хүртсэн нь Монгол Улсын Гавьяат хуульч, доктор, профессор Р.Оюунбадам байсан юм.

Тэр бээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад 30 гаруй жил ажилласан бөгөөд түүнийхээ 20 жилд нь эмэгтэйчүүдийн хорих ангийн даргаар ажиллаж байгууллагын хөгжилд өөрийн ухамсарт амьдрал, залуу нас, сурсан эрдэм, мэдлэгээ зориулан, хуулиар хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлсэн эрхэм хүмүүн билээ.





---o0o---

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЭМЭГТЭЙ АЛБАН ХААГЧДЫН ДУНД “ДАРТС-2023” ТЭМЦЭЭН БОЛЛОО

Дотоод хэргийн их сургуулийн харьяа Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвөөс Их сургуулийн эмэгтэй албан хаагчдын дунд “Дартс-2023” бооцоот тэмцээнийг зохион байгууллаа. Энэхүү тэмцээнд бүрэлдэхүүн сургууль, бүтцийн нэгжүүдээс 40 тамирчин оролцож, хурд хүч, авхаалж самбаагаа дайчлан өрсөлдөв.

Тэмцээний тэргүүн байранд Их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Боловсрол судлалын төвийн дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Ариунзаяа, дэд байранд Сургалтын бодлого, төлөвлөлтийн газрын сургалтын төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн, дэслэгч Б.Батцэцэг, гутгаар байранд Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын албаны Чанарын баталгаажуулалтын төвийн мэргэжилтэн, ахмад А.Жаргалзаяа нар тус тус шалгарлаа.

Тус тэмцээний шүүгчээр Монголын дартс сонирхогчдын холбооны шүүгч С.Мөнгөнчимэг ажиллажээ.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг дартсын тэмцээнд амжилттай оролцсон бүсгүйчүүддээ баяр хүргэж, амжилт хүсье.





---o0o--

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН АЛБАНЫ СУРГУУЛИЙН СОНСОГЧ МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЕРӨНХИЙ КОМАНДЛАГЧИЙН НЭРЭМЖИТ 2023 ОНЫ “ШИЛДЭГ СОНСОГЧ” ШАГНАЛ ХҮРТЛЭЭ

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит 2023 оны шилдэг сонсогчид тодорлоо. Энэхүү шагналыг Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл-Эрх зүй” бакалаврын хөтөлбөрийн 541 дүгээр дамжааны сонсогч, дэд түрүүч Батзоригийн Азжаргал хүртлээ.

Шагналыг Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Ухнаагийн Хүрэлсүх гардуулж, сурлагын өндөр амжилт хүсэн ерөөсөн юм. Дэд түрүүч Б.Азжаргал нь зургаан улирал дараалан 3.7-оос доошгүй голч дүнтэй суралцсанаас гадна оюутны эрдэм шинжилгээний хурлуудад илтгэл хэлэлцүүлэн дэд болон тэргүүн байруудыг эзэлж, мөн мэргэжлийн спортын уралдаан тэмцээнүүдэд амжилттай оролцож энэхүү шагналын болзлыг хангажээ.



Үе тэнгийн сонсогчдоо манлайлан Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит 2023 оны "Шилдэг сонсогч" шагнал хүртсэн дэд түрүүч Батзоригийн Азжаргалдаа баяр хүргэж, сурлагын өндөр амжилт хүсье.

---o0o---

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН АЛБАНЫ СУРГУУЛИЙН 521 ДҮГЭЭР ДЭД ТҮРҮҮЧ М.МАРАЛМАА ШИНЭ ҮНДСЭН ХУУЛИЙГ СУРТАЛЧЛАХ ИЛТГЭЛИЙН УРАЛДААНЫ ШИЛДЭГЭЭР ТОДОРЛОО

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг Даргын Тамгын газраас Монгол Улсын шинэ Үндсэн хуулийг сурталчлах зорилгоор Их, дээд сургуулийн оюутнуудын дунд эрдэм шинжилгээний бага хурлыг хоёр үе шаттайгаар зохион байгуулжээ.

Оюутан, суралцагчдын дунд “Хүний эрхийг хангах орон нутгийн байгууллагын үүрэг”, “Орон нутгийн бие даасан байдал, тулгамдаж буй асуудал” сэдвээр, ерөнхий боловсролын сурагчдын дунд “Хүний эрхийг хангахад төрийн болон хувийн хэвшлийн үүрэг оролцоо” сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан.

Уралдааны нэгдүгээр шатанд хууль зүйн их, дээд сургуулийн 60 гаруй оюутан, суралцагч бүтээлээ ирүүлснээс хоёрдугаар шатанд 20 илтгэлийг шалгаруулж 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдөр хэлэлцүүлж, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн Олон улсын эрх зүйн ангийн 5 дугаар түвшний оюутан М.Амина, Г.Мягмарцэрэн нарын хамтран хэлэлцүүлсэн *“Нутгийн өөрөө удирдах байгууллага захиргааны хэм хэмжээний акт гаргах эрх зүйн зохицуулалтын тулгамдаж буй асуудал”* сэдэвт илтгэл тэргүүн байранд, Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны сургуулийн 521 дүгээр дамжааны дэд түрүүч Мөнх-Эрдэнийн Маралмаагийн *“Цэцэрлэгийн хүрэлцээ ба орон нутгийн байгууллагын урвуу хамаарал”* сэдэвт илтгэл дэд байрт, Их засаг Олон Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн 3 дугаар дамжааны оюутан Б.Өнөрзаяагийн *“Хүний эрхийг хангах орон нутгийн байгууллагын үүрэг”* сэдэвт илтгэл гутгаар байрт тус тус шалгарсан юм.





Судлаач оюутан, сонсогчдоо манлайлан оролцож дэд байрт шалгарсан дэд түрүүч М.Маралмаадаа баяр хүргэж, сурлага, хөдөлмөр, эрдэм судлалын ажилд нь өндөр амжилт хүсье.

---o0o---

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН АЛБАНЫ СУРГУУЛИАС СУРГАЛТЫН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ТОХИЖИЛТЫН АЖИЛ ХИЙЛЭЭ

Дотоод хэргийн их сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар хоорондын хамтын ажиллагааны хүрээнд сонсогч, суралцагчдын сурч боловсрох орчныг сайжруулах, багш, албан хаагчдын ая тухтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн анги, танхимуудад тохижилт хийлээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шийдвэр гүйцэтгэх алба, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Банк хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албаны дэмжлэгтэйгээр “Алдрын танхим”-ыг “Багшийн хөгжлийн тэнхим” болгон, мөн Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны тэнхимийн багш нарын өрөө, нийт 362 ам.метр талбай бүхий хоёр танхимыг бүрэн засварлаж тохижуулсан.





Түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас сонсогч, суралцагчдын хичээлийн танхимыг иж бүрнээр нь тохижуулжээ.

Дашрамд дуулгахад, Дотоод хэргийн их сургуулийн захирал, доктор, профессор, цагдаагийн хурандаа П.Батбаатар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа О.Амарсанаа нарын тушаалаар “Хамтарсан ажлын хэсэг” байгуулагдаж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийх, хөтөлбөрийг сайжруулан боловсруулах, “Аюулгүй байдал судлал”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл” бакалаврын сургалтын хэрэгцээнд зориулсан сурах бичиг боловсруулах чиглэлээр ажиллаж байгаа юм.

---o0o---

СОНСОГЧ, СУРАЛЦАГЧИД ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГТ ОРОЛЦЛОО

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, иргэдэд мэдээлэл, зөвлөгөө өгөх, санал хүсэлтийг түргэн шуурхай хүлээн авч шийдвэрлэх зорилготой “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийн үйл ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон харьяа нийслэл, орон нутаг дахь газар, хэлтэс, хорих анги, нэгжийн хэмжээнд 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулсан өдөрлөгт Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Нийгмийн ажил хөтөлбөрийн 512, 522 дугаар дамжааны сонсогчид 407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, Баривчлах төвийн, Шийдвэр гүйцэтгэл хөтөлбөрийн 521 дүгээр дамжааны сонсогчид Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын өдөрлөгт оролцлоо.

Өдөрлөгийн хүрээнд хорих анги, баривчлах төвийн үйл ажиллагааны зохион байгуулалт, хоригдлыг нийгэмшүүлэх ажил, тэдэнд үзүүлэх сэтгэл зүйн үйлчилгээ, баривчлагдсан этгээдэд явуулах сургалт, нөлөөлийн ажлын зохион байгуулалт зэрэгтэй танилцаж, хорих байгууллагын алба хаагчидтай хорих ял, баривчлах шийтгэл эдлүүлэх ажиллагааны талаар сонирхолтой хэлэлцүүлэг өрнүүлсэн юм.





Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийг хангаж буй Цахим удирдлага, хяналтын төвийн үйл ажиллагаа, хүмүүжигчдийн хийсэн гар урлалын бүтээл, “Мөнхөд дурсагдах баатрууд” төрийн бус байгууллагаас дэлгэсэн “Мөнхөд дурсагдах баатрууд” үзэсгэлэнг сонирхож, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас иргэдэд үзүүлдэг үйлчилгээтэй танилцсан юм.

---o0o---

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН “СПОРТЫН 6 ТӨРӨЛТ ТЭМЦЭЭН” 7 БҮСЭД БОЛЛОО

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Спортын 6 төрөлт тэмцээн” улсын хэмжээнд 7 бүсэд зохион байгуулагдлаа.

Уг тэмцээнд нийт 47 хорих анги, байгууллагын баг тамирчид сагсан бөмбөг, гар бөмбөг, шатар, теннис, дартс, туухай өргөлтийн төрлөөр хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөв.

Улаанбаатар хотын А бүсийн тэмцээнийг Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги зохион байгуулж байгаа бөгөөд 7 анги, байгууллага, салбар нэгжийн 322 тамирчин оролцож, шилдгүүдээ тодруулсан байна. Харин хотын Б бүсийн тэмцээнийг Баривчлах төв зохион байгууллаа.

Дархан-Уул аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-445 дугаар нээлттэй хорих ангийн зохион байгуулсан Хойд бүсийн тэмцээнд нийт 6 анги, байгууллагын 105 тамирчин оролцож, 6 төрлөөр шилдгүүдээ тодруулжээ.

Баруун бүсийн тэмцээнийг Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар зохион байгуулж байгаа бөгөөд 2023 оны 03 дугаар сарын 24-нд дартс, туухай өргөлт, шатар, гар бөмбөг, ширээний теннис болон сагсан бөмбөгийн тэмцээний шилдгүүд тодорлоо.

Хэнтий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-419 дүгээр нээлттэй хорих ангийн зохион байгуулж буй Зүүн бүсийн тэмцээнд 7 анги, байгууллага, салбар нэгжийн 120 гаруй тамирчин оролцсон.





Дээрх 7 бүсийн тэмцээний 6 төрлийн тэргүүн болон дэд байрт шалгарсан баг, тамирчид 2023 оны 03 дугаар 30-наас 04 дүгээр сарын 01-ний өдрийн хооронд Улаанбаатар хотноо болох Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын аварга шалгаруулах шигшээ тэмцээнд оролцох юм.

---o0o---

МЭДЭЭЛЭЛ

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ СЭТГҮҮЛД НИЙТЛЭГДЭХ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛД ТАВИГДАХ ХЭЛБЭРИЙН ШААРДЛАГА

ӨГҮҮЛЛИЙН ЭХНИЙ НҮҮР:

ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН “ПАНОПТИКУМ” ЗАГВАРЫН ТУХАЙ
(бүтээлийн ерөнхий шарчиг нь 12pt хэмжээтэй, Arial, **Bold, ТОМ ҮСГЭЭР**)

ABOUT THE PANOPTICUM MODEL OF THE PRISON INSTITUTION
(бүтээлийн гарчиг Англи хэлээр)

*Б.Галбадрах**
(*Зохиогчийн овог, нэр, эрдмийн зэрэг, эрхэлж байгаа ажил, байгууллага* Arial, *12pt* хэмжээтэй, *Italic*)

ТОВЧ УТГА, ТҮЛХҮҮР ҮГС БИЧИХ:

Өгүүлэлд зохиогч тус бүтээлийн товч утгыг монгол болон англи хэл дээр бичнэ. Өгүүллийн товч утга нь 50-100 үгтэй байх бөгөөд түүнд эшлэл авахгүй. Өгүүллийн товч утгыг өгүүллийн эхэнд бичнэ.

Жишээ нь: /монголоор/

(Товч утга)

Олон улс орнууд гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэрэгтний аюулгүй болгох, нийгмээс тусгаарлах ажиллагаанд анхаарлаа хандуулж ирсэн байдаг. Гэмт хэрэгтнийг ял эдлүүлэх байгууламж буюу өнөөгийн хэллэгээр хорих байгууллагын зохион байгуулалт, архитектурын олон санал, санааг дэвшүүлсэн байдаг. Өгүүлэлд эдгээр загваруудын нэг болох шоронгийн “паноптикум” загварын тухай тайлбарласан болно.

(Түлхүүр үгс)

Түлхүүр үг нь нэр үг, нэрлэхийн тийн ялгал, ганц тоон дээр байна. Түлхүүр үгс нь өгүүлэлд голлох ач холбогдолтой үгс байна. Түлхүүр үгсийг монгол болон англи хэлээр бичсэн байна.

Түлхүүр үгс: хорих ял, хоригдол, паноптикум.

Жишээ нь: (англиар)

(**ABSTRACT**)

Many countries haye focused on crime preyention, offender safety, and social isolation. Many proposals and ideas haye been put forward for the organization and architecture of facilities for serying criminals, or prisons in today's terms. The article describes one of these models, the prison "panopticon" model.

Keywords: imprisonment, prisoner, panopticon.

ҮНДСЭН БИЧВЭР:

Сэтгүүлд нийтлүүлэхээр ирүүлж буй эрдэм шинжилгээний бүтээл нь урьд өмнө ижил төрлийн гадаад болон дотоодын сэтгүүлд нийтлэгдэж, нийтийн хүртээл болоогүй байна.

Өгүүлэл нь хураангуй, түлхүүр үг, үндсэн хэсэг, дүгнэлт, санал эсхүл зөвлөмж, эх сурвалжийн жагсаалт оролцуулалгүйгээр 2000-аас доошгүй үгтэй байна.

ЖИШЭЭ НЬ:

Бүтээлийн үндсэн хэсэг нь 12pt хэмжээтэй, Times new Roman бичигдсэн байна. Цаасны хэмжээ А4, бүх талаас 2см зай авагдсан байна. Мөр хоорондын зай 1.15, догол мөр 1.25, шинэ мөр хоорондын зай 6pt.

Бүтээлд дараах байдлаар тоогоор дугаарлахаас гадна тэмдэгт ашиглана:

Жишээ нь:

Дээрх бүгдийг нэгтгэн үзвэл”нийтийн өмч” хэмээх ойлголт нь нийтлэг утгаараа:

- Public буюу нийтийн зүгээс эзэмших, ашиглах боломж бүхий
- Төр, орон нутаг болон бусад нийтийн эрх зүйн этгээдийн мэдэлд хамаарах
- Нийтийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдах эд юмс гэсэн нийтлэг ойлголтонд хүрч болохоор байна.

Өгүүлэлд зураг, хүснэгт ашиглах:

Хүснэгтийн дугаар: Хүснэгтийн дугаар нь хүснэгтийн зүүн дээд хэсэгт –

(Arial, 11pt) тухайн бүлгийг баримталсан дугаартай байна. Жишээ: хүснэгт 1.1 гэх мэт

Хүснэгтийн нэр: Дугаарын ард залгуулан – (Times new Roman, 11pt, italic) бичнэ. Жич: Хүснэгт Монгол Улсын эрх зүйн тогтолцоо гэх мэт.

Жишээ нь:

Хүснэгт 1. Монгол улсын эрх зүйн тогтолцоо

№			
1.			
2.			

Өгүүлэлд ашиглах зурган мэдээлэл нь дараах шаардлагыг хангасан байна.

Зурган мэдээллийн дугаар: зурган мэдээллийн зүүн дээд хэсэгт, – (Times new Roman, 11pt, italic), тухайн бүлгийг баримталсан дугаартай байна. Жич зураг 1 гэх мэт.

Зурган мэдээллийн нэр: Дугаарын ард залгуулан – (Times new Roman, 11pt, italic) бичнэ. Жич: зураг 1,2 монгол улсын эрх зүйн тогтолцоо гэх мэт.

Өгүүлэлд оруулах зураг нь сэтгүүлд хэвлэгдэхүйц чанарын шаардлага, нягтаршилтай байна. Шаардлагатай тохиолдолд зургийг өгүүллээс тусдаа файл хэлбэрээр илгээнэ.

Жишээ нь:

Зураг 1. Монгол улсын эрх зүйн тогтолцоо

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

Ашигласан эх сурвалжийн жагсаалт нь гагцхүү тухайн эрдэм шинжилгээний бүтээлд ашигласан бүтээлээс бүрдэх бөгөөд зохиогч, бүтээлийг цагаан толгойн үсгийн дарааллаар жагсаан бичнэ. – (Times new Roman, 11pt, мөр

хоорондын зай 1, баруун зүүн талаасаа зэрэгцсэн байна). Ингэхдээ гадаад болон дотоод эх сурвалжийг бүлэглэн бичнэ. –(I. Монгол эх сурвалж, II. Гадаад эрх сурвалж, III. Эрх зүйн эх сурвалж, IY. Бусад эх сурвалж гэх мэт).

Жишээ нь:

I. Монгол эх сурвалж:
II. Гадаад эх сурвалж:
III. Эрх зүйн эх сурвалж:
IV. Бусад эх сурвалж гэх мэт.

Өгүүлэл хүлээн авах:

Өгүүллийг setguul.cd@gmail.com цахим хаягаар хүлээн авна.